

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1	Хуралдааны товч тэмдэглэл	1-98
2	Дэлгэрэнгүй тэмдэглэл	99-372
	<i>1.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	101-365
	<i>2.Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар дүгнэлт</i>	365-372

**Монгол Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 10 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ш.Раднаасэд;
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Учрал.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс ирүүлсэн саналын дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдээр нийтийн сонсгол зохион байгуулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	3
Татгалзсан:	10
Бүгд:	13

23.1 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Нэг.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Атарцэцэг, Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт, Д.Мөнхтуяа, Б.Ундрах, Д.Эрдэнэбалсүрэн, Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Амардэлгэр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, судлаач О.Мөнхсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Хонгорзул, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг явуулав.

Төслийн 1, 4, 5, 6, 9, 15, 16, 19, 20, 22, 23, 24, 25, 27, 34, 35, 37, 43, 47, 48, 49, 50, 52, 56, 57, 58, 59, 61, 65, 73, 75, 78, 79, 87, 89, 100, 108 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа, Б.Пүрэвдорж, Д.Ганбат, Н.Алтанхуяг, Ц.Сандаг-Очир, Л.Мөнхбаатар, С.Амарсайхан, Х.Нямбаатар, Б.Энх-Амгалан, Б.Дэлгэрсайхан, Ц.Мөнх-Оргил, С.Бямбацогт, Б.Энхбаяр, Ц.Мөнхцэцэг, Д.Цогтбаатар, Ж.Сүхбаатар нарын тавьсан асуултад Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ш.Адьяа, Н.Алтанхуяг, Ц.Мөнх-Оргил, Ж.Сүхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Атарцэцэг, Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт, Д.Мөнхтуяа, Б.Ундрах, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, судлаач О.Мөнхсайхан нар хариулж тайлбар хийв.

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ш.Адьяа, Н.Алтанхуяг, Ц.Мөнх-Оргил, Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир, Ж.Сүхбаатар /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, 1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “эрүү, иргэн, захиргаа зэрэг” гэснийг хасаж, 3.1.5, 3.1.6 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.3.5 дахь заалт, мөн зүйлийн 43.4, 43.5 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 44 дүгээр зүйл болгож, 74 дүгээр зүйлийн 74.1.3 дахь заалтын “сэлгэн ажиллуулах,” гэснийг хасах:

“44 дүгээр зүйл.Шүүгчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах

44.1.Шүүхийг татан буулгасан, өөрчлөн зохион байгуулсан, тухайн шүүхийн шүүгчийн орон тоо цөөрсөн тохиолдолд шүүгчийн өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн орон тоо дутуу байгаа адил шатны шүүхэд, адил шатны шүүхэд орон тоо байхгүй бол доод шатны шүүхэд шилжүүлэн томилж болно.

44.2.Шүүгчийг энэ хуулийн 44.1-д заасан үндэслэлээр шилжүүлэн томилуулах тухай саналаа Ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх бөгөөд саналыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тухайн шүүгчийг шилжүүлэн томилно.

44.3.Шүүгчийн мэргэжил, ур чадварыг сайжруулах, шүүн таслах ажиллагааны дадлага эзэмшүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн шүүгчийг адил шатны шүүхэд хоёр жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно.

44.4.Энэ хуулийн 44.3-т заасан үндэслэлээр шүүгчийг сэлгэн ажиллуулах журмыг Ерөнхий зөвлөл батална.

44.5.Шүүгч энэ хуулийн 44.3-т заасан сэлгэн ажиллах хугацаа дууссанаар урьд ажиллаж байсан шүүхэд эргэн ажиллах баталгаагаар бүрэн хангагдана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 2

Бүгд: 14

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.4.шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хангах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 1

Бүгд: 15

93.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.15-д заасны дагуу хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төсөлд “Шүүх Үндсэн хууль зөрчсөн тухай маргаантай асуудал болон Засгийн газрын улс төрийн шийдвэр, бодлогын асуудлаар гаргасан улс төрийн шийдвэрийг авч хэлэлцэхгүй.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Х.Нямбаатар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 8

Бүгд: 15

46.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйл, 14 дүгээр зүйлүүдийг нэгтгэж, доор дурдсанаар өөрчлөн найруулж, 14 дүгээр зүйл болгох:

“14 дүгээр зүйл.Шүүхийн тогтолцоо

14.1.Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу байгуулсан шүүх хэрэгжүүлнэ.

14.2.Монгол Улсын шүүхийн тогтолцоо зохион байгуулалтын хувьд бие даасан байх бөгөөд Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэнэ.

14.3.Шүүхийг шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнан байгуулж болох бөгөөд дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.

14.4.Анхан болон давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг тойргийн зарчмаар байгуулахад энэ хуулийн 15.4-т заасныг харгалзахаас гадна иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг хангах, шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 1

Бүгд: 15

93.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгүүдийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6.1 дэх хэсэг болгож, 6.4 дэх хэсгийн “тухайлсан” гэснийг, 6.5 дахь хэсгийн “гадаад, дотоодын хүн, хуулийн этгээдээс аливаа” гэснийг хасаж, 6.7 дахь хэсэгт “Шүүхийн төсвийн урсгал зардлын хэмжээг төсвийн хэмнэлтээс бусад тохиолдолд өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмж, 6.11 дэх хэсгийн “шүүн таслах ажиллагаанаас” гэснийг “шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхээс” гэж өөрчлөх:

“6.1.Шүүх нь шүүх эрх мэдлийг аливаа этгээдээс хараат бусаар хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 2

Бүгд: 16

87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “мэдээлж болно” гэснийг “мэдээлнэ. Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журмыг Ерөнхий зөвлөл батална.” гэж, 13.6 дахь хэсгийн “дамжуулах” гэснийг “нэвтрүүлж болох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 2

Бүгд: 16

87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3 дахь хэсгүүдийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 15.3 дахь хэсэг болгож, 15.4 дэх хэсгийн “тоог” гэсний өмнө “төрөл,” гэж нэмэх:

“15.3.Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний байршлыг тогтоох асуудлыг Улсын дээд шүүхтэй зөвшилцсөн

Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 4
Бүгд: 16
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “шүүн” гэсний өмнө “шүүгчийн” гэж нэмж, 16.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 16.4, 16.5 дахь хэсэг болгож, 16.5 дахь хэсгийн “Томилолтоор ажиллах нийтлэг журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.” гэснийг “Томилолтоор ажиллахтай холбоотой харилцааг хэрэг, маргаан хянан шийдвэрлэх холбогдох хуулиар зохицуулна.” гэж өөрчлөх:

“16.4.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн түр эзгүйд, эсхүл сул орон тоо гарсан тохиолдолд дараагийн Ерөнхий шүүгч томилогдох хүртэл хугацаанд түүнийг хамгийн олон жил шүүгчээр ажиллаж байгаа танхимын тэргүүн орлоно.

16.5.Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийн түр эзгүйд, эсхүл сул орон тоо гарсан тохиолдолд дараагийн Ерөнхий шүүгч сонгогдох хүртэл хугацаанд түүнийг шүүгчээр хамгийн олон жил ажиллаж байгаа танхимын тэргүүн, эсхүл шүүгч орлоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 3
Бүгд: 16
81.2 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын “түүний” гэснийг хасаж, 17.1.6 дахь заалтын “тусгай” гэсний өмнө “хууль хэрэглээний талаар” гэж, 17.1.9 дэх заалтын “Ерөнхий шүүгч,” гэсний дараа “танхимын тэргүүн,” гэж тус тус нэмж, 17.1.7, 17.1.11 дэх заалтуудыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 17.1.10 дахь заалтын “Шүүгчдийн зөвлөлийн төлөөлөгч,” гэснийг, “мэргэшлийн болон” гэснийг тус тус хасаж, 17.2 дахь хэсгийн “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь оролцогчдын хүсэлтээр зохих” гэснийг “хэрэг, маргаан хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар” гэж өөрчлөх:

“17.1.7.энэ хуулийн 20.1-д заасан Нийт шүүгчийн чуулганд оролцох;”

“17.1.11.багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 4
Бүгд: 16

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 18.1.3 дахь заалтын “шүүх хуралдааныг даргалах,” гэснийг хасаж, 18.1.4, 18.1.5 дахь заалтуудыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 18.1.4 дэх заалт болгож, 18.1.7, 18.1.8 дахь заалтуудыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 18.1.7-18.1.9 дэх заалт болгож, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 18.2 дахь хэсэг нэмж, 30 дугаар зүйлийг хасах:

“18.1.1.тухайн шүүхийг бүрэн эрхийнхээ хүрээнд төлөөлөх;

18.1.4.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамааралгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдолд Тамгын газраас хариу өгч байгаа ажиллагаанд хяналт тавих;

18.1.7.танхимын тэргүүний ажлыг уялдуулах;

18.1.8.шүүхийн практик, тоон мэдээлэлд үндэслэн шүүн таслах ажиллагааны чанар, үр дүн, хэргийн хөдөлгөөний ерөнхий удирдлага, хяналтын талаар Зөвлөгөөнд мэдээлэл хийх;

18.1.9.хуульд заасан бусад бүрэн эрх.”

“18.2.Ерөнхий шүүгч шүүн таслах ажиллагаанд оролцохдоо давуу эрх эдлэхгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 1

Бүгд: 16

93.8 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 19 дүгээр зүйл нэмж, 31, 33 дугаар зүйлүүдийг хасах:

“19 дүгээр зүйл.Танхимын тэргүүний бүрэн эрх

19.1.Танхимын тэргүүн энэ хуулийн 17.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.1.1.танхимыг тэргүүлж, шүүх хуралдааны бэлтгэл ажлыг хангахад танхимын шүүгч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын ажлыг уялдуулан зохион байгуулах;

19.1.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамааралгүй асуудлаар иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэхэд Тамгын газарт туслалцаа үзүүлэх;

19.1.3.хуульд заасан бусад бүрэн эрх.

19.2.Танхимын тэргүүн шүүн таслах ажиллагаанд оролцохдоо давуу эрх эдлэхгүй.

19.3.Танхимын тэргүүн бүрэн эрхийнхээ хүрээнд захирамж гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 2

Бүгд: 17

88.2 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19 дүгээр зүйл.Шүүгчдийн зөвлөгөөн

19.1.Шүүхэд тухайн шүүхийн нийт шүүгчээс бүрдсэн Зөвлөгөөн ажиллана.

19.2.Зөвлөгөөн дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

19.2.1.тодорхой хэрэг, маргаан хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн дотоод ажлын зохион байгуулалт, журмыг хуульд өөрөөр заагаагүй бол тогтоох;

19.2.2.шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоох;

19.2.3.шүүгчийг мэргэшүүлэх сургалтын саналаа энэ хуулийн 24.1-д заасан Хүрээлэнд хүргүүлэх;

19.2.4.тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийг шүүгчид дотроосоо сонгох;

19.2.5.энэ хуулийн 19.3-т заасан нөхцөл, шаардлага болон энэ хуулийн 20.2.4-т заасан нийтлэг журамд үндэслэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргаан хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журмыг батлах;

19.2.6.энэ хуулийн 18.1.8-д заасан мэдээлэлтэй танилцах;

19.2.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

19.3.Энэ хуулийн 19.2.5-д заасан журам нь хуваарилагдах шүүгчийг урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан байх бөгөөд дараах шаардлага хангасан программ хангамжийг ашиглана:

19.3.1.шүүх хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан даруй хуваарилалтыг хийх, Зөвлөгөөний шийдвэргүйгээр өөрчлөх боломжгүй хамгаалалттай байх, хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг оролцогч этгээдэд шууд өгөх боломжтой байх;

19.3.2.цахимаар хийгдсэн хуваарилалтыг гагцхүү хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар зөвшөөрөгдсөн татгалзал, эсхүл шүүгч, шүүх бүрэлдэхүүн солигдох бусад нөхцөлд өөрчлөх бөгөөд уг өөрчлөлт нь хүний нөлөөллөөс ангид, ил тод, баримтжуулсан байх.

19.4.Энэ хуулийн 19.2.5-д заасан журам олон нийтэд нээлттэй байна.

19.5.Зөвлөгөөн ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байх бөгөөд ээлжит зөвлөгөөнийг улиралд нэгээс доошгүй удаа, ээлжит бус зөвлөгөөнийг тухайн шүүхийн шүүгчдийн гуравны нэгийн, эсхүл танхимын, эсхүл Ерөнхий шүүгчийн саналаар хуралдуулна.

19.6.Шүүгч Зөвлөгөөнөөр хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцах, санал гаргах, хуралдаанд оролцох тэгш боломжоор хангагдах бөгөөд шийдвэр гаргах үйл явц нь нээлттэй, шуурхай, үндэслэл бүхий байна.

19.7.Зөвлөгөөн хуралдааныхаа дэгийг өөрөө тогтооно.

19.8.Тухайн шүүхийн шүүгчдийн дийлэнх олонх оролцсоноор Зөвлөгөөнийг хүчинтэйд тооцох бөгөөд энэ хуулийн 19.2-т заасан асуудлыг Зөвлөгөөнд оролцсон шүүгчдийн олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 3

Бүгд: 17

82.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 19 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

12-1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20 дугаар зүйл.Нийт шүүгчийн хуралдаан

20.1.Бүх шатны шүүхийн нийт шүүгчээс бүрдсэн хуралдааныг /цаашид “Нийт шүүгчийн хуралдаан” гэх/ дөрвөн жил тутам зохион байгуулна.

20.2.Нийт шүүгчийн хуралдаанаар дараах асуудлыг шийдвэрлэнэ:

20.2.1.Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгчийг сонгох, огцруулах;

20.2.2.шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөх хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналыг Улсын дээд шүүхэд уламжлах;

20.2.3.Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг сонсох;

20.2.4.энэ хуулийн 19.2.5-д заасан хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргаан хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журмыг батлах;

20.2.5.шүүхийн үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлыг авч хэлэлцэх, зөвлөмж гаргах.

20.3.Нийт шүүгчийн хуралдаан хуралдааны дэгээ өөрөө тогтооно.

20.4.Нийт шүүгчийн ээлжит бус хуралдааныг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн, эсхүл бусад шүүхийн Ерөнхий шүүгчдийн гуравны нэгийн, эсхүл нийт шүүгчийн тавны нэгээс доошгүйн саналаар хуралдуулна.

20.6.Нийт шүүгчийн хуралдаанд шүүгч биечлэн оролцох боломжгүй тохиолдолд түүнийг цахимаар санал өгөх боломжоор хангана.

20.7.Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны гишүүнд нэр дэвшигч шүүгчийг нууц санал хураалтаар сонгоно.

20.8.Нийт шүүгчийн хуралдааны шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

20.9.Нийт шүүгчийн хуралдааныг Улсын дээд шүүхийн Зөвлөгөөнөөс сонгосон хоёр, нийслэлийн эрүү, иргэн, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Зөвлөгөөн тус бүрээс сонгосон нэг, дүүргийн анхан шатны шүүхээс шүүгчээр хамгийн олон жил ажилласан хоёр шүүгч, Ерөнхий зөвлөл дотроосоо сонгосон шүүгч хоёр гишүүнээс бүрдсэн ажлын хэсэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ зохион байгуулна.

20.10.Ажлын хэсэг Нийт шүүгчийн хуралдааныг зохион байгуулж дуусах хүртэл ажиллах бөгөөд ахлагчаа дотроосоо нууц санал хураалтаар сонгоно. Ерөнхий зөвлөлийн ажлын алба хуралдааны зохион байгуулалтын асуудлаар Ажлын хэсэгт туслалцаа үзүүлэх бөгөөд хуралдааны материал архивлах асуудлыг хариуцна.

20.11.Нийт шүүгчийн чуулган даргалагчаа дотроосоо сонгоно.

20.12.Нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын саналыг тоолох тооллогын комисс ажиллана. Комиссын бүрэлдэхүүнд хяналтын болон давж заалдах шатны шүүхээс тус бүр хоёр, анхан шатны шүүхээс гурван шүүгчийг Нийт шүүгчийн хуралдаанаас нууц санал хураалтаар сонгох бөгөөд даргыг дотроосоо сонгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын тавьсанд асуултад Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 3
Бүгд: 16
81.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.15-д заасны дагуу хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, Төслийн 20 дугаар зүйлд заасан “шүүгчдийн зөвлөл” гэснийг “нийт шүүгчийн чуулган” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 4
Бүгд: 16
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12-2.Ажлын хэсгийн гаргасан, “20.5.Нийт шүүгчийн олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцох бөгөөд асуудлыг чуулганд оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн гаргасан, “20.5.Нийт шүүгчдийн дийлэнх олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцох бөгөөд асуудлыг хуралдаанд оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэнэ.” гэсэн саналаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.18-д заасны дагуу санал хураалт явуулаагүй болно.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн гарчгийн “бэлгэ тэмдэг,” гэснийг, мөн зүйлийн 21.2 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 2
Бүгд: 16
87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.3, 22.8, 22.9, 22.10 дахь хэсэг, 22.5 дахь хэсэгт “Хяналтын шатны шүүхийн шүүгч нь тусгай саналаа уг шүүхийн цахим хуудаст байршуулж, нийтлэх эрхтэй.” гэсэн 2 дахь өгүүлбэр тус тус нэмэх:

“22.3.Шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлал нь шүүхийн шийдвэрийн бүтэц, төрөл, агуулга, хэл найруулга, хууль зүйн техник, шүүхийн шийдвэр эшлэхэд

тавих шаардлага, талуудын шаардлага, татгалзал, тайлбарт маргаж байгаа үйл баримт болон хууль зүйн үндэслэл бүрд бүрэн дүгнэлт өгөх арга зүйг агуулсан байна.

22.8.Улсын дээд шүүхийн шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтэлнэ.

22.9.Олон нийтийг мэдээллээр хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг тайлбарлах зорилгоор шүүхийн шийдвэрийг олон нийтэд ойлгомжтой байдлаар мэдээлнэ.

22.10.Хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгч, шүүх бүрэлдэхүүн шүүхийн шийдвэрийг тухай бүр, ойлгомжтой байдлаар бичгээр болон биечлэн тайлбарлана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	4
Бүгд:	17

76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24 дүгээр зүйл. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн

24.1.Шүүхийн хэрэгцээ, судалгаанд тулгуурлан сургалт зохион байгуулах, шүүн таслах ажиллагааг сургалт, судалгаа, мэдээллээр хангах, Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад шаардагдах судалгаа хийх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал бэлтгэх, шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэх, олон нийтэд мэдээлэх үүрэг бүхий Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн /цаашид “Хүрээлэн” гэх/ Улсын дээд шүүхийн дэргэд ажиллана.

24.2.Хүрээлэн нь сургалтын хөтөлбөрийг боловсруулах чиг үүрэг бүхий бүх шатны шүүхийн шүүгч, Ерөнхий зөвлөл, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хууль зүйн их, дээд сургуулийн төлөөллөөс бүрдсэн орон тооны бус хороотой байна.

24.3.Хүрээлэнгийн бүтэц, орон тоо, ажиллах журам, шүүгчийн сургалтын хөтөлбөрийг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Шүүхийн ерөнхий зөвлөлтэй зөвшилцөн батална.

24.4.Зөвлөгөөн болон шүүгчийн өөрийнх нь саналыг үндэслэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг зургаан сар хүртэлх хугацаагаар судлаачаар ажиллуулж болох бөгөөд түүнд шүүгчийн цалин хөлсийг хэвээр олгож, шүүгчээр ажилласанд тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	4
Бүгд:	17

76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

16-1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “зэрэг” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 25.3 дахь хэсэг нэмж, 25.4 дэх хэсгийн “шүүгч” гэснийг “Ерөнхий шүүгч, шүүгч” гэж өөрчилж, 25.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 25.6, 25.7 дахь хэсэг болгох:

“25.3.Улсын дээд шүүх нь давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан үзэх замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангана.”

“25.6.Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.6.1.хуулиар тусгайлан харьяалуулсан тохиолдолд хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;

25.6.2.энэ хуулийн 25.6.1-д заасан болон хуульд заасан үндэслэл, журмын дагуу давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэсэн хэргийг давж заалдах журмаар хянан хэлэлцэх;

25.6.3.хуульд заасан үндэслэлээр Улсын дээд шүүхийн танхимын шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд шүүх бүрэлдэхүүнийг томилох;

25.6.4.хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох;

25.6.5.Улсын дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор давж заалдах шатны шүүхийн магадлалыг дараах тохиолдолд хяналтын журмаар хянан шийдвэрлэх:

25.6.5.1.анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;

25.6.5.2.хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;

25.6.5.3.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн.

25.7.Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагаанаас бусад асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.7.1.хуульд тусгайлан заасан тохиолдолд Улсын дээд шүүхэд хэрэг, маргааны төрлөөр дагнасан танхим байгуулах, бүрэлдэхүүнийг батлах;

25.7.2.давж заалдах шатны шүүхэд шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнасан танхим байгуулах асуудлыг тухайн шүүхийн Зөвлөгөөний саналыг

үндэслэн хэлэлцэж, шийдвэрлэх;

25.7.3.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон шүүхийн үйл ажиллагаа, эрх зүйн байдалтай холбогдсон хууль тогтоомжийн төсөлд саналаа хууль санаачлагчид хүргүүлэх, бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлагчид уламжлах;

25.7.4.шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг танхимын саналыг үндэслэн гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх;

25.7.5.хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх;

25.7.6.энэ хуулийн 75.2-т заасан Ерөнхий зөвлөлийн саналын дагуу, эсхүл энэ хуулийн 7.4-т заасан саналыг хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах;

25.7.7.Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх, эгүүлэн татах хуульд заасан үндэслэл бий болсноос хойш 30 хоногийн дотор санал гаргах;

25.7.8.хуульд заасан бусад бүрэн эрх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 3

Бүгд: 17

82.4 хувийн саналаар дэмжигдлээ.

16-2.Ажлын хэсгийн гаргасан, “25.3 дахь хэсгийн доошгүй гэснийг дээшгүй гэж өөрчлөх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 12

Бүгд: 17

29.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

16-3.Ажлын хэсгийн гаргасан, “Төслийн 25.4 дэх хэсгийн “шүүгч” гэснийг “ерөнхий шүүгч, шүүгч” гэж тус тус өөрчлөх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, Төслийн 25.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 2 дахь өгүүлбэр нэмэх:

“Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч нь Улсын дээд шүүхийн шүүн таслах ажиллагаанд танхим харгалзахгүй оролцоно.” гэсэн саналаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.18-д заасны дагуу санал хураалт явуулаагүй болно.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.15-д заасны дагуу хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, Төсөлд “улс төрийн намын бүртгэл хөтлөх.” гэсэн заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 1
Бүгд: 16
93.8 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Х.Нямбаатар нарын гаргасан, Төсөлд “25.6.5.4.хуулийн нэгдмэл хэрэглээг тогтооход зарчмын ач холбогдолтой бол” гэсэн дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, Б.Энхбаяр нар үг хэлж, Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, судлаач О.Мөнхсайхан нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 12
Бүгд: 16
25.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн гаргасан, Төсөлд “25.6.5.4.Улсын дээд шүүх нь авлига, албан тушаал, мөнгө угаах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, хүн амины, байгаль орчны эсрэг гэмт хэргийг хяналтын журмаар шийдвэрлэж болно.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 10

Бүгд: 16
37.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, Ажлын хэсгийн 12 дахь саналын томъёоллын 20 дугаар зүйлийн “нийт шүүгчдийн хуралдаан” гэснийг “нийт шүүгчийн чуулган” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 2
Бүгд: 16
87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, “Төслийн 25.3 дахь хэсгийн “24-өөс доошгүй” гэснийг “24” гэж өөрчлөх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 3
Бүгд: 16
81.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаан 13 цаг 45 минутаас 15 цаг 00 минут хүртэл түр завсарлав.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “25.6.3, 25.6.4, 25.6.5, 25.6.6, 25.6.7, 25.6.8, 25.6.9, 25.6.10-т” гэснийг “25.6.3, 25.6.4, 25.7-д” гэж, 26.2 дахь хэсгийн “түүний түр эзгүйд,” гэснийг “эсхүл энэ хуульд заасны дагуу түүний” гэж өөрчилж, 26.4 дэх хэсгийн “асуудлыг” гэсний дараа “нийт шүүгчийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.1.1-27.1.5 дахь заалтуудыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 27.1.1-27.1.7 дахь заалт болгох:

27.1.1.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан, Зөвлөгөөн зарлах, бэлтгэлийг хангах, даргалах;

27.1.2.Улсын дээд шүүхийг гадаад харилцаанд төлөөлөх;

27.1.3.Улсын дээд шүүхийн шүүгчид гадаад, дотоод ажлын томилолт олгох;

27.1.4.танхим хоорондын ажлыг уялдуулан зохион байгуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас бусад шаардлагатай гэж үзсэн асуудлыг

хэлэлцүүлэхээр танхимд хуваарилах;

27.1.5.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн зөвлөгөөнд танилцуулснаар Тамгын газрын дарга, Хүрээлэнгийн захирлыг томилох, чөлөөлөх;

27.1.6.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан, Зөвлөгөөнөөс гаргасан шийдвэрийн дагуу Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газартай Улсын дээд шүүхийг төлөөлөн харилцах;

27.1.7.хуульд заасан бусад бүрэн эрх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.15-д заасны дагуу хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 27.1.7-д “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх талаар гаргасан өргөдөл, гомдолд Дээд шүүхийн ерөнхий шүүгч албан бичгээр хариу өгөх.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.2 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28 дугаар зүйл.Улсын дээд шүүхийн танхимын бүрэн эрх

28.1.Улсын дээд шүүхийн танхим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиар тогтоосон журамд нийцүүлэн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.1.1.хуульд өөрөөр заагаагүй бол хэргийн харьяаллыг тогтоох;

28.1.2.хяналтын шатны шүүхийн тогтоолд үг, үсэг, тооны зэрэг техникийн шинжтэй алдаа гарсан бол залруулга хийх;

28.1.3.шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах саналыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанд оруулах;

28.1.4.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан, Зөвлөгөөн зарлан хуралдуулах талаар Ерөнхий шүүгчид санал гаргах;

28.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 2

Бүгд: 16

87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 29.5.1 дэх заалтын “хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан гомдол, прокурорын эсэргүүцлийг үндэслэн” гэснийг “хуульд заасны дагуу” гэж, 29.4 дэх хэсгийн “шүүгч” гэснийг “Ерөнхий шүүгч, шүүгч” гэж тус тус өөрчилж, 29.5.3 дахь заалтын “мэдээлэл, зөвлөмж гаргуулах,” гэснийг хасаж, доор дурдсан агуулгатай 29.5.3 дахь заалт нэмэх:

“29.3.Давж заалдах шатны шүүх шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнасан танхимтай байж болно. Танхимыг тухайн шүүхийн Зөвлөгөөний саналыг үндэслэн Улсын дээд шүүхийн шийдвэрээр байгуулж, бүрэлдэхүүнийг тухайн шүүхийн Зөвлөгөөн батална.”

“29.5.3.хуульд өөрөөр заагаагүй бол хэргийн харьяаллын талаар доод шатны шүүх хооронд гарсан маргааныг шийдвэрлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 3

Бүгд: 16

81.2 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “дүүргийн” гэсний дараа “шүүх” гэж нэмж, 32.3 дахь хэсгийн “тодорхой хэрэг, маргааны төрлөөр” гэснийг “шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнасан” гэж өөрчилж, 32.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 32.5 дахь хэсгийн “нүүдэллэн ажиллаж” гэснийг “шүүх хуралдааныг шүүхийн байрнаас бусад газарт хийж” гэж өөрчлөх:

“32.4.Энэ хуулийн 32.3-т заасан танхимыг тухайн шүүхийн Зөвлөгөөний саналыг үндэслэн Улсын дээд шүүхийн шийдвэрээр байгуулж, бүрэлдэхүүнийг тухайн шүүхийн Зөвлөгөөн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 3

Бүгд: 16

81.2 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалтын “гэмт хэрэгт холбогдоогүй буюу” гэснийг хасаж, 34.2 дахь хэсгийн “жагсаалтыг” гэснийг “жагсаалт болон энэ хуулийн 41.2.2-т заасан эрүүл мэндийн шалтгааныг тогтоох журмыг” гэж, 34.4 дэх хэсгийн “шаардлагыг” гэснийг “шаардлагын аль нэгийг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 34.4.3 дахь заалт нэмж, 34.5, 34.6 дахь хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34.4.3.магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн их, дээд сургуульд 10-аас доошгүй жил багшилсан.”

“34.5.Сүүлийн зургаан жилд улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан хүнийг шүүгчээр томилохыг хориглоно.

34.6.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн гуравны хоёроос доошгүй нь энэ хуулийн 34.4.1-д заасан шүүгч байна. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 3

Бүгд: 16

81.2 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.1-35.4 дэх хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 35.1-35.5 дахь хэсэг болгох:

35.1.Хуульчдаас шүүгчийг шилж олох, сонгон шалгаруулах, шүүгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх ажлыг Ерөнхий зөвлөл нээлттэй, ил тод, хараат бус байх, хууль дээдлэх зарчмыг баримтлан зохион байгуулна.

35.2.Ерөнхий зөвлөл дараах хугацаанд шүүгчийн сонгон шалгаруулалтын зарыг өөрийн цахим хуудас болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ:

35.2.1.шүүгч энэ хуулийн 49.6-д заасны дагуу өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол тэтгэвэр тогтоолгох өдрөөсөө 120-оос доошгүй хоногийн өмнө Ерөнхий зөвлөлд мэдэгдэх бөгөөд орон тоо гарахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө;

35.2.2.шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрэхээр байгаа бол орон тоо гарахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө;

35.2.3.энэ хуулийн 35.2.1, 35.2.2-т зааснаас бусад үндэслэлээр шүүгчийн сул орон тоо гарсан бол тухайн өдрөөс хойш 14 хоногийн дотор.

35.3.Энэ хуулийн 35.2-т заасан зард шүүгчийн сул орон тоонд нэр дэвшүүлэх болзол, шаардлага, өргөдөл, хавсралт баримт бичгийг хүлээн авах, бүртгэх, сонгон шалгаруулах хугацаа, журам, газрыг тодорхойлсон байна.

35.4.Энэ хуулийн 35.2-т заасан зарыг тухайн шүүгчийн ажиллах аймаг, нийслэлийн өдөр тутмын хэвлэлд нийтэлж болно.

35.5.Ерөнхий шүүгч тухайн шатны шүүхийн шүүгч, эсхүл өөрөө шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрэхээс 120-оос доошгүй хоногийн өмнө, бусад тохиолдлоор шүүгчийн сул орон тоо гарсан бол Ерөнхий зөвлөлд ажлын таван өдрийн дотор мэдэгдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 2

Бүгд: 14

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36 дугаар зүйл.Шүүгчид нэр дэвшигчийг өргөн мэдүүлэх

36.1.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 89.8-д заасан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор тухайн эрэмбийн дагуу зарлагдсан орон тоогоор анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг шүүгчээр томилуулах тухай саналыг Ерөнхийлөгчид, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах тухай албан бичгийг Улсын Их Хуралд холбогдох баримт бичгийн хамт хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 2

Бүгд: 14

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

25-1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 37.2 дахь хэсэг нэмж, 37.2 дахь хэсгийн “хуульд” гэснийг “энэ хуулийн 34 дүгээр зүйлд” гэж өөрчилж, 37.4, 37.5 дахь хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулах, 37.4-37.7 дахь хэсэг болгох:

“37.2.Улсын Их Хурал Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй дараах журмаар танилцана:

37.2.1.шүүгчид нэр дэвшигчийн танилцуулга, холбогдох баримт бичгийг Улсын Их Хурал чуулганы үеэр хүлээн авсан бол 14 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт хүлээн авсан бол ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/ нэр дэвшигчийн талаарх танилцах сонсголын товыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлаж, нэр дэвшигчийн танилцуулга, холбогдох баримт бичгийг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах бөгөөд хувь хүний нууцад хамаарах мэдээллийг нийтлэхгүй;

37.2.2.энэ хуулийн 37.2.1-д заасны дагуу танилцах сонсголын товыг нийтэд зарласнаас хойш 14 хоногийн дотор сонирхсон этгээд шүүгчид нэр

дэвшигчээс асуух асуулт, саналаа Байнгын хороонд ирүүлж болох бөгөөд нэргүй асуулт, саналыг хүлээн авахгүй;

37.2.3.Байнгын хороо энэ хуулийн 37.2.2-т заасан хугацаа өнгөрснөөс хойш 14 хоногийн дотор танилцах сонсголыг зохион байгуулах бөгөөд зохион байгуулах журмыг Байнгын хороо батлах;

37.2.4.энэ хуулийн 37.2.3-т заасны дагуу танилцах сонсгол зохион байгуулснаас хойш 14 хоногийн дотор шүүгчид нэр дэвшигч болон сонсголын тайланг Байнгын хороогоор хэлэлцэж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах;

37.2.5.энэ хуулийн 37.2.4-т заасны дагуу чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулснаас хойш ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын дарга нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулсан талаар Ерөнхийлөгчид албан бичгээр мэдэгдэх;

37.2.6.энэ хуулийн 37.2.1-д заасны дагуу шүүгчид нэр дэвшигчийн танилцуулга, холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор Улсын Их Хурал танилцах сонсгол зохион байгуулж танилцаагүй бол тухайн нэр дэвшигчийг танилцуулсанд тооцох бөгөөд уг хугацаа дууссан өдрөөс хойш 7 хоногийн дотор Ерөнхий зөвлөлийн дарга шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулсанд тооцсон талаар Ерөнхийлөгчид албан бичгээр мэдэгдэх.”

“37.4.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүх санал болгосноос хойш Ерөнхийлөгч 14 хоногийн дотор зургаан жилийн хугацаагаар, зөвхөн нэг удаа томилно.

37.5.Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг тухайн шүүхийн Зөвлөгөөнөөс нууц санал хураалтаар гурван жилийн хугацаагаар олонхын саналаар сонгох бөгөөд нэг удаа улируулан сонгож болно.

37.6.Энэ хуулийн 37.5-д заасны дагуу Ерөнхий шүүгчид нэр дэвшээгүй бол шүүгчээр хамгийн олон жил ажилласан шүүгчийг гурван жилийн хугацаагаар тухайн шүүхийн Зөвлөгөөнөөс томилно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	3
Бүгд:	13

76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

25-2.Ажлын хэсгийн гаргасан, “37.7.Танхимын тэргүүнийг тухайн шүүхийн Зөвлөгөөн дотроосоо нууц санал хураалтаар, гурван жилийн хугацаагаар сонгох бөгөөд түүнийг нэг удаа улируулан сонгож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, “Танхимын тэргүүнийг тухайн шүүхийн Зөвлөгөөний саналыг үндэслэн тухайн шүүхийн Ерөнхий шүүгч гурван жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө. Танхимын тэргүүнийг нэг удаа улируулан томилж болно.” гэсэн саналаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.18-д заасны дагуу санал хураалт явуулаагүй болно.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.15-д заасны дагуу хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяагийн гаргасан, “Анхан болон давах шатны шүүхийн шүүгчийг Ерөнхий зөвлөлийн санал болгосноор, хяналтын шатны шүүхийн шүүгчийг Ерөнхий зөвлөл Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 13
Бүгд: 13
0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы гаргасан, Төсөлд “90 хоногийн дотор Улсын Их Хурал танилцах сонсгол зохион байгуулсны дараа Ерөнхий зөвлөлийн дарга шүүгчид нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид бичгээр танилцуулна.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 8
Бүгд: 14
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн “мэргэшүүлэх” гэсний өмнө “гурван сар хүртэлх хугацаагаар” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “орон тооны” гэснийг хасаж, 40.5 дахь хэсгийн “сэргээнэ.” гэснийг “даруй сэргээж, энэ тухай Ерөнхий зөвлөлд мэдэгдэнэ.” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 40.5 дахь хэсэг нэмэх:

“40.5.Энэ хуулийн 40.4-т заасан үндэслэлээр бүрэн эрх нь түдгэлзсэн шүүгчид уг хугацаанд цалин хөлсийг 90 хувиар тооцож олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг, 41.2.9 дэх заалт, 41.5 дахь хэсгийг тус тус доор дурдсанаар өөрчлөн найруулж, 41.2.2 дахь заалтын “болон хүндэтгэн үзэх бусад” гэснийг хасаж, 41.2.3 дахь заалтын “өөр” гэснийг “өөрийн хүсэлтээр энэ хуулийн 40.1-д зааснаас бусад” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 41.6 дахь хэсэг нэмэх:

“41.1.Шүүгч хуульд заасан өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн, эсхүл шүүгчээр 25 жил ажилласан бол өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгож, чөлөөлөгдөж болно.”

“41.2.9.шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн.”

“41.5.Шүүгч огцорсон бол түүнийг шүүгчийн сонгон шалгаруулалтад оролцуулахгүй.”

“41.6.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч өөрийн хүсэлтээр албан тушаалаас чөлөөлөгдөх бол хүсэлтээ Улсын дээд шүүхийн Зөвлөгөөнд гаргах бөгөөд Зөвлөгөөн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл Ерөнхийлөгчид уламжилна. Ерөнхий шүүгч албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтийн үндэслэлээ олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 4

Бүгд: 14

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 42 дугаар зүйлийн гарчгийн “Шүүгчийн” гэснийг “Ерөнхий шүүгч, танхимын тэргүүн, шүүгчийн” гэж өөрчилж, 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 42.1, 42.2 дахь хэсэг болгох:

“42.1.Шүүгчийн бүрэн эрх дуусгавар болох хугацааг шүүгч өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн бол уг насанд хүрэх сарын сүүлийн өдрөөр, бусад үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох шийдвэр гарсан бол уг шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөр тоолно.

42.2.Ерөнхий шүүгч, танхимын тэргүүний бүрэн эрх дуусгавар болох хугацааг сонгогдсон хугацаа дуусгавар болох өдрөөр тоолно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	4
Бүгд:	14

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

30-1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “Шүүгчийн хараат бус байдал халдашгүй байх бөгөөд” гэснийг, 43.3.4 дэх заалтын “эрх зүйн байдлын онцлогт нь нийцүүлэн” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	7
Бүгд:	14

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх саналыг дахин хураалгах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	4
Бүгд:	14

71.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

30-1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “Шүүгчийн хараат бус байдал халдашгүй байх бөгөөд” гэснийг, 43.3.4 дэх заалтын “эрх зүйн байдлын онцлогт нь нийцүүлэн” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	4
Бүгд:	14

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

30-2.Ажлын хэсгийн гаргасан, “43.3.6.шүүгч өөрийн хүсэлтээр ахисан түвшинд мэргэшлээ дээшлүүлэх зорилгоор хоёр жил хүртэл хугацаагаар гадаад улсад

суралцах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх болсон тохиолдолд ажлын байр нь хэвээр хадгалагдах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

30-3.Ажлын хэсгийн гаргасан, “43.4.Шүүгчийг олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийн одонгоор шагнах, улсын тэтгэврийг өргөтгөн нэмэгдүүлэх тухай хуульд зааснаас бусад цол, одон, тэмдэг, шагнал олгохыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Н.Алтанхуяг, Х.Нямбаатар, Б.Дэлгэрсайхан нар үг хэлж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Атарцэцэг тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 7
Бүгд: 14
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлийн гарчгийг “Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага” гэж өөрчилж, Арван зургадугаар бүлэгт шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн “Мэргэшлийн болон” гэснийг, “ашгийн төлөө бус хуулийн этгээд, бусад” гэснийг, 45.5 дахь хэсгийг тус тус хасаж, 45.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 46 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 46.8, 46.9, 46.10 дахь хэсэг нэмэх:

“45.2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 11.1.6, 11.1.7, 11.1.8, 12.1.4-т заасан этгээд нь шүүгчтэй албан ажлаар уулзах тохиолдолд тэмдэглэл хөтөлж, баталгаажуулан тухайн байгууллагын нууцын асуудал хариуцсан албан тушаалтанд ажлын гурван өдрийн дотор өгөх үүрэгтэй. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэлэлцэх болон албан ёсны тэмдэглэл хийгдэх бусад үйл ажиллагааны явцад шүүгчтэй уулзсан тохиолдолд тэмдэглэл хөтөлж, баталгаажуулах үүргээс чөлөөлөгдөнө.”

“46.8.Шүүгч энэ хуулийн 46.1-д заасан нөлөөллийн мэдүүлгээс гадна энэ хуулийн 45.2-т заасан этгээдтэй уулзсан, харилцсан бөгөөд уг этгээд өөрөө, эсхүл бусдаар дамжуулан тухайн шүүгчид аливаа хэлбэрээр нөлөөлсөн, нөлөөлөхөөр

оролдсон, үүрэг, чиглэл өгсөн бол энэ талаарх бүхий л мэдээллийг агуулсан тэмдэглэл үйлдэн Ерөнхий зөвлөлд битүүмжлэн ажлын гурван өдрийн дотор хүргүүлэх үүрэгтэй.

46.9.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 46.8-д заасны дагуу битүүмжлэн ирүүлсэн тэмдэглэлийг хадгалах бөгөөд эрх бүхий байгууллага, эсхүл шүүгчийн хүсэлтээр холбогдох этгээдэд гарган өгнө.

46.10.Энэ хуулийн 46.8-д заасан үүргээ биелүүлээгүй нь шүүгчид сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 3

Бүгд: 14

78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 47 дугаар зүйлийн гарчгийн “Шүүгч” гэсний өмнө “Шүүх,” гэж нэмж, 47.2, 47.5 дахь хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 47.8 дахь хэсгийн “журам, шалгуур үзүүлэлтийг” гэснийг “шалгуур үзүүлэлт, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох” гэж өөрчлөх:

“47.2.Шүүгчийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн албанд ажилласан хугацааны, докторын зэргийн нэмэгдлээс бүрдэнэ. Шүүгчийн цалингийн хэмжээ шүүгчээр ажилласан тав дахь жилээс эхлэн жил бүр өмнөх оныхоос хоёр хувиар нэмэгдэнэ.”

“47.5.Шүүгчийн албан ёсны айлчлал, томилолт, төрийн ёслол, хүндэтгэл, энэ хуулийн 16.5-д заасны дагуу томилолтоор ажиллах болон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад арга хэмжээний зардлыг шүүхийн төсвөөс санхүүжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 0

Бүгд: 14

100 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 47 дугаар зүйлийн 47.9.1, 47.9.2 дахь заалтуудыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 47.9.1-47.9.3 дахь заалт болгох:

“47.9.1.Улсын дээд шүүх өөрийн, Ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхээс бусад шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Байнгын хороонд хянуулахаар хүргүүлэх;

47.9.2.Улсын дээд шүүх, Ерөнхий зөвлөл Байнгын хороогоор хянагдсан төсвийн төслийн эцсийн хувилбарыг улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасны дагуу хүргүүлэх;

47.9.3.Засгийн газар Улсын дээд шүүхийн болон бусад шүүхийн төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж, холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;" гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 48 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.2.1 дэх заалтын "өв залгамжлагчид" гэснийг "гэр бүлд" гэж өөрчилж, 49.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 49.7, 49.8 дахь хэсэг болгох:

"49.7.Шүүгчийг өндөр насны тэтгэвэрт гарахад түүний авч байсан сарын дундаж цалингийн хэмжээгээр 36 сарын хугацаагаар тооцож нэг удаагийн тэтгэмж олгох бөгөөд өндөр насны тэтгэврийн хэмжээг түүний авч байсан сарын дундаж цалин хөлсний 80 хувиар тогтооно. Шүүгчийн өндөр насны тэтгэвэртэй холбоотой бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

49.8.Шүүгчийн ээлжийн амралтын үндсэн болон нэмэгдэл амралтын хугацааг энэ хууль болон Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоох бөгөөд шүүгчээр ажилласан таван жил тутамд ажлын гурван өдрийн нэмэгдэл амралт олгоно." гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.15-д заасны дагуу хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 49.1 дэх хэсгийн "шүүгч эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн даатгалаас хэтэрсэн зардал, түүнчлэн өвчтэй эсвэл хөгжлийн бэрхшээлтэй болсон бол түүний цалин хөлсийг бүрэн хэмжээгээр олгоно." гэсэн 2 дахь өгүүлбэрийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн гаргасан, “49.6.шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах нас нь 60 байх, 55 насанд хүрсэн эсхүл шүүгчээр 25 жил ажилласан шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа, Б.Дэлгэрсайхан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн гаргасан, Төсөлд “Шүүгчээр 30 болон түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэсэн хоёр дахь өгүүлбэр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 51 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 51.2.3 дахь заалт нэмж, мөн зүйлийн 51.9 дэх хэсгийг хасах:

“51.2.3.ажил хэргийн нэр хүнд;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

38-1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “52.1.Шүүгчид дараах зүйлийг хориглоно:

52.1.1.албан тушаалын байдал, эрх нөлөөгөө урвуулан ашиглаж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгох;

52.1.2.албан үүрэгтэй нь холбоотой, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн нууцыг задруулах;

52.1.3.албан үүрэгтэй нь холбоотой, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн албаны, байгууллагын, хувь хүний нууцыг задруулах;

52.1.4.шүүхээр хянан хэлэлцэгдэж байгаа хэрэг, маргааны талаар шүүхийн шийдвэр гарахаас өмнө өөрийн байр суурийг олон нийтэд мэдээлэх, илэрхийлэх;

52.1.5.албан ажлын хэрэгцээнд зориулсан материал, техник хэрэгслийг шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс өөр зориулалтаар ашиглах;

52.1.6.бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн аливаа мэдээллийг шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс өөр зорилгоор ашиглах;

52.1.7.шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан бусад шүүгчийн шүүн таслах ажиллагаанд хуульд зааснаас бусад хэлбэрээр оролцох, нөлөөлөх, заавар, удирдамж, чиглэл өгөх, авах, урьдчилан санал хэлэх;

52.1.8.шүүгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хэргийн оролцогч, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч болон бусад иргэн, хуулийн этгээдээс шууд ба шууд бусаар тусламж авах, үйлчлүүлэх, давуу байдал, хөнгөлөлт, мөнгөн болон бусад урамшуулал, хууль тогтоомжоор зөвшөөрөгдөөгүй шагнал авах;

52.1.9.өөрийн, гэр бүлийн гишүүний, төрлийн хүний, эсхүл албан байгууллагын эрх ашиг хөндөгдсөнөөс бусад тохиолдолд гуравдагч этгээдийн хууль ёсны төлөөлөгч байх, хууль зүйн зөвлөгөө өгөх;

52.1.10.тухайн шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчтэй гэр бүл, эсхүл төрөл, садангийн холбоотой талаар Ерөнхий зөвлөлд мэдэгдэхгүйгээр ажиллах;

52.1.11.өөрөө, эсхүл итгэмжлэгдсэн этгээдээр дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, аж ахуйн нэгж, тэдгээрийн холбоо, нэгдлийн удирдах бүрэлдэхүүнд орох, зохион байгуулалтын үйл ажиллагаа явуулах;

52.1.12.Монгол Улсын олон улсын гэрээ, гадаад улсын шүүх, олон улсын болон гадаадын байгууллагатай харилцан тохиролцсоноос бусад гадаад улс болон олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүний санхүүжилтээр багшлах, эрдэм шинжилгээний болон бусад ажил эрхлэх, гадаад улсад зорчих;

52.1.13.гадаад улсын төр, олон нийтийн болон бусад байгууллагын шинжлэх ухааныхаас бусад хүндэт, тусгай цол, шагнал, одон, тэмдэг авах;

52.1.15.Монгол Улсын олон улсын гэрээгээр гадаад улсын холбогдох шүүх, олон улсын болон гадаадын байгууллагатай харилцан тохиролцсоноос бусад Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин байгаа гадаад улсын болон олон улсын байгууллага, түүний салбар нэгжийн удирдах бүрэлдэхүүнд орох;

52.1.16.багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсрах;

52.1.17.улс төрийн байгууллагын удирдах болон бусад албан тушаал эрхлэх, улс төрийн байгууллага, улс төрийн сонгуульд нэр дэвшигчийн талаар олон нийтэд хандаж үг хэлэх, сонгуулийн сурталчилгаанд оролцох, улс төрийн сонгуульд нэр дэвшигчид санхүүжилт, хандив өгөх;

52.1.18.хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах, харилцах;

52.1.19.хэргийн оролцогч болон бусад этгээдтэй харилцахдаа шүүхийн нэр хүнд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох хувийн дотно харилцаа тогтоох;

52.1.20.хэргийн оролцогч болон бусад этгээдтэй албан үүргийн хувьд харилцахдаа зүй бус авирлах, эсхүл хуралдааны дэг сахиулах хүрээнд бусдын зүй бус авирыг таслан зогсоох талаар шаардлага тавихгүй байх;

52.1.21.хуульд заасны дагуу олгосон бие хамгаалах тусгай хэрэгслийг зориулалтын бусаар ашиглах, бусдад ашиглуулах;

52.1.22.энэ хуулийн 19.2.2, 19.2.5-д заасан дараалал, журмыг санаатай зөрчих;

52.1.23.хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах;

52.1.24.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр албан ажлаа удаа дараа таслах;

52.1.25.шүүх хуралдаан, урьдчилсан хэлэлцүүлгийн товыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа зөрчих;

52.1.26.шүүхийн шийдвэр гаргахтай холбоотой хуульд тодорхой заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа 30 хоногоос дээш хугацаагаар, эсхүл нэг удаа 60 хоногоос дээш хугацаагаар зөрчих;

52.1.28.хуульд заасны дагуу татгалзан гарах үүрэгтэйгээ мэдсээр байж татгалзан гараагүй;

52.1.29.ажлын байранд болон албан үүргээ гүйцэтгэхдээ согтууруулах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, эсхүл ийм байдалтай ажилдаа ирэх;

52.1.30.шүүгчийн сахилгын хэрэг шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах;

52.1.31.хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээл зэргээр нь ялгаварлан гадуурхах, дарамт үзүүлэх;

52.1.32.хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээ ашиглахдаа шүүх, шүүгчийн нэр хүндэд харшилсан, эсхүл шүүхийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх санал, сэтгэгдэл, зураг, дууны, дуу-дүрсний бичлэг болон бусад хэлбэрийн мэдээ, мэдээлэл тараах, байршуулах;

52.1.33.шийдвэр гаргахаар зөвлөлдөх явцад бусадтай аливаа хэлбэрээр харилцах, зөвлөлдөх тасалгааны нууцыг задруулах;

52.1.34.шүүх хуралдааны явцад гар утас хэрэглэх зэрэг хэрэгт хамааралгүй өөр бусад үйл ажиллагаа явуулах;

52.1.35.шүүхийн ажилтан болон өөрийн удирдлага дахь этгээдэд албан үүрэгт нь хамааралгүй үүрэг даалгавар өгөх;

52.1.36.шүүхэд гэрчээр дуудагдсан хүн, эсхүл өөрийн удирдлага дахь ажилтны талаар тодорхойлохоос бусад тохиолдолд хүний зан байдал, ёс зүй, нэр төр, үр чадварын талаар тодорхойлох;

52.1.37.албан үүргээ гүйцэтгэхээс бусад тохиолдолд шүүгчийн үнэмлэх, тэмдэг ашиглан өөртөө давуу байдал бий болгох, хувийн хэрэгцээнд шүүгчийн үнэмлэх, тэмдэг ашиглах, барьцаа болгон үлдээх;

52.1.38.хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн талаар эргэлзээ төрүүлэхүйц ойлголтыг бусдад өгөх, нийтэд мэдээлэх;

52.1.39.энэ хуулийн 46.8-д заасан үүргээ биелүүлээгүй;

52.1.40.энэ хуулийн 68.6-д заасныг биелүүлээгүй. гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 1

Бүгд: 14

92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

38-2.Ажлын хэсгийн гаргасан, “52.1.14.төрийн дээд одон, медаль, шинжлэх ухааныхаас бусад хүндэт, цол, шагнал, одон, тэмдэг авах; хориглох;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

38-3.Ажлын хэсгийн гаргасан, “52.1.23.хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

38-4.Ажлын хэсгийн гаргасан, “52.1.27.шүүхийн шийдвэрт үндэслэл огт бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх ажлын хэсгийн 38 дугаар санал буюу төслийн 52 дугаар зүйлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 заасны дагуу мэтгэлцээн явуулсан болно.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 56.1, 56.2 дахь хэсэг болгож, 56.2 дахь хэсгийн “алдаа” гэсний өмнө “мэргэжлийн үйл ажиллагааны” гэж нэмж, 56.3 дахь хэсгийг хасаж, 57.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 58 дугаар зүйлийг хасах:

“56.1.Шүүгч зөвхөн хуульд захирагдах бөгөөд зөрчсөн бол хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

56.2.Шүүгчид зөвхөн энэ хуульд заасан үндэслэл, журмаар сахилгын шийтгэл оногдуулна.”

“57.1.Шүүхийн сахилгын хороо энэ хуулийн 52, 53.1, 54, 55 дугаар зүйлд заасан хориглосон, хязгаарласан, үүрэг болгосон зохицуулалтыг зөрчсөн /цаашид “сахилгын зөрчил” гэх/ шүүгчид сахилгын шийтгэл оногдуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.15-д заасны дагуу хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төсөлд “Улсын дээд шүүхийн шүүгч, дээд шүүхийн ерөнхий шүүгчийг Үндсэн хуулийн суурь зарчим иргэний үндсэн эрхтэй зөрчилдсөн үйл ажиллагаа явуулсан, хууль, мэргэжлийн ёс зүйгээ зөрчиж шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулсан гэх үндэслэлээр Улсын Их Хуралд импичмент хийж албан тушаалаас нь чөлөөлөх шийдвэр гаргасан бол огцорсонд тооцно.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 12
Бүгд: 15
20.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 59 дүгээр зүйлийн 59.1.3, 59.1.4, 59.6.1 дэх заалтуудыг доор дурдсанаар, мөн зүйлийн 59.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 59.2-59.5 дахь хэсэг болгож, 59.4 дэх хэсгийг хасах:

“59.1.3.цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах;

59.1.4.шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах;”

“59.6.1.энэ хуулийн 59.1.1, 59.1.2-т заасан шийтгэл оногдуулах зөрчлийг 10-аас дээш удаа, эсхүл энэ хуулийн 59.1.3, 59.1.4-т заасан шийтгэл оногдуулах зөрчлийг таваас дээш удаа гаргаж сахилгын шийтгэл хүлээсэн;”

“59.2.Энэ хуулийн 59.1.5-д зааснаас бусад шийтгэл оногдуулах сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш нэг жил, зөрчил гаргаснаас хойш хоёр жил өнгөрсөн бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулж болохгүй.

59.3.Энэ хуулийн 59.1.5-д заасан шийтгэл оногдуулах сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш хоёр жил, зөрчил гаргаснаас хойш таван жил өнгөрсөн бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулж болохгүй.

59.4.Шүүгчид сахилгын хэрэг үүсгэснээр энэ хуулийн 59.2, 59.3-т заасан хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсооно.

59.5.Энэ хуулийн 59.1.4-т заасан шийтгэл оногдуулсан шүүгчид сургалтад суух хугацаанд албан тушаалын цалинг 50 хувиар тооцож олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Улсын дээд шүүхийн шүүгч Б.Ундрах нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	2
Бүгд:	14

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 60 дугаар зүйл нэмэх:

“60 дугаар зүйл.Шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах

60.1.Энэ хуульд заасан сахилгын зөрчил гаргасан шүүгчид дараах сахилгын шийтгэлийг энэ хуулийн 59.5-д заасныг баримтлан оногдуулна:

60.1.1.энэ хуулийн 52.1.5, 52.1.21, 52.1.34, 52.1.35, 52.1.36, 52.1.37, 52.1.38, 52.1.40-д заасан зөрчилд хаалттай сануулах, эсхүл нээлттэй сануулах;

60.1.2.энэ хуулийн 52.1.13, 52.1.14, 52.1.20, 52.1.25, 52.1.29, 52.1.32, 52.1.33, 53.1-д заасан зөрчилд хаалттай сануулах, эсхүл нээлттэй сануулах, эсхүл цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах;

60.1.3.энэ хуулийн 52.1.3, 52.1.4, 52.1.9, 52.1.28-д заасан зөрчилд нээлттэй сануулах, эсхүл цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах;

60.1.4.энэ хуулийн 52.1.18, 52.1.19-д заасан зөрчилд нээлттэй сануулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах;

60.1.5.энэ хуулийн 52.1.22, 52.1.26, 52.1.31-д заасан зөрчилд нээлттэй сануулах, эсхүл цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах;

60.1.6.энэ хуулийн 52.1.15, 52.1.17, 52.1.23, 52.1.30, 55.1-д заасан зөрчилд цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах;

60.1.7.энэ хуулийн 52.1.6, 52.1.10, 52.1.12, 52.1.39, 54.1-д заасан зөрчилд хаалттай сануулах, эсхүл нээлттэй сануулах, эсхүл цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах, эсхүл огцруулах;

60.1.8.энэ хуулийн 52.1.8, 52.1.16, 52.1.24-д заасан зөрчилд цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах, эсхүл огцруулах;

60.1.9.энэ хуулийн 52.1.7, 52.1.11, 52.1.27-д заасан зөрчилд шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах, эсхүл огцруулах;

60.1.10.энэ хуулийн 52.1.1, 52.1.2-д заасан зөрчилд огцруулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 1

Бүгд: 14

92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 65 дугаар зүйлийн 65.5 дахь хэсгийн “үзэх шалтгаантай” гэснийг “шүүх хуралдаанд оролцох боломжгүй” гэж өөрчилж, 68 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 68.3-68.8 дахь хэсэг нэмэх:

“68.3.Иргэдийн төлөөлөгч хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх анхан шатны шүүхийн хуралдаанд оролцохдоо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

68.3.1.шүүх хуралдааны үед тодруулах асуулт тавих замаар нотлох баримт шинжлэхэд оролцох;

68.3.2.шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр шүүгдэгч, зохигч, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, прокурор, гэрч, шинжээчид асуулт тавих;

68.3.3.хэргийн үйл баримтад үнэлэлт өгч, шүүгдэгч, зохигчийн гэм буруутай эсэх талаар бичгээр дүгнэлт гаргах;

68.3.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

68.4.Иргэдийн төлөөлөгч энэ хуулийн 68.3.3-т заасан дүгнэлтийг бичгээр гаргах боломжгүй бол энэ тухай шүүх хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлж, дүгнэлтийг амаар гаргаж болно.

68.5.Иргэдийн төлөөлөгч энэ хуулийн 68.3.3-т заасан дүгнэлтээ шүүх хуралдаанд уншиж сонсгоно.

68.6.Шүүх бүрэлдэхүүн шийдвэр гаргахдаа иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг харгалзан үзнэ.

68.7.Шүүх бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичиж, уг дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгана.

68.8.Давж заалдах шатны шүүх хуульд заасан тохиолдолд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг харгалзан үзэж, энэ хуулийн 68.7-д заасны дагуу шийдвэртээ тусгана.

68.9.Шүүх бүрэлдэхүүн энэ хуулийн 68.7-д заасныг биелүүлээгүй бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсгийн “шүүгч” гэсний өмнө “шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах,” гэж, 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн “зорилго” гэсний өмнө “, хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах” гэж тус тус нэмж, 72.2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 72.2.3 дахь заалтын “эрх” гэснийг “хараат бус байдлыг хангах” гэж өөрчлөх:

“72.2.1.шүүхийн бие даасан байдлыг хангах,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 73 дугаар зүйлийн гарчгийг “Шүүхийн бие даасан байдлыг хангах” гэж, 73.1 дэх хэсгийн “захиргааны удирдлагын” гэснийг “шүүхийн бие даасан байдлыг хангах” гэж, 73.1.1 дэх заалтын “шүүх эрх мэдлийн”

гэснийг “шүүхийн бие даасан, шүүхийн хараат бус байдлыг хангах” гэж, 73.1.2 дахь заалтын “Засгийн газар болон Улсын дээд шүүхтэй зөвшилцөн Улсын Их Хуралд” гэснийг “Улсын дээд шүүхтэй зөвшилцөн Засгийн газарт” гэж өөрчилж, 73.1.23 дахь заалтыг 73.2 дахь хэсэг болгон шилжүүлж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 73.1.26, 73.1.27 дахь заалт нэмэх:

“73.1.26.хэргийн хөдөлгөөний удирдлагыг хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацаа, үзүүлэлт, ажиллагаанд байгаа хэргийн насжилт, тодорхой хэргийн хөдөлгөөний талаар хяналт-шинжилгээ хийх болон хуульд заасан бусад аргыг ашиглан хэрэгжүүлэх;

73.1.27.хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт болон шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг тогтоосон журмын дагуу хуваарилсан, томилсон эсэхэд хяналт тавих, улирал бүр нийтэд мэдээлэх, хүсэлт гаргасан этгээдэд уг мэдээллийг гаргаж өгөх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	2
Бүгд:	13

84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.15-д заасны дагуу хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, Төсөлд “73.1.27.Шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг орон сууцаар хангах хөтөлбөр баталж хэрэгжүүлэх.” гэсэн заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	4
Татгалзсан:	9
Бүгд:	13

30.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 74 дүгээр зүйлийн 74.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 74.1.5 дахь заалтын “болон шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн талаар дүгнэлт гаргах журам, шалгуурыг Мэргэшлийн хороотой хамтран” гэснийг “журам” гэж өөрчлөх:

“74.1.4.шүүгчийг сэлгэн ажиллуулах шийдвэр гаргах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	1
Бүгд:	13

92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

47.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 75 дугаар зүйлийн гарчгийн, 75.1 дэх хэсгийн “эрх” гэснийг “хараат бус байдлыг хангах” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 75.2-75.4 дэх хэсэг нэмэх:

“75.2.Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй үйл ажиллагаа явуулсан бол Ерөнхий зөвлөл даруй хуралдаж, Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргуулах саналыг Улсын дээд шүүхэд хүргүүлнэ. Улсын дээд шүүх Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлтээ гаргаж, шийдвэрлүүлнэ.

75.3.Энэ хуулийн 75.2-т зааснаас бусад этгээд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл үйл ажиллагаа явуулсан, шүүгчийн эрх ашгийг зөрчсөн тохиолдолд Ерөнхий зөвлөл даруй хуралдаж, дээрх шийдвэр, үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалахад зайлшгүй шаардлагатай арга хэмжээг хуульд заасны дагуу хүсэлт, гомдол, нэхэмжлэл, мэдэгдэл гаргах зэрэг хэлбэрээр авч хэрэгжүүлнэ.

75.4.Шүүгчийн эрх ашгийг зөрчсөн, хараат бус байдлыг алдагдуулсан талаар шүүгчээс Ерөнхий зөвлөлд хандан гомдол, хүсэлт гаргасан бол уг асуудлаар шүүгчийг төлөөлөн гомдол, нэхэмжлэл гаргах зэргээр холбогдох этгээдэд хандаж хуульд заасан журмын дагуу шийдвэрлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ц.Мөнх-Оргил нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 1

Бүгд: 13

92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

48-1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 78 дугаар зүйлийн 78.1-78.9 дэх хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 78.1-78.10 дахь хэсэг болгох:

“78.1.Ерөнхий зөвлөл орон тооны 10 гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллана.

78.3.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох шүүгч гишүүн нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан, сахилгын шийтгэлгүй, бусад гишүүд нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй, сүүлийн таван жил шүүгч, улс төрийн албан тушаал

болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байна.

78.4.Ерөнхий зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа сонгоно. Ерөнхий зөвлөлийн даргын сул орон тоо гарснаас хойш 14 хоногийн дотор даргыг сонгоно.

78.5.Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрх сонгогдож, томилогдсоноор эхэлж, дараагийн гишүүн сонгогдож, томилогдсоноор дуусгавар болно.

78.6.Ерөнхий зөвлөлийн нөхөн сонгогдсон, томилогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

78.7.Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа хуулиар тогтоосон хугацаанаас өмнө дуусгавар болсон бол өөр хүнийг энэ хуульд заасан журмын дагуу нөхөн сонгох, эсхүл нөхөн томилно.

78.8.Ерөнхий зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр нь бүрдсэнээр бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэлдэхүүнтэйд тооцно.

78.9.Ерөнхий зөвлөлийн гишүүн нь төрийн өндөр албан тушаалтны зэрэг, зиндаа, түүнтэй адилтгах албан тушаалтны зэрэглэлд тохирсон цалин хөлс, зайлшгүй шаардлагатай бусад хангамж эдэлж, хуульд заасан баталгаагаар хангагдана.

78.10.Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тус зөвлөлийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	0
Бүгд:	13

100 хувийн саналаар дэмжигдлээ.

48-2.Ажлын хэсгийн гаргасан, “78.2.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах болон анхан шатны шүүхээс тус бүр хоёр шүүгчийг Нийт шүүгчийн чуулганаас нууц санал хураалтаар сонгож, Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	4
Бүгд:	13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайханы гаргасан, “Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах болон анхан шатны

шүүхээс тус бүр хоёр шүүгчийг тухайн шатны шүүхийн шүүгчдээс сонгоно.” гэсэн саналаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.18-д заасны дагуу санал хураалт явуулаагүй болно.

49.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 79 дүгээр зүйлийн 79.1-79.10 дахь хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 79.1-79.19 дэх хэсэг болгох:

“79.1.Улсын Их Хурал Ерөнхий зөвлөлийн шүүгч биш гишүүнийг дараах журмаар нээлттэйгээр нэр дэвшүүлж, томилно:

79.1.1.Ерөнхий зөвлөлийн дарга тус зөвлөлийн шүүгч биш гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 120-оос доошгүй хоногийн өмнө, эсхүл гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсноос хойш ажлын гурван өдрийн дотор Байнгын хороонд болон олон нийтэд энэ тухай мэдэгдэх;

79.1.2.Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө, эсхүл гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсноос хойш 14 хоногийн дотор, хэрэв чуулганы чөлөө цагт эдгээр нөхцөл бий болсон бол ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор Байнгын хорооноос Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай зарыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх;

79.1.3.иргэн сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлснээс хойш 21 хоногийн дотор нэр дэвших тухай хүсэлтээ дараах баримт бичгийн хамт Байнгын хороонд хүргүүлэх:

79.1.3.а.Ерөнхий зөвлөлийн гишүүний хувьд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэлээ бичсэн тайлбар;

79.1.3.б.төрийн албан хаагчийн анкет;

79.1.3.в.мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга;

79.1.3.г.нийгмийн даатгалын дэвтэр, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;

79.1.3.д.энэ хуулийн 78.3-т заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бичиг.

79.1.4.Байнгын хороо нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудаст хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг байршуулах;

79.1.5.Байнгын хороо энэ хуулийн 79.1.4-т заасан мэдээллийг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхсон этгээдээс нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг хүлээн авах бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг бүртгэхгүй;

79.1.6.Байнгын хороо энэ хуулийн 79.1.2-т заасан зарыг нийтэд мэдээлснээс хойш 21 хоногийн дотор сонгон шалгаруулалтыг хараат бусаар зохион байгуулах чиг үүрэгтэй ажлын хэсэг байгуулах.

79.2.Ажлын хэсэг нь Улсын Их Хурал дахь олонх, цөөнх, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн сургалт, судалгааны байгууллага, хууль зүйн их, дээд сургуулийн санал болгосон төлөөллөөс бүрдсэн 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар томилсон Улсын Их Хурлын гишүүн ахална.

79.3.Ажлын хэсэг энэ хуулийн 79.1.2-т заасны дагуу зарыг нийтэд мэдээлснээс хойш 60 хоногийн дотор сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, Ерөнхий зөвлөлийн гишүүнд тавих шаардлагыг хамгийн сайн хангасан нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгоно.

79.4.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг дараах журмаар зохион байгуулна:

79.4.1.энэ хуульд заасан шаардлагыг хангасан нэр дэвшигчийг бүртгэн нийтэд мэдээлэх;

79.4.2.нэр дэвшигчийг тохиолдлын журмаар ажлын хэсгийн гишүүдэд тэнцвэртэй хуваарилж, илтгэгч гишүүнийг томилох;

79.4.3.илтгэгч гишүүн нь нэр дэвшигчийн баримт бичиг, олон нийтээс ирүүлсэн саналыг судлах, нэр дэвшигчтэй болон бусад этгээдтэй ярилцлага хийх зэргээр мэдээллийг бүрдүүлж, тухайн нэр дэвшигч Ерөнхий зөвлөлийн гишүүнд тавих шаардлагыг хангаж байгаа эсэх талаар дэлгэрэнгүй тайлан бичих;

79.4.4.ажлын хэсгийн гишүүд илтгэгч гишүүний тайлан болон холбогдох бусад баримт, мэдээлэлд үндэслэн нууцаар санал хураах;

79.4.5.энэ хуулийн 79.4.4-т заасан санал хураалтын дүнгээр ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг саналын дарааллаар эрэмбэлэн сул орон тоогоор болон дараагийн олонхын санал авсан хоёр хүртэлх хүний хамт нэр дэвшүүлж, Байнгын хороонд тайлангийн хамт ажлын гурван өдрийн дотор хүргүүлэх.

79.5.Байнгын хороо энэ хуулийн 79.4.5-д заасны дагуу ирүүлсэн тайланг хүлээн авснаас хойш дараах ажиллагааг хийнэ:

79.5.1.хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг агуулсан тайланг ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах;

79.5.2.энэ хуулийн 79.5.1-д заасны дагуу тайланг байршуулснаас хойш ажлын таван өдрийн дотор томилгооны сонсголын товыг зарлах;

79.5.3.тайланг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхогч этгээд нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг хүлээн авах бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг бүртгэхгүй;

79.5.4.энэ хуулийн 79.5.3-т заасан хугацаа өнгөрснөөс хойш 14 хоногийн дотор хуульд заасны дагуу томилгооны сонсголыг зохион байгуулах.

79.6.Энэ хуулийн 79.5.4-т заасны дагуу томилгооны сонсголыг хийснээс хойш ажлын таван өдрийн дотор нэр дэвшигчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилох эсэх талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

79.7.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нэр дэвшигчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилно.

79.8.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар нэр дэвшигчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилохоос татгалзсан бол ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчдээс дараагийн хамгийн олон санал авсан хүнийг энэ хуулийн 79.4.5-д заасны дагуу Улсын Их Хуралд нэр дэвшүүлнэ.

79.9.Энэ хуулийн 79.8-д заасан нөхцөлд ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигч байхгүй бол ажлын таван өдрийн дотор Байнгын хороо сонгон шалгаруулалт явуулах тухай зарыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, 90 хоногийн дотор энэ зүйлд заасан журмын дагуу сонгон шалгаруулалтыг дахин явуулна.

79.10.Улсын Их Хурлаас татгалзсан нэр дэвшигчийг дахин нэр дэвшүүлэхгүй.

79.11.Ерөнхий зөвлөлийн шүүгч биш гишүүнийг сонгон шалгаруулахтай холбоотой журмыг энэ хуульд нийцүүлэн Байнгын хороо баталж, Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулна.

79.12.Нийт шүүгчийн чуулган Ерөнхий зөвлөлийн шүүгч гишүүнийг дараах журмаар нэр дэвшүүлж, сонгоно:

79.12.1.Ерөнхий зөвлөлийн дарга тус зөвлөлийн шүүгч гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө, эсхүл гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсноос хойш ажлын таван өдрийн дотор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх;

79.12.2.Ерөнхий зөвлөлийн шүүгч гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө, эсхүл гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсноос хойш 14 хоногийн дотор Нийт шүүгчийн чуулганы товыг энэ хуулийн 20.4-т заасны дагуу зарлаж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх бөгөөд нийтэд мэдээлснээс хойш 45 хоногийн дараа Нийт шүүгчийн хуралдааныг зохион байгуулах;

79.12.3.Нийт шүүгчийн хуралдааны товыг нийтэд мэдээлснээс хойш 21 хоногийн дотор шүүгч Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвших тухай хүсэлтээ дараах баримт бичгийн хамт энэ хуулийн 20.9-д заасан ажлын хэсэгт хүргүүлэх:

79.12.3.а.Ерөнхий зөвлөлийн гишүүний хувьд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэлээ бичсэн тайлбар;

79.12.3.б.мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга.

79.12.4.ажлын хэсэг хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор Ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршуулах;

79.12.5.мэдээллийг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхогч этгээд нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг ажлын хэсэг хүлээн авах бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг бүртгэхгүй.

79.13.Нийт шүүгчийн чуулганд нэр дэвшигч нь хийх ажил, нэр дэвшсэн үндэслэлээ танилцуулж, оролцогчийн асуултад хариулна.

79.14.Нэр дэвшигчийн танилцуулга хийх дарааллыг тохиолдлын журмаар тогтоож, танилцуулга хийх, энэ хуулийн 79.12.5-д заасны дагуу ирүүлсэн асуултад хариулах ижил хугацааг нэр дэвшигч бүрд олгоно.

79.15.Нийт шүүгчийн хуралдаанд оролцогчид нийтээрээ, чөлөөтэй, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах бөгөөд санал хураалтыг цахим хэлбэрээр явуулж болно.

79.16.Нийт шүүгчийн хуралдаанд оролцогчдын олонхын санал авсан нэр дэвшигчдийг саналын дарааллаар эрэмбэлж, сул орон тоо гарсан тоогоор Ерөнхий зөвлөлийн гишүүнээр сонгогдсонд тооцно. Санал хураалтаар нэр дэвшигчдийн хэн нь ч оролцогчдын олонхын санал аваагүй бол дахин санал хураалт явуулж, хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцно.

79.17.Ажлын хэсэг энэ хуулийн 79.16-д заасан санал хураалт дууссанаас хойш ажлын гурван өдрийн дотор Нийт шүүгчийн чуулганы тогтоол, тэмдэглэлийг үйлдэж, Ерөнхий зөвлөлд хүргүүлнэ.

79.18.Энэ хуулийн 79.12.3-т заасан хугацаанд хүсэлт гаргаагүй шүүгчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээр сонгохыг хориглоно.

79.19.Ерөнхий зөвлөлийн гишүүнд шүүгчийг нэр дэвшүүлэх, сонгох ажиллагаанд шүүгчийн хараат бус, нээлттэй, ил тод байдлыг хангах, үүссэн асуудлыг шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай бусад асуудлыг энэ хуулийн 20.3-т заасан дэгээр зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2

Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.15-д заасны дагуу хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяагийн гаргасан, “Ажлын хэсэг нь Улсын Их Хурлын олонх, цөөнх, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Хуульчдын сургалт судалгааны байгууллага, Их, дээд сургуулийн санал болгосон төлөөллөөс бүрдсэн 11 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ажлын хэсгийг Төрийн албаны зөвлөлийн дарга ахална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 8
Бүгд: 12
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

50.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсгийн “архив, бүх шатны шүүхийн тамгын газарт түүний салбар” гэснийг хасаж, 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсгийн “хэлэлцэн” гэсний дараа “ил санал хураалт явуулж” гэж нэмж, 81.4 дэх хэсгийн “тав” гэснийг “гурав” гэж өөрчилж, 81.6 дахь хэсгийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 81.8 дахь хэсэг нэмэх:

“81.8.Ерөнхий зөвлөл хуульчдаас шүүгчийг шилж олох, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбогдуулан гаргасан шийдвэрээ тухай бүр, ажлын тайланг жил бүр өөрийн цахим хуудаст байршуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

51.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 82 дугаар зүйлийн 82.1.1 дэх заалтын “удирдах” гэснийг “уялдуулан зохицуулах” гэж, 82.1.11 дэх заалтын “Шүүгчдийн зөвлөлд” гэснийг “Нийт шүүгчийн хуралдаанд” гэж тус тус өөрчилж, 82.4 дэх хэсгийн “түр” гэснийг, “орон тооны” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

52.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 83 дугаар зүйлийн 83.1.1 дэх заалтын “орон тооны гишүүний хувьд” гэснийг хасаж, 83.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 83.1.6, 83.1.7 дахь заалт нэмэх:

“83.1.6.Ерөнхий зөвлөлийн хуралдаан болохоос ажлын гурваас доошгүй өдрийн өмнө холбогдох баримт бичгийг урьдчилан хүлээн авч танилцах;

83.1.7.хүндэтгэн үзэх шалтгаантай бол Ерөнхий зөвлөлийн хуралдаанд цахим хэлбэрээр оролцох, эсхүл саналаа бичгээр өгөх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

53.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 84 дүгээр зүйлийн 84.2.1 дэх заалтын “энэ хуулийн 20.2.3-т заасны дагуу сонгогдсоноос бусад гишүүн” гэснийг, 84.2.6 дахь заалтын “хороо болон Шүүхийн мэргэшлийн” гэснийг тус тус хасаж, 84.2.1 дэх заалтын “гурван” гэснийг “нэг” гэж, 84.2.2 дахь заалтын “үүсэхээс урьдчилан сэргийлэх” гэснийг “үүсгэх” гэж тус тус өөрчилж, 84.2.7 дахь заалтын “авах” гэсний дараа “, өөртөө аливаа давуу байдал бий болгохыг шаардах” гэж нэмж, 84.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 84.2.5-84.2.7 дахь заалт болгох:

“84.2.5.шүүн таслах ажиллагаа, шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх, хөндлөнгөөс оролцох;

84.2.6.нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтын болон үнэлгээ, шалгалтын баримт бичгийг урьдчилан ил болгох, тодорхой нэр дэвшигчийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр байр сууриа илэрхийлэх;

84.2.7.нэр дэвшигчийн үнэлгээг үндэслэлгүйгээр өөрчлөх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

54.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 85 дугаар зүйлийн гарчгийн “, эгүүлэн татах” гэснийг, 85.7 дахь хэсгийн “эгүүлэн татах,” гэснийг тус тус хасаж, мөн зүйлд дараах агуулгатай 85.2.3 дахь заалт нэмж, 85.3, 85.4, 85.5 дахь хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 85.3-85.8 дахь хэсэг болгох:

“85.2.3.энэ хуулийн 89.3-т заасны дагуу хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтад нэр дэвшигчийг урьдчилан мэдэх боломжгүй байх, хөндлөнгийн байдлаар үнэлэх нөхцөлийг зөрчсөн, эсхүл шалгалтын даалгаврын агуулга, нууцлалыг задруулсан;”

“85.3.Энэ хуулийн 85.2-т заасан зөрчил гарсан тухай өргөдөл, мэдээллийг Сахилгын хороонд гаргана.

85.4.Сахилгын хороо Ерөнхий зөвлөлийн гишүүний талаарх өргөдөл, мэдээллийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор сахилгын хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэнэ. Сахилгын хэрэг үүсгэсэн бол тухайн өргөдөл, мэдээллийн үндэслэлийг шалгах хараат бус шинжээч /цаашид “шинжээч” гэх/-ийг Сахилгын хороо томилно.

85.5.Шинжээч томилогдсоноосоо хойш 30 хоногийн дотор өргөдөл, мэдээлэлд дурдсан зөрчлийн талаарх баримт, мэдээллийг цуглуулж, хууль зүйн дүгнэлт гаргах бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

85.6.Шинжээч энэ хуулийн 85.2-т заасан сахилгын зөрчил гарсан байх үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан бол Сахилгын хороо уг дүгнэлтийг эрх бүхий этгээдэд даруй хүргүүлж, Ерөнхий зөвлөлийн гишүүнийг огцруулах эсэх асуудлыг дараах журмаар шийдвэрлэнэ:

85.6.1.Ерөнхий зөвлөлийн шүүгч гишүүнийг огцруулах асуудлыг энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан журмын дагуу хуралдааныг зохион байгуулж, Нийт шүүгчийн чуулганд оролцогчдын олонхын саналаар, нууцаар санал хурааж, шийдвэрлэх;

85.6.2.Ерөнхий зөвлөлийн шүүгч биш гишүүнийг огцруулах асуудлыг Байнгын хороогоор хэлэлцэж, санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх;

85.6.3.гэмт хэргийн шинжтэй бусад үйлдэл, эс үйлдэхүйг шалгуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх.

85.7.Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүний энэ хуулийн 84.1, 84.2-т заасныг зөрчсөн үйлдэлд огцруулах шийтгэл оногдуулахааргүй бол зөрчлийн шинж, хэр хэмжээнд тохируулан хаалттай, эсхүл нээлттэй сануулах шийтгэлийг Ерөнхий зөвлөл оногдуулах бөгөөд уг асуудлыг шийдвэрлэхэд тухайн гишүүнийг оролцуулахгүй.

85.8.Сахилгын хороо энэ хуулийн 84.1, 84.2-т заасныг зөрчсөн талаарх өргөдөл, мэдээллийг хүлээн авах, сахилгын хэрэг үүсгэх, шалгах, хянан шийдвэрлэх журмыг хараат бус, бодитой байх зарчимд нийцүүлэн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

55.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 88 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 36 дугаар зүйл болгон Наймдугаар бүлэгт шилжүүлэх:

“36 дугаар зүйл.Шүүгчид нэр дэвшигчийг бүртгэх

36.1.Энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан болзол, шаардлагыг хангасан гэж үзсэн иргэн энэ хуулийн 35.2-т заасны дагуу зарыг нийтэд мэдээлснээс хойш 30 хоногийн дотор шүүгчид нэрээ дэвшүүлэх эрхтэй.

36.2.Энэ хуулийн 36.1-д заасны дагуу өргөдөл гаргагч нь энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан болзол, шаардлагыг хангасан тухай баримтыг өргөдөл, анкет, мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга, оршин суугаа газрын хаяг, гэр бүлийн болон эд хөрөнгийн эрхийн лавлагаа, Монгол Улсын иргэний үнэмлэх, мэргэжлийн боловсролын диплом, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын дэвтэр, хөдөлмөр эрхлэлтийн талаарх болон бусад баримт бичгийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт Ерөнхий зөвлөлд цахимаар болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

36.3.Ерөнхий зөвлөл өргөдөл гаргагчийн бүрдүүлсэн баримт бичгийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор бүрэн гүйцэд, үнэн зөв эсэхийг нягтлан шалгаж, шүүгчид нэр дэвшигчээр бүртгэсэн, эсхүл бүртгэхээс татгалзсан тухай тогтоол гаргана.

36.4.Энэ хуулийн 36.3-т заасан тогтоол гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор нэр дэвшигчийн баримт бичгийг Ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршуулах бөгөөд хувь хүний нууцад хамаарах мэдээллийг нийтлэхгүй.

36.5.Энэ хуулийн 36.4-т заасан мэдээллийг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхсон этгээд нэр дэвшигчээс асуух асуулт, саналаа Ерөнхий зөвлөлд ирүүлэх бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг хүлээн авахгүй.

36.6.Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн мэдээллийг тухайн шүүхийн болон нутгийн захиргааны байгууллагын цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

36.7.Анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тавих болзол, шаардлагад нийцүүлэн бүрдүүлэх баримт бичиг болон бүртгэлтэй холбогдсон харилцааг энэ хуулийн 74.1.5-д заасан журмаар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

56.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 8 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 87 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 6
Бүгд: 12
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх саналыг дахин хураалгах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

56.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 8 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 87 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

57.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 89 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 37 дугаар зүйл болгон Наймдугаар бүлэгт шилжүүлэх:

“37 дугаар зүйл.Шүүгчид нэр дэвшигчийн шалгалт

37.1.Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийг энэ хуулийн 36.3-т заасны дагуу бүртгэснээс хойш 60 хоногийн дотор шүүгчид нэр дэвшигчийн шалгалт авна. Шүүгчид нэр дэвшигчийн шалгалт нь хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт болон мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтаас бүрдэнэ.

37.2.Хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтыг эрх зүйн тохиолдол шийдвэрлэх, сорилын асуултад хариулах, эрх зүйн баримт бичиг боловсруулах, хууль тайлбарлан хэрэглэх, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх зэрэг аргаас сонгон хэрэглэж, 70 хүртэлх оноогоор үнэлнэ. Анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн шалгалт ялгаатай байна.

37.3.Хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт нь нэр дэвшигчийг урьдчилан мэдэх боломжгүй, хөндлөнгийн байдлаар үнэлэх нөхцөлийг хангасан байх бөгөөд шалгалтын даалгаврын агуулга, нууцлалыг Ерөнхий зөвлөл хариуцна.

37.4.Энэ хуулийн 37.2-т заасан шалгалтад 50, түүнээс дээш оноо авсан нэр дэвшигчийг хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтад тэнцсэнд тооцож, тогтоол гарган мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтад оруулна.

37.5.Энэ хуулийн 37.4-т заасан тогтоол гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор хувь хүний нууцад хамаарахаас бусад нэр дэвшигчийн мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга болон холбогдох баримт бичгийг Ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршуулна. Ийнхүү байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхогч этгээд нэр дэвшигчийн талаарх саналаа Ерөнхий зөвлөлд хүргүүлж болох бөгөөд нэр, хаяггүй саналыг хүлээн авахгүй.

37.6.Энэ хуулийн 37.4-т заасан нэр дэвшигчийг тохиолдлын журмаар Ерөнхий зөвлөлийн гишүүн /цаашид “илтгэгч гишүүн” гэх/-д тэнцвэртэй хуваарилна. Илтгэгч гишүүн өөрт хуваарилагдсан нэр дэвшигчийн баримт бичиг, шүүн таслах болон бусад ажлын туршлага, шүүгчээр ажиллаж байсан нэр дэвшигчийн хувьд хянан шийдвэрлэсэн хэргийн шийдвэрийн чанар, олон нийтээс хүлээн авсан санал, нэр дэвшигчийн талаар бусад этгээдтэй болон нэр дэвшигчтэй хийсэн ярилцлагын дүн зэргийг судалсны үндсэн дээр тухайн нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг үнэлсэн үндэслэл бүхий тайлан бичиж, Ерөнхий зөвлөлийн бусад гишүүдэд хүргүүлж, хуралдаанд танилцуулна.

37.7.Ерөнхий зөвлөл нэр дэвшигчтэй ярилцлага хийсний дараа дараах зүйлийг үндэслэн нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг 30 хүртэл оноогоор үнэлэх бөгөөд 20, түүнээс дээш оноо авсан нэр дэвшигчийг уг шалгалтад тэнцсэнд тооцно:

37.7.1.нэр дэвшигчтэй хийсэн ярилцлага;

37.7.2.нэр дэвшигчийн баримт бичиг;

37.7.3.нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх хөндлөнгийн дүгнэлт;

37.7.4.олон нийтээс хүлээн авсан санал;

37.7.5.илтгэгч гишүүний тайлан;

37.7.6.бусад.

37.8.Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадвар болон мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалт тус бүрд өгсөн оноо, тэдгээрийн нийлбэр онооны дарааллаар эрэмбэлэн өөрийн цахим хуудаст байршуулж, нийтэд мэдээлнэ.

37.9.Энэ хуулийн 37.8-д заасан үнэлгээ хоёр жилийн хугацаанд хүчинтэй байна.

37.10.Шүүгчийн сонгон шалгаруулалт олон нийтэд ил тод байх бөгөөд шалгалттай холбогдуулан гаргасан Ерөнхий зөвлөлийн шийдвэр үндэслэл бүхий, оролцогч болон сонирхогч этгээдэд ойлгомжтой, нээлттэй байна.

37.11.Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчээс шалгалт авахдаа зохих журмын дагуу хөндлөнгийн хараат бус шинжээчийг оролцуулж болно.

37.12.Шалгалт авах арга, хэлбэр, үнэлэх аргачлал, нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх хөндлөнгийн дүгнэлт гаргах, олон нийтээс санал хүлээн авах болон холбогдох бусад харилцааг энэ хуулийн 74.1.5-д заасан журмаар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

58.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 91 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 91.1.9 дэх заалт нэмэх:

“91.1.9.иргэн, хуулийн этгээдээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасны дагуу шийдвэрлэж, хариу өгөх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

59.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 94 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 94.2 дахь хэсэг нэмэх:

“94.2.Улсын дээд шүүхийн шүүгч энэ хуулийн 94.1-д зааснаас гадна хэрэг, маргаан хянан шийдвэрлэхтэй холбоотой судалгаа хийх чиг үүрэг бүхий гурав хүртэлх судлаач туслахтай байх бөгөөд судлаач туслах нь хууль зүйн магистраас дээш зэрэгтэй, харьцуулсан эрх зүйн судалгаа хийх чадвартай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

60.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 100 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“100 дугаар зүйл.Шүүхийн сахилгын хороо

100.1.Энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий бие даасан байгууллага болох Шүүхийн сахилгын хороо /цаашид “Сахилгын хороо” гэх/ ажиллах бөгөөд улсын хэмжээнд нэг байна.

100.2.Сахилгын хороо орон тооны есөн гишүүнээс бүрдэнэ.

100.3.Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгч гишүүн нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан, сахилгын шийтгэлгүй, бусад гишүүн нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй, сүүлийн таван жил шүүгч, улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байна.

100.4.Сахилгын хорооны бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах шатны шүүхээс хоёр, анхан шатны шүүхээс нэг шүүгчийг Нийт шүүгчийн чуулганаас нууц санал хураалтаар сонгож, Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилох бөгөөд эдгээр гишүүн шүүгчээр ажиллаж байгаагүй иргэн байна.

100.5.Нийт шүүгчийн чуулган энэ хуулийн 79.12, 79.13, 79.14, 79.15, 79.16, 79.17, 79.18-д заасан журмаар Сахилгын хорооны шүүгч гишүүнийг нийтээрээ, чөлөөтэй, шууд, тэгш сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, олонхын саналаар сонгоно. Улсын Их Хурал энэ хуулийн 79.1, 79.2, 79.3, 79.4, 79.5, 79.6, 79.7, 79.8, 79.9, 79.10-т заасан журмыг баримтлан Сахилгын хорооны шүүгч биш гишүүнийг сонгон шалгаруулж, томилно.

100.6.Сахилгын хорооны шүүгч гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох ажиллагаанд хараат бус, нээлттэй, ил тод байдлыг хангах болон үүссэн асуудлыг шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай дэгийг Нийт шүүгчийн хуралдаан батална.

100.7.Сахилгын хорооны шүүгч биш гишүүнийг сонгон шалгаруулж, томилох ажиллагаанд хараат бус, нээлттэй, ил тод байдлыг хангах болон үүссэн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай журмыг Байнгын хороо энэ хуульд нийцүүлэн батална.

100.8.Сахилгын хорооны бүрэлдэхүүнд Ерөнхий зөвлөлийн гишүүн, шүүхийн захиргааны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, прокурор, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн болон сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан хүн орохыг хориглоно.

100.9.Сахилгын хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа зургаан жил байх бөгөөд зөвхөн нэг удаа сонгогдож, томилогдоно. Сахилгын хорооны гишүүний бүрэн эрх сонгогдож, томилогдсоноор эхэлж, дараагийн гишүүн сонгогдож, томилогдсоноор дуусгавар болно.

100.10.Сахилгын хорооны шүүгч биш гишүүний албан тушаалын зэрэг зиндаа, цалин хөлс, нэмэгдлийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.

100.11.Сахилгын хорооны даргыг гишүүд дотроосоо нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа сонгоно. Сахилгын хорооны даргын сул орон тоо гарснаас хойш 14 хоногийн дотор даргыг сонгоно.

100.12.Сахилгын хороо бүрэн эрхийнхээ хүрээнд өргөдөл, мэдээлэл, гомдол, эсэргүүцэл, сахилгын хэргийг дангаар болон хамтын зарчмаар хянан хэлэлцэж, илээр санал хурааж, шийдвэрээ олонхын саналаар гаргана.

100.13.Сахилгын хорооны дарга, гишүүн нь хүний нэр төр, алдар хүнд, эрх, эрх чөлөөг хүндэтгэх, шударга байх, төвийг сахих, хууль дээдлэх, ялгаварлан гадуурхахгүй байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, гишүүний нэр хүндээ эрхэмлэх зарчмыг баримтална.

100.14.Сахилгын хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байна.

100.15.Сахилгын хорооны гишүүдийн гуравны хоёр нь бүрдсэнээр түүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэлдэхүүнтэйд тооцно.

100.16.Сахилгын хорооны дарга, гишүүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд аливаа этгээд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, заавар өгөх, үйл ажиллагаанд нь саад учруулахыг хориглоно.

100.17.Сахилгын хороо ажлын албатай байх бөгөөд бүтэц, орон тоо, үйл ажиллагааг зохицуулах дүрэмтэй байна.

100.18.Сахилгын хороо бие даасан төсөвтэй байх бөгөөд чиг үүргээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нөхцөлийг төр хангана.

100.19.Сахилгын хороо хэвлэмэл хуудас, тамга, тэмдэгтэй байна.

100.20.Сахилгын хорооны шийдвэр хууль ёсны, үндэслэл бүхий байх бөгөөд захирамж, тогтоол, магадлал хэлбэртэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.15-д заасны дагуу хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн гаргасан, Төсөлд “Улсын Их Хурал Сахилгын хорооны шүүгч биш гишүүнийг сонгон шалгаруулалтыг Улсын Их Хурлын даргын захирамжаар томилсон Төрийн албаны зөвлөлийн дарга ахална.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 9
Бүгд: 12
25.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

61.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 101 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“101 дүгээр зүйл.Сахилгын хорооны зөвлөгөөн

101.1.Сахилгын хорооны нийт гишүүнээс бүрдсэн Сахилгын хорооны зөвлөгөөн ажиллана.

101.2.Сахилгын хорооны зөвлөгөөн дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

101.2.1.Сахилгын хорооны хөдөлмөрийн дотоод журмыг хуульд нийцүүлэн батлах;

101.2.2.гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн, Сахилгын хорооны хуралдаан болон хянан үзэх хуралдаан /цаашид “хуралдаан” гэх/ даргалагчийн дарааллыг тогтоох;

101.2.3.Сахилгын хорооны гишүүнийг мэргэшүүлэх сургалтыг төлөвлөх, зохион байгуулах;

101.2.4.Сахилгын хорооны даргыг гишүүд дотроосоо сонгох;

101.2.5.сахилгын хэрэг, өргөдөл, мэдээлэл, гомдол хүлээн авах, хуваарилах болон сахилгын хэрэг хянан шийдвэрлэх гишүүн, бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журмыг энэ хуулийн 19.3, 19.4-д заасан нөхцөл, шаардлагад нийцүүлэн батлах;

101.2.6.сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай журмыг энэ хуульд нийцүүлэн батлах;

101.2.7.Сахилгын хорооны зөвлөгөөний дэгийг тогтоох;

101.2.8.Сахилгын хорооны гишүүн гурван сараас дээш хугацаагаар эмчилгээ хийлгэх бол чөлөө олгох;

101.2.9.Сахилгын хорооны ажлын албаны даргыг томилох, чөлөөлөх;

101.2.10.энэ хуулийн 40.4, 51.8-д заасан саналыг хянан үзэж, шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэх, энэ хуулийн 40.5-д заасны дагуу шүүгчийн бүрэн эрхийг сэргээх;

101.2.11.Сахилгын хорооны ажлын албаны ажилтны ёс зүйн дүрмийг батлах;

101.2.12.энэ хуулийн 85.8, 120.2-т заасан журам, энэ хуулийн 100.17-д заасан дүрмийг батлах;

101.2.13.Сахилгын хорооны ажлын албаны хагас, бүтэн жилийн ажлын тайланг сонсох;

101.2.14.энэ хуулийн 85.4-т заасны дагуу Ерөнхий зөвлөлийн гишүүнд сахилгын хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх, сахилгын хэрэг үүсгэсэн тохиолдолд хараат бус шинжээч томилох;

101.2.15.энэ хуулийн 102.2.6-д заасан мэдээлэлтэй танилцах;

101.2.16.энэ хуульд заасан бусад мэдээлэл.

101.3.Сахилгын хорооны зөвлөгөөн нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байх бөгөөд ээлжит зөвлөгөөнийг улиралд нэгээс доошгүй удаа, ээлжит бус зөвлөгөөнийг Сахилгын хорооны дарга, эсхүл гишүүдийн гуравны нэгийн саналаар хуралдуулна.

101.4.Сахилгын хорооны гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор зөвлөгөөнийг хүчинтэйд тооцох бөгөөд энэ хуулийн 101.2-т заасан асуудлыг зөвлөгөөнд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

62.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 102 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“102 дугаар зүйл.Сахилгын хорооны гишүүн, даргын бүрэн эрх

102.1.Сахилгын хорооны гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд бүрэн эрхийнхээ хүрээнд захирамж гаргана:

102.1.1.хуралдааныг даргалах;

102.1.2.хуралдааныг товлон зарлах, хуралдуулах, сахилгын хэргийн оролцогчийг тогтоох;

102.1.3.хуралдааны бэлтгэлийг хангах ажлыг ажлын албатай хамтран зохион байгуулах;

102.1.4.бүрэлдэхүүнтэйгээр сахилгын хэрэг, гомдол, эсэргүүцэл хянан шийдвэрлэхэд оролцох;

102.1.5.бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байгаа сахилгын хэрэг, гомдол, эсэргүүцлийн талаар саналаа бие даан гаргах, тусгай саналтай бол бичгээр гаргаж, сахилгын хэрэгт хавсаргах;

102.1.6.сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасан дэг, журам, хугацааны дагуу явуулах нөхцөлийг бүрдүүлэх, хуралдааны дэг зөрчсөн сахилгын хэргийн оролцогч болон бусад этгээдэд хуульд заасан арга хэмжээ авах, шийтгэл оногдуулах;

102.1.7.Сахилгын хорооны даргад нэрээ дэвшүүлэх, хуульд зааснаар Сахилгын хорооны даргыг орлох;

102.1.8.багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх;

102.1.9.энэ хуульд заасан бусад бүрэн эрх.

102.2.Сахилгын хорооны дарга энэ хуулийн 102.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал, захирамж гаргана:

102.2.1.Сахилгын хороог дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

102.2.2.Сахилгын хорооны зөвлөгөөнийг товлон зарлах, бэлтгэлийг хангах, хуралдуулах, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

102.2.3.энэ хуульд өөрөөр заагаагүй бол хуралдааны даргалагч болон бүрэлдэхүүнийг томилсон шийдвэрийг албажуулах;

102.2.4.сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамааралгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдолд ажлын албаар дамжуулан хариу өгөх ажлыг зохион байгуулах;

102.2.5.Сахилгын хорооны гишүүнд энэ хуулийн 101.2.8-д зааснаас богино хугацааны чөлөө олгох эсэхийг Сахилгын хорооны зөвлөгөөнөөр хэлэлцүүлэн шийдвэрлэх, хөдөлмөрийн дотоод журамд заасан чөлөөг дангаар олгох;

102.2.6.өргөдөл, мэдээлэл, гомдол, эсэргүүцэл, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанар, үр дүн, сахилгын хэргийн хөдөлгөөний ерөнхий удирдлага, хяналтын талаар Сахилгын хорооны зөвлөгөөнд мэдээлэл хийх;

102.2.7.төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд төсвийн төсөл боловсруулж, хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

102.2.8.Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг нэгтгэж Сахилгын хорооны зөвлөгөөнд танилцуулах;

102.2.9.сахилгын хэргийн оролцогчоос гаргасан гишүүнийг татгалзан гаргах тухай хүсэлтийг энэ хуульд заасны дагуу шийдвэрлэх;

102.2.10.энэ хуульд заасан бусад бүрэн эрх.

102.3.Сахилгын хорооны даргыг түр эзгүйд, эсхүл сул орон тоо гарсан тохиолдолд дараагийн даргыг сонгох хүртэл Сахилгын хорооны хамгийн ахмад настай гишүүн орлоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

63.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 103 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 103, 104 дүгээр зүйл болгох:

“103 дугаар зүйл.Сахилгын хорооны дарга, гишүүний үүрэг, хориглох зүйл

103.1.Энэ хуулийн 100.13-т зааснаас гадна Сахилгын хорооны дарга, гишүүн дараах үүрэгтэй:

103.1.1.Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан чиг үүргээ хараат бусаар гүйцэтгэж, бусад гишүүний хараат бус байдалд хүндэтгэлтэй хандах;

103.1.2.албаны чиг үүргээ хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлэх;

103.1.3.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан албан тушаалтанд тавих хориглолт, хязгаарлалтыг дагаж мөрдөх;

103.1.4.энэ хуульд заасан бусад үүрэг.

103.2.Сахилгын хорооны дарга, гишүүнд дараах зүйлийг хориглоно:

103.2.1.илтгэгч гишүүнээр сонгогдсоноос бусад тохиолдолд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай харилцах, санаачилга гаргах, зөвшөөрөх;

103.2.2.бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулах, албан үүрэгтэйгээ холбоогүй зорилгоор ашиглах;

103.2.3.өөрийн, гэр бүлийн гишүүний эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөнөөс бусад тохиолдолд шүүхэд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, бусдыг төлөөлөх;

103.2.4.сахилгын хэргийн оролцогч болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдээс бэлэг, шан харамж, зээл, эд хөрөнгө, хандив, үйлчилгээ, бусад үнэ бүхий зүйл авах;

103.2.5.хараат бус, төвийг сахих байдалд харшлах улс төрийн үйл ажиллагаанд оролцох;

103.2.6.өөрийн, эсхүл бусдын ашиг сонирхлыг хангах зорилгоор албан тушаалын нэр хүндийг урвуулан ашиглах, зохисгүй байдал гаргах;

103.2.7.энэ хуулийн 52, 53.1, 54, 55, 84.2.1-д заасан хориглосон, хязгаарласан, үүрэгжүүлсэн зохицуулалтыг зөрчих;

103.2.8.энэ хуульд заасан бусад.

103.3.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Сахилгын хорооны дарга, гишүүн дараах тохиолдолд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах үүрэгтэй:

103.3.1.өргөдөл, мэдээллийг өөрөө, эсхүл түүний хамаарал бүхий этгээд гаргасан;

103.3.2.сахилгын хэргийн оролцогчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садан, эсхүл түүнтэй хувийн харилцаатай;

103.3.3.ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон;

103.3.4.тухайн хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал.

103.4.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх явцад Сахилгын хорооны гишүүний өөрийн, эсхүл сахилгын хэргийн оролцогчийн хүсэлтээр Сахилгын хорооны нэгээс илүү тооны гишүүнийг татгалзан гаргахыг хориглоно. Хуралдааны бүрэлдэхүүн хүрэлцэхээр байгаа бол энэ хуулийн 103.3-т заасан үндэслэлээр нэгээс илүү тооны Сахилгын хорооны гишүүнийг татгалзан гарах асуудлыг шийдвэрлэж болно.

103.5.Сахилгын хорооны дарга, гишүүнийг дараах үндэслэлээр огцруулна:

103.5.1.албан тушаалын байдал, эрх нөлөөгөө урвуулан ашиглаж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгосон;

103.5.2.албан үүрэгтэй нь холбоотой, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн нууцыг задруулсан;

103.5.3.гэм буруутайд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

103.5.4.энэ хуулийн 103.1, 103.2, 103.3-т заасныг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн.

103.6.Сахилгын хэрэгт шалгагдаж байгаа Сахилгын хорооны дарга, гишүүн энэ хуулийн 106.1.1-106.1.4-т заасан эрхийг эдэлнэ.

103.7.Сахилгын хорооны гишүүнийг бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан, эсхүл санал өгсөн шийдвэрийн агуулгад үндэслэн огцруулах, бусад сахилгын шийтгэл оногдуулахыг хориглоно.

104 дүгээр зүйл.Сахилгын хорооны гишүүнийг огцруулах, сахилгын бусад шийтгэл оногдуулах

104.1.Энэ хуулийн 103.5-д заасан зөрчил гарсан тухай өргөдөл, мэдээллийг Ерөнхий зөвлөлд гаргана.

104.2.Ерөнхий зөвлөл Сахилгын хорооны гишүүний талаарх өргөдөл, мэдээллийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор сахилгын хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх бөгөөд сахилгын хэрэг үүсгэсэн бол тухайн өргөдөл, мэдээллийн үндэслэлийг шалгах шинжээч томилно.

104.3.Шинжээч томилогдсоноосоо хойш 30 хоногийн дотор өргөдөл, мэдээлэлд дурдсан зөрчлийн талаарх баримт, мэдээллийг цуглуулж, хууль зүйн дүгнэлт гаргах бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

104.4.Шинжээч энэ хуулийн 103.5-д заасан сахилгын зөрчил гарсан байх үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан бол Ерөнхий зөвлөл уг дүгнэлтийг эрх бүхий этгээдэд даруй хүргүүлж, Сахилгын хорооны гишүүнийг огцруулах эсэх асуудлыг дараах журмаар шийдвэрлэнэ:

104.4.1.Сахилгын хорооны шүүгч гишүүнийг огцруулах асуудлыг энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан журмын дагуу хуралдааныг зохион байгуулж, Нийт шүүгчийн чуулганд оролцогчдын олонхын саналаар нууц санал хураалтаар шийдвэрлэх;

104.4.2.Сахилгын хорооны шүүгч биш гишүүнийг огцруулах асуудлыг Байнгын хороогоор хэлэлцэж, санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх.

104.5.Сахилгын хорооны дарга, гишүүн энэ хуулийн 103.1, 103.2, 103.3-т заасныг зөрчсөн үйлдэлд огцруулах шийтгэл оногдуулахааргүй бол зөрчлийн шинж, хэр хэмжээнд тохируулан зөрчилд хаалттай, эсхүл нээлттэй сануулах шийтгэлийг Сахилгын хороо оногдуулах бөгөөд уг асуудлыг шийдвэрлэхэд шалгагдаж байгаа гишүүнийг оролцуулахгүй. Зөрчлийн талаарх өргөдөл, мэдээллийг хүлээн авах, сахилгын хэрэг үүсгэх, шалгах, хянан шийдвэрлэх журмыг хараат бус, бодитой байх

зарчимд нийцүүлэн Ерөнхий зөвлөл батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

64.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 104 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“104 дүгээр зүйл.Сахилгын хорооны ажлын алба

104.1.Сахилгын хорооны ажлын албаны дарга хууль зүйн дээд боловсролтой, Төрийн албаны тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.

104.2.Ажлын алба Сахилгын хорооны дарга, гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

104.3.Ажлын албаны дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

104.3.1.ажлын албыг өдөр тутмын удирдлагаар хангах;

104.3.2.ажлын албаны ажилтанг томилж, чөлөөлөх;

104.3.3.төсвийг захиран зарцуулах;

104.3.4.ажлын тайланг Сахилгын хороонд тайлагнах;

104.3.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

104.4.Ажлын алба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

104.4.1.Сахилгын хороонд харьяалагдах өргөдөл, мэдээлэл, гомдлыг хүлээн авч бүртгэх;

104.4.2.өргөдөл, мэдээлэл гаргагчид сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцын талаар мэдээлэл өгөх;

104.4.3.Сахилгын хорооны болон ажлын албаны дарга, гишүүний өгсөн үүрэг, даалгаврыг зохих журмын дагуу шуурхай гүйцэтгэх;

104.4.4.захирамж, нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал, магадлал, тогтоол бэлтгэхэд Сахилгын хорооны гишүүнд туслэх;

104.4.5.Сахилгын хорооны гишүүнийг шаардлагатай хууль тогтоомж, мэдээллээр хангах;

104.4.6.Сахилгын хорооны дарга, гишүүнд техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх;

104.4.7.хуралдааны бэлтгэлийг зохион байгуулах, шийдвэрийг албажуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах;

104.4.8.энэ хуульд заасны дагуу захирамж, тогтоол, магадлал, албан бичиг, бусад баримт бичгийг холбогдох этгээдэд хүргэх;

104.4.9.Сахилгын хорооноос гаргасан шийдвэрийн талаар бүртгэл хөтөлж, тайлан гаргах;

104.4.10.сахилгын хэрэг, Сахилгын хорооны шийдвэр, албан бичиг, бусад баримт бичгийг хадгалах, хамгаалах, зохих журмын дагуу архивлах;

104.4.11.хуульд заасан бусад чиг үүрэг.

104.5.Ажлын албаны дарга, ажилтан ажлын албаны ажилтны ёс зүйн дүрмийг мөрдөхөөс гадна энэ хуулийн 103.1, 103.2, 103.3-т заасан зохицуулалт нэгэн адил хамаарна.

104.6.Энэ хуулийн 104.5-д заасан үүргээ ажлын албаны ажилтан зөрчсөн тухай өргөдөл, мэдээллийг ажлын албаны даргад, ажлын албаны дарга зөрчсөн тухай өргөдөл, мэдээллийг Сахилгын хорооны зөвлөгөөнд гаргана.

104.7.Энэ хуулийн 104.6-д заасныг зөрчсөн ажлын албаны дарга, ажилтанд Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

65.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 105 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“105 дугаар зүйл.Шүүгчид холбогдох сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ерөнхий нөхцөл

105.1.Сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь энэ хуулийн 57.1-д заасан сахилгын зөрчлийн тухай өргөдөл, мэдээлэл /цаашид “өргөдөл, мэдээлэл” гэх/-ийг хүлээн авах, сахилгын хэрэг үүсгэх, шалгах, Сахилгын хорооны хуралдаанаар хянан шийдвэрлэх, гомдол, эсэргүүцэл гаргах, гомдол, эсэргүүцлийг хянан шийдвэрлэх ажиллагаанаас бүрдэнэ.

105.2.Сахилгын хороо шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэхдээ хууль дээдлэх, шударга, ил тод, хараат бус байх, өргөдөл, мэдээллийг заавал хянан шийдвэрлэх зарчмыг мөрдлөг болгоно.

105.3.Энэ хуулийн 108.2-т заасны дагуу сахилгын хэрэг үүсгэсэн бол өргөдөл, мэдээллээсээ татгалзсан эсэхээс үл хамааран сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна.

105.4.Сахилгын хорооны хуралдаан зарлахаас өмнө өргөдөл, мэдээлэлд дурдагдаагүй шүүгчийн сахилгын зөрчлийн шинжтэй үйл баримт сахилгын хэрэг хянан шийдвэрлэх явцад илэрсэн бол түүнд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулна.

105.5.Сахилгын зөрчилд холбогдох шүүгч /цаашид “холбогдох шүүгч” гэх/, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийг сахилгын хэргийн оролцогч гэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

66.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 106 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“106 дугаар зүйл.Сахилгын хэргийн оролцогчийн эрх, үүрэг

106.1.Сахилгын хэргийн оролцогч сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах эрхтэй:

106.1.1.өргөдөл, мэдээлэл, сахилгын хэргийн баримттай танилцах, тэмдэглэл хийх, хуулбарлан авах, амаар болон бичгээр тайлбар гаргах, нотлох баримт гаргаж өгөх;

106.1.2.хуралдаанд биечлэн болон цахимаар оролцох, тайлбар гаргах, хуралдааныг хойшлуулах талаар хүсэлтийг нэг удаа бичгээр болон цахимаар гаргах;

106.1.3.Сахилгын хорооны гишүүн, хуралдааны бүрэлдэхүүнийг энэ хуульд заасан үндэслэлээр татгалзан гаргах хүсэлт гаргах;

106.1.4.Сахилгын хорооны гишүүний гаргасан захирамж, Сахилгын хорооны магадлалыг эс зөвшөөрвөл энэ хуульд заасны дагуу гомдол гаргах.

106.2.Сахилгын хэргийн оролцогч болон бусад этгээд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах үүрэгтэй:

106.2.1.сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, хуралдааны дэгийг сахих;

106.2.2.Сахилгын хорооны дуудсанаар хүрэлцэн ирэх;

106.2.3.үнэн зөв тайлбар өгөх;

106.2.4.Сахилгын хорооны шаардсан нотлох баримтыг гаргаж өгөх.

106.3.Сахилгын хэргийн оролцогч болон бусад этгээд хуралдааны явцад дууны, дуу-дүрсний бичлэг хийх, утсаар ярихыг хориглоно. Энэ хориглолт энэ хуульд заасны дагуу хуралдааны тэмдэглэл хөтлөх зорилгоор дууны, дуу-дүрсний бичлэг хийхэд хамаарахгүй.

106.4.Согтуурсан, мансуурсан этгээдийг хуралдаанд оруулахыг хориглоно.

106.5.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, хуралдааны дэг зөрчсөн этгээдэд хуралдаан даргалагч урьдчилан сануулна. Дахин зөрчил гаргасан этгээдийг хуралдаан даргалагч хуралдааны танхимаас гаргаж, энэ тухай хуралдааны тэмдэглэлд бичиж, хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

67.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 107 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“107 дугаар зүйл.Өргөдөл, мэдээлэл гаргах, хүлээн авах, хуваарилах

107.1.Сахилгын зөрчил гарсан гэж үзсэн хүн, албан тушаалтан, хуулийн этгээд холбогдох шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр Сахилгын хороонд өргөдөл, мэдээлэл гаргана.

107.2.Өргөдөл, мэдээллийг итгэмжлэгдсэн төлөөлөгч гаргасан бол төлөөлөх эрх олгосон баримт бичиг болон итгэмжлэлийг хавсаргана.

107.3.Сахилгын хороо өргөдөл, мэдээллийг хүлээн авч, хавсаргасан баримт, хуудасны тоог бүртгэх дэвтэрт бичиж, гарын үсэг зуруулан, баримт үйлдэх ба хуудасны тоо, огноо, цаг, минутыг тэмдэглэн баталгаажуулна.

107.4.Өргөдөл, мэдээллийг хүлээн авсан даруй энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар Сахилгын хорооны гишүүн /цаашид “илтгэгч гишүүн” гэх/-нд хуваарилна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 3

Бүгд: 12

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

68.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 108 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“108 дугаар зүйл.Сахилгын хэрэг үүсгэх, үүсгэхээс татгалзах, гомдол хянан шийдвэрлэх

108.1.Илтгэгч гишүүн дараах тохиолдолд сахилгын хэрэг үүсгэхээс татгалзах тухай захирамж гаргана:

108.1.1.энэ хуулийн 57 дугаар зүйлд заасан зөрчилд хамаарахгүй бол;

108.1.2.өргөдөл, мэдээлэлд заасан үйл баримт, шүүгчийн үйл ажиллагааны талаар, эсхүл уг өргөдөл, мэдээллийн дагуу сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосон Сахилгын хорооны гишүүний захирамж, Сахилгын хорооны магадлал, тогтоол, хянан үзэх хуралдааны тогтоол хүчин төгөлдөр байгаа;

108.1.3.өргөдөл, мэдээлэл гаргасан этгээд тодорхойгүй.

108.2.Илтгэгч гишүүн энэ хуулийн 108.1-д зааснаас бусад тохиолдолд өргөдөл, мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор сахилгын хэрэг үүсгэх эсэх тухай эсхүл үүсгэхээс татгалзах тухай захирамж гаргана

108.3.Сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан захирамжийг гаргаснаас хойш даруй өргөдөл, мэдээлэл гаргагчийн оршин суугаа газар болон ажлын газрын аль нэг хаягаар баталгаат шуудангаар, эсхүл ажлын албаны ажилтнаар хүргүүлнэ. Уг захирамжийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор өргөдөл, мэдээлэл гаргагч Сахилгын хороонд гомдол гаргаж болно. Энэ хугацааны дотор гомдол гаргаагүй бол захирамж хүчин төгөлдөр болно.

108.4.Илтгэгч гишүүний энэ хуулийн 108.2, 109.11-д зааснаас бусад захирамжид гаргасан гомдлыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар томилогдсон хоёр гишүүний бүрэлдэхүүн /цаашид “гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн” гэх/-тэйгээр хэлэлцэж шийдвэрлэнэ. Уг бүрэлдэхүүнд илтгэгч гишүүн орохыг хориглоно.

108.5.Илтгэгч гишүүн нь шүүгч гишүүн бол гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүний хоёр гишүүн нь шүүгч биш байна. Илтгэгч гишүүн нь шүүгч биш бол бүрэлдэхүүний нэг нь шүүгч, нөгөө нь шүүгч биш гишүүн байна.

108.6.Сахилгын хорооны гишүүнд гаргасан татгалзал, эсхүл бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 108.5-д заасан шаардлага хангагдахгүй болсон бол энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар Сахилгын хорооны гишүүнийг гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүнд оруулж болох бөгөөд илтгэгч гишүүнийг оруулахыг хориглоно.

108.7.Гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн дараах тогтоолын аль нэгийг гаргана:

108.7.1.захирамжийг хэвээр үлдээх, эсхүл захирамжийн үндэслэлийг өөрчлөн захирамжийг хэвээр үлдээх;

108.7.2.сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан захирамжийг хүчингүй болгож, сахилгын хэрэг үүсгэх.

108.8.Энэ хуулийн 108.7-д заасан тогтоолыг гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүний хоёр гишүүн санал нэгтгэйгээр гаргана. Санал нэгдээгүй бол захирамжийг хэвээр үлдээнэ.

108.9.Энэ хуулийн 108.8-д заасан тогтоол нь эцсийн шийдвэр байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	2
Бүгд:	12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

69.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 109 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“109 дүгээр зүйл.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

109.1.Сахилгын хэргийг үүсгэснээс хойш 60 хоногийн дотор, сахилгын хэргийг дахин шалгуулахаар буцааснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Энэ хугацааг шаардлагатай тохиолдолд 30 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.

109.2.Илтгэгч гишүүн сахилгын хэргийг үүсгэсний дараа доор дурдсан шалгах ажиллагаа явуулна:

109.2.1.сахилгын хэрэг үүсгэсэн захирамж, тогтоол гарсан өдрөөс хойш 14 хоногийн дотор уг захирамж, тогтоолыг өргөдөл, мэдээллийн хуулбарын хамт холбогдох шүүгчид гардуулж, эсхүл энэ хуулийн 115.6, 115.7-д заасан журмаар хүргүүлж, энэ тухай баримтжуулах;

109.2.2.сахилгын хэргийн оролцогчид эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухайгаа баримтжуулах;

109.2.3.сахилгын хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, гэрчийг дуудаж мэдүүлэг авах, шинжээч, орчуулагч, хэлмэрч томилох болон шаардлагатай бусад ажиллагаа явуулах;

109.2.4.сахилгын хэргийн оролцогчийг дуудан ирүүлэх;

109.2.5.сахилгын хэрэг хянан шийдвэрлэх бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах;

109.2.6.шаардлагатай тохиолдолд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх хугацааг энэ хуульд заасны дагуу сунгах;

109.2.7.шаардлагатай тохиолдолд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасны дагуу түдгэлзүүлэх, сэргээх;

109.2.8.энэ хуульд заасан бусад ажиллагаа.

109.3.Холбогдох шүүгч энэ хуулийн 108.2-т заасан сахилгын хэрэг үүсгэсэн тухай захирамж, тогтоолыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор өргөдөл, мэдээллийн талаар бичгээр хариу тайлбар, нотлох баримт, нотлох баримт гаргах хүсэлт гаргаж болно.

109.4.Нэг шүүгчид холбогдуулан гаргасан хэд хэдэн өргөдөл, мэдээлэл, эсхүл хэд хэдэн шүүгчид холбогдуулан гаргасан нэг агуулга бүхий өргөдөл, мэдээлэлтэй хэд хэдэн сахилгын хэргийг нэгтгэн шалгаж, хянан шийдвэрлэж болно. Нэгтгэн гаргасан, эсхүл хэд хэдэн өргөдөл, мэдээлэл гаргасан болон хэд хэдэн шүүгчид холбогдуулан гаргасан өргөдөл, мэдээллийн шаардлагатай нэг болон хэд хэдэн хэргийг тусгаарлаж болно.

109.5.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шаардсан нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээд илтгэгч гишүүнд гаргаж өгөх үүрэгтэй.

109.6.Илтгэгч гишүүн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1-д заасан үндэслэлээр сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг захирамж гарган түдгэлзүүлнэ. Түдгэлзүүлсэн нөхцөл байдал арилсан тохиолдолд илтгэгч гишүүн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээнэ.

109.7.Энэ хуулийн 109.6-д зааснаас бусад үндэслэлээр сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхийг хориглоно.

109.8.Сахилгын хэрэг шалгах ажиллагаа сахилгын хэргийн оролцогчоос бусад этгээдэд хаалттай байна.

109.9.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад энэ хуулийн 108.1, 108.2, 109.11-д зааснаас бусад асуудлаар гаргасан захирамжийг Сахилгын хорооны гишүүн ажлын гурван өдрийн дотор бичгээр гаргаж, сахилгын хэргийн оролцогчид даруй хүргүүлэх бөгөөд сахилгын хэргийн оролцогч уг захирамжийг хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор Сахилгын хороонд гомдол гаргах эрхтэй. Энэхүү захирамж илт үндэслэлгүй бол түүнийг гаргасан Сахилгын хорооны гишүүн хүчингүй болгох, эсхүл өөрчилж болно.

109.10.Сахилгын хэргийн оролцогч, эсхүл өргөдөл, мэдээлэл гаргагч энэ хуульд заасны дагуу илтгэгч гишүүний захирамжид гомдол гаргах хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтээ холбогдох нотлох баримтын хамт илтгэгч гишүүнд гаргах бөгөөд хүсэлтийг хангах эсэхийг илтгэгч гишүүн тухайн хүсэлтэд хавсаргасан баримтыг үндэслэн шийдвэрлэж, захирамж гаргана.

109.11.Сахилгын хэрэг үүсгэх тухай захирамж, тогтоол гаргаснаас хойш илтгэгч гишүүн 30 хоногийн дотор дараах дүгнэлт, саналын аль нэгийг Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамж гаргана:

109.11.1.сахилгын зөрчил гаргасныг нотлох дүгнэлт;

109.11.2.сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал.

109.12.Илтгэгч гишүүн энэ хуулийн 109.11-д заасан хугацааг зайлшгүй шаардлагатай тохиолдолд 30 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

70.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Арван зургадугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 110, 111, 112, 113 дугаар зүйл нэмэх:

“110 дугаар зүйл.Нотлох баримт бүрдүүлэх ажиллагаа

110.1.Илтгэгч гишүүн сахилгын хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах үүрэгтэй.

110.2.Сахилгын хороо сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргуулан авах эрхтэй бөгөөд холбогдох этгээд гаргаж өгөх үүрэгтэй.

110.3.Холбогдох шүүгч хариу тайлбарын үндэслэлийн талаар нотлох баримтаа гаргаж өгөх ба гаргаж өгөх боломжгүй, түүнчлэн мэдэгдээгүй нотлох баримтын эх сурвалжийг заах үүрэгтэй.

110.4.Сахилгын хэргийн оролцогч өргөдөл, мэдээлэлтэй холбоотой нотлох баримттай хуралдаан товлороос өмнө танилцах эрхтэй.

110.5.Сахилгын хэргийн оролцогч, өргөдөл, мэдээлэл гаргагч, илтгэгч гишүүн хуурамч, хуульд заасан арга хэрэгслээр олж аваагүй нотлох баримт гаргахыг хориглоно. Энэ хэсэгт заасныг зөрчсөн гэм буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

110.6.Сахилгын хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргийн нотлох баримтаас хасах бөгөөд уг баримтыг шаардан гаргуулж болохгүй.

110.7.Хилийн чанадад нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай бол сахилгын хэргийн оролцогчийн хүсэлтээр, эсхүл Сахилгын хорооны санаачилгаар эрх бүхий байгууллагаар дамжуулан тухайн улсын зохих байгууллагад хандаж болно.

110.8.Нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор, тухайн сахилгын хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв талаас нь үнэлнэ.

110.9.Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, эсхүл Сахилгын хорооны шийдвэрээр нэгэнт тогтоогдсон болон нийтэд илэрхий үйл баримт сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй.

110.10.Нотлох баримт гаргах, цуглуулах талаар хууль бус аргаар олж авсан нотлох баримт нотлох чадвараа алдах бөгөөд Сахилгын хорооны шийдвэрийн үндэслэл болохгүй.

110.11.Сахилгын хэргийн оролцогчийн гаргасан тайлбар бодит үнэнд нийцсэн, сахилгын хэрэгт авагдсан нотлох баримтад үндэслэсэн байна.

110.12.Энэ хуулийн 110.11-д заасан этгээд өөрийн тайлбарт холбогдох өөрт байгаа болон гаргах боломжтой нотлох баримтыг өгнө.

110.13.Гэрчээр дуудагдсан этгээд Сахилгын хороонд заавал хүрэлцэн ирэх ба үнэн зөв мэдүүлэг өгөх үүрэгтэй.

110.14.Гэрч мэдүүлэг өгөхөөс татгалзах, зайлсхийх, эсхүл зориуд худал мэдүүлэг өгсөн бол хуульд заасан хариуцлага оногдуулна.

110.15.Гэрч өөрийн болон гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй.

110.16.Дараах хүнийг гэрчээр дуудах болон мэдүүлэг авч болохгүй:

110.16.1.үүргээ гүйцэтгэх замаар хэргийн нөхцөл байдлыг мэдэх болсон хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч;

110.16.2.иргэний эрх зүйн чадамжгүй этгээд.

111 дүгээр зүйл.Бичмэл нотлох баримт

111.1.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий бичгийн хэлбэртэй баримтыг бичмэл нотлох баримт гэнэ.

111.2.Бичмэл нотлох баримтыг Сахилгын хороонд эх хувиар нь, хэрэв тухайн баримтын эх хувийг өгөх боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг өгнө. Сахилгын хороо шаардлагатай гэж үзвэл тухайн баримтын эх хувийг шаардан авах эрхтэй.

111.3.Төрийн байгууллага, хуулийн этгээд нь бичмэл нотлох баримтыг өөрийн байгууллагын архивын “хуулбар үнэн” гэсэн тэмдэг дарж баталгаажуулна.”

112 дугаар зүйл.Шинжээчийн дүгнэлт

112.1.Тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулахын тулд илтгэгч гишүүн өөрийн санаачилгаар, эсхүл сахилгын хэргийн оролцогчийн хүсэлтээр шинжээч томилж болно.

112.2.Шинжээч шинжилгээ хийж дүгнэлт гаргахдаа Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан журмыг баримтална.

113 дугаар зүйл.Тэмдэглэл

113.1.Сахилгын хорооны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх тохиолдолд хуралдааны тэмдэглэл үйлдэнэ.

113.2.Хуралдааны тэмдэглэлийг ажлын алба хөтөлж, хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж байгаа гишүүн албажуулна.

113.3.Тэмдэглэлд ямар ажиллагааг хэн, хэзээ, хаана явуулсан, эхэлсэн, дууссан цаг, ажиллагаанд оролцсон болон байлцсан хүн нэг бүрийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, ажиллагааны дараалал, явц, илэрсэн нөхцөл байдлыг бичнэ.

113.4.Тэмдэглэлийг уг ажиллагаа явуулахад оролцсон болон байлцсан хүнд танилцуулах бөгөөд тэмдэглэлд засвар оруулахаар санал гаргах эрхтэйг тайлбарлаж өгнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	2
Бүгд:	13

84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

71.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 110 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 114 дүгээр зүйл болгох:

“114 дүгээр зүйл.Сахилгын хорооны хуралдаан

114.1.Сахилгын хорооны хуралдааны бүрэлдэхүүнд энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар томилогдсон гурван гишүүн орно.

114.2.Сахилгын хорооны хуралдааны бүрэлдэхүүний хоёр нь шүүгч биш гишүүн, нэг нь шүүгч гишүүн байх бөгөөд илтгэгч гишүүн орохыг хориглоно.

114.3.Сахилгын хорооны хуралдааныг энэ хуулийн 101.2.2-т заасан дарааллын дагуу бүрэлдэхүүний аль нэг гишүүн даргална.

114.4.Сахилгын хорооны хуралдааныг доор дурдсан дарааллаар явуулна:

114.4.1.даргалагч хуралдааныг нээж, хянан шийдвэрлэх гэж байгаа сахилгын хэргийн талаар танилцуулах;

114.4.2.хуралдааны ирцийг нарийн бичгийн дарга бүртгэж, ирээгүй оролцогчид хуралдааны товыг урьдчилан мэдэгдсэн эсэх, ямар шалтгаанаар ирээгүй болохыг хуралдаан даргалагчид танилцуулах;

114.4.3.сахилгын хэргийн оролцогчтой танилцаж, төлөөлөх бүрэн эрхийг шалгаж, эрх, үүргийг тайлбарлах;

114.4.4.даргалагч бүрэлдэхүүнийг танилцуулан, татгалзан гаргах эрхийг сахилгын хэргийн оролцогчид тайлбарлан өгөх;

114.4.5.сахилгын хэргийн оролцогчийн зүгээс шинээр нотлох баримт гаргаж өгөх эсэхийг асуух;

114.4.6.сахилгын хэргийн оролцогчийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэх;

114.4.7.илтгэгч гишүүн гомдол, хүсэлт, сахилгын зөрчил гарсныг нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг танилцуулах;

114.4.8.сахилгын хэргийн оролцогчийн тайлбарыг сонсох;

114.4.9.гэрчийн мэдүүлэг сонсох, нотлох баримтыг шинжлэн судлах;

114.4.10.хуралдаанд оролцогч болон илтгэгч гишүүнээс асуулт асууж, хариулт авах;

114.4.11.сахилгын хэргийн оролцогч болон илтгэгч гишүүнээс нэмэлт тайлбарыг сонссоны дараа хуралдаан завсарлаж, бүрэлдэхүүн шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орох.

114.5.Зөвлөлдөх үед гишүүд хэлэлцэж байгаа асуудлаар ил санал хурааж, олонхын саналаар шийдвэрлэнэ. Сахилгын хорооны гишүүн санал өгөхөөс татгалзах, түдгэлзэх эрхгүй бөгөөд нэрийн эхний үсгийн цагаан толгойн дарааллаар саналаа хэлнэ. Зөвлөлдөх тасалгаанд гаргасан гишүүний санал нууц байна.

114.6.Сахилгын хорооны хуралдааныг нээлттэй явуулна. Хэргийн нотлох баримт, үйл явдал нь төрийн болон албаны, байгууллагын, хувь хүний нууцад хамаарах бол сахилгын хэргийн оролцогчийн хүсэлтээр, эсхүл гишүүний санаачилгаар хуралдааныг бүрэн, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулж болно.

114.7.Сахилгын хорооны хуралдааны тэмдэглэлийг ажлын албаны ажилтан хөтөлж, хуралдаан даргалагч болон ажилтан ажлын долоон өдрийн дотор тэмдэглэлд гарын үсэг зурж, тэмдэг дарна.

114.8.Сахилгын хорооны гишүүнд гаргасан татгалзал, эсхүл бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 115.2-т заасан шаардлага хангагдахгүй болсон бол энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар Сахилгын хорооны хуралдааны бүрэлдэхүүнд нэгээс илүүгүй гишүүнийг оруулж болох бөгөөд илтгэгч гишүүнийг оруулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 2

Бүгд: 13

84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

72.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 111 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 115 дугаар зүйл болгох:

“115 дугаар зүйл.Сахилгын хорооны хуралдааны шийдвэр

115.1.Сахилгын хорооны хуралдаанаар сахилгын хэргийг хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

115.1.1.нотлох дүгнэлтийг хүчингүй болгож, сахилгын хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох;

115.1.2.сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг хүлээн авч, сахилгын хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох;

115.1.3.нотлох дүгнэлтийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүлээн авч, шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах;

115.1.4.шүүгчийн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх;

115.1.5.сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал, эсхүл нотлох дүгнэлтийг хүчингүй болгож, дахин шалгуулахаар илтгэгч гишүүнд буцаах.

115.2.Сахилгын хорооны хуралдаан энэ хуулийн 115.1.1, 115.1.2, 115.1.3-т заасны дагуу сахилгын хэргийг шийдвэрлэж, магадлал гаргана.

115.3.Сахилгын хорооны хуралдаан энэ хуулийн 116.1.4, 116.1.5-д заасан болон хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой бусад асуудлаар тогтоол гаргах бөгөөд тогтоол нь эцсийн шийдвэр байна.

115.4.Тогтоол, магадлал уншиж сонсгосноор хүчинтэй болох бөгөөд даргалагч, гишүүд гарын үсэг зурж, тамга дарж албажуулна. Бүрэлдэхүүнд орсон гишүүд тогтоол, магадлалд гарын үсэг зурахаас татгалзах эрхгүй.

115.5.Сахилгын хорооны хуралдаанаас гаргах тогтоол, магадлал нь дараах агуулга бүхий удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсэгтэй байна:

115.5.1.удиртгал хэсэгт тогтоол, магадлалыг хэзээ, хаана гаргасан, бүрэлдэхүүнд орсон гишүүдийг нэрлэн заах;

115.5.2.тодорхойлох хэсэгт нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал, түүний үндэслэл болон сахилгын хэргийн оролцогчийн тайлбарын агуулгыг тусгах;

115.5.3.үндэслэх хэсэгт нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналын талаар хууль зүйн үндэслэл, нотлогдсон байдлын талаар заах;

115.5.4.тогтоох хэсэгт сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд үндэслэсэн хуулийн холбогдох заалт, шийтгэлийн төрөл, нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг хэрхэн шийдвэрлэсэн болон гомдол гаргах талаар тодорхой тусгах;

115.5.5.тогтоох хэсэг нь захиран тушаах хэлбэртэй байх.

115.6.Сахилгын хорооны тогтоол, магадлалыг гаргаснаас хойш 14 хоногийн дотор сахилгын хэргийн оролцогч болон өргөдөл, мэдээлэл гаргагчийн оршин суугаа газар болон ажлын газрын аль нэг хаягаар баталгаат шуудангаар, эсхүл ажлын албаны ажилтнаар хүргүүлнэ.

115.7.Энэ хуулийн 116.6-д заасны дагуу хүргүүлснээр магадлалыг гардан авсанд тооцох бөгөөд энэ нь гомдол гаргах хугацааг тоолох үндэслэл болно.

115.8.Энэ хуулийн 116.7-д заасны дагуу Сахилгын хорооны магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор сахилгын хэргийн оролцогч гомдол, илтгэгч гишүүн эсэргүүцэл Сахилгын хороонд гаргаж болно.

115.9.Сахилгын хэргийн оролцогч, эсхүл илтгэгч гишүүн энэ хуулийн 116.8-д заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтээ холбогдох нотлох баримтын хамт магадлал гаргасан бүрэлдэхүүнд гаргах бөгөөд хүсэлтийг хангах эсэхийг уг бүрэлдэхүүн тухайн хүсэлтэд хавсаргасан баримтыг үндэслэн шийдвэрлэж, тогтоол гаргах бөгөөд тогтоол нь эцсийн шийдвэр байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 2

Бүгд: 13

84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

73.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 112 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 116, 117 дугаар зүйл болгох:

“116 дугаар зүйл.Сахилгын хорооны хуралдаанд бэлтгэх ажиллагаа

116.1.Илтгэгч гишүүн нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх захирамж гаргаснаас хойш 14

хоногийн дотор энэ хуулийн 114.1-д заасан хуралдааныг товлон зарлаж, хуралдуулна.

116.2.Хуралдаан болохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг сахилгын хэргийн оролцогчийн оршин суугаа газар болон ажлын газрын аль нэг хаягаар баталгаат шуудангаар, эсхүл ажлын албаны ажилтнаар хүргүүлнэ.

116.3.Ажлын алба Сахилгын хорооны хуралдааны товыг бүрэлдэхүүний гишүүдэд мэдэгдэж, хуралдаан болохоос ажлын гурваас доошгүй хоногийн өмнө энэ хуулийн 109.11-д заасан захирамжийг холбогдох баримтын хамт хүргүүлнэ.

116.4.Сахилгын хэргийн оролцогчид Сахилгын хорооны хуралдаан болохоос долоогоос доошгүй хоногийн өмнө товыг мэдэгдэж, энэ тухай баримт үйлдэж, сахилгын хэрэгт хавсаргана. Сахилгын хэргийн оролцогч Сахилгын хорооны хуралдааны товыг лавлах үүрэгтэй.

116.5.Сахилгын хорооны хуралдаанд сахилгын хэргийн оролцогч оролцож болно. Сахилгын хэргийн оролцогч хуралдаан болохоос өмнө хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хүрэлцэн ирэх боломжгүй тухай хүсэлтээ бичгээр болон цахимаар ирүүлсэн бол хуралдааныг хойшлуулж болох бөгөөд хэргийг хянан шийдвэрлэх хугацаа сахилгын хэрэг үүсгэснээс хойш 90 хоногоос хэтрэхгүй.

116.6.Сахилгын хорооны хуралдаан болохоос долоогоос доошгүй хоногийн өмнө товыг өргөдөл, мэдээлэл гаргагчид мэдэгдэж энэ тухай баримт үйлдэж, сахилгын хэрэгт хавсаргана. Өргөдөл, мэдээлэл гаргагч нь гэрчээр дуудагдсанаас бусад тохиолдолд хуралдаанд ажиглагчаар оролцож болно.

116.7.Бүрэлдэхүүнд орсон гишүүнийг энэ хуулийн 103.3-т заасан үндэслэлээр татгалзан гаргах тухай сахилгын хэргийн оролцогчоос хүсэлт гаргавал тухайн гишүүнийг байлцуулахгүйгээр бүрэлдэхүүн уг асуудлыг шийдвэрлэнэ. Бүрэлдэхүүний санал тэнцсэн тохиолдолд тухайн гишүүнийг татгалзан гаргаж, хуралдааныг хойшлуулах тухай тогтоол гаргана.”

117 дугаар зүйл.Сахилгын хорооны хянан үзэх хуралдаан

117.1.Энэ хуулийн 116.8-д заасан гомдол, эсэргүүцлийг бичгээр гаргаж, дараах зүйлийг тусгана:

117.1.1.сахилгын хэргийн оролцогчийн, эсхүл илтгэгч гишүүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал;

117.1.2.магадлалын огноо, дугаар;

117.1.3.магадлалыг эс зөвшөөрсөн үндэслэл;

117.1.4.гомдол, эсэргүүцлийн шаардлага.

117.2.Сахилгын хорооны магадлалд гаргасан гомдол, эсэргүүцлийг энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар томилогдсон гурван гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх бөгөөд уг бүрэлдэхүүн нь дараах шаардлагыг хангасан байна:

117.2.1.бүрэлдэхүүний хоёр нь шүүгч гишүүн, нэг нь шүүгч биш гишүүн байх;

117.2.2.Сахилгын хорооны тухайн магадлал гаргасан бүрэлдэхүүнийг оролцуулахгүй;

117.2.3.илтгэгч гишүүнийг оролцуулахгүй.

117.3.Сахилгын хорооны гишүүнд гаргасан татгалзал, эсхүл бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 117.2.1, 117.2.2-т заасан шаардлага хангагдахгүй болсон бол Сахилгын хорооны бусад гишүүнээс энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар хянан үзэх хуралдааны бүрэлдэхүүнд оруулж болох бөгөөд илтгэгч гишүүнийг оруулахыг хориглоно.

117.4.Сахилгын хорооны магадлалд гаргасан гомдол, эсэргүүцлийн үндэслэлд Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцээгүй шинэ нотлох баримтыг заах эрхгүй.

117.5.Энэ хуулийн 101.2.2-т заасан дарааллын дагуу томилогдсон хуралдаан даргалагч Сахилгын хорооны магадлалд гомдол, эсэргүүцэл гарсан талаар илтгэгч гишүүн, сахилгын хэргийн оролцогчид мэдэгдэж, танилцах боломжоор хангана.

117.6.Сахилгын хэргийн оролцогч гомдлоосоо татгалзсан бол гомдол гаргаагүйд тооцно.

117.7.Илтгэгч гишүүн эсэргүүцлээсээ татгалзах эрхгүй.

117.8.Сахилгын хорооны магадлалд гаргасан гомдол, эсэргүүцлийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор Сахилгын хорооны хянан үзэх хуралдаанаар шийдвэрлэж, дараах агуулга бүхий хяналтын тогтоолыг бүрэлдэхүүний гишүүдийн олонхын саналаар гаргана:

117.8.1.гомдол, эсэргүүцлийг хангахгүй орхиж, магадлалыг хэвээр үлдээх;

117.8.2.гомдол, эсэргүүцлийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хангаж, магадлалд өөрчлөлт оруулах;

117.8.3.гомдол, эсэргүүцлийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хангаж, магадлалыг хүчингүй болгож, дахин шалгуулахаар илтгэгч гишүүнд, эсхүл дахин хэлэлцүүлэхээр Сахилгын хорооны хуралдаанд буцаах;

117.8.4.гомдол, эсэргүүцлийн зарим хэсгийг хангаж, магадлалын зарим хэсгийг хэвээр үлдээх, өөрчлөх, хүчингүй болгож, сахилгын хэргийг хэрэгсэхгүй

болгох, эсхүл дахин шалгуулахаар илтгэгч гишүүнд, эсхүл дахин хэлэлцүүлэхээр Сахилгын хорооны хуралдаанд буцаах.

117.9.Хянан үзэх хуралдааны товыг мэдэгдэж, хуралдаанд оролцох эрхийг хангана. Хуралдааны товыг мэдэгдсэн боловч хуралдаанд ирээгүй нь гомдлыг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.

117.10.Хуралдаан даргалагч гомдол, эсэргүүцэл, магадлалын агуулгыг танилцуулсны дараа сахилгын хэргийн оролцогчийн болон илтгэгч гишүүний тайлбарыг сонсоно.

117.11.Бүрэлдэхүүн сахилгын хэргийн оролцогчийн болон илтгэгч гишүүний тайлбарыг сонссоны дараа асуулт тавих, нэмэлт тайлбарыг сонсож, хуралдаан завсарлан зөвлөлдөх тасалгаанд орж, хяналтын тогтоол гаргана.

117.12.Хяналтын тогтоол нь уншиж сонсгосноор хүчин төгөлдөр болох бөгөөд энэ хуулийн 118.1-д заасны дагуу гомдол гаргаснаас бусад тохиолдолд эцсийн шийдвэр байна.

117.13.Хяналтын тогтоолд магадлал, гомдол, эсэргүүцлийн агуулга, тогтоолын үндэслэл, гаргасан шийдвэрийг бичнэ.

117.14.Хяналтын тогтоолыг уншиж сонсгосноос хойш 14 хоногийн дотор тогтоолын агуулгыг бүрэн эхээр нь бичгээр үйлдэж, бүрэлдэхүүн гарын үсэг зурна. Тогтоолыг сахилгын хэргийн оролцогч болон өргөдөл, мэдээлэл гаргагчид энэ хуулийн 116.6, 116.7-д зааснаар хүргүүлнэ.

117.15.Энэ хуулийн 114 дүгээр зүйл, 115.3, 115.4, 115.5, 115.6, 115.7, 116.4, 116.5-д заасан журам хянан үзэх хуралдаанд нэгэн адил хамаарна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 2

Бүгд: 13

84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

74.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 118, 119 дүгээр зүйл нэмэх:

“118 дугаар зүйл.Хяналтын тогтоолд гомдол гаргах

118.1.Хяналтын тогтоолыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор энэ хуулийн 119.1-д заасан үндэслэлээр хүчингүй болгуулах тухай гомдлыг сахилгын хэргийн оролцогч, илтгэгч гишүүн эсэргүүцлийг Улсын дээд шүүхэд гаргаж болно.

118.2.Сахилгын хэргийн оролцогч, эсхүл илтгэгч гишүүн энэ хуулийн 118.1-д заасан гомдол, эсэргүүцлийг бичгээр гаргаж, дараах зүйлийг тусгана:

118.2.1.холбогдох шүүгч болон илтгэгч гишүүний нэр, албан тушаал, оршин суугаа газрын хаяг, утас, цахим шуудангийн хаяг;

118.2.2.Сахилгын хорооны хяналтын тогтоолын огноо, дугаар;

118.2.3.Сахилгын хорооны хяналтын тогтоолыг хүчингүй болгуулах үндэслэл.

118.3.Энэ хуулийн 118.1-д заасан гомдол, эсэргүүцэлд дараах баримт бичгийг хавсаргана:

118.3.1.хяналтын тогтоолын эх хувь, эсхүл түүний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

118.3.2.хяналтын тогтоолыг хүчингүй болгуулах үндэслэлийг нотлох баримт;

118.3.3.итгэмжлэл.

118.4.Хяналтын тогтоолд гаргасан гомдол, эсэргүүцлийг хянан үзэх хуралдааны даргалагч гишүүн хүлээн авч, сахилгын хэргийн оролцогч, эсхүл илтгэгч шүүгчид танилцуулан тайлбар гаргуулан сахилгын хэрэгт хавсаргана.

118.5.Энэ хуулийн 118.1-д заасан гомдол, эсэргүүцлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

118.6.Хянан үзэх хуралдааны даргалагч гишүүн нь энэ хуулийн 118.1, 118.2, 118.3-д заасан шаардлагад нийцээгүй гомдол, эсэргүүцлийг буцаах тухай захирамж гаргаж, энэ талаар хариу мэдэгдэнэ.”

119 дүгээр зүйл.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан

119.1.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан хяналтын тогтоолыг зөвхөн дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

119.1.1.Сахилгын хорооны хянан үзэх хуралдааны товыг энэ хуулийн 116.3, 116.4, 116.6-д заасны дагуу мэдэгдээгүйн улмаас хуралдаанд зохих ёсоор оролцож чадаагүй гэдгийг сахилгын хэргийн оролцогч, эсхүл илтгэгч гишүүн нотолсон;

119.1.2.Энэ хуулийн 106.1-д заасан эрхийг эдлүүлээгүй гэдгийг сахилгын хэргийн оролцогч, эсхүл илтгэгч гишүүн нотолсон.

119.2.Хяналтын тогтоолд сахилгын хэргийн оролцогчоос гомдол, илтгэгч гишүүнээс эсэргүүцэл гаргасан тохиолдолд тухайн тогтоолын биелэлт түдгэлзэнэ.

119.3.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан энэ хуулийн 118.1-д заасан гомдол, эсэргүүцлийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

119.4.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан энэ хуулийн 118.1-д заасан гомдол, эсэргүүцлийг таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэнэ.

119.5.Энэ хуулийн 119.4-т заасан бүрэлдэхүүнийг энэ хуулийн 19.2.5-д заасан журмын дагуу томилох бөгөөд тухайн шүүхийн Зөвлөгөөнөөс тогтоосон дарааллаар томилсон шүүгч даргална.

119.6.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдааны товыг хэргийн оролцогч, илтгэгч гишүүнд долоогоос доошгүй хоногийн өмнө мэдэгдэж баримтыг сахилгын хэрэгт хавсаргана. Уг мэдэгдлийг хүлээн авсан этгээд ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

119.7.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан энэ хуулийн 119.1-д заасан үндэслэл байгаа эсэхийг гомдол, эсэргүүцлийн шаардлага болон татгалзлын үндэслэл, шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтыг шинжлэх замаар тогтооно.

119.8.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан хяналтын тогтоолыг хүчингүй болгуулах тухай гомдол, эсэргүүцлийг хянан хэлэлцэж, дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

119.8.1.хяналтын тогтоолыг хэвээр үлдээх;

119.8.2.хяналтын тогтоолыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгох;

119.8.3.сахилгын хэргийг дахин хэлэлцүүлэхээр Сахилгын хорооны хуралдаан, эсхүл хянан үзэх хуралдаанд буцаах.

119.9.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдааны шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.

119.10.Энэ хуулийн 119.9-д заасан тогтоолд доор дурдсан зүйлийг тусгана:

119.10.1.маргаж байгаа хяналтын тогтоолын тухай мэдээлэл, түүнийг гаргасан газар;

119.10.2.хяналтын тогтоолыг хүчингүй болгуулах тухай гомдол, эсэргүүцлийн агуулга;

119.10.3.шүүхээс гаргаж байгаа шийдвэрийн үндэслэл;

119.10.4.хяналтын тогтоолыг хэвээр үлдээсэн, эсхүл бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгосон, эсхүл энэ хуулийн 119.8.3-т заасны дагуу буцаасан тухай заалт.

119.11.Энэ хуулийн 119.9-т заасны дагуу гарсан Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдааны тогтоол гармагц хууль хүчин төгөлдөр болох бөгөөд эцсийн шийдвэр байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 3

Бүгд: 13

76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

75.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 113 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 120 дугаар зүйл болгох:

“120 дугаар зүйл.Шүүгчийн сахилгын хэргийн бүртгэл, тайлан болон шийдвэрийн ил тод байдал

120.1.Ажлын алба шүүгчийн сахилгын хэргийн бүртгэл хөтөлж, Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг гаргана.

120.2.Энэ хуулийн 120.1-д заасан бүртгэл, тайланд хамаарах мэдээлэл хөтлөх журамтай байх бөгөөд тайланг цахим хуудаст байршуулна.

120.3.Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд хүргүүлнэ.

120.4.Сахилгын хорооны магадлал, хяналтын тогтоол, Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдааны тогтоолыг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 21 хоногийн дотор цахим хуудаст байршуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

76.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 114 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“114.1.Энэ хуулийг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 2

Бүгд: 13

84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Найруулгын санал

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “хуулиар” гэсний өмнө “тухайлсан” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “шүүгчдийн зөвлөгөөнийг” гэсний дараа “/цаашид “Зөвлөгөөн” гэх/ гэж, 26 дугаар зүйлийн “Нийт шүүгчдийн” гэсний өмнө “Улсын дээд шүүхийн” гэж тус тус, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн “түдгэлзүүлэх” гэсний өмнө “шүүгчийн бүрэн эрхийг” гэж, 74 дүгээр зүйлийн 74.1.9 дэх заалтын “дарга” гэсний дараа “/цаашид “Гүйцэтгэх нарийн бичгийн дарга” гэх/” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 1

Бүгд: 13

92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “түүний” гэснийг “шүүгчийг” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “байгуулагдсан” гэснийг “байгуулсан” гэж, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “холбогдох” гэснийг “тухайлсан” гэж, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “мэдээлж байна” гэснийг “мэдээлнэ” гэж, 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийн “шийдвэрлэгдсэн” гэснийг “шийдвэрлэсэн” гэж, 15.5 дахь хэсгийн “харгалзах” гэснийг “харгалзан үзэх” гэж, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “шаардан гаргуулах” гэснийг “гаргуулан авах” гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “бичих” гэснийг “боловсруулах” гэж, “тогтооно” гэснийг “батална” гэж, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр” гэснийг “сайн дураараа” гэж, Долдугаар бүлгийн гарчиг, 34 дүгээр зүйлийн гарчгийн, 37.2 дахь хэсгийн “тавигдах” гэснийг “тавих” гэж, 39 дүгээр зүйлийн “хоногийн” гэснийг “өдрийн” гэж, 43 дугаар зүйлийн 43.7 дахь хэсгийн “хууль зүйн” гэснийг “хуулийн” гэж, 49 дүгээр зүйлийн 49.2.1 дэх заалтын “бие махбодь гэмтсэн буюу эрүүл мэндэд нь хохирол учирснаас нас барсан” гэснийг “эрүүл мэндэд нь хохирол учирснаас амь насаа алдсан” гэж, 49.5 дахь хэсгийн “нас барвал” гэснийг “амь насаа алдвал” гэж, 49.6 дахь хэсгийн “байна” гэснийг “байх ба” гэж, “тэтгэврээр” гэснийг “тэтгэвэр” гэж, 51 дүгээр 51.3 дахь хэсгийн “буруутайд тооцогдсон” гэснийг “буруутай” гэж, “ямар нэгэн” гэснийг “аливаа” гэж, 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсгийн “хойших” гэснийг “хойш” гэж, 73 дугаар зүйлийн 73.1.17 дахь заалтын “иргэдийн” гэснийг “хүн, хуулийн этгээдээс” гэж, 76 дугаар зүйлийн 76.1.6 дахь заалтын “орчин үеийн” гэснийг “дэвшилтэт” гэж, 77 дугаар зүйлийн 77.2.2 дахь заалтын “байрлуулах” гэснийг “байршуулах” гэж, 77.2.3 дахь заалтын “хуудсыг” гэснийг “хуудасны мэдээллийг” гэж, 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсгийн “байх бөгөөд” гэснийг “байна.” гэж, 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсгийн “хуралдаанаас тогтоол гаргана.” гэснийг “хуралдааны шийдвэр тогтоол хэлбэртэй байна.” гэж, 85 дугаар зүйлийн 85.6 дахь хэсгийн “104.1.1-104.1.5-д” гэснийг “106.1.1-106.1.4-т” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 2

Бүгд: 13

84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “бүх” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “холбогдох” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн “заавал” гэснийг, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “/цаашид “Нийт шүүгчдийн хуралдаан” гэх/” гэснийг, 26.3 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн” гэснийг, 26.4 дэх хэсгийн “хэлэлцсэн” гэснийг, 49 дүгээр зүйлийн 49.2.2 дахь заалтын “бие махбодь гэмтсэн буюу” гэснийг, 49.2.3 дахь заалтын “бие махбодь,” гэснийг, 49.4 дэх хэсгийн “гэмтсэн болон” гэснийг, 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсгийн “/цаашид “Ерөнхий зөвлөл” гэх/,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 1

Бүгд: 13

92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 1

Бүгд: 13

92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Төслийн 4.1.1 дэх заалтыг хасах гэсэн саналаа татав.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Б.Энхбаяр, Ж.Сүхбаатар, Д.Цогтбаатар нар үг хэлж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг тайлбар хийв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг явуулав.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, Б.Энхбаяр, С.Амарсайхан, Ш.Адьяаа, Ц.Мөнх-Оргил нар үг хэлж, Улсын дээд шүүхийн шүүгч Д.Мөнхтуяа тайлбар хийв.

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Давж заалдах шатны шүүхийн шийдвэрт дараах үндэслэлээр оролцогч хяналтын журмаар гомдол, прокурор, дээд шатны прокурор эсэргүүцэл гаргаж болно:

1.1.анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;

1.2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн;

1.3.шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.”

2/40.2 дугаар зүйлийн 4, 5, 6 дугаар хэсэг:

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан шүүхийг шүүгч хэргийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор дараах тогтоолын аль нэгийг гаргана.

4.1.гомдол, эсэргүүцлийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх;

4.2.гомдол гаргахдаа энэ хуульд заасан журмыг баримтлаагүй гэсэн үндэслэлээр гомдлыг хяналтын шатны шүүхийн хуралдаанаар хэлэлцүүлэхгүй.

5.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан тогтоолыг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэлэлцэж шийдвэрийг олонхын саналаар гаргана. Тогтоол шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Тогтоол эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй.

6.Гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэхэд хэргийн оролцогч, өмгөөлөгч оролцохгүй.

3/40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Хяналтын шатны шүүх нь анхан шатны болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн эсэх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн эсэх, шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн эсэхийг хянаана.”

4/40.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүхийн таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэх бөгөөд шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг тогтоосон журмын дагуу томилно.”

5/40.8 дугаар зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг:

“2.Хяналтын шатны шүүх хуралдаан даргалагч гомдол, эсэргүүцлийг хангасан эсэхийг сонсгоно. Шийдвэрийг шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргах бөгөөд хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

3.Хяналтын шатны шүүхийн тогтоолд шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Хяналтын шатны шүүхийн тогтоолд анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсгийн агуулга, гомдол, эсэргүүцэл болон гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тус тус тусгана.

4.Хяналтын шатны шүүхийн тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд уг тогтоолд гомдол гаргахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “22.1.3” гэснийг “22.3” гэж өөрчилж, “3.4 дүгээр” гэсний өмнө “2.2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “Тэргүүний шийдвэрээр” гэснийг “шийдвэрээр” гэж, “Ерөнхий шүүгчийн” гэснийг “шүүгчдийн зөвлөгөөний” гэж,” гэж нэмж, “40.10 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн “хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн” гэснийг “нийт шүүгчдийн” гэж, 40.10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “бичгээр” гэснийг “ажлын албаны даргаар дамжуулан бичгээр” гэснийг “40.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн нь” гэснийг “Танхимын зөвлөгөөнөөс” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.2 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 40.10, 40.11, 40.12 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2
Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг явуулав.

Төслийн 2, 12, 14 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, Ц.Мөнх-Оргил нар үг хэлэв.

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 20.9-д заасан ажлын хэсэг Нийт шүүгчийн чуулганыг уг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 120 хоногийн дотор зохион байгуулж Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны шүүгч гишүүнийг сонгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “хороо, Шүүхийн мэргэшлийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл.Улсын Их Хурал Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 120 хоногийн дотор Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч биш гишүүнийг сонгон шалгаруулж, томилно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 0
Бүгд: 12
100 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг батлахаас өмнө Улсын Их Хуралд танилцуулахаар ирүүлсэн Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчид Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 37.2 дахь хэсгийн зохицуулалт хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11 дүгээр зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 47.2 дахь хэсгийн дагуу шүүгчид олгох “онцгой нөхцөлийн, төрийн албанд ажилласан хугацааны, докторын зэргийн” нэмэгдлийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 0
Бүгд: 12
100 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 12 дугаар зүйл нэмэх:

“12 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 49.7 дахь хэсгийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 0
Бүгд: 12
100 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 13, 14 дүгээр зүйл нэмэх:

“13 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн дагуу байгуулагдах Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны 2021

оны үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг Засгийн газар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

14 дүгээр зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 75.2 дахь хэсгийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.15-д заасны дагуу хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, Төсөлд “2013 онд Шүүх байгуулах тухай хууль батлагдсантай холбогдуулан шүүгчээс чөлөөлөгдөөд дахиж томилоогүй шүүгч нарыг Шүүхийн ерөнхий зөвлөл дахин өргөн барьж шийдвэрлүүлнэ.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 11
Бүгд: 12
8.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг явуулав.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын шүүхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн

шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг явуулав.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн захиргааны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг явуулав.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Шүүхийн захиргааны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Зургаа.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг явуулав.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Долоо.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг явуулав.

Төслийн 1, 2, 3, 4, 5, 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/122 дугаар зүйлийн 122.3 дахь хэсэг:

“122.3.Хяналтын журмаар гомдол гаргасан бол хэргийг хэлэлцүүлэхээс татгалзах тогтоол гарах, эсхүл хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд энэ хуулийн 69 дүгээр зүйлд зааснаар урьд нь авсан шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ хүчинтэй хэвээр байна.”

2/173 дугаар зүйлийн 173.5, 173.6, 173.7 дахь хэсэг:

“173.5.Хяналтын шатны шүүх гомдлыг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор дараах тогтоолын аль нэгийн гаргана.

173.5.1.гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх;

173.5.2.гомдол гаргахдаа энэ хуульд заасан журмыг баримтлаагүй гэсэн үндэслэлээр гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж улсын тэмдэгтийн хураамжийг буцаах.

173.6.Энэ хуулийн 173.5-д заасан тогтоолыг танхимын нийт шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэлэлцэж шийдвэрийг 4-өөс доошгүй шүүгч гишүүний саналаар гаргана. Тогтоолд шүүх бүрэлдэхүүн гарын зурснаар хүчин төгөлдөр болно. Тогтоол эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй.

173.7.Гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэхэд хэргийн зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч оролцохгүй.”

3/176 дугаар зүйлийн 176.4, 176.5 дахь хэсэг:

176.4.Хяналтын шатны тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй.

176.5.Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш долоо хоногийн дотор зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, эсхүл өмгөөлөгчид хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	2
Бүгд:	12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн гарчгийн “Бичмэл” гэсний дараа “, цахим” гэж, мөн зүйлийн 110.1 дэх хэсгийн “бичмэл” гэсний дараа “, цахим” гэж, мөн зүйлийн 110.3 дахь хэсгийн эхний өгүүлбэрийн “Хэрэгт байгаа бичмэл” гэсний дараа “, цахим” гэж, хоёр, гурав дугаар өгүүлбэрийн “Бичмэл” гэсний дараа “, цахим” гэж, мөн зүйлийн 110.4 дэх хэсгийн “Бичмэл” гэсний дараа “, цахим” гэж, “110 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 1010.3 дахь хэсэг, 110.4 дэх хэсгийн “Бичмэл” гэсний дараа, мөн зүйлийн 1010.1, 1010.3 дахь хэсгийн “бичмэл” гэсний дараа “, цахим” гэж, 120 дугаар зүйлийн 120.1.2 дахь заалтын “гаргаагүй” гэсний дараа “, эсхүл гомдол гаргасан боловч гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзах тогтоол гаргасан гэж” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг:

“31.1.Прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25, 26 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно.”

1/51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэг:

“51.1.Анхан шат, хяналтын шатны шүүх хуралдаанд тэмдэглэл үйлдэнэ. Хэргийн оролцогч оролцож байгаа бол давж заалдах шатны шүүх хуралдаанд тэмдэглэл үйлдэнэ.”

2/172 дугаар зүйлийн 172.2 дахь хэсэг:

“172.2.Хяналтын журмаар дараах үндэслэлээр гомдол гаргана:

172.2.1.анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;

172.2.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн;

172.2.3.шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.”

3/173 дугаар зүйлийн 173.4 дэх хэсэг:

“173.4.Хяналтын журмаар гомдол гаргахад энэ хуулийн 167.5, 173.3-т заасныг хангаагүй бол анхан шатны шүүх гомдлыг хүлээн авахгүй бөгөөд энэ тухай шүүгч захирамж гаргана.”

4/174 дүгээр зүйлийн 174.1 дэх хэсэг:

“174.1.Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тогтоол гарснаас хойш 30 хоногийн дотор хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.”

5/176 дугаар зүйлийн 176.1, 176.3 дахь хэсэг:

“176.1.Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүхийн таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэж, энэ хуулийн 114.1-д заасан журмын дагуу шийдвэрээ гаргаж гомдлыг хангасан эсэхийг сонсгоно. Шийдвэрийг шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргах бөгөөд хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

176.3.Тогтоолд шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Тогтоолд анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсгийн агуулга, хяналтын гомдлын болон гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тус тус тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	3
Бүгд:	12

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх “хуваарилна” гэснийг “хуваарилах бөгөөд уг журам нь урьдчилан мэдэх боломжгүй, тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан байна” гэж, 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсгийн “шийдвэр, магадлалыг” гэснийг “шийдвэрийг” гэж, 172 дугаар зүйлийн 172.3 дахь хэсгийн “тооцож, улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгох тухай шүүгч захирамж гаргана.” гэснийг “тооцно. Энэ тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгохгүй.” гэж, 176 дугаар зүйлийн 176.4 дэх хэсгийн дугаарыг “176.6” гэж тус тус өөрчлөх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	0
Бүгд:	12

100 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.6 дахь заалтын “давж заалдах, хяналтын журмаар” гэснийг, 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсгийн “буюу хяналтын” гэснийг, 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсгийн, 122 дугаар зүйлийн 122.2 дахь хэсгийн “болон хяналтын” гэснийг тус тус хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	3
Бүгд:	12

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “79.2 дахь хэсгийг” гэснийг “79.2 дахь хэсэг, 176², 177¹, 178¹ дүгээр зүйлийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	4
Бүгд:	12

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Найм.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг явуулав.

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “зүйл,” гэснийг хасаж, 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2, 3, 4 дэх заалт болгох:

2/123 дугаар зүйлийн 123.2 дахь хэсэг:

“123.2.Дараах үндэслэлээр Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргана:

123.2.1.анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;

123.2.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн;

123.2.3.шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.”

3/124 дүгээр зүйлийн 124.3, 124.4, 124.5 дахь хэсэг:

“124.3.Хяналтын шатны шүүх гомдлыг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор дараах тогтоолын аль нэгийг гаргана:

124.3.1. гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх;

124.3.2.гомдол гаргахдаа энэ хуульд заасан журмыг баримтлаагүй гэсэн үндэслэлээр гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, улсын тэмдэгтийн хураамжийг буцаах.

124.4.Энэ хуулийн 124.3-т заасан тогтоолыг танхимын нийт шүүгчдийн бүрэлдэхүүнтэй хэлэлцэж шийдвэрийг олонхын саналаар гаргана. Дөрвөөс доошгүй шүүгчийн саналаар гаргана. Тогтоолд шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Тогтоол эцсийн шийдвэр байх бөгөөд гомдол гаргахгүй.”

124.5.Гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэхэд хэргийн оролцогч тэдгээрийн төлөөлөгч хүмүүс оролцохгүй.”

4/125 дугаар зүйлийн 125.1 дэх хэсэг:

“125.1.Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тогтоол гарснаас хойш 30 хоногийн дотор хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.”

5/127 дугаар зүйлийн 127.1 дэх хэсэг:

“127.1.Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүхийн таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэж, энэ хуулийн 105.1-д заасан журмын дагуу шийдвэрээ гаргаж гомдлыг хангасан эсэхийг сонсгоно. Шийдвэрийг шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргах бөгөөд хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 127.4, 127.5, 127.6 дахь хэсэг нэмсүгэй:

“127.4.Тогтоолд шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Тогтоолд анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсгийн агуулга, хяналтын гомдлын болон гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тус тус тусгана.

127.5.Хяналтын шатны тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй.

127.6.Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш долоо хоногийн дотор хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	0
Бүгд:	12

100 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “75 дугаар” гэсний өмнө “16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “Ерөнхий шүүгч” гэснийг “Шүүгчдийн зөвлөгөөн” гэж,” “даргалагч” гэсний өмнө “шүүх хуралдаан” гэж,” тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	1
Бүгд:	12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1.2 дахь заалтын “гаргаагүй” гэсний дараа “, эсхүл гомдол гаргасан боловч гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзах тогтоол гарсан” гэж нэмсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	3
Бүгд:	12

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “гэснийг” гэсний дараа “, 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалтын “давж заалдах, хяналтын журмаар” гэснийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсэг, 128, 129 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болгосугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Ес.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг явуулав.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арав.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг явуулав.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “орон тооны” гэснийг хасаж, 2 дугаар зүйлийн “байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаал” гэснийг “байгууллага” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арван нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг явуулав.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Атарцэцэг хариулж, тайлбар хийв.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн “өөрчлөлт” гэсний өмнө “нэмэлт,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арван хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, Улсын Их Хурлын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг явуулав.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг үг хэлэв.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн гаргасан, Төсөлд “Шүүгчээр 30 болон түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн шүүгч” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арван гурав.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг явуулав.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арван дөрөв.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, Улсын Их Хурлын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг явуулав.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил үг хэлэв.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 44.7 дахь хэсгийн “Хуульчдын холбооны гишүүнчлэлээс түдгэлзэнэ.” гэснийг “түдгэлзэж болно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арван тав.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг явуулав.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “15.31 дүгээр” гэснийг “15.32 дугаар” гэж, 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “хүлээхээргүй” гэснийг “хүлээлгэхээргүй” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арван зургаа.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг явуулав.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “15.31 дүгээр” гэснийг “15.32 дугаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арван долоо.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг явуулав.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Арван найм.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг явуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “орон тооны” гэснийг хасаж, “ТӨ-VA-ийн тусгай албан тушаалд “Монголбанкны тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч,” гэснийг “ТӨ-VIA-ийн тусгай албан тушаалд “Монголбанкны тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	0
Бүгд:	12

100 хувийн саналаар дэмжигдлээ.

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дуусав.

Арван ес.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг явуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, хавсралтыг хасах:

“1.“Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 18 дугаар тогтоолын нэг дэх заалт, мөн тогтоолын хавсралтын гарчгийн “Үндэсний статистикийн хороо,” гэсний дараа “Шүүхийн сахилгын хороо,” гэж, мөн хавсралтын “Үндэсний статистикийн хороо” гэсэн хэсгийн дараа “Шүүхийн сахилгын хороо” гэсэн 13 дахь хэсэг, түүнд “Тэргүүн түшмэл” гэсэн ангиллын “АА-1” гэсэн зэрэглэлд “Ажлын албаны дарга” гэж, “Эрхэлсэн түшмэл” гэсэн ангиллын “АА-4” гэсэн зэрэглэлд “Хэлтсийн дарга” гэж, “АА-5” гэсэн зэрэглэлд “Ахлах референт” гэж, “Ахлах түшмэл” гэсэн ангиллын “АА-6” гэсэн зэрэглэлд “Референт” гэж, “АА-7” гэсэн зэрэглэлд “Ахлах шинжээч” гэж, “АА-8” гэсэн зэрэглэлд “Шинжээч” гэж, “Дэс түшмэл” гэсэн ангиллын “АА-9” гэсэн зэрэглэлд “Ахлах мэргэжилтэн” гэж, “АА-10” гэсэн зэрэглэлд

“Мэргэжилтэн” гэж, “АА-11” гэсэн зэрэглэлд “Ахлах зохион байгуулагч” гэж тус тус хамааруулан нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	2
Бүгд:	12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дуусав.

Уг асуудлыг 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 02 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар дүгнэлт

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Цэцийн дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Н.Алтанхуяг нар үг хэлэв.

С.Бямбацогт: 1.Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	1
Татгалзсан:	11
Бүгд:	12

8.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 12
Бүгд: 12
0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 10
Бүгд: 12
16.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 11
Бүгд: 12
8.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 11
Бүгд: 12
8.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Хуралдаан 16 цаг 30 минут үргэлжилж, 19 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 89.5 хувийн ирцтэйгээр 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 03 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

С.БЯМБАЦОГТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

С.Бямбацогт: Байнгын хорооныхоо гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая. Бүгдэд нь шинэ оны мэнд хүргэе. 2021 оны Хууль зүйн байнгын хорооны анхны хуралдааны ирц хүрсэн тул нээснийг мэдэгдье. Энэ царгиад цуурайтаад байна вэ? Хуралдаан хүрэлцэн ирсэн гишүүдийг танилцуулъя. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн, Цэдэвийн Сэргэлэн гишүүн, Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн, Сандагийн Бямбацогт гишүүн, Лхагвын Мөнхбаатар гишүүн, Норовын Алтанхуяг гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Баттөмөр Энхбаяр гишүүн, Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн, Хишгээгийн Нямбаатар нарын 11 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Адьшаа гишүүн Ширнэнбаньдын Адьшаа гишүүн хүрэлцэн ирсэн байна 11 гишүүн. Уучлаарай. Шатарбалын Раднаасэд гишүүн чөлөөтэй, Ням-Осорын Учрал гишүүн өвчтэй байгаа. Бусад гишүүдийг Байнгын хорооны хуралдаандаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 дүгээрт нь Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, анхны хэлэлцүүлэг үргэлжилнэ. 2 дугаарт Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, энэ Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар дүгнэлт. 3 дугаарт нь Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл гэсэн ийм 3 асуудал байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Адьшаа гишүүн тасаллаа санал. Энэ царгиж байгааг техникийнхэнд хэлэхгүй бол.

Ш.Адьшаа: Та бүгдийн энэ өдрийн амгаланг айлтгаж шинэ жилийн мэнд дэвшүүлье. Шүүхийн тухай хуулийг бид хэлэлцэж байгаа. Урд нь Ардчилсан нам 2 удаа завсарлага авсан. Тэгээд одоо шинэ оны эхний хуулийн төслийг хэлэлцэж байгаа юм. Энэ хуулийн төслийг хэлэлцэхийг ер нь дэмжиж байгаа. Энэ дээр бол Ардчилсан намын бүлэг болон гишүүдийн зүгээс энийг хойшлуулах ийм санаа зорилго байхгүй гэдгийг хэлье.

Оны өмнө Улсын Их Хурлын дарга болон Бямбацогт гишүүний нэр дээр Ардчилсан намын бүлгээс Монгол Улсын Шүүхийн тухай хуулиар нийтийн сонсгол явуулъя гэсэн ийм албан бичгийг хүргүүлсэн байгаа. Энэ яагаад ингэж хүсэлт тавьсан бэ гэхээр шүүхийн тухай энэ хуулийг Засгийн газар өргөн мэдүүлснээс хойш ажлын хэсэг дээр олон зүйлийг өөрчлөлт оруулсан. Түүнээс гадна энэ хуулийн талаар энэ

өөрчлөлт орсон зүйлүүдийн хуульд заасан иргэд олон нийтээс санал аваагүй мэргэжлийн байгууллагаас санал аваагүй, хэвлэл мэдээллээр энэ тухай олон нийтэд мэдээлээгүй зэрэг ийм үндсэн шалтгаануудын улмаас бас энэ сонсгол хийлгээ гэдэг ийм хүсэлтийг тавьсан байгаа.

Тэрнээс биш өнөөдөр энэ хуулийг хойшлуулъя янз бүрийн санаа зорилгыг агуулъя гэсэн ийм юм байхгүй шүү гэдгийг Хүрэлсүх даргад хэлж байна. Энэ асуудлыг хэрхэн шийдсэн бэ гэдэг талаар Бямбацогт даргаас асууж энийг хэлэлцүүлж өгөх горимын саналыг оруулж байгаа юм.

С.Бямбацогт: 12 сарын 28, 2020 оны 12 дугаар сарын 28 буюу өнгөрсөн долоо хоногийн 1 дэх өдөр Ардчилсан намын бүлгээс бичиг ирсэн. 28 өдөр бас Хууль зүйн байнгын хороо хуралдах ёстой байсан. Ардчилан намын бүлэг завсарлагаа сунгасан. Энэ өдөр бас бичиг ирсэн байгаа. Энэ бичиг дээр бол Шүүхийн тухай хуулийн төслөөр багц хуулийн төслийн Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалыг илэрхий гажуудуулсан Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлт зарчмыг алдагдуулсан нэн хариуцлагагүй болсон байна. Ажлын хэсэг ажиллахдаа бас үзэл баримтлалыг тодорхойгүй болгосон нэг ёсондоо үзэл баримтлалыг тодорхойгүй болгосон нэг ёсондоо үзэл баримтлалыг хуулийн төслийг шүүхийн асуудлыг шийдвэрт хүргэж байна гэсэн асуудлууд хөндөөд нийтийн сонсгол явуулах санал гаргаж байна. Энийг одоо шийдэж өгөөсэй гэсэн бичиг ирүүлсэн. Энэ бичгийг бол би бас санал хураалгаж шийдүүлнэ. Ер нь бол хууль санаачлагч төслөө үзэл баримтлал нь өөрчлөгдсөн байна. Утга агуулга нь алдагдсан байна гэж үзэх юм бол хэлэлцүүлгийн аль ч шатанд татах эрхтэй. Засгийн газраас Шүүхийн тухай хуулийн төслийг 2020 оны 4 сард өргөн барьсан. Хэлэлцүүлэг хийгдээд үндсэндээ 2 сар гаруй хугацаанд он дамнаж байна.

Энэ хугацаанд Засгийн газраас ямар нэгэн байдлаар одоо үзэл баримтлалын өөрчлөлт агуулга өөрчлөгдсөн гэсэн хууль санаалагчаас албан бичиг гомдол санал ирээгүй байгаа. Хуулийг энэ хуулийг бол нэн яаралтай хэлэлцэж батлах ёстой одоо гэдгийг бол ард түмэн ч ойлгож байгаа, Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн ойлгож байгаа. Ардчилсан намын бүлэг ч гэсэн ойлгож байгаад бас хүндэтгэлтэй хандаж байна. Тийм болохоор энэ ирсэн бичгийг дагуу Байнгын хороон дээр санал хураалт явуулна. Нийтийн сонсголын тухай хуульд бол 7.1.2-т нийтийн ашиг сонирхолд шууд хамааралтай эдийн засаг нийгмийн болон байгаль орчны асуудлыг шийдвэрлэх, 7.2-оор бол хууль тогтоомжийн төсөл сонсгол явуулахаар бол тухайн Байнгын хорооны нийт гишүүдийн 1/3-ээс доошгүйн саналаар шийдвэрлэнэ гэж заасан байгаа. Тэгэхээр 1/3-ээс дээш нь дэмжих юм бол нийтийн сонсгол хийгдэнэ. 1/3-ээс дээш дэмжихгүй бол энэ сонсгол хийгдэхгүй. Хэлэлцүүлэг үргэлжлээд явагдана.

Байнгын хорооны гишүүд бас энд бас анхааралтай хандаж саналаа өгөхийг хүсэж байна. Дэгийн тухай хуульд бас нийтийн сонсгол явуулж болно хүсэлт гаргавал. Энийг санал хурааж шийдвэрлэх ийм хуулийн заалттай. Тийм учраас би

санал хураалт явуулъя гэж бодож байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.25-д холбогдох Байнгын хороо хэлэлцэж байгаа төсөл болон тухайн төслийн талаар гаргасан санал нь улсын болон орон нутгийн төсөв түүнчлэн санхүү хөрөнгө оруулалт бизнесийн орчинд шууд ба шууд бус байдлаар сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл олон нийтийн хэлэлцүүлэг нийтийн сонсгол зохион байгуулж болно гэж заасны дагуу Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс ирүүлсэн саналаар Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төслөөр нийтийн сонсгол зохион байгуулъя гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ санал хураалтыг дүн. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 3 гишүүн буюу 23,1 хувийн саналаар энэ саналд дэмжигдсэнгүй. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын дэд хэсгийг та бүхэндээ танилцуулъя. Ажлын дэд хэсгийн гишүүд Лхүндэвийн Атарцэцэг наашаагаа суучихвал боломж байвал. Юу багтаамж муутай байна тийм ээ. Лхүндэвийн Атарцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Дашдоржийн Мөнхтуяа Улсын дээд шүүхийн шүүгч, Батсүрэнгийн Ундрах Улсын дээд шүүхийн шүүгч, Дамдингийн. Эрдэнэбалсүрэн Улсын дээд шүүхийн шүүгч, Цэндийн Цогт Улсын дээд шүүхийн шүүгч, Барсүрэнгийн Баасандорж Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн дарга, Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Шагдарсүрэнгийн Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч, Одонхүүгийн Мөнхсайхан Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор. Ийм хүмүүс хүрэлцэн ирсэн байна. Ажлын хэсгийг та бүхэнд танилцууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. 1 дүгээр зүйл дээр. 1 дүгээр зүйл бол хөндөгдөөгүй байгаа. Асуулт алга байна. Байгаа юу Адьшаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьяа: Энэ 1 дүгээр зүйлд Монгол Улсын шүүхийн хугацааны асуудал байгаа. Тэгэхээр өнөөдөр Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтөөр шүүх эрх мэдлийн байгууллагыг нэлээн одоо олон талаас нь харж үзсэн өөрчлөлтийг хийхийг

үндсэн хуулийн өөрчлөлтөөр бий болгосон. Тэгэхээр өнөөдөр шүүх эрх мэдэл гүйцэтгэх эрх мэдэл хууль тогтоох эрх мэдэл гэдэг энэ төрийн байгуулалтын үндсэн 3 зарчим, өөр өөрсдөө хоорондоо хяналттай байж өнөөдөр энэ төрийн эрх мэдэл явах ийм Үндсэн хуулийн үзэл баримтлал байдаг. Өнөөдөр Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо гэдэг энэ Үндсэн хуулийн бүтцийг өнөөдөр хууль тогтоох эрх мэдлийн одоо бидэнд ирүүлэх ийм үндсэн үзэл санаа суурь зарчмыг энэ хуулиар баталсан юм.

Тэгэхээр энэ төрийн байгууламжийн зарчим хоорондын уялдаа холбоо өөрсдийнх нь нэг нэгэндээ тавих хяналт механизм алдагдах ийм эрсдэл байгаа. Энийг одоо ямар зарчмаар ингэж шийдсэн бэ гэдгийг би энэ ажлын хэсгийн дарга Энхбаяраас асууя.

С.Бямбацогт: Хуулийн төслийн 1 дүгээр зүйл бол хуулийн зорилт байгаа. Саяын асуулт яг хуулийн зорилттой холбогдож байна уу үгүй юу бас хөндөгдөөгүй заалт байх шиг байна. Энхбаяр ажлын хэсгийн ахлагч бас хариулчих уу?

Б.Энхбаяр: Адьшаа гишүүний асуултад хариулъя. Энэ хуулийн зорилт гэсэн өгүүлбэр байгаа юм. Тэгээд энэ ажлын хэсгээс хөндөөгүй учраас хөндөгдөөгүй зүйл дээр л асуугаад байна л даа. Тэгэхээр нөгөө дэг яадаг бол? Хөндөөгүй юм чинь ажлын хэсэг. Тэгэхээр хариулт байхгүй.

С.Бямбацогт: Адьшаа гишүүн яг хөндөгдсөн зүйл заалттай. Шүүхийн ерөнхий зөвлөл дээд шүүхтэй холбоотой заалтаар хөндөгдөх байх. Тэр үед нь асууя тэгэх үү. 1 дүгээр зүйл дээр асуулт асууж дууслаа. Санал хураалт явуулъя. Санал хураалт байхгүй. Бичгээр гаргасан санал байхгүй тийм байна. Тийм байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан бичгээр гаргасан санал ажлын хэсгээс байхгүй. Энэ цаашаа явъя.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Монгол Улсын шүүхийн хууль тогтоомж гэсэн заалт байгаа хөндөгдөөгүй. Асуулт алга байна. Бичгээр гаргасан санал байхгүй байна. Цаашаа явъя.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. 3 дугаар зүйл бол хуулийн нэр томъёоны тодорхойлолт хөндөгдсөн. Асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгийн санал хураалт явуулна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалтыг явуулж эхэлье. Төслийн 1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “эрүү, иргэн, захиргаа зэрэг” гэснийг хасаж, 3.1.5, 3.1.6 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.3.5 дахь заалт, мөн зүйлийн 43.4, 43.5 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 44 дүгээр зүйл болгож, 74 дүгээр зүйлийн 74.1.3 дахь заалтын “сэлгэн ажиллуулах,” гэснийг хасах:

“44 дүгээр зүйл.Шүүгчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах

44.1.Шүүхийг татан буулгасан, өөрчлөн зохион байгуулсан, тухайн шүүхийн шүүгчийн орон тоо цөөрсөн тохиолдолд шүүгчийн өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн орон тоо дутуу байгаа адил шатны шүүхэд, адил шатны шүүхэд орон тоо байхгүй бол доод шатны шүүхэд шилжүүлэн томилж болно.

44.2.Шүүгчийг энэ хуулийн 44.1-д заасан үндэслэлээр шилжүүлэн томилуулах тухай саналаа Ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх бөгөөд саналыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тухайн шүүгчийг шилжүүлэн томилно.

44.3.Шүүгчийн мэргэжил, ур чадварыг сайжруулах, шүүн таслах ажиллагааны дадлага эзэмшүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн шүүгчийг адил шатны шүүхэд хоёр жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно.

44.4.Энэ хуулийн 44.3-т заасан үндэслэлээр шүүгчийг сэлгэн ажиллуулах журмыг Ерөнхий зөвлөл батална.

44.5.Шүүгч энэ хуулийн 44.3-т заасан сэлгэн ажиллах хугацаа дууссанаар урьд ажиллаж байсан шүүхэд эргэн ажиллах баталгаагаар бүрэн хангагдана.” Ийм байдлаар өөрчлөгдөж байгаа юм байна ажлын хэсгээс оруулж ирж байгаа санал. Хуулийн төсөлтэй холбогдуулан, одоо санал хураалт явуулна. Асуулт эхэнд нь яасан. Дэгээрээ. Санал хураалт явуулъя. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 12 гишүүний санал буюу 85,7 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна. Дараагийнхаа зүйл рүү орёе. Санал гаргах юм уу тийм ээ? Адьшаа гишүүн бичгээр санал гаргах юм байна. Саналаа гаргая. 3 дугаар зүйл дээр. Бичгээр гаргаж байж хураах ёстой л доо. Харин байхгүй л байна л даа.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. 4 дүгээр зүйлээ харж байгаа байх тийм ээ. Шүүхийн эрхэм зорилго. Пүрэвдорж гишүүнээр тасаллаа асуулт. Пүрэвдорж гишүүний микрофон өгье.

Б.Пүрэвдорж: Энэ зүгээр би нэг ганцхан үг л асуух гэж байгаа юм. Шүүхийн эрхэм зорилго гэхээр ер нь компани энэ тэрд бол эрхэм зорилго гэхээр алсын хараа энэ тэрийг хардаг байхгүй юу. Тэгэхээр ер нь бол шүүх бол яг прагматик асуудал шийддэг газар чинь энэ үндсэн зорилго биш юм уу? Энийг л асуух гэсэн юм өөр юм байхгүй. Уг нь үндсэн байвал зүгээр юм шиг санагддаг. Энэ дээрээ зүгээр нөгөө редакц дээрээ анхаараарай л гэж хэлэх гэж байгаа юм. Тийм. vision тал руу шүүх чинь өөрөө vision гэж.

С.Бямбацогт: Хариулах уу цаашид анхаарах юм уу? Цаашид анхааръя гэж байх шиг байна. Асуулт асууж дууслаа. Санал хураалт явуулж эхэлье. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна. 2.Төслийн 4 дүгээр

зүйлийн 4.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах. 4.1.4.шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хангах. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 14 гишүүн буюу 93,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналуудаар санал хураалт явуулъя. Пүрэвдорж гишүүн Шүүх Үндсэн хууль зөрчсөн тухай маргаантай асуудал болон Засгийн газрын улс төрийн шийдвэрийг авч хэлэлцэхгүй. Бодлогын асуудал 4.2 дээр ийм заалт нэмж оруулъя гэж байгаа юм байна. Пүрэвдорж гишүүн саналаа тайлбарлая.

Б.Пүрэвдорж: Ер нь бол Үндсэн хуульд Засгийн газрын шийдвэрийг ер нь 2 субъект л авч хэлэлцэх ёстой. 1 дүгээрт бол Үндсэн хуулийн цэц, 2 дугаарт нь Их Хурал өөрөө энэ Засгийн газрын шийдвэртэй холбоотой асуудлыг авч хэлэлцэх ёстой. Гэтэл сүүлийн үед бол шүүх, та 2 наашаа анхаарч байгаарай. Сүүлийн үед шүүх бол Засгийн газрын хамтын шийдвэрийг шүүдэг болчихоод байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ дээр би бодлогын асуудал гэж байгаа шүү дээ. Өөрөөр хэлбэл энэ Засгийн газрын өөрөөр хэлбэл хэн нэгэн өөртөө юм уу хамаатан хамаарал бүхий этгээддээ давуу тал олгосон зүйлийг энд оруулахгүй. Улс төрийн шийдвэр гэж байгаа юм. Бодлогын шийдвэр гэж байгаа. Өөрөөр хэлбэл хүүхдийн мөнгө өгсөн асуудлаар дараа нь хэн нэгэн хуулийн байгууллага шалгаж болохгүй байхгүй юу. Аль эсхүл дөнгөж сая одоо ингээд нөгөө нэг цахилгаан тэглэх асуудал гарсан шүү дээ. Энийг тэгээд ингээд тэглэх шийдвэр гарсан байсан чинь дараа нь шүүх яах вэ гэхээр нөгөө сайд нь хэн гэдэг билээ. Тавинбэх гэдэг хүнийг Монголын энэ одоо энергийн салбарт хохирол учруулсан гээд тэр хүнээ сугалж аваад шүүгээд байвал яах юм бэ?

Ийм практик өнөөдөр энэ шүүхийн чинь практикт яваад хэд хэдэн хүмүүсийг аваачаад энэ Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлснийх төлөө одоо ингээд шоронд хориод байна шүү дээ. Тэгэхээр би бол нэг зүйлийг ер нь бол яах вэ маш их олон асуудлууд дараа нь бол ялангуяа өнөөдөр эрх барьж байгаа хүмүүс дээр гарч ирнэ. Би бол энэ заалтыг оруулахгүй байх тийм юу байдаг юм сонирхол миний улс төрийн хувьд бол байж болох юм. Гэхдээ ер нь бол цаашдаа бол энэ их хэн нэгэн эрх баригч болчихоод л тэгээд нөгөө урд талын Засгийн газрынхаа гаргасан шийдвэрийг жаахан асуудалтай тэр шийдвэрүүдийг нь татаж авчирч байгаад шалгаа шоронд явуулдаг ийм зүйл цаашдаа Монголд байх хэрэггүй л гэж үзэж байна. Ийм учраас энэ саналыг оруулж байна. Энэ бол улс төрийн шийдвэр шүү. Бодлогын шийдвэр шүү. Бусдаар одоо юу байдаг юм хэн нэгэн хамаатай хамаарал бүхий этгээдтэй улаан цагаан ашиг сонирхлыг зөрчил гаргаад өгсөн, шийдвэрийг бол тэр чинь өөрөө угаасаа Эрүүгийн хуулиараа ингээд юу яагаад явна. Шийдэгдээд явна.

Энэ дээр бодлогын шийдвэр дээр хэн нэгэн Засгийн газрын аль нэг тийш ээ аль нэгэн одоо шүүхийн байгууллага ч юм уу хуулийн байгууллагын дур сонирхлын

дагуу очиж шийдэх ёсгүй гэж би энэ саналыг гаргаж байгаа юм. Энэ бол та нарын ирээдүйд хэрэгтэй.

С.Бямбацогт: Хууль санаачлагч нөгөө хуулийн төслийн үзэл баримтлалтай зөрчилдөх үү агуулга нийцэх үү хаана ямар зохицуулалт байдаг билээ? Нямбаатар сайд хариулах уу?

Х.Нямбаатар: Би Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Энэ 4 дүгээр зүйл дээр Пүрэвдорж гишүүний гаргаж байгаа саналыг дэмжих боломжгүй гэж би хууль санаачлагчийн хувьд үзэж байгаа юм. Энэ бол шүүхийн эрхэм зорилгын асуудал яригдаж байгаа. Ерөөсөө шүүхийн эрхэм зорилго бол шударга ёс тогтоох. Сая Пүрэвдорж гишүүний хэлж байгаа зүйл бол Засгийн газрын хамтын шийдвэрийг шүүхээр шийдэхгүй байя гэдэг ийм асуудал яригдаж байна. Энэ бол буруу. Өнөөдөр Засгийн газрын шийдвэрийг захиргааны хэргийн шүүх харьяалж шийдэж байгаа.

Төр иргэн хоёрыг тэнцвэржүүлэх гол зүйл бол өөрөө өнөөдөр захиргааны шүүх. Засгийн газар иргэн хуулийн этгээдийн газар эзэмших эрх, ашигт малтмалын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл энэ тэр зэргийг хүчингүй болгодог. Зарим тохиолдолд томоохон төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх үүднээс иргэний болон хуулийн этгээдийн өмч хөрөнгөд халдах ийм шийдвэрүүд гаргадаг.

Энэ тохиолдолд иргэн хуулийн этгээд эрхээ хаана очиж хангуулж төртэй тэнцвэржих вэ гэвэл захиргааны шүүх дээр л очно. Бид нар удахгүй Захиргааны ерөнхий хуулийг бас Их Хуралд өргөн мэдүүлэх гэж байгаа. Энд яг Пүрэвдорж гишүүний хэлэх гэж байгаа санаа дээр бид нар яг ажиллаж байгаа. Тэр юу вэ гэвэл Засгийн газрын хамтын шийдвэрийг захиргааны шүүхийн 1 шүүгч дангаараа шийдээд хүчингүй болгоод байгаа нь зарчимд нийцэхгүй байна. Ийм учраас Засгийн газрын хамтын шийдвэрийг заавал бүрэлдэхүүнтэй шийдье. Эсхүл шууд давахынх нь шүүх нь шийддэг больё гэдэг ийм зохицуулалт оруулж ирж байгаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай ойлголт бол зөвхөн Эрүүгийн хуульд заасан тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдсэн гэдэг үндэслэлээр шалгах тухай асуудал байгаа. Эрүүгийн хуульд заагаагүй асуудлаар тухайн хүнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулна гэдэг ойлголт ерөөсөө огтоос байхгүй. Тэгэхээр энэ саналыг бол дэмжихгүй байна. Харин таны хэлж байгаа тэр Засгийн газрын хамтын шийдвэр, стратегийн том бодлого шийдвэр гаргаад үйл ажиллагаа явуулах гэж байгаа асуудал дээр захиргааны шүүх дээр бид нар нөгөө өнгөрсөн жил ярьсан шүү дээ. Урд нисэх онгоцны буудал том нисэх онгоцны буудлыг барих гэхээр газар чөлөөлдөггүй. Сумын засаг дарга нь газар олгосон байдаг. Үүнийг нь хүчингүй болгоод том төслөө явуулах гэхээр захиргааны хэргийн шүүх дээр нэг шүүгч дангаараа асуудлыг авч шийдвэрлээд

Засгийн газрын хамтын шийдвэрийг хүчингүй болгодог маань өөрөө шударга ёсонд нийцэхгүй гэдэг ийм зүйл яригдсан.

Тэгээд өнгөрсөн 2019 онд бид нар Захиргааны ерөнхий хуульд таны хэлж байгаа нөгөө Засгийн газрын улс төрийн шийдвэрээс бусад шийдвэрийг захиргааны хэргийн шүүх өөрт авч харьяалан шийднэ гэсэн ийм утга агуулгатай зүйл оруулсан. Гэтэл өнөөдөр яг амьдрал дээр Засгийн газрын шийдвэрийг аль хэсэг нь улс төрийн шийдвэр, аль хэсэг нь улс төрийн биш шийдвэр вэ гэдгээ бас захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тодорхойлоход хүндрэлтэй байгаа учраас бид нар ерөөсөө Засгийн газрын бүх шийдвэрийг захиргааны хэргийн шүүх авч шийдвэрлэе.

Ингэхдээ гагцхүү бүрэлдэхүүнтэй шийдвэрлэе. Эсхүл давж заалдах шүүх нь анхан шатын журмаар Засгийн газрын шийдвэрийг нэг удаа шийдвэрлэж байя гэсэн ийм өргөн хүрээтэй өөрчлөлтийг оруулж ирэхээр бид нар хуулийн төслөө бэлдээд өргөн барих ийм процесс явагдаж байгаа.

С.Бямбацогт: Пүрэвдорж гишүүний саналаар санал хураалт явуулъя. Асуулт саналаа гаргасан тайлбарласан сонслоо. Шүүх Үндсэн хууль зөрчсөн тухай маргаантай асуудал болон Засгийн газрын улс төрийн шийдвэрийг бодлогын асуудлаа гаргасан улс төрийн шийдвэрийг авч хэлэлцэхгүй гэсэн саналыг Пүрэвдорж гишүүн гаргасан. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 7 гишүүн буюу 46,7 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. 5 дугаар зүйл шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус байдалтай холбоотой заалт бол хөндөгдсөн. Ганбат гишүүнээр асуулт тасаллаа. Адьшаа гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Бямбацогт гишүүн, Бямбацогт дарга энэ зүйл заалтынхаа өмнө саяынх шигээ хэлээд явчихвал зүгээр байна тийм ээ. Тэгвэл их ойлгомжтой аятайхан болчих гээд байна. Би юу хэлэх гээд байна вэ гэхээр өмнө нь одоо энэ ардчилсан төрийн тогтолцооны тулгийн 3 чулуу бол гүйцэтгэх засаглал. Хууль тогтоох засаглал, шүүх засаглал юм. Тэгээд энэ шүүх засаглалын хараат бус байдалд халдсан шүүхийг одоо самарсан. Ялангуяа 2016-2020 оны хооронд бол энэ байдал бий болсон.

Тэр шүүхийн тогтолцоог самарсан улсуудын хулхи гурав. Нэг нь дотор сууж байна. Тэгээд үндэсний аюулгүй байдлын зөвлөлд аваачиж эрх мэдлийг өгсөн. Тэнд нь бол одоо Ардын намын 2 гишүүн байдаг. Одоо эргээд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг бол та бүхэн бол эргээд үндэсний аюултай байдлын зөвлөл болсон мэтээр ярьж байгаа л даа. Тэгэхээр дахиад ийм зүйл давтагдахгүй уу үгүй юу. Өмнө нь бол хууль эрх зүйн орчин бол шүүх хараат бус байхаар хуульчлагдсан байсан шүү дээ.

Үндсэн хуулиараа. Гэтэл маш сайхан юм хийж байна гээд ингээд бид нар яваад байдаг.

Дараа нь дахиад ийм байдал давтагдахгүй гэсэн тийм баталгаа байна уу? Энийг одоо энэ шүүхийн хуулийг яаж байгаа энэ намын бүлгээс тэгэхэд та нар 65-лаа байсан. Гэх мэтээр. Тэгээд одоо шүүхийн нэр хүндийг шүүхэд итгэх иргэдийн итгэлийг байхгүй болгосон шүү дээ. Тэгээд хуульд бол шүүгчид итгэх итгэлийг шүүхэд итгэх илтгэлийг байхгүй болговол тэр хүмүүстэй хариуцлагын тогтолцоо байгаа юу? Оруулсан уу? Ийм зүйл заалт байхгүй бол эргээд энэ зүйл заалт чинь дахиад л давтагдах ийм байдал бий болоод байгаа. Ингээд та бүхэн маань их л гайхамшигтай сайн юм хийх гэж байна гээд ингээд яриад байдаг.

Нөгөө л самарсан юмаа эргүүлээд л босгох гээд л ингээд л явж байгаа ийм л улсууд шүү дээ. Энэ дээр нэг хариулт авъя энэ зүйл заалт дээр. Тэгээд би дараа нь тодруулъя.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Хууль санаачлагч Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Нөгөө хулгайч хулгайчийг бариарай гээд орилдогтой л адилхан юм ярих юм. Би андуураагүй бол 2013 оны шүүхийн хуулийн шүүхийн 5 багц хуулийг Их Хурлаар батлуулах үед та Хууль зүйн байнгын хорооны дарга байсан шүү дээ. Энэ нөгөө самарсан гэж яригдаад байгаа эрүүгийн зөрчлийн хуулийг та Хууль зүйн байнгын хорооны дарга байхдаа батлуулсан шүү дээ Ганбатаа. Юмаа бас бодож ярь. Тэр үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 3 гишүүний саналаар шүүгчийг чөлөөлдөг энэ хуулийн төслийг таны хамтран зүтгэгч Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Их Хуралд өргөн мэдүүлж батлуулсан. Та нар 2012-2016 онд Монгол Улсын хууль шүүхийн тогтолцоо эрх зүйн тогтолцоогоор бүтэн самарч тэрийг чинь засаж залруулах ажил ингээд өнөөдөр 2016 оноос хойш өнөөдрийг хүртэл тасралтгүй үргэлжилж байна шүү дээ.

Хаана та нар шударга ёс тогтоосон юм бэ? Би биеэ ээлжилж барьж хорьдог. Бизнесменүүдийг барьж авч хорьж эд хөрөнгийг нь булааж авдаг. Тэр шударга бусын хонгилыг цуг үрсэн угсралцсан улсууд чинь та нар биз дээ. Би бол танд нэг юм хэлэхэд та шударга ёс яриад зохихгүй шүү. Улсын төсвийн хөрөнгөөр тойргийнхоо гишүүдэд тэрбум төгрөгөөр бетон тараачхаад энийг шударга ёс гэх юм уу.

С.Бямбацогт: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж ярина шүү. Ганбат гишүүнд нэмэлт 1 минут.

Д.Ганбат: Ингээд давхар дээлтэй сайдуудын балайрал нь эхэлж байгаа байхгүй юу. Би Хууль зүйн байнгын хорооны дарга байсан нь үнэн. Тэр ажлыг хийсэн нь үнэн. Тэр үед би шүүгчдийн цалинг нэмсэн. Манай Ардчилсан намын үед. Бүх

нийгэм эсрэг байхад шүүгч шүүхийн тогтолцоог бэхжүүлсэн юм. Тэгээд тэр бетоной холбоотой асуудлаар бол би өөрөөсөө тэрбум төгрөг гаргасан юм. Тэрийг шалгаад хараад үзээрэй. Иймэрхүү юм яриад байх шаардлага байхгүй. Энэ ажлаа л хийх ёстой та нарын одоо тэр гадагшаа тэр рекламдах тэр юм чинь хэтэрч байна. Монгол Улсын Ерөнхийлөгч рүү дайрдаг чинь цадигаа алдаж байна. Хуулийг бид нар л тогтоодог шүү дээ. Та нар 65-лаа байхдаа л тогтоосон хууль шүү дээ.

С.Бямбацогт: Гишүүд бие биедээ харилцан хүндэтгэлтэй хандаад ажил хэрэгчээр асуудалд хандъя. Адьшаа гишүүн асуултаа асууя. Асуусангүй шүү дээ сая. Түрүүн асуултад хариулсан. Одоо маргаан яах вэ. Тийм. Бид Шүүхийн сахилгын хороотой холбоотой асуудал би ярья гэж бодож байгаа юм. Уучлаарай Адьшаа гишүүнээ нөгөө юу сахилгын хороотой холбоотой хамгийн сүүлд байгаа тэрэн дээр. Шүүхийн тогтолцоо. Одоо бид нар 5 руу орж байгаа. Та саналаа бичээд бэлдэж байгаарай, асуултаа бэлдэж байх уу? 5 дугаар зүйлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа. Санал хураалт явуулж эхэлье.

3.Төслийн 5 дугаар зүйл, 14 дүгээр зүйлүүдийг нэгтгэж, доор дурдсанаар өөрчлөн найруулж, 14 дүгээр зүйл болгох: зөв биз.

“14 дүгээр зүйл.Шүүхийн тогтолцоо

14.1.Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу байгуулсан шүүх хэрэгжүүлнэ.

14.2.Монгол Улсын шүүхийн тогтолцоо зохион байгуулалтын хувьд бие даасан байх бөгөөд Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэнэ.

14.3.Шүүхийг шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнан байгуулж болох бөгөөд дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.

14.4.Анхан болон давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг тойргийн зарчмаар байгуулахад энэ хуулийн 15.4-т заасныг харгалзахаас гадна иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг хангах, шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн байна.” Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 92,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Ойлголоо. Дэлгэрсайхан гишүүн техникийн асуудал гарсан байна. 5 дугаар зүйл сая болсон.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Бие даасан шүүгчийн хараат бус байдал. Адьшаа гишүүнээр асуулт тасаллаа. Алтанхуяг гишүүн асуултаа асууя.

Н.Алтанхуяг: Та бүхний өглөөний амгаланг айлтгая. Энэ шүүхийн тухай хуулийн ажлын хэсэгт би орж ажилласан юм. Ер нь манай улсад бол энэ шударга ёс тогтоох асуудал дээр асар их доголдол гарсан. Үнэхээр одоо шударга бусын хонгил гэдэг юм ингээд олон жил ингээд болсон л доо. Гэхдээ одоо би нэг юм та нараас хүсэх гээд байна. Энэ хууль дээр ажилласан хүмүүс магадгүй одоо Ардын нам 60 хэдэн суудалтай байж байхдаа Үндсэн хуульд өөрчлөлт оруулж Ерөнхийлөгч гэдэг хүн байдаг олон эрх мэдлийг тэр дотроо шүүх эрх мэдлийг шүүхийг самардаг эрх мэдлийг болиулсан энэ тэрийг би зөв зүйтэй гэж үзэж байгаа.

Би энэ шүүх шударга ёсны асуудал бол аль нэг намын асуудал биш. Нямбаатар сайдад би нэг юм хүсэх гэж байна. Та энэ Улсын Их Хурлын гишүүд ямар нэгэн юм асууж санал янз бүрийн юм хэлэхэд битгий эмзэглэж байгаач. Хувь хүн рүү битгий дайрч байгаач. Хэн ч байж болно. Энэ чинь өнөөдөр Их Хурлын гишүүн асуултаа л асууж байгаа. Саналаа л илэрхийлж байгаа. Би өөрөө бас таны оронд сууж л байсан сайд байж л байсан. Өчнөөн л янз бүрийн юм болдог. Бид нар энэ ажлаа явуулмаар байна. Түүнээс биш ямар нэгэн асуулт асуусны төлөө хэн нэгнээр ингэж тэр дотроо Хууль зүйн сайдаар ялтан болтлоо дуудуулмааргүй байна. Би энийг хэлье.

Хэн асуух юм бэ, хэн санал хэлэх юм бэ энэ Их Хурал дээр чинь ингээд хүнийг элдэв янзын юмаар нь нотлогдоогүй юмаар нь ингээд л Хууль зүйн сайд нь хүртэл ингээд яриад байвал тэгэхээр та жаахан биеэ бариад энэ хүмүүсийн асуултад хариул. Юмаа хэл. Ер нь шударга бусын хонгилыг чинь чиний нам, миний нам гэх юм байхгүй. Тэр Ардчилсан намаас гарсан Ерөнхийлөгч Элбэгдорж танай намын тэр Энхболд энэ тэр нийлж байгаад төгөлдөржүүлсэн. Тэрнээс өмнөхийг нь би ярихаа больё төгөлдөржүүлсэн. Энэ төгөлдөржүүлсэн бантанг бид нар янзлах гээд л ингээд л сууж байгаа.

Тэгэхээр битгий ингэж энийг намжуулж улс төржүүлж энэ асуудлыг битгий унагаарай. Таны энэ байдал бол харин энэ асуудлыг унагаах шинжтэй явж эхэллээ шүү. Би бол энэ зөв зүйтэй болоод энэ хуулиуд нь батлагдаад энэ хууль бол би 100 хувь төгс гэж хэлэхгүй. Гэхдээ өмнөх байдлаас бол хавьгүй дээрдсэн аль нэг улс төрч аль нэг улс төрийн хүчин самралтад бол бага болох байх. Гэхдээ нэг өдөр бүгдийг нь рам-ыг байгуулж болдоггүй юм чинь жижиг жижгээрээ том араг ясаа ингээд аваад бөөгнүүлээд явчихмаар байх юм. Би энийг одоо танаас хүсэж байна. Болиоч би маш олон хурал дээр би таныг харлаа. Хэн үг хэлж хэн асуух юм бэ, энэ зүгээр Их Хурлын гишүүний эрх шүү дээ. Би энийг ингэж ойлгож байна би дутуу ойлгосон байдаг байж болно, би буруу ойлгосон байж болно. Би энийг мэдэхгүй байж болно. Би асуух эрхтэй. Тэр байтугай би санал хэлэх эрхтэй.

Тэрнийхээ төлөө яагаад ингээд яллуулаад байдаг юм бэ энэ олон нийтийн өмнө. Чи тэр үед тэдэн оны тэдэн сарын өдөр чи тэгж байсан, тэгвэл тэр үед нь

мэдэж байсан юм бол чи шоронд хийхгүй яасан юм бэ? Ялыг нь үүрүүлэхгүй яасан юм бэ? Яагаад хүмүүсийг ингээд байдаг юм бэ би ерөөсөө ойлгохгүй юм таныг. Хууль зүйн сайд гэдэг чинь бол баргийн юманд бол хөдлөхгүй тайван амгалан байж байгаад энэ хуулийг харин ингээд батлуулчихвал энэ бол хэн нэгэн хүнд ашигтай биш би Монгол Улсад шударга ёс тогтоход нэмэр болохуйц ийм хууль болох болов уу гэж бодож ажлын хэсэгт нь анхнаас нь орж дуустал нь ажилласан. Энхбаяр дарга харин та нэг юм хэлээрэй ажлын хэсгийн ахлагч.

Бид нарын нөгөө нэг эцэслэсэн юм дотроос одоо юу өөрчлөгдсөнийг би яг мэдэхгүй яваа шүү. Тийм учраас та нэг асуултад хариулах замдаа яг бид нарын эцэслээд хамтраад ингээд суугаад эцэслээд орхисноос хойш ямар өөрчлөлт орсныг би мэдэхгүй байна. Тэрэн дээр би будилж магадгүй надад өөр будилах юм алга. Санал хэллээ ажлын хэсгийн гишүүн Алтанхуяг ажиллаж байгаа. Сандаг-Очир гишүүн бас ажлын хэсгийн гишүүн байгаа. Сандаг-Очир гишүүн ажлын хэсэг ажлын хэсгээсээ асуухгүй байх. Санал хэлэх юм болов уу.

Ц.Сандаг-Очир: Би санал хэлье. Энэ дээр шүүхийн төсвийн урсгал зардлын хэмжээг төсвийн хэмнэлтээс бусад тохиолдолд өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно гэж байна. Тэгээд бид нар ирэх жил 21 оны энэ жил шүүхийн төсвийг батлахдаа урсгал төсөв дээр нь хөрөнгийг нь 4 тэрбум төгрөг баталж өгсөн байх. Тэгээд цаашдаа энэ буурахгүй л явах нь л дээ. Тэгээд ер нь бол энэ шүүхийн үйл ажиллагаанд төсвийн нөхцөлийг бол нэлээн сайн дээшлүүлж байгаа энэ хуулиараа. Сүүлийн 4, 5 жил ерөөсөө хөрөнгө оруулалт салбарт нь хийгдээгүй юм байна лээ шүү дээ. Шүүхийн салбарт.

Тэгэхээр цаашдаа ингээд хуульчлаад өгөхөөр шүүхийн салбарын хөрөнгө оруулалт дотоод гадаад засвар үйлчилгээ машин техник, техник хэрэгсэл компьютер гээд ингээд ажилтнуудын шүүгчдийн ажиллах орчин нөхцөл маш сайжирч байгаа. Бууруулахгүй учраас. Дор хаяж энэ хэмжээндээ батлаад явна гэсэн үг. Тийм учраас манайхан одоо энэ шүүхийн салбар энэ шинэ хуулиараа бас төсвийн асуудал бол дагаад бас нийгмийн асуудал нэлээн сайн сайжирч байгаа шүү гэдгийг бас хаана хаанаа ойлгож байгаа байх гэж ингэж бодож байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүн Сандаг-Очир санал хэллээ. Ганбат гишүүн асуултаа асууя. Ганбат гишүүн одоо ярья.

Д.Ганбат: Түрүүний тэр асуултад хариулаарай Нямбаатар сайдаа. Нэг их хэрэлдэж уралдаад байх юм ерөөсөө алга. Угаасаа би 4 жил завсарлаад ороод ирсэн. Хэрэв би гэм буруутай ийм байсан бол энд өнөөдөр энд сууж байхгүй. Тэр бол ойлгомжтой. Тэгэхээр наад ажил төрлөө л сайжруулахаа л бод. Тэрнээс биш ийм хоёрын хооронд оруулж ирээд байх шаардлагагүй байх. Түрүүн дахиад ийм явдал давтагдвал яах юм бэ гэхийн гэсэн тэр асуултад хариулчих. Шүүх шүүгч хараат бус

байна гэж байгаа тийм ээ. Сая шүүхийн зардал чирэгдэл бол сүүлийн 5 жил бол үнэхээр хөрөнгө оруулалт байхгүй ийм байлаа.

Энийг засаж залах ёстой энэ хуулиараа. Энэ дээрээ жаахан тодруулаад оруулчих шаардлага байна уу байхгүй юу нэг. Нөгөө талаараа шүүх шүүгчийн хараат байдалд нөлөөлсөн. Шүүгч хараатаар асуудлаа шийдвэрлэсэн ийм байх юм бол тэр шүүгчид ямар хариуцлага хүлээлгэх вэ? Зөвхөн одоо шүүгчийн албан тушаалаас нь сахилгын хороогоор оруулаад л тэгээд дуусах юм уу? Эсхүл өөр илүү ял зэм байна уу?

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч хариулъя Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Ганбат гишүүний асуултад хариулъя. Энэ шүүгчийн хараат бус байдал шүүх эрх мэдлийн бие даасан байдалд халдаж байгаа алдагдуулж байгаа шийдвэрийг хэн гаргаж байна вэ гэхээр Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар гэсэн Үндсэн хуулийн бие даасан ийм дээд түвшинд шийдвэр бас гаргаж байгаа гэсэн дүгнэлт хийдгийг бол мэдэж байгаа. Тийм учраас энэ ер нь бие даасан институт эрх мэдэл гэдэг утгаар нь энийгээ бас энэ ер нь бие даасан институт эрх мэдэл гэдэг утгаар нь энийгээ бас энэ хүмүүсээс бас хамгаалах ёстой.

Тэр утгаараа ажлын хэсгээс хуулийн төслийн 75 дугаар зүйлийн 2, 75 дугаар зүйлийн 3, 75 дугаар зүйлийн 4-т шинэ томъёолол оруулж ирж байгаа. Энэ хойшоо санал хураагдаж бас яригдана. Гол агуулга нь юу вэ гэхээр Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус байдалд халдсан алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус байдалд халдсан алдагдуулсан шинжтэй үйл ажиллагаа явуулсан бол Шүүхийн ерөнхий зөвлө даруй хуралдаж Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргуулах саналыг Улсын дээд шүүхэд хүргүүлнэ гэдэг ийм тодорхой санал орж ирж байгаа.

Өөрөөр хэлбэл шүүхийн бие даасан шүүх эрх мэдлийнхээ бие даасан байдлыг хамгаалах үүрэг бол Үндсэн хууль ёсоор Шүүхийн ерөнхий зөвлөлд байгаа. Үүнийгээ хэрэгжүүлдэггүй бас ийм бас иржээ эс үйлдэл гаргадаг. Шүүгч нараа хамгаалдаггүй. Ийм төрийн өндөр дээд түвшинд шүүх эрх мэдлийн бие даасан байдалд халдаад байхад түүний төлөө тэр институтээ хамгаалдаггүй. Тийм учраас Үндсэн хуулийн цэцэд энэ хүмүүсээ өгнө. Үндсэн хууль зөрчвөл энэ хүмүүс Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн дагуу цаашдаа огцордог болно.

Ингэж байж бид нар шүүхийнхээ бие даасан байдал энэ эрх мэдлээ хамгаална. Бусад иргэн аж ахуйн нэгж байгууллагын тухайд ийм үйл ажиллагаа явуулбал Шүүхийн ерөнхий зөвлөл мөн шүүхэд хандаж тухайн шийдвэрийг захиргааны шүүхээр

байна уу эсхүл бусад үйл ажиллагаа нь гэмт хэргийн шинжтэй үйлдэл байна уу нэхэмжлэл гомдол л гаргах замаар мөн энэ институтийнхээ бие даасан байдлыг хамгаалахыг нь үүрэгжүүлж өгч байгаараа онцлог болж байгаа. Энэ асуудал төслийн 75 дугаар зүйлийг яригдах үед тухайлан дэлгэрэнгүй яригдах байх гэж бодож байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Ганбат гишүүн тодруулъя 1 минут.

Д.Ганбат: Шүүхийн хараат бус байдал гэдэгт шүүгчийнхээ өөрийнх нь цалин орно. Тухайн үед намайг байхад Хууль зүйн байнгын хорооны даргаар ажиллаж байхад хэдийгээр нийгэм ойлгодоггүй ч гэсэн тэр үед бол цалинг нь бол боломжийн тогтоож байсан. Одоо бол шаардлага хангаж чадаж байгаа юу ямар байгаа вэ энэ талаар одоо зүйл заалт орсон уу? Нөгөө талаар бас орон тооны асуудал байна. Өнөөдөр 500-аад шүүгч л ажиллаж байгаа байх. Яг ийм бүрэлдэхүүнтэйгээр энэ улсын шүүх эрх мэдлийг энэ 500 шүүгч маань хараат бусаар хэрэгжүүлж чадах уу? Ачаалал нь ямар байдаг бол. Энэ орон тоо юмыг нь бас заасан оруулсан ийм зүйл заалт байгаа юу?

Цалин хангамж дээр байгаа юу? Тэр хүний хуучин бол маршалын албыг тахарын алба нэртэйгээр байгуулж бас шүүхийг хамгаалдаг энэ тогтолцоо байсан. Дэлхийн бүх улс оронд ийм байдаг. Энэ юмаа бол зүгээр цаасан дээр үлдэхгүйгээр амьдрал дээр дахиад бий болох ийм шаардлага урган гарч байна уу? Энэ хараат бус байдал гэдэг дээрээ бас энэ талаар бодсон барьсан тийм ээ хийх ажлууд байгаа юу гэдгийг бас Засгийн газраас бас энэ ажлын хэсгээс асууя.

С.Бямбацогт: Атарцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн. 4 дүгээр микрофон дээр хариулъя. 2 дээр. Атарцэцэг гишүүн Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн. 4 дүгээр микрофон дээр хариулъя. 2 дээр.

Л.Атарцэцэг: Баярлалаа. Гишүүдийн энэ өглөөний амар амгаланг айлтгая. Ер нь бол шүүгчийн хараат бус байдал шүүхийн бие даасан бие даасан байдлыг хангахад эдийн засгийн асуудал чухал байр суурьтай гэдэг ойлгомжтой. Болд гишүүний асуултад хариулахад өнөөдөр Монгол Улсын шүүхэд 518 шүүгч яг одоогийн ажиллаж байгаа шүүгч 518 шүүгч байгаа. 2016 онд Улсын Их Хурлын 42 дугаар тогтоолоор 699 шүүгч ажиллахаар ингэж орон тоог нь баталж өгсөн юм. Ингээд 699 гэсэн тоонд хүрч ажилласан тохиолдол бол байхгүй. Хамгийн сүүлд 20 шүүгчийн орон тоо цалингийн сантай нь нэмэгдүүлж авснаар энэ сүүлийн шүүхийн төсөл нэмэгдсэн байдалтай харагддаг юм. Энэ нь нөгөө 20 шүүгчийн цалингийн сантай холбогдолтойгоор.

Өнөөдрийн байдлаар бол зүгээр шүүхийн нэг шүүгчид ноогдох хэргийн ачаалал бол их байгаа. Энэ 18 онд хөгжлийн санаачилга бодлогын судалгааны төв гэсэн

байгууллагаар бид нар зүгээр нэг дүн шинжилгээ хийлгэсэн юм. Тэгэхээр иргэний хэрэг бол ер нь бол нормаль хэмжээ бол иргэний хэрэг нэг шүүгчид ноогдох иргэний хэрэг 200, эрүүгийн хэрэг 75, захиргааны хэрэг 42 гэсэн ийм ачаалалтай ажиллах юм бол нэг шүүгчийн нэг норматив байдаг гэсэн ийм судалгаа гаргаж өгсөн юм байгаа юм.

Гэтэл өнөөдөр манай Монгол Улсын шүүхэд ажиллаж байгаа шүүгчид бол иргэний хэрэг бол 400 орчмыг шийдэж байна. 300-аас. Эрүүгийн хэрэг 100 гаруйг шийдэж байна. Захиргааны хэрэг 50-иас дээш шийдэж байгаа. Тэгэхээр ер нь яг энэ 599 одоо ажиллаж байгаа 518 шүүгчийн бүрэлдэхүүнтэй ажиллахад бол шүүгчдийн ачаалал бол их, цаашдаа ядаж энэ Улсын Их Хурлын 42 дугаар тогтоолоор тогтоосон тоонд нь барьж ажиллах ийм шаардлага байгаа гэдэг нь эндээс харагдаж байгаа юм.

Яг энэ цалингийн сантай шүүгчийн орон тоо одоо бол сул орон тоо 10 байна. Энэнээс бол Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын тушаалаар орон тоог нөхөхөөр 5 орон тоо одоо зарлагдаад байгаа. Цаашдаа 5 орон тоо сул байна. Энэ бол ингээд зарлагдаад явахаар энэ 518 дээр 528 шүүгч болж ирнэ. 699 хүрэхгүй гэсэн үг. Ийм байдалтай байна.

С.Бямбацогт: Баярлалаа. Дээд шүүхээс шүүгч нараас нэмж хариулт байгаа юу? Хариулт алга уу? Ажлын хэсгийн ахлагч.

Б.Энхбаяр: Баярлалаа. Энэ шүүхийн төсвийн хувьд эдийн засгийн хувьд бие даасан байдлыг хангасан их 3 чухал заалт шүүхийн хуульд байсныг 2015 оны 12 дугаар сард аваад хаясан юм байна лээ. Тэр нь энэ төсвийн хэмнэлттэй холбоотой гээд. Тэр хүрээнд буцааж сэргээж байгаа нэг заалт бол энэ 6 дугаар зүйлийн 7-д байгаа урсгал зардлын хэмжээг бууруулахгүй гэдэг ийм заалт байгаа. Энэ бол товчдоо бол цалинг бууруулахгүй орон тоог бууруулахгүй шүү гэсэн үг санаа явж байгаа.

Нэгт цалингийн хувьд бол яах вэ нэг ийм ойлголт гарсан л юм байна лээ. Тэгээд өөрсдөө ч бас энэ шүүхийнхэн маань ч бас буруу зөрүү их ярьж байгаад тийм ойлголт өгсөн юм уу? Их цалинтай хүмүүс байдаг гээд ойлгосон. Тэгээд ажлын хэсгийн хүрээнд цалинг нь үнэхээр судалж үзсэн. Анхан шатны шүүгчдийн дундаж цалин 2,7 сая төгрөг байна лээ. Давж заалдах шатныхан 3 сая байна лээ. Тэр 5, 6 сая төгрөгийн цалинтай гээд байгаа хүмүүс чинь Дээд шүүхийнхэн байна лээ. Яагаад гэсэн чинь Дээд шүүхийнхэн нөгөө төсвөө тусдаа Улсын Их Хуралд оруулж ирээд батлуулаад яваад байдаг. Тийм хуультай болсон.

Тэр хүрээндээ нөгөө цалин юмнуудаа нэмээд яваад байсан. Тэрийг нь одоо Монгол Улсын нийт шүүгчид л ийм өндөр цалинтай юм шигээр ойлгоод л ингээд явдаг л нэг ийм л юм болсон юм байна лээ. Тэгээд энийг бас залруулна. Төсвийн хувьд

цалингийн хувьд ганцхан шүүгчийн цалингаас гадна энэ бид нар энэ шүүхийн нарийн бичгийн дарга, туслахуудын цалинг хүртэл ёстой юм байна лээ.

Жишээлбэл ажлын ачааллын хувьд гээд бодоход дунджаар шүүхийн туслах нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа дундаж хугацаа 1 жил гэж байгаа юм. 1 хүн. Энэ бол маш тогтворгүй байна гэсэн үг. Яагаад гэхээр яг гар дээрээ авч байгаа цалин нь дунджаар 700 мянган төгрөг байна лээ. Тэгэхээр харьцангуй ийм цалинтайгаар их өндөр ачаалал бас үүрэг хариуцлагатай ийм зүйлийг миний ойлгосноор бол залуу насны эрч хүчээр нэг жил хийж байх шиг байна.

Тэрнээс цаашаа бол ер нь больё гэж байгаа юм байна лээ. Тэгэхээр ийм өөрөө байдал нь өөрөө шүүхийнхээ энэ бусад тэр чадавх, шийдвэр гаргалт, бусад бүх л юманд нөлөөлж байгаа ийм олон зүйл байгаа юм байна лээ. Тийм учраас энэ асуудлыг бол цогцоор нь шийдэх хүрээнд мөн Шүүхийн хуулийг дагаж гарах Улсын Их Хурлын тогтоолын төсөл гэж ажлын хэсгээс бас бэлдсэн. Энэ дээр яг цалин хангамжтай холбоотой бас нэн тодорхой ийм саналыг бас ажлын хэсгээс оруулж байгаа. Тэр үед нь эрхэм гишүүд та бүхнийг дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Ажлын хэсгийн ахлагч тэр хамгаалалт аюулгүй байдалтай холбоотой асуудлыг яаж зохицуулж шийдэж байгаа вэ гэсэн асуулт орхигдлоо гэж байна. Маршалын алба гэж тодорхой асуугаад байна. Шинэчилсэн найруулга шүү дээ. Хөндөөгүй гэж байна. Адьшаа гишүүн, Мөнхбаатар гишүүний нэр нэмээрэй. Адьшаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьшаа: Давхардчихлаа.

С.Бямбацогт: Асуулт давхардсан. Мөнхбаатар гишүүн асуултаа асууя.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурал шүүхийн тухай хуулийг шинэчлэн батлах гэж байна. Өөрөөр хэлбэл төрөөс шүүхийн талаар баримтлах бодлогоо шинэчилж байна гэсэн үг. Энэ хуулиар бол ажлын Засгийн газрын өргөн баригдсан хууль дээр ажлын хэсэг гарч ажиллаад нэлээн олон дэвшилтэд магадгүй ил тодорхой болгосон ийм хуулийн төсөл орсон учраас дэмжиж байгаа юм. Энэ яах вэ яг одоо хэлэлцэж байгаа энэ зүйлтэй холбогдуулаад хэлэхэд энэ шүүхийн хараат бус байдлын асуудал яригдаж байна. Ингэхээр энд нэг анхаарах бас нэг асуудал орчин үед шинээр бий болоод байгаа юм болов уу гэж би хараад байгаа юм.

Энэ бол энэ харилцаа холбоо мэдээлэл технологи бол хөгжсөн. Үүнтэй холбогдуулаад энэ сошиал медиа гээд хүн бүр үзэл бодлоо илэрхийлэх эрх маань бол нээлттэй болсон. Ингээд тодорхой хэрэг маргааны асуудлаар иргэд бол үзэл бодлоо илэрхийлдэг. Ямар зүйл анги ямар ял өгөх нь зүйтэй гэдгийг олон үзэл бодлоо илэрхийлж байгаа. Энэ бол одоо иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх нэг талын

эрх байх. Нөгөө талаар энэ асуудлыг бол зохион байгуулалтайгаар компаничилж явуулдаг асуудлууд байна. Тодорхой асуудлыг сошиал медиа энэ чиглэлээр зохион байгуулалтаа тавьж байгаад араас нь эрүүгийн хэрэг үүсгэдэг, тэгээд шүүдэг.

Тэгээд шүүхийн өмнө шүүх хурлын өмнө маш олон компанит ажлууд хийж зохион байгуулдаг. Энд шүүх өөрөө хараат бус байх энэ байдал хэрхэн хангагдах вэ? Энэ субъектив энэ мэдээллийн асар их урсгалын субъектив байдлаас нөлөөлөлд автахгүй байх энэ зүйлүүдийг энэ хуулийн энэ заалтуудад хангаж чадаж байгаа юу гэдгийг ажлын хэсгээс би асууя гэж бодож байгаа юм. Энэ бол ер нь манай ажлын хэсэг ч тэр цаашид одоо шинэ бий болж байгаа зүйл шүү дээ. Хараат бус байдал гэдэг дээр бол бид нар нөлөөллийн мэдүүлэг авах, шүүгч өөрөө хараат бус улс төрөөс хараат бус байх энэ тэр гэдэг зүйлээс ангид, шинэ бий болж байгаа ийм зүйл байгаа.

Одоо Өвөрхангай аймагт гэдэг юм уу нэг үйлдэгдсэн танхай хэрэг энэ Улаанбаатарт үйлдэгдсэн нэг олны танил хүний танхай хэрэг хоёр бол байлаа гэж бодоход олон нийтэд үзэн ядуулах шигших зүйл нь явсаар байгаад адилхан 2 хэрэг мөртөө өгч байгаа ял нь магадгүй одоо олны танил этгээдэд өгч байгаа ял нь илүү өндөр байх ч юм уу. Ийм зүйлүүд их олон байна нэг ижил хэрэг дээр гэхэд. Ийм учраас энэ шүүгч өөрөө субъектив энэ нөлөөлөлд автахгүй байх зүйлийг хэрхэн хангаж байгаа вэ гэдэг асуултыг асууя гэж бодож байна.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Мөнхбаатар гишүүн их чухал асуудал хөндөж байгаа юм. Энэ шүүхийн бие даасан байдал шүүгчийн хараат бус байдлыг бид хангах, хамгаалах гэдэг дотор хууль ёсны дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа шүүгчдийн албаны нэр хүнд дархлааг хуулиар баталгаажуулах хамгаалах асуудал бас багтаж яригдах ёстой. Өөрөөр хэлбэл шүүгчийн тэр шийдвэрт нөлөөлөх зорилгоор хууль бус нөлөөллийн ажиллагаануудыг компаничлах байдлаар явуулж байгаа ийм асуудал бол байгаа. Ажлын хэсэг дээр энэ асуудал бас нэлээн олон талаасаа яригдсан. Шүүгчид энэ тал дээр тодорхой саналууд гаргасан.

Тэр утгаараа Шүүхийн ерөнхий зөвлөлд харьяалуулж шүүгчийн алдар хүндэд хууль бусаар зориуд санаатай хэрэгт нөлөөлөх зорилгоор халдаж байгаа ийм үйл ажиллагааг тухай тодорхой төрлийнх нь тэр хэв шинжээр өөрөөр хэлбэл иргэний шинжтэй байна уу эсхүл энэ нь бүр гэмт хэргийн шинжтэй байна уу, тэр чиглэлээр нь Шүүхийн ерөнхий зөвлөл өөрөө шүүхдээ хандаж бас хууль хамгаалах байгууллагууддаа хандаж энэ шүүгчдээ хамгаалдаг байх ёстой. Энийг нь үүрэгжүүлж байгаа юм.

Тэгэхгүй болохоор одоо ямар нэгэн байдлаар энэ шүүгчдээ хамгаалдаггүй. Нөгөө шүүгч нь бүлтийчхээд яахаа мэддэггүй. Яагаад гэхээр хуульд зааснаар хамаагүй ярилцлага өгөөд байж болдоггүй. Өөрөө ийм хязгаарлалттай хүн шүү дээ энэ чинь бас. Хүний хувьд хуулиар нь хязгаарласан, хэвлэл мэдээлэлд ярилцлага өгөхийг нь хориглосон хуулиар нь. Байр суурь илэрхийлэхийг нь хязгаарлалттай. Тэгээд ингээд ярьж болдоггүй. Ийм зовлонтой байдалд байдаг юм. Тийм учраас энийг Шүүхийн ерөнхий зөвлөлд албан ёсоор үүрэгжүүлж байгаа. Шүүхийн ерөнхий зөвлөл үүнийхээ төлөө тэмцдэг байх ёстой энэ институтээ хамгаалдаг байх ёстой гэдгийг нь одоо хариуцлагажуулж байгаа юм.

Иргэний журмаар шүүхэд гаргаж болно. Захиргааны нэг албан тушаалтан байх юм бол тэрийг нь захиргааны шүүхэд нь хандах ёстой. Гэмт хэргийн шинжтэй бол энийг хууль хяналтын байгууллагад нь өгөөд шалгуулах ёстой. Үндсэн хуулийн шинжтэй зөрчил байвал цэцэд өгөөд шалгуулах ёстой. Тэр бүх түвшинд нь ажиллах тэр юмыг нь бол хийдэг байх ёстой. Нөгөө талаараа энэ хараат бус байдал гэдэг нь бол сая хэлсэнчлэн 70 хэддүгээр зүйл дээр яригдах байх. Мөнхбаатар гишүүнээ. Тэрэн дээр бас нэг оруулж байгаа өөрчлөлт бол энэ халдашгүй байдал гэдэгт энэ шүүгчийн хууль ёсны энэ ажил хэргийн нэр хүнд багтана шүү гэдгийг бүр ажлын хэсгээс шинээр оруулж өгч байгаа юм. Энэ ганцхан тэр бие мах бодь махан бодитой тэр зүйл биш. Энэ өөрөө тэр шийдвэрийг хараат бусаар гаргах гэж байгаа институт учраас энэ институтээ өөрөө бас хамгаалдаг. Тэр нэр хүндийг нь бас ингэж хамгаалж явдаг ийм байх ёстой гэдэг агуулгаар бас саналууд бэлтгэсэн байгаа.

С.Бямбацогт: Жаахан товчхон тодорхой хариулна хэдүүлээ. Асуултууд асууж дууслаа. Санал хураалт явуулна. 4.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгүүдийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6.1 дэх хэсэг болгож, 6.4 дэх хэсгийн “тухайлсан” гэснийг, 6.5 дахь хэсгийн “гадаад, дотоодын хүн, хуулийн этгээдээс аливаа” гэснийг хасаж, 6.7 дахь хэсэгт “Шүүхийн төсвийн урсгал зардлын хэмжээг төсвийн хэмнэлтээс бусад тохиолдолд өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмж, 6.11 дэх хэсгийн “шүүн таслах ажиллагаанаас” гэснийг “шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхээс” гэж өөрчлөх:

“6.1.Шүүх нь шүүх эрх мэдлийг аливаа этгээдээс хараат бусаар хэрэгжүүлнэ.” дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 14 гишүүн буюу 87,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. 7 дугаар 6 дээр гишүүдээс санал байхгүй тийм ээ.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. 7 дугаар зүйл дээр санал байхгүй учраас санал хураалт бас явагдахгүй. Бичгээр гарсан санал бас байхгүй байна. Нямбаатар сайд. Энэ найруулгын санал байгаа байх. 7.2 дээр тухайлсан гэж оруулсан найруулгын санал. Найруулга сүүлд нь бөөнөөр нь хураана.

8 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явагдахгүй. 8 дугаар зүйл санал гараагүй. Бичгээр гарсан санал байхгүй. Хуулийн төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Амарсайхан гишүүн. Мэтгэлцэх зарчим.

С.Амарсайхан: Энэ чинь 8 биз дээ.

С.Бямбацогт: Хуулийн төслийг 9 дүгээр зүйл.

С.Амарсайхан: Энэ ийм байгаа юм. Ерөнхий шүүгч хурал даргалдаг. Ерөнхий шүүгчийн хурал даргалах эрх бусад шүүгчтэй нэгэн адил байх ёстой. Өөрөөр хэлэх юм бол бусад шүүгчдэд шүүх хуралдааныг даргалах эрхийг бас ижил тэнцүү олгодог. Цаашилбал хэрэг маргааныг шийдвэрлэх хянан шийдвэрлэх ачаалал нь ижил тэнцүү байх ёстой гэж бодож байгаа юм. Одоо бол үндсэндээ тухайн шүүхийн ерөнхий шүүгч л хурлыг даргалж байгаа. Тэгээд тэр хэрээрээ тухайн шүүхэд шат шатанд шийдвэрлэгдэж байгаа дагнасан танхимуудад шийдвэрлэгдэж байгаа хэргүүд бол бас ерөнхий шүүгчийн нөлөөнд автдаг ийм зүйл мэр сэр байдаг. Иргэд олон нийт ч гэсэн шүүмжилж байдаг.

С.Бямбацогт: Ерөнхий шүүгчийн бүрэн эрхтэй холбоотой асуудал 15 дугаар зүйл дээр.

С.Амарсайхан: Шүүх хуралдаан даргалах гэсэн байна энэ дээр. Шүүх хуралдааныг даргалах гэж. Энийг хасаж байгаа.

С.Бямбацогт: 25 дээр та асуултаа асуучих уу, 25 зүйл дээр.

С.Амарсайхан: Тэгье. Тийм байна энэ дээр хасагдаж байгаа юм байна.

С.Бямбацогт: Хуулийн төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд алга байна. Асуулт асууж дууслаа. Санал байхгүй, гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй.

10 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Асуулт алга байна. Санал хураалт явуулъя. Гишүүдээс гарсан санал алга байна. Хуулийн төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Шүүхийн үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоо. Асуулт алга байна. Санал хураалт гишүүдээс бичгээр гарсан санал алга. Ажлын хэсгээс санал байхгүй байна. 12 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулъя. Алга байна. 13 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Шүүхийн үйл ажиллагаа нээлттэй ил тод байх. Асуулт алга байна. Ажлын хэсгийн

бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 5.Төслийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “мэдээлж болно” гэснийг “мэдээлнэ. Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журмыг Ерөнхий зөвлөл батална.” гэж, 13.6 дахь хэсгийн “дамжуулах” гэснийг “нэвтрүүлж болох” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 14 гишүүн буюу 87,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн 13 хураасан. 14 ярьсан уу? Одоо 15. 14 биз дээ тийм ээ? 14 дүгээр зүйл шүүхийн тогтолцоотой холбоотой холбогдуулан асуух асуулттай гишүүдийн нэрс. Тэгсэн тийм ээ нэгтгээд хураасан.

15.хуулийн төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явуулъя. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. 6.Төслийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3 дахь хэсгүүдийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 15.3 дахь хэсэг болгож, 15.4 дэх хэсгийн “тоог” гэсний өмнө “төрөл,” гэж нэмэх:

“15.3.Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний байршлыг тогтоох асуудлыг Улсын дээд шүүхтэй зөвшилцсөн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” Мөнх-Оргил гишүүн. Асуулт тасаллаа.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ 15.3-г өөрчлөн найруулсан дээр бид нар энийг чинь нөгөө ажлын хэсэг дээр шүүхийн ерөнхий зөвлөлөөр нь буцаагаад хэвээр үлдээе гэж яриагүй билүү? Ерөнхийлөгчөөс бол Ерөнхийлөгч өргөн барья гэсэн санал оруулж ирсэн. Тэгээд ярьж байгаад энэ ер нь Засгийн газар оролцоод байх ач холбогдолгүй юм байна. Шинээр шүүх байгуулах асуудлыг өөрчлөн байгуулах татан буулган асуудлыг Засгийн газрын саналыг аваад өргөн барьснаар нь явъя гэж бид нар ажлын хэсэг дээр ярьсан санагдаад байх юм. Би тийм санал гаргасан санагдаад байх юм.

Энэ шүүх байгуулах өөрчлөн байгуулах татан буулгах асуудал Засгийн газрын саналыг авахаас биш Засгийн газар санал энэ асуудлаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зохимжгүй шүү дээ гишүүдээ. Засгийн газрын анх өргөн барьсан хувилбар нь зөв байна шүү дээ. Ерөнхий зөвлөл Засгийн газрын саналыг нь аваад Ерөнхий зөвлөл Их Хуралдаа өргөн бариад Их Хурал нь шийддэг нь зөв биш үү. Энэ хоорондоо ингээд шүүх байгуулах асуудлыг хүртэл Засгийн газар өргөн бариад байх зохимжгүй шүү дээ. Би энэ саналыг эсэргүүцэж байгаа шүү цөөнх болж байгаа шүү 15.3 дээр.

С.Бямбацогт: Ерөөсөө энэ хууль дотор Засгийн газрын саналыг авч Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ганцхан ийм зүйл байна лээ энэ заалт байна лээ. Өөр газар ерөөсөө байхгүй байна лээ. Ажлын хэсгийн ахлагч Энхбаяр хариулъя.

Б.Энхбаяр: Энэ ерөөсөө шүүхийг байгуулах асуудлыг хэн Улсын Их Хуралд өргөн барих вэ гэдэг асуудлыг яриад байгаа юм. Сая Мөнх-Оргил даргын хэлж байгаагаар төслөөрөө бол Шүүхийн Ерөнхий зөвлөл Улсын Их Хуралд өргөн бариад Улсын Их Хурал байгуулна гэж байгаа юм. Гэтэл энэ маань өөрөө Үндсэн хууль зөрчинө. Яагаад вэ Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 3-т шүүхийг зөвхөн Үндсэн хууль бусад хуулийн дагуу байгуулна гэж байгаа. Өөрөөр хэлбэл шүүхийг хуулиар байгуулна. Хуулиар байгуулна гэдэг бол энийг хууль санаачлах эрх бүхий этгээд Улсын Их Хуралд өргөн барина гэсэн үг. Шүүхийн ерөнхий зөвлөл Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар хууль санаачлах эрх байхгүй. Тийм учраас Үндсэн хуулиа зөрчүүлэхгүй байх гэж нийцүүлж Засгийн газар Их Хуралд өргөн барина.

Гэхдээ Засгийн газар дураараа өргөн барихгүй. Улсын дээд шүүхтэй зөвшилцсөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэж байж Улсын Их Хуралд өргөн барина гээд Үндсэн хуульдаа нийцүүлж томъёолсон юм. Хэрэв энэ санал дэмжигдэхгүй төслөөрөө үлдвэл энэ төслийн заалт Үндсэн хуулийн цэц дээр очоод унана. Яагаад гэхээр Шүүхийн ерөнхий зөвлөл Улсын Их Хуралд хуулийн төсөл санаачилж оруулж ирдэг субъект биш. Ийм л Үндсэн хуульд нь нийцүүлсэн ийм агуулгын саналыг оруулж ирж байгаа юм. Тийм учраас ажлын хэсгийнхээ саналыг та бүхэн дэмжиж өгөөч гэж хүсэж байна.

С.Бямбацогт: Гишүүд ойлголцсон байх. Ер нь Засгийн газрын оролцоо бол зөвхөн энэ дээр л байна лээ. Өөр ерөөсөө хуулийн төсөлд Засгийн газар оролцох тийм зүйл заалт ер нь харагдахгүй байсан. Энэнээс өөр хувилбар байхгүй. Ажлын хэсэг дээрээ сайн ярилцаагүй юм уу? Саяын Энхбаяр ажлын хэсгийн ахлагчийн бас ярьж байгаа үндэслэл сонсогдож л байна. Ерөнхий зөвлөл хууль өргөн барих эрхгүй. Хууль санаачлах эрхтэй 78 субъектэд Засгийн газар үлдчихээд байгаа юм байна л даа тийм ээ. Эсхүл Их Хурлын гишүүд санаачлах болчихоод байгаа юм. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Би дахиад унших уу, санал хураалт хүчингүй. Би дахиад тайлбарлая. 6 дахь санал та бүхэнд тараасан материалын 6 дахь санал. Төслийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3 дахь хэсгүүдийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 15.3 дахь хэсэг болгож, 15.4 дэх хэсгийн “тоог” гэсний өмнө “төрөл,” гэж нэмэх:

“15.3.Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний байршлыг тогтоох асуудлыг Улсын дээд шүүхтэй зөвшилцсөн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэсэн томъёоллоор ажлын хэсгийн саналаар. Ажлын хэсэг дээр бол Ерөнхийлөгч байж болно, Их Хурал Засгийн газар байж болно гэж Засгийн газраас орж ирж байгаа юм байна. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал

хураалтад 16 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 75 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 16 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Шүүхийн бүрэлдэхүүн. Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. 7.Төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “шүүн” гэсний өмнө “шүүгчийн” гэж нэмж, 16.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 16.4, 16.5 дахь хэсэг болгож, 16.5 дахь хэсгийн “Томилолтоор ажиллах нийтлэг журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.” гэснийг “Томилолтоор ажиллахтай холбоотой харилцааг хэрэг, маргаан хянан шийдвэрлэх холбогдох хуулиар зохицуулна.” гэж өөрчлөх:

“16.4.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн түр эзгүйд, эсхүл сул орон тоо гарсан тохиолдолд дараагийн Ерөнхий шүүгч томилогдох хүртэл хугацаанд түүнийг хамгийн олон жил шүүгчээр ажиллаж байгаа танхимын тэргүүн орлоно.

16.5.Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийн түр эзгүйд, эсхүл сул орон тоо гарсан тохиолдолд дараагийн Ерөнхий шүүгч сонгогдох хүртэл хугацаанд түүнийг шүүгчээр хамгийн олон жил ажиллаж байгаа танхимын тэргүүн, эсхүл шүүгч орлоно.” Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Нямбаатар гишүүн та чинь ингээд. Нямбаатар гишүүн.

Х.Нямбаатар: Энэ хойшоогоо төслийн 22 дээр байгаа билүү нөгөө Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн бүрэн эрхтэй холбоотой зохицуулалт одоогийн энэ ажлын хэсгийн томъёолол энэ хоёрыг ингээд уялдуулаад харахаар ийм байдлаар уншигдах гээд байгаа юм. Энэ юу вэ гэхээр Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн түр эзгүйд эсхүл сул орон тоо гарсан тохиолдолд дараагийн ерөнхий шүүгч томилогдох хүртэл хугацаанд түүнийг хамгийн олон жил ажилласан олон жил шүүгчээр ажиллаж байгаа танхимын тэргүүн орлоно гэж байгаа юм. Хойд талын ажлын хэсгийнхний оруулж ирж байгаа саналаар юуг Ерөнхий шүүгчийг аль нэг танхимд харьяалуулахаар саналын томъёолол бичсэн байгаа юм.

Тэгэхээр Ерөнхий шүүгчийн ажиллаж байсан тэр танхимынх нь тэргүүн орлоно гэж уншигдах гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр шүүгчээр хамгийн олон жил ажиллаж байгаа аль нэг танхимын тэргүүн орлоно гээд аль гээд үг оруулбал илүү уншигдах нь энэ чинь 3 танхимынх нь аль нэгнийх нь тэгсэн мөртөө хамгийн олон жил шүүгчээр ажилласан танхимын тэргүүн орлоно гэж уншигдана. Үгүй бол тэр Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн бүрэн эрх түүнтэй холбоотой эрх зүйн байдлыг тодорхойлсон заалт дээр байгаачлан Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч нь өөрөө аль нэг танхимд харьяалагдаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр тэр улсын дээд шүүх өөрөө Ерөнхий шүүгч нь орон нь гарсан тохиолдолд тэр танхимынх нь тэрүүн л заавал орлоно гэсэн ийм агуулгаар уншигдахаар харагдаж байгаа юм.

С.Бямбацогт: Тэгж харагдахгүй л байна шүү дээ энэ чинь. Аль нэг танхим 3 танхимтай нь өөрөө нэг танхимд харьяалагдаж байгаа бол нөгөө 2 танхимынх нь

хамгийн олон жил ажиллаж байгаа танхимынх ахлах юм биш үү. Хамгийн олон жил гэдэг чинь ойлгомжтой шүү дээ. 3 танхимынхаас олон жил ажиллаж байгаа нь л ахална шүү дээ. 3-лаа яг нэг ижил ажилласан байхгүй шүү дээ тийм биз дээ. Адилхан байхгүй шүү дээ цаг хугацааны хувьд ч гэсэн. Адилхан байх боломжгүй биз дээ. Цааш нь явъя. Санал хураалт. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Цаг алдахгүй одоо. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 81,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гаргасан санал энэ зүйл заалт дээр алга байна. Энэ зүйл дээр.

Хуулийн төслийн 17 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. 17 шүүгчийн нийтлэг бүрэн эрх асуулт алга. Ажлын хэсгээс гарсан санал алга байна. Санал хураалт, байгаа юм уу. Тийм байна ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

8.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын “түүний” гэснийг хасаж, 17.1.6 дахь заалтын “тусгай” гэсний өмнө “хууль хэрэглээний талаар” гэж, 17.1.9 дэх заалтын “Ерөнхий шүүгч,” гэсний дараа “танхимын тэргүүн,” гэж тус тус нэмж, 17.1.7, 17.1.11 дэх заалтуудыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 17.1.10 дахь заалтын “Шүүгчдийн зөвлөлийн төлөөлөгч,” гэснийг, “мэргэшлийн болон” гэснийг тус тус хасаж, 17.2 дахь хэсгийн “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь оролцогчдын хүсэлтээр зохих” гэснийг “хэрэг, маргаан хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар” гэж өөрчлөх:

“17.1.7.энэ хуулийн 20.1-д заасан Нийт шүүгчийн чуулганд оролцох;”

“17.1.11.багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх;” Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 75 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүдээс гарсан санал байхгүй 17 дээр бичгээр гаргасан санал байхгүй байна.

18 дугаар зүйл. Асуулт асуух гишүүд байна уу, алга байна. 18 дээр ажлын хэсгээс зарчмын бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 9.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 18.1.3 дахь заалтын “шүүх хуралдааныг даргалах,” гэснийг хасаж, 18.1.4, 18.1.5 дахь заалтуудыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 18.1.4 дэх заалт болгож, 18.1.7, 18.1.8 дахь заалтуудыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 18.1.7-18.1.9 дэх заалт болгож, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 18.2 дахь хэсэг нэмж, 30 дугаар зүйлийг хасах:

“18.1.1.тухайн шүүхийг бүрэн эрхийнхээ хүрээнд төлөөлөх;

18.1.4.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамааралгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдолд Тамгын газраас хариу өгч байгаа ажиллагаанд хяналт тавих;

18.1.7.танхимын тэргүүний ажлыг уялдуулах;

18.1.8.шүүхийн практик, тоон мэдээлэлд үндэслэн шүүн таслах ажиллагааны чанар, үр дүн, хэргийн хөдөлгөөний ерөнхий удирдлага, хяналтын талаар Зөвлөгөөнд мэдээлэл хийх;

18.1.9.хуульд заасан бусад бүрэн эрх.”

“18.2.Ерөнхий шүүгч шүүн таслах ажиллагаанд оролцохдоо давуу эрх эдлэхгүй.” Ерөнхий шүүгчийн бүрэн эрхтэй холбоотой. 18.1.4 дээр би өргөдөл гомдолд Тамгын газраас хариу өгч байгаа хяналт тавих гээд өргөдөл гэсэн үг орхисон байна шүү. Дахиад хэлье протоколд. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 15 гишүүн буюу 93,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Амарсайхан гишүүн 18.2 дээр ерөнхий шүүгч шүүн таслах ажиллагаанд оролцохдоо давуу эрх эдлэхгүй гэж түрүүн таны хөндөж байсан заалт энд орсон. Тийм.

Хуулийн төслийн 19 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Танхимын тэргүүний бүрэн эрх гээд. Асуулт алга. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. Тийм.

10.Төсөлд доор дурдсан агуулгатай 19 дүгээр зүйл нэмж, 31, 33 дугаар зүйлүүдийг хасах:

“19 дүгээр зүйл.Танхимын тэргүүний бүрэн эрх

19.1.Танхимын тэргүүн энэ хуулийн 17.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.1.1.танхимыг тэргүүлж, шүүх хуралдааны бэлтгэл ажлыг хангахад танхимын шүүгч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын ажлыг уялдуулан зохион байгуулах;

19.1.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамааралгүй асуудлаар иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэхэд Тамгын газарт туслалцаа үзүүлэх;

19.1.3.хуульд заасан бусад бүрэн эрх.

19.2.Танхимын тэргүүн шүүн таслах ажиллагаанд оролцохдоо давуу эрх эдлэхгүй.

19.3.Танхимын тэргүүн бүрэн эрхийнхээ хүрээнд захирамж гаргана.” Цааш нь унших уу, болсон биз дээ. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцсоноос 15 буюу 88,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулъя. Байхгүй байгаа тийм ээ, байхгүй байна.

Хуулийн төслийн 20 дугаар зүйлтэй холбогдуулан, тийм үү. 19 дээр дахиад нэг санал байгаа шүү. 19 дээр дахиад санал байгаа гишүүдээ.

11.Төслийн 19 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19 дүгээр зүйл.Шүүгчдийн зөвлөгөөн

19.1.Шүүхэд тухайн шүүхийн нийт шүүгчээс бүрдсэн Зөвлөгөөн ажиллана.

19.2.Зөвлөгөөн дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

19.2.1.тодорхой хэрэг, маргаан хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн дотоод ажлын зохион байгуулалт, журмыг хуульд өөрөөр заагаагүй бол тогтоох;

19.2.2.шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоох;

19.2.3.шүүгчийг мэргэшүүлэх сургалтын саналаа энэ хуулийн 24.1-д заасан Хүрээлэнд хүргүүлэх;

19.2.4.тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийг шүүгчид дотроосоо сонгох;

19.2.5.энэ хуулийн 19.3-т заасан нөхцөл, шаардлага болон энэ хуулийн 20.2.4-т заасан нийтлэг журамд үндэслэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргаан хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журмыг батлах;

19.2.6.энэ хуулийн 18.1.8-д заасан мэдээлэлтэй танилцах;

19.2.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

19.3.Энэ хуулийн 19.2.5-д заасан журам нь хуваарилагдах шүүгчийг урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан байх бөгөөд дараах шаардлага хангасан программ хангамжийг ашиглана:

19.3.1.шүүх хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан даруй хуваарилалтыг хийх, Зөвлөгөөний шийдвэргүйгээр өөрчлөх боломжгүй хамгаалалттай байх, хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг оролцогч этгээдэд шууд өгөх боломжтой байх;

19.3.2.цахимаар хийгдсэн хуваарилалтыг гагцхүү хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар зөвшөөрөгдсөн татгалзал, эсхүл шүүгч, шүүх бүрэлдэхүүн солигдох бусад нөхцөлд өөрчлөх бөгөөд уг өөрчлөлт нь хүний нөлөөллөөс ангид, ил тод, баримтжуулсан байх.

19.4.Энэ хуулийн 19.2.5-д заасан журам олон нийтэд нээлттэй байна.

19.5.Зөвлөгөөн ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байх бөгөөд ээлжит зөвлөгөөнийг улиралд нэгээс доошгүй удаа, ээлжит бус зөвлөгөөнийг тухайн шүүхийн шүүгчдийн гуравны нэгийн, эсхүл танхимын, эсхүл Ерөнхий шүүгчийн саналаар хуралдуулна.

19.6.Шүүгч Зөвлөгөөнөөр хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцах, санал гаргах, хуралдаанд оролцох тэгш боломжоор хангагдах бөгөөд шийдвэр гаргах үйл явц нь нээлттэй, шуурхай, үндэслэл бүхий байна.

19.7.Зөвлөгөөн хуралдааныхаа дэгийг өөрөө тогтооно.

19.8.Тухайн шүүхийн шүүгчдийн дийлэнх олонх оролцсоноор Зөвлөгөөнийг хүчинтэйд тооцох бөгөөд энэ хуулийн 19.2-т заасан асуудлыг Зөвлөгөөнд оролцсон шүүгчдийн олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана.” Б.Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Энэ бол энэ хуулийн бас амин сүнс нь байх шиг байна. Шүүгчдийг зөвлөгөөнөөр хуваарилдаг, өөр дээрээ хэрэг татаж авахаас болгоомжилсон, тэгээд энэ хуваарилж байгаа тэр хэрэг маргааных нь асуудал дээр шууд нэхэмжлэл гаргасан хүнд шууд томилоод өгчихдөг энэ тэр. Энэ бол тэгээд сүүлдээ зөвлөгөөнөөр энэ асуудлаа шийддэг түүнээс нэг 1, 2 шүүгч дураараа асуудалд оролцдоггүй. Хуваарилалтад оролцдоггүй ийм байх асуудал ярьж байгаа юм байна.

Энэ би 19.3.2 дээр асуугаад байна л даа. Цахимаар хийгдсэн хуваарилалтыг гагцхүү хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар зөвшөөрөгдсөн татгалзал эсхүл шүүгч шүүх бүрэлдэхүүн солигдох бусад нөхцөлд үүсэх бөгөөд уг өөрчлөлт нь хүний нөлөөллөөс ангид ил тод, баримтжуулсан байна гэж. Энэ цахимаар хийгдэж байгаа юмаа яаж ил тод баримтжуулах юм бэ? Одоо тэр нөгөө оператор дээр сууж байгаа тэр barcode мэдэж байгаа нэг нөхөр л хуваарилаад хаячихдаг шүү дээ. Тэгэхээр зэрэг тэр яг одоо цахимаар хийгдэж байгаа юм дээр энэ ямар ч байсан нөлөөлөлгүйгээр хуваарилагдлаа гэдгийг яаж баримтжуулах вэ гэж би асуух гээд байгаа юм. Энэ олон нийтэд нээлттэй байна гээд ингээд зарлах юм байна л даа. Тэр журмаа бол.

Тэгэхээр зэрэг би энэ цахим дээрээс жаахан болгоомжлоод байгаа байхгүй юу. Энийг надад нэг тайлбарлаад өгөөч.

С.Бямбацогт: Цогт шүүгч 1 дүгээр микрофон Улсын дээд шүүхийн шүүгч Цогт.

Ц.Цогт: Асуултад хариулъя. Тэгэхээр энэ өмнө жилүүдэд бас энэ цахимаар хэрэг хуваарилагддаг арга бол хэрэглээд явж ирж байгаа. Энэ дээр хамгийн гол асуудал юундаа байгаа вэ гэхээр тухайн үедээ хуваарилалт нь хийгддэггүй. Тодорхой хугацааны дараа хийгддэгээс болоод энэ хооронд ямар нэгэн байдлаар хэргийн нэхэмжлэл хуваарилахад хүний оролцоо ордог, нөлөөлөл ордог гэдэг ийм шүүмжлэл гарч байгаа. Тийм учраас бол төсөл дээр хийж байгаа гол агуулга бол тухайн үед нь хүн нэхэмжлэлээ авчраад өгсөн хүн бараг өөрөө тэр кнопоо дараад тэгээд тэр автоматаар хуваарилалт нь хийгдээд хэн гэдэг шүүгч дээр хэрэг нь очсон баримтаа өөрөө аваад тухайн үедээ ингээд явдаг. Үүнээс хойш нөгөө шүүгч солигдохгүй байх тэр алтан зарчим нь бол өөрөө заавал хэрэгжиж байх ёстой гэдэг агуулгаар энэнээс хойш аливаа шүүгч өөрчлөгдөх тохиолдолд гагцхүү хуульд заасан тэр үндэслэлээ 1 дүгээрт өөрчлөгдөнө.

2 дугаарт тэр нь бүгд бичлэгтэй баримттай, шүүгчдийн зөвлөгөөний тогтоолтой тийм тохиолдолд л өөчилнө гэсэн юм байгаа. Дараагийн нэг асуудал нь бол яах вэ ер нь энэ цахим хуваарилалттай холбоотой асуудал дээр бол давхар нөгөө хөндлөнгийн тэр мониторинг бас хийгдэх тэр нь бас хийгдсэн мониторинг нь сонирхсон этгээдүүдэд ил байх ийм агуулгыг бас энэ төсөлд тусгасан байгаа.

С.Бямбацогт: Хариулт хангалтай юу тийм ээ. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцсоноос 14 гишүүн буюу 82,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулъя. Пүрэвдорж гишүүн санал гаргасан байна. Шүүхийн тухай хуулийн 19.9-д заалт нэмэх. Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрх, эрх чөлөөнд Улсын дээд шүүхийн шийдвэрээр хангагдаагүй зөрчигдсөн гэж үзэж буй бол Монгол Улсын иргэн Үндсэн хуулийн цэцэд уул эрхээ хангуулахаар хамгаалуулахаар гомдол гаргах эрхтэй. Санал гаргасан Пүрэвдорж гишүүн. Саналаа тайлбарлах уу, Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрх чөлөө нь Улсын дээд шүүхийн шийдвэрээр хангагдаагүй, зөрчигдсөн гэж үзэж буй бол Монгол Улсын иргэн Үндсэн хуулийн цэцэд уг эрхээ хамгаалуулахаар гомдол гаргах эрхтэй гэж. Өөрөөр хэлбэл өнөөдөр энэ шүүхийн тухай хуулиар шүүх дээд шүүх дээр маргаан шийдэх тоо бол маш их багасна гэж байгаа. Ойролцоогоор бараг 50 хувиар багасна гэсэн ийм тооцоолол байгаа. Тэгэхээр дээд шүүх рүү ирдэг маргааны ихэнх нь бол иргэний гомдолтой холбоотой байдаг. Тэгээд иргэн хүн гомдол гаргаад дээд шүүх хүртэл яваад, дээд шүүхийн дараа хэн ч хандах боломжгүй хий дэмий Ерөнхийлөгчид нэг гомдол гаргаад ингээд л явдаг.

Гэхдээ энэ гомдлоо Үндсэн хуулийн цэцэд гаргаад яг тэр нөгөө нэг Үндсэн хуульд заасан тэр заяагдмал эрхийг маань зөрчсөн гэж үзээд энэнийх нь дагуу гомдол гаргаад тэрнийх нь дагуу Цэц шийдвэр гаргах юм бол бас энэ Үндсэн хуульд заасныхаа цэц дээд шүүхийн шүүгч ерөнхий шүүгчдэд хариуцлага тооцдог ийм л механизмыг оруулж ирье гэж байгаа юм. Тэгэхээр ер нь бол би дахиад тэрний дараа 58 дугаар зүйл дээр бас Их Хурал дээр импичмент тооцдог шүүгчид импичмент тооцдог ийм саналыг бас гаргана. Тэгэхээр дээд шүүхийн шүүгч Ерөнхий шүүгч бол ийм ганцхан сахилгын хороонд харьяалагддаг, ганцхан сахилгын хороо гэдэг даргатай байх юм бол бас энэ яг шүүгчийнхээ ёс зүйг баримталж бас шийдвэр гаргаж чадахгүй гэж үзэж байгаа.

Тэгэхээр олон даргатай болох. Өөрөөр хэлбэл цэц гэдэг нэг асуудлыг нь шийддэг газартай, дээрээс нь Их Хурал дээр импичмент тооцдог ийм 3 даргатай олон хүнтэй болчих юм бол яах вэ энэ шүүх чинь ийм олон хүмүүст таалагдаж асуудал шүүхийн үйл ажиллагаа явуулж байхын оронд ерөөсөө шударгаар асуудлаа шийдье. Намайг хариуцлага тооцдог маш их олон хүн байна. Тэд нарт бол бүх хүнд таалагдах гэж явж байхын оронд асуудлаа зөвөөр шийдье гэдэг л ийм л зүйл бий болно гэж үзэж байгаа. Тийм учраас энэ саналыг гаргасан. Ялангуяа одоо дээд шүүхэд хандаад эрх нь хангагдаагүй тэр хүмүүс бол маш их гомдолтой хоцордог. Ийм хүмүүсийг дахиад нэг шат тэртээ тэргүй Үндсэн хуулийн цэц дээр бол Үндсэн хуульд заагдсан

тэр хүний заяагдмал эрхтэй холбоотой асуудлыг шийдэх ийм боломж байгаа учраас энэ заалтыг та бүхэн дэмжиж өгөөч гэж хүсэж байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Пүрэвдорж гишүүнээ энэ Үндсэн хууль зөрчсөн санал хураалт болох гээд байна. 48 дугаар зүйл. Үндсэн хуулийн. 48 дээр бишээ ерөөсөө Шүүхийн шийдвэр эцсийн байна гэсэн Үндсэн хуулийн заалт байгаа. Хэд дээр байгаа билээ, 50.2. Улсын дээд шүүхийн шийдвэр тийм үү эцсийн байна. Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ. Энэ 50.2. Улсын дээд шүүх нь бусад шүүх бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй албан ёсны нийтлэг хуулийг хэрэглэхгүй гээд.

Үндсэн хуулийн цэцийн үүрэг бол 60 дугаар зүйл дээр Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ. Ингээд Үндсэн хуулийн 2 ч заалт зөрчигдөх гээд байна. Саналаа яах уу, хураах уу, хураахгүй. Дэгийн хуулиар хууль зөрчсөн санал хураахгүй. 19 дээр бичгээр гаргасан саналуудаар санал хураалт явуулж дууслаа.

Хуулийн төслийн 20 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Шүүгчдийн зөвлөл Нямбаатар сайд, Б.Энх-Амгалан гишүүнээр тасаллаа. Дэлгэрсайхан гишүүнээр тасаллаа. Эхлээд Нямбаатар сайд. Нямбаатар гишүүн.

Х.Нямбаатар: Би энэ ажлын хэсгийн гаргасан санал агуулгын хувьд ерөөсөө зөрчигдөх зүйл нэг ч байхгүй. Энэ санал бол анх ажлын хэсгийн гишүүн Алтанхуяг гишүүнээс гарч байсан. Энэ нөгөө 510 хэдэн шүүгчдээ нийтэд нь хуралдуулаад 4 жил тутам нэг удаа хуралдуулаад тэгээд энэ Үндсэн хуулийн байгууллагууд болох Шүүхийн ерөнхий зөвлөл, Сахилгын хороонд орох хүмүүсээ сонгох энэ эрхийг л энэ нийт шүүгчдийн хуралдаан гэдэг одоо хуралдаан шийдэхээр байгаа юм.

Тэгэхээр Байнгын хорооны даргаа та энэ дээр нэг анхааралтай хандуулмаар байна. Хуралдаан гэхээр юуг хэлж байна вэ гэвэл дандаа шүүх хуралдаан. Хэрэг маргаан хянан шийдвэрлэж байгаа хуралдаануудыг хуралдаан гээд байгаа юм. Би тэгэхээр нэр томъёоны хувьд энийг юу болгоё нийт шүүгчдийн чуулган гэж нэрлэхгүй бол бүх шүүхийн хуралдаануудаас ялгагдахгүйгээр уншигдаад байгаа юм. Зөвлөгөөн гэхээр өмнө нь зөвлөгөөний тухай яригдсан. Зөвлөгөөн бол илүү захиргааны шинж чанартай тийм ийм нэршил байгаа юм.

Тэгэхээр би ямар зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа вэ гэвэл ажлын хэсгийн гаргасан энэ бүх томъёоллуудтай санал нэг байгаа бөгөөд нийт шүүгчдийн

хуралдаан гэдгийг нийт шүүгчдийн чуулган гэж нэрлэе. Энэ бол 4 жилд нэг удаа хуралдана. Энэ хуралдааны үндсэн зорилго чиг үүрэг бол нөгөө шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчдийн сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгчдийг сонгож огцруулах ийм л эрх эдэлж байгаа юм. Энэ бол тодорхой хэрэг маргаан хянан шийдвэрлэдэг ийм чиг үүрэггүй. Нөгөө саяын ярьж байгаа 518 билүү Атарцэцэг шүүгчээ 518 шүүгч 4 жилд нэг удаа л чуулж байгаа юм. Чуулаад ерөөсөө тодорхой асуудал хэлэлцээд л сонгоод л нэр дэвшүүлээд л энэ хурлын зорилго хангагдана.

Бусад нь болохоор одоо энэ Шүүхийн тухай хууль дээр дандаа хуралдаан гэсэн нэр томьёонууд яваад байгаа юм. Тэгэхээр энийг гишүүд дэмжиж өгөөч, энийг чуулган гэдэг нэрээр сольж өгөөч гэсэн санал оруулж байна.

С.Бямбацогт: Зарчмын зөрүүтэй санал гаргасан юм байна хураалгая. Бичгээр гарсан байна ирсэн байна. Амарсайхан гишүүн асуултаа асууя.

С.Амарсайхан: Энэ 17.1.10, 20.7 дээр байсан мэргэжлийн зөвлөл гэдэг зүйл хасагдсан байна. Бид нар чинь шүүгчдээ ерөнхийдөө бие даасан мэргэжлийн хараа бус байлгана гээд байдаг. Гэтэл сахилгын хороо байна. Ёс зүйн алдаа гаргавал ёс зүйн сургалтад суухыг даалгана гэсэн мөртөө мэргэжлийн сургалтад өөрийн хүсэлтээр сууж болно. Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулж болно гээд. Хамгийн чухал зүйлээ ингээд хасаад хаясан байгаад байдаг. Өөрөөр хэлбэл шүүгчдээ хариуцлага тооцох асуудал яриад байгаа.

Тэгсэн хэр нь мэргэжлийг нь дээшлүүлэх, албан ёсны зохион байгуулалт хуулийн зүйл заалтаа хасаад хаяж байгаа нь өөрөө энэ хуулийн үзэл баримтлал үнэт зүйлтэй нийцэхгүй байна гэж харж байгаа. Ямар учраас энэ мэргэжлийн зөвлөлийг хасаад хаясан бэ, мэргэжлийн алдаа гаргасан бол тэр шүүгчийн ажил хэргийн ур чадвар мэргэжлийн түвшнийг тодорхойлох зайлшгүй шаардлагатай сургалтад хамруулах үнэхээр мэргэжлийн алдаа гаргасан юм уу эсхүл ёс зүй авир аашны алдаа гаргасан юм уу гэдгийг тогтоодог ийм зөвлөл байж энэ шүүх өөрөө мэргэжлийн байх үндэс бүрдэнэ. Тэгэхээр энэ дээр тодорхой хариулт өгөөч. Яагаад тэгээд 58 дээр байсан шүүгчийн үндсэндээ оногдуулах шүүгчийн мэргэжлийн хариуцлагын зөрчил гэдэг зүйлийг 58-г тэр чигээр нь бас хасаад хаясан байгаад байгаа юм.

Энэ дээр ер нь ур чадварыг дээшлүүлэх ур чадварын түвшинг тодорхойлох тал дээр ер нь энэ хуулиар ямар тодорхойлолтыг бид ажил хэрэг дээр нь авч хэрэгжүүлэх юм бэ, хассан шалтгаанаа хэлээч гэж.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Амарсайхан гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ бол цэвэр Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 сарын 16-нд орсон өөрчлөлтийн үзэл

баримтлалаас үүдэж гарч ирж байгаа. Өөрөөр хэлбэл хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх огцруулах болон сахилгын бусад шийтгэл ноогдуулах чиг үүрэг бүхий шүүхийн сахилгын хороо ажиллана гэж байгаа юм. Энэ бол Үндсэн хуульд орсон өөрчлөлт байгаа. 49 дүгээр зүйлийн 6. Тэгэхээр энэний дагуу одоо энэ шүүгчийн тэр мэргэжил, ёс зүй, хариуцлагын асуудлуудыг бол шүүхийн сахилгын хороо хариуцаж ажиллана.

Ингэхдээ ер нь бол энэ манай шүүх системийнхэн бол энэ шүүх систем ч яах вэ дээ манай энэ дээд шүүхийн зарим шүүгчид бол юу яагаад байгаа юм. Мэргэжлийн хороогоо байлгаад сахилгын хорооны хяналтаас гарах гээд байгаа юм. Тэгээд сахилгын шинжтэй хуулийг илт буруу хэрэглэж байгаа хууль хэрэглээний алдаатай шийдвэрүүдийг гаргаж байгаа шийдвэртэй үндэслэлээ бичдэггүй талуудын гаргаж ирж байгаа эш үндэслэл баримтыг үнэлдэггүй, нэг талд үндэслэж шийдвэрээ гаргадаг энэ асуудлуудаа болохоор мэргэжлийн алдаа гэдгээр сахилгын хорооны хариуцлагаас гаргах гээд байгаа юм. Шуудхан хэлэхэд. Өөрөөр хэлбэл өөрсдийнхөө ийм захиалгатай эсхүл ур чадваргүй хуулийг илтэд буруу хэрэглэж байгаа энэ алдаа дутагдлаа энэ бол мэргэжил чадвар алдсан дутсан гэдэг ийм уутны хүрээнд нөгөө сахилгын хорооноос хариуцлагаас гаргах гээд байгаа юм.

Шуудхан хэлэхэд хариуцлага өөрсдөө эндээ хүлээдэггүй байх гээд байгаа юм. Тэгэхээр яах гэж Үндсэн хуулийн өөрчлөлтөөр энэ сахилгын хороог гаргаад бие даалгаад Үндсэн хуулийн байгууллага болгоод байна вэ гэхээр ерөөсөө энэ шүүхийн шийдвэр гэдэг чинь өөрөө үндэслэлтэй гарах ёстой. Тодорхой гарах ёстой. Талуудын гаргаж байгаа баримтуудад үнэлгээ хийдэг байх ёстой. Энэ үнэлж байгаа байдал нь өөрөө яг мэргэжил ухаан дутаад байна уу, эсхүл санаатай гаргаад байна гэдэг чинь ялгахад хэцүү, хүний дотор тархинд ороод үзээгүй л бол хэцүү. Өнөөдрийг хүртэл энэ мэргэжлийн алдаа дээрээ хариуцлага хүлээж байгаа байдал туйлын хангалтгүй байгаа.

Яагаад гэхээр сая хэлсэнчлэн санаатай ийм зөрчил дутагдал гаргаад үүнийгээ мэргэжил ухаан жаахан дутсан ухааны юм ярьж ингэж аргалж өнөөдрийг хүртэл хуулийн хариуцлагаас гадуур байж ирсэн. Одоо тийм юм байхгүй. Тийм учраас энэ Үндсэн хуульд нэгэнт байгуулсан учраас энэ мэргэжлийн хороо гээд энэ Үндсэн хуулийн байгууллага ч биш шүү дээ. Энэ ерөнхий зөвлөл дотор байгаа. Ерөнхий зөвлөлийн өөрийнх нь нэг бий болгосон шалгалт авдаг ийм институт байхгүй юу. Институт гэхэд бас биш. Тэгээд асуудал болонгуут энэ рүү чихээд энэний урд хормойгоор гэх үү, хойд хормойгоор гэх үү гарч хариуцлагаас зугтдаг энэ буруу практикаа хадгалах гээд байгаа юм.

Тийм учраас үүнийг нь хуулиар бүхэлд нь сахилгын хороонд харин илүү дэлгэрүүлээд өөрөөр хэлбэл яг ямар, ямар чиглэлийн алдаа дутагдал гаргавал сахилгын хороо хариуцлага тооцох вэ гэдгийг нь 52 дугаар зүйлд нэн тодорхой

заагаад оруулж ирж байгаа юм. Энэ нь нөгөө талаасаа бол шүүгчээ бас хамгаалж байгаа юм. Яагаад гэхээр ийм ерөнхий байдлаар биш нэгэнт Үндсэн хуулийн ийм том эрхтэй сахилгын хороо байгуулагдаж байгаа юм бол маш тодорхой үндэслэлээр хариуцлага тооцдог байх ёстой. Тухайлбал шүүхийн шийдвэрийнхээ үндэслэлийг.../минут дуусав/

С.Бямбацогт: Амарсайхан гишүүн тодруулах уу?

С.Амарсайхан: Энхбаяр гишүүний ярьж байгаатай бол санал нэг байгаа. Сахилгын хороо мэдээж байх ёстой. Сахилгын хороог мэргэжлийн хороогоор солино гэдэг утга агуулга санаагаар хэлээгүй. Давхар сахилгын хороо гэж байгаа бол мэргэжлийн хороо гэж байж энэ шүүгчдээ бас мэргэших чадавхжих эрхээ хамгаалах өөрийгөө хөгжүүлэх тэр боломжийг нь давхар нээж өгөх ёстой гэж. Мэдээж Үндсэн хуульд сахилгын хороотой байна гээд заасан учраас энэ асуудал яригдаж байгаа гэдгийг ойлгож байгаа. Гэхдээ Үндсэн хуулиар мэргэжлийн хороотой байж болохгүй гэж заагаагүй. Үндсэн хуульд бол бас хориглосон зүйл байхгүй учраас мэргэжлийн хороотой байх нь зүйтэй юм гэж үзэж байгаа юм.

Сахилга гэдэг нэрийн доор мэргэжлийн нь ч хольж хутгаад сахилгыг нь ч хольж хутгаад ёс зүй нь ч мэдэгдэхгүй сүүлд нь нэг холион бантан болсон юу нь ч мэдэгдэхгүй ийм шийдвэр гардаг асуудал ярьдаг, цаг үрдэг ийм байх шаардлагагүй юм.

С.Бямбацогт: Сүхбаатар гишүүн дараа нь Мөнхтуяа шүүгч хариулъя гэж байна уу тийм ээ ажлын хэсэг сонсьё бас. Сүхбаатар гишүүн дараа нь Мөнхтуяа шүүгч бэлдэж байгаарай.

Ж.Сүхбаатар: Амарсайхан гишүүний асуултад бас нэмж хариулъя гэж бодож байна. Энэ шүүгчийн мэргэжлийн түвшинг давтан сургалт мэргэжил мэдлэг дээшлүүлэх асуудал орхигдсон уу гэдэг асуудал яриад байх шиг байгаа юм нэг талаас. Тэгэхээр энэ төслийн 50 дугаар зүйл дээр шүүгчийн мэргэшлийн түвшинг дэмжих ажил байгаа. Заалтууд байж байгаа. Шүүгчийн мэргэжлийг дээшлүүлэх давтан сургах ажлыг шүүхийн ерөнхий зөвлөл улсын дээд шүүхтэй хамтран зохион байгуулна гэж заасан байгаа.

Мөн шүүхийн сургалт судалгаа мэдээллийн хүрээлэн улсын дээд шүүхийн дэргэд ажиллана гэж байж байгаа. Шүүхийн ерөнхий зөвлөлтэй тэр бусад юу хөтөлбөр энэ тэрээ зөвшилцөөд батлаад ингээд ажиллаад явдаг. Тэгэхээр энэ утгаараа бол шүүгчийн давтан сургалт энэ шүүхийн ерөнхий зөвлөл өөрөө шүүхийн захиргааны байгууллага байхгүй юу. Тэгэхээр таны хэлдэг хүний нөөцийн удирдлага бол үндсэндээ Шүүхийн ерөнхий зөвлөл дээр төвлөрч байгаа. Тэр хүний нөөцийн нэг хэсэг нь таны хэлээд байгаа мэргэжлийн түвшинг дээшлүүлэх, үнэлэх, дүгнэх.

Жишээлбэл сая Энхбаяр гишүүний тэр хэлээд байгаа шүүгчид нэр дэвшигчээс анх мэргэжлийн шалгалт авч байгаа нь хэн билээ дээ гэхээр Шүүхийн ерөнхий зөвлөл зохион байгуулж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энийгээ шүүхийн мэргэжлийн шалгалт авч байгаа бол шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтэц дотор таны хэлээд байгаа мэргэжлийн түвшинг үнэлэх дүгнэх ажлууд мэргэжлийн алдаан дээр ажиллах асуудлууд тэрэн дээр үндэслээд жишээлбэл дээд шүүх бол онолын шүүх маягийн энэ чиглэл рүү явуулахаар бид түлхэж өгч байгаа юм. Хуулийн хэрэглээ талаас. Энэ дээр ер нь шүүгч нарын ур чадварын асуудал аяндаа гараад ирнэ. Яагаад гэвэл шүүхийн сургалт судалгааны мэдээллийн хүрээлэн энд судалгаа хийнэ, сургалт зохион байгуулна. Шийдвэрээ гаргана. Тэгээд энэ болгон дээр бол шүүгч нар бол үндсэндээ мэргэжлийн алдаа яг хэрхэн яаж гарч байгаа гэдэг нь гараад ирнэ.

Тэрийг нь дагуулаад шүүхийн ерөнхий зөвлөл дээд шүүх хоёр давтан сургах, мэргэшүүлэх тэр түвшнийг нь дээшлүүлэх асуудлаа хийнэ. Ер нь бол мэргэжлийн алдааг бол шүүх дээр өөгшүүлж болохгүй бусад газартай харьцуулахад бол. Бид бол шүүх гэдэг бол шүүгч гээд хэлсэн байхгүй юу. Мэргэжлийн ялимгүй өчүүхэн алдаануудыг магадгүй одоо асуудлуудыг бид нар бол яах вэ ойлгож одоо ингээд давтан сургах гэхэд л тэнд хүний хувь заяа шийдэгдэж байгаа байхгүй юу. Бүх асуудал тэрэн дээр шийдэгдээд явчхаж байгаа. Тэгэхээр энэ асуудал бол сахилгын асуудалтайгаа холбогдох ёстой. Сахилгын арга хэмжээ авагдах хэрэг үүсгэхдээ шалгагдах явцдаа сахилгын яг зөрчил болоогүй байх юм бол тэнд мэргэжлийн асуудал байх юм бол тэр асуудал нь тэр шүүх дүгнэлтээ хийгээд шүүгчийгээ Шүүхийн ерөнхий зөвлөл нь анхаараад ингээд засаж сайжруулах ажлууд цаашид чиг үүргүүд нь бол энэ ерөнхий тогтолцоогоороо орхигдохгүй байхгүй юу даа.

Энэ хуулийн ажлын хэсгийн гол зорилго бол шүүхийн ерөнхий зөвлөл нь энэ ажлаа хийгээд явах бололцоо байна. Бусад ажлын зохион байгуулалтуудаар энэ бусад механизмуудаар энэ бол хийгдэнэ гэж үзэж байгаа. Түүнээс дахиад тусад нь ингээд олон бид нар чинь сахилгын хороо шүүхийн ерөнхий зөвлөл дээд шүүх, сургалт судалгааны хүрээлэн зөвлөгөөн хуралдаан одоо тэгснээ мэргэжлийн хороо гэж. Тэрийг бол шүүхийн зөвлөл бүтцээрээ ажиллаж байхад тэр журам юмнуудаа хийгээд явахдаа тодорхой өөрийнхөө дотор хийгээд явж болох байх. Бид 10 хүнтэй ийм шүүхийн ерөнхий зөвлөлийг шинээр байгуулах гэж байгаа шүү дээ. 2 дахин нэмэгдүүлээд.

Тэгэхээр энэ бол орхигдохгүй юм гэж. Ер нь манай энэ шүүхийн энэ юугаараа давж заалдах шатны шүүх дээр нэлээн хэрэг маргааны үйл ажиллагаа төвлөрнө. Ер нь шүүгчийн сургалт чадварын асуудал боловсролын асуудал тавигдах шалгуурууд бүгд өндөрсөж байгаа. Тэр чиглэлээр хүний нөөцийг ханган сайжруулах шилж олох ажлыг шүүхийн ерөнхий зөвлөл хийнэ. Мэргэжлийн түвшинг яг үнэлж дүгнэх ажил бол

ях аргагүй шүүхийн зөвлөл хийхгүй бол ажлаа угаасаа хийж чадахгүй шүү дээ тэр байгууллага. Үндсэн чиг үүрэг л юм чинь.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гишүүн Мөнхтуяа Улсын дээд шүүхийн шүүгч. 1 дүгээр микрофон ажлын дэд хэсгийн гишүүн. Бас нэмээд хариулъя. Дараа нь Мөнхсайхан багш бас бэлдэж байгаарай.

Д.Мөнхтуяа: Баярлалаа. Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Тэгээд мэргэжлийн хороотой холбоотой асуудлыг ажлын дэд хэсэг дээр санал гаргасан. Ер нь бол энэ Амарсайхан гишүүний хэлээд байгаа санал даа. Ер нь энэ шүүхийн тогтолцоо өөрөө мэргэжлийн алдаагаа мэргэжлийн хариуцлагаа ярьдаг. Ийм тогтолцоог өөрөө дотроо байх нь зөв юм байна. Гэхдээ энэ бол улсын дээд шүүх хажуудаа авъя гэсэн санал бол ерөөсөө гаргаагүй. Одоо бид нарын яриад байгаа энэ 4 жилд нэг удаа хуралдаад байхаар чуулганаасаа байгуулдаг юм уу эсхүл анхан давах нь шат шатандаа байдаг юм уу.

Тэгэхээр яагаад одоо энийг энэ сахилгын зөрчил гэдэг энэ агуулга руу мэргэжлийн зарим алдааг оруулаад сахилгын хариуцлага хүлээлгэнэ гээд байгаа энийг зөвшөөрөхгүй байгаа вэ гэвэл уг нь бол яах вэ энэ гол ялгаа нь мэргэжлийн алдаа хариуцлага бол нэг талын гомдлоор илрүүлээд нэг талын гомдлоор хариуцлага тооцох ёсгүй байхгүй юу энэ. Өөрөөр хэлэх юм бол гомдол гарсан эсэхээс хамаарахгүйгээр тэр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаа зөрчдөг ийм алдаа гаргаад байвал тэрийг нь тогтоогоод дүгнэлтээ гаргадаг.

Мэргэжлийн хороо бол яг бид нарын саналаар бол хариуцлага тооцсон шүүгчид гэдэг тийм санал бол огт гаргаагүй. Дүгнэлтээ гаргая. Бүр ноцтой зөрчлийг гаргасан бол дүгнэлтээ гаргаад сахилгын хороонд нь шилжүүлдэг байж магадгүй юм. Энэ дүгнэлт ямар үр дагавар учруулах вэ гэхээр шүүгчээ давтан сургадаг ямар асуудлаар яаж энэ хүн мэргэжлийн алдаа гаргаад байгаа юм бэ гэдгийг тогтоодог. Сургалтад хамруулдаг ийм дотроо ийм бүтэцтэй байя гэдэг ийм санал өгсөн. Энхбаяр гишүүний хэлж байгаа үнэн. Мэргэжлийн алдаа сахилгын алдааг бол ялгахад хүнд гэж.

Ялгахад хүнд учраас энэ алдааг сахилгын хороонд өгөхөөр энийг сахилгын зөрчил болгох уу үгүй юу гэдэг нь үзэмжээр шийдэгдэнэ. Би одоо энэ 52 дугаар зүйл дээр ярихаар бас боломж олдвол санал хэлье гэж бодож байна. Яагаад энэ мэргэжлийн алдаатай холбоотой заалтыг сахилгын хороонд өгч болохгүй вэ гэдэг талаар. Сая энд бас хэлж байна. Яагаад энэ сахилгын мэргэжлийн хороо тэртээ энэ мэргэжлийн өөрөө удирдах ёс бол угаасаа энэ гомдол гарсан эсэхээс хамаарахгүйгээр дотроо явж байх ёстой байтал одоо нэг шийдвэр дээр таалагдаагүй хүний гомдлоор жишээлбэл сахилгын хороонд өргөдөл өгөх гэж байна.

Тэгээд тэр өргөдлийг авсан сахилгын хорооны гишүүн сахилгын хэрэг болгох уу эсхүл энэ хамаарахгүй юм байна гэдгийг яаж шийдэх юм бэ, энэ ямар ч ийм ойлгомжгүй байгаад байгаа юм. Тийм учраас мэргэжлийн хороог байгуулах нь зөв. Гэхдээ энэ нь бол шүүхийнхээ өөрийн үндсэн бүтэц дотор байх ёстой юм байна гэдэг ийм санал гаргасан юм. Тэгээд дэд ажил дээр бол дэмжигдээгүй. Энэ мэргэжлийн хороо бол 2002 оны хуулиар байж байгаад 12 оны хуулиар мэргэжлийн хариуцлага мэргэжлийн хариуцлага тооцдог юмыг нь 12 оны хуулиар Үндсэн хууль зөрчсөн гээд 13 онд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гараад хүчингүй болгосон. Тэрнээс хойш мэргэжлийн хороо шүүгчийн мэргэжлийн алдаа хариуцлагад нэг ч тооцсон тохиолдол бол байдаггүй. Тийм учраас, үгүй ээ тэр шүүгчийн хараат бус байдалд халдах юм байна, хариуцлага тооцдог нь буруу байна гэдэг агуулгаар гарсан юм байна лээ.

Одоо бол бид нарын санал бол энэ шүүгчийг мэргэжлийн хариуцлагаас нь чөлөөлөөд хариуцлага хүлээдэггүй байя гэдэг ийм зорилго бол байхгүй. Ер нь бол ийм агуулгаар бол энийг хэлээгүй гэдгийг бас зүгээр тодруулж хэлье. Гэхдээ энэ дэд ажлын хэсэг дээр дэмжигдээгүй санал.

С.Бямбацогт: Мөнхсайхан дэд ажлын хэсгийн гишүүн Мөнхсайхан гишүүн хариулъя. 2 дугаар микрофон.

О.Мөнхсайхан: Тэнцвэртэй байх үүднээс судалгааны дүгнэлтийг хэлье гэж бодож байна. Тэгэхээр энэ мэргэжлийн алдаа гэж зүйл бол хуулийг тайлбарлахтай холбоотой зөрүү гарч байгаа. Энэ бол давах болон хяналтын шатаараа засагдаад явдаг. Анхан шатны шүүгчийн шийдвэр давах шатан дээр унасан өөрчлөгдсөн гэдгээр бол хариуцлага хүлээлгэж болохгүй. Энэ бол шүүгчийн хараат бус байдлыг ноцтой хөндөнө.

Энэ ажлын хэсгээс оруулж ирж байгаа санал бол юу байгаа вэ гэхээр энэ сахилгын асуудлыг нь сахилгын хороо шийддэг Үндсэн хуулийнхаа заалтыг баримтлах агуулга явж байгаа. Өөрөөр хэлэх юм бол одоо бас 52 дугаар зүйл дээр яригдах байх. Хуулийн маш тодорхой маргаангүй тэр заалтыг удаа дараа ноцтой зөрчинө гэдэг бол энэ ерөөсөө мэргэжлийн алдаа биш. Манайх 30 жил энийг мэргэжлийн алдаа мэтээр хэлж хариуцлагагүй байдал хаацайлдаг энэ явдал бол өөрөө байж болохгүй юм гэдэг ийм судалгааны дүгнэлт 3 жилийн өмнө олон улсын хурал хийж байхад гарсан юм. Энэ нь бол өөрөө олон улсын яг жишиг практикт нийцэж байгаа. Тэгээд манай Монголын жишээ гэх юм бол юу гарч байсан бэ гэхээр ерөөсөө шүүгч хэргээ шийдэхээсээ мөн тэр хуралдааны талаар биечлэн оролцох, нотлох баримт гаргаж өгөх ямар ч боломж олгоогүй ийм байдлаар хэргийг шийдэж байсан тохиолдлууд гарч байсан.

Энэ дээр бол өмнө нь ёс зүйн хороо сануулах арга хэмжээ аваад л шүүх зөвшөөрч байсан. Эсхүл шүүгч гаргасан шийдвэрээ бол биелж эхлэхээс нь өмнө

тайлбар гаргана гээд хууль дээр тодорхой биччихээд байхад шийдвэр нь биелж эхэлснээс хойш 8 сарын дараа тайлбар гаргасан ийм тохиолдол гарч байсан юм. Энийг бас ёс зүйн хороо сахилгын зөрчил гэж үзээд арга хэмжээ авсныг нь шүүх зөвшөөрч байсан. Хууль дээр бүр гомдол гаргах эрхтэй гээд бичээд байхад эрхгүй гээд тэрийг нь хаагаад байдаг гэх мэт. Өөрөөр хэлбэл гадаад руу зорчих эрхийг нь хуулийн ямар ч үндэслэлгүйгээр хязгаарлаад хаагаад бүтэн жил хүний эрхийн хохироочихдог.

Тэгэхээр энэ асуудал бол мэргэжлийн алдаа ерөөсөө биш гэдгийг одоо судалгаагаар гарч ирсэн. Яагаад гэхээр энэ бол ямар нэгэн мэдлэг чадвар шаардахгүй, бүх хуульч ч байх шаардлагагүй жирийн иргэн энийг мэдээд шийдэх боломжтой ийм зүйл байдаг. Тэгэхээр энийг бол зохих харьяаллынх нь дагуу 52 дугаар зүйл дээр сахилгын хороо шийдэх юм гэдгийг нь тодорхой зааж өгч байгаа юм. Хэрэв энийг хасаад мэргэжлийн хороо гээд Үндсэн хуулийн биш ийм субъектэд өгөх юм бол энэ Үндсэн хуулийн ноцтой зөрчил рүү орно. Олон улсын туршлагад ерөөсөө байхгүй ийм юмыг бид нар 30 жил хэрэглэх гэж үзээд энэ асуудлаа шийдэж чадаагүй.

Судалгаагаар бол юу вэ гэхээр Испани, Итали, Бельги, Америк, Молдова, Гүрж, Румын гээд маш олон улсуудад яг ийм агуулгатай зүйлийг сахилгын зөрчилд тооцоод сахилгын чиг үүрэгтэй хороо нь арга хэмжээ авдаг. Жишээлбэл эрүүгийн хууль дээр зөвхөн торгох ялтай гээд бичсэн байхад хорих ялаар шийтгэсэн ч юм уу тийм ээ. Германд ямар жишээ гарч байсан бэ гэхээр шүүгч процессын хуулийн ямар одоо үндэслэл журамгүйгээр өмгөөлөгчийг албадаж гаргасан байгаа байхгүй юу. Энийг бол мэргэжлийн алдаа гэж үздэггүй сахилгын арга хэмжээ аваад сахилгын шүүх нь шийтгэсэн байж байгаа. Энэ бол олон улсад байдаг жишгээрээ ингэж орж ирж байгаа зүйл. Хэрэв Үндсэн хуулиас гадуур Үндсэн хуульд байдаг сахилгын хорооны энэ чиг үүргийг мэргэжлийн хороо гэдэг нэртэй ийм субъектэд дан шүүгч нараас бүрдсэн субъектэд өгөх юм бол энэ хариуцлага тооцож чадахгүй. Үндсэн хуулийн зөрчил рүү орно.

Хэрэв мэргэжлийн хороо нь сануулна, сургалтад суулгана гэсэн ийм шийдвэр гаргаж байгаа чинь энэ чинь өөрөө сахилгын арга хэмжээ байхгүй юу. Яг сахилгын хорооны чиг үүргийг хэрэгжүүлэх гээд байгаа юм. Дээрээс нь тэр мэргэжлийн хороо гэж орон тооны бус субьектийг яаж бид нар бүрдүүлэх вэ гээд дахиад 3, 4 хуудас процесс бичнэ. Энэ төрөл чинь өөрөө маргаан учраас энэ маргааныг яаж шийдэх вэ гэдэг дахиад процесс бичих болно. Хууль дээр ямар ч процесс байхгүй. Өнгөрсөн хугацаанд мэргэжлийн хороо би мэргэжлийн алдааны талаар бол үзэмжээрээ шийдэж ирсэн. Хууль дээр ямар ч процесс байдаггүй, журам ч байдаггүй. Тэгээд энэ бол явж юу руу очдог вэ гэхээр.../минут дуусав/

С.Бямбацогт: Хариулт бол хангалтай яригдлаа. Энх-Амгалан гишүүн асуултаа асууя.

Б.Энх-Амгалан: Энэ нийт шүүгчдийн хуралдаан гэнэ үү, энэ шүүгчдийн зөвлөгөөн шүүх хуралдаантай андуурагдаж уншигдах ойлгогдох энэ чуулганд гэнэ үү тэр нь бол ялгаа алга. Ямар ч байсан энэ дээр дэвшилттэй нэлээн хэдэн зүйл орсон байна. Нэг ч шүүгч нийт шүүгчдийн хуралдааныг зохион байгуулах ажлын хэсэг гээд хэн нэгэн томилохооргүйгээр сонгогдох ийм боломжтой болж шүүх хуралдаан даргалагчаа дотроосоо сонгох ийм боломжийг олгож мөн шүүх хуралдааны хэлэлцэх асуудлыг тоолох тооллогын комиссыг ямар бүрэлдэхүүнтэй хийх вэ гэдэг ийм шалгуураа тавьсан байна.

Ерөнхий зөвлөл сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгчдийг сонгох огцруулах ийм эрхийг нь бас ингээд нийт шүүгчдийн хуралдаан гэж одоо энэ дээр томъёологдож байгаараа бол орж байна. Энэ бол сайн зүйл. Энэ шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөх хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналыг улсын дээд шүүхэд нийт шүүгчдийн хуралдаан уламжилдаг нь ямар учиртай юм бэ? Энийг нэг тайлбарлаж өгөөч.

2 дугаарт нийт шүүгчдийн хуралдааны асуудлыг олонхын саналаар шийднэ гэж байгаа юм. Тэгээд шүүгч шүүх хуралдаанд биеэр нийт шүүгчдийн хуралдаанд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд цахимаар санал өгөх боломжоор хангана гэж байгаа юм. Энэнийхээ ард ерөнхий зөвлөл сахилгын хорооны гишүүнд нэр дэвшигч шүүгчийг нууц санал хураалтаар сонгоно гэж байгаа юм. Тэгэхээр энэ цахимаар орж байгаа хүн чинь яаж нууц санал хураалт өгөх юм бэ? Яаж боломжоор нь хангах юм бэ? Энэ нэг хоёр жаахан зөрчилтэй юм биш үү. Би зүгээр тэгж уншаад байна. Ажлын хэсгийн ахлагчаас тайлбар авъя.

Мөн нийт шүүгчдийн ээлжит бус хуралдааныг Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч. Эсхүл шүүхийн ерөнхий шүүгчдийн 1/3 эсхүл нийт шүүгчийн 1/5-ээс доошгүй саналаар хуралдуулна гэж байгаа юм. Энийг би сайн ойлгосонгүй. Ерөнхий шүүгч ээлжит бус хуралдаанаа хийнэ гэвэл хуралдуулах юм уу, эсхүл заавал тэрэн дээр нь энэ 1/5 нь бас давхар хуралдуулах нь зөв гэдэг санал өгөх юм уу? Эсхүл Ерөнхий шүүгчдийн 1/3 нь ерөөсөө хуралдуулах нь зөв юм байна гэх юм бол шийдчих юм уу? Энийг ямар процедураар шийдэх юм бэ надад нэг хэлж өгөөч.

Сүүлд нь нэг зүйлийг би сайн ойлгодоггүй. Энэ шүүхийн тайлбар гэдэг юмыг ойлгож байна. Шүүхийн шаардлага гэдэг юмыг бол ойлгож байна. Шүүхийн татгалзал гэж ямар нэр томъёо байдаг юм бол? Би нэг ийм Монгол нэр томъёо сайн ойлгохгүй юм. Татгалзал гэж ямар нэг томъёо юм бэ? Ийм нэг хэдэн асуултад хариулаад өгөөч.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч хэн хариулах юм бэ? Цогт шүүгч үү? 1 дүгээр микрофон. Дээд шүүхийн шүүгч Цогт.

Ц.Цогт: Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Тэр татгалзал гэдэг нь би зөв ойлгосон бол шүүх хуралдаанд томилогдсон шүүгч юм уу бүрэлдэхүүнд томилогдсон шүүгч хуульд зааснаар тэр хэргийг шийдвэрлэж болохгүй хэргийн аль нэг оролцогчтой төрөл садангийн холбоотой гэр бүлийн хамааралтай ч байдаг юм уу ийм этгээд байвал бид нар татгалзан гарах гэдэг ийм ойлголт байдаг. Тэрийг ярьж байна уу гэж ойлголоо. Тэр бол нийт шүүгчдийн хуралдаанд гэхээсээ илүүгээр яг хэрэг шийдэж байгаа шүүх бүрэлдэхүүнд хамааралтай ийм хууль зүйн ойлголт байдаг.

2 дугаарт ер нь энэ нийт шүүгчдийн хуралдаан ямар тохиолдолд хууль тогтоомжийг сайжруулах талаар саналаа гаргах вэ гэхээр өөрсдийнх нь нөгөө шүүгч нарын өдөр тутмын шүүн таслах ажиллагаанд нь хэрэглэгддэг процессын хуулиуд гэж бид нар ярьдаг. Эрүү иргэн, захиргаа зөрчлийн энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиуд эсхүл байнга хэрэглэгддэг эрүүгийн хууль, захиргааны ерөнхий хууль гэх мэт хуулиудад зайлшгүй хэрэглэхэд төвөгтэй нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай ийм тохиолдлууд гарвал тэрийгээ шүүгч нар одоо нэгтгээд ингээд өөрсдөө нөгөө хууль тогтоох, хууль санаачлах ийм эрхгүй учраас дээд шүүхэд гаргаад. Дээд шүүх нь холбогдох журмын дагуу тэр хуулиудыг боловсронгуй болгох саналаа гаргах ийм л зохицуулалт байгаа.

С.Бямбацогт: Тэр цахимтай холбоотой. Сая энэ хурал нийт шүүгчийн хуралдаанд шүүгч биечлэн оролцох боломжгүй тохиолдолд түүнийг цахимаар санал өгөх боломжоор хангана. Энэ чинь нөгөө нууцаар санал хураахтай зөрчилдөөд байна шүү дээ яаж хангах юм бэ гэж асуусандаа сая. Хэн хариулах юм бэ? Баасандорж дарга 3 дугаар микрофон.

Б.Баасандорж: Хууль зүй, дотоод хэргийн яам Баасандорж Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Саналын томьёоллын 12 дахь саналын томьёоллын 20.6 дээр сая Энх-Амгалан гишүүн асуулаа. Энийг бол ажлын хэсэг дээр бас тал талаас нь ярьсан. Ер нь бол энэ бол техникийн шийдлийн хувьд бол бүрэн боломжтой байгаа. Өнөөдөр яг албан тушаалтныхаа хувьд цахим гарын үсгийн тухай хуульд зааснаар 23 мянган цахим гарын үсэг авсны дийлэнх олонх нь яг албан тушаалтнуудынхаа хувьд авсан байдаг.

Шүүхийн ерөнхий зөвлөл бол яг энэ шүүгч нараа болон шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдээ тоон гарын үсгээр ханган ажил бол эхэлсэн байгаа. Ингээд шүүгч нарыг албан тушаалтных нь хувьд тоон гарын үсэгтэй болгох юм бол энэ 20.6-д заасан биечлэн оролцох боломжгүй тохиолдолд цахимаар саналаа өгөх бүрэн боломжтой. Энэ бол техникийн шийдлийн асуудал байгаа юм. Өмгөөлөгчдийн холбооны Их Хурлыг бол Хууль зүй, дотоод хэргийн яам сая анхдугаар их хурлыг зохион байгуулсан. Энэ Их Хурал дээр бол мөн цахимаар санал өгөх асуудлыг яг энэ техникийн шийдлээр зохион байгуулсан байгаа юм.

Тэр тухайн албанд шүүгч өөрөө цахим гарын үсгээ өөрийнхөө албан тушаалтныхаа хувьд авч байна гэдэг нь өөрөө яг тэр хүний л яг өөрийн хувийн тоон гарын үсэг байгаа юм. Тэгэхээр тэр юугаараа өөрийнхийгөө илэрхийлээд нэвтэрч ороод яг өөрийнхөө саналыг өгөх бүрэн боломжтой. Цахим гарын үсэгтэй болно гэсэн үг. Албан тушаалтныхаа хувьд.

С.Бямбацогт: Болдог л юм. Бид нар ч гэсэн нууцаар санал өгөөд бас болдог тэрэнтэй л адилхан юм. Дэлгэрсайхан гишүүн асуултаа асууя.

Б.Дэлгэрсайхан: Надад 2 санал байна. Энэ нийт шүүгчдийн хуралдаанаар энэ сахилгын хорооны 5 гишүүнийг томилно гэж байгаа юм. Жишээлбэл одоо дээд шүүхээс нэг давж заалдах шатнаас 2, анхан шатнаас 2 гэж байгаа юм. Тэгээд нийт одоо нэг шүүгчдийн тоо ойролцоогоор нэг 530-аад шүүгч байна гэж байгаа юм. Тэгэхээр энийг зүгээр миний бодлоор бол энэ бүх шүүгч нар бол дээд шүүхийнхээ ихэнх шүүгч нарынхаа бараг зүсийг нь хараагүй танихгүй байж магадгүй. Яагаад гэвэл тэр олон хагас сая шахуу, хагас мянга шахуу юм чинь. Тэгэхээр зэрэг энийг тус бүрд нь ялангуяа би ажлын хэсэгт ийм санал оруулж байгаа юм.

Дээд шүүхийн 23 гишүүнээсээ нэг хүнийг өөрсдөөр нь сонгуулах. Давж заалдах шатнаас нь 2 хүнээ тэр давж заалдах шатны шүүгч нар нь өөрөө сонгох. Анхан шатны 390-ээсээ 2 хүнээ өөрсдөө сонгох гэдгээр ингэж салгаж өгөхгүй бол наадах чинь нэг төрийн бус байгууллагынх шиг юм болно шүү. Та нар энийгээ бас сайн бодоорой гэдгийг 1 дүгээрт хэлье. Санал. 2 дугаарт бол энэ сая би энэ Амарсайхан энэ Мөнхтуяа 2 шүүгч хоёртой бас санал нэг байна. Хүний мэргэжлийн алдааг сахилгын хороо шийдэж болохгүй байх. Сахилгын хороо гэдэг чинь нэг тийм мангас юм шиг л одоо харагдаж байна шүү дээ.

Тэгээд л нэг иргэн дураа хүрэхээр гомдол өгөөд л тэгээд л хүнийг сахилгын хороогоор оруулж байвал оруулаад ямар хэдэн шүүгч үлдэх юм бэ цаана нь. Тэгэхээр энийгээ бас олон талаас нь аягүй сан бодохгүй бол мэргэжлийн алдааг бол хэн ч гаргадаг. Жишээлбэл одоо эмч нар дээр мэргэжлийн алдаа гардаг. Эхлээд эмч нарын мэргэжлийн эмч нарын зөвлөгөөнөөр ороод энэ ямар яг ямар алдаа гаргасан юм бэ гэдгийг ярьдаг юм байгаа биз дээ. Тэгж байж дараа нь тэр сахилгын асуудал яригддаг болохоос юуг нь ч мэдэлгүй нэг иргэн миний намайг ингээд ингэж хохироогоод гээд нэг хэн дуртай нь гомдол мэдүүлэнгүүт л сахилгын хороо шүүрч аваад шийдээд байна гэж ийм юм бол байж арай болохгүй байх.

Мэргэжлийн алдаа гэдэг бол амьдрал баян учраас олон төрөл бий шүү дээ. Тэрнээс биш Германд ийм байдаг олон улсад ийм байдаг гээд юм яриад манайх чинь шал өөр шүү дээ бас зан заншил. Хэн нэгэнд нь таалагдахгүй шүүгч нэг хэн нэгэнд нь таалагдахгүй шийдвэр гаргахаар зэрэг л сахилгын хороонд хандах уу тэгээд. Энэ

намайг ингэж гомдоосон гээд. Сахилгын хороо чинь ямар бүрэлдэхүүнээс бүрэлдэх юм бэ та бод доо.

Би ойлгохдоо бол энэ дээд шүүхийн 23 шүүгч чинь нэлээн олон жил шүүхэд ажилласан мэргэжлийн олон жилийн туршлагатай олон хэргийг одоо бас сайн муу талаас нь шүүсэн ийм улсууд байгаа учраас нэгнийхээ алдсан алдааг эхэлж энэ мэргэжлийн ямар алдаа гаргасан юм бэ гэдгээ гаргаж байж дараа нь сахилгын хороо гэдэг юмаа ярих ёстой байх гэж бодож байна. Тэрнээс сахилгын хороог бол үгүйсгээгүй. Сахилгын хороо чинь одоо тэр хүний ёс зүй, илтэд хүний эрхийг зөрчсөн юм нь бол сахилгын хороогоор орох нь зөв. Гэхдээ мэргэжлийн алдаа гэдэг бол харилцан адилгүй зүйл шүү дээ. Тийм учраас бол энэ сахилгын хороо чинь бол бас нэг хүн айлгадаг мангас болсон. Одоо байгуулагдаагүй байхдаа ийм болж харагдаад байна шүү.

Тэгэхээр сахилгын хороо чинь бол яг одоо бид нарын ярьж байгаагаар одоо сахилгын хорооны 5 гишүүнийг шүүхээсээ 5-г нь гаднаас олон нийтийн санал асуулгаар ч билүү Улсын Их Хурал томилно гэж байгаа юм. Тэгэхээр чинь зэрэг наадах чинь Улсын Их Хурлаас хэн нэгэн сонирхлын зөрчилтэй баахан гишүүд томилогдож.../минут дуусав/

С.Бямбацогт: Горимын санал байхгүй одоо явуулъя. Болно тэгэх үү. 52 дээр яригдана шүү дээ 52 дээр хангалттай яригдана энэ чинь. Нийт шүүгчийн хуралдаан ярьж байгаа шүү дээ. Нийт шүүгчийн хуралдаан дээр одоо яваад байх юм. Яг нийт шүүгчдийн хуралдаантай холбоотой. Сая зүгээр яах вэ сахилгын хороо мэргэжлийн зөвлөл гээд цаашаа явсан чинь бүр ингээд хадуураад алга боллоо. Хадуурахгүй одоо зөвхөн нийт шүүгчийн хуралдаан. Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Ажлын хэсэг дээр ярьж байхад ингэсэн шүү дээ нөгөө нийт шүүгчдийн хуралдаанаар шүүхийн ерөнхий зөвлөл сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгч нарыг сонгох асуудлаа шийдье гэж бодъё. Гэтэл байнга орон тоо гараад байнга нөгөө нийт шүүгчдийн хуралдаан хийх шаардлага зөвлөгөөн хийх шаардлага гараад байх вий дээ. Запас илүү хэдийг нөгөө нэг бусад орнуудын жишгээр 5 шүүгч сонгох ёстой байлаа гэхэд 7 ч юм уу 8-г сонгоод 10-г сонгоод юу гараад байвал бас араас нь 4 жилийн хугацаандаа дахиж хурал хийх шаардлагагүйгээр нөхөөд байя гэсэн нэг санал орсон. Тэгж томъёолъё гэж ярьсан.

Тэгээд яг одоо энэ 22.1-ээрээ бол тэгж уншигдахгүй байх юм. Энийг протоколд тэмдэглүүлээд тийм санаатай хийхгүй бол жил болоод юм уу 2 жил болоод 6 сар болоод орон тоо гарчихдаг. Тэгээд орон тоогоо нөхөх гээд 500, 600 шүүгч нараа жил болгон цуглуулаад юм хагас жил цуглуулаад хуралдаан зөвлөгөөн хийгээд байдаггүй байх нэг механизм баймаар байгаа юм. Энийг нэг санал болгох гэсэн юм. Тэр мэргэжлийн хорооны юм дээр даргаа би ийм горимын санал хэлэх гэсэн юм.

Тэр 52 дугаар зүйл дээр сахилгын хорооны бүрэн эрхийн асуудал яригдана шүү дээ. Энэ дээр бол аль нь мэргэжлийн аль нь сахилгын гэдэг ингээд нэлээн хэлэлцүүлэг өрнөх байх. Тэгэхээр миний санал бол тэрийг хэлэлцэж байх үедээ энэ мэргэжлийн хороо ер нь байх юм уу үгүй юм уу гэдэг тэнд шийдмээр байх юм. Тэрнийг редакцлаад. Энхбаяр гишүүнээ.

С.Бямбацогт: Саяын юмнуудаа анхааръя тийм ээ. Ер нь бол.../үг тасрав/

Ц.Мөнх-Оргил: Бишээ юу яриад байна шүү дээ саяын тэр нийт зөвлөгөөнөөр тулгаж нэр дэвшүүлэхгүйгээр тоог нь жаахан тавьж өгөөд байнга хурал хийгээд байхгүй нөхцөл бүрдүүлье гэж ярьсан шүү дээ Энхбаяраа.

С.Бямбацогт: Тэрэн дээр яах вэ цахимаар нууцаар санал хурааж болж байгаа тийм байдлаар бас заавал цуглахгүй бас шийдэх бололцоо байх юм шиг байна. Ажлын хэсэг дээр эргэж ярилцаарай тэрийг. Саяын Мөнх-Оргил гишүүний ярьж байгаа саналыг тэр орон гарсан тохиолдолд хурал хийхгүй байх запас нөөц гишүүнтэй байх гэдэг асуудлыг яаж шийдэх вэ гэдэг дээр шийдэл яриарай. Ингээд хуулийн төслийн 20 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж дууслаа гишүүд. Одоо санал хураалт явуулна.

12.Төслийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20 дугаар зүйл.Нийт шүүгчийн хуралдаан

20.1.Бүх шатны шүүхийн нийт шүүгчээс бүрдсэн хуралдааныг /цаашид “Нийт шүүгчийн хуралдаан” гэх/ дөрвөн жил тутам зохион байгуулна.

20.2.Нийт шүүгчийн хуралдаанаар дараах асуудлыг шийдвэрлэнэ:

20.2.1.Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгчийг сонгох, огцруулах;

20.2.2.шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөх хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналыг Улсын дээд шүүхэд уламжлах;

20.2.3.Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг сонсох;

20.2.4.энэ хуулийн 19.2.5-д заасан хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргаан хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журмыг батлах;

20.2.5.шүүхийн үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлыг авч хэлэлцэх, зөвлөмж гаргах.

20.3.Нийт шүүгчийн хуралдаан хуралдааны дэгээ өөрөө тогтооно.

20.4.Нийт шүүгчийн ээлжит бус хуралдааныг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн, эсхүл бусад шүүхийн Ерөнхий шүүгчдийн гуравны нэгийн, эсхүл нийт шүүгчийн тавны нэгээс доошгүйн саналаар хуралдуулна.

20.6.Нийт шүүгчийн хуралдаанд шүүгч биечлэн оролцох боломжгүй тохиолдолд түүнийг цахимаар санал өгөх боломжоор хангана. 20.5 санал гарсан учраас тусад нь хураалгах юм.

20.7.Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны гишүүнд нэр дэвшигч шүүгчийг нууц санал хураалтаар сонгоно.

20.8.Нийт шүүгчийн хуралдааны шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

20.9.Нийт шүүгчийн хуралдааныг Улсын дээд шүүхийн Зөвлөгөөнөөс сонгосон хоёр, нийслэлийн эрүү, иргэн, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Зөвлөгөөн тус бүрээс сонгосон нэг, дүүргийн анхан шатны шүүхээс шүүгчээр хамгийн олон жил ажилласан хоёр шүүгч, Ерөнхий зөвлөл дотроосоо сонгосон шүүгч хоёр гишүүнээс бүрдсэн ажлын хэсэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ зохион байгуулна.

20.10.Ажлын хэсэг Нийт шүүгчийн хуралдааныг зохион байгуулж дуусах хүртэл ажиллах бөгөөд ахлагчаа дотроосоо нууц санал хураалтаар сонгоно. Ерөнхий зөвлөлийн ажлын алба хуралдааны зохион байгуулалтын асуудлаар Ажлын хэсэгт туслалцаа үзүүлэх бөгөөд хуралдааны материал архивлах асуудлыг хариуцна.

20.11.Нийт шүүгчийн чуулган даргалагчаа дотроосоо сонгоно.

20.12.Нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын саналыг тоолох тооллогын комисс ажиллана. Комиссын бүрэлдэхүүнд хяналтын болон давж заалдах шатны шүүхээс тус бүр хоёр, анхан шатны шүүхээс гурван шүүгчийг Нийт шүүгчийн хуралдаанаас нууц санал хураалтаар сонгох бөгөөд даргыг дотроосоо сонгоно.” Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Саяын 2 асуулт. Нямбаатар гишүүн.

Х.Нямбаатар: Би дэгтэй холбоотой яг Байнгын хорооноос Үнэнбатаас тодруулмаар байна. Одоо ингээд нийт шүүгчдийн хуралдаан гэдгээр санал хураана. Дэмжигдсэн тохиолдолд миний гаргасан тэр нийт шүүгчдийн хуралдаан гэдгийг чуулган гэдгээр энэ санал дэмжигдсэний дараа чуулган гэдэг нэр томьёог оруулах гэж тусдаа санал хураах уу? Тэгэхээр энэ дэгийн зөрчил болохгүй юу? Яг нэг асуудлаар 2 ижил санал байна шүү дээ. Эхлээд хажуугийн санал байх ёстой. Хажуугийн саналаа эхэлж хураахгүй юм уу?

С.Бямбацогт: Үнэнбат зөвлөх.

М.Үнэнбат: Нямбаатар гишүүний асуултад хариулъя. Чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу 39.18 дээр заасан байгаа. Төслийн зүйл хэсэг заалт тус бүрээр 2 ба түүнээс дээш саналын томьёолол гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа бусад саналыг танилцуулж

санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдээгүйд тооцож эдгээр саналаар санал хураалт явуулахгүй гэсэн дэгийн заалт нь бол ийм.

Яг сая энэтэй холбоотойгоор 20.5 дээр Мөнхцэцэг гишүүн санал гаргасан. Тийм болохоор тэрийг салгаж аваад яагаад гэвэл нэг заалт нь нэг хэсгээр гарсан учраас салгаж аваад одоо энэ хоёрыг зэрэг уншаад тэгээд санал хураалт ажлын хэсгийн санал хураагаад тэгээд ажлын хэсгийн санал унах юм бол Мөнхцэцэг гишүүний санал дэмжигдсэн гэж үзнэ. Таны гаргаж байгаа санал болохоор энийг бол нэг агуулга гэж үзэхгүй. Яагаад гэхээр шууд энэ чинь нэр өөрчилж байгаа зүйл учраас одоо энэний дараа шууд тохиолдол бүр дээр таныхаар л чуулган гэж өөрчлөх үү гэдэг дахиж санал хураалт явуулаад хэрэв гишүүд дэмжих бол бид нар нэгдсэн чуулганд орохдоо аваад орно.

С.Бямбацогт: Нэр өөрчилж байгаа учраас тусад нь хурааж болно. Хэрэв агуулга өөрчлөх бол хамтад нь хураана гэсэн дэгтэй гэж тайлбарлаж байна. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 81,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүдээс санал гарсан байгаа. Ажлын хэсгийн саналаар сая санал хураалт явагдсан. Эхлээд Нямбаатар гишүүний гаргасан санал. Төслийн 20 дугаар зүйлд заасан шүүгчдийн зөвлөл гэснийг нийт шүүгчийн чуулган гэж өөрчлөх. Үүнтэй холбогдуулан төслийн бусад зохицуулалт бүрт шүүгчдийн зөвлөл гэснийг нийт шүүгчийн чуулган. Нийт шүүгчийн хуралдаан гээд байгаа шүү дээ яагаад зөвлөл гээд яваад байгаа юм бэ? Бараг ойлгомжтой биз дээ. Сая Нямбаатар сайд саналаа тайлбарласан шүү дээ. Нэрээ өөрчилье тэгэхгүй хуралдаан гэх юм бол шүүхийн хуралдаан, шүүхийн хуралдаантай адилхан сонсогдоод байна.

Тийм болохоор чуулган болгоод өөрчилье гэсэн санал хэлсэн. Чуулган болохоор баяр ёслолын шинжтэй болох уу болохгүй бас тэгээд гайгүй биз дээ тийм ээ. Чуулган гэхээр чинь тэгээд. Тийм ээ тийм бас. Нямбаатар гишүүний гаргасан саналаар нэр өөрчилье. Төслийн 20 дугаар зүйлд заасан шүүгчдийн зөвлөл гэснийг нийт шүүгчийн чуулган гэж өөрчилье. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Чуулга уулзалт болчихвол бүр балрах байлгүй дээ. Санал хураалтад 16 гишүүн оролцож 12 гишүүн буюу 75 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Одоо Мөнхцэцэг гишүүний гаргасан санал байгаа. 20 дугаар зүйл дээр. 20.5 би эхлээд ажлын хэсгийн саналыг уншиж танилцуулъя. Гишүүд анхааралтай байгаарай ажлын хэсгийн гишүүд. 20.5.Нийт шүүгчийн олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцох бөгөөд асуудлыг чуулганд оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэнэ. Энэ ажлын хэсгийн санал. Мөнхцэцэг гишүүний өөрчлөх гэж байгаа саналыг та бүхэнд уншиж танилцуулъя. Нийт шүүгчдийн дийлэнх олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцох бөгөөд асуудлыг хуралдаан оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэнэ. Ирцийг өндөр босготой байя гэж байгаа юм байна тийм үү. Мөнхцэцэг гишүүн саналаа тайлбарлая.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ маань энэ нийт шүүгчдийнхээ төлөөллийг аль болох зохистой өндөр босготойгоор хангамаар байна. Ингээд 530 байна уу 520 байна гээд ингээд шүүгчээ бодохоор олонх гэхээр 250 орчим хүн 260 орчим хүн ирээд тэгэнгүүтээ тэгээд 260 орчим хүнийхээ дахиад олонх гэхээр 120, 130-аад хүний саналаар шүүгчийн ерөнхий зөвлөл сахилгын хороо энэ томоохон Үндсэн хуулийн гол шүүхийн байгууллагуудаас сонгох болоод байна. Тийм учраас энэ босгыг бол өндөрлөө. Ингэхдээ дийлэнх олонхын ирцээр гэдэг юм уу эсхүл ирсэн гишүүд төлөөлөгчдийнхөө дийлэнх олонхоор гэсэн ийм хувилбар уг нь байгаад байгаа юм.

Тэгээд би бол ямар ч байсан энэ нийт шүүгчдийнхээ дийлэнх олонх буюу 75 хувийн ирцийн босгоор энэ шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаа оруулъя гэсэн ийм саналтай байна.

С.Бямбацогт: Манай гишүүд ойлгосон анхаарсан тийм ээ. Одоо тэгээд санал хураалт явуулна. Санал хураалт явуулахдаа ажлын хэсгийн саналаар эхэлж санал хураана. Нямбаатар гишүүнээ томоотой. Тэгээд ажлын хэсгийн санал дэмжигдэх юм бол Мөнхцэцэг гишүүний саналаар хураахгүй унасанд тооцно. Ажлын хэсгийн санал унах юм бол Мөнхцэцэг гишүүний санал боссонд тооцогдоод дэмжигдээд тооцогдож явна. Энийг гишүүд ойлгоорой. Хураагүй 20.5 ялгаад үлдээсэн. Тийм. одоо бид бүхэн дахиад уншиж танилцуулаад ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулъя. 20.5.Нийт шүүгчийн олонх оролцсоноор чуулганыг хүчинтэйд тооцох бөгөөд асуудлыг чуулганд оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэнэ. Ажлын хэсгийн санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Хуралдаа бүгд ирэх байлгүй дээ. 4 жилд нэг удаа суулгаж байгаа юм чинь. Санал хураалтад 16 гишүүн оролцож 11 гишүүн буюу 68,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Ажлын хэсгийн санал дэмжигдсэнгүй учраас ажлын хэсгийн саналаар цаашдаа явахаар болж байна. Мөнхцэцэг гишүүний санал дэмжигдсэнгүй. Гишүүдийн гаргасан бичгээр гаргасан саналуудаар санал хурааж дууслаа.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Шүүхийн бэлгэ тэмдэг, тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас албан хэрэг хөтлөлт. Асуулт алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 13.Төслийн 21 дүгээр зүйлийн гарчгийн “бэлгэ тэмдэг,” гэснийг, мөн зүйлийн 21.2 дахь хэсгийг тус тус хасах. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 14 гишүүн 87,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Төслийн 22 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Шүүхийн шийдвэртэй холбоотой. Мөнх-Оргил гишүүнээр тасаллаа. Ажлын хэсгийн гишүүн асуугаад байх юм уу уг нь ажлын хэсэг дээр та нар бүх юмаа ярьж орж ирсэн шүү дээ. Ажлын хэсэг ярьсан биз дээ. Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Ажлын хэсэг дээр ярьсан юм маань яг эндээ сууж уу өөр газар суусан уу би бас нөгөө юуг нь олж харахгүй байгаа юм л даа. 22.5 дээр ингэсэн юм. Шүүх хамтын зарчмаар хэрэг маргааныг хянан хэлэлцэхдээ олонхын саналаар шийдвэр гаргана гээд. Тэгээд дээд шүүхийн шүүгч нар нөгөө тусгай саналтай бол тусгай саналаа бичгээр гаргах эрхийг нь бид нар олгосон байгаа шүү дээ. Тэрэнтэй

адилхан бүх шатны шүүгч нарт тусгай саналаа гаргаад хавсаргая тэр эрхийг нь олгоё гэж ярьсан юм. Тэр хаана орсон бэ? Анхан дээр, давж заалдах дээр ч гэсэн гарч болно шүү дээ. Зөвхөн дээд шүүхийн шүүгч тусгай саналтай байж болохгүй шүү дээ. Олонхоороо шийдэж байдаг. Нэг нь цөөнх болчихдог. Орсон билүү? За. Орсон уу? Энхбаяраа орсон тийм ээ, харин тийм.

С.Бямбацогт: Орсон юм байна. Энэ 22.8 дээр бас юу байгаа юм. Улсын дээд шүүхийн шийдвэрийг төрийн мэдээлэл эмхэлгэлд нийтэлнэ гэж байна. Улсын Их Хурлын хуулийг Засгийн газрын тогтоолыг нийтэлдэг байгаа. Дээрээс нь Дээд шүүхийн шийдвэр нийтлэхээр чинь одоо бас нэлээд олон хуудас зузаан тэгээд нөгөө төрийн мэдээлэл сэтгүүл чинь хууль нөгөө төрийн мэдээлэлд хэвлэгдсэнээрээ хүчин төгөлдөр болдог. Түүнтэй адилхан дээд шүүхийн шийдвэр тэрийн мэдээлэлд хэвлэж байх нь ямар зорилготой юм бол. Тэр их олон хуудас олон зуун хуудас сэтгүүлийг хэн унших бол. Хэрэгтэй юм болов уу? Ажлын хэсгийн гишүүн Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Энэ ингэж ярьсан юм. Байнгын хорооны даргаа. Дээд шүүх маань одоо хэлэлцдэг хэргийн тоо цөөрнө гэж бид нар ойлгоод байгаа шүү дээ. Доод шатны шүүхэд хууль буруу хэрэглэсэн эсхүл нэг хуулийг янз янзаар хэрэглэсэн байдаг юм уу эсхүл дээд шүүхийн албан ёсоор гаргасан тайлбартай зөрсөн шийдвэрүүд гаргасан юм уу одоо өөрөөр хэлбэл онолын шүүх болно гэж үзээд байгаа шүү дээ. Нэгэнт онолын шүүх болох юм бол Дээд шүүхийн шийдвэрүүд их ач холбогдолтой болоод байгаа юм. Нөгөө албан ёсны тайлбараас ер нь ялгаагүй шахуу болох гээд байгаа байхгүй юу 1 дүгээрт.

2 дугаарт тийм урчаас гарцаагүй хэвлэх хэрэгтэй болчихоод байгаа юм. Гарцаагүй хэвлэнэ гэх юм бол нөгөө нэг арга нь төрийн мэдээлэлд хэвлэхгүй бол шүүх шүүхийн байгууллагууд өөрөө нэг ийм төрийн мэдээлэлтэй адилхан нэг газеты гэдэг юмнууд байдаг шүү дээ тийм ээ тийм юмтай болох гээд. Энэ хоёрын нэгийг л сонгох хэрэгтэй болчихоод байгаа. Тэгээд бид нар ярьж байгаад тусад нь одоо дахиж нөгөө шүүхийн газеты, шүүхийн мэдээллийн сэтгүүл энэ тэр гээд шинэ юм гаргаж байхаар төрийн мэдээлэл дээрээ хэвлээд явбал яадаг юм бэ, шууд цахимаар гарчихна. Тэгээд төрийн мэдээлэл дээрээ хэвлэхихдэг. Хамгийн гол нь төрийн мэдээлэл маань шүүгч нарын гар дээр очдог байх л асуудал чухал.

С.Бямбацогт: Ойлголоо. Одоо болсон. Тайлбар сонсьё. Тийм үү. Яг хэрэг маргааныг тийм үү тодорхой нэр устай нь компанитай нь юутай байдаг юм тэгэхгүйгээр журам гаргах юм байна тийм үү. Энэ чинь төсөл тэр чигээрээ яах гээд байна шүү дээ. Төрийн мэдээлэлд сэтгүүлд хэвлүүлнэ гэдгээ энийгээ анхааръя. Энийгээ ажлын хэсэг эргэж ярилцаарай чуулган руу орохдоо эцсийн хэлэлцүүлгээ бас эргэж ярья. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Энэ чинь дотор нь байж байгаа нэг заалт шүү. Энэ олон заалттай шүү гишүүд бас анхааралтай байгаарай. Ажлын хэсгээс чиглэл өгсөн тэгээд Нямбаатар

сайд ажлын хэсгийн ахлагч Энхбаяр гишүүн та хоёр дахиад нэг сайн ярилцаарай. Тэгээд эргээд энийг эцсийн хэлэлцүүлэг дээр ярья. Чуулган руу орохдоо.

14.Төслийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.3, 22.8, 22.9, 22.10 дахь хэсэг, 22.5 дахь хэсэгт “Хяналтын шатны шүүхийн шүүгч нь тусгай саналаа уг шүүхийн цахим хуудаст байршуулж, нийтлэх эрхтэй.” гэсэн 2 дахь өгүүлбэр тус тус нэмэх:

“22.3.Шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлал нь шүүхийн шийдвэрийн бүтэц, төрөл, агуулга, хэл найруулга, хууль зүйн техник, шүүхийн шийдвэр эшлэхэд тавих шаардлага, талуудын шаардлага, татгалзал, тайлбарт маргаж байгаа үйл баримт болон хууль зүйн үндэслэл бүрд бүрэн дүгнэлт өгөх арга зүйг агуулсан байна.

22.8.Улсын дээд шүүхийн шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтэлнэ.

22.9.Олон нийтийг мэдээллээр хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг тайлбарлах зорилгоор шүүхийн шийдвэрийг олон нийтэд ойлгомжтой байдлаар мэдээлнэ.

22.10.Хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгч, шүүх бүрэлдэхүүн шүүхийн шийдвэрийг тухай бүр, ойлгомжтой байдлаар бичгээр болон биечлэн тайлбарлана.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 76,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гэхдээ саяын тэр ярьсан асуудлуудыг Мөнх-Оргил гишүүний ярьж байгаа асуудлууд тэр төрийн мэдээлэл сэтгүүлд хэвлэхтэй холбоотой асуудлуудыг эргэж ярья. Ажлын хэсэг дээр дахиж ярилцаарай. Их Хурлын даргын ахлах зөвлөх эрхэм Лүндээжанцан ах сайн анхаарал тавиад өгөөрэй бас.

Дараагийн хуулийн төслийн 24 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Шүүхийн судалгаа сургалтын хүрээлэн. Алга байна. 23 явсан биз дээ сая. 23 уучлаарай тийм байна. Хуулийн төслийн 23 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Ганбат гишүүн. Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Бараг орхих шахлаа тийм ээ. Ийм чухал асуудлыг. Ингээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх гэж байгаа юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага маань одоо аль харьяандаа явах гээд байна вэ? Засгийн газрын харьяа байх юм уу шүүхийнхээ Ерөнхий зөвлөлийн харьяа байх юм уу? Тэрийг тодотгомоор байна. Шүүхийн шийдвэр биелэгдэхгүй бол яах юм бэ? Тухайлбал би нэг жишээ ярья. Манай Баянхонгор аймгийн захиргааны аймгийн захиргааны нэг хэсэг төрийн өмч мөн. Гэтэл шүүхийн хамгийн эцсийн шийдвэр гарсан бүх шатны шийдвэр гарсан. Энэ бол одоо төрийн өмч гээд.

Гэтэл Ардын нам өмчлөөд яваад байдаг. Шүүхийн шийдвэр ерөөсөө биелэгддэггүй. Нэг ийм зүйл байна. Энэ одоо засрах уу? Бас дахиад нэг жишээ татъя. Бас л Баянхонгор дээрээ. Авлигын хэргээр 2, 3 нөхөд шалгагдаж байгаа. Аймгийн иргэдийн хуралд сонгогдсон. Тэр нөхдийн шүүх маань түдгэлзүүлсэн. Гэтэл

нөгөө нөхөд маань хуралдаа ороод шийдвэрээ гаргаад яваад байдаг. Ийм нөхцөл байдалтай юмнууд яах юм бэ? Шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байна л даа. Энэ яавал биелэгддэггүй болох юм бэ? Энийг энэ хууль дүрэмд зааснаараа өөрчлөгдөх үү. Бас л цаасан дээр үлдэх үү.

С.Бямбацогт: Эрүүгийн хууль дээр бол шүүхийн шийдвэр биелүүлэхгүй бол эрүүгийн хариуцлага хүлээх заалт байгаа. Энэ хууль дээр ч бас байгаа байх. Нямбаатар сайд хариулах уу? Нямбаатар гишүүн.

Х.Нямбаатар: Би Ганбат гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоог боловсронгуй болгох гээд ийм заалт мөрийн хөтөлбөрт орсон явж байгаа. Сая шүүхийн тухай хуулийг ажлын хэсэг дээр хэлэлцэж байх үед миний бие шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг 2 салгая. Нэг нь хорих байгууллагуудыг удирдах газар чигээрээ явъя. Нөгөөх нь иргэний болон захиргааны шийдвэр гүйцэтгэлийн байгууллагыг шүүх эрх мэдлийн харьяанд аваачъя. Гүйцэтгэх засаглалаас ангид болгоё. Шүүхийн шийдвэрийг гарцаагүй хэрэгждэг ийм зарчмыг нь хангая гэсэн ийм агуулгаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол бэлдээд ажлын хэсгийн хуралдаанд хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Энийгээ дагаад шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг бараг бүхэлд нь шинэчилсэн найруулга хэлбэрээр бичиж оруулсан. Тэгээд Их Хурлын гишүүд ажлын хэсэгт орсон Мөнх-Оргил гишүүн, Энхбаяр гишүүн, Сүхбаатар гишүүн бид хэд хоорондоо ярилцаад энэ том бүтцийн шинжтэй өөрчлөлт тогтолцооны өөрчлөлтийг энэ хууль дагуулж өөрчлөхөө больё. Засгийн газар тусад нь хууль оруулж ирээч гээд тусад нь энэ асуудал энэ хаврын чуулганаар оруулахаар бид нар бэлдээд зэхээд явж байна.

Ганбат гишүүний хэлж байгаатай нэг зүйл дээр туйлын санал нэг байна. Шүүхийн шийдвэр бол гарцаагүй хэрэгждэг байх л энэ зарчимтай. Харамсалтай нь өнөөдөр захиргааны шийдвэр гүйцэтгэл 10 хүрэхгүй хувьтай, иргэний шийдвэр гүйцэтгэл дөнгөж 40 хүрэхгүй хувьтай л явж байгаа. Энд маш олон шалтгаан нөхцөлүүд бий. Бид нар дампуурлын тухай хуулиа эргэж харах ёстой. Эрүүгийн хуульд заасан сая Байнгын хорооны даргын хэлдэг тэр шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийх гэдэг юугаар санкцаа гэмт хэргийнхээ санкцыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Иргэний болон захиргааны шийдвэр гүйцэтгэлийн хуучин хувь урамшуулал олгодог байсан тогтолцоо хөшүүргийг бий болгох ёстой.

Шүүхийн урдаас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулж гаргадаг шийдвэрүүдийг маш тодорхой болгох хэрэгтэй, хилийн хоригуудын тодорхой болгох хэрэгтэй. Хилийн хоригийг авснаас болж 17 оны хуулийн өөрчлөлтийн дараа маш олон гаднын иргэд хил давж шүүхийн шийдвэртэй иргэд тэр чигтээ ирээгүй яваад

өгсөн. Энэ дээр тухайн үед би бас хэлж л байсан. Тэгээд цөөнх болоод үлдсэн. Тэгэхээр цаашид энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр Засгийн газар мөрийн хөтөлбөртөө заасныхаа хүрээнд бие даасан хуулийн төсөл санаачилж оруулж ирнэ. Оруулж ирэхдээ саяын бүх хүчин зүйлүүдийг тал талаас нь тусгаж байж энэ шийдвэр гүйцэтгэлийн хувь хэмжээ нэмэгдэх ийм бодит эрх зүйн орчин бүрдэнэ.

С.Бямбацогт: Баярлалаа. Асуулт асууж хариулт авч дууслаа. 23 дээр хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал хураалт алга байна.

Хуулийн төслийн 24 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. 24 дээр Адьшаа гишүүн асуулт асууя. Шүүхийн судалгаа сургалтын хүрээлэн.

Ш.Адьшаа: Энэ миний энэ ажлын хэсэг дээр зарчмын зөрүүтэй санал хураалгаад энэ унасан санал эргээд дэмжигдсэнээр орж ирсэн байх юм. Энэ ямар учиртай юм юм бэ? Ингэж болдог юм уу, болох уу. Гайхаад байна. Энэ чинь тэгээд нэг дэмжсэн дэмжээгүй гээд бүр ингээд яагаад гэхээр энэ шүүхийн сургалт судалгааны хүрээлэн дээд шүүхийн дэргэд байна гээд би санал хураалгасан чинь шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэд байна гээд манай Энхбаярын санал дэмжигдэж байсан. Тэгсэн чинь миний санал ингээд, орж ирсэн. Ингэж болдог л юм бол сайн хэрэг л байна л даа. Чи л мэднэ шүү дээ.

С.Бямбацогт: Таны хүсэж байсан саналыг оруулж ирээд дэмжээд явсан манай ажлын хэсгийн ахлагчид баярлалаа бас тийм. Зарим ч гэсэн асуудлыг нь авсанд. Асуулт асууж хариулт авлаа. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Гишүүдээс бичгээр ирсэн санал байхгүй байна. Энийг чинь. 15.Төслийн 24 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24 дүгээр зүйл. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн

24.1.Шүүхийн хэрэгцээ, судалгаанд тулгуурлан сургалт зохион байгуулах, шүүн таслах ажиллагааг сургалт, судалгаа, мэдээллээр хангах, Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад шаардагдах судалгаа хийх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал бэлтгэх, шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэх, олон нийтэд мэдээлэх үүрэг бүхий Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн /цаашид “Хүрээлэн” гэх/ Улсын дээд шүүхийн дэргэд ажиллана.

24.2.Хүрээлэн нь сургалтын хөтөлбөрийг боловсруулах чиг үүрэг бүхий бүх шатны шүүхийн шүүгч, Ерөнхий зөвлөл, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хууль зүйн их, дээд сургуулийн төлөөллөөс бүрдсэн орон тооны бус хороотой байна.

24.3.Хүрээлэнгийн бүтэц, орон тоо, ажиллах журам, шүүгчийн сургалтын хөтөлбөрийг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Шүүхийн ерөнхий зөвлөлтэй зөвшилцөн батална.

24.4.Зөвлөгөөн болон шүүгчийн өөрийнх нь саналыг үндэслэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг зургаан сар хүртэлх хугацаагаар судлаачаар ажиллуулж болох бөгөөд түүнд шүүгчийн цалин хөлсийг хэвээр олгож, шүүгчээр ажилласанд тооцно.” санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Адьшаа гишүүний гаргасан санал ороод ирсэн одоо дэмжинэ шүү нөхдөө. Санал хураалтад 17 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 76,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 25 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Улсын дээд шүүх түүний бүрэн эрх. Алга байна. Ганбат гишүүнээр тасаллаа. 1 цаг 30 минутаас хоолонд ороод 2 цаг 30 минутад хуралдаа орно. Байнгын хорооноос хоол бүх унд зохицуулсан байгаа ажлын хэсгийн дэд гишүүд болон гишүүдэд. Та бүхнийг тэвчээртэй сууж хуралдаа оролцохыг хүсэж байна. Төрийн байгуулалт 2 цагаас хэдүүлээ ирцдээ оръё. 2 цаг минутын хооронд тэр хооронд. 13.30-14.30 хооронд хоолондоо оръё. Тэр болтол бүгдээрээ тэсээд тэгээд хуралдаад хоолоо захиж болно шүү дуртай хоолоо захиалж болно шүү. Мөнхбаатар гишүүнийг нэмье. Адьшаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьшаа: Энэ дээд шүүх бол Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар бүх шүүхэд хяналт тавьдаг удирдлагаар хангадаг ийм байгууллага гээд заасан байгаа. Тэгэхээр өнөөдөр бүх хэрэг маргааныг ер нь ихэнхийг нь Монгол Улсын энэ Шүүхийн тухай хуулиар анхан болон давж заалдах шатны журмаар шийдвэрлэх ийм хуулийг батлах гэж байна. Тэгэхээр өнөөдөр энэ дээд шүүх гэдэг энэ байгууллагыг сүүлийн үед шүдгүй арслан гэдэг юм нэг яриад байгаа шүү дээ.

Яг ийм байдалтай болгох ийм бодлого ямар учраас ингэж гарч ирж байгаа юм бэ? Би одоо энэ дээр зарчмын зөрүүтэй саналын томьёолол оруулсан байгаа. Өнөөдөр бүх шүүхийн шийдвэрийг бүх хэрэг маргааныг анхан болон давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэж байгаа нь олон ач холбогдолтой боловч энэ авлигал албан тушаалын үндэслэлгүйгээр хөрөнгөжих байгаль орчны гэмт хэрэг зэрэг ийм ноцтой үр дагавар дагуулсан ийм асуудлуудыг дээд шүүхэд хянаж шийдвэрлэх нь одоо зүй ёсны хэрэг гэж ингэж бодож байгаа.

Тийм учраас өнөөдөр нийтийн анхаарлыг татсан энэ асуудлыг бид өнөөдөр олон талаас нь ярьж хэлж шийдэхгүй бол зөвхөн энэ Үндсэн хуулийн нэрийг бариад Үндсэн хуульд ингэж заасан ийм бодлого явуулж байна гэдэг ийм байдлаар цаашид яавч байж болохгүй гэсэн ийм бодолтой байгаа юм. Ийм учраас Энхбаяр гишүүнээс тэр дээд шүүхийг энэ авлигал албан тушаалын бусад ноцтой хүн амины хэрэг үндэслэлгүйгээр хөрөнгөжих хэрэг оффшор бүсэд мөнгө хөрөнгөтэй холбоотой энэ хэргүүдийг дээд шүүхэд хамааруулах энэ асуудлыг оруулах энэ боломжийг та юу гэж харж байна вэ энэ талаар асууя.

С.Бямбацогт: Энхбаяр гишүүн ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Б.Энхбаяр: Баярлалаа Адьшаа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ Монгол Улсын дээд шүүх гэдэг бүлэг бол бас энэ шүүхийн хууль тогтоомжийн шинэчлэлийн нэлээн цөм ийм хэсэг байгаа. Ер нь энэ удаагийн энэ бүлгээр хийгдэх гэж байгаа хамгийн гол өөрчлөлт бол ер нь энэ хуулийн энэ шүүхийн шинэчлэлийн гол амин сүнс энд яваа юм. Яагаад гэхээр Монгол Улсын дээд шүүх бүх хэрэг маргааныг цаашдаа хянаж шийдвэрлэдэг байх юм уу үгүй юм уу? Энэ шүүх системдээ дарга хэв шинжтэй буюу босоо удирдлагатай шүүхийн тогтолцоо цаашаа байх уу үгүй юу гэдэг асуудал бол энэ бүлгээр шийдэгдэнэ.

Дээд шүүх амьгүй албат болох гээд байгаа юм шигээр ярьж байгаа үг үсэг бол дээд шүүхийн одоо байгаа шүүгчдийн нөлөөлөлтэй шууд холбоотой. Яагаад ер нь бүх хэрэг маргааныг шийдвэрлэх гээд байгаа юм бэ? Би 3 статистик хэлье. Өнөөдөр Монгол Улсын эрүүгийн анхан болон давж заалдах шатаар шийдвэрлэгдсэн хэргийн 50 хувь гээд дээд шүүх дээр өөрчлөгдөж байгаа. Захиргааны хэргийн $\frac{1}{4}$ нь Монгол Улсын дээд шүүх дээр өөрчлөгдөж байгаа. Иргэний хэрэг 2, 3 мянгаараа улсын дээд шүүхийн 7 шүүгч дээр овоорсон байгаа юм.

Өдөрт хувь хүний ачааллын хувьд ч дийлэхээргүй болсон. Тэгсэн мөртөө даахгүй нохой бялуу хураана гэгчээр зөвхөн өөрсдөө ингэж тэр эрх мэдлээсээ ангижрахгүй гэж амь тэмцэж байгаа. Энэ бусад улс орны тэр шүүгчид шиг нь байж болохгүй юу. Манай улс одоо 25 дээд шүүхийн шүүгчтэй. Америк гэсэн тэр том улс дээд шүүхийн 9 шүүгчтэй болоод л байна. Яагаад болоод байна вэ гэхээр сая Мөнх-Оргил дарга хэлж байна. Бүх хэрэг маргааныг хянан шийдвэрлэхгүй хууль хэрэглээний тэр нэгдмэл байдлыг хангах ёстой. Тодорхой хэрэг маргаан дээр нэг хуулийн заалтыг илтэд 2 өөрөөр эрс тэс хэрэглэж байгаатай холбоотой маргааныг л шийдвэрлэж байна. Тэрнээс биш тэр хууль ял нь хөнгөдсөн хөнгөдөөгүй их бага байлгах тухай асуудал руу ордог ийм зүйл алга.

Энэ өөрөө шүүхийн хамгийн том реформ болно. Ингэснээр өнөөдөр хэрэг дээрээ шүүх биш болоод байгаа давж заалдах шатны шүүхүүд амилна. Бүгд мэддэг л болсон шүү дээ. Давж заалдах шатны шүүхэд ер нь шүүх дээр тэрийг бол шүүх гэж тоохоо ч больсон. Дээд шүүх дээр очиж учраа олно эцсийн шийдвэрээ гаргана. Ийм л жишиг рүү явж байгаа. Энэний үр дүнд банк санхүүгийн бизнесийн маргаанууд шүүхээр явж байгаа дундаж хугацаа 4,6 жил гэж явж байгаа. 4,6 жил гэрээнээс алдагдсан мөнгөнийхөө хойноос шүүхдэж байна. Энэ хугацаанд нөгөө мөнгө нь үнэгүйдэж байна. Ямар ч үнэ цэнгүй.

Ийм учраас Монголд хөрөнгө оруулалт орохгүй байгаад байгаа юм. Шүүх нь ийм хүнд сурталтай ийм их сурталтай ийм их цаг авдаг. Тийм учраас арбитр хөгжих ёстой гэж бас яриад байгаа юм. Манай томоохон иргэний хэлцлүүд өнөөдөр яагаад

гаднын улс орны арбитраар хэрэг маргаанаа шийдүүлнэ гэдэг гэрээний заалтыг оруулаад байна вэ гэхээр манай шүүх өөрөө ийм их хүнд сурталтай.../минут дуусав/

С.Бямбацогт: Адьшаа гишүүн 1 минут.

Ш.Адьяа: Энхбаяраа ингэж онол ярьж худлаа ярихаа больё. Өнөөдөр тэр дээд шүүхийнхэн лобби хийгээд байсан юм байхгүй. Чи өнөөдөр түрүүн нэг их надад их баяртай юм ярилаа шүү дээ. Энд унасан саналыг хүртэл дэмжигдсэнээр оруулж ирж байна. Дэд ажлын хэсэг болон бусад юунууд 2, 3 хуралдаан дээд дээд шүүхийн шүүгчдийг бид нар хөөж явуулсан шүү дээ. Эд нар яагаад үгээ хэлж болдоггүй юм бэ, бид нар. Чи түрүүн ажлын хэсгийн хурал дээр улс төрийн хувьсгал хийнэ л гэсэн. Гэтэл өнөөдөр дээд шүүхийг байхгүй болгож, анхан болон давж заалдах шатан дээр аливаа хэрэг маргааныг шийддэг ийм шийдвэрийг гаргахын тулд улайрч байна. Энэ ямар зорилготой юм бэ? Өнөөдөр.../минут дуусав/

С.Бямбацогт: Дээд шүүхээс яг энэ асуудал дээр хариулт байна уу? Цогт шүүгч. 1 дүгээр микрофон.

Ц.Цогт: Гишүүдийн хэлэлцэж байгаа асуудал дээр тайлбар хэлье. Тэгэхээр ер нь бол улсын дээд шүүх бол өөрөө тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэх замаар хуулийн хэрэглээг нэгдмэл байдлыг хангах ийм үндсэн чиг үүрэгтэй шүүх бол байдаг. Шүүхийн тогтолцоонд. Энэ чиг үүрэг рүүгээ ойртохын тулд бүх хэргийг дээд шүүх авч хэлэлцдэг ийм зарчмаас тодорхой нөхцөлүүдийг заасан шаардлагыг хангасан тэр хэргүүдийг хяналтын журмаар хэлэлцэж улмаар доод шатны шүүхүүддээ хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад хэрэг болохуйц ийм жишиг шийдвэрүүдийг гаргадаг болох. Ингэснээрээ шүүх өөрөө ижил төстэй хэргийг өөр, өөр шийддэг нэг жилийн дараа ирж байгаа хэргийг өөрөөр шийддэг ийм байдлаасаа дээд шүүх өөрөө хүртэл ангижрах. Яагаад тэр өөрийнхөө гаргасан хууль тайлбарласан шийдвэрээ өөрөө бас дагаж мөрдөх ёстой гэдэг агуулгаар ийм зарчим явж байгаа.

Энэ дээр зүгээр нэг асуудал байгаа. Одоо бол энэ дээд шүүхийн хэрэг хүлээж авах шалгуур дээр 3 зүйлийг оруулсан байж байгаа. Тэгэхээр энэ бол энэ дээр бол 1 зүйлийг бол бас нэмж болохоор байгаа. Яагаад гэвэл аль ч улсын дээд шүүхэд бол хяналтын журмаар ирсэн гомдлыг харгалзаж үзээд энэ хөндөгдөж байгаа асуудал бол хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход суурь ач холбогдолтой зүйл мөн байна гэж үзэх юм бол тэрийг шүүх дээд шүүх өөрөө хэлэлцдэг ийм эрх хэмжээ олгогдсон байдаг юм байна лээ.

Тэгэхээр энэ зарчмыг нэмсэн тохиолдолд бол энэ шүүхийн хяналтаас ноцтой ач холбогдолтой гэж үзэж байгаа зүйлүүд нь гарахгүй үлдэх ийм боломж бол хангагдах юм.

С.Бямбацогт: Энх-Амгалан гишүүн асуултаа асууя.

Б.Энх-Амгалан: Энэ хуулийн гол юм дээр улсын дээд шүүх энэ хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах үүднээс нэг хуулийн заалтыг хоёр өөрөөр хэрэглээд ял оноосон бол эсхүл дээд шүүхийн тайлбарыг хоёр өөрөөр тайлбарлаад 2 өөр ял оноосон бол эсхүл шүүхийн хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд ноцтой зөрчил гаргасан бол ингээд дээд шүүх хянана гэж онолын шүүх болно гэж яриад байна тийм ээ.

Тэгвэл энэ дээд шүүхийн шүүгч шүүх хуралдаанд орж суугаад ажлын хэсгийн даргаа та нөгөө хуулиа авч гарна шүү дээ. Дээд шүүхийн шүүгч шүүх хуралдаанд орж суугаад өөрөө удирдаад яваад байдаг ийм тохиолдлууд байсан гээд. Тэрнээс болж Зориг гэдэг шүүгч ингэсэн барьсан гээд яригдаад байдаг. Энийг яаж зохицуулах вэ нэг дэх нь.

2 дахь нь энэ хуулийн 25.6.8-д байна л даа. Хуульд заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх, гишүүнээс чөлөөлөх, эргүүлэн татах тухай санал гаргана гэж байгаа. Тэгээд яах вэ Ерөнхийлөгч Улсын Их Хурал нь саналаа өгчхөөд байдаг. Дээд шүүх нь саналаа өгдөггүй ингээд гацаадаг гээд нэг ийм юм ярьдаг юм. Ингээд дээд шүүх нь Үндсэн хуулийн цэцэд дэвшүүлэх гишүүнээ оруулж ирэхгүй бол одоо ямар хариуцлага тооцох юм бэ? Ерөнхий шүүх. Тэгээд аваачиж өгөх материалаа өгөхгүй ингээд бариад байгаад байвал ямар хариуцлага тооцох юм бэ гэж. Ийм 2 асуулт би ажлын хэсгийн даргаас асууя.

С.Бямбацогт: Энхбаяр гишүүн ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Б.Энхбаяр: Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч нь одоогоор бол аль нэг танхимдаа харьяалагдахгүй ингээд явж байгаа. Ер нь бол шүүх таслах үйл ажиллагаандаа оролцохгүй. Шүүх таслах чиг үүргээ хэрэгжүүлэхгүй. Тэгээд бас энэ дээд шүүхийн санал ирүүлсэн юм. Бас нэг нөгөө шүүгчийнхээ шүүх таслах ажлаа хийх ёстой гэдэг ийм саналыг ирүүлсэн. Ажлын хэсэг дээр бол ярилцаад гэхдээ нэг асуудал байна. Энэ дуртай хэрэг дээрээ оролцдог дуртай шүүн таслах хэрэг дээр сонгож ингэж оролцдогийг бол зөвшөөрөхгүй. Энэ бол ерөөсөө байж болохгүй энэ бол.

Хэрэв шүүн таслах ажлаа хийх гэж байгаа бол яг бусад шүүгчдээсээ ямар нэгэн байдлаар давуу эрх эдлэхгүй. Яг нөгөө дараалалдаа ор. Хуваарьтаа ор. Нийт шүүгч нарын нөгөө дээд шүүгчдийнхээ зөвлөгөөний хуваарьт ороод дараалалд ороод аль нэг танхимдаа харьяалагдаад хэрэг маргаанаа шийд. Тэр нь бол энэ төслийн 25.4-т орж ирж байгаа юм. Дээд шүүхийн ерөнхий шүүгч энэ хуулийн 25.2-т заасан танхимын аль нэгт харьяалагдана гэж байгаа. Аль нэг. Нөгөөх нь бол энэ дээд шүүх энэ цэцийн гишүүдийн орон тоо гаргаад бараг жил гаруй энэ цэцийн 2 гишүүнд нэр

дэвшүүлэх ажлаа хийхгүй эс үйлдэл гаргаад бас хууль ёс хугацаа ийм хэтрээд байгаа асуудал бол байгаа юм байна лээ.

Тэгээд энэ төслийн 25.7.7 дээр Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх эгүүлэн татах хуульд заасан үндэслэл бий болсноос хойш 30 хоногийн дотор санал гаргах гэж үүрэгжүүлж хугацаа тавьсан байгаа. Өөрөөр хэлбэл одоо бол ингэж тийм хязгааргүй байхгүй шүү энийг 30 хоногийн дотор гэдэг ийм хугацааны ийм хашилтыг бас энэ хууль төсөл юу одоо санал хураах энэ төсөл дээр оруулж ирсэн байгаа.

С.Бямбацогт: Мөнх-Оргил гишүүн ажлын хэсгийн ахлагч юу гишүүн тайлбар хэлэх үү. Тайлбар Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ хорин тавын дөрөв дээр улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч аль нэг танхимд харьяалагдах уу, үгүй юу гэдэг дээр нэлээн их асуудал, маргаан, маргаан юу ч байх вэ дээ тойрсон хэлэлцүүлэг болсон юм. Тэгээд энэ дээр би дээд шүүхийн шүүгчдийг энэ асуудал дээр саяын байр сууриа нэг яагаад та нар ер нь дээд шүүхийн ерөнхий шүүгч танхимд харьяалагдах хэрэггүй юм бэ гэдэг үндэслэлээ ахиад нэг хэлчхээч гэж би хүсэж байгаа юм. Протокол дурдчих хэрэгтэй юм байгаа юм. Нэгдүгээрт. Энэ нэг процессын асуудлууд яриад байгаа нөгөө алдаагаа засах асуудлууд яриад байгаа юм.

Хоёрдугаарт ажлын хэсгийн Байнгын хорооны гишүүдийг би энэ хорин тавын зургаагийн тав дээр сая тэр Цогт шүүгч хэллээ шүү дээ. Нөгөө гурван үндэслэл дээд шүүх асуудал авч хэлэлцэх хяналтын журмаар шийдвэрлэх асуудал гурван төрөл байгаа. Энэ дээр дөрөв дэх төрлийг нь нэмээд хуулийн хэрэглээний нэгдмэл байдлыг хангаагүй. Тэгэхдээ эхний гурван шаардлагыг хангачихсан. Өөрөөр хэлбэл хуулийн хэрэглээнд нэгдмэл байдал байхгүй. Тэгэхдээ эхний гурван шаардлагыг хангаагүй асуудлуудыг дээд шүүх харж байгаад энэ бол үнэхээр одоо ач холбогдолтой юм байна, эрх зүйн ач холбогдолтой юм байна, энэ асуудлыг дээд шүүх хэлэлцэх нь хэрэгтэй юм байна гэж үздэг эрхийг нь дээд шүүхэд нь олгомоор байгаа юм.

Өөрөөр хэлбэл энэ асуудлын ач холбогдлыг харгалзаад бид нар бол эхний гурван шаардлагыг биелүүлээгүй ч гэсэн энэ асуудлыг хэлэлцэх нь зүйтэй юм байна гэж үздэг. Дээд шүүхийн өөрийн нэг тийм шийдэх эрх нь баймаар байгаа юм. Энийг нэмж оруулмаар байгаа юм.

С.Бямбацогт: Дээд шүүх нэгдүгээр микрофон. Ундрам шүүгч үү. Хариулт өгье дөө.

Б.Ундрах: Сонсогдож байна уу? Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр Монгол улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч танхим харгалзахгүй хуралд оролцох асуудал энд яригдаж байгаа. Тэгэхээр одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа

процесс болон шүүхийн тухай хуульд дээд шүүхийн ерөнхий шүүгч танхим харгалзахгүй оролцож байгаа үндэслэл нь өөрөө юу байсан бэ гэхээр Үндсэн хуульд зааснаар Монгол улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн юм байна. Цэцийн шийдвэрт ч бас зарим тохиолдол гарсан байгаа. Өөрөөр хэлэх юм бол хяналтын шатны шүүхийн шийдвэр эцсийн юм байна гэж хэлээгүй. Монгол улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байна гэсэн.

Тэгээд алдаагаа өөрөө засна гээд ийм хоёр заалт Үндсэн хуульд байдаг. Шүүхийн тухай хуулийн төсөл дээр бол дээд шүүх алдаагаа засах энэ механизм бол орхигдсон байгаа. Тэгэхээр Монгол улсын дээд шүүх тооцооны алдаа, техникийн алдааг бол засаж болно. Тэр бол танхимаараа засчихна. Яг одоо хууль хэрэглээний хувьд алдаа гарсан тохиолдолд Үндсэн хуульд заасан тэр бүрэн эрхээ хэрхэн яаж хэрэгжүүлэх вэ гэдгийг одоогоор бол шүүхийн тухай хуульд тусгаагүй гэдгээ эхлээд хэлчих нь хэрэгтэй байхаа. За яг үүнтэй холбоотойгоор дээд шүүхийн ерөнхий шүүгчийн бүрэн эрх энд хэрэгжиж байсан. Тэгэхээр шүүх алдаа гаргасан гэж үзвэл одоо ямар байдлаар хэрэгжиж байгаа вэ гэхээр дүгнэлт бичээд хуралдаанаар оруулдаг. Дүгнэлт бичдэг учраас аль нэг танхимд харьяалагддаггүй ийм байсан.

Одоогийн шүүхийн тухай хуулиар аль нэг танхимд харьяалуулаад хийчихээр, бид нар одоо алдаа засах механизмыг хэрхэн яаж засах вэ гэдэг асуудалтай холбоотой л энэ асуудал яригдана, нэгдүгээрт. Хоёрдугаарт шүүх одоо танхим яг одоогийн байдлаар хэрэв байгаагаар танхим болгонд найман шүүгч байдаг. Зарим тохиолдолд бүрэлдэхүүн хүрэхгүй ийм тохиолдолд бас ерөнхий шүүгч орох энэ боломжийг нь бид нар авч үлдэх үүднээс энийг нь дэмжээд байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол аль нэг танхимд харьяалагдахгүйгээр оролцоно. Аль нэг танхимд байгаа харьяалагдахгүйгээр оролцохоор дуртай хэргээ авч шийдээд байх боломж угаасаа байхгүй. Яагаад гэвэл одоо шүүхийн тухай хуулийн төсөл дээр бид нар энийг тодорхой зааж өгсөн байгаа. Шүүгчдийн зөвлөгөөнөөр хэрэг маргаанаа хэрхэн яаж хуваарилах вэ гэдгээ заана. Энэ дотор ерөнхий шүүгч шийдэх хэрэг мөн орно. Тэгэхээрээ урьдчилан шийдвэрлэсэн ч тогтоосон журмын дагуу ерөнхий шүүгч шүүх хуралдаанд оролцох асуудал энд яригдах юм. Тийм болохоор одоо ерөнхий шүүгч танхим харгалзахгүй оролцоно гэдэг асуудал өөрөө энэтэй холбоотой юм.

Дараагийн асуудал дээр тэртээ тэргүй дээд шүүхийн бүрэн эрх энд ярьж байгаа учраас одоо тэр хяналтын шатны шүүхийн чиг үүргийг хэрэгжүүлэх асуудал мөн яригдах гээд байгаа юм. Одоо шүүхийн тухай хуулийн төсөлд бол гурван үндэслэлээр хянаж байгаа, хянахаар тусгачихсан. Тэр гурван үндэслэлийн хоёр нь үндсэндээ хууль хэрэглээ гэж ойлгогдохгүй байгаа. Эхний үндэслэл нь юу вэ гэхээр ноцтой алдаа гаргасан, тэр нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн бол дээд шүүх хянана гэж байгаа. Энэ дээр бол ямар ч хууль хэрэглээ буюу материаллаг хууль хэрэглээ байхгүй. Процессын алдаа байгаа тохиолдолд буцааж байгаа. Энэ ноцтой алдаа бол хэзээ ч дээд шүүх эцсийн шийдвэр гаргахгүй. Ноцтой алдаа гаргасан тохиолдолд

зөвхөн буцаана. Буцаахдаа, материаллаг хуулийн талаар дүгнэлт өгөхгүй эхний хувилбар. Тэгэхээр энэ дээр бол хууль хэрэглээ зөвхөн процессын талаар ярина гэсэн үг.

Хоёр дахь нь болохоороо ямар үндэслэлээр хянаж байгаа вэ гэхээр дээд шүүхийн тайлбарт зааснаас өөрөө шийдсэн бол гэдэг ийм үндэслэл байгаа. Тэгэхээр дээд шүүхийн урьд нь гаргасан шийдвэр тайлбарт одоо гаргаж байгаа хянагдаж байгаа энэ шийдвэр нийцэж байна уу, үгүй юу гэдэг дүгнэлтийг л хийнэ.

С.Бямбацогт: Нэг минут сунгая, нэгдүгээр микрофон.

Б.Ундрах: Уучлаарай мөн тайлбар гаргахгүй гаргах одоо хэмжээний шийдвэр гарахгүй байна гэж хараад байгаа юм. Хамгийн нэг хувилбар нь буюу тэр зөрүүтэй шийдвэр гаргасан, анхан давахын шийдвэр зөрүүтэй гарсан бол энэ дээр бол хууль хэрэглээн тайлбар гарч магадгүй. Мөн нийт шүүгчдийн хуралдаанаас хэрэв танхим оруулах юм бол тайлбар гаргана гэж ийм хоёр л үндэслэл байгаа. Тэгэхээр зүгээр ямар нөхцөл байдал энд байна вэ гэхээрээ хяналтын шатны шүүхийн чиг үүргийг Үндсэн хуульд зааснаараа хэрэгжүүлэх боломжийг нь сая Мөнх-Оргил гишүүний хэлсэн өөр нэг үндэслэл нэмээд оруулчихвал яах юм бэ, болж байна уу гэдэг талаас нь яг ийм үндэслэлээр дэмжээд байгаа юм гэдгээ хэлэх гэсэн юм. Тэр боломж гарсан дээр нь тэр төрийн мэдээллийг хэлчихье. Төрийн мэдээлэл дээр бол яг хяналтын шатны чиг үүргээ хэрэгжүүлж байгаа тайлбар хэмжээний юу шийдвэр гарахгүй гэж харж байгаа. Хуулийг бүхэлд нь агуулгаар нь харах юм бол тэр яг нөгөө норматив тайлбар буюу танхим оруулаад, нийт шүүгчдийн хуралдаанаар хорин тавуулаа сууж байгаад хийж байгаа тайлбар л нийтлэгдэнэ гэж ойлгогдож байгаа. Баярлалаа.

С.Бямбацогт: Ганбат гишүүн асуултаа асууя. Дэлгэрсайхан гишүүнийг нэмчхээрэй.

Д.Ганбат: Энэ дээд шүүхийг яриад байна л даа. Энэ дээд шүүх, ерөнхий шүүгч эд нартай л холбоотойгоор нөгөө хонгил, хонгил гэсэн зүйлүүд л гараад байдаг гэж ойлгоод байгаа шүү дээ. Олон нийтийн шүүмжлэл тэгж яваад байгаа. Тэрнээс биш тэр таван зуун шүүгчид бол бас бүгд л ихэнх нь бараг ерэн есөн хувь нь бол хэвийн ажиллаж байгаа хүмүүс гэж ойлгож байгаа. Энэ дээр юу хэлэх гэж байна вэ гэхээр таван зуун шүүгчээс одоо энэ дээд шүүхийн шүүгчид маань онолын шүүх болчихоод, тэгээд хорин дөрвүүлээ хорин дөрвөөс доошгүй гэчихсэн байна л даа. Ийм олон шүүгч байх шаардлагатай юм уу нэг. Хоёрт одоо энэ ажлын хэсэг, энэ хууль тогтоох Хууль зүйн байнгын хороон дээр дээд шүүхийн шүүгчид маань орж ирээд ингээд янз бүрийн тайлбар тайлбар хийгээд яриад байдаг. Энэ одоо ашиг сонирхлын зөрчил болчихгүй юу? Дээд шүүхээс саналыг нь л авсан болоо биш үү. Ингэж явдаг шүү дээ, уул нь бол.

Тэгээд бас өшөө нэг юм байна. Сахилгын ерөнхий хороо гээд Үндсэн хуулийн байгууллага байгуулж байгаа. Сахилгын ерөнхий хорооны тэр шүүгчтэй холбоотой шийдвэр бол эцсийн шийдвэр байхаар байна уу? Эсвэл энэ дээд шүүхэд нь хандаад дээд шүүх нь тэрийг нь бас эцсийн удаа хянаж барьж болохгүй юу? Энэ асуудлыг яаж шийдвэрлэж байгаа юм?

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч хариулъя. Энхбаяр гишүүн. Ер нь бол юу байна шүү дээ бас дэд ажлын хэсгийн гишүүн шү дээд шүүхийнхэн маань. Бас тодорхой бид нар бас мэдээлэл, судалгаа авах үүднээс бас ажлын дэд хэсгээ сонсоно, сонсолгүй яах вэ?

Б.Энхбаяр: Баярлалаа. Гэхдээ нөгөө ажлын хэсгийн гишүүд эхлээд бас хариулт дэд хэсгийн гишүүдээр хариулуулъя гэвэл хариулдаг байх байдлаар ярихгүй бол энэ бол ажлын хэсэг дээр долоо хоног өдөр шөнөгүй ярьсан асуудал шүү, долоо хоног. Тэгэхээр дэд хэсэгтэйгээ нийлээд хэрэв бид нар явна гэвэл энэ долоо хоног ч багадаа байх. Яг ийм байдлаар явуул. Тэгээд олон талаас нь бол байр сууриа бас бид нар ярьсан, ярьсан. Би сая хэллээ. Энэ хуулийн шинэчлэлийг хийх гэж байгаагийн утга учир одоо ганцхан өгүүлбэр ярьж байна. Улсын дээд шүүх зарчмын ач холбогдолтой гэж үзвэл хэрэг маргаанаа хянан шийдвэрлэдэг байх тухай ярьж байна. Тэгвэл энэ өнөөгийнхөөсөө бүрэн ухарна.

Дээд шүүх өөрөө зарчмын ач холбогдолтой гэж юугаа үзэх юм, юугаа үзэхгүй гэж энэ ямар шалгуур вэ? Энэ улс төрийн шалгуур уу, хувийн шалгуур уу, хүний шалгуур уу, хуулийн шалгуур уу? Зарчмын ач холбогдолтой гэж үзвэл шийддэг гэж ямар одоо улсад ийм юм байна вэ? Энэ чиглэлээр парламентын судалгааны хүрээлэнгээр судалгаа хийлгэсэн. Бусад улс орны дээд шүүх ямар үндэслэлээр хэрэг маргааныг хянан шийдвэрлэж байна. Нэн тодорхой үндэслэлээр хэрэг маргааныг хянан шийдвэрлэдэг болохоос юу нь мэдэгдэхгүй, юунд ч баригдахгүй ийм ерөнхий үндэслэлээр хэрэг маргаан ханадаггүй юм. Яагаад энэ том уутыг авах гээд байгаа юм бэ? Дөрөвхөн үг байна. Дөрөвхөн үг одоо оруулчихъя тухай яриад байна. Манай гишүүд рүү лоббидож байна. Шударга л хэлье.

Та нар өнөөдөр хүртэл шийддэг л байсан юм бол яагаад шүүхийн реформыг хийх ёстой гэж өнөөдөр бид яриад сууж байгаа юм. Гучин жил болохгүй болсон учраас бид нар энэ хууль эрх зүйн реформыг хийх гэж байгаа юм. Одоо энэ заалтыгаа авч үлдэх тухай яриад дахиад л сууж байна. Дахиад гучин жил тэсэж чадахгүй Монголын ард түмэн. Монгол улс энэ бол таны өөрийн асуудал биш. Үр хүүхдийн чинь ирээдүйн асуудал. Олигтой байсан юм бол хэрэг маргааныг нэр төртэй шийдэж байх нь яасан юм. Яагаад хэдэн хэдүүлээ нийлж тэр авлига авч, өөрсөд дээрээ хэрэг овооруулж гадныхнаас байгалиа зарж өнөөдөр зарим чинь шоронд орчихсон сууж байгаа юм. Тийм учраас одоо боль оо, наад лоббигоо. Манай гишүүд ч гэсэн одоо боль.

С.Бямбацогт: Ганбат гишүүн тодруулъя. Жоохон эмоцио барьцааж хариулна шүү, яг ажил хэрэгч хуралдана шүү хэдүүлээ. Бие биедээ хүндэтгэлтэй хандъя.

Д.Ганбат: Би асуулт асуудаг, тов тодорхой асуулт асуугаад байхад яагаад ингээд тойроод байна. Тэгэхээр энэ хууль маань бас л их л сайн хууль гаргачих хэрэгтэй байна шүү дээ. Бид нар чинь ярилцаж байгаа тийм ээ. Одоо танай намын мөрийн хөтөлбөрт ч байгаа. Бид бүхэн одоо ширээ яах гэж ингээд тойроод сууж байгаа юм. Тэгэхээр энэ зүйл дээрээ бас анхаармаар байна. Тэр лобби гэдэг нь одоо юу юм. Энэ дээд шүүхийн шүүгчид одоо энэ дотор орж ирээд суучихсан. Тэр ажлын хэсэгт нь байгааг лобби гээд байна уу? Тэрийгээ тодруулаарай. Би асуусан шүү дээ. Яагаад хорин дөрвөөс доошгүй байх ёстой юм бэ гэж. Хуулийн заалт нь байна л даа. Хорин тавын гурав улсын дээд шүүх нь ерөнхий шүүгч хорин дөрвөн хорин дөрвөөс доошгүй шүүгчээс бүрдэнэ гэж байна. Энэ таван зуун шүүгчийн чинь хорин дөрөв нь ингээд байхаар одоо анхан шатанд шийдэж байгаа хэргүүд маань ачаалал ихтэй. Тэгээд иргэд маань тэр шүүхийнхээ шударга.../минут дуусав/

С.Бямбацогт: Ганбат гишүүн нэмээд нэг минут.

Д.Ганбат: Шударга шүүхээр шүүлгэх тэр эрх нь зөрчигдөж байна уу, ямар байна вэ? Нөгөө талаар бас тэр сахилгын ерөнхий хороо, Үндсэн хуулийн байгууллага маань бас нэг хонгил бий болох ийм үндэс суурийг нь тавьчих вий. Тэр шүүгч нь асуудлаа шийдүүлэхдээ нэг удаа дээд шүүхдээ хяналтын журмаар шийдүүлж болохгүй юу. Яг тэр мэргэжлийн хүмүүсээр нь онолынх нь хүмүүсээр. Ийм хоёр асуулт би тов тодорхой асуугаад байхад л яагаад хариулахгүй ингээд байна вэ? Цаана нь ямар нэгэн учир байна уу?

С.Бямбацогт: Хариулъя, эхний асуулт нь ярьсан шүү дээ. Нөгөө сахилгын хорооны шийдвэрийг дээд шүүх хянах уу, гэрээний тоо процессыг хянах уу энийг тодорхой хариулж өгөөч гэж байна. Хоёр дахь асуулт нь хорин дөрвөн шүүгч хорин дөрвөөс доошгүй шүүгчтэй байх ёстой гээд байна. Яагаад хорин дөрвөөс доошгүй байх ёстой юм бэ? Хорин дөрөв чинь их юм биш үү, бага юм биш үү гэж ойлгосон. Ажлын хэсгийн бол хорин дөрвөөс дээшгүй гэж өөрчилсөн байж байгаа. Тэгээд энэ тооныхоо үндэслэлүүдийг бас нэг тайлбарлаад өгөөч гэсэн асуулт асууж байна. Энхбаяр гишүүн хариулах уу ажлын хэсгийн ахлагч.

Б.Энхбаяр: Дээд шүүхийн шүүгчдийн тооны хувьд бол улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч хорин дөрвөөс дээшгүй шүүгчээс бүрдэнэ гээд Засгийн газраас өргөн барьсан төсөлд байгаа. Энийг хөндөөгүй ажлын хэсэг. Доошгүй байсныг нь дээшгүй. Доошгүй гэдэг чинь юу байхгүй юу дээшээ нэмэх гээд байгаа байхгүй юу. Хэн нэмэх юм. Тэгэхээр энэ чинь хэд ч хүрч магадгүй гэсэн үг байхгүй юу. Нэг мэдсэн чинь парламентынхаас олон шүүгчтэй болчихсон байх юм уу, үгүй юм уу? Бидний нөгөө

энэ тоо чинь өөрөө энэ ярьж байгаа реформтойгоо холбоотой байгаад байгаа байхгүй юу. Одоо дээд шүүх бүх хэрэг маргааныг хянан шийдвэрлэхгүй учраас ер нь бол цаашдаа бол ойлгож байгаа хорин дөрөв, тав нь ч гэсэн ихэднэ. Угаасаа ачаалал нь хөнгөрчихнэ гэсэн үг. Яг тодорхой хэрэг маргаан шийдвэрлэхгүй болоод ирэхээр.

Өөрөөр хэлбэл тэр онолынхоо шүүхийн тэр чиг хандлага руу яваад ирэхээр тэр хорин дөрөв, тав гэдэг чинь бол ер нь хангалттай хэмжээнд бол байх байх гэсэн утгаар ажлын хэсэг бол ийм санал оруулж байгаа. Сахилгын хорооны шийдвэрийг дээд шүүх хянах ёстой, хянах ёсгүй гэдэг тухай асуудал бол нэлээн хойшоо сахилгын хорооны хэсэг дээр бол нэлээн тодорхой яригдах байх. Товчдоо бол дээд шүүх сахилгын хорооны шийдвэрүүдийг хянадаг байх тухай бас дахиад ярих байх. Ажлын хэсэг дээр ярьж байгаад бас процесс зөрчвөл сахилгын хороо магадгүй одоо хүнд нөгөө санал гомдлоо тавих, эрхээ хамгаалуулах, магадгүй өмгөөлөгч авах ч гэдэг юм уу ийм эрхийг нь хангахгүйгээр бас хэрэг шийдвэрлэж магадгүй шүү дээ.

Тийм учраас тийм процессын алдаа гаргавал улсын дээд шүүх бас хянаж болох юм гэдэг тэр заалтыг бол дэмжээд. Өөрөөр хэлбэл шүүгч хүний ч гэсэн бас нөгөө шүүхдээ шүүхээр хэрэг маргаанаа хянан шийдвэрлэх тэр үндсэн эрхийг бол хангаад, хангаад оруулж ирж байгаа юм. Тийм. Тэгэхээр энэ дээр бол асуудал гарахгүй байх.

С.Бямбацогт: Хариултаа авчихсан, одоо болсон хоёр минут өгчихсөн танд. Мөнхбаатар гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаатар: Улсын дээд шүүхээр хэлэлцэх хэргийн хүрээг бас нэлээн явцуу хүрээгээр ингээд томьёолж байгаа юм байна. Ер нь бол яах вэ энэ улсын дээд шүүх гэдэг өөрөө энэ Үндсэн хуулийнхаа ойлголтоор бол энэ чинь шүүх шүү дээ. Яах вэ онолын шүүх рүү явж байна гээд нэлээн ерэн оноос өмнө байсан шиг коллегийн гишүүн гэдэг шиг одоо ерөнхийдөө тэр тал руу нь явж байгаа гэсэн ийм агуулга байх шиг байна. Шүүх, дээд шүүх гэдэг бол шүүх. Шүүн таслах үйл ажиллагаа явуулдаг. Шүүх л шүүх таслах үйлчилгээ явуулна шүү дээ. Тэгэхээр энэ агуулгаар нь бас харах ёстой. Нөгөөдөх үр одоо дээд шүүхэд нийт гарч байгаа хэрэг маргааны гурван хувийг нь л одоо дээд шүүхэд ханддаг юм байна лээ шүү дээ. Хяналтын шугамаар хандаж байгаа гурван хувь нь нийт маргааны гурван хувийг нь.

Тэгэхээр энэ гурван хувьд нь хандаж байгаа энэ хүмүүсийн одоо эрхийг бас хөндөх вий? Би Үндсэн хуулийн нөгөө суурь зарчим, үзэл баримтлалтай нь холбож яриад байна шүү дээ. Энэ хүмүүсийн эрх бас зөрчигдөхгүй гэж би бас болгоомжилж хараад байна. Тийм учраас энэ асуудлыг бас бид энэ дотроо бас ярья. Түрүүн бас Мөнх-Оргил гишүүн ч бас хэлээд байгаа. Энэ бол гурван чиглэл байгаа. Энэ хууль хэрэглээнийхээ зөрүүг арилгах чиглэлээр, хоёр дахь нь энэ хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан энэ шүүхийн шийдвэрт нөлөөлсөн бол гэж

байгаа. Дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөр өөр хуулиуд тайлбарлаж хэрэглэсэн бол гээд. Энэний дараа шат нь бол дөрөв дэх зүйл нь болгоод энэ улсын дээд шүүх бол хуулийн нэгдмэл байдлаа хэрэглээг одоо энэ хангах зорилгоор давж заалдах шатны шүүхийн одоо магадлалыг хяналтын журмаар хянадаг. Ийм бас нэг гарцыг нь тодорхой хэмжээнд хийж өгөхгүй бол нь энэ тодорхой бас хүний эрх, энэ эрхээ хамгаалуулах энэ эрх нь бол бас зөрчигдөх байдал үүсэж магадгүй байна гэдгийг би хэлье гэж бодож байна.

Хоёрдугаарт сая тэр шүүгчдийн тоо ярьж байна. Хорин дөрвөөс одоо дээшгүй доошгүй гэснийг нь дээшгүй болгоод ингээд өөрчилж байгаа юм байна. Ингэж өөрчилж байгаа тохиолдолд нэг ийм юм байгаад байгаа юм. Энэ хуулийн энэ хорин тавдугаар зүйл дээр улсын дээд шүүх шүүн таслах ажиллагааны төрлөөр хэрэг маргааныг хянан шийдвэрлэх, эрүү, иргэн, захиргааны хэргийн зэрэг дагнасан танхимтай байна гэж байгаа. Хэрэв танхимтай л байх юм бол энэ хорин таваас хорин дөрөвд ерөнхий шүүгчтэйгээ хорин тав байхгүй бол угаасаа танхимын зарчмуудыг чинь байхгүй болчихно шүү дээ. Гэхдээ энд бас нэг болгоомжлол байна. Хуучин хоёр мянга хоёр онд ч гэсэн гарч байсан. Дээд шүүх арван долоон гишүүнтэй байсан. Арван нэг болоод багасгачихсан шүү дээ, энэ чинь. Нөгөө энэ эрх зүйн үндсийг нь нээгээд өгөхөөр л ингээд багасгачихдаг ийм боломж бас гараад ирдэг.

Ийм учраас энийг бол одоо өөрчлөхгүйгээр, Засгийн газрын өргөн барьсан энэ төслийг нь одоо ингэж дэмжээд явах нь зүйтэй юм байна гэж үзэж байгаа юм. Тэгж байж энэ танхимын зарчим буюу энэ шүүхэд одоо бий болсон энэ дэвшилтэт зөвлөл эрүү, иргэн гээд энэ дагнасан шүүхэд ажиллах боломжоо хадгалж хамгаалж үлдэх ёстой. Энэ бол бас чухал, тоонд бол бас их чухал байгаа шүү. Өөрөө энэ бас тодорхой үр дагавартай зүйл шүү гэдгийг гишүүддээ хэлье гэж бодож байна.

С.Бямбацогт: Мөнхбаатар гишүүн ерөнхийдөө санал хэллээ. Дэлгэрсайхан гишүүн.

Б.Дэлгэрсайхан: Хөөе байж байгаарай. Мөнх-Оргил гишүүнээ. Би саналаа хэлээдэхье. Энэ дээд шүүхийн хэрэг хянан шийдвэрлэхийг нэлээн хязгаарлачихаар зэрэг бас их сонин юм гарч ирэх вий дээ. Энэ ажлын хэсэг бид одоо энэ ажлын хэсэг өөрсдийгөө л одоо бид төгс юм хийж байна, шинэчлэл хийж байна гээд л ингээд уурлаад бухимдаад байх юм. Энийг чинь долоо хоног байтугай хэдэн сар, жил ч ярьсан болно шүү дээ. Энэ чинь шүүхээр ордоггүй нэг ч иргэн, аж ахуйн нэгж байдаггүй шүү дээ. Бүх хүний л хувь заяаг шийддэг. Тэгэхлээр зэрэг ингээд практикаас хараад байхад бол иргэн ч бай, аж ахуйн нэгж ч бай, ер нь аргаа ядарсан бүр зүдэрсэн ийм хүмүүс л дээд шүүхийн шийдвэрийг л одоо хүлээдэг шүү дээ. Яг амьдрал дээр. Тэгээд одоо ингээд давж заалдах шатны шүүхээр ингээд таслаад зогсоочихоор энэ иргэнийхээ эрхийг одоо зөрчих юм биш үү, нэгдүгээрт.

Хоёрдугаарт Үндсэн хуульд бол одоо дээд шүүхийн шийдвэр эцсийнх байна гээд ингээд Үндсэн хуульд байгаа учраас саяын Тунгалаг шүүгчийн хэлдгээр бол энэ цэц дээр очоод унана. Тийм учраас бол энэ дээд шүүхийн хэрэг одоо хянах энэ процессыг багасгаад, бараг зөвхөн онолын шинжтэй болгоно гэвэл арай болохгүй байх нэгдүгээрт. Хоёрдугаарт энэ чинь юундаа байгаа юм биш шүү дээ. Дээд шүүхийн одоо байгууламж одоо юу гэдэг юм Дээд шүүхийн хэрэг хянан шийдвэрлэхдээ байгаа юм биш, хүндээ байгаа асуудлыг аваачаад дээд шүүхэд нь байгаа мэтээр ойлгож, ингэж тайлбарлаад байж болохгүй шүү дээ. Би дахиж хэлье. Ямар ч одоо шүүх ямар ч одоо хэрэг заргаа, заргадаа гомдол гомдолдсон энэ давж заалдах шатны шүүхээр орсон шийдвэр таалагдахгүй байгаа иргэн аж ахуйн нэгж, дээд шүүхэд хандана шүү дээ. Энийг шийдэхгүй байх юм уу. Энэ чинь их сонин болчихлоо шүү дээ.

Дээр нь урьд нь одоо энэ жаран дөрвөн оны хууль мөрдөгдөж байхад одоо энэ хуучин биднийг ажиллаж байхад бол улсын дээд шүүхийн тайлбар гэж гардаг байсан. Энийг бол бүх шатны хууль хяналтын байгууллагууд гарын авлага болгож хэрэглэдэг байсан. Энэ зүйлийг буцааж сэргээвэл одоо бидний яриад байгаа энэ алдаа завхрал гарахгүй байх магадлал аягүй их өндөр. Тэр үед янз бүрийн юм гардаггүй байсан шүү дээ. Яг л нэг тайлбар журмыг нь бариад энэ хуулийг ингэж ойлгоно гээд дээд шүүх тайлбар хийгээд өгчихлөөр зэрэг хууль хяналтын байгууллагууд процессын хувьд ч тэр тэрийгээ баримтлаад явдаг байсан. Тэгэхгүй одоо тийм тайлбар байхгүйгээс болоод хуулийг хэн дуртай нь өөрийнхөөрөө тайлбарладаг.

Ялангуяа манай далан зургаа бол бүгд өөрсдийнхөөрөө хууль тайлбарладаг болчихсон шүү дээ. Тэгэхэд чинь тэр дээд шүүх чинь олон жил мэргэшчихсэн хорь, гучин жил ажиллачихсан, шүүхийн практикт энийг чинь ингэж хэрэглэдэг юм, энийг ингэж ойлгоно гэж тайлбар гаргадаг байсан шүү дээ. Энийг л буцаагаад сэргээх хэрэгтэй шүү дээ. Тэгж байж энэ хуулийн хэрэглээ чинь зөв болох байх шүү гэдэг ийм хоёр санал хэлье. Тэрнээс биш дээд шүүхийн хэрэг хянан шийдвэрлэдэг юмыг ингээд бүр таслан зогсоож яагаад ч болохгүй. Давж заалдах шатны шүүгчийг шударга шүүнэ гэж хэн хэлчхээд байгаа юм. Тэгэхлээр хүмүүсийн одоо эцсийн горьдлого магадгүй одоо хүн амины хэрэгтэй хүмүүс ял нь одоо буруу шийдэгдчихсэн, эсвэл их хэмжээний хохирол хохирлоо алдчихсан улсууд тэгээд дээд шүүхэд гомдохгүй өөр яах юм. Давж заалдах шатны шүүхээр ингээд таслан зогсоогоод одоо болно гэх юм уу, эсвэл цэцэд явах юм уу?

С.Бямбацогт: Энхбаяр гишүүн хариулъя. Дээрээс нь Алтанхуяг гишүүн ажлын хэсгийн гишүүд хариулъя. Сүхбаатар гишүүн бас бэлдэж байгаарай. Энхбаяр гишүүн асуултаа хариулаач. Сүхбаатар гишүүн дараа нь Алтанхуяг гишүүн ажлын хэсгийн гишүүд.

Ж.Сүхбаатар: Би түрүүний тэр нэг юутай ажлын дэд хэсэгтэй холбоотой асуудлаар бас хуралдаан даргалагчид хэлж байгаа юм. Энд яригдаж байгаа үг болгон

протоколд бичигдэж байгаа. Энэ бол зүгээр нэг тийм хийсвэр яриад шийдэгдчих асуудал биш. Энэ бол дэмжсэн, дэмжээгүй санал болгон бол ойрын хэдэн жилд бол үр дагавар авчирна. Тэгэхээр энэ бол протокол бас үр дагавартай юм. Ажлын дэд хэсэг бол мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх л үүрэгтэй. Өөрөөр хэлбэл ажлын хэсгийн гаргасан шийдвэрийг сөрж тайлбар хийх үүрэг байхгүй. Энийг хуралдаан даргалагч сахиулах ёстой. Тэгж л ажлын хэсэг гардаг. Тэрнээс биш одоо дэмжихээс өөр байр суурийг танилцуулах гэж мэдээлэл өгөх гэж ингэж суудаггүй юм. Хэрэв ингэх юм бол энэ бол ажлын хэсгийн эсрэг ажлын дэд хэсгийн гишүүд юм ярина. Энийг бол хэлчихье бас ийм практик тогтож болохгүй.

Хоёрдугаар асуудал бол дээд шүүхийн асуудал дээр бол ингээд энэ чинь концепцын ялгаа гарч байна. Дэлгэрсайхан гишүүний ярьж байгаа асуудал. Энэ эцсийн шийдвэр байна гэдэг чинь бол эцсийн шат байж байгаа учраас бүх бүх хэрэг маргаан энүүгээр орох ёстой гэдэг ийм тайлбар, ойлголт бол энэ өнгөрсөн он жилүүдэд явж ирсэн. Одоо яаж байна вэ гэхээр хяналтын шат болж хяная гэж байгаа юм. Тэгээд энд бичиж байгаа хорин тавын зургаагийн тав бол хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор гэж байгаа юм. Хэрэв энэ зорилгоо больё гэж байгаа бол хуучин хуучнаараа явах хэрэгтэй. Энэ зорилгоо энд энэ зорилгоо тавьчихсан энэ заалт нь зөв юм бол доод талын гурван үндэслэлд багтаад зөрүүгээ арилгах ажлаа тайлбарлаад, нэгдмэл байдлаар хангах бололцоо байгаа шүү дээ.

Анхан болон давж заалдах чинь шүүх хэрэглээний зөрүүг арилгана гээд тэр яриад байгаа. Тэр чухал гээд байгаа хэргүүдийнхээ асуудлыг оруулаад авч хэлэлцээд шийдэх боломж байгаа шүү дээ. Заавал энд ингэж энэ тэр юм яриад байх шаардлагагүй шүү дээ. Улсын дээд шүүхэд албан ёсны тайлбар гаргах эрх нь байж л байна. Хэрэглээний зөрүү арилгана гээд л асуудлаа аваад үзэх эрх нь байж л байна. Тэгэхээр энийг зүгээр өргөжүүлж ингэж хийж байгаа гэж байна. Шүдтэй шүдгүй байх тухай асуудал, энэ шүдний асуудал биш. Шүүх бол үнэн худлын дэнсийг тогтоодог. Нэг талдаа илд байвч нөгөө талд нь бамбай байдаг. Тэрнээс илд бариулаад шүд тэрийг нь хурцлах тухай биш, бас бамбай байх ёстой. Шүүхийг өөрийг нь хязгаарлах ёстой бас. Энэ илдээ барьчхаад ийш тийшээ давхиж цавчаад, ийш тийшээ дур зоргоороо авирлаад байж болохгүй. Тэгээд энэ утгаар нь асуудалд хандаж байгаа.

Энэ бол зүгээр яах вэ концепцын буюу сэтгэлгээний ялгаа болох байх. Өнөөдөр энд ч гэсэн яригдаж байгаа асуудлуудыг би чөлөөтэй ярих нь үнэхээр зөв. Бүх хүн яг бодож байгаагаа ярих хэрэгтэй. Энэ протоколд энд үлдэж байгаа учраас. Би бол дээд шүүх, ерөнхий шүүгч, Ерөнхийлөгч гэсэн энэ бүгдийнх нь эрх мэдлийг хязгаарлахын төлөө байгаа. Энэ таалагдахгүй байж магадгүй. Хязгаарласны дараа магадгүй тэр дээд шүүхдээ одоо ажиллах боломж олгоё, суллая зөөллөө, сайхан болгоё гэж ярьж болно. Дур зорог хэтэрсэн учраас төвлөрсөн эрх мэдэл хэтэрхий их төвлөрсөн учраас тэрийг задлах гээд байгаа юм. Тэрийг хязгаарлах гээд байгаа юм. Тэрийг шахах гээд байгаа юм. Тэр үүднээсээ хандаж байгаа.

Түүнээс биш давж заалдах шатны шүүх шударга сайн ажиллах тухай асуудал биш. Хаана ч шударга бус байдал гарч болно. Механизмаараа энэ чинь шударга болох ёстой байхгүй юу. Бүх л дүнгээрээ. Тэгэхээр энэ утгаараа бол би энэ дээр хэлж байгаа. Тэр дээд шүүхийн гишүүдийн тоо ярьж байгаа. Хорин дөрвөөс хэтрүүлэхгүй байх нь бидний хувьд чухал. Ер нь цаашдаа багасгах ёстой. Онолын гэж яриад байгаа, онолын биш л дээ энэ чинь. Хууль хэрэглээний нэгдмэл байдал гэдэг нь Монгол улсад нэг хууль хэрэглэгдэнэ гэдэг чинь нэгдмэл шударга ёс тогтох байх юу даа. Нэгдмэл жишиг тогтох гэж байгаа юм. Энэ дээд шүүхийн чинь гол үүрэг нь улс оронд нэгдмэл нэг байдлаар л хандъя. Нэг бизнесмен, нэг том улс төрчид нэг намд, нэг өөр хүнд өөр өөр ханддагаа л больё гэж байгаа байхгүй юу. Хууль алагчлал гэдэг чинь шударга ёс байхгүй гэсэн үг. Дээд шүүх энэ үүргээ биелүүлье гэдэг ийм үүднээс энэ гуравхан юман дээр базах гээд байгаа юм. Түүнээс ажиллах боломж олгоё тэд маань хөөрхий бас ингээд одоо юм хумаа үзэж харж болохгүй байна гэдэг.../минут дуусав/

С.Бямбацогт: Алтанхуяг гишүүн ажлын хэсэг хариулчхаад дараа нь тодруулах уу Дэлгэрсайхан гишүүн. Алтанхуяг гишүүн ажлын хэсгийн гишүүн бас хариулъя нэмж.

Н.Алтанхуяг: Надад нэг их хариулах юм байхгүй. Би та нарт зовлон л хэлнэ ойлгов уу? Би энэ ажлын хэсэгт орж ажиллалаа, маш их ажилласан эд нар. Эд нар гэдгийг нь би хажууд нь суусан байхгүй юу, тасралтгүй. Их юм ойлгож авсан. Би ч бас заримдаа өөрийнхөө зүтгэж байсан, ингэх ёстой гэсэн ойлголтуудаасаа зарим нь ухарсан. Жишээ нь Ганбат, манай Ганбат дарга тэр сахилгын хорооны шийдвэр эцсийн байх ёстой гэдэг дээр би их хатуу байсан. Тэгээд сүүлдээ эд нартай ярьсаар байгаад за тэгвэл яах вэ аргаа барахад дээд шүүх дээр очоод анхан шатны журмаар нэг юм ярь. Тэгэхдээ та нар хэрэг маргаан ярихгүй, хууль зөв хэрэглэгдсэн эсэх тухай ярина. Тэгвэл сахилгын хороон дээр чинь шүүгчийн чинь харьцаа өөр байх ёстой шүү. Цөөнх болох ёстой шүү. Их нарийн юмнууд ярьдаг юм байна лээ.

Надад ганцхан хүсэл сонирхол бий. Тэр бол миний хувийн ч биш. Тэр бол Монгол улс жаахан шударга болмоор байна. Ялангуяа энэ шүүх. Дээд шүүх дээр яагаад тийм их харшил ингээд үүсчихсэн юм гэхээр яагаад надад ч гэсэн өнөөдөр ингээд их хар байгаа юм. Би одоо хар гэж хэлье тэгэхээр. Та нар найман жил дээд шүүхийг дампууруулсан байхгүй юу. Дандаа захиалгаар хэрэг шийдсэн байхгүй юу. Явсаар байгаад шүүгчид нь өөрсдөө хэрэг хахуульд ороод ингээд дууслаа шүү дээ. Энэ улс дууслаа, алга боллоо. Тийм учраас энэ дээр нэг нэгнийгээ ингээд буруутгаад байх юм байхгүй. Би хэллээ шүү дээ. Өглөө хүн ярих юм уу? Хууль ярих юм уу? Хуулиа ярьа л даа. Зөв боловсронгуй болгоё. Би тэгэхээр энэ дунд сууж байгаа хүмүүс их зовлон дундуур явдаг юм байна. Тэгээд яах вэ дээ, одоо тэр хорин дөрвийг чинь ингэсэн байхгүй юу. Ний нуугүй ярьж байгаад ажлын хэсэг. Хорин дөрвөөс дээш

гээд хорин дөрвийг чинь бүр бага болгоё гэж би бас санал гаргаж үзсэн юм. Тэгэхээр болдоггүй юм байна лээ. Тэгээд ядаж хорин дөрвөөс нэмэхгүй байхаар энэ удаа ойлгуулчихсан. Тоондоо биш механизмтай байна асуудал.

Тэгэхээр тэр нэг, хоёр, гурав гэдэг тэр гурваас өөр юмыг дээд шүүх рүү битгий өг л дөө. Дээд шүүх рүү өгөнгүүт чинь одоо дээд шүүхийн дарга, ерөнхий шүүгч, бусад бусад шүүгчид дээр алаан болно. Хэдийн болтол бид нар хүний төлөө тэнд өөрсдийн дараачийн эрх ашиг, амин хувийн юмны төлөө энэ улсаа сүйтгэх юм бэ? Үр хүүхдүүдээ сүйтгэх юм бэ. Тийм учраас би та нарт дотор нь сууж байгаа хүнд би хариулт өгч байгаа юм биш шүү. Зовлон л хэлж байна ийм. Тэр байтугай танхимгүй болох ёстой юм байна лээ яваандаа. Өнөөдөр тэрнийг хийж чадахгүй юм байна лээ. Тэгэхдээ өнөөдрийн энэ цаасан дээр биччихээд байгаа энэ их нарийн ширийн юмнуудыг бид нар рамаар нь зөв гаргачихвал том дэвшил болох юм байна лээ. Нэг Ерөнхийлөгч гарч ирээд л шүүхийг самраад байхгүй. Монгол улсыг самраад байхгүй. Тэгэхдээ би эртээд хэлсэн шүү. Одоо нэгнээс нь хайгаад нөгөөдөх рүү нь далдганаж гүйгээд Ерөнхий сайд дээр асар их эрх мэдэл очиж байгаа юм шүү. Энэ дахиад л буруу юм руу аваачих вий.

Ер нь эцсийн эцэст энэ улс орон, энэ шүүх, хууль хяналт, энэ хууль тогтоох, гүйцэтгэх гэдэг чинь баланс л юм байна лээ шүү дээ. Тэгээд хүнд найддаггүй, баланст л найдах ёстой механизмд л найдах ёстой. Энд нэг эрэг шурга эргэхэд гэхэд нөгөө талд нь тооромсолдог эрэг шураг нь байж байх ёстой. Ийм нарийн ухааны юм бол одоо би бараг сар гаруй сонссон доо. Тийм учраас би та нарт юм хариулаагүй шүү. Их зовлон дундуур явдаг юм байна. Их зовлон явж байна. Тэгэхдээ том дэвшил хийж байгаа юм шүү. Тэр сахилгын хороо, өмнө нь би бас практикаар харж байсан шүү дээ. Үгүй ээ наад шүүх чинь улаан цайм одон аваад хүний хэрэг шийдээд байна. Наадхаа сахилгын яам, сахилга биш ээ ёс зүйн хороонд өг гээд өгүүлж байсан. Шүүгчид нь өөрсдөө хуралдаад тэгээд нээрээ тэгсэн байна гэсэн чинь давж заалдаад шүүгчид нь шүүгчээ хамгаалаад шийдвэр гаргачихсан. Тийм учраас би сахилгын хороо эцэслэдэг байх ёстой гэж үзээд тэгээд болсонгүй. Тэгэхдээ болсонгүй ч гэсэн би тэрнийг шүүмжлэхгүй байгаа ажлын хэсэг дээр. Та нарын хийж байгаа энэ ийм байдлаар энэ удаа хийхэд өмнөхөөсөө хавьгүй дээр юм байна.

С.Бямбацогт: Дэлгэрсайхан гишүүн тодруулъя.

Б.Дэлгэрсайхан: Тэр дээд шүүх, энэ шүүх найман жил дампуурах дампуурсан гэж ярьж байна л даа. Тэр дампуурах үед чинь би Их Хуралд байгаагүй юм. Гудамжинд явж байсан юм. Бас энэ дампуурлаар шалгуулж явсан юм. Тийм учраас нэг их энд нэг их одоо намайг лоббидоод байна гэж андуураад эндүүрээд байх хэрэггүй байх хүмүүс. Ер нь энэ бас нэг тийм өнгө цухалзаад байна. Зарим нэг энэ ажлын хэсгийнхэн. Яагаад америкт ер нь энэ холбооны улс болгон дээд шүүхтэй байдаг юм. Тэр есөн шүүгч гээд байгаа чинь муж болгон дээд шүүхтэй. Тэр есөн

шүүгч чинь бол холбооны шүүх байхгүй юу. Тэр муж болгоны шүүхийн шийдвэрийг авчраад жилдээ нэг дунджийг нь олоод за та нарын яриад байгаа нөгөө их бага ял өгснийг чинь тэнцүүлээд хуулийг нэг хэрэглэнэ гэдэг юмыг чинь л гаргаж ярьдаг шүү дээ. Түүнтэй адилхан би сая асуулаа хариулсангүй шүү. Дээд шүүхийн тайлбар гэдэг юмыг чинь та нар энэ энэ хуульдаа оруулаад гаргуулдаг энэ нэг.../минут дуусав/

С.Бямбацогт: Дэлгэрсайхан гишүүн 1 минут.

Б.Дэлгэрсайхан: Энэ дээд шүүхийн тайлбар гэдгийг яагаад ингээд хуульд заагаад гаргуулах гээд байгаа юм бэ гэхлээр энэ хууль хяналтын байгууллагууд энэ хуулийг нэг мөр ойлгоод хэрэглэдэг ийм л болгож байж л саяын хэлээд байгаа зүйл чинь хуулийг хуульдаа байгаа юмаа, хүндээ биш болгох гэж хуульдаа болох гэж л энийг хэлж байгаа юм. Тэрнээс биш хүний тухай нэг ч яриагүй. Хуулийг бас хязгаартай, хуулиар хязгаарлаж өгье, ингэж өгье гэдгийг чинь зөв дэмжиж байна. Гэхдээ ямар ч иргэн, аж ахуйн нэгж тэгвэл одоо дээд шүүхэд гомдол гаргах эрхгүй байх юм уу, яах юм. Одоо гомдол гаргасан хүний гомдлыг авч хэлэлцэхгүй байх юм уу? Тэгвэл энийг хэлээд л дээ. Энэ шүүгч нарын үгийг сонсох ёстой шүү. Эд нарыг одоо давж ярилаа гэж Сүхбаатар гишүүн яриад байх шиг. Эд нарын үгийг сонсохгүй гэвэл өөр хэний үг сонсох юм. Бид нар ижилхэн шүү дээ. Бид нар бол онол ярьдаг улсууд шүү дээ. Үгүй ээ чи бол онол л ярина шүү дээ. Чи практик ярьж чадахгүй шүү дээ.

С.Бямбацогт: Гишүүдээ маргахгүй хоорондоо. Би Дэгийн тухай хууль уншаад сануулчихъя та бүхэнд. Захирамжаар бол дэд ажлын хэсэг, Байнгын хорооноос байгуулагдсан ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх үндсэн үүрэгтэй. Дэгийн тухай хуульд бол ингэж заасан байгаа. Арван гурвын арван дөрөв хууль, тогтоолын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон түүнчлэн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдон уригдаж ирсэн хүн хуралдаан даргалагчид зөвшөөрснөөр тайлбар хийж, асуултад хариулна. Дэгийн тухай хуулийн арван гурвын арван дөрөв. Хуралдаан даргалагчийн эрх, үүрэг гээд Дэгийн тухай хуулийн арван зургаад байж байгаа. Арван зургаагийн нэгийн тав энэ хуулийн арван гурвын арван дөрөвт заасан хүмүүст гишүүдийн асуултад хариулах тайлбар хийх зөвшөөрөл өгнө гээд. Тийм болохоор яриулна, сонсоно. Ажлын хэсэг дээр нэгдсэн ойлголтод хүрээд орж ирэх ёстой. Ёстой энд бид нар ярих ёстой, тийм. Яагаад гэвэл энэ парламент бол мэтгэлцэнэ, олон ургалч үзэл уралдуулна. Хамгийн гол нь ажлын хэсэг дээр нэгдсэн ойлголтод хүрсэн байх ёстой. Хэн хариулах вэ? Сая Дэлгэрсайхан гишүүний асуултад. Цогт шүүгч нэгдүгээрт, дараа нь Мөнхсайхан бэлдэж байгаарай. Нэгдүгээр микрофон.

Ц.Цогт: Энхбаяр гишүүнээ, тэр тайлбартай холбоотой асуудал дээр нэг нэмэлт тайлбар хийчихье. Тэгэхээр Дэлгэрсайхан гишүүнээ, адил би санал өгөхгүй гээгүй

байна. Энэ Энхбаяр гишүүнээ. Хууль тогтоох эрх нь бол Үндсэн хуулиар Улсын Их Хурлын гишүүдэд байгаа. Тэгэхээр та бүхэн маань.../үг тасрав/

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч тайван бай та. Та ганцаараа яадаг нь биш. Бид нар сонсоно. Олон талаас нь сонсоно. Олон талаас нь Их Хурлын гишүүд сонсож байж шийдвэрээ гаргана. Бид нар олон талаас нь сонсож байж шийдвэр гаргана. Гишүүд өөр өөрсдийн үзэл бодол байгаа.

Ц.Цогт: Тэр дээд шүүх тайлбар гаргадаг хэмжээ тэр хэвээрээ байгаа. Гэхдээ үндсэн.../үг тасрав/

С.Бямбацогт: Санал хураалтад оролцоогүй байна. Бид нар санал, байр суурь сонсож байна. Бид нар мэдээлэл авах эрхтэй гишүүд. Цогт шүүгч.

Ц.Цогт: Сая тэр Дэлгэрсайхан гишүүний асуусан асуулттай холбогдуулж л тайлбар хэлэх гэсэн юм. Тэр бол нөгөө дээд шүүх тайлбар гаргадаг Үндсэн хуулиар олгогдсон энэ эрх хэмжээ нь бол энэ хуулийн төслөөр бол тодорхой болж орж ирж байгаа. Тэр нь яаж тодорхой болж орж ирж байгаа вэ гэхээр хуучин цэцийн шийдвэрээр танхим хууль тайлбарлаж байгаа нь бол Үндсэн хууль зөрчиж байна. Яагаад гэвэл Үндсэн хуулиар улсын дээд шүүхийн тайлбарыг одоо ерөнхий шүүгч болоод нийт шүүгчдийн бүрэлдэхүүн дээр гаргана гэж ингэж зохицуулсан байна гэж үзсэн. Энэний дагуу бол шинэ төсөлд ажлын хэсэг ажиллаад тайлбарыг бол танхимын гаргасан саналыг үндэслээд улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцэж гаргана гэж ингэж зохицуулж оруулж ирсэн байгаа. Тийм учраас бол тайлбар гаргах эрх хэмжээ бол энэ хуулиар дээд шүүхэд бол хэвээрээ байгаа. Тийм тайлбарыг хэлэх гэсэн юм. Угаасаа Үндсэн хуульд зааснаар бол.../үг тасрав/

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Энхбаяр гишүүнээ чимээгүй байчих тэгэх үү? Сая та тэд ажлын хэсгээс бас бид мэдээлэл авч байна, сонсож байна, бас байр суурь. Хүрээгүй байна шүү дээ. Мөнх-Оргил гишүүн шал өөр юм яриад явж байна. Хууль зүйн сайд чинь шал өөр юм яриад явж байна. Эд нарыгаа хоорондоо ярь та нар наадахаа. Энэ ажлын хэсгийн Адьшаа гишүүн бас өөр юм яриад байж байна тэгээд. Нэгдсэн байр суурь чинь энэ байдаг юм уу тэгээд. Мөнхсайхан шүүгч юу багш, судлаач. 2 номерын, микрофон хоёр.

О.Мөнхсайхан: Энэ дээр Дэлгэрсайхан гишүүний асуулт дээр тайлбар хэлье. Засгийн газрын өргөн барьсан төсөл, бас ажлын хэсгийн саналаар бол хууль шүүхийн шийдвэр, шүүхийн практикт үндэслэн хуулийн тайлбар гаргах энэ Үндсэн хуулийн одоо дээд шүүхийн чиг үүрэг бол яг процессжоод орчихсон байгаа. Түрүүн Цогт шүүгч хэллээ. Тэгэхээр тэр практик дээр тулгуурласан тэр тайлбар бол гараад хэвлэгдээд явах зохицуулалт бол нэлээн сайн орчихсон учраас энэ бол цаашдаа бас үр дагавраа

гаргах байх. Хоёрдугаарт Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургаагийн арван дөрөвт бол иргэний шүүхтэй холбоотой эрхүүдийг заасан. Шүүхэд гомдол гаргах эрх, шударгаар шүүлгэх эрх, тэгээд шүүхийн шийдвэр давж заалдах эрх гээд ингээд заасан байгаа юм. Тэгэхээр энэ маань бол ер нь шүүхэд гомдол гаргах эрх бол анхан шатны журмаар тэр гомдол гаргаж байгааг бол энэ эрх нь хангагдаж байгаа гэж тооцдог.

Тэр анхан шатны шүүхийн үйл баримтын тухай, эсвэл хууль хэрэглээтэй холбоотой асуудал дээр буруу зөрүү шийдлээ гэж иргэн үзэх юм бол давж заалдах эрхтэй. Энэ эрх нь бол давж заалдах шатны шүүхэд гаргаснаар бол хангагддаг. Өөрөөр хэлбэл анхан шатны журмаар шийдсэн тэр шийдвэрийг өөр бүрэлдэхүүнээр нэг хянуулаад эцэслэдэг. Энэ бол Үндсэн хуулийн давж заалдах эрхийг бүрэн хангаж байгаа юм. Иргэний болон улс төрийн тухай олон улсын фактын бас давж заалдах эрхийн агуулга яг энэ агуулгаар явдаг. Өөрөөр хэлбэл нэг өөр бүрэлдэхүүнээр шийдүүлнэ гээд. Дээд шүүх бол зөвхөн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдсэн дээр давж заалдах эрхийг хангана. Энэнээс бусад тохиолдолд бол давж заалдах одоо эрхийг хангадаг газар бол дээд шүүх ерөөсөө биш байгаа юм. Манай Үндсэн хуулиар ч тэр, олон улсын одоо энэ сайн туршлагаар тэр. Тэгэхээр дээд шүүх бол яг энэ ажлын хэсгийн гаргаж ирж байгаа гол зарчим бол ерөөсөө хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуулийн тайлбарын хамгийн маргаантай тэр асуудлыг өөр өөр шүүхүүд ялгаатай шийдээд зөрчилдөөд байгаа, хууль шүүхийн өмнө эрх тэгш байна гээд Үндсэн хуулийн арван дөрвийн нэгд заасан тэр байдал хангагдахгүй, хууль нэг байхад өөр өөрөөр тайлбарлагдаж хэрэглээд байгаа тэр ноцтой асуудал дээр дээд шүүх төвлөрч, одоо хэрэг маргаан шийдэхээр энэ ажлын хэсгийн саналын хорин тавын зургаагийн тав гээд энэ юугаар ингэж хашиж орж ирж байгаа гэж ойлгож байгаа юм. Тэгэхээр иргэний тэр шүүхэд гомдол гаргах, давж заалдах эрх бол энүүгээр зөрчигдөхгүй гэж харж байгаа.

Хоёрдугаарт улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн байна гэдэг бол тухайн хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахтай холбоотой тэр шийдвэрүүд нь эцсийн байх тухай гэж ойлгож байгаа. Түүнээс дээд шүүхээ бол Монгол улсад явж байгаа энэ хэдэн мянган маргаан руу хүссэнээрээ ордог явж ирсэн. Тэгэхдээ мэдээж бол сая түрүүн гишүүн хэлж байна. Нийт маргааны гурван хувь гэж байгаа боловч энэний цаана юу байна вэ гэхээр хамгийн ноцтой нь бүр хүссэн юм руугаа ордог ийм үзэмжийн дур зоргын шинжтэй байдлаар хэрэгжиж ирсэн нь одоогийн асуудлыг үүсгэхдээ байгаа юм. Тэгэхээр зөвхөн хууль хэрэглээнийхээ юм руугаа дээд шүүх нь орох. Фактын юм руу бол ерөөсөө орж болохгүй гэдэг энэ Үндсэн хуулийн зарчим бол энэ одоо ажлын хэсгийн саналаар орж ирж байгаа гэж ойлгож байгаа.

С.Бямбацогт: Хангалттай ярьсан. Дэлгэрсайхан гишүүн одоо болно оо. Одоо жаахан тайван байцгаана гишүүдээ. Жоохон төвлөрнө тийм. Хувийн эмоци гаргахгүй. Одоо удахгүй гучин хоолоо иднэ. Манай Байнгын хороо арван долоон гишүүн

хуралдаж байгаа шүү дээ. Арван есөн гишүүнтэй, арван есөн гишүүнээс арван долоон гишүүн хуралдаа маш ирц өндөртэй орж байгаа. Учрал гишүүн өвчтэй байгаа. Раднаасэд гишүүн чөлөө авсан. Бусад гишүүд зуун хувийн ирцтэй үндсэндээ хуралдаа оролцож байна. Маш чухал хууль учраас ач холбогдол өгч, маш гишүүд маань хариуцлагатай хандаж байна. Ажлын хэсэг, дэд ажлын хэсэг бас ч гэсэн бас хариуцлагатай хандаж байгаа. Гишүүд, Нямбаатар гишүүн, Сүхбаатар гишүүн, ажлын хэсгийн ахлагч Энхбаяр гишүүн суугаарай наашаа. Санал хураалт явуулна. Саналаа хураацгаая. Гишүүд асуултаа асууж, хариулт тавьж дууссан. Олон талаас нь одоо хариултууд өглөө. Санал хураалт, асуулт асууж дууссан. Хорин тавдугаар зүйлтэй холбоотой асуулт асуусан. Санал хураалт явуулъя. Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье.

16 тэр саналыг хасаад уншина. Ижил саналыг. Төслийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “зэрэг” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 25.3 дахь хэсэг нэмж, 25.4 дэх хэсгийн “шүүгч” гэснийг “Ерөнхий шүүгч, шүүгч” гэж өөрчилж, 25.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 25.6, 25.7 дахь хэсэг болгох:

“25.3.Улсын дээд шүүх нь давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан үзэх замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангана.”

“25.6.Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.6.1.хуулиар тусгайлан харьяалуулсан тохиолдолд хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;

25.6.2.энэ хуулийн 25.6.1-д заасан болон хуульд заасан үндэслэл, журмын дагуу давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэсэн хэргийг давж заалдах журмаар хянан хэлэлцэх;

25.6.3.хуульд заасан үндэслэлээр Улсын дээд шүүхийн танхимын шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд шүүх бүрэлдэхүүнийг томилох;

25.6.4.хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох;

25.6.5.Улсын дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор давж заалдах шатны шүүхийн магадлалыг дараах тохиолдолд хяналтын журмаар хянан шийдвэрлэх:

25.6.5.1.анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;

25.6.5.2.хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;

25.6.5.3.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил

гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн. Дэлгэрсайхан гишүүнээ суугаарай. Санал хураалт.

25.7.Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагаанаас бусад асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.7.1.хуульд тусгайлан заасан тохиолдолд Улсын дээд шүүхэд хэрэг, маргааны төрлөөр дагнасан танхим байгуулах, бүрэлдэхүүнийг батлах;

25.7.2.давж заалдах шатны шүүхэд шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнасан танхим байгуулах асуудлыг тухайн шүүхийн Зөвлөгөөний саналыг үндэслэн хэлэлцэж, шийдвэрлэх;

25.7.3.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон шүүхийн үйл ажиллагаа, эрх зүйн байдалтай холбогдсон хууль тогтоомжийн төсөлд саналаа хууль санаачлагчид хүргүүлэх, бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлагчид уламжлах;

25.7.4.шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын *Үндсэн хуулиас* бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг танхимын саналыг үндэслэн гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх;

25.7.5.хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх;

25.7.6.энэ хуулийн 75.2-т заасан Ерөнхий зөвлөлийн саналын дагуу, эсхүл энэ хуулийн 7.4-т заасан саналыг хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах;

25.7.7.Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх, эгүүлэн татах хуульд заасан үндэслэл бий болсноос хойш 30 хоногийн дотор санал гаргах;

25.7.8.хуульд заасан бусад бүрэн эрх.” Санал гаргасан ажлын хэсэг. Энхбаяр, Сүхбаатар, Мөнх-Оргил, Адъяа, Сандаг-Очир. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад арван долоон гишүүн оролцсоноос арван дөрвөн гишүүн буюу наян хоёр аравны дөрвөн хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Уучлаарай Алтанхуяг гишүүн ажлын хэсгийн уучлаарай.

Нямбаатар гишүүний гаргасан санал байгаа. Төслийн хорин тавын гурав дахь хэсгийн доошгүй гэснийг хасах. Ажлын хэсэг бол дээшгүй гэсэн санал байгаа. Тэгэхээр тийм, тэгээд үндсэндээ бол дээшгүйг хасаад, бишээ тийм байна. Тэгэхээр энэ чинь доошгүйг хасчих юм бол хорин дөрвөөр үлдэх юм байна, тийм үү. Ажлын хэсэг бол дээшгүй байя гэсэн юм байна шүү дээ. Нямбаатар гишүүн саналаа тайлбарлаж үг хэлье. Ер нь хорин дөрвөн больё гэсэн үг байна шүү дээ. 25 Нямбаатар гишүүн. Яг болчих юм биш үү энэ чинь.

Х.Нямбаатар: Энэ ерөөсөө нэг ийм байгаа юм хэдүүлээ гишүүдээ. Энэ нөгөө шүүхийн тухай хууль дээр хэдүүлээ их тал талаасаа ойлголцож, энэ парламент гэдэг бол бие биетэйгээ ойлголцож олонхынхоо шийдвэрийг л хүндэтгэхийн нэр. Тэгээд энэ дээр дээшгүй гэхээр доошоогоо хэд ч байж болох гээд байгаа юм. Гурван гишүүнтэй ч байлгаж болчих гээд байгаа юм. Хоёрт махан тоо тавихгүй бол ямар асуудал гардаг вэ гэхээр улс төрд шийдвэр гаргаж байгаа олонх өөрсдөдөө таалагдаагүй дээд шүүхийн шүүгч нарыг орон тооны цомхотголд оруулахын тулд

тоог нь доош нь татаж шүүх байгуулах хуулиараа багасгачих бас эрсдэл байгаа. Энэ хоёр мянга арван гурван онд гарч байсан зүйл. Энэ өмнө нь ч бас гарч байсан хэд хэдэн удаа шүүхийн тухай хууль байгуулахад улсын дээд шүүхийн тоо маш олон удаа дээш доошоо савласан юм.

Тийм учраас ерөөсөө тогтсон ийм тоотой байя. Тэгээд гурван танхимд байгаа гэдэг юм. Зарим нь энэ дээд шүүхийн гишүүдийн тоог их гэж үзэж ярьж байгаа энэ хүн болгоны л үзэл бодол. Өнөөдөр улсын дээд шүүх нийт шүүхээр шийтгэгдэж байгаа хэргийн гурван хувийг чадан ядан шийдэж байгаа гурван хувийг. Түрүүн бас тэр холбооны төрийн байгууламжийн хувьд холбооны тийм улс орнуудын жишээ энэ тэрийг татаж байна лээ. Бид бол нэгдмэл тогтолцоотой улс орон. Хоёр гэвэл өнөөдөр дээд шүүх, иргэний танхим гэхэд бараг гурван мянган хэрэгтэй жилдээ ингээд овоорчихсон, тунарчихсан байгаа. Өнөөдрийн энэ шүүхийн тухай хууль ингээд бидний ярьж байгаа энэ концепцоор батлагдвал одоо урьдчилан харж байгаагаар нийт хэрэг маргааны нэг хувийг шийдэхээр байгаа нэг хувийг. Өөрөөр хэлбэл иргэний танхим одоо жилдээ мянга орчим хэрэг шийднэ ч гэдэг юм уу, ийм хийсвэр төсөөллүүдийг бид нар бас гаргаж ирсэн юм.

Тэгэхээр энэ дээр ийм нэг тогтсон тоотой. Дээшээ ч үгүй, доошоо ч үгүй яг хорин дөрөв байна. Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч нь танхим харгалзахгүй байя. Яагаад гэвэл энэ Үндсэн хуулийн тавьдугаар зүйлд заасан улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч улсын дээд шүүхийн өөрийнх нь чиг үүргийг харахаар улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, дээд шүүхийн шүүгчдээс бүрдэнэ л гэж байгаа юм. Тэрнээс биш улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч нь аль нэг танхимдаа харгалзаж хэрэг маргааныг шийднэ, эсхүл тааллаараа өөрийнхөө дуртай танхимд орж хэрэг шийднэ гэсэн ямар ч тийм одоо логик гарч ирэхгүй. Сая бид нар энэ хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ нөгөө гомдол хүсэлт гаргасан нэхэмжлэл гаргасан хүмүүсийн одоо автомат уналтаар хүсэлтээр хэргийн харьяалалд шийдэгддэг хуваарилагддаг энэ автомат хэргийн хуваарилалтын тохиргоо орж ирнэ. Тийм учраас ерөнхий шүүгчид тийм давуу байдал үүсгэхгүй. Тэгэхээр энийгээ би ийм хоёр саналыг ингээд та бүхнийг дэмжээд өгөөч гэсэн ийм саналыг гаргаж байна.

С.Бямбацогт: Болно, болно. Би тайлбарлаад өгчихье Пүрэвдорж гишүүнээ. Дэг байхгүй. Тийм дэгийн хууль байхгүй. Одоо ингээд бүх зүйл дээр яриад байдаг. Тэгээд ийм байгаа юм. Ажлын хэсэг бол төсөл өргөн барьсан төслөөр бол хорин таваас доошгүй гэж байсан. Хорин дөрвөөс доошгүй. Ажлын хэсгийг бол хорин дөрвөөс дээшгүй болгож төсөл оруулж ирсэн. Ажлын хэсэг. Нямбаатар гишүүн бол төслийн тийм доошгүй гэснийг хасчихъя гэж байгаа юм. Тэгээд ажлын хэсгийн санал хэрэв дэмжигдэхгүй уначихвал Нямбаатар гишүүний санал босож байгаа буюу хорин дөрөв гэдэг тийм үү хорин дөрвөөс дээшгүй доошгүй. Хорин дөрөв гэсэн яг шууд утгаараа энэ тоо үлдэх юм махан тоо. Ерөнхий шүүгчдээ хорин тав тийм. Ингэж ойлгоод гишүүд маань саналаа орж болж байна уу? Тэгээд ажлын хэсгийн санал уначихвал үндсэндээ хорин тав гэсэн яг тоо л үлдэнэ. Доошгүй дээшгүй гэж үг байхгүй болно. Болж байна уу? Тэгвэл ингэж ойлголцоод санал хураалт. Дэмжье гэсэн Нямбаатар биш, ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураагдана. Гэхдээ уначихвал хорин тав гэсэн тоо л үлдэнэ гэж ойлгоод.

Төслийн хорин тавын гурав дахь хэсгийн доошгүй гэснийг биш ээ, ажлын

хэсгийг уншина тийм. 25.3 дахь хэсгийн доошгүй гэснийг дээшгүй гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. санал хураалтад арван долоон гишүүн оролцсоноос таван гишүүн буюу хорин ес аравны дөрвөн хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй. Өөрөөр хэлэх юм бол хорин тав гэсэн тоо үлдлээ. Ингэж ойлгож болно. Тодорхой болсон. Дээшгүй доошгүй гэж үг хасагдлаа. Тийм нэг л тоо. Хорин дөрөв гэсэн. Дараагийн санал. 25.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 2 дахь өгүүлбэр нэмэх:

Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч нь бол дээд шүүхийн шүүн таслах ажиллагаанд танхим харгалзахгүй оролцох гэсэн өгүүлбэр нэмье гэж байгаа юм байна. Ажлын хэсэг бол хорин тавын дөрөв дэх хэсгийн шүүгч гэснийг ерөнхий шүүгч шүүгч гэж тус тус өөрчлөх. Энд болохоор аль нэг танхимд харьяалагдана гэсэн агуулгаар орж ирж байгаа хорин таван дөрөв дээр. Энэ саналаа тайлбарлах уу, ажлын хэсэг саналаа тайлбарлахгүй юу. Тэгвэл санал ажлын хэсгийн саналаар санал хураалт явууллаа. Ажлын хэсэгт тайлбарлахгүй юу? Ийм байгаа юм. Хорин тавын дөрөв дээр улсын дээд шүүхийн шүүгч энэ хуулийн хорин тавын хоёрт заасан танхимын аль нэгт харьяалагдана гэж төслөөр орж ирсэн. Үүнийг ажлын хэсэг өөрчлөхдөө Адьшаа гишүүн, Энхбаяр гишүүн нарын одоо ажлын хэсэг өөрчлөхдөө Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, шүүгч энэ хуулийн хорин тавын хоёрт заасан танхимын аль нэгд харьяалагдаж өөрчилж оруулж ирсэн. Нямбаатар гишүүн санал гаргахдаа Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч нь улсын дээд шүүхийн шүүн таслах ажиллагаанд танхим харгалзахгүй оролцоно гэсэн санал гаргаж байна. Нямбаатар гишүүн тайлбар хийе.

Х.Нямбаатар: Хэдүүлээ юу яая. Энэ ерөөсөө улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч өөрийн одоо тааллаараа аль нэг танхимд харьяалагдаад юм уу, аль нэг ач холбогдолтой давуу байдал үүсгэсэн энэ хэрэг дээр хуваарилагдаж орно гэсэн ойлголтыг бид нар өмнө нь сая хураасан санал хураалтаар хаачихсан. Өөрөөр хэлбэл хэргийг хуваарилахдаа энэ хүний оролцоогүйгээр цахим байдлаар хуваарилдаг энэ юуг сая бид нар ажлын хэсэг дээр баталчихсан. Хоёр гэвэл улсын дээд шүүх одоогоор гурван танхимтай байгаа. Сая энэ төсөл дээр бид нар улсын дээд шүүхэд танхим байгуулах эрхийг нь сая нээгээд өгчихсөн. Дээд шүүхийн ерөнхий шүүгч зөвхөн нэг танхимд харьяалагдаж байгаа тохиолдолд наад саяын хүмүүсийн гаргаад байгаа тийм хардалт сэрдэлтийн асуудал ерөөсөө гарч ирэхгүй. Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар 4 дэх үед хэрэг маргааныг шийддэг энэ зохицуулалтыг байхгүй болгосон тийм ээ. Энэ саяын ажлын хэсгийн оруулж ирсэн саналаар. Улсын дээд шүүх дараах хэдэн асуудал шийдэх гэж байгаа нийт шүүгчийн хуралдаанаар. 1 дүгээрт улс төрийн намын харьяалалтай холбоотой бүртгэлтэй холбоотой асуудлыг би одоо зарчмын зөрүүтэй саналаар дараагийнх дээр нь хураалгах гэж байгаа юм.

2 дугаарт нь албан ёсны норматив тайлбар гаргах эрхийг нийт шүүгчдийн хуралдаан шийдэх гэж байгаа. Бусад тохиолдолд энэ нөгөө Үндсэн хуульд заасан танхимын зарчмаар хэрэг маргааныг тус тусдаа 3 дээд шүүх шийднэ л гэсэн үг. Ерөнхий шүүгч энэ 3-н аль нэгэнд тохиолдлын журмаар тэр компьютерын уналтаар хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож явна гэсэн үг. Тэгэхгүй бол улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч зөвхөн эрүүгийн танхимын шүүгчээр ажиллана.

Бусад хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохгүй гэвэл энэ маань өөрөө Үндсэн хуулийнхаа энэ 50 дугаар зүйлд заасан зарчимтайгаа зөрчилдөж эхэлнэ гэдгийг л та бүхэн бод. Тэрнээс биш хэн нэгэнд давуу байдалд үүсгэх гэж байгаа тухай ойлголт байхгүй.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Энхбаяр гишүүн саналаа тайлбарлая.

Б.Энхбаяр: Баярлалаа. Би энэ ажлын хэсгийнхээ саналыг зөвтгөж тайлбарлах гэж байгаа юм. Ерөнхий шүүгч нь аль нэг танхимдаа л харьяалагдаг. Энэ бүх юмыг мэддэг бурхан багш биш. Яах гэж бид танхим байгуулж байгаа юм бэ, яах гэж шүүх таслах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлж шүүхүүдийг байгуулах тухай яриад байна вэ? Өнөөдрийн бидний харж байгаагаас энэ хууль зүйн салбар бол дахиад цаашаа мэргэшнэ. Шүүхүүд маань дагнаж байгуулагдана. Эрүүгийн шүүх байгуулагдана. Компанийн арилжааны шүүхэд байгуулагдана. Зөвхөн гэрээний маргаан шийдвэрлэдэг шүүхүүд ч байгуулагдана цаашдаа ирээдүйд.

Тэгэхээр энэ шүүгч маань эрүүгээ ч мэддэг, захиргаагаа ч мэддэг, иргэнээ ч мэддэг ийм универсал одоо байж 1 дүгээрт чадахгүй. 2 дугаарт урд нь гарсан тохиолдол байгаа шүү дээ. Дээд шүүхийн ерөнхий шүүгч нь Зоригийн хэрэг дээр өөрөө ороод хурлаа даргалаад шийдсэн. Тэгээд ийм хонгил үүсээд дурай хэрэг маргаанаа үзэмжээрээ шийддэг ийм эрх мэдлийг ерөнхий шүүгч төвлөрүүлж болохгүй гээд энэ талбай дээр хэдэн мянгуулаа жагсаад байсан санагдаад байх юм. Энэ манлайлагч дотор Нямбаатар сайд өөрөө байж л байсан биз дээ. Үгүй тэгээд яагаад ерөнхий шүүгчид одоо ийм хязгааргүй эрх мэдэл өгөх юм санал гаргаад байгаа юм бэ? Тийм учраас би ажлын хэсгийн саналыг бол дэмжиж өгөөч гэж гишүүдээсээ хүсье.

С.Бямбацогт: Санал хураалт явуулах уу, ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулна. Ажлын хэсгийн санал дэмжигдвэл ажлын хэсгийн саналаар дэмжигдэхгүй бол Нямбаатар гишүүний саналаар томьёологдоно. Зөв биз. Сая тэр тоон дээр бас нэг дэгийн зөрчил гарч байна гэж асуулт асуулаа анхаараарай. Санал хураалт. Би дахиад томьёоллыг танилцуулъя. 25.4 дэх хэсгийн, Төслийн 25.4 дэх хэсгийн шүүгч гэснийг ерөнхий шүүгч, шүүгч гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Энхбаяр, Адьшаа, Мөнх-Оргил, Алтанхуяг, Сүхбаатар, Сандаг-Очир. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцсоноос 11 гишүүн Ганбат гишүүн 12 гишүүн дэмжлээ.

Одоо тэгэхээр Нямбаатар гишүүний төслийн 25.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 2 дахь өгүүлбэр нэмэх. Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч нь улсын дээд шүүхийн шүүн таслах ажиллагаанд тэнхим оролцоно гэсэн санал дэмжигдсэнгүй. Зөв үү. Дараагийн санал.

25.6 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 25.6.11 дэх заалт нэмэх. 25.7.8.Улс төрийн намын бүртгэл хөтлөх гэсэн ийм заалтыг нэмье гэсэн улсын дээд шүүхэд харьяалал. Нямбаатар гишүүн санал гаргасан байна. Нямбаатар гишүүн саналаа тайлбарлая.

Х.Нямбаатар: Одоо улсын дээд шүүх улс төрийн намыг бүртгэж байгаа дүрмийн өөрчлөлтийг бүртгэж байгаа. Ингэхдээ улсын дээд шүүхийн иргэний танхим дээр энэ хэрэг харьяалагдаж байгаа. Өөрөөр хэлбэл бүртгэл. Ер нь бол юу хэлэх гэсэн бэ гэвэл олон намын тогтолцоо бол энэ Монгол Улсад ардчилал түүний үнэт зүйл орших үндсэн баталгаа. Аль болох энэ улс төрийн намуудыг улс төрийн зорилгоор нэр усыг нь өөрчилдөг жижиглэдэг хагалдаг бутаргадаг магадгүй бүртгэхгүй байх гэдэг бол өөрөө ардчиллын үнэт зүйлд халтай. Тийм учраас улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар улсын дээд шүүхийн улс төрийн намуудыг бүртгэдэг болъё.

2028 оноос эхлээд улс төрийн намуудын тухай хууль шинэ Үндсэн хуулийн өөрчлөлтийн дагуу өөрчлөлт орж бүртгэгдэж явна. Тэгэхээр энэ саналыг та бүхэн дэмжиж өгөөч. Илүү их олуулаад шийдэж байж хараат бус байдлаар улс төрийн нөлөөлөл хань хамаарал багатай байдлаар энэ шийдвэрийг гаргаж бүртгэж авна гэсэн ийм зүйл байгаа юм. Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан бол улс төрийн намын бүртгэл хийнэ. Одоо энэ хуулиар мөн дээд шүүхийн тайлбар хийнэ. Мөн дээр нь нэмээд улсын дээд шүүхийн томилгоонуудыг хийдэг ийм том чиг үүргүүд ингээд өргөжиж нэмэгдэж байгаа гэдгийг бас давхар хэлье. Тэгэхээр энэ дээр та бүхэн дэмжиж өгөөрэй.

С.Бямбацогт: Нямбаатар гишүүн саналаа тайлбарлаж хэллээ сая. 25.6 дахь хэсэг. 25.7.8-д улс төрийн намын бүртгэл хөтлөх санал гаргасан Нямбаатар гишүүн. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Биш. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 14 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Ганбат гишүүн дэмжсэн гэж байна шүү. Дэмжигдээгүй санал гээд орох юм байна.

Мөнх-Оргил, Нямбаатар нарын гишүүд саналын томъёоллын 16-д доор дурдсан санал гаргах. 25.6.5.4.хуулийн нэгдмэл хэрэглээг тогтооход зарчмын ач холбогдолтой бол гэсэн дээд заалт нэмэх. Нямбаатар, Мөнх-Оргил нарын гишүүд гаргаж байна. 25.6.5.4 нөгөө дээд шүүхийн хяналтын журмаар гомдолтой холбоотой. 25.6.5 чинь ийм байгаа шүү дээ. Улсын дээд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор давж заалдах шатны шүүхийн магадлалыг дараах тохиолдолд хяналтын журмаар хянан шийдвэрлэнэ гээд 3 тохиолдол бичсэн байгаа.

Анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, 2 дугаарт нь хуулийг улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн бол, 3 дугаарт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны

ноцтой зөрчил гаргасан шүүхийн шийдвэрт нөлөөлсөн бол гэсэн 3 тохиолдолд хяналтын журмаар хянан шийдвэрлэнэ гэсэн. Үүн дээр нэмээд Мөнх-Оргил, Нямбаатар гишүүд 25.6.5.4-т хуулийн нэгдмэл хэрэглээг тогтооход зарчмын ач холбогдолтой бол гэсэн дэд заалт нэмье гэсэн санал гаргаж байна. Ойлгомжтой юу тийм ээ. Мөнх-Оргил гишүүн саналаа тайлбарлая.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ байна шүү дээ гишүүдээ ийм юм. Бид нар энэ хуулиар маш том өөрчлөлт оруулж байгаа реформын шинж чанартай нь бол энэ улсын дээд шүүх зөвхөн хуулийн хэрэглээний нэгдмэл байдлыг хангах болзлыг тавьж өгч байгаа юм. Өөрөөр хэлбэл асуудал цөөхөн шийдэгдэнэ гэж тооцож байгаа юм. Анхан болон давж шатны шүүхийн шийдвэрүүдийн ач холбогдол эрс нэмэгдэнэ гэж тооцож байгаа юм.

Ингээд дээд шүүх дээр ямар асуудлууд очих вэ гээд дээд шүүх ямар асуудлыг өөрөө авах эрх нь үүсэж байна вэ гэхээр саяын 3 нөхцөлийг хэлж байгаа юм. 3 нөхцөл. Гэхдээ би энд юм дээр ажлын хэсэг дээр ч гэсэн сая Энхбаяр ажлын хэсгийн даргын тайлбар дээр ч гэсэн санал нийлэхгүй нэг юм байгаа юм. Хаана ч байна шүү дээ дээд шүүх ямар асуудлыг авч хэлэлцэх вэ гэдгээ өөрөө мэддэг эрх байгаа. Ямар ч улсын дээд шүүх хуулийн хэрэглээ зөрчигдсөн байна нэгдмэл хэрэглээ алдагдсан байна гэж үзвэл энийг нь бол авч хэлэлцэх хэрэггүй юм байна, шаардлагагүй юм байна гээд буцаачихдаг. Энийг бол авч хэлэлцэх хэрэгтэй юм байна гээд өөрөө мэддэг эрх нь үлдэх хэрэгтэй. Өөрөө мэдэх эрх нь үлдэх хэрэгтэй.

Тэгээд энэ эрх мэдэл үлдлээ гээд дээд шүүхийн саяын Энхбаяр гишүүний тайлбарлаад шиг дээд шүүхийн юм уу Ерөнхий шүүгчийг эрх мэдэл асар их нэмэгдэх зүй гарахгүй. Яагаад вэ гэвэл энэ чинь угаасаа гомдлоор орж ирнэ. Хяналтаар энийг хэлэлцээд өгөөч гээд гомдол ирнэ. 2 дугаарт тэнд бол дээд шүүхийн нөгөө дэг журмаар процессоороо яваад хуулийн хэрэглээний нэгдмэл байдалд үнэхээр ноцтой ач холбогдолтой юм байна гэдгээ тогтоосон байхад энийг асуудлыг хэлэлцээд явчихад бол ерөөсөө асуудал байхгүй.

Тэгэхгүй бол юу үүсэх вэ гэхээр энэ 3 эхний бидний тавьсан 3 хязгаарт аль алинд нь ороогүй боловч магадгүй энэ хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад ач холбогдолтой асуудлууд цаана нь үлдчихэж магадгүй байхгүй юу. Тэгэхээр яах вэ тэр дээд шүүх алдаатай ажилласан одоо олны бухимдлыг төрүүлсэн миний ч гэсэн бухимдлыг төрүүлж байгаа тэр бол байгаа. Тэрийг бол бид нар ойлгож байгаа. Гэхдээ дээд шүүхээ бас дандаа тийм байна. Эсхүл дандаа тийм байгаа гэж бид нар бас бодож энэ хуулийг баталж болохгүй. Ерөнхий структур суурийг нь тавьж өгөх л асуудал ярьж байна шүү дээ.

Тэр утгаар нь бол энийг дэмжээд өгөөч. Энэ дээр бол ямар нэгэн лоббины асуудал байхгүй шүү. Бид нар хэчнээн хууль батлах эрх бидэнд байгаа ч гэсэн бид

бол энэ төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа 3 салбарын нэг шүү. Би биедээ адилхан хүндэтгэлтэй хандаж бие биеийнхээ саналыг бас сонсох асуудал байгаа. Гэхдээ энийг би заавал дээд шүүхийн саналаар оруулж ирж байгаа юм биш. Би сая Энхбаяр гишүүний хэлэхээр ингээд интернэтээр ухаад сууж байна. Энэ дээр чинь бас сая Америк харлаа, Энэтхэг харлаа, Орос харлаа. Өөрөө асуудлыг авах уу үгүй юу гэдгээ эрх байхгүй бол дээд шүүх байж болохгүй. Тэр хэмжээний итгэлийг бид нар дээд шүүхдээ үзүүлж болно шүү дээ.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Энхбаяр гишүүн тайлбар хэлье саналаа.

Б.Энхбаяр: Баярлалаа. Энэ ер нь энэ хуулийн 50 хувьтай дүйх шинэтгэлийн илэрхийлж байгаа асуудлыг ярьж байгаа юм. Одоо ямар байгаа юм бэ гэдгийг би нэг товчхон хэлье. Одоо эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар Монгол улсын дээд шүүх 2 тохиолдолд хэрэг маргааныг хяналтын журмаар шийдвэрлэнэ гэж байгаа юм. 2 үндэслэлээр шүү. Бид 3 болгоод ороод орсон байгаа шүү ажлын хэсэг. Одоо ч дээд шүүх ийм эрхгүй. Гэтэл бүгдийг нь шийдэж байгаа. Одоо оруулах гэж байгаа гишүүдийн гаргаж байгаа санал бол бүр ноцтой гэж би хэлнэ.

Яагаад зарчмын ач холбогдолтой гэж үзвэл гэж ер нь яг юу гэсэн үг вэ? Энэ нэгдмэл байдлаар ойлгогдож тайлбарлагддаг үг мөн үү эсхүл улс төрийн үг үү. Энэ хуулийн лав их дээд сургуульд зарчмын ач холбогдолтой нь энэ, зарчмын ач холбогдолгүй нь энэ гэж заадаг юм би мэдэхгүй юм байна. Шүүхээр хэлэлцэгдэж байгаа бүх асуудал тэгвэл ач холбогдолтой л асуудал шүү дээ. Зарчмын. Шүүх одоо зарчмын ач холбогдолгүй асуудал хэлэлцдэг юм уу. Энэ одоо би шуудхан хэлэхэд онолын хувьд ч тэр улс төрийн хувьд хууль зүйн хувьд энийг би тайлбарлаж би хэлж чадахгүй байгаад байгаа байхгүй юу.

Ийм том уутыг одоо хуульд ч байдаггүй. Бид хонгил нураах тухай ярьж байсан. Одоо бид хонгилыг бүр энэ 4 үгийн цаана одоо юу нээж өгөх гэж байна вэ. Бүр үзэмжээрээ шийддэг, дур зоргоороо шийддэг. Ийм том хонгилыг өгөх гэж байна. Тэгэхээр энэ бол болохгүй. Энэ дээрээ хэдүүлээ шалгалтаа өгье гэж хэлэх гэж байна.

С.Бямбацогт: Цогт шүүгчээс би бас тодруулга асууя. Энэ дээр ямар байр суурьтай байна вэ? 1 дүгээр микрофон. Дараа нь Мөнхсайхан багш бас бэлдэж байгаарай.

Ц.Цогт: Энэ улсын дээд шүүхийн хэрэг нэхэмжлэл хүлээж авах энэ шалгууртай холбоотой асуудал дээр гишүүд болгоомжтой хандаж байгааг бол бас ойлгож байна. Ялангуяа ажлын хэсгийн ахлагчийн хэлж байгаа тайлбараар нэг талаас. Нөгөө талаас энэ эрх зүйн соёл хэр тогтсон байгаа юм бэ гэдгээс энэ асуудал шалгагдах байх л даа. Тэрнээс бид нар өнөөдөр дээд шүүх хэрэгтэй хэргээ сонгож аваад ач

холбогдолтой хэргээ шийдэх гээд байна тийм агуулгаар ийм заалт орж ирэх гэж байна гэж үзэхгүй байна. Ер нь бол.

Энэ яг томьёоллын хувьд бол хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад зарчмын ач холбогдолтой гэж ийм томьёолол байгаа л даа. Тэгэхээр яа вэ энэ бол тухайн хэргийг шийдвэрлэснээр тэр хуулийг ижил төстэй өрсөлдөөнт хэм хэмжээнүүдээс ялгаж салгаж шийдвэрлэх ижил төстэй хэргүүд энэ дээд шүүхийн тайлбарлаж хэрэглэсний дагуу цаашдаа хэрэглэж шийдэх ийм ач холбогдлыг л үүсгэх болохуйц тийм одоо хэрэг маргааныг шийдвэрлэх боломжтой байхаар ингэж томьёолж өгвөл уг нь бас боломжтой юм байгаа юм.

Гэхдээ хууль тогтоогчдын өөрсдийнх нь шийдэх асуудал байх энэ бол. Энэ дээр бол шүүхийн зүгээс бол аль нэг талыг нь бариад байхаасаа илүүгээр эрх зүйн соёлын хувьд бол энэ ирээдүйдээ бас энэ боломжийг нээлттэй байдлаар тавьж өгөх нь бол бас нөгөө талдаа Үндсэн хуулиар нөгөө шүүхэд мэдүүлэх эрх, хуулийн нэгдмэл хэрэглээг тогтоох тэр юманд ач холбогдолтой байна байх гэж ингэж бодож байна.

С.Бямбацогт: Мөнхсайхан багш 2 дугаар микрофон.

О.Мөнхсайхан: Эрхэм гишүүд маань саналаа өгөх шийдвэрээ гаргахад бас тэнцвэртэй байх үүднээс санал хэлэх боломж олгож байгаад баярлалаа. Тэгэхээр энэ ажлын хэсгийн саналын 25.6.5-д бол энэ 3 үндэслэлээр давж заалдах шатны магадлалыг хянах дээд шүүхийн энэ үндэслэл дээр 4 дэхийг нэмэх ийм санал гарч ирж байна. Түрүүн Цогт шүүгчийн хэлсэнтэй төстэй бодол юу байна вэ гэхээр энэ эрх зүйн соёлын асуудал байгаа юм. Манайд бол дээд шүүх бол фактын асуудал руу эсхүл хууль хэрэглээний тийм ноцтой биш юм руу орох хуулийн процессын зохицуулалт байхгүй. Уг нь хэрэглээний л тэр ноцтой асуудал дээр төвлөрнө гэж байгаа.

Гэтэл манай дээд шүүх бол хэдийгээр нийт тэр хэрэг маргааны 2, 3 хувийг шийддэг гэж байгаа боловч хүссэн юмаа зарчмын ач холбогдолтой гээд орчихдог нь энэний цаана бол янз бүрийн үзэмж дур зорог яваад байна уу гэдэг үндэслэл бүхий хардлагыг үүсгээд байгаа юм. Тэгэхээр энэ нөхцөлд таарсан байдлаар ажлын хэсгээс 25.6.5 гэсэн энэ зүйл дээр 3 маш тодорхой үндэслэлийг оруулж ирж байгааг бол би судлаачийн хувьд одоогийн эрх зүйн соёлд нийцсэн тодорхой заалт байна гэж харж байгаа.

Шүүгчдийн маань хэлж байгаа энэ зүйлүүд бас энэ 6.5.1, 6.5.2-т байж байгаа хүрээнд шийдэгдэх бүрэн боломжтой. Яагаад вэ гэхээр 5.1 дээр анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр зөрүүтэй байна гэж шүүх үзэж байгаа тэр нэгдмэл хэрэглээг нь хангахын

тулд энэ чинь орох боломж нь байна. Тэгэхээр энэнээс өөрөөр яам нэгдмэл хэрэглээний асуудлыг хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах ийм юм үүсэх юм бэ, би миний хувьд бол гайхаж байгаа юм.

Өөрөөр хэлбэл энэ зөрүүтэй байна гэж үзэх юм бол энэ үндэслэл бол бас байна. Үнэхээр зөрүүтэй юмыг л хэрэглээний хувьд нэгдмэл болгох үндэслэл байна. Энэнээс гадуур зарчмын ач холбогдолтой юм гэхээр юу байх вэ гэдэг юм байгаа юм. 2 дугаарт тэр дээд шүүх бол шүүхийн шийдвэр практикт үндэслээд танхимын саналаар бол нэгдсэн хуралдаанаар тайлбар гаргана. Хэрэв 5.1-т багтахгүй тийм ноцтой асуудлууд байна гэвэл дагнасан танхим нь саналаа гаргаад тайлбараа гаргах ийм бүрэн боломж бол байна уу гэж.

Тэгэхээр энэ манай өнөөдрийн эрх зүйн соёлын байж байгаа байдалтай холбоотойгоор бид нар энийгээ ингэж хашиж тодорхой болгоод тэгээд энэ дээрээ үндэслээд яг дээд шүүх өөрөө дээд шүүх шиг ийм болох алхмыг хийхгүй бол өмнөх шиг ерөнхий зохицуулалтаа оруулаад өгчихдөг. Тэгээд хүссэн юм руугаа ордог ийм байдал өөрчлөгдөхгүй байх вий гэсэн одоогийн нөхцөлд тохирсон байдлаар энийг бол ойлгож харж байгаа.

С.Бямбацогт: Хариултууд авлаа. Санал байр суурийг сонслоо. Гишүүд нэлээн ойлголттой болж авсан байх. Санал хураалт явуулах уу? Мөнх-Оргил, Нямбаатар нарын гаргасан гишүүдийн гаргасан санал. 16-д доор дурдсан санал гаргах. 25.6.5.4.хуулийн нэгдмэл хэрэглээг тогтооход зарчмын ач холбогдолтой бол гэсэн дээд заалт нэмэх. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 4 гишүүн буюу 25 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал хураалт. Адьшаа гишүүн гаргасан байна. 25.6.5.4.Улсын дээд шүүх нь авлига, албан тушаал, мөнгө угаах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, хүн амын байгаль орчны эсрэг хүн амины болон байгаль орчны эсрэг гэмт хэргийг хяналтын журмаар шийдвэрлэж болно. Зөв үү, Адьшаа гишүүн саналаа тайлбарлах уу? Саяын 3 заалт дээр нэмж 4 дэх заалт бас нэмж оруулъя гэж байгаа юм байна. Адьшаа гишүүн.

Ш.Адьяа: Миний санал дэмжигдэхгүй л байх л даа. Мөнх-Оргилын санал унаж байгаа юм чинь. Гэхдээ саналаа тайлбарлаад хураалгая. Ер нь энэ бүх хэрэг маргааныг дээд шүүх дээр хяналтын журмаар хянахгүй байх энэ зарчмын дэмжиж байгаа юм. Гэхдээ энэ дээд шүүх бол хэрэг маргааныг хянадаг шийдвэр гаргадаг бүр тийм концепц энэ хууль дээр суусан байгаа.

Тэгэхээр өнөөдөр анхан шатны шүүх дээр давж заалдах шатны шүүх дээр бүх хэрэг маргааныг шийдвэрлэнэ гэдэг энэ ойлголт бол өнөөдөр шүүхийн практикт

өнөөдрийн амьдрал дээр бол үнэхээр бэрхшээлтэй байгаа. Өнөөдөр энэ нийгэмд олны анхаарлыг татсан энэ авлигал албан тушаал мөнгө угаах үндэслэлгүйгээр хөрөнгөжих оффшор бүс болон хүн амины байгаль орчинтой холбоотой энэ гэмт хэргүүдийг хяналтын шатны шугамаар заавал одоо энд гомдол гаргасан бай ч прокурор эсэргүүцэл бичсэн нөхцөлд хянаж үзэж тодорхой хэмжээний хяналтын дүгнэлт гаргах энэ асуудал бол хууль дээдлэх хуульд шударга шүүхээр шүүлгэх шүүхэд итгэх итгэлд бол онцгой ач холбогдолтой юм.

Өнөөдөр бол энэ Энхбаяр гишүүн бид нар чинь ажлын хэсэг дээр ажилласан. Энэ дээр бол олон юм дээр бид нар зарчмын хувьд санал нийлээгүй. Би цөөнх болсон үнэн. Гэхдээ энэ шүүхийн шинэчлэлийн асуудал. Энэ шударга шүүхээр шүүлгэх асуудал. Шүүхэд итгэх энэ ард түмний итгэлийн асуудал бол өнөөдөр энэ шүүхийн хуулиар шийдэгдэнэ. Гэтэл өнөөдөр давж заалдах шатны шүүх, анхан шатны шүүх дээр энэ анхаарал татсан энэ хэргийг эцэслэн шийдээд сөрөг үр дагавар гарч дахиад нэг мөсөн уул бий болгох ийм нөхцөл бололцоо гарвал хэн хариуцах юм бэ? Дээр нь нэг хянадаг юмтай гэсэн тийм бодолтойгоор энэ асуудалд хандмаар байна.

Шүүхийн шийдвэр эцсийн гээд алх цохидог. Тэгээд энэ улс эх орны эрх ашиг хохирсон хүний амь нас хохирсон энэ улс орны байгалийн баялагтай холбоотой олон энэ анхаарал татсан асуудлууд анхан шатны болон давж заалдах шатны шийдвэрээр гараад дуусвал ямар үр дүн гарах вэ? Энэний үүрэг хариуцлагыг хэн хүлээх вэ? Энэ шүүхэд итгэх итгэлийг хэн хүлээх юм бэ? Өнөөдөр та бүхэн бас энд бодолтой хандаарай. Энийг дэмжиж өгөөрэй. Үнэхээр авлигал албан тушаалын энэ байгалийн баялагтай холбоотой асуудлыг хяналттай төрийн хяналтад мэргэжлийн дээд шатны байгууллагын хяналтад байхын эсрэг санал өгөх тийм хүн байхгүй байх гэж найдаж байгаа би нарт. Эрүүл саруулаар энэ шийдээрэй. Энэ дээр нэг намын бодлого ч гэдэг юм уу, аливаа энэ улс төрийн шинэтгэл хийнэ ч гэдэг юм уу ийм байдлаар хандахгүй байх гэж найдаж байгаа.

Би энэ асуудлыг эцсээ хүртэл Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр ч гэсэн энд унасан ч гэсэн санал хураалгана. Энийг ард түмэн харна. Хэн нь ямар бодолтой байдаг юм. Тийм учраас та бүгд миний энэ саналыг дэмжиж өгнө гэж би найдаж байна. Энэ бол тэр Үндсэн хууль зөрчсөн асуудал ерөөсөө байхгүй. Монгол Улсын Үндсэн хууль дээр дээд шүүх бол бүх шатны шүүхийн үйл ажиллагааг хянаж удирдана гэсэн тийм тодорхой заалт байгаа шүү дээ. Тэгэхээр энэ Адьшаа гэж цөөнхийн гишүүн ийм санал гаргаж байна гэхгүйгээр.../минут дуусав/

С.Бямбацогт: Тийм ээ тийм. Таны гаргасан санал Үндсэн хууль зөрчөөгүй. Таны саналыг хураалгана. Санаа зоволтгүй. 25.6.5.4 улсын дээд шүүх нь авлига албан тушаал мөнгө угаах үндэслэлгүйгээр хөрөнгөжих хүн амины байгаль орчны эсрэг гэмт хэргийг хяналтын журмаар шийдвэрлэж болно гэсэн саналыг Адьшаа

гишүүн гаргасан байна. Нэмье гэсэн тийм ээ. 25.6-д ийм заалт нэмж оруулъя гэсэн санал гаргаж байна. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 6 гишүүн буюу 37,5 хувийн саналаар Адьшаа гишүүний санал дэмжигдсэнгүй. Та өөрөө эсрэг өгсөн байна шүү. 2-хон санал хураалттай тэгээд цайндаа оръё хэдүүлээ.

Түрүүн Нямбаатар гишүүний гаргасан саналууд дэмжигдсэн саналуудыг бид бас хураах ёстой юм байна. Ажлын хэсгийн 12 дахь саналын томьёоллын 20 дугаар зүйлийн нийт шүүгчдийн хуралдаан гэснийг нийт шүүгчийн чуулган гэж өөрчлөх. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Энийг баталж хураах ёстой гэнэ. Харин тийм. Та асуулт дээрээ асууж болно, санал дээрээ бас хэлж юу зарчмын зөрүүтэй саналаа гаргаж болно шүү дээ. 16 гишүүн оролцсоноос 14 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Дараагийнх.

Төслийн 25.3 дахь хэсгийн 24-өөс доошгүй гэснийг 24 гэж өөрчлөх. 24 илүү ч үгүй дутуу ч үгүй. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 81,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Ингээд бид нар чинь 25 дугаар зүйлээ хэлэлцээд дууслаа. Түр завсарлаад үдийн цайндаа ороод 14.30-аас үргэлжлээд энэ танхимдаа хуралдана. Гишүүддээ баярлалаа. Хоол 4 давхарт биз дээ, хаана вэ, Мөнхчимэг. 4 давхрын их танхимд юм байна шүү. Тусдаа хэсэгт зассан. Манай дээд шүүхийн шүүгч нар, дэд ажлын хэсгийнхэн, Сайнзориг эд нар ороорой, Баасандоржоо, Мөнхсайхан багшаа.

ЗАВСАРЛАГА

С.Бямбацогт: Гишүүдийг танхимдаа урьж байна. 14.40 болж байна. Ажлын хэсэг хоолондоо орсон биз дээ. Хуралдаан зохион байгуулах гишүүдээ дуудаарай. Нямбаатар сайдыг дуудъя. Би ч Төрийн байгуулалтад байгаа шүү дээ бас. Хурлаа үргэлжлүүлъя. Сая чинь 26 дугаар зүйлээ 25-г ярьсан тийм ээ. Хуулийн төслийн 26 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? 26. Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан гэсэн бүлэг байгаа. Асуулт алга байна. Санал хураалт явуулъя. Ажлын хэсгийн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

19.Төслийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “25.6.3, 25.6.4, 25.6.5, 25.6.6, 25.6.7, 25.6.8, 25.6.9, 25.6.10-т ” гэснийг “25.6.3, 25.6.4, 25.7-д” гэж, 26.2 дахь хэсгийн “түүний түр эзгүйд,” гэснийг “эсхүл энэ хуульд заасны дагуу түүний” гэж өөрчилж, 26.4 дэх хэсгийн “асуудлыг” гэсний дараа “нийт шүүгчийн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Пүрэвдорж гишүүн байраа эзэлчих тэгээд саналаа хураая. Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд анхааралтай саналаа өгөөрэй. Пүрэвдорж гишүүнээ. 26 явж байгаа. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 62,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

27 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгнө үү. 27 шүү. Пүрэвдорж гишүүн. Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн бүрэн эрх. Асуулт алга байна. Ажлын хэсгийн бэлдсэн саналаар санал хураалт явуулъя зарчмын зөрүүтэй саналаар. 18 дугаар санал. Зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд уншиж танилцуулъя. 18.Төслийн 27 дугаар зүйлийн 27.1.1-2.1.5 дахь заалтуудыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 27.1.1-27.1.7 дахь заалт болгох:

27.1.1.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан, Зөвлөгөөн зарлах, бэлтгэлийг хангах, даргалах;

27.1.2.Улсын дээд шүүхийг гадаад харилцаанд төлөөлөх;

27.1.3.Улсын дээд шүүхийн шүүгчид гадаад, дотоод ажлын томилолт олгох;

27.1.4.танхим хоорондын ажлыг уялдуулан зохион байгуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас бусад шаардлагатай гэж үзсэн асуудлыг хэлэлцүүлэхээр танхимд хуваарилах;

27.1.5.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн зөвлөгөөнд танилцуулснаар Тамгын газрын дарга, Хүрээлэнгийн захирлыг томилох, чөлөөлөх;

27.1.6.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан, Зөвлөгөөнөөс гаргасан шийдвэрийн дагуу Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газартай Улсын дээд шүүхийг төлөөлөн харилцах;

27.1.7.хуульд заасан бусад бүрэн эрх.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. 27 дээр үү, хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулъя. Пүрэвдорж гишүүн Шүүхийн тухай хуулийн төслийн 27.1.7-д заалт нэмэх.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх талаар гаргасан өргөдөл гомдолд Дээд шүүхийн ерөнхий шүүгч албан бичгээр хариу өгөх. Саналаа тайлбарлах уу, Пүрэвдорж гишүүн саналаа тайлбарлая.

Б.Пүрэвдорж: Энэ саналын томъёоллоо уншиж танилцуулъя. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх талаар гаргасан өргөдөл гомдолд дээд шүүхийн ерөнхий шүүгч албан бичгээр хариу өгөх гээд. Тэгэхээр энэ 2002 оноос хойш энэ практик дээр ерөөсөө энэ улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, ерөнхий прокурор нар иргэдийн гомдолд ерөөсөө хариу өгөхөөр больсон. Дандаа танхимын шүүгч юм уу орлогч нараар өгүүлдэг. Энэ нь юунаас болдог вэ гэхээр ерөөсөө Үндсэн хуулийн цэц ерөнхий прокурор дээд шүүхийн шүүгч хоёрыг хууль зөрчсөн асуудлаар нь одоо гомдлыг авч хэлэлцэх ийм заалттай. Тэгээд энэнээсээ энд очихгүйн тулд өөрсдөө албан бичгээр ямар нэгэн тийм бичиг өгүүлдэггүй. Дээд шүүхийн орлогчоор одоо ингээд 10 гаруй жил ингээд 10 хэдэн жил ингээд явсан.

Ямар ч бичиг ингэж иргэдийн гомдолд ерөнхий шүүгчийн албан бичгээр хариу өгч байгаагүй. Зөндөө л асуудал байна. Одоо Үндсэн хууль дээр иргэдийг аливаа хүнийг эрүүдэн шүүж болохгүй гэсэн заалттай. Гэтэл шүүх эрүүдэн шүүсэн асуудлаар хэрэг хянан шийдвэрлээд ингээд явж байгаа. Гэтэл энэ дээр нь гомдол гаргаад өгье гэхээр нөгөө нэг ерөнхий шүүгчийг л Үндсэн хуулийн цэц авч хэлэлцэх ёстой учраас танхимын шүүгч ч юм уу эсхүл орлогч нь тийшээ очих боломжгүй болчихдог. Тэгээд энийг л энэ заалтад оруулах гэж зүтгэж байгаа юм. Өөрөөр

хэлбэл бид нар байна шүү дээ энэ шүүгч нарыг томилдог нэг гараар томилоод нөгөө гараараа огцруулах тэр зүйлийг л бид нар хангалттай сайн гаргаж өгөх ёстой байхгүй юу.

Тэгээд би энэ хууль дээр ингээд уншаад ингээд танилцахаар Энхбаяр гишүүнээ хууль санаачлагч Нямбаатараа энэ хууль дээр чинь шүүгч нарын үүрэг гэж ерөөсөө байхгүй байна шүү дээ. Энэ чинь ямар бүрэн эрхүүд бараг ингээд бараг хуудас хуудсаараа байна. Гэтэл үүрэг ерөөсөө байхгүй. Энэ үүрэг дотор нь ийм, ийм заалт дээр тэрэн дотор нь оруулъя гэсэн чинь ямар ч тийм үүрэг шүүгчийн үүрэг гэсэн юм ерөөсөө байхгүй. Ийм л хууль оруулж ирж байна дандаа бүрэн эрхтэй. Тэгээд ерөөсөө энэ шүүгчийг огцруулах өөрөөсөө ерөнхий шүүгчийг огцруулах энэ бүх зүйлийг л энэ хуулиасаа бүгдийг нь аваад, аваад хаясан.

Өөрөөр хэлбэл иргэний хэрэг маргаан шийдвэрлэхтэй холбоогүйгээр бүх маргааныг Тамгын газрын даргаараа хариу өгүүлдэг. Одоо энэ шүүгч нар бол надад тайлбар хэлэхдээ аливаа хэрэг хянан шийдвэрлэх тухай холбоотой бүх асуудлыг бүх шүүгч нар бүрэлдэхүүнээрээ гарын үсэг зурж байгаа гэж тайлбарлана байх. Тэгэхээр энэ дээр заавал ерөнхий шүүгч бас тодорхой хэрэг маргаанд оролцож байгаа тэр оролцох тохиолдолд гарын үсэг зурсан тэр зүйлүүдийгээ заавал албажуулж иргэнд хүргэх. Хэрэв энэ нь Үндсэн хуулийн цэцийн маргаан болох юм бол нөгөө шүүгчийг огцруулах үндэстэй гэж үзвэл огцруулах ийм л заалтыг гаргаж ирэх ёстой л гэж үзэж байгаа юм. Тэгэхээр 2002 оноос хойш Ерөнхий шүүгч бол ямар ч албан бичигт иргэний хэрэгт иргэний гомдолд хариу өгч байгаагүй ийм зүйл явж байна. Ерөөсөө дандаа ингээд хариуцлагаас зугтдаг. Тэгээд өөрсдөө баахан эрх бол ингээд хуулиараа бүгдийг нь авсан. Ийм л юмнууд явж байна тийм учраас энэ заалтыг дэмжиж өгөөч гэж Их Хурлын гишүүдээсээ хүсэж байна.

С.Бямбацогт: Ерөнхий шүүгчийн бүрэн эрх шүүгчийн бүрэн эрх гээд яригдаж байгаа асуудлын цаад талд ерөөсөө ер нь бүрэн эрхийн цаад талд бол эрх үүргийн нэгдэл. Бүрэн эрх гэдгийн цаад талд бол эрх нь ч байгаа үүрэг нь ч байж байгаа. Тийм болохоор энэ хүрээндээ бид нар ойлгох ёстой. Тэгэхээр тодорхой үүргүүд байж байгаа. Энэ 18.1.4-д бол заасан байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамааралгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл гомдолд Тамгын газраас хариу өгч байгаа ажиллагаанд хяналт тавих гээд. Үндсэндээ Тамгын газраас өргөдөл гомдол хариу өгөх ийм хуультай. Энэнийхээ дагуу энэ ажиллагаа нь зөв явж байна, буруу явж байна уу гэдгийг хяналт тавь л гэж байна л даа. Тэгэхээр энэ дээр ажлын хэсгээс тайлбар байна уу? Шүүхийн ерөнхий зөвлөл, тайлбар байхгүй юу? Тайлбар алга. Тэгвэл санал хураалт явуулъя. Пүрэвдорж гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх талаар гаргасан өргөдөл гомдолд Дээд шүүхийн ерөнхий шүүгч албан бичгээр хариу өгөх. Төслийн 27.1.7-д заалт нэмье гэсэн санал гаргаж байна. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Одоо чинь хэд билээ? Хуулийн төслийн 28 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. 28. Асуулт алга байна. Ажлын хэсгийн гаргасан

зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Энэ чинь юу болсон бэ? Тийм байна. 19.Төслийн 28 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28 дугаар зүйл.Улсын дээд шүүхийн танхимын бүрэн эрх

28.1.Улсын дээд шүүхийн танхим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиар тогтоосон журамд нийцүүлэн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.1.1.хуульд өөрөөр заагаагүй бол хэргийн харьяаллыг тогтоох;

28.1.2.хяналтын шатны шүүхийн тогтоолд үг, үсэг, тооны зэрэг техникийн шинжтэй алдаа гарсан бол залруулга хийх;

28.1.3.шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах саналыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанд оруулах;

28.1.4.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан, Зөвлөгөөн зарлан хуралдуулах талаар Ерөнхий шүүгчид санал гаргах;

28.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 14 гишүүн буюу 87,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй тийм ээ. Дараагийн зүйл.

Хуулийн төслийн 29 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Давж заалдах шатны шүүх түүний бүрэн эрх. Асуулт алга байна. Ажлын хэсгийн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

20.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 29.5.1 дэх заалтын “хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан гомдол, прокурорын эсэргүүцлийг үндэслэн” гэснийг “хуульд заасны дагуу” гэж, 29.4 дэх хэсгийн “шүүгч” гэснийг “Ерөнхий шүүгч, шүүгч” гэж тус тус өөрчилж, 29.5.3 дахь заалтын “мэдээлэл, зөвлөмж гаргуулах,” гэснийг хасаж, доор дурдсан агуулгатай 29.5.3 дахь заалт нэмэх:

“29.3.Давж заалдах шатны шүүх шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнасан танхимтай байж болно. Танхимыг тухайн шүүхийн Зөвлөгөөний саналыг үндэслэн Улсын дээд шүүхийн шийдвэрээр байгуулж, бүрэлдэхүүнийг тухайн шүүхийн Зөвлөгөөн батална.”

“29.5.3.хуульд өөрөөр заагаагүй бол хэргийн харьяаллын талаар доод шатны шүүх хооронд гарсан маргааныг шийдвэрлэх;” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 13 гишүүний саналаар 81,2 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна. 29 дүгээр зүйлтэй холбогдуулж гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 30 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. 30 байхгүй юу. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй хасагдсан юм байна. Бичгээр гарсан санал байхгүй.

Хуулийн төслийн 31 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Бас хасагдсан юм байна. Санал алга байна. Хуулийн төслийн 32 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Сум дундын шүүхтэй холбоотой. Асуулт алга байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан санал бичгээр гаргасан санал алга. Ажлын хэсгийн саналыг санал хураалт явуулъя. 21.Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “дүүргийн” гэсний дараа “шүүх” гэж нэмж, 32.3 дахь хэсгийн “тодорхой хэрэг, маргааны төрлөөр” гэснийг “шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнасан” гэж өөрчилж, 32.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 32.5 дахь хэсгийн “нүүдэллэн ажиллаж” гэснийг “шүүх хуралдааныг шүүхийн байрнаас бусад газарт хийж” гэж өөрчлөх:

“32.4.Энэ хуулийн 32.3-т заасан танхимыг тухайн шүүхийн Зөвлөгөөний саналыг үндэслэн Улсын дээд шүүхийн шийдвэрээр байгуулж, бүрэлдэхүүнийг тухайн шүүхийн Зөвлөгөөн батална.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 81,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. 32 дугаар зүйлтэй холбогдуулаад бичгээр гаргасан санал бол алга байна.

33 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. 33 дугаар зүйл хасагдсан байна. Ажлын хэсгээс санал гараагүй. Бичгээр гарсан санал алга. 34 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Шүүгчид тавигдах болзол шаардлага. Асуулт алга байна. Мөнхцэцэг гишүүн. Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнхцэцэг: Энэ төслийн 34.4.3 дээр ажлын хэсгээс ийм санал оруулж ирсэн байна. Энэ магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн их дээд сургуульд 10-аас доошгүй жил багшилсан байна гээд. Тэгэхээр энэ дээд шүүхийн шүүгч болохын тулд заавал их дээд сургуульд багшилсан байх ёстой ийм болзол тавьчихаад байна л даа. Тэгэхээр нийт одоо шүүгчдийн маань яг хэдэн хувь нь их дээд сургуульд багшилдаг вэ. Ер нь бол шүүх нөгөө мерит зарчмаар дээд шатны шүүхийг томилох бүрдүүлэх ёстой. Давхар ингээд эрдэм шинжилгээ судалгааны ажил хийж байгаа бол уг нь бол давуу тал. Гэхдээ ийм заалт оруулчихаар дээд шүүхийн шүүгчид одоо хэт ийм өндөр босго тавьчихаж байгаа юм биш үү.

Мөн одоо тодорхой мэргэжил гэдэг юм уу, тодорхой одоо ажлын салбар ингээд явцууруулсан маягтай заалт биш үү л гэж хараад байна л даа. Тэгэхээр ажлын хэсгээс хариулт авъя.

С.Бямбацогт: 34.1-т бол шүүгчид тавигдах тодорхой шаардлагууд тавигдсан. 34.3 дээр бол дараах 3 шаардлагын аль нэгийг гэсэн байгаа тийм ээ. Шүүгчээр ажиллаж байсан байх өмгөөлөгч прокуророор ажиллаж байсан байх. Их дээд сургуульд багшилж байх гээд. Цогт шүүгч тайлбарлах уу. 1 дүгээр микрофон.

Ц.Цогт: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Энэ 34 заалт бол өөрөө хяналтын шатны шүүхийн шүүгчид тавигдах шаардлагыг заасан байгаа. Тэгээд сая Бямбацогт гишүүний хэлсэнчлэн шаардлагын аль нэгийг хангасан тохиолдолд бол

хяналтын шатны шүүхэд томилогдох боломжтой. Жишээлбэл хуульчаар 10 жил ажилласан эсхүл давж заалдах шатны шүүхэд 6 жил ажилласан ч гэдэг юм уу тийм ээ. Дээрээс нь энэ 2013 оны шүүхийн тухай хуульд хяналтын шатны шүүх нөгөө онол хууль хэрэглээний жишиг тогтоодог шүүх байх ёстой гэдэг үүднээс хууль зүйн сургуулийн туршлагатай багш хүн бол бас шүүгчээр ажиллаагүй ч гэсэн хяналтын шатанд бол томилогдож болох юм гэдэг ийм заалт хэрэгжиж байсан.

Энэ заалтыг бол нөхөж оруулж ирсэн. Төсөл дээр байгаагүйг ажлын хэсэг дээр нөхөж оруулж ирсэн ийм заалт байгаа. Тэгээд дараа нь бол энэ дээр бас код тогтоогоод өгсөн байж байгаа. Энэ шууд одоо Их сургуулийн багш байж байгаад дээд шүүхийн шүүгч болох хүний тоог бол 34.6 дээр бол хязгаарлалттай зааж өгсөн байгаа.

С.Бямбацогт: Мөнхцэцэг гишүүн тодруулъя.

Ц.Мөнхцэцэг: Гишүүдэд тараасан төсөл дээр бол аль нэг гэдгээрээ байхгүй орж ирсэн байгаа юм. Доор дурдсан шаардлагыг хангах гэнгүүтээ энэ шүүгчээр 10-аас доошгүй жил, прокурор өмгөөлөгчөөр 10-аас доошгүй жил их дээд сургуульд 10 жил гээд орж ирсэн. Тийм учраас энэ дээр энэ техникийн алдаа гарсан байна шүү.

С.Бямбацогт: Шаардлагын аль нэгийг хангана гэж оруулж ирсэн тийм ээ тэрийг орхигдсон байсан байна. Анхаараарай. Ажлын хэсэг оруулсан байна тийм үү. Оруулсан юм байна. Асуулт асууж дууссан санал хураалт явуулъя. 22.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалтын “гэмт хэрэгт холбогдоогүй буюу” гэснийг хасаж, 34.2 дахь хэсгийн “жагсаалтыг” гэснийг “жагсаалт болон энэ хуулийн 41.2.2-т заасан эрүүл мэндийн шалтгааныг тогтоох журмыг” гэж, 34.4 дэх хэсгийн “шаардлагыг” гэснийг “шаардлагын аль нэгийг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 34.4.3 дахь заалт нэмж, 34.5, 34.6 дахь хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34.4.3.магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн их, дээд сургуульд 10-аас доошгүй жил багшилсан.”

“34.5.Сүүлийн зургаан жилд улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан хүнийг шүүгчээр томилохыг хориглоно.

34.6.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн гуравны хоёроос доошгүй нь энэ хуулийн 34.4.1-д заасан шүүгч байна. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан байна.” гэсэн заалтууд нэмье гэсэн саналыг ажлын хэсэг гаргасан байна. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 81,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. 34 дүгээр заалттай холбогдуулж гишүүдээс бичгээр санал гараагүй байна.

Хуулийн төслийн 35 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуултай гишүүд байвал нэрсээ өгнө үү. Шүүгчийг сонгон шалгаруулах журам. Асуулт байгаа юу? Алга байна. Ганбат гишүүн байна уучлаарай. Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Царгиад байна шүү наадах чинь. Цуурайтаад. Ганбат гишүүн.

Д.Ганбат: Энэ хууль маань ингээд батлагдаад гарсны дараагаар дээд шүүхийн шүүгч нар энэ давж заалдах шатны шүүгч нар маань яг энэ хуулийн шаардлагыг хангаагүй бол яах юм бэ? Тийм хүмүүс байгаа юу? Тэгвэл бас энэ хуулийн зүйл заалтыг биелүүлэх хангах шаардлага үүсэх үү. Нөгөө талаас энэ шүүгч нарыг яг төрийн албаныхантайгаа адилтгах нь зөв юм уу. Энд нөгөө насны дээд хязгаар заагаад тэтгэвэрт гарахыг нь заасан байна л даа. Бусад улс орнууд чинь бараг арай өөр маягаар явдаг. Бараг насаараа тийм ээ бүр 95 настай хүн хүртэл шүүгч хийгээд тэр эмэгтэй шүүгч байж байгаад нас барлаа шүү дээ Америкт ингэж ажилладаг.

Тэгэхээр сайн шүүгч гэдэг бол бас шаардлага хангасан ийм шүүгч одоо нэг 55, 60 насандаа ингээд гарчхаад байвал бас тэрний орон тоог нөхөх тийм одоо боловсон хүчин хангалттай байж чадах уу. энэ дээр манай энэ одоо хуулийг санаачилж байгаа Засгийн газар манай ажлын хэсэг юу гэж үзэж байгаа юм бэ?

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Энхбаяр гишүүн хариулъя. 2 асуулт асуулаа.

Б.Энхбаяр: Ганбат гишүүний асуултад хариулъя. Энэ хуулийн шаардлагын дагуу энэ хууль маань эргэж үйлчилж энэ жишээлбэл энэ шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд тэр шүүгчийг чөлөөлөх тийм асуудал бол байхгүй. 2 дугаарт угаасаа энд тавигдсан 3 шаардлагыг одоо ажиллаж байгаа улсын дээд шүүхийн бүх шүүгч нар шаардлагыг хангаж байгаа учраас бас энэ 3 заалтаас бас хамарч үйлчлэх тийм шүүгч бол бас байхгүй байгаа.

Тийм учраас энэ хууль гарснаар эрсдэлд орох чөлөөлөгдөх ийм дээд шүүхийн шүүгч бол бол байхгүй. Ер нь шүүгчийн насны тухайд бол бас одоо бас гишүүд маань бас ярих байх. Олон талаас нь. Нэг талаасаа насаараа тэгж томилогддог байх юм уу төрийн албаны бас хууль гэж байгаа. Нөгөө талаараа энэ маань өөрөө бас тийм амар ажил бас биш байдаг. Бас л хүнд хөдөлмөрт ордог шүү дээ сэтгэл зүйн хувьд тэр. Бичиг цаастай харьцана. Ажлын ачаалал тэр дарамт шахалт гэдэг юм бол одоо бас нэлээн өндөрт ордог. Тийм учраас бол харин эсрэгээрээ зарим тохиолдолд бас нийгмийн баталгааг нь хангаад арай жаахан наана гаргах гарчихмаар байдаг гэсэн бодолтой шүүгч нар ч бас байхыг бол үгүйсгэхгүй.

Тийм учраас бол энийг бас олон талаас нь яриад бол шийдэх ёстой байх. Яах вэ бид нар бас энэ хууль дээрээ энэ шүүгчээр ажиллахад бас хүндрэл учирч байгаа эрүүл мэндийн нөхцөл байдлуудыг бас хаанаас тогтоох вэ гээд бас журамлаж байгаа.

Манайд бол бас тийм тохиолдлууд гарч байсан байна лээ. Өөрөө хэргээ уншиж чадахаа больсон. Хүнээр уншуулдаг. Тэгээд шийдэж байсан. Тэгээд нөгөөх нь одоо шийдвэрээ бичиж чадаж байгаа ч юм уу үгүй ч юм уу бүү мэд гэсэн ийм бас асуудлууд бас байдаг юм байна лээ. Тийм учраас бол энэ олон талаас нь л хандаж бас энэ хуулийн асуудал дээр нь журамлах ийм л шаардлагатай юм байна лээ гэсэн дүгнэлтэд хүрсэн. Баярлалаа.

С.Бямбацогт: Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Саяын зүйл дээр тэгээд анхаарч байгаа юм байна. Тэр зөв зүйтэй байх. Нөгөө тал дээр бас энэ шүүгчийг сонгон шалгаруулах дээр өмнө нь бас шүүгчийн туслах шүүхийн нарийн бичиг энэ тэр хийж байсан хүмүүс олноороо шүүгчид болсон л доо. Тэгээд энэ зүйл заалт маань сайн шүүгч нар ч гарсан байх. Би үгүйсгэхгүй л дээ. Гэхдээ бусад улс орны яг адил зүйлд шүүгчдийг шалгаруулах байдлыг нь хараад байхад бол тийм 4 ханан дундаас гарч үзээгүй хүмүүсийг бол шүүгчээр оруулдаггүй гаргадаггүй. Нэлээн тэр өмгөөлөгч хийж байсан одоо олон газар ажиллаж байсан ажил амьдрал мэдэх тийм ээ бүр доод талын насыг нь хүртэл заадаг л даа. Энэ тал дээр ямар байгаа вэ? Одоо яг тэр зүйл заалт үйлчилж байгаа юу, энэ хуулиар өөрчлөгдөж байгаа юу ямар байгаа вэ?

С.Бямбацогт: Ажлын хэсэг Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Шүүгчид тавих шаардлагын хувьд бол нэлээн өндөрсгөж байгаа. Үндсэн хуульд бол 25 насанд хүрсэн 35 насанд хүрсэн гэсэн насны болон мэргэжлийн шаардлага л байдаг. Ер нь шүүгч хүн бол ямар ч тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байх ёстой. Тухайн үедээ мөн янз бүрийн хэрэг төвөгт оролцоогүй байх ёстой. Шүүгчээр ажиллах мэдлэг чадвар ёс зүйтэй байх ёстой гэдэг олон шаардлагуудыг тавьж байгаа.

Давж заалдах шатны шүүгчийн тухайд жишээлбэл анхан шатны шүүгчээр 6-аас доошгүй жил ажилласан байх ёстой гэдэг шаардлага тавьж байгаа. Түрүүн бас Мөнхцэцэг гишүүн хөндөж байсан. Яагаад дээд шүүхийн тухайд хууль зүйн их дээд сургуульд бас нэг жаахан академик түвшний ийм боловсрол шаардаад байгаа вэ гэхээр энэ маань өөрөө бас хууль хэрэглээний тухайд ганцхан шүүн таслах ажлыг эрхэлж байхаасаа гадна бас онолын буюу тэр бусад хэрэглээ талаасаа нэлээн жишиг болж байгаа. Хуулийн нэгдмэл байдлыг хангах гэж байгаа учраас ийм академик түвшний.../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээх үү болсон уу? Болсон уу тийм ээ? Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Би зүгээр энэ Байнгын хорооны даргаас асуумаар байна. Энэ 35 дээр одоо энэ шалгуур байна шүү дээ тийм ээ. Энэ шалгуур дээр чинь 10 гаруй зүйл өөрчлөгдсөн байна заалт одоо шинээр орж байна л даа. Энэ дотор чинь надад 2, 3 нь ерөөсөө таалагдахгүй байна. Энэ янз янзын лобби орсон ийм зүйлүүд яваад байдаг. Тэгээд энэ дээр чинь би ганцхан санал өгөх гээд байдаг. Нөгөө таалагдаагүй болохгүй өөрийнхөө итгэл үнэмшлийнхээ эсрэг санал өгөх гээд байна шүү дээ.

Одоо ингээд энэ юун дээр хар л даа. 25 дээр. Шүүгчийн бүрэн эрх гээд энд чинь ингээд 20 заалт дээр өөрчлөлт орсон. Тэгээд энэ чинь энэ нь ардаа байх хэдэн зуун асуудал агуулгыг ингээд дагуулж байдаг. Асуудлыг зохицуулж байдаг ийм зүйл шүү дээ. Тэгээд энийг чинь бас 6, 7 нь ерөөсөө янз янзын одоо Энхбаярын юм орсон явж байна. Тэр Нямбаатарын бас юм сэмхэн шургуулсан явж байна. Тэгээд энэ дээд шүүхийн шүүгч нарын бүхэн эрхээ хэтрүүлсэн юмнууд бас орсон явж байна. Эд нарыг чинь ингээд би бүгдийг нь ингээд ганцхан заалтаар нь зүйлээр нь ингэж кноп дарахаар чинь энэ болохгүй байна шүү дээ. Хэд хэдэн юмнууд орсон байна. Энэ Сүхбаатар ч гэсэн юм хийсэн л байна гэж байна лээ. Тэгээд ийм юмнууд чинь би ингээд заалтаар нь энэ чинь дэг арай дэндүү будилуулсан байна.

Энэ чинь ийм том, том асуудлыг шийддэг юмыг ганцхан кнопоор дарна гэдэг чинь болохгүй шүү дээ. Би дараа нь тэгээд хэтэрхий одоо ингээд юу байдаг юм энэ би олонх нь бас зөв зүгээр л ямар ч асуудалгүй зүйл байна. Тэрнийгээ би ингээд олонх нь зөв байна гээд би кноп дардаг. Гэтэл энэ дотор чинь дараа нь энэ хууль баталсны дараа нөгөө нэг хөөн хэлэлцэх хугацаа шиг юм гарч ирээд. Тэгээд би тэрнээс чинь болж асуудалд ормооргүй байна шүү дээ. Тэгэхээр энэ Дэгийн тухай хуульд одоо яаж яваад байгаа юм бэ? Яг энэ заалт бүрээр нь кнопоо даруулж энэ санал хураалгамаар байна. Би ийм л санаатай байна. Бусдаар би хэл аманд ормооргүй байна. Дотор нь наадах чинь асуудалтай юмнууд байна шүү дээ. Дандаа бүрэн эрхүүдийг ингээд авчихсан.

С.Бямбацогт: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өнгөрсөн таван сард энэ хоёр хууль хоёулаа шинэчлэн найруулагдсан батлагдсан. Үүгээрээ хууль хэлэлцэх Үндсэн хуульдаа ч одоо хууль хэлэлцэхтэй холбоотойгоор хуулийн төслийг эцэслэн батлахдаа гучин есөөс дээш гишүүний саналаар батална гээд одоо хуулийг хэлэлцдэг баталдаг процесс бол илүү одоо нарийвчилсан илүү дэгтэй, илүү чанартай болсон. Яг Үндсэн хуульд нийцүүлж Дэгийн тухай хуулийг бид өөрчилсөн. Ингэхдээ хуулийн төслийг Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрэн хэлэлцсэний гучин есийн аравд энэ заалтаар олсон юм. Урд нь яаж явдаг байсан бэ гэхээр өргөн барьсан хуулийн төслийг хэлэлцэх эсэхээ шийдсэний дараа анхны хэлэлцүүлгийн шатанд одоо буюу одоо өнөөдрийн шатанд зөвхөн зарчмын зөрүүтэй саналуудыг хэлэлцээд явчихдаг байсан. Хуулийн төслийг хэлэлцэх биш зарчмын зөрүүтэй саналууд дээр л санал хураагаад явчихдаг байсан.

Тэгвэл бид нар дэгийн хуулиа улам сайжруулаад, хуулийн төслийн тийм үү бүх зүйл бүрийг бүгдийг нь хэлэлцдэг болсон. Хэрэв ингээд зүйлээр хэлэлцээд явахаар заалтууд дээр асуудал орхигдож байна. Сая одоо Нямбаатар юм шургуулсан, Энхбаяр юм шургуулсан гэдэг ч юм уу ярьж байгаа тийм хардлага байгаа бол та тэр бүгдийг үзээд судлаад уншаад тэр заалт болгон дээр нь энэ заалт ингээд болохгүй байна. Тийм учраас ингэж өөрчилье гэсэн зарчмын зөрүүтэй саналаа гаргаад хураалгах бүрэн эрх нь танд нээлттэй байгаа. Тийм болохоор өөрөөр хэлэх юм бол дэгийн хууль бол өмнөх одоо дэгээсээ хууль сайжирсан. Урьд нь бол зарчмын зөрүүтэй саналуудаар л санал хураагаад хуулийн төсөл ерөөсөө хэлэлцдэггүй байсан бол одоо хуулийн төслийг бүтнээр нь хэлэлцдэг ийм болсон байгаа. Заалтууд дээр та бол саналаа гаргах эрх нь нээлттэй байгаа. Яг одоо тодорхой сая нэр дурдсан заалтууд дээр яг ийм ийм заалтууд байна гэх юм бол та зарчмын зөрүүтэй саналаа бэлдээд бичээд өгчих. Тэрийг чинь бид нар санал хураалгая. Дэлгэрсайхан гишүүн асуулт асууя.

Б.Дэлгэрсайхан: Энэ ажлын хэсгийнхнээс би энэ гучин тавын хоёрын нэгийг асуух гээд байна л даа. Шүүгч хүсэлтээрээ чөлөөлөгдөх өндөр насны тэтгэвэрт гарах, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн бол гэж байгаа юм. Төрийн албаны алба хаах насны дээд хязгаар бол эрэгтэй жаран тав, эмэгтэй тавин тав гэж байгаа юм. Жар уу тийм. Тэгэхлээр энийг бас жоохон анхаарахгүй бол болохгүй байх. Энэ чинь бараг энэ шүүхэд ажиллаж байгаа ихэнх одоо шүүгч нарын одоо ихэнх нь эмэгтэйчүүд шүү дээ. Тийм учраас энэ насны хязгаарыг нь жоохон дээшээ болгох, тэгээд дотор нь бол дээд шүүхийн шүүх ч нь одоо насаараа байна гэдэг олон улсын энэ жишгийг одоо бас авбал яасан юм. Энийг бас ажлын хэсэг бас анхаарч үзсэн юм уу? Энд нэг хариулт авмаар байх юм тийм.

Тэгэхгүй бол одоо ингээд нас чинь болсон гээд манай төрийн алба чинь тэр шүү дээ. Нас чинь болсон. Дараагийн хүн томилно гээд ингээд хүнийг одоо бараг тэтгэвэрт гарах нас нь маргааш болонгуут билүү, сарын дараа болох үед нь бараг юуг нь албан бичгийг нь өгөөд та ингээд тэтгэвэрт гарах гэж байна гээд ингээд хүчээр гаргачихдаг шүү дээ. Тэгэхлээр шүүх дээр арай ингэж болохгүй байх. Энийг бас эргэж харах нь зөв болов уу гэж бодож байна.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Дэлгэрсайхан гишүүний асуултад хариулъя. Шүүгчийн тэтгэвэрт гарах настай холбоотой харилцаа бол энэ гучин тавдугаар зүйл биш. Дөчин есдүгээр зүйлд байгаа. Дөчин есдүгээр зүйлээр зохицуулагдаж байгаа дөчин есийн зургаад байгаа. Энэ гучин тавдугаар зүйлээр юу зохицуулаад байгаа вэ гэхээр нөгөө тэтгэвэрт гарах насан нь хүрчихсэн байдаг. Тэгээд бас ингээд хэн нь ямар хугацааны дараа зарлах нь мэдэгддэггүй. Тэгээд яг тухайн одоо насанд хүрэхээр өргөдлөө

гаргаад чөлөөлнө гэхээр энэ нөгөө шүүхээс чөлөөлөгддөг нэг процесс өөрөө хугацаа авдаг юм байна, нэг. Хоёрдугаарт чөлөөлөгдсөнтэй холбоотойгоор сул орон тоо гарсан гэж үзээд зарлаад нээлттэй сонгон шалгаруулалт маань бас нэлээн хугацаа авдаг учраас энэ хооронд нөгөө шүүгчийн ажлыг өөр хэн ч оролддоггүй их онцлогтой албан тушаал юм байна.

Прокурор дээр гэхэд прокурор орлоод яваад байдаг түр орлож байгаа юм. Шүүгч дээр болохоор шүүгчийн ажлыг өөр хүн орлоно гэдэг ойлголт байдаг уу? Энэнээсээ л улбаалаад юу үүсээд байгаа вэ гэхээр шүүхийн одоо тэр таван зуун далан шүүгч гээд байгаа. Энэний чинь үндсэндээ нэг жил тутам байнга арван хувь нь хэмнэлттэй яваад байдаг юм. Яагаад хэмнэлттэй яваад байдаг вэ гэхээр нөгөө энэ тэтгэвэрт гарч байгаа энэ насны завсар дээр нөгөө цонх үүсээд. Тэгээд нөгөө шүүхийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах, одоо юманд нөлөөлөөд. Нэн ялангуяа энэ Улаанбаатар хотын тухайд бол нөгөө хэрэг маргаан их ачаалалтай болчихсон. Тэгээд энэ дээр их нөлөөлөөд нөгөө бусад шүүгч дээрээ нэмэлт ийм ачаалал үүсгээд байгаа юм. Тийм учраас нөгөө шүүгч яг тэтгэвэрт гарах нас нь болох гэж байгаа бол тэрнээсээ одоо ерээс доошгүй хоногийн өмнө одоо тэр шүүгч мэдэгдэнэ шүү гэдэг тэр харилцаануудыг энэ зохицуулсан зүйл юм байгаа юм. Энэ гучин тавдугаар зүйл гээд. Нас нь дөчин ес дүгээр зүйл дээр яригдах юм. Тэр тэтгэвэрт гарах насных нь асуудал.

С.Бямбацогт: Гучин тавдугаар зүйлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Санал хураалт явуулъя ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зүйтэй саналаар санал хураалт явуулна. 23.Төслийн 35 дугаар зүйлийн 35.1-35.4 дэх хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 35.1-35.5 дахь хэсэг болгох:

35.1.Хуульчдаас шүүгчийг шилж олох, сонгон шалгаруулах, шүүгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх ажлыг Ерөнхий зөвлөл нээлттэй, ил тод, хараат бус байх, хууль дээдлэх зарчмыг баримтлан зохион байгуулна.

35.2.Ерөнхий зөвлөл дараах хугацаанд шүүгчийн сонгон шалгаруулалтын зарыг өөрийн цахим хуудас болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ:

35.2.1.шүүгч энэ хуулийн 49.6-д заасны дагуу өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол тэтгэвэр тогтоолгох өдрөөсөө 120-оос доошгүй хоногийн өмнө Ерөнхий зөвлөлд мэдэгдэх бөгөөд орон тоо гарахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө;

35.2.2.шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрэхээр байгаа бол орон тоо гарахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө;

35.2.3.энэ хуулийн 35.2.1, 35.2.2-т зааснаас бусад үндэслэлээр шүүгчийн сул орон тоо гарсан бол тухайн өдрөөс хойш 14 хоногийн дотор.

35.3.Энэ хуулийн 35.2-т заасан зард шүүгчийн сул орон тоонд нэр дэвшүүлэх болзол, шаардлага, өргөдөл, хавсралт баримт бичгийг хүлээн авах, бүртгэх, сонгон шалгаруулах хугацаа, журам, газрыг тодорхойлсон байна.

35.4.Энэ хуулийн 35.2-т заасан зарыг тухайн шүүгчийн ажиллах аймаг, нийслэлийн өдөр тутмын хэвлэлд нийтэлж болно.

35.5.Ерөнхий шүүгч тухайн шатны шүүхийн шүүгч, эсхүл өөрөө шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрэхээс 120-оос доошгүй хоногийн өмнө, бусад тохиолдлоор шүүгчийн сул орон тоо гарсан бол Ерөнхий зөвлөлд ажлын таван өдрийн дотор мэдэгдэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 12 гишүүний саналаар буюу 85,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн гучин зургаадугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Шүүгч нэр дэвшигчийг бүртгэх. Алга байна. Санал хураалт явуулъя ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрлийн саналаар санал хураалт явуулна.

24.Төслийн 36 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36 дугаар зүйл.Шүүгчид нэр дэвшигчийг өргөн мэдүүлэх

36.1.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 89.8-д заасан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор тухайн эрэмбийн дагуу зарлагдсан орон тоогоор анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг шүүгчээр томилуулах тухай саналыг Ерөнхийлөгчид, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах тухай албан бичгийг Улсын Их Хуралд холбогдох баримт бичгийн хамт хүргүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 12 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. 36 дугаар зүйлтэй холбогдуулан бичгээр гаргасан санал гишүүдээс алга байна.

Хуулийн төслийн 37 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Амарсайхан, Мөнхбаатар гишүүнээр тасаллаа. Амарсайхан гишүүн асуултаа асууя.

С.Амарсайхан: Энэ хуулийн 37.2.6 энэ хуулийн 37.2.1-д заасны дагуу шүүгчид нэр дэвшигчийн танилцуулга, холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор Улсын Их Хурал танилцах санал сонсголыг зохион байгуулна гэж байгаа юм. Зохион байгуулаагүй бол нэр дэвшигчийг танилцуулсанд тооцож ерөнхий шүүгч ерөнхийлөгчид бичиг явуулна гэсэн байгаа юм. Тэгээд энэ дээр би бас нэг зарчмын зөрүүтэй санал өгчхөөд байгаа юм. Бичгээр. Хэрэв Их Хурал томилох одоо сонсгол, танилцуулга сонсгол хийнэ л гэсэн бол хийх л ёстой. Хийхгүй бол хийсэнд тооцсоныг ерөнхий зөвлөлийн дарга, шүүгч, нэр дэвшигчийг тооцно гэж одоо Их Хуралд танилцуулснаар тооцно гэдэг нь өөрөө бас болохгүй байна гэж үзэж байгаа юм. Нэг бол одоо танилцах сонсголоо хий, хийхгүй бол энийг нэг бүр хасаж хая гэдэг ийм л одоо санал байгаа юм. Энэ дээр найруулгын шинж чанартай өөрчлөлт хийж танилцах сонсгол зохион байгуулж танилцаагүй бол тухайн нэр дэвшигчийг танилцуулсанд тооцох бөгөөд уг хугацаа дууссан өдрөөс хойш долоо хоногийн дотор

ерөнхий зөвлөлийн дарга, шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулсанд тооцсон талаар Ерөнхийлөгчид албан бичгээр мэдэгдэх гэдгийг хэсгийг хасъя гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл 90 хоногийн дотор Улсын Их Хурал танилцах сонсголоо зохион байгуулна л гэдэг нэг өгүүлбэрээр энэ зүйл заалтыг өөрчилж найруулъя гэсэн санал.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Хэрэв зохион байгуулахгүй байгаад байвал тэгээд л яах вэ? Хэн хариулах вэ? Мөнхсайхан, хоёрдугаар микрофон.

О.Мөнхсайхан: Энэ гучин долоогийн хоёрт улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчдээ Улсын Их Хуралд танилцах процессыг энэ хорин найман жилийн хугацаанд анх удаа ингэж хуульчилж байгаа. Урьд өмнө нь бол яасан бэ гэхээр ерөөсөө л Их Хуралд танилцана гээд орхичихсон. Энэ дээр бол нарийвчилсан процессгүй учраас яаж танилцах нь тодорхойгүй. Эсвэл Их Хурал танилцахгүй болбол тэгээд л тэр нэр дэвшигч одоо цаашаа Ерөнхийлөгчид өргө мэдүүлэгдэхгүйгээр үлдэх ийм байдал бол үүсэх зохицуулалт явж ирсэн. Гэвч Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгийн хоёрт бол шүүхийн ерөнхий зөвлөлөөс улсын дээд шүүхийн шүүгчийг Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно гээд маш тодорхой байгаа. Энэ заалтын цаад агуулга бол юу вэ гэхээр сонгон шалгаруулалт хийгээд гаргаж ирсэн хүнийг ерөнхий зөвлөл Их Хуралд танилцуулна. Тэгээд Ерөнхийлөгч томилно гэж байгаа.

Өөрөөр хэлбэл Их Хурал бол энд тэр дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчээс томилуулахаас татгалзах, тэр одоо танилцуулгыг хийхгүйгээр цаашаа Ерөнхийлөгч рүү явуулахгүй байх ийм бүрэн эрх бол Үндсэн хуулиар огт олгогдоогүй. Тийм учраас энэ бол ажлын хэсгийн гишүүн Сүхбаатар гишүүний саналаар энэ танилцах сонсгол гэдэг зүйлийг хийгээд ямар ч байсан ил тодоор тэр нэр дэвшигч дээд шүүхийн шүүгчид тавигддаг тэр өндөр шаардлагыг хангаж байна уу үгүй юу гэдгийг тал талаас нь хэлэлцдэг иргэдийн саналаар ил тод хэлэлцдэг процессыг хийгээд, тэгээд энийгээ бол 90 хоногт багтаагаад цаад талын хугацаа 90 хоногт багтаагаад хий гэдэг ийм нарийвчилсан журам орж ирж байгаа юм. 60-90 хоногийн дотор. Хэрэв энэ хугацаандаа хийхгүй байх юм бол энийг танилцсанд тооцоод Ерөнхий зөвлөлийн дарга бол тухайн нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид албан бичгээр мэдэгдэж уламжлах энэ Үндсэн хуулийн агуулгыг нь хадгалж байгаа.

Хэрэв энэ гучин долоогийн хоёрын зургаа аваад хаячих юм бол Их Хурал одоо томилуулмааргүй хүнээ бол цаашаа явуулахгүй, танилцахгүй үлдэх, үлдээх ийм үр дагавар бол үүснэ. Ингэснээр бол энэ өөрөө Үндсэн хуулийн зөрчил рүү орох ийм байдал байгаа учраас санкц байдлаар бол Их Хурал өөрөө энэ танилцах сонсгол хийх үүргээ энэ хангалттай хугацаандаа буюу жараас ерэн хоногийн дотор биелүүлэхгүй бол яах вэ гэдэг нь байж байгаа. Тэгэхээр Их Хурал маань бол энэ дээр одоо бүрэн хангалттай хугацаа байгаа учраас энэ ажлаа хийх боломжийг нэг талаас олгож байгаа, нөгөө талаас Үндсэн хуулийн зөрчил рүү орохоос сэргийлсэн ийм зохицуулалт байгаа юм.

С.Бямбацогт: Баярлалаа. Ажлын хэсгийн ахлагч Энхбаяр гишүүн нэмж хариулъя, нэг минут.

Б.Энхбаяр: Амарсайхан гишүүний асуултад хариулъя. Яах вэ энэ заалттай холбоотойгоор гишүүдийн бас мэдэхийг хүсэж сонирхож байгаа асуудал нь энэ саяхан бас манай Байнгын хороо улсын дээд шүүхийн нэр дэвшигч нь Батхүлэг гэж хүнтэй танилцахгүй гээд орхичихсон. Тэгээд энэ хүнд энэ заалт үйлчлэх юм уу, үгүй юм уу ч гэж бас сонирхож байж магадгүй. Энэ заалт дэмжигдсэн тохиолдолд дагаж мөрдөх журмын тухай хууль талаар бол энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш Улсын Их Хуралд танилцуулахаар нэр дэвшүүлсэн нэр дэвшигчдэд хамаарна гэдэг ийм тодотгол заалттайгаар явж байгаа гэдэг эрхэм гишүүдэд хэлье.

С.Бямбацогт: Мөнхбаатар гишүүн асуултаа асууя. Адьшаа гишүүний нэрийг нэмрээрээ.

Л.Мөнхбаатар: 37.5 дээр энэ ерөнхий шүүгчээ сонгох асуудлыг зохицуулсан байгаа юм. За улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчээс бусад шүүхийн ерөнхий шүүгчдийг одоо тухайн шүүгчдийнхээ зөвлөгөөнөөс гурван жилийн хугацаатайгаар сонгодог ийм зохицуулалт байгаа. Хуулийн төсөл дээр. Ажлын хэсэг энэ дээр бол бас дахиад нэг шинэ хувилбар дээр нь нэмсэн. Энэ хуулиар бол яг энэ зохицуулалтаар бас ерөнхий шүүгчээ сонгож чадахгүй байж магадгүй. Тийм учраас энэ ерөнхий шүүх сонгогдоогүй бол тухайн шүүхийн хамгийн ахмад настай шүүгчийн гурван жилийн хугацаагаар энэ зөвлөгөөнөөс томилно гээд заачихсан. Энд одоо саналыг ажлын хэсгийн саналыг бол агуулгын хувьд дэмжиж байгаа нь зүйтэй. Гэхдээ энд бас ахиад бас нэг ийм байдал үүсэж магадгүй байгаад байгаа. Ахмад шүүгч маань өөрөө татгалзвал яах вэ? Дараагийн ахмад шүүгч гэдэг ойлголт байх уу, үгүй юу. За яг аймаг дээр одоо аваад үзэхэд ялангуяа захиргааны хэргийн шүүх дээр харагддаг, тийм ээ. Нэг гурван шүүгчийн орон тоотой. Нэг хоёр нь орон тоо дутуу явж байдаг байдаг ч юм уу. Ийм асуудлууд үүсдэг.

Ерөнхий шүүгчээр ажиллаж байгаад хугацаа нь дууслаа гэж бодоход нөгөө гурван шүүгчээ чинь өөрийнх нь хугацаа дуусчихсан байдаг. Хоёр шүүгч дээрээ яаж энэ ерөнхий шүүгчээр сонгох вэ гэдэг ийм асуудлууд гарч ирнэ. Мөн бас зарим шүүгч нь бо ерөнхий шүүгчийн шаардлага хангахгүй байж болно. Зарим нь өөрсдөө бүр ерөнхий шүүгч болох сонирхолгүй байж болно шүү дээ. Энэ тохиолдолд яаж зохицуулах вэ гэдэг асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр энэ тохиолдолд гурав дахь хувилбар болгоод ижил шатны шүүхийн шүүгчдийг энэ ерөнхий шүүгч нэр дэвшүүлдэг байж болох уу? Одоо ажлын хэсгээс би асуух гээд байна л даа. Энэ ийм гарцыг гурав дахь хувилбар болгож нэмж өгөхгүй бол зөвхөн ахмад шүүгчээр орхих юм бол, ахмад шүүгч нь татгалзах юм бол ингээд л наад зүйл чинь ерөнхий сонгож чадахгүй байдалд хүрэх гээд байна шүү дээ. Тийм учраас ингээд ажлын хэсэг хуулийн төслийг хоёр дахь хувилбараар гарсан юм байна. Гурав дахь хувилбарыг нь одоо бас энэ дээрээ зарчмын зөрүүтэй саналаар юм уу та нар ингээд оруулаад ирэх юм бол уул нь ерөнхий шүүгчээ сонгох энэ асуудал чинь зохицуулалтын хувьд бол одоо тодорхой болох нь гэж хэлэх гээд байна.

С.Бямбацогт: Хэн хариулах юм. Энхбаяр гишүүн. Ажлын хэсгийн ахлагч.

Б.Энхбаяр: Мөнхбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр яг Мөнхбаатар гишүүний яг хэлж байгаа санаа зовж байгаа ийм асуудал бол ер нь бол гарна. За яагаад гарах вэ гэхээр энэ ерөнхий шүүгчийг томилох асуудал дээр бол цэвэр дээд

шатны удирдлага хүнээс биш дотоод ардчилалд нь томилгоог нь одоо өгч байгаа нь өөрөө энэ шүүхийн хуулийн бас нэг онцлог зохицуулалт болж байгаа. Магадгүй ерөнхий шүүгчид бие дааж шийдэх ийм эрх хэмжээ энэ хуулиар ер нь бараг олгоогүй. Өөрөөр хэлбэл өнөөдрийг хүртэл явж ирсэн ерөнхий шүүгч нь тийм бусад шүүгчийнхээ дарга байдалтай юм шиг, эсвэл ингээд хоёр давхар зарлигаар томилогдсон гэж бас бусдадаа жоохон зарим нэг нь аархдаг сураг билээ. Ийм одоо хэв шинж бол цаашдаа үгүй болох юм. Өөрөөр хэлбэл дарга хэв шинжээ алдана. Дарга хэв шинжээ алдаж байгаатай холбоотойгоор энэ Мөнхбаатар гишүүний яг санаа зовж байгаа. Өөрөө ер нь та одоо хүсэхгүй нөгөө нэр дэвшигч байхгүй байвал яах вэ гэдэг энэ асуудал бол гарцаагүй үүсгэх гээд байгаа юм.

Тийм учраас бол яах вэ энэ зохицуулалт нь бол хамгийн олон жил шүүгчээр ажилласан хүн нь ерөөсөө тэгээд л байя. Ингэлээ гээд бол яах вэ ерөнхий шүүгч нар дээр нэмэлт тийм нөгөө шүүн таслах ажлаа хийх тэр ажлын ачааллаас нь илүү их нэмэлт тийм ачаалал айхтар ирэхгүй. Яагаад гэхээр ерөнхий шүүгч өөрөө шийдвэрлэх тийм одоо заалт одоо энэ хууль дээр байхгүй байгаад байгаа юм. Бие дааж шийдэх. Яг бусад шүүх нартайгаа л адилхан. Зөвхөн нэг хуралд шүүгчдийнхээ зөвлөгөөнийг одоо зарлаж хуралдуулах түвшний. Тэгээд тэр зөвлөгөөнөөрөө шийдсэн асуудлыг нь албажуулж гарын үсэг зурах төдий ийм одоо ёсчилдог хүн болж байгаа учраас бол айхтар тийм асуудал гарахгүй явчих болов уу гэж ингэж найдаж байгаа юм.

С.Бямбацогт: Адьшаа гишүүн асуулт асууя.

Ш.Адьяа: Би энэ гучин долоогийн нэгд заасан шүүгчийг Ерөнхийлөгч томилохтой холбоотой асуудлаар саналаа хэлье гэж бодож байгаа юм. Монгол улсын Үндсэн хууль, хууль болон бусад хууль тогтоомжид зааснаар төрийн эрх мэдлийн хуваарилалт, томилогдох, томилох зарчмын тухай асуудлыг энд тодорхой ярьж бодож байна. Өнөөдөр бол шүүх эрх мэдэл, гүйцэтгэх эрх мэдэл, хууль тогтоох эрх мэдэл бол харилцан нэг, нэгэндээ хяналттай байж төрийн одоо үйл ажиллагаа явагддаг. Дээр нь Монголын ард түмнээс сонгогдсон Ерөнхийлөгчийн институтын оролцоо энд байж байж энэ шүүх эрх мэдлийн үйл ажиллагаа явагдах ийм үндсэн хуулийн ойлголт байгаа. Гэтэл өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгч тэр шүүхийн ерөнхий зөвлөл Улсын Их Хурлын сонсгол хийсэн хүмүүсийг шууд томилохыг энэ хуулиар үүрэг болгосон байна.

Энэ бол Үндсэн хуулийн зөрчлийн асуудал гэж үүсэж байгаа юм. Түрүүчийн долоо хоногт ирэх онд урд онд бид нар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийг баталсан. Энэ дээр Монгол Улсын Ерөнхий сайд доод шатны засаг даргыг томилох тухай, түүний бүрэн эрхийн тухай, томилгооны зарчмын тухай асуудлыг хуулиар баталгаажуулсан. Ерөнхий сайд доод шатны засаг даргыг томилж болно, буцааж болно. Тэгэхдээ бүр өөр хүнийг санал болгоно гэдэг ийм асуудлыг хуулиар баталгаажуулж өгсөн шүү дээ. Гэтэл өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгч сонгон шалгаруулалтад оролцоогүй, Улсын Их Хурлын сонсгол хийсэн гэх тэр хүмүүсийг хэдэн хоногийн дотор томил гэдэг ийм үүрэг чиглэл өгөх нь Үндсэн хуулийн хямрал зөрчил гэж үзэж байгаа. Тийм учраас энэ одоо асуудлыг яагаад ийм байдлаар оруулсан юм бэ гэдгийг ажлын хэсгийн гишүүд бас тайлбарлах байх. Тэгэхдээ би энэ дээр зарчмын зөрүүтэй саналыг оруулж байгаа юм. Энэ төрийн эрх

мэдлийн хуваарилалтын зарчим гэдэг юм чинь энд өнөөдөр хэрэгжих юм уу, хэрэгжихгүй юм уу. Энийг ярих юм уу, ярихгүй юм уу. Ерөнхийлөгчийн бүх л юмыг авч хаядаг. Бүх юмыг гүйцэтгэх засаглал, хууль тогтоох засаглал руу шилжүүлж байгаа энэ үйл явц чинь ямар үр дагавартай болохыг та нар мэдэж байгаа юм уу.

Хэдэн жил ингэж олонхоороо өнөөдөр энэ төрийг барьж, энэ шүүх эрх мэдэл, төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг алдагдуулсан энэ үйл ажиллагаа чинь хэвийн үйлчлэх юм бэ? Өнөөдөр тэр томилгооны сонсгол хийсэн гэж байгаа юм. Ерөнхий зөвлөлөөс сонгон шалгаруулсан гэж байгаа юм. Энэ хүмүүсийн чинь талаар нэг ч ажиллагаанд оролцоогүй Монгол Улсын Ерөнхийлөгч шууд томилоод зарлиг гаргаад гэдэг ийм үүргийг өгөх нь өнөөдөр ардчилсан Үндсэн хуультай, хууль.../минут дуусав/

С.Бямбацогт: Адьшаа гишүүн нэг минут.

Ш.Адьяшаа: Ерөнхийлөгчийн эрх мэдлийг л хязгаарлаж л байвал өнөөдөр тэр Үндсэн хуулийн суурь зарчмаа зөрчинө үү, төрийн эрх мэдлийн хуваарилалтын зарчим алдагдана уу энд хамаагүй шиг байдлаар ойлгож энэ хуулийг ажлын хэсэг ажилласан. Ний нуугүй ярихад. Энийг эргэж харж үзэж болдоггүй юм уу. Энэ Ерөнхийлөгч чинь насаараа сонгогдохгүй шүү дээ. Бид зургаан жилийн асуудал биш жаран жилийн асуудлыг өнөөдөр ярих ёстой шүү дээ. Тэгээд ингээд л өнөөдөр Улсын Их Хурлын оруулж ирсэн Ерөнхий сайдын эрх мэдлийн томилгоо нэг өөр байдаг. Ерөнхийлөгчийн эрх мэдлийн томилгоо нэг өөр байдаг гэдэг ийм хуулийг яаж гаргаж ирж байгаа юм бэ? Энэ чинь төрийн эрх мэдлийн хуваарилалт, томилогдох, томилох зарчим гэдэг чинь өөр онолтой байдаг биз дээ. Энэ дээр одоо бас Энхбаяр гишүүнээс.../үг тасрав/

С.Бямбацогт: Хэн хариулах вэ, Энхбаяр гишүүн. Сүхбаатар гишүүн ажлын хэсгийн гишүүн Сүхбаатар гишүүн хариулъя.

Ж.Сүхбаатар: Баярлалаа, эрхэм гишүүн Адьяшаагийн асуултад хариулъя гэж. Хэн Мөнхсайхан доктор бол хэлсэн л дээ. Нөгөө танилцах сонсголын асуудлыг би ажлын хэсэг дээр хэлсэн юм. Үндсэн хуульд зааснаар бол шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчдийг танилцуулснаа Улсын Их Хуралд танилцуулснаар гэж байгаа юм. Тэгэхээр энэ дандаа бид нар чинь Улсын Их Хурал дээр юм эрх мэдэл авах гээд байгаа юм биш ээ. Түрүүн Алтанхуяг гишүүн ч хэлсэн. Энэний цаана дандаа тийм хяналт, тэнцвэр байгаад байгаа юм. Тэнцвэр. Тэгэхээр Улсын Их Хурал гэдэг бас нэг энэ хуулиар бас өөрийнхөө зарим эрхийг хязгаарлаж байгаа. Одоо ингээд танилцахгүй орхиод байж бас болохгүй. Танилцуулна гээд шүүхийн ерөнхий зөвлөл асуудал нэр дэвшигчийгээ ингээд явуулчихаар Улсын Их Хурал нь бүхэл бүтэн гурван сар болж байхад бас танилцахгүй суугаад байж болохгүй. Тэгэхээр танилцах бол бас Улсын Их Хурлын үүрэг. Улсын Их Хуралд хүлээлгэж байгаа үүрэг. Тэгээд энэ хугацаандаа багтаж тэр танилцах сонсголоо хий. Хийхгүй бол шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Их Хурал тэр нэр дэвшигчээ тэр бичгээр тэр нэр дэвшигчийнхээ танилцуулгыг өгчихсөн юм чинь Улсын Их Хурал тэрийг танилцсанд тооцоод ингээд явж байгаа.

Ер нь тэр цаад Ерөнхийлөгчийг ч гэсэн томилох үүрэг гэж. Ер нь бид нар дандаа эрх гэдгээ бас үүрэг гэж харах ёстой. Одоо ер нь заримдаа бүр хүмүүст

зориулаад энэ бүрэн эрхтэй гээд заачихсаныгаа одоо салгаж бичдэг юм уу, яадаг юм. Уг нь энэ хуулийн нэр томъёогоор бүрэн эрх дотор чинь эрх, үүрэг явж байгаа. Тэгэхгүй бол хүмүүс бүрэн эрх гэххээд үгүй ээ энэ чинь ганцхан эрхийн эрх л эдлэх гээд байна шүү дээ. Үгүй л дээ. Тэгэхээр энэ Улсын Их Хурал бол танилцах тэр үүрэг хүлээж байгаа утгаараа тодорхой цаг хугацаа тавьж байгаа нь хариуцлагажуулж байгаа юм. Тэгээд тэр үүргийг биелүүлэхийг бас шаардаж шахаж байгаа юм. Энэ утгаараа бол энэ заалт бол ингэж орж байгаа. Энэ бол хангалттай зохистой рационал ийм хугацаа гэж бодож байгаа. Гурван сар. Гурав бүхэл бүтэн гурван сар шүү дээ. Хүнээ өгчхөөд асуудал танилцах.

Дээр нь, бас Улсын Их Хурал ч гэсэн юу юугүй бас богино хугацаанд шахагдахгүй байх бололцоо бол энэ хугацаанд бас харагдаж байгаа юм. Энэ хугацаанд ер нь бол тэр нэр дэвшигч нөхөр бол бүх байдгаа л онгичуулах ёстой шүү дээ. Улсын Их Хуралд материал нь ирчихсэн, гэнэтийн гэнэдүүлсэн тийм байдлаар гэнэт томилгоо танилцуулах гэдэг юм уу, ажиллагаанууд хийгдэхгүй байх энэ юмнууд бол энд суугдчихсан байгаа. Ер нь Монголын өнгөрсөн он жилүүдийн парламент дахь хийгдэж байгаа томилгоонуудын нэг аюул бол юунд байсан бэ гээд судлаачид үзэхээр зэрэг улс төрийн хүрээнд бол маш богино хугацаанд нөгөө гялалзуулна гэдэг шиг ингээд томилгоо хийчихдэг. Тэр хүнтэй танилцах боломжийг Улсын Их Хуралд танилцах боломж олгоно гэдэг нь иргэдэд олгож байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм одоо байдлаараа бол энэ энэ заалтууд орж ирсэн.

Тэрнээс биш энэ бол Улсын Их Хурлыг бол шахсан, хязгаарласан заалт юм шүү. Бас бас үүргийг нь биелүүлэхийг нь тулгаж шахаж байгаа юм шүү. Дээр нь бас Улсын Их Хуралд бас том боломж олгож байх хугацаа бас гурван сар ингээд. Аль аль нь л багтаж байгаа. Ийм л юм байгаа юм.

С.Бямбацогт: Ерөнхийлөгчийн одоо томилж байсан бүрэн эрх рүү яагаад халдаад байгаа юм бэ. Заавал Их Хурал, Засгийн газарт авах гээд байгаа юм уу гэсэн асуултад л хариулт ажлын хэсэг хоёрдугаар микрофон Мөнхсайхан гишүүн. Мөнхсайхан багш.

О.Мөнхсайхан: Баярлалаа. Тэгэхээр ер нь бол энэ Засгийн газрын өргөн барьсан төсөл, ажлын хэсгээс гарч байгаа саналын нэг амин сүнс бол энд одоо орж байгаа аливаа бүрэн эрхийг яаж хэрэгжүүлэх вэ гэдгийг бүх субъектээр процессжуулж өгч байгаа. Жишээлбэл Их Хурал дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцана гэдэг процессгүй байсныг сая ярьснаар ингээд процессжуулсан. Эсвэл шүүгчийг яг яаж шалгалт авах юм? Сонгон шалгаруулах юм гэдэг маш нарийн процессдоо бичиж байгаа. Яг энэнтэй адилхан, өөрөөр хэлбэл Их Хурал болон бусад субъектийн бүрэн эрхийг яаж хэрэгжүүлэхийг процессжуулж байгаадаа хугацаа тавьж байгаатай адилхан Ерөнхийлөгчийн Үндсэн хуульд байж байгаа бүрэн эрхийг бас адилхан л процессжуулж аль алин дээр нь процессжуулж өгч байгаа. Өөрөөр хэлэх юм бол ерөнхий зөвлөл сонгон шалгаруулалт хийгээд тэрний үр дүн дээр гарч ирсэн эрэмбээр тухайн орон тооны, тоогоор санал болгосон хүнийг Ерөнхийлөгч арван дөрвөн хоногийн дотор томилно гэж заасан. Одоо энэ өргөн барьсан төсөл дээр байж байгаа.

Тэгээд хэрэв энэ төслийн гучин дөрөвдүгээр зүйлд жагсаасан, одоо мэргэжлээрээ ажилласан байх шаардлага, ял шийтгэлгүй байх шаардлага зэрэг тэр зүйлүүдийг хангаагүй гэсэн үндэслэл байх юм бол Ерөнхийлөгч тэр үндэслэлээ хэлээд албан ёсоор одоо ерөнхий зөвлөлд мэдэгдэх энэ зохицуулалт бол гучин долоогийн хоёрт орчихсон байж байгаа. Тэгэхээр энэ бол Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрх рүү ерөөсөө халчихсан юм бол байхгүй. Харин энэ томилгоогоо яаж хийх вэ? Энэ дээр хэрвээ Үндсэн хуулиар тавьчихсан тэр шаардлага хуулиар тавьчихсан болзол шаардлагыг хангаагүй бол яаж татгалзах вэ гэдгийг нь нарийвчилж өгч байгаа. Тэгээд энийг зааж өгөөгүйгээс өнгөрсөн хугацаанд бол маш ноцтой зүйлүүд гарч байсан. Жишээлбэл 2013, 15 онд бол шүүх анхан болон давж заалдах шатны шүүхүүдийг өөрчлөн байгуулаад Монгол Улсын анхан, давж заалдах шатны бүх шүүгчдийг чөлөөлчхөөд арван гурван шүүгчийг зүгээр л томилоогүй үлдээчихсэн. Одоо ч гэсэн энэ бол шийдэгдээгүй. Тэр шүүгч нар нь шүүхэд хандаад, цэцэд хандаад одоо бүтэн долоон жил бол энэ асуудлаа шийдүүлж чадаагүй явж байгаа юм.

Энэний цаад шалтгаан бол юу вэ гэхээр ерөөсөө Ерөнхийлөгчийн энэ Үндсэн хуулийн ерөнхий зөвлөлийн саналаар шүүгчийг томилно гэсэн энэ бүрэн эрхийг тодруулсан процесс байхгүй. Хугацаа байхгүй, татгалзах үндэслэл байхгүй. Энэнээс болоод одоо янз бүрийн асуудал үүсэж байсан. Тэгээд Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгийн хоёрт бол юу гэж заасан бэ гэхээр ерөнхий зөвлөлөөс санал болгосон хүнийг Ерөнхийлөгч томилно гэж байж байгаа юм. Томилж болно гэж бичээгүй. Томилох бүрэн эрхтэй гэж бичээгүй. Тэгэхээр ер нь Үндсэн хууль дээр бол томилно гэж тэгнэ ингэнэ гэж бичиж байгаа бол цаанаа дандаа үүрэгжүүлсэн утгыг агуулж байдаг. Энэ Үндсэн хууль байж байгаа болзол, хуульд тавьчихсан тодорхой шаардлагыг хангаж уу үгүй юу гэдгийг нягтлаад тэр хангагдсан бол томилох үүрэгтэй Үндсэн хуулиар. Энэ болбол тогтчихсон манай Үндсэн хуулийн эрх зүйн номлол.

Ийм үндэслэл байхгүй байж байхад тэр арван гурав, арван таван оны кейс шиг ямар ч шалтгаан хэлэхгүй одоо долоон жил дарчихдаг ч юм уу, эсвэл одоо үзэмжээрээ дур зоргоороо ханддаг энэ зүйл бол өөрөө энэ практик нь Үндсэн хуулийн эсрэг байсан. Тэгэхээр энийг засаж процессжуулж ингэж Засгийн газрын төсөл ажлын хэсгийн саналаар орж ирж байгаа нь бол манай өнгөрсөн хугацаанд гарсан энэ одоо алдаа завхралыг засах маш чухал ийм зохицуулалт байгаа юм. Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийн одоо энэ бүрэн эрх рүү бол халдаагүй. Тэгээд бас нэг юмыг нэмээд хэлэхэд ерөнхий зөвлөлийн арван гишүүний тав нь бол шүүгчид байна. Шүүгчдээсээ сонгогдоод гарч ирнэ. Нөгөө тавыг нь шүүгч биш тавыг нь сонгон шалгаруулах тэр мэргэжлийн ажлын хэсэг бол арван нэгэн гишүүнтэй байна гээд хойно далан наймдугаар зүйл дээр далан есдүгээр зүйл дээр зохицуулж байгаа. Тэр арван нэгэн нөгөө сонгон шалгаруулах ажил хийх бүрэлдэхүүнд Ерөнхийлөгчийн бас санал болгосон нэг хүн орно гэдгээр бас оролцоо нь бол тодорхой хэмжээгээр тэр мэргэжлийн сонгон шалгаруулалтад оролцох оролцоо бол.../минут дуусав/

С.Бямбацогт: Сүхбаатар гишүүн ажлын хэсгийн гишүүн. Нэг минут.

Ж.Сүхбаатар: Энэ томилгооны асуудал зүгээр Мөнхсайхан багшийн хэлдэг дээр нэмээд нэг хэлэхэд энэ хуучин бол бид нар ийм байсан юм томилгоон дээр сонгох, томилох, батлах гэсэн гурван арга байсан юм. Тэгээд манай энэ шинэ системд шилжсэнээс хойш бол батлах арга нь байхгүй болоод тэгээд томилгоо нь

бол хоёр янзын томилгоо байгаа. Батламжилдаг маягийн одоо үүрэг хүлээсэн томилгоо, эрх эдэлж татгалзаж болдог бас томилгоо гэсэн ийм хоёр агуулгатай юм яваад байгаа байхгүй юу. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар цэцээс гэсэн тогтоосон юмаар засаг даргад нэр дэвшигчийг нэг удаа татгалздаг. Дараачийн удаа дээд шатны засаг дарга юм уу, эсвэл Ерөнхий сайд нь шууд томилдог. Тэгэхээр энэ тэр, энэ тохиолдолд гэхэд томилгоо бол үүрэг болж очдог. Бид нар Ерөнхий сайдыг томилдог бас татгалзаж болдог, тэр бол Улсын Их Хурлын эдэлж байгаа эрх гэдэг юм уу. Тэгэхээр энэ томилгоо бол хоёр янзаар явж байгаа. Тэгэхээр Ерөнхийлөгчийн энэ тохиолдох томилгоо бол батламжлах ёсчлох төрийн тэргүүний тэр эрхийн хүрээнд хийгдэж байгаа томилгоо байхгүй юу. Тэгэхээр энийг бас.../минут дуусав/

С.Бямбацогт: Нэг минут Адьшаа гишүүн.

Ш.Адьяа: Үндсэн хууль бичихэд нэг дээр үеийн ажлын хэсэг дээр чинь ийм л юм ярьж байсан, миний дүү чи бас их зарчимтай юм яримаар байна. Энэ Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрх гэдэг асуудалд ийм байдлаар хандаж болохгүй. Энэ Үндсэн хуулийн зөрчил шүү. Энийг зүгээр энд би протоколд албан ёсоор тэмдэглүүлчихье. Дээр нь тэр Ерөнхий сайд хүн томилохдоо нэг хууль барьдаг, Ерөнхийлөгч хүн томилохдоо нэг хууль барьдаг тухай л би надад ялгааг нь гаргаад өгөөч л гэж би Сүхбаатараас ч асууж байгаа, Энхбаяраас ч асууж байгаа шүү дээ. Би тэр ажлын хэсгийн гишүүн, тэр хуульч судлаачийг би энд нэг тайлбар хийж өг гэж хэлээгүй. Дэд хэсгийн. Энийг л надад хариулж өгөөч л гэж байгаа юм.

С.Бямбацогт: Энхбаяр гишүүн ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Б.Энхбаяр: Адьяа гишүүний асуултад хариулъя. Шүүх эрх мэдлийн томилгоонд Ерөнхийлөгч нэг хугацаатай, Ерөнхий сайд нэг хугацаатай гэдэг энэ бол ташаа мэдээлэл байна. Яагаад гэхээр шүүгч нарыг томилох асуудалд Монгол Улсын Ерөнхий сайд оролцдоггүй. Угаасаа тийм тусдаа хугацаа гэж байхгүй. Ямар ч оролцоо байдаггүй. Зөвхөн Ерөнхийлөгч одоо өнөөдрийг хүртэл томилж ирсэн. Тэр байтугай бүх шатны ерөнхий шүүгч, шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн ёс зүйн хороо, мэргэшлийн хороо гээд бүх одоо томилгоо бол нэг төвлөрсөн удирдлагатай явж ирснийг та мэдэж байгаа. Тэгээд энэ яагаад ер нь Үндсэн хуулийнхаа үзэл санааны хүрээнд нийцэхгүй байна уу гээд тэгэхээр бүх л судалгаа бүх шатны л одоо дүгнэлтүүдээр энэ нэг л болохгүй байна гэдэг юм бол хангалттай гарчхаад л байгаа шүү дээ. Үндсэн хуулийн өөрчлөлт ч гэсэн яг энэ хүрээнд хийгдсэн гэж ингэж.../минут дуусав/

С.Бямбацогт: Төслийн гучин долоодугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, гишүүд гучин долоо байх. Тий. Асуулт асууж хариулт авлаа. Санал хураалт явуулъя. Ажлын хэсгийн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулна.

25.Төслийн 37 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 37.2 дахь хэсэг нэмж, 37.2 дахь хэсгийн “хуульд” гэснийг “энэ хуулийн 34 дүгээр зүйлд” гэж өөрчилж, 37.4, 37.5 дахь хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулах, 37.4-37.7 дахь хэсэг болгох:

“37.2.Улсын Их Хурал Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй дараах журмаар танилцана:

37.2.1.шүүгчид нэр дэвшигчийн танилцуулга, холбогдох баримт бичгийг Улсын Их Хурал чуулганы үеэр хүлээн авсан бол 14 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт хүлээн авсан бол ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/ нэр дэвшигчийн талаарх танилцах сонсголын товыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлаж, нэр дэвшигчийн танилцуулга, холбогдох баримт бичгийг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах бөгөөд хувь хүний нууцад хамаарах мэдээллийг нийтлэхгүй;

37.2.2.энэ хуулийн 37.2.1-д заасны дагуу танилцах сонсголын товыг нийтэд зарласнаас хойш 14 хоногийн дотор сонирхсон этгээд шүүгчид нэр дэвшигчээс асуух асуулт, саналаа Байнгын хороонд ирүүлж болох бөгөөд нэргүй асуулт, саналыг хүлээн авахгүй;

37.2.3.Байнгын хороо энэ хуулийн 37.2.2-т заасан хугацаа өнгөрснөөс хойш 14 хоногийн дотор танилцах сонсголыг зохион байгуулах бөгөөд зохион байгуулах журмыг Байнгын хороо батлах;

37.2.4.энэ хуулийн 37.2.3-т заасны дагуу танилцах сонсгол зохион байгуулснаас хойш 14 хоногийн дотор шүүгчид нэр дэвшигч болон сонсголын тайланг Байнгын хороогоор хэлэлцэж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах;

37.2.5.энэ хуулийн 37.2.4-т заасны дагуу чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулснаас хойш ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын дарга нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулсан талаар Ерөнхийлөгчид албан бичгээр мэдэгдэх;

37.2.6.энэ хуулийн 37.2.1-д заасны дагуу шүүгчид нэр дэвшигчийн танилцуулга, холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор Улсын Их Хурал танилцах сонсгол зохион байгуулж танилцаагүй бол тухайн нэр дэвшигчийг танилцуулсанд тооцох бөгөөд уг хугацаа дууссан өдрөөс хойш 7 хоногийн дотор Ерөнхий зөвлөлийн дарга шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулсанд тооцсон талаар Ерөнхийлөгчид албан бичгээр мэдэгдэх.”

“37.4.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүх санал болгосноос хойш Ерөнхийлөгч 14 хоногийн дотор зургаан жилийн хугацаагаар, зөвхөн нэг удаа томилно.

37.5.Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг тухайн шүүхийн Зөвлөгөөнөөс нууц санал хураалтаар гурван жилийн хугацаагаар олонхын саналаар сонгох бөгөөд нэг удаа улируулан сонгож болно.

37.6.Энэ хуулийн 37.5-д заасны дагуу Ерөнхий шүүгчид нэр дэвшээгүй бол шүүгчээр хамгийн олон жил ажилласан шүүгчийг гурван жилийн хугацаагаар тухайн шүүхийн Зөвлөгөөнөөс томилно. Тийм санал хураалттай юм байна. Ажлын хэсгийн

гаргасан санал. Энэ саналаар дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ. 13 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 76.9 хувийн саналаар. Одоо хуулийн төсөлтэй холбогдон гишүүдийн бичгээр гаргасан саналуудыг санал хураана. Гишүүд санал гаргахдаа нөгөө хуулийн төсөл дээр санал гаргана. Гишүүдийн гаргасан ажлын хэсгийн гаргасан санал дээр биш. Хуулийн төсөл дээр санал гаргана гэдгийг бас ойлгоорой. Нямбаатар гишүүн. Энэ гучин долоогийн долоо дахь санал ажлын хэсгээс гаргасан санал байгаа. Ажлын хэсгийн санал бол Танхимын тэргүүнийг тухайн шүүхийн Зөвлөгөөн дотроосоо нууц санал хураалтаар, гурван жилийн хугацаагаар сонгох бөгөөд түүнийг нэг удаа улируулан сонгож болно.” Гэж ажлын хэсэг санал гаргасан.

Яг энэ заалтыг Нямбаатар гишүүн танхимын тэргүүнийг тухайн шүүхийн зөвлөгөөний саналыг үндэслэн тухайн шүүхийн ерөнхий шүүгч гурван жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө. Танхимын тэргүүнийг нэг удаа улируулан томилж болно гэсэн санал гаргасан байна. Тэгэхээр ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулна. Ажлын хэсгийн санал. Нямбаатар гишүүн тайлбарлах уу? Нямбаатар гишүүн саналаа тайлбарлая. Ажлын хэсэг бас саналаа тайлбарлаж болно.

Х.Нямбаатар: Саяын санал дээр би зүгээр энэ хуулпау хэлэлцүүлж байгаа энэ процесс маань угаасаа протоколд тэмдэглэгдээд хуулийн хувийн хэрэг үлдэнэ. Би тийм учраас зориуд хэлж байгаа юм. Хөдөө орон нутагт гурван шүүгчтэй, дөрвөн шүүгчтэй газар байгаа. Тэгээд энэ дотор дотроо сонгууль явуулаад дотроосоо нэгийгээ ерөнхий шүүгчээр сонгоод ээлжилж, ингээд ээлж халаатай явна гэдэг энэ зохицуулалт бол маш хүнд болно. Өөрөөр хэлбэл хүний нөөцийн хувьд. Тэгэхээр энэ бол би миний энэ санал дэмжигдэхээргүй харагдаж байна. Би дараа нь энэ яг асуудал маань газар дээрээ хэрэгжээд, хэрэгжээд тэгээд хүндрэл үүсээд ирэхэд энэ протоколыг би иргэд сануулж бас ярья гэж бодож байгаа юм. Бид нар бас өнөөдөр өөрийнхөө энэ өнөөдрийн байгаа эрх зүйн тогтолцооныхоо онцлогийг харгалзаж үзэх хэрэгтэй гэж хэлэх гэсэн юм. Миний бас нэг гаргасан энэ яг санал хураах гэж байгаа санал маань бол ерөнхий шүүгч, шүүгчдийн зөвлөгөөний саналыг үндэслэж танхимын тэргүүнийг томилъё гэдэг энэ зүйл оруулж ирж байгаа.

Бид өнөөдрийн байгаа шүүхээр эсхүл бол бид одоо өнгөрсөн шүүхээр энэ шүүхийн хуулийг төсөөлж, бодож хийж болохгүй байх гэж бодож байгаа юм. Монгол Улсын Үндсэн хуульд заасан цөөхөн хэдэн албан тушаалтны нэг бол Монгол Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч. Өнөөдөр энэ шүүхийн хуулийн төсөл дээр дээд шүүхийн ерөнхий шүүгч гэдэг албан тушаалыг хасчихвал зүгээр байгаа юм. Хасчихвал. Энэ хүн ерөөсөө жилд нэг юм уу, хоёр удаа нийт шүүгчдийн дээд шүүхийн нийт шүүгчдийн зөвлөгөөнийг л хуралдуулах үүрэгтэй. Өөр ямар ч эрх үүрэггүй болсон. Нэг танхимдаа орж ажиллана. Танхимынхаа тэргүүнд базагдана өөр ямар ч чиг үүрэг энэ хүнд үлдээгүй. Тийм учраас бараг одоо энэ улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч гэдэг албан тушаалыг Үндсэн хууль зөрчөөд хасчихвал бараг энэ төсөл маань бараг шулуун зам руугаа орох гээд байгаа юм. Тэгэхээр би дээд шүүхийн ерөнхий шүүгчид ямар хоёр эрх үлдээе гэж хэлээд байгаа вэ гэхээр нэгдүгээрт улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч танхим харгалзалгүй, тэр тохиолдлын журмаар хэрэгтээ харьяалалдаа аль нэг танхимдаа харьяалагдаж хэрэг, маргаан шийтгэх ажиллагаанд оролцдог.

Хоёр дахь нь өөрөө шүүгчдийн зөвлөгөөнийхөө саналыг үндэслэж тухайн танхимын тэргүүнийг батламжилж томилдог энэ эрх хоёрыг нь үлдээчихвэл уг нь наад Үндсэн хуульд байгаа. Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч гэдэг тэр албан тушаал чинь бас эргэж харагдах юм. Үгүй бол аль нэг танхимын тэргүүндээ захирагдсан, жилд нэг удаа шүүгчдийн зөвлөгөөнийг хуралдуулдаг ийм л чиг үүрэгтэй албан тушаалтан болж үлдэж байгаа. Тэрийг хэлэх гэсэн юм. Тийм учраас та бүхэн бодоорой. Ийм хоёр асуудлыг эргэж хожмын хойчид би протоколд тэмдэглүүлж байгаа.

С.Бямбацогт: Ажлын хэсгээс тайлбар байгаа юу саналаа тайлбарлах хураалгах уу, байхгүй юу. Гишүүд анхааралтай байгаарай. Ажлын хэсгийн саналаар санал хураалгана дэмжигдэх юм бол ажлын хэсгийн томьёолол хэвээрээ үлдэнэ. эмжигдэхгүй бол Нямбаатар гишүүний саналаар томьёологдоно. 37.7.Танхимын тэргүүнийг тухайн шүүхийн Зөвлөгөөн дотроосоо нууц санал хураалтаар, гурван жилийн хугацаагаар сонгох бөгөөд түүнийг нэг удаа улируулан сонгож болно.” Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Дараагийн санал Адьшаа гишүүн санал гаргасан байна. Гучин долоогийн нэгд өөрчлөлт оруулъя. Анхан болон давах шатны шүүхийн шүүгчийг ерөнхий зөвлөлийн санал болгосноор хяналтын шатны шүүхийн шүүгчийн ерөнхий зөвлөл Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно. Саналаа тайлбарлах уу та. Адьшаа гишүүн саналаа тайлбарлаж үг хэлье.

Ш.Адьшаа: Энэ ямар учиртай гэж яриад байгаа юм гэхээр ер нь Монголын ард түмнээс сонгогдсон энэ Ерөнхийлөгчийн бүрэн эрхтэй холбоотой энэ шүүх засаглалтай холбоотой энэ асуудлыг л яриад байгаа юм. Үгүй ээ, одоо энэ ажлын хэсгийн гишүүдээс асуухаар одоо яагаад байгаа юм нь Энхбаяр одоо чи Ерөнхий сайд, шүүгчийг томилдоггүй гэж. Би Ерөнхий сайд, шүүгч томилох тухай яриагүй шүү дээ. Орон нутгийн засаг захиргаа, түүний удирдлагын тухай хуулиар Ерөнхий сайд доод шатны засаг даргыг томилох тухай нэг өөр ойлголт байн. Ерөнхийлөгч шүүгчдийг томилох тухай нэг ойлголт байна л гэсэн. Тэр хуулиар доод шатны иргэдийн хурлын санал болгосон хүнийг Монгол Улсын Ерөнхий сайд томилж болно, буцааж болно, өөр хүн дэвшүүлж болно гэсэн ийм хуулийг та нар баталчхаад. Хэдхэн хоногийн дараа Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу шүүх эрх мэдлийн томилгооны асуудал дээр Ерөнхийлөгчийг зүгээр Их Хурлын санал болгосон хүнийг шууд томилдог ийм хуулийг оруулж ирж Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд халдаж байгаа юм.

Энэ өнөөгийн Ерөнхийлөгчид хамаатай асуудал биш. Энэ бол үе үеийн Ерөнхийлөгчид хамаатай асуудал учраас ингэж яриад байгаа юм. Тэрнээс биш өнөөдрийн энэ Ерөнхийлөгчийг хамгаалсан тэрнийг одоо эрх мэдлийг нь өргөжүүлэх гэсэн тийм одоо байдлаар авч үзэхгүй байхыг хүсье. Тийм ямар ч тийм бодол байхгүй. Гэтэл өнөөдөр тэр томилогдох зарчим, Үндсэн хуулийн томилгооны асуудал гэдэг чинь өөр ойлголт шүү дээ. Өнөөдөр тэр хүн ямар ч хүн хүнийг мэдэхгүйгээр, тэр судлах боломжийг нь хангагдахгүйгээр Улсын Их Хурлаас ирүүлсэн хүнийг том шууд томилдог, хэдэн хоногийн томилохгүй бол Үндсэн хууль зөрчинө гэдэг ийм зүйлийг заасан хуулийг өнөөдөр оруулж ирж байгаа нь үнэхээр учир дутагдалтай байгаа юм.

Тийм учраас энийг Монгол Улсын Ерөнхийлөгч арван дөрвөн хоногийн дотор биш тэр шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгож, Улсын Их Хурлын хурлаар томилгооны сонсгол хийсэн хүнийг Ерөнхийлөгч томилно л гэсэн ийм саналын томьёоллыг оруулж байгаа юм.

Тэрнээс биш арван дөрвөн хоногийн дотор томил, томилохгүй бол хууль зөрчөө шүү гэж байгаа нь энэ өөрөө Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд халдсан. Өөрөө Үндсэн хуулийн зөрчил рүү авч явж байгаа асуудлууд байгаа учраас тэр арван дөрвөн хоног.../минут дуусав/

С.Бямбацогт: Энд юу гишүүд байх юугүй л дээ. Саналаа тайлбарлаж үг хэлнэ. Тэгэхээр гучин долоогийн нэг бол бас Адьшаа гишүүн зөв жоохон ойлголтын зөрүү байх шиг байна. Ажлын хэсэг хөндөөгүй байна. Засгийн газрын өргөн барьсан төсөл дээр гучин долоогийн нэг анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор, хяналтын шатны шүүхийн шүүгчийг шүүхийн ерөнхий зөвлө Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч арван дөрвөн хоногийн дотор томилно гэж одоо хоёр мянга хорин оны дөрвөн сард өргөн барьсан хуулийн төсөлд яг ийм заалт байж байна. Энийг ажлын хэсэг ерөөсөө хөндөөгүй байна. Та бол Засгийн газраас өргөн барьсан төсөл дээрх Ерөнхийлөгч арван дөрөв хоногийн дотор гэдгийг л авч хаяа гэсэн санал гаргаж байгаа юм байна, тийм үү? Гишүүд бас ойлгосон байх. Адьшаа гишүүний саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос санал дэмжигдсэнгүй. Та өөрөө дэмжихгүй байна шүү дээ. Тэр үг хэлэхийн тулд үг хэлдэг юм уу хаашаа юм. Энэ санал дэмжигдсэнгүй. Амарсайхан гишүүн санал гаргасан байна. Гучин долоодугаар зүйл дээр 90 хоногийн дотор Улсын Их Хурал танилцах сонсгол зохион байгуулсны дараа ерөнхий зөвлөлийн дарга, шүүгчид нэр дэвшигчийг Ерөнхийлөгч бичгээр танилцуулна гэж өөрчлөх, нэмэх. Амарсайхан гишүүн саналаа тайлбарлах уу?

С.Амарсайхан: Манай энэ ажлын хэсгийнхэн Үндсэн хуулийн ном л их ярьж байна, ойлгож байгаа. Бид Үндсэн хуулиа дээдэлнэ, Үндсэн хуулиа дагаж мөрдөнө төрийн хууль тогтоомжоо ч дагаж мөрдөнө. Тэрийгээ бүгд мэдэж байгаа. Гэхдээ Үндсэн хуулийн номлолыг битгий өөрийн үзэл бодол, байр суурины номд болгоод бай. Та нарын ярьж байгаа бол үндсэндээ Үндсэн хуульд байхгүй учраас бид энд тусгаж болохгүй гэж өмнөх 20.1.7 дээр тэгээд хассан. Үндсэн хууль дээр тусчихсан танилцах сонсгол хийнэ. Гэхдээ бид нар ингэж өөрчилж байгаа юм гэж Үндсэн хуулийг өөрийнхөөрөө тайлбарлаж, Үндсэн хуулийг өөрийнхөөрөө ойлгож бусдад тулгадгаа боль. Бид чинь бас энэ хууль тогтоомжоо мэддэг, эрх зүйгээ ойлгодог хүмүүс энд сууж байгаа. Нөгөө юм л бол одоо Үндсэн хууль гээд нөгөө аавдаа хэлнэ шүү гэж бусад юм мэддэггүй хүүхдүүдийг айлгадаг жоохон хүүхдүүдтэй харьцаж байгаа юм шиг наад нэг ийм сонин хандлагаа боль. Ялангуяа энэ Мөнхсайхан гэж залуу. Би хоёр гурван юман дээр бас энийг чинь харж байгаа шүү.

Энэ шударга ёс, хуулийн шүүлтүүр болсон Шүүхийн хууль ийм задгай бөгөөд хоёр салаа утгатай байж болохгүй. Хуулийг бид нар маш тодорхой болгоно гэж байгаа шүү дээ. Хуулийн зүйл заалтыг. Жишээ нь гучин долоогийн хоёрын нэг дээр Байнгын хороо арван дөрвөн хоногийн дотор танилцах сонсголын зарыг тавьж зохион байгуулна гэсэн байгаа юм. Гэтэл гучин долоогийн хоёр дээр 90 хоногийн дотор

зохион байгуулахгүй бол танилцан тооцно гээд ийм одоо эргүү эсхүл бол орон гаран хүний өдрийн тэмдэглэл шиг юм өөрсдөө хийчхээд тэгээд одоо энийгээ тулгаж бид нар шийдүүлэх гээд өөрсдийнх нь бүх юм зөв гэдэг шиг ийм юм руу битгий оруулаад бай. Юм хэлэхгүй ингээд хүлээн зөвшөөрөөд явъя гэхээр энийг чинь ярихаас өөр арга алга. Хэрэв Байнгын хороо Их Хурлаар хэлэлцэх тов зарлаж байгаа юм бол Их Хурал үүргээ л гүйцэтгэх ёстой шүү дээ. Үүргээ гүйцэтгэж чадахгүй үүргийг бид хэд энд оруулаад яах юм. Иймэрхүү юмнууд дээрээ маш тодорхой анхаарч, энийг өөрчлөхгүй бол болохгүй байна.

Их Хурлыг үүрэгжүүлэх гэж байгаа бол Их Хурал тэр үүргээ биелүүлье 90 хоногийн дотор сонсголоо хийе, танилцах. Хэрэв тэгж чадахгүй гэж байгаа бол энийг хасъя гэж байгаа юм, энийг. Тийм учраас би энэ саналаа маш тодорхой оруулж байгаа юм. Тэгээд энэ дээр та бүхэн бас анхаараарай. Энэ хоёр давхцал гучин долоогийн хоёрын нэг, гучин долоогийн хоёрын зургаа хоёр хоорондоо бие биеийгээ үгүйсгээд байна шүү, үгүйсгээд байна. Ийм заалттай юмыг бид хүлээн зөвшөөрч баталж болохгүй. Энэ дээр бол байр суурь нэгдэхгүй байна. Тэгээд наад Үндсэн хуулийн тэр үзэл агуулгаа хэрвээ заачихсан юм бол Үндсэн хууль ярих гэж байгаа бол тэр Үндсэн хуулиа дага. Дагаж чадахгүй юм бол Үндсэн хуулийг өөрсдөө өөрчилж өөрсдийнхөөрөө хэрэглэдгээ боль, энэ чинь та нарын энэ эндээс чинь энэ завхрал чинь эхэлж байна шүү, энэ ажлын хэсгийнхэн. Тэгээд энэ саналаа хураалгая. Энэ дээр бас та бүхэн бас энэ.../минут дуусав/

С.Бямбацогт: Амарсайхан гишүүн санал гаргасан. Ер хоногийн дотор Улсын Их Хурал танилцах сонсгол зохион байгуулсны дараа ерөнхий зөвлөлийн дарга, шүүгч нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид бичгээ танилцуулна гэж өөрчлөх нэмэх төсөлт нэмэх гэж байгаа. Түрүүн бол хэлсэн, тийм ээ, танилцуулаагүй бол процесс хийгдсэн гэж үзээд явна гэж шүү дээ. Тэрэнтэй, агуулга ойролцоо санал байна. Амарсайхан гишүүн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 6 гишүүн буюу 40,9хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Өөр санал байгаа билүү, болчихсон уу? Хөөе. Сая 37.3 дээр бас хураагдсан байгаа. Байнгын хороо энэ хуулийн гучин долоогийн хоёрын хоёрт заасан хугацаа өнгөрснөөс хойш арван дөрвөн хоногийн дотор танилцах сонсголыг зохион байгуулах бөгөөд зохион байгуулах журмыг Байнгын хороо батлах гээд хураагдсан. Энийг дотор нь нэг жоохон найруулаад хэсэг болгоод өөрчилчхөөрэй чуулган руу оруулахад. Энэ асуудал ингээд. Гучин долоодугаар зүйлийг хэлчихлээ. Гишүүдийн бичгээр гарсан саналуудыг хураасан.

Одоо хуулийн төслийн гучин наймдугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд ирсэн өгнө үү. Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 26.Төслийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн “мэргэшүүлэх” гэсний өмнө “гурван сар хүртэлх хугацаагаар” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу далан нэг аравны дөрвөн хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн гучин есдүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явуулъя. Ажлын хэсгийнхэн тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Гишүүдээс бас бичгээр гарсан санал байхгүй.

Хуулийн төслийн дөчдүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 27.Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “орон тооны” гэснийг хасаж, 40.5 дахь хэсгийн “сэргээнэ.” гэснийг “даруй сэргээж, энэ тухай Ерөнхий зөвлөлд мэдэгдэнэ.” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 40.5 дахь хэсэг нэмэх:

“40.5.Энэ хуулийн 40.4-т заасан үндэслэлээр бүрэн эрх нь түдгэлзсэн шүүгчид уг хугацаанд цалин хөлсийг 90 хувиар тооцож олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт, 90 хувь нь одоо арай өндөр биш үү? Болж байгаа юм уу тийм ээ. Түдгэлзчихээд 90 хувийн цалингаа авах юм уу. Санал хураалтад 14 гишүүн оролцож 9 гишүүний буюу 64.3 саналаар санал дэмжигдлээ. Хуулийн төслийн гишүүдээс бичгээр гарсан санал алга байна.

Хуулийн төслийн дөчин нэгдүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явуулъя. Ажлын хэсгийн зарчмын зүйлийн саналаар санал хураалт явуулна. 28.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг, 41.2.9 дэх заалт, 41.5 дахь хэсгийг тус тус доор дурдсанаар өөрчлөн найруулж, 41.2.2 дахь заалтын “болон хүндэтгэн үзэх бусад” гэснийг хасаж, 41.2.3 дахь заалтын “өөр” гэснийг “өөрийн хүсэлтээр энэ хуулийн 40.1-д зааснаас бусад” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 41.6 дахь хэсэг нэмэх:

“41.1.Шүүгч хуульд заасан өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн, эсхүл шүүгчээр 25 жил ажилласан бол өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгож, чөлөөлөгдөж болно.”

“41.2.9.шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн.”

“41.5.Шүүгч огцорсон бол түүнийг шүүгчийн сонгон шалгаруулалтад оролцуулахгүй.”

“41.6.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч өөрийн хүсэлтээр албан тушаалаас чөлөөлөгдөх бол хүсэлтээ Улсын дээд шүүхийн Зөвлөгөөнд гаргах бөгөөд Зөвлөгөөн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл Ерөнхийлөгчид уламжилна. Ерөнхий шүүгч албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтийн үндэслэлээ олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор. Тэтгэврийн нас 49. Арай болоогүй тийм. Тэтгэврийн нас 49 байгаа. санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр санал ирээгүй 41 дээр.

Хуулийн төслийн 42 зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 29.Төслийн 42 дугаар зүйлийн гарчгийн “Шүүгчийн” гэснийг “Ерөнхий шүүгч, танхимын тэргүүн, шүүгчийн” гэж өөрчилж, 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 42.1, 42.2 дахь хэсэг болгох:

“42.1.Шүүгчийн бүрэн эрх дуусгавар болох хугацааг шүүгч өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн бол уг насанд хүрэх сарын сүүлийн өдрөөр, бусад үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох шийдвэр гарсан бол уг шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөр тоолно.

42.2.Ерөнхий шүүгч, танхимын тэргүүний бүрэн эрх дуусгавар болох хугацааг сонгогдсон хугацаа дуусгавар болох өдрөөр тоолно.” Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 71,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Хуулийн төслийн дөчин гуравдугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явуулъя. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна. 30.Төслийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “Шүүгчийн хараат бус байдал халдашгүй байх бөгөөд” гэснийг, 43.3.4 дэх заалтын “эрх зүйн байдлын онцлогт нь нийцүүлэн” гэснийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 43.3.6 дахь заалт нэмэх:

“43.3.6.шүүгч өөрийн хүсэлтээр ахисан түвшинд мэргэшлээ дээшлүүлэх зорилгоор хоёр жил хүртэл хугацаагаар гадаад улсад суралцах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх болсон тохиолдолд ажлын байр нь хэвээр хадгалагдах.”

43.4.Шүүгчийг олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийг одонгоор шагнах, улсын тэтгэврийг өргөтгөн нэмэгдүүлэх тухай хуульд зааснаас бусад цол, одон, тэмдэг, шагнал олгохыг хориглоно. Асуулт байхгүй дээ. Энх-Амгалан гишүүн асуултаа асууя.

Б.Энх-Амгалан: Энэ их дөчин гурвын дөрвөн их сонин заалт болчихоод байх юм. Энэ хүн чинь одоо нэг олон хүүхэд төрүүлсний нэг одон авах юм байна. Нэг өргөтгөсөн нэмэгдүүлэх тухай хуулиараа нэг улсын тэтгэвэр авах юм байна, тэгээд бусад одоо цол одон, медаль, тэмдэг авахгүй гэхээр чинь одоо энэ чинь юу гэсэн үг вэ. Энэ хүмүүс чинь одоо тэр Монгол Улсын иргэн болгон авдаг, зарлигаар явдаг. Тэр төрийн одон медаль, цол тэмдэг, гавьяа шагнал авах эрхгүй гэж арай байж боломгүй санагдаад байх юм. Энэ заалтыг хасаад хаячихвал яадаг юм. Тэр чинь адилхан л хүн. Тэр чинь ажил хийж байгаа л хүн юм чинь. Төрийн одон медаль шагнал авна л биз дээ. Тэр гавьяат хуульч бол болно л биз дээ. Бусадтайгаа бас адилхан хүн шүү дээ. Тэгэхээр зөвхөн чи эхийн алдар одон нь өөр юу ч авахгүй шүү гэж бас болохгүй биз дээ. Энэ дээр нэг жоохон санал өөр байх юм. Энэ ажлын хэсгийг нь тайлбарлаадхаач ингэж болох юм уу? Энэ чинь одоо шүүгч гэхээр яах вэ зүгээр тэр эрх эрх юм алдах барих юмыг одоо ингээд хязгаарлаад хуулиар ингээд тодорхой заагаад өгчихдөг байж. Ядаж шагнагдах эрхийг нь хааж болохгүй байх. Энийг нэг тайлбарлаадхаач.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя хэн хариулах вэ? Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Энэ бас яг шүүгчийн тухайд их онцлог тавигдаж байгаа бас хязгаарлалтын нэг нь бол энэ байгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл эхийн алдраас бусад ямарваа нэгэн байдлаар төрийн одоо одон медаль авахгүй шүү гэдэг нь нэг талаасаа Монгол Улсын төрийн тэргүүний Үндсэн

хуульд заасан төрийн дээд одон медаль, шагнал гардуулах энэ онцгой бүрхэн эрхийг хязгаарлаж байгаа агуулга байгаа боловч энийг ажлын хэсэг дээр бас нэлээн олон талаас нь яриад ажлын хэсгийн гишүүд бол ер нь энэ бол зохисгүй юм байна, тэгээд нэг гавьяат хуульч болох гэж нэг удаа алтангадас авах гэж бас хэрэг маргаанд нөлөөлдөг ийм юмнууд байна. Тэр байтугай одоо тодорхой нэр бүхий улс төрчийн хэргийг цагаатгачхаад тэрнийх нь дараа бас шагнал юмнууд бас авсан ийм асуудлууд хүртэл урьд нь гарч байсан.

Тэгээд улсын дээд шүүхийн шүүгчид өөрсдөө энэнээсээ татгалзъя гэдэг саналыг дээд шүүхийнхээ өөрсдөө гаргасан юм. Энэ бид нарыг бас ер нь хараат байдалд оруулаад байна. Бид бас энэ нэг их тийм одон медалийг харж ажлаа хийдэг хүмүүс бас биш. Ийм бас нөлөөнд ормооргүй байна гэдэг санал гаргасан юм. Энийг бас ажлын хэсгийн гишүүд бас хүндэтгэж хүлээж аваад та бүхэнд уламжилж байгаа юм.

С.Бямбацогт: Одоо дууссан шүү дээ. Нямбаатар гишүүн. Нямбаатар микрофон өгье.

Х.Нямбаатар: Ажлын хэсгээс нэг асуулт асууя. Энэ төслөөс өөрөөр томъёологдож орж ирсэн юм. Энэ дөчин гурвын гурвын зургаа дээр шүүгч өөрийн хүсэлтээр ахисан түвшинд мэргэжлээ дээшлүүлэх зорилгоор хоёр жил хүртэлх хугацаагаар гадаад улсад суралцах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх болсон тохиолдолд ажлын байр нь хэвээр хадгалагдана гээд ийм юу заалт орж ирж байна. Тэгэхээр би юу юу гэж хэлэх гэж байна вэ гэвэл өнөөдөр шүүгч нарын ачаалал хүрэлцэхгүй байгаа. Энэ хүний оронд ажлын байран дээр дахиад өөр хүн сонгон шалгаруулалт хийгээд шүүгчээр авч болдоггүй. Нэг хэдэн хүмүүс нь одоо ёстой хамаг ачаалалдаа дарагдаад суугаад байдаг. Эргээд нөгөө ажлын байрны ачааллыг тэнцүүлэх ийм боломж хязгаарлагддаг. Тэгээд нөгөө хүмүүс маань ингээд гадаадад суралцах зорилгоор ингээд яваад өгчихдөг. Нөгөө талдаа эрдэм шинжилгээний судалгааны ажил хийнэ гээд бас ингээд ажлын байр нь хадгалагдаад үлд, ажлын ачаалал тэнцвэржихгүй ийм нэг нөхцөл байдал үүснэ.

Хоёр гэвэл хүн хариуцлагаас бултахын тулд янз бүрийн одоо хариуцлагаас бултахын тулд яг энэ үндэслэлээр суралцах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийнэ гээд ажлын байраа хадгалуулаад ингээд яваад өгчихнө. Энд ийм сөрөг үр дагаврыг тооцож үзсэн үү. Энийг ажлын хэсэг дээр хэн ийм санал гаргасан юм бэ? Би бас л протоколд тэмдэглүүлж үлдье. 50-иараа, 10-аараа явчихвал энэ шүүхийн системд доргилт үүснэ шүү дээ. Нэг хэсэг нь ачааллаа үүрч үлдэнэ, нөгөөдүүл нь ажлын байраа хадгалуулчихсан яваад өгчихнө. Тэгэхээр энийг яг одоо би ажлын хэсгийнхэн, гишүүдээс асуух гэж байна. Энэ саналыг хэн томъёолж гаргаж ирсэн бэ? Энэ саналыг томъёолсон хүн энэнийхээ одоо үндэслэлийг нэг тайлбарлаж өгөөч. Шүүх гэдэг байгууллага бол хэн нэг одоо хүнийг мэргэшүүлж сургаж яахаасаа илүүтэй мэргэшсэн хуульчид шүүхийн ерөнхий зөвлөлийн одоо тэр зарласан сонгон шалгаруулалтад тэнцэж орж ирж энэ шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлж байгаа ийм л субъект байх ёстой. Энэ дээр нэг яг санаачилсан хүмүүс нь нэг хариулт өгөөч. Яг ажлын байр, ажлын байр яаж хадгалагдах бусад нь яаж ажлын ачааллаа тэнцвэржүүлэхийг хариулт өгөөч.

С.Бямбацогт: Хоёрдугаар микрофон Атарцэцэг шүүхийн ерөнхий зөвлөлийн зөвлөл.

Л.Атарцэцэг: Энэ зүгээр манай шүүгчдээс гарсан энэ санал байсан юм. Одоо хуулийн төслийг хэлэлцүүлэх явцад. Шүүхийн ерөнхий зөвлөл дээр ямар асуудал гардаг вэ гэхээр энэ шүүгч нар өөрсдөө гадагшаа сургалтад хамрагдах болоод түр хугацааны чөлөө хүссэн ийм асуудал юм амьдрал дээр яг гараад байгаа юм. Тэгээд энэ тохиолдолд бол бид нарт ганцхан зохицуулалт юу вэ гэхээр одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төрийн албаны тухай хуулийн дөчин зургаадугаар зүйлийн нэгийн хоёрын зургаагаас дээш хугацааны сургалтаар шинэ дадлага туршлага эзэмших сургалтыг оролцуулан бэлтгэгдэх болсон гэдэг энэ заалтаар нөгөө төрийн албанаас түр чөлөөлөгдөх гэсэн энэ зохицуулалт руу ороод байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар зүгээр ажлын хэсэг дээр энэ томъёоллыг өгсөн гэхээсээ илүүтэйгээр одоо энэ төрийн албанаас түр чөлөөлөгдөх шүүгч өөрийн хүсэлтээр сургалтад хамрагдах нөхцөлд тэр чөлөөг ямар байдалтай болгох вэ гэдэг асуудлыг яаж шийдвэрлэх вэ гэдэг асуудлыг шүүхийн ерөнхий зөвлөлөөс ажлын хэсэгт орсон гишүүд энэ хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг хэсэгт бол бид нар танилцуулсан юм байгаа юм.

Ингээд бид нар ямар томъёоллоор оруулъя гэхээр энэ бол яг зүгээр энэ томъёоллоор байх юм бол би зүгээр өөрөө ингэж бодоод байгаа юм. Нэлээн ийм тийм аягүй том хүүдий болчихоод байна л даа. Үнэхээр Нямбаатар гишүүний хэлснээр хэн дуртай нь одоо хоёр жил яваад л алга болчихдог. Энэ хооронд бол нөгөө шүүхүүдийн ачаалал бусад шүүгч нарт одоо дарамт болж ирнэ. Тэгэхээр бид нар энэ томъёоллыг бол зүгээр ямар байдлаар оруулъя гэж тухайн үед ярьж байсан гэхээр зөвхөн одоо шүүхийн захиалгаар тийм үү, шүүхийн захиалгаар тухайн шүүгч сургалтад хамрагдах асуудал болох юм бол ийм байж болох юм гэдэг асуудал яригдаж байсан юм. Тэгээд одоо зүгээр яг энэ томъёоллыг одоо хэн нь гаргасан гэдгийг бол би сайн хэлж мэдэхгүй байна. Өнөөдөр шүүхийн ерөнхий зөвлөл дээр шүүгч нар өөрийн хүсэлтээр сургалтад хамрагдах чөлөө хүсэх асуудал зөндөө гардаг юм. Энэ тохиолдолд тэр төрийн албаны тухай хуулийн тэр зохицуулалтаар үзэх юм бол түр чөлөөлөгдөөд дахиад түр чөлөөлөгдсөн хүн маань яг энэ хуулийнхаа зохицуулалтын дагуу эргээд шүүгчийн албан тушаалыг хаших болсон нөхцөлд, сонгон шалгаруулалтад нэрээ дэвшүүлээд л явах бол сул оронтой гарсан нөхцөлд нэрээ дэвшүүлээд явах ийм л нөхцөл байдал үүсээд байгаа юм. Харин тийм ээ, ажлын байр нь.../үг тасрав/

С.Бямбацогт: Нямбаатар гишүүн тодруулчих, дараа нь ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Х.Нямбаатар: Энэ ингээд шүүгчийн хараат бус байх зарчим баталгаа гээд энд ороод ирчхэж байгаа байхгүй юу. Тэгэхээр чи гадаадад сургалтад явж болно, чи явж болохгүй, чи эрдэм шинжилгээний ажил хийж болно, чи болохгүй гэдэг ийм ямар ч ялгамжийг гаргаж болохгүй. Тэгэхээр хүмүүс ачаалал ихтэй, маш их хүнд одоо нөхцөлд ажиллаж байгаа хэдэн зуун хэрэг дээр хэргийн ачаалал үүрч байгаа ийм шүүгчдийн хувьд бол ихэвчлэн энэ ачааллаа бууруулах, нөгөө талдаа одоо биеийн амрыг хараад явах ийм нөхцөл байдал руу л явна шүү дээ. Тэгээд эндээс гарч сөрөг үр дагаврыг яаж тооцсон юм бэ. Энхбаяр ажлын хэсгийн ахлагч энийг хариулж өгөөч. Манай төсөл дээр энэ зүйл байгаагүй. Хоёр дахь нь байна шүү дээ. Энэ дөчин гурвын

дөрөв дээр энэ Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд халдаж байна. Хоёрдугаарт энэ Монгол Улс.../минут дуусав/

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч хариулъя. Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Нямбаатар гишүүний асуултад хариулъя. Мэдлэг боловсрол танин мэдэх гэдэгт бол хязгаар байхгүй л дээ. Хүн бол үхэн үхтлээ сурах ёстой. Тэр тусмаа шүүгч хүн тасралтгүйгээр мэргэжил боловсролоо дээшлүүлэх ахисан түвшний боловсрол эзэмших тэр баталгаа юмыг бол хангах ёстой. Зөвхөн одоо нэг өнөөдрөөрөө хэмждэг ийм одоо байдалтай шүүгч нар байгаагийн улмаас хөрөнгийн үнэт цаасны арилжаанд хийсэн хүнийг эрүүгийн ял шийтгээд, дараа нь нөгөө нөхрөөсөө уучлал гуйгаад нөгөө нөхрөөсөө сургалт авч байсан шүүхийн туршлага байгаа. Орчин үеийн зах зээлийн эдийн засгийн энэ байдал нөхцөл байдал гэдэг бол цаг тутам шинэ хөгжиж байж баяжиж явдаг ийм харилцаа. Зөвхөн эрүүгийн хууль мэддэг хүмүүсийг шүүгч гэхгүй. Энэ бол тасралтгүй суралцах ёстой. Тэр бололцоог бид олгохын тулд ахисан түвшний мэргэжил дээшлүүлэх зорилгоор гэж хэлж байгаа.

Өөрөөр хэлбэл хуулийн салбартаа хууль зүйн магистр болон докторын зэрэг хамгаалах гэж байгаа асуудлыг л энэ зүйлд хамааруулж байгаа. Зүгээр хэлний хэлний курст зуугаараа, одоо хууль зүйн докторт баруунд явж байгаа бол одоо их сайн байна. Би бол бүр баярлана. Энэ хугацаанд нь шүүгчтэй хоёр жилийн хугацаанд гэдэг нь ажлын байрыг нь хадгалъя шүү гэсэн болохоос биш оронд нь хүн авч болохгүй гэсэн үг биш шүү дээ. Энэ чинь ажлын байрыг хадгалах тухай заалт байхгүй юу. Энэ хугацаанд нь хүнгүй болчихоод шүүгчгүй болчихоод хэрэг маргаанаа хянан шийдэхгүй байна гэсэн үг биш шүү дээ. Хоёр жилийн хугацаанд хүнээ түр хугацаагаар томилоод явна шүү дээ. Яагаад бусад төрийн албан хаагчид хүмүүс хоёр жилийн хугацаагаар гадаад улсад мэргэжлээ дээшлүүлэхэд ажлын байрыг нь хадгалах ийм Төрийн албаны хуулийн баталгаатай заалттай мөртөө шүүгч дээр энийг тавихгүй гэж.

Хоёрдугаарт энэ бол бас энэ ийм тохиолдлууд маш их байгаа. Жишээлбэл одоо манай улсын Японы Солонгосын Германы их дээд сургуулиудтай харилцаа холбоотой хамтын ажиллагааны түнштэй энэ хүрээндээ магистр, докторын зэргийг одоо цахимаар зайнаас хамгаалуулж байгаа ийм одоо хамтын ажиллагааны хэлбэр өргөн одоо өргөн хүрээнд байгаа. Бид энэ судалгаа хийж, шинжилгээ хийж, жоохон нэг юм уншсан шүүгч нартай байж яагаад болохгүй юм бэ. Яагаад зөвхөн ганцхан дотооддоо л энэ одоо байж байх ёстой өнөөдрийнхөө энэ нэг хэдэн баталсан хуулийнхаа хүрээнд юмаа уншаад ажиллаж байх ёстой гэж. Бид жоохон тархиндаа бас цус сэлбэх ёстой шүү. Агаар оруулах ёстой шүү. Тэр боломжийг нь олгох гэж л энэ хугацаанд нь одоо ажлын байрыг нь хадгална гэдэг л ийм л баталгаа олгосон заалт байгаа.

С.Бямбацогт: Цалинтай хадгалах юм уу, цалингүй хадгалах юм уу. Нямбаатар гишүүн тодруулъя.

Х.Нямбаатар: Энхбаяр гишүүн би асууя ажлын хэсгийн ахлагчаас. Энэ түр оронд нь хүн томилно гээд сая хэлчихлээ. Цогт шүүгчээ шүүгчээр хүн түр томилох тухай ийм зохицуулалт байгаа юу? Өөрөөр хэлбэл өнөөдрийн ачааллын тухай ярьж байгаа юм. Тэгээд хэсэг хүний нуруун дээр маш их ачаалал ирнэ. Би ерөөсөө тэр

мэргэжил дээшлүүлэхийг хязгаарлах тухай яриагүй. Та энэ Энхбаяр гишүүн хэт их ийм юу уянгын халилтай энэ хариулт өгөөд байх юм. Энэ дотооддоо гадаадад богино хэмжээний сургалтын тухай бол энэ бол нээлттэй байгаа шүү дээ. Зургаан сарын, нэг жилийн гадаад сургалт, мэргэжил дээшлүүлэх сургалтын хувьд нээлттэй байгаа. Тэгэхээр бид нар таван зуун арван найман хүн байна. Хоёр зуу нь гадагшаа сургуульд явчихлаа. Энэ шүүхийн ачааллыг хэн хариуцах юм бэ? Энхбаярын хэлж байгаа шиг тэгж түр хоёр жилийн хугацаатай Доржийн орон Дондогийг томилдог энэ ийм.../минут дуусав/

С.Бямбацогт: Манай Хууль зүйн сайд, Хууль зүйн байнгын хорооны ажлын хэсгийн ахлагч шүүхийн хуулийн хоёр хоорондоо жоохон ойлголцоно. Битгий ингээд тэмээ гэхээр ямаа гээд эсвэл хоёр тийш нь чирээд байгаач. Та хоёр маань. Тэгээд зөв ойлголцоод найруулгаа хийгээд явчихмаар байна. Наана чинь одоо тэр сэлгэн ажиллуулах бас бололцоо байгаа шүү дээ. Шүүх ерөнхий зөвлөл шүүгчийг сэлгэн ажиллуулах журам бас батлаад сэлгэн ажиллуулж болно гээд орчихсон байж байгаа. Тийм. Нөгөө талдаа одоо тэр саяын ярьж байгаа тэр бас хоёр жил ажиллаад л хоёр жил сургалтад яваад л хоёр жил ажиллаад л хоёр жил сургалтад яваад л ингээд байгаад байдаг бол бас яах юм. Онолын хувьд тийм үү зуу зуугаар явчихвал яах юм онолын хувьд зүгээр, цалинтай байвал яах юм. Тийм болохоор ярьж байна шүү дээ. Хэдийгээр шүүхийн ерөнхий зөвлөл зохицуулах ёстой ч гэсэн тодорхой боломжоор энийг эргэж хараад өшөө тийм үү тодотгоод найруулаад ирэх бололцоо байна уу? Хэрэв тийм бололцоотой гэж үзэх юм бол тэгж ойлголцоод протоколд тэмдэглээд чуулган руу орохдоо тийм үү аль аль талаасаа одоо Нямбаатар гишүүн, Энхбаяр гишүүн ойлголцоод саналаа хураачихъя. Хэрэв ойлголцож чадахгүй гэвэл одоо яах юм гээд. Ойлголцоод тэгвэл саяын одоо ярьж байгаа зовлон бэрхшээлтэй асуудлуудыг.../минут дуусав/

С.Бямбацогт: Энийг салгаад салгаад санал хураая яршиг. Ингэе. Одонгийн асуудал ярихад одон дээр нь хураачихъя. Би одоо салгаж хураах гэж байна. Нэгдүгээрт нь байна шүү дээ ингэнэ. 30.Төслийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “Шүүгчийн хараат бус байдал халдашгүй байх бөгөөд” гэснийг, 43.3.4 дэх заалтын “эрх зүйн байдлын онцлогт нь нийцүүлэн” гэснийг тус тус хасах. Тийм үү санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Эхлээд энийгээ хасъя энэ хэл амгүй. Тийм. Уначихлаа шүү дээ энэ чинь. Ажлын хэсэг Сүхбаатар гишүүн. Энэ зүгээр найруулгын санал байсан юм. Хэл амгүй тэгээд л явъя гэж байгаа юм. Яах юм бэ ингээд явах юм уу тэгээд. Санал гаргах хүн байна уу Сүхбаатар ажлын хэсгийн гишүүн.

Ж.Сүхбаатар: Би бол сая дэмжиж санал өгсөн. Тэгээд татгалзсан дээр гарчихлаа. Уг нь бол ингээд дарсан. Тэгээд энэ тэгэхээр дахиад хураалгаж өгөөч.

С.Бямбацогт: Сүхбаатар гаргасан горимын саналаар энэ санал хураалтыг хүчингүй болгох горимын саналаар санал хураалт явуулъя. Сүхбаатар гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэн учраас саяын санал хураалтыг дахин явуулъя. 30.Төслийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “Шүүгчийн хараат бус байдал халдашгүй байх бөгөөд” гэснийг, 43.3.4 дэх заалтын “эрх зүйн байдлын онцлогт нь нийцүүлэн” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 14 гишүүн

оролцсоноос 10 гишүүн буюу 71,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Дараагийн санал хураалт.

43.3.6. сая ерөнхийдөө ойлголцоод найруулъя гээ ойлголцсон. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хэлсэн, Нямбаатар сайд ажлын хэсгийн ахлагч нар ойлголцсон гэж ойлгож байгаа. Энэ дээр тодорхой саяын тэр амьдрал дээр тохиолдох онолын болоод амьдралын практикуудыг үзэж байгаад найруулаад чуулган руу орох үед эцэслээд найруулга оруулж ирээрэй гээд санал хураалгачих уу? Зарчмыг нь дэмжээд. Зарчмыг нь дэмжье та нар томьёоллоо илүү сайжруулах хэрэгтэй. Ингээд дэмжчихье. Тэр сургалттай холбоотой. Дэмжчихээд дахиж сайжруулна. Нямбаатар гээд гишүүн Энхбаяр гишүүн. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 8 гишүүн буюу 57,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

43.4. Энэ дээр одоо Сүхбаатар гишүүн, ажлын хэсгийн гишүүн, Алтанхуяг гишүүн, дараад нь. Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Энэ шагналын асуудал бол ийм байгаа юм. Шүүгч бол яг шүүх эрх мэдэл гээд тусдаа Монгол улсын энэ хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэдэг ийм субъект. Тэгэхээр энэ шүүгч дээр бол энэ шагнал гэдэг чинь юуны төлөө байдаг юм бэ гэж. Шагнал гэдэг бол ёс суртахууны шагнал гэж бий. Материаллаг шагнал гэж бий. Статусын шагнал гэж бий. Хийж байгаа ажилд нь үнэлэлт дүгнэлт өгч урамшуулж байгаа арга хэмжээ байхгүй юу. Гэтэл шүүгчийн ажлыг хэн үнэлж дүгнээд урамшуулах гээд байгаа юм, асуулт байхгүй юу. Тэгэхээр Монгол улсын Ерөнхийлөгч, шүүхийн ерөнхий зөвлөл, дээд шүүх, эсвэл одоо шүүхийн энэ тэр ерөнхий шүүгч нь ч гэдэг юм уу, тэр хүнийг сайн ажиллаж байна гэж дүгнэж урамшуулах асуудал тавьчихаад байгаа байхгүй юу. Бид нарын шүүгчийг урамшуулж байгаа хамгийн гол юм юу юм гэхээр зэрэг одоо үндсэндээ тэтгэвэрт гарах хүртэл нь тодорхой насанд хүрэх хүртэл нь тодорхой зөрчил гарах хүртэл нь одоо өндөр эрх ямба эдлүүлж баталгаа өгч байгаа байхгүй юу. Энэ бол хамгийн том урамшуулал.

Тэгэхээр өөр нэг эрх бүхий этгээд энийг одонгоор шагна улсын цол зэрэг юм уу, ингээд одон медаль өгнө гээд явчихаар хууль тогтоох эрх мэдлийн зүгээс гүйцэтгэх эрх мэдлийн зүгээс, Ерөнхийлөгчийн зүгээс шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж бие даан хэрэгжүүлж байгаа тэр этгээдэд цол, одон, медаль өгч ажлыг нь сайн муу байна гэж цаад утгаараа үнэлж байгаа нь өөрөө асуудал байхгүй юу даа. Олон жил ажилласан байна шүү дээ. Маш олон жил ажилласан миний таньдаг улсууд байж байна. Тэд яагаад энэ өөр өөрөөс нь бага жил ажилласан ч гэдэг юм уу, эсвэл одоо арай хурдан ахисан хүн гавьяат хуульч болчихоод байгаа юм бэ. Тэр хүнд насаараа тэр хүн чинь сайн сайхан ажиллаж байгаа шүү дээ. Гэтэл бүгд гавьяат хуульч болж чадахгүй. Тэр таван зуун шүүгч чинь бүгд нормальны зөрчил гаргахгүй бол яг ажиллаж байгаа юм. Нэр хүнд нь бол харин өөр. Нийгмийн нэр хүнд. Энэ шүүгч бол шударга шүүгч шүү гэж манай Цогт шүүгч шиг ингээд хэлэгдэж байгаа бол энэ нийгмээс өгч байгаа хамгийн том үнэлгээ байхгүй юу.

Түүнээс биш хажуугаар нь энд сууж байснаа нэг өөр, шүүгч нь энэ бол гавьяат хуульч юм. Энэ бол арай илүү алтагадас авах хүн юм гээд ингээд ялгамжтай хандаад ирэхээр зэрэг тэр шүүгчийн нийгмийн зүгээс өгч байгаа үнэлгээнээс илүү төрийн нэг этгээдийн тэр одоо үнэлгээ дүгнэлтээс хамаарч байгаа юм. Энэ чинь хэн

ч гэсэн тэр хүмүүсийн өөрсдийнх нь бие даасан байдалд сэтгэл зүйн хувьд нийгмээс өгч байгаа юманд нь нөлөөлж байгаа байхгүй юу. Статусын том өөрчлөлт гэж байгаа юм. Одоо нас барлаа гэж бодоход Алтан өлгийд оршуулагдана гавьяат учраас. Насаараа зөв сайхан ажилласан хүн болохоор чи тийм юм байхгүй. Тэгэхээр энэ шүүгч гэдэг бол бид бүгдийг бүгдийг нь шүүдэг хүн байхгүй юу даа. Бусад хүнтэй адилтгаад. Энэ чинь иргэний тухай яриагүй шүү дээ. Монгол улсын иргэнд цол, одон, медаль олгох нь бол Монгол Улсын Ерөнхийлөгчид олгогдсон эрх мөн. Гэхдээ энэ шүүгч дээр бол бид нар хязгаарлалт тавих шаардлагатай учраас.

Яагаад гэвэл жам ёсных нь юмтай нь холбоотой юмыг бол одоо өөрчилж болохгүй байгаад байна. Тэтгэвэрт гарч байна уу, гарч байна, олон хүүхэд төрүүлж байна уу төрүүлж байна. Энэ бол жам ёсоороо ингээд явж байгаа зүйлүүд. Энэ дээр ямар нэгэн одоо том урамшууллын механизм энд байх шаардлагагүй. Тэр хүн бол өөрийнхөө одоо биологийнхоо нийгмийнхээ амьдралынхаа хүрээнд хийгдэж байгаа ийм холбоотой асуудал. Тэрнээс бусдаар бол энэ шагнал гэдэг нь гол нь тэндээ л байгаа юм. Урамшуулна, сэдэлжүүлнэ, үнэлнэ, дүгнэнэ. Тэгээд энэ чинь хүний сэтгэл зүйд мотивацид түлхэц үзүүлж, нөлөөллийн үйл ажиллагаа явуулж байгаа байхгүй юу. Маш том хөшүүрэг. Захиргааны алба одоо аргын гол хэсэг бол урамшуулах, урамшуулах дотроо шагнах арга байхгүй юу. Тэгэхээр энэ одоо энийг бол би энэ дээр энэ утгаар нь бол ийм заалт орох нь зөв гэж үзэж байгаа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гишүүн Алтанхуяг гишүүн саналаа хэлье. Санал тасалсан үг хэлэх хүмүүсийг гишүүд.

Н.Алтанхуяг: Нямбаатар сайд энийг би бас би нэлээн бас ингэж санаачилж яах вэ оруулж байгаа юм. Энэ Монголд нэг этика гэдэг л юм бий болгомоор байгаа юм. Энэ шагнал чинь байна шүү дээ. Энэ одон медаль, тэр гавьяат тэр юу билээ нөгөө цэргийн генерал. Энэ чинь бол хонгилынхны хүнийг өөрийнхөө хүмүүсийг урамшуулдаг зэвсэг байхгүй юу. Энэ зэвсгийг алга болох хэрэгтэй. Хүний хэргийг захиалгаар шийдчихээд шагнал авч болохгүй. Гавьяат авч болохгүй, генерал болж болохгүй. Би та нарт амьдралын юм л ярьж байгаа юм. Энэ бол дэндүү юм болчихсон. Энэ бусад тэр одоо ямар юм гэдгийг нь нэг бусад одоо яг бодитойгоороо тэр янз бүрийн салбар дээр одоо ажиллаад юмаа авч байгаа хүмүүстээ бол би ярихгүй байна. Энэ шийдвэр гаргаж байгаа, тэр тусмаа хүний амьдралыг шийдэж байгаа. Яахаараа шүүгч шүүгчийг яахаараа тэндээс шагнаж байдаг юм? Яахаараа шагнуулах гээд материалыг нь бариад гүйж явдаг юм. Энэ чинь энэ хонгилын аймаар том зэвсэг шүү, би тэгэхээр энэ зэвсгийг л устгая гэсэн.

Тэгээд эд нар нэлээн ярьж байгаад л наана цаана болж байгаад ингэсэн. Таны хэлж байгаа шиг Ерөнхийлөгчийн эрх халдаж, Ерөнхийлөгчийн эрхэнд халдсан юм байхгүй. Ер нь цааш цаашдаа Монгол Улсын Ерөнхийлөгч нар хэнийг шагнах вэ, аль салбарын хүнийг шагнаж болдог уу, шүүгчийг шагнаж болдог юм уу, прокурорыг шагнаж болдог юм уу, Авлигатай тэмцэх даргыг шагнаж болдог юм уу, генерал болгож болдог юм уу гэдгээ бодох цаг болчихсон. Би энэ агуулгаар оруулж байгаа шүү, би бусад хүмүүсийн тухай яриагүй.

С.Бямбацогт: Бүгдээрээ саналаа хэлчихсэн шүү дээ. Тэгээд нэгнийхээ үгэн дээрээс дөрөөлөөд нөгөөх нь үг хэлээд байх юм уу? Ажлын хэсэг дээр ярьсан байна

шүү дээ, наадах чинь. Шүүгчдийн зөвлөгөөний хуралдаад шүүгч нар өөрсдөө бидэнд шагнал хэрэггүй гэсэн саналаа гаргаад ингээд энэ саналыг ажлын хэсэг оруулж ирсэн гэж байна шүү дээ. Шүүгчдийн саналаар. Тэгээд байхад л одоо шүүгч шагнах нь зөв. Шагнал буруу гээд. Тэгээд нэгнийхээ үгэн дээрээс өлгөж аваад ярих гээд байх юм. Үгүй ээ, тэгж ярьсан байна шүү дээ. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хариулт бэлдэж байгаарай, бас. Нямбаатар гишүүн нэг минут, Дэлгэрсайхан нэг минут. Дараа нь шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчдээс. Нямбаатар гишүүн.

Х.Нямбаатар: Үгүй ээ, үгүй. Бид нарын энэ өнөөдөр хэлэлцэж байгаа хууль бүхэн энэ хуульд нийцэх ёстой. Монгол Улсын Үндсэн хуульд нийцэх ёстой. Энэ Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэг арван зургаадугаар зүйлд, хүний эрхийн одоо бүх эдэлбэл зохих эрхүүдийг энд заасан байгаа. Нэгдүгээрт. Хоёрт гэвэл байна шүү дээ бид өнөөдөр энэ хуульд нийцүүлж энэ хуулиудаа гаргахын тулд асуудлыг ярьж байгаа болохоос биш би эсэргүүцэхийн тулд энэ асуудлыг яриагүй. Стратификацийн онол гэж энэ онолоор энэ шагналын асуудал манайд бүр их хавтгайрсан. Энэ юу гэвэл нөгөө хуучин системийн үед анги давхаргаар нь бие биеийг нь өрсөлдүүлдэг ажилчин, малчин, тариачин, сэхээтэн гэдэг энэ анги давхарга дээр тулгуурласан ийм шагналын систем манайд энэ өнгөрсөн одоо зуун жилийн хугацаанд илүү их тодорхой болсон. Цаашид бид нар энэ.../минут дуусав/

С.Бямбацогт: Дэлгэрсайхан гишүүн.

Б.Дэлгэрсайхан: Энэ шагналын тухай маргаад байхаар, эсвэл энэ хуулиасаа бүр аваад хаячих л даа. Эсвэл заавал шагналыг нь энэ хуульд заагаад байх юу байдаг юм. Шагнах шагнуулах ч одоо тэр хүний эрхийн асуудал шүү дээ нэгт. Хоёрдугаарт одоо энэ хамаагүй хамааруулж яриад байх юм. Энэ генерал цэргийн цол хэргэмийг чинь тэртээ тэргүй албан тушаал буюу бас явж ирсэн одоо хугацаагаараа авдаг л ийм цол юм байгаа юм. Энгийг бас хоморголж болохгүй байх гэж нэгдүгээрт бодож байгаа юм.

Хоёрдугаарт бол энэ шүүх дээр шийтгэлийг нь одоо баахан чангаруулчихаад сөргүүлээд шагнана гэхлээр үгүй ээ гээд байдаг тийм ийм утга учиргүй юм бас ярьж болохгүй шүү дээ. Хүнийг одоо шүүгч болохлоороо л заавал эсвэл одоо арга хэмжээ авхуулах л байдаг. Арга хэмжээ авхуулах болохлоор төрөл бүрийн арга хэмжээ авхуулдаг. Шагнуулах болохлоор, үгүй гээд ингээд зүтгээд байж болохгүй шүү дээ. Энэ зүгээр л орхичихгүй юу даа, эсвэл заавал тийм биз дээ.

С.Бямбацогт: Гишүүд тал талаасаа байр сууриа илэрхийллээ. Шүүхийн ерөнхий зөвлөл Атарцэцэг гишүүн хоёрдугаар микрофон. Шүүгчдийн зөвлөгөөнөөс энэ санал гарсан гэж түрүүн санал яригдсан. Хоёрдугаар микрофон.

Л.Атарцэцэг: Энэ ажлын хэсэг дээр яригдаад шүүгчид энэ саналыг дэмжиж энэ томьёоллоор орж ирсэн ийм зохицуулалт юм байгаа юм. Зүгээр, үгүй ээ, яах вэ, яг энэ. Одоо нөгөө нэг дөрвөн сарын арванд Засгийн газраас өргөн барьсан төсөлд бол энэ байгаагүй байсан юм. Тийм болохоор энд бол нэг их тийм шагналын асуудал босож ярьж ирээгүй байсан л даа. ая энэ нөгөө нэг шинэ ажлын хэсэг, байгуулагдаад улсын дээд шүүхийн шүүгчид, анхан болон давж заалдах шатны шүүхийн төлөөлөл, шүүхийн ерөнхий зөвлөлийн төлөөлөл, бусад хуульчдаас

бүрдсэн дэд ажлын хэсэг дээр энэ асуудал юу томьёоллоор орж ирээд ингээд дэмжигдсэн юм. Тэгээд ер нь бол зүгээр шүүгчид бол юу гэж энийг үзэж байгаа вэ гэхээр тэр шагналаас бид нар өөрсдөө татгалзъя гээд байгаа нь юу гээд байна гэхээр ер нь шүүгчдийг авсан шагналтай нь холбогдуулж шийдсэн хэргийнх нь төлөө авч байгаа шагнал гэдэг байдлаар одоо нөгөө муухай дээр нь бүр улцан болгож яригдаад байгаа энэ асуудлаас бас жоохон сэргийлж байгаа ийм зохицуулалт.

Тэгэхээр энэ бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд нэг халдсан бүрэн эрхийг нь хязгаарласан ийм зохицуулалт бол биш гэж бодож байна. Шүүгч бол тухайн хүнийхээ хувьд шүүгчээсээ чөлөөлөгдсөн өндөр насны тэтгэвэрт гарсны дараа энэ байгуулсан гавьяаныхаа төлөө энэ одоо шударгаар ажилласныхаа төлөө, хөдөлмөрлөснийхөө төлөө шагнуулах эрх нь бол нээлттэй. Энийг бол шүүхийн ерөнхий зөвлөл хэдийд ч одоо өргөн бариад журмынхаа дагуу шагнуулах энэ асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барих эрхтэй юм байгаа юм. Тэгэхээр шүүгчийн ажил шүүн таслах ажиллагаагаа хэрэгжүүлж байх үедээ энэ шагналаасаа татгалзъя л гэдэг энэ томьёоллыг оруулж ирээд бид ажлын хэсэг дээр санал хураалгаад дэмжигдээд явж байгаа ийм л асуудал юм байгаа юм.

С.Бямбацогт: Ерөнхийдөө ойлгомжтой болчихлоо. Тийм ээ. Санал хураалт явуулна. Саналын томьёоллыг та бүхэнд уншиж танилцуулъя. Хуулийн төсөлд 43.4 гэсэн доорх заалт нэмэх:

43.4.Шүүгчийг олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийн одонгоор шагнах, Улсын тэтгэврийг өргөтгөн нэмэгдүүлэх тухай хуульд зааснаас бусад цол, одон, тэмдэг, шагнал олгохыг хориглоно. Санал гаргасан ажлын хэсэг дэмжье томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ санал дэмжигдсэнгүй. Цаашаагаа явъя.

44 хуулийн төслийн 44 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Шүүгчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах. Асуулт алга байна. Санал хураалт явуулъя ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна. 31.Төслийн 44 дүгээр зүйлийн гарчгийг “Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага” гэж өөрчилж, Арван зургадугаар бүлэгт шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд анхааралтай санал хураалт явагдаж байна. Санал хураалтад 14 гишүүн оролцож 10 гишүүн буюу 71,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 45 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. За санал хураалт явуулъя ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна. 32.Төслийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн “Мэргэшлийн болон” гэснийг, “ашгийн төлөө бус хуулийн этгээд, бусад” гэснийг, 45.5 дахь хэсгийг тус тус хасаж, 45.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 46 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 46.8, 46.9, 46.10 дахь хэсэг нэмэх:

“45.2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 11.1.6, 11.1.7, 11.1.8, 12.1.4-т заасан этгээд нь шүүгчтэй албан

ажлаар уулзах тохиолдолд тэмдэглэл хөтөлж, баталгаажуулан тухайн байгууллагын нууцын асуудал хариуцсан албан тушаалтанд ажлын гурван өдрийн дотор өгөх үүрэгтэй. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэлэлцэх болон албан ёсны тэмдэглэл хийгдэх бусад үйл ажиллагааны явцад шүүгчтэй уулзсан тохиолдолд тэмдэглэл хөтөлж, баталгаажуулах үүргээс чөлөөлөгдөнө.”

“46.8.Шүүгч энэ хуулийн 46.1-д заасан нөлөөллийн мэдүүлгээс гадна энэ хуулийн 45.2-т заасан этгээдтэй уулзсан, харилцсан бөгөөд уг этгээд өөрөө, эсхүл бусдаар дамжуулан тухайн шүүгчид аливаа хэлбэрээр нөлөөлсөн, нөлөөлөхөөр оролдсон, үүрэг, чиглэл өгсөн бол энэ талаарх бүхий л мэдээллийг агуулсан тэмдэглэл үйлдэн Ерөнхий зөвлөлд битүүмжлэн ажлын гурван өдрийн дотор хүргүүлэх үүрэгтэй.

46.9.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 46.8-д заасны дагуу битүүмжлэн ирүүлсэн тэмдэглэлийг хадгалах бөгөөд эрх бүхий байгууллага, эсхүл шүүгчийн хүсэлтээр холбогдох этгээдэд гарган өгнө.

46.10.Энэ хуулийн 46.8-д заасан үүргээ биелүүлээгүй нь шүүгчид сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 78,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Хуулийн төслийн дөчин зургаадугаар зүйлтэй холбогдуулан бичгээр гарсан санал байхгүй тийм үү? Байхгүй байна.

Хуулийн төслийн дөчин долоодугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүдээ байвал нэрсээ өгье. Алга байна, орохгүй байна ороогүй байна. Амарсайхан гишүүн. Амарсайхан гишүүнээр тасаллаа.

С.Амарсайхан: 47.9.3 дээр Засгийн газар, улсын дээд шүүхийн болон бусад шүүхийн төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж, холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэж заасан байгаа юм. Дөчин долоогийн есийн гурав дээр. Тэгээд энэ чинь өөрөө Засгийн газрын тухай хууль, засгийн газрын эрхэнд халдаж байгаа нэгдүгээр асуудал болох гээд байгаа юм биш үү. Хоёрдугаарт тэр шүүхийн одоо өөрийнх нь оруулж ирж байгаа төсвийн төсөл, Төсвийн тухай хууль зөрчсөн, төсөв хөрөнгийн эх үүсвэртэй уялдаагүй үндэслэлгүй төсвүүд орж ирвэл яах юм. Тэгээд тэр чигээр нь Засгийн газар оруулж өгөх ёстой гээд Засгийн газарт үүрэг даалгавар болгоод Засгийн газрын бүрэн эрхэд халдаад тэгээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ийм зүйл заалт зайлшгүй байх шаардлага байгаа юм уу? Энийг нэг тайлбарлаж өгөөч.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулах уу. Дараа нь шүүхийн ерөнхий зөвлөл цалинтай холбоотой асуудал дээр бас хариулахаар бэлдэж байгаарай. Хоёр хувиар нэмэгдүүлнэ гэж байгаа шүү дээ бас. Тийм ээ. Дараа нь хэн Мөнхсайхан багш хариулна. Энхбаяр гишүүн хариулъя ажлын хэсгийн ахлагч.

Б.Энхбаяр: Амарсайхан гишүүний асуултад хариулъя. Энэ Засгийн газраас Үндсэн хуульд зааснаар Засгийн газар улсын төсвийг нөгөө Улсын Их Хуралд өргөн мэдүүлдэг. Тэр утгаараа улсын дээд шүүхийн төсвийг ч гэсэн нөгөө нийт улсын

төсвийн төсөл гэдгээрээ Засгийн газар, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх агуулга яваа. Гол юм нь бол яах вэ Улсын дээд шүүх, шүүхийн ерөнхий зөвлөл ингээд бас Засгийн газраасаа ч бас ингээд хараат болчихоод байгаад байж болохгүй. Төсвийн хувьд. Сангийн сайдын үүдэнд суугаад ерөнхий шүүгч ингээд нэг машин барилга шийдүүлэх гээд ингээд бас байгаад байж болохгүй. Энэ шүүх эрх мэдлийнхээ нөгөө бас эдийн засгийн дархлаа, бие даасан байдлыг хангахын тулд Улсын Их Хурал бас энд хамтын хариуцлага хүлээе. Өөрөөр хэлбэл эхлээд бас Улсын Их Хурал дээрээ Байнгын хороон дээр ирүүлээд. Байнгын хороо нэг танилцаад ямар хүрээ раманд, юу байгаа вэ гэдэг дээр нь нэг танилцаад Хууль зүйн байнгын хороо. Тэгээд үүнийхээ дараа бас Сангийн яам руу тэр танилцсан байдлаараа хүргүүлдэг байя.

Мэдээж Засгийн газар бол тэрийгээ одоо өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд бол түүнийх нь дагуу одоо бас Улсын Их Хуралд өргөн бариад мэдээж Улсын Их Хурал бол эцсийн шийдвэрээ гаргаж явдаг байя. Тэгэхгүй бол өнгөрсөн энэ долоон жилийн байдлыг харахад бол энэ шүүхийн хөрөнгө оруулалт дээр нэг ч төгрөг тавигдаагүй ингээд байдалтай болчихсон. Энэ дээр их дүгнэлт хийсэн. Хоёрдугаарт энэ заалт дээр бас бусад энэ шүүхийн бас эдийн засгийн хараат бус байдал, бие даасан байдлыг хангах чиглэлд гарсан дүгнэлтүүд зөвлөмжүүд бас байдаг юм байна лээ. Энэ заалт өмнөх шүүхийн хуульд бол байсан юм байна лээ. Тэгээд хоёр мянга арван таван оны арван хоёр сард аваад хаячихсан. Гэнэт төсвийн хуультай хамт аваад хаячихсан байна лээ. Тэгээд ингээд шүүхийн эдийн засгийн бие даасан байдлыг хангахтай холбоотой ингээд бас юм байхгүй байна гээд нэг жоохон процессжуулах байдалтай.

Ер нь бол сая Амарсайхан гишүүний яг хөндөж байгаа зарчмын хувьд бол Засгийн газраасаа Улсын Их Хуралдаа нөгөө нэгдсэн төсөвтэйгөө хамт өргөн барих юм тийм. Тэрнээс биш бол дээд шүүх ч гэдэг юм уу, ерөнхий зөвлөл бол шууд Улсын Их Хуралд бол өргөн барихгүй энэ нэг Үндсэн хуультай зөрчилдөнө бас тэгвэл.

С.Бямбацогт: Хариулт хангалттай юу тийм ээ. Амарсайхан гишүүн тодруулъя.

С.Амарсайхан: Яах вэ ойлгож байгаа. Засгийн газар оруулж ирэх ёстой гэж. Тэгэхээр энэ чинь Засгийн газар бууруулахгүйгээр оруулж ирнэ гэдэг чинь үндэслэлгүй. Одоо тийм байр сав ч гэдэг юм уу, ийм ийм одоо асуудлууд шийднэ гээд шат шатны шүүхүүд ингээд шүүхийн байгууллагууд өөрөө өөрсдөө янзын төсөв гаргаад ирдэг. Тэгээд тэрийг нь хүссэн хүсээгүй Засгийн газар бууруулахгүйгээр бууруулах, хасах зүйл байсан ч гэсэн хасахгүйгээр Их Хуралд оруулж ирдэг. Гэтэл Их Хурлын одоо тухай хуулиараа бид чинь төсвийн тухай хуулиараа төсвийг танах, хасах эрхгүй болчихсон байгаа шүү дээ. Их Хурал өөрөө. Тэгээд энэ асуудлуудаа яаж хооронд нь уялдуулах юм. Ямар зохицуулалтыг хийх юм? Их Хурлын төсөв өөрчилдөг төсвийн одоо алдагдлыг нэмэгдүүлдэг, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлдэг асуудал чинь өөрөө хуулиар хязгаарлалттай болчихсон шүү дээ. Энийгээ яаж тооцсон юм. Энийг бас манай ажлын.../минут дуусав/

С.Бямбацогт: Энэ урд нь бол улсууд Сангийн яам руу төсвөө өгөөд Сангийн яаман дээр төсвийг нь тэгээд хянаад тайраад ингээд тэгээд нэгтгээд оруулчихдаг байсан. Одоо яг тийм байдлаар Засгийн газар өргөн мэдүүлсэн юм байна лээ. За энэ дээр ажлын хэсэг ажиллаад бол үндсэндээ холбогдох Байнгын хороондоо хянуулаад,

холбогдох Байнгын хороо хянаад хясах шаардлагатай бол хасаад гэхдээ бууруулахгүй. Урьд жилийнхээс бууруулах гээд зарчим орчихсон шүү дээ. Ингээд Засгийн газар руу хүргүүлээд Засгийн газар тэрийг харин хөндөхгүйгээр нь оруулж ирэхээр ийм байдлаар хуулийн төсөлд орж ирж байгаа юм байна лээ. Ингэж явах нь бас зөв байх цааш цаашдаа бол. Тэгэхгүй бол ерөөсөө л одоо Сангийн яамандаа очоод л бүх төсөв нь хасагдаж байдаг хянагдаж байдаг. Сангийн яамнаасаа үндсэндээ тийм хараат байдалтай болчихоод байгаа. Үүнтэй холбоотойгоор бид нар бол төсөв батлахдаа үндсэн чиглэл бодолд батална, төсвийн хүрээний мэдэгдэл батална. Мөн Улсын Их Хурал төлөвлөгөө батална. Улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, улсын төсөвтэй холбоотой Монгол Улсыг хөгжүүлэх төлөвлөгөө батална.

Энэ дээрээ бид нар бол үндсэндээ тэр яг хүрээ хязгаарт нь заагаад өөрчлөөд батлаад өгчихнө. Тэр хүрээ хязгаарт нь багтааж шүүхийн эрхий зөвлөлөөс болон улсын дээд шүүхээс төсвөө Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо хянаад тэр нь Засгийн газар дээр нэгтгэгдээд л одоо орж ирэх ийм байдлаар бас нэг хараат бус төсөвтэй болгохгүй бол төсвөөрөө бас нэг хараат болчих гээд байдаг асуудал байгаад байгаа гэдэг үүднээс ийм санал орж ирсэн гэж ойлгож байгаа. Тэр шүүгч нарын цалинтай холбоотой асуудал дээр шүүхийн ерөнхий зөвлөл, шүүгчийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн албанд ажилласан хугацааны, докторын зэргийн нэмэгдлээс бүрдэнэ гэххэж байгаа юм. Тэгсэн мөртөө шүүгчээр ажилласан тав дахь жилээс эхлэн жил бүр өмнөх оныхоос хоёр хувиар нэмэгдэж иж байгаа юм. Жил бүр. Энэ чинь давхардсан баахан цалингийн нэмэгдэл болох уу? Энэ нөгөө анхан шатны, давах, мөн хяналтын шатандаа ямар ялгаа, ялгаварлаас үүсэх вэ. Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч? Хоёрдугаар микрофон тав дахь жилээс эхлэн жил бүр өмнөх оныхоос хоёр хувиар нэмэгдэнэ. Дээрээс нь төрийн албанд ажилласан хугацаа нь нэмэгдлээ авна, докторын нэмэгдлээ авна, дээрээс нь онцгой байдлын нэмэгдлээ авна. Албан тушаалын цалингаа бас нэмж авна.

Л.Атарцэцэг: 2015 онд шүүгчдийн цалинг Улсын Их Хурлаас тогтоосноор одоогийн цалин хөлсний хэмжээ мөрдөгдөж байгаа. Бүх Монгол Улсын гурван шатны шүүхийн шүүгчид ганцхан төрлийн нэмэгдэл байгаа. Өмнө нь 93, 2002 оны шүүхийн тухай хуулиар олгож байсан нэмэгдлүүд бүгд хасагдсан. Арван хоёр оны шүүхийн захиргааны шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд энэ шүүгчээр ажилласан таван жил тутам хоёр хувийн нэмэгдэл гэдэг ганцхан нэмэгдэлтэйгээр өнөөдөр Монгол Улсын шүүхийн шүүгчид ажиллаж байгаа. Тэгэхээр улсын дээд шүүх, давж заалдах, анхан шатны шүүхийн бүх шүүгч нар яг энэ таван жил ажиллаад л таван жил тутамдаа хоёр хувийн нэмэгдэл гэдэг ийм нэг л төрлийн нэмэгдэлтэй байгаа юм. Энэ талаар бол энэ шүүхийн тухай хуулийн хэлэлцүүлгийн явцад Монгол улсын шүүхийн шат шатны шүүгчдээс бол ялангуяа анхан шатны шүүхийн шүүгчид давж заалдах ялангуяа биш анхан болон давж заалдах шатны шүүх, хяналтын шатны шүүхэд анх шүүгчээр томилогдон ажиллаж байгаа шүүгчид маш их юу ирүүлсэн санал ирүүлсэн.

Өөрөөр хэлбэл ерөөсөө төрийн албанд арван таван жил ажиллаад шүүгчээр ажиллах ийм боломж олдоод шүүгчээр томилогдсон хүн нөгөө төрийн албанд арван таван жил ажилласныхаа нэмэгдлийг бол ерөөсөө огт авахаа больчихсон. Ингээд таван жил шүүгчээр ажиллаж байж дөнгөж хоёр хувийн нэмэгдэлд ордог ийм нэг тэгш бус байдал байна гэдгээр олон шүүгчид судалгаатай, тооцоотой ийм саналыг

ирүүлсэн юм. Ингээд хэлэлцүүлгийн явцад бол шүүгчид шүүгчдээс ирүүлсэн энэ саналыг үндэслээд энэ хоёр хувийн нэмэгдэл гэдгийг бол хэвээр нь үлдээе. Зүгээр би тооцоо гарахад шүүхийн ерөнхий зөвлөлөөс бол тооцоо гаргаад өгсөн байгаа. Өмнөх хуулийн төсөлтэй бас нэгтгээд одоо би зүгээр санахгүй байна. Энэ хоёр хувийн нэмэгдлээр бол нэг их одоо өндөр тоо гардаг ийм үзүүлэлт бол нэг их байдаггүй юм байна лээ. Тэгэхээр тийм.

Тэгэхээр бол шүүгчийн цалин хөлс нь энэ төрийн бусад албан хаагчидтай адилхан төрийн тусгай албан үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн тусгай албан хаагчийнхаа хувьд төрийн албаны хуульд заасан энэ нэмэгдлүүдээ авах нь зүйтэй юм байна гэдэг энэ юуг бид нар төсөлдөө оруулсан юм. Энэ маань ингээд дэмжигдээд явж байгаа. Тэгээд энэ тооцоогоо хийхдээ бид нар энэ хуулийн зардлын тооцоо хийхдээ бол энэ хоёр хувийн нэмэгдлээр нь оруулчихсан байгаа. Тийм ээ Сайнзориг даргаа, тийм. Төрийн албаны тухай хуулийн тавин долоодугаар зүйлийн нэмэгдлүүдээс гадна тийм гадна хоёр хувийн нэмэгдэл гэдгээрээ бид нар оруулсан байгаа юм. Төрийн тусгай үүргийг хэрэгжүүлж байгаа, төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлж байгаа. Шүүгчид бол өөр ямар ч нэмэгдэл авдаггүй, өөр ямар ч үйл ажиллагаа эрхэлдэггүй. Үйл ажиллагаа зөвхөн эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа нь бас хязгаартайгаар хэрэгждэг. Өөр ямар ч нэмэгдэл урамшуулал байдаггүй ийм албан хаагчид юм байгаа юм.

Тэгэхээр бол бид нар энэ шүүгчийн цалин хөлс нь албан тушаалын цалингаас гадна бусад нэмэлтүүдээсээ Төрийн албаны тухай хуульд заасан нэмэлтүүдээс гадна хоёр хувийн нэмэгдлээ ингээд аваад явахад бол ачаалал нэг их нэмэгдэхгүй гэдэг ийм тооцоо байгаа. Ийм л тайлбар байна даа.

С.Бямбацогт: Ажлын хэсэгт нэмж хариулах уу? Энхбаяр гишүүн нэмж хариулъя.

Б.Энхбаяр: Баярлалаа. Энэ шүүгчийн шүүгч дээр ер нь өөр цалингийн нэмэгдэл гэж байхгүй, бусад нөгөө төрийн тусгай албан хаагчид бол цолны нэмэгдлүүд байгаа, зэрэг дэвийн нэмэгдлүүд байгаа. Шүүгчид ерөөсөө ганцхан нэмэгдэл нь энэ шүүгчээр ажилласан тав дахь жилээс эхлэн хоёр хувийн нэмэгдэл. Тэгээд энэ нь яг хэдэн төгрөг шүүгчийн хэмжээнд нэгдүгээрт байгаад байгаа юм бэ гэсэн нэг сарын нэг 50 орчим мянган төгрөг л байна даа. Хоёрдугаарт энэ бас цоо шинэ зүйл биш. Уг нь одоо УЛСЫН ИХ ХУРЛЫН тогтоолоор байгаа мөртөө Засгаас өгдөггүй юм байна лээ. Бас энэ ерөөсөө ойлгомжтой. Уг нь Улсын Их Хурлын тогтоол дээрээ байгаа юм байна лээ. Энэ хоёр хувийн нэмэгдэл нь. Тэгчхээд засгаас өгдөггүй байсан юм байна лээ. Тэгээд ийм одоо хүртэл, өөрөөр хэлбэл би нөгөө яагаад хэлээд байна вэ гэхээр энэ нөгөө Засгийн газар гэдэг юм уу, Сангийн яамнаасаа хэтэрхий ингэж хамааралтай болчихсон. Их Хурал нь бүр ингээд нэмэгдлийг нь олгоно гээд тогтоол гаргачхаад байхад чинь хүртэл тэр тавин мянган төгрөгийг нь өгдөггүй.

Ингээд нэг та бүхэн бод л доо, таван зуугуулаа энийг авах гэж байгаа бас биш. Энэ нэг ойролцоогоор нэг хоёр зуу орчим шүүгчдийн асуудал бол болов уу таваас дээш жилийнхээр. Хоёр зуу орчим шүүгчдийн одоо яг асуудал яригдах байх. Энийг бас би өөрөө бас ажлын хэсэг дээр ийм санал яригдаж байна гээд тооцоо хийгээд бас

Сангийн сайдтай санал солилцсон. Сангийн сайд бол бас энийг дэмжиж байгаа. Тийм.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч, дээрээс нь шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн хоёр хариулаад байх юм. Ямар ч нэмэгдэл авдаггүй гээд их нэмэгдэхгүй гээд ингээд байх юм. Энэ дээр чинь 47.2 ингээд биччихсэн байна л даа. Шүүгчийн цалин хөлс нь албан тушаалын, цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн албанд ажилласан хугацааны, докторын зэргийн нэмэгдлээс бүрдэнэ гээд. Урьд нь авдаггүй байсан юм байна. Одоо тэгвэл энэ хууль батлагдах юм бол авдаг болох юм байна гэж ойлгож болох уу нэг. Хоёрдугаарт нь шүүгчээр ажилласан тав дахь жилээс эхлэн жил бүр өмнөх оныхоос хоёр хувиар нэмэгдэх нь. Жил болгон хоёр хувиар нэмэгддэг цалин авдаг болох нь. Ийм болох нь, урьд нь бас байхгүй байсан байж болно. Одоо ийм болох юм байна, хэрэв дэмжигдвэл гэж ойлгож болох уу? Харин тодорхойгүй, юу ч авахгүй гээд яриад байх юм. Харин тийм. Ингээд бид томьёолчихсон байна шүү дээ. Атарцэцэг гишүүн шүүхийн зөвлөлийн гишүүн хоёрдугаар микрофон.

Л.Атарцэцэг: Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар шүүгчдэд байгаа нэмэгдэл бол би түрүүн хэлсэн зөвхөн нөгөө нэг таван жил ажиллаад тэгээд хоёр хувийн нэмэгдэл рүү орж байгаа. Эхний юу. Тэгэхээр бол бид нар бол энэ бол төрийн бусад албан хаагчидтай бас ерөөсөө ингээд хоёр хувийн нэмэгдлээрээ ингээд явахад бид нар ижил чиг үүргийг хэрэгжүүлдэг энэ байгууллагуудынхаа албан тушаалтнаас нөгөө нийгэмд яригдаад байгаа шүүгч өндөр цалинтай байна гэдэг энэ ойлголт ерөөсөө юу буруу байгаа юм гэдэг ийм л юм яриад байгаа юм. Тэр хоёр хувийн нэмэгдэлтэй. Тэгэхээр бид нар төрийн тусгай албан хаагчийнхаа хувьд Төрийн албаны тухай хуульд заасан нэмэгдлүүдээ бол авах нь зүйтэй юм. Ингэж байж шүүгчээр анх томилогдсон хүний нөгөө арван таван жил, хорин жил төрийн албанд ажилласан энэ хугацаа нь бол үгүйсгэгдэхгүйгээр энэ баталгаагаа шууд хангуулаад явах юм гэсэн ийм л тайлбар хэлье.

С.Бямбацогт: За за урьд нь авдаггүй байсан. Одоо энэ хууль батлагдах юм бол авдаг болох юм гэж ойлголоо. Гишүүд асуулт асууж хариулт байж дууслаа. 33.Төслийн 47 дугаар зүйлийн гарчгийн “Шүүгч” гэсний өмнө “Шүүх,” гэж нэмж, 47.2, 47.5 дахь хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 47.8 дахь хэсгийн “журам, шалгуур үзүүлэлтийг” гэснийг “шалгуур үзүүлэлт, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох” гэж өөрчлөх:

“47.2.Шүүгчийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн албанд ажилласан хугацааны, докторын зэргийн нэмэгдлээс бүрдэнэ. Шүүгчийн цалингийн хэмжээ шүүгчээр ажилласан тав дахь жилээс эхлэн жил бүр өмнөх оныхоос хоёр хувиар нэмэгдэнэ.”

“47.5.Шүүгчийн албан ёсны айлчлал, томилолт, төрийн ёслол, хүндэтгэл, энэ хуулийн 16.5-д заасны дагуу томилолтоор ажиллах болон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад арга хэмжээний зардлыг шүүхийн төсвөөс санхүүжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 47 тийм ээ? Тийм байна. Гайгүй л гээд байна шүү дээ. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Цалинг нь нэмэх дуртай манай гишүүд. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд бичгээр гаргасан санал байхгүй. Тийм ээ.

48 дугаар зүйлтэй холбогдуулан асуух, тийм байна. 47 хоёр хуваагдсан юм байна. Дараагийн санал хураалт. 34.Төслийн 47 дугаар зүйлийн 47.9.1, 47.9.2 дахь заалтуудыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 47.9.1-47.9.3 дахь заалт болгох:

“47.9.1.Улсын дээд шүүх өөрийн, Ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхээс бусад шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Байнгын хороонд хянуулахаар хүргүүлэх;

47.9.2.Улсын дээд шүүх, Ерөнхий зөвлөл Байнгын хороогоор хянагдсан төсвийн төслийн эцсийн хувилбарыг улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасны дагуу хүргүүлэх;

47.9.3.Засгийн газар Улсын дээд шүүхийн болон бусад шүүхийн төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж, холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;” Санал гаргасан, ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 12 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийнх 48 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Адьшаа гишүүн. Адьшаа гишүүнээр тасаллаа.

Ш.Адьяа: Хасаагүй гэж хэлсэн шүү дээ 48. Хассан юм уу. Хассан юм бол асуух юм байхгүй.

С.Бямбацогт: Тийм хассан юм байна. Бүгдийг нь хасаж байгаа юм байна. Саналаа татаж байгаа юм байна. Адьшаа гишүүн саналаа татаад асуулт асуухаа болилоо. 49 дүгээр зүйл. Төслийн 48 дугаар зүйлийг хасах санал хураагдаж байж хасагдана одоо. Болно. Адьшаа гишүүний микрофон өгье.

Ш.Адьяа: Зэрэг дэвийг нь байхгүй болгох юм бол би санал хэлээд хэрэггүй шүү дээ цаг авч яах юм бэ хэрэггүй. Зэрэг дэвийг нь байхгүй болгох юм бол. Зэрэг дэвтэй холбоотой юм ярих гэсэн байхгүй юу.

С.Бямбацогт: 35.Төслийн 48 дугаар зүйлийг хасах. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя санал гаргасан ажлын хэсэг. Шөнөжингөө байна шүү дээ. Цэцийн дүгнэлт байгаа дараа нь. Цэцийн дүгнэлт хуулийн хугацаатай. Хуулийн хугацаа дуусах гээд байгаа юм.

49 дүгээр зүйл. Хуулийн төслийн 49 дүгээр зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу? 49. Адьшаа гишүүн, Дэлгэрсайхан гишүүн, Энх-Амгалан гишүүн, нэрсээ дарчхаарай. Дэлгэрсайхан гишүүнээр тасаллаа. Адьшаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьяшаа: Би энэ 49.6-д заасан үндэслэлээр асуулт асууя гэж бодож байна. Шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар 65 байна гэж оруулсан байгаа. Гэтэл өнөөдөр энэ шүүгчийн өндөр насны тэтгэвэр 60 настай байх энэ асуудал өнөөдөр бас шаардлагатай байгаа гэж үзэж байгаа юм. Яагаад гэхээр түрүүчийн парламентын үед Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн томилгооны үеэр энэ асуудал их олны анхаарлыг татаж олон удаа хэл ам дагуулсан асуудал болж байсан. Энийг бол манай энэ хуучин сууж байсан Их Хурлын гишүүд үг л мэдэж байгаа байх. Тэгэхлээр энэ цагдаа, прокурор гээд энэ хууль хүчний байгууллагын хүмүүс ч ерөөсөө 60 настай л одоо тэтгэвэрт гардаг ийм юм бараг ховор тохиолдол байгаа шүү дээ.

Тийм учраас заавал одоо энэ шүүгчдийг 65 настай 50, 60 настай гэдэг энэ насны хязгаарыг одоо энэ бусад төрийн албанд ажиллаж байгаад тэтгэвэрт гардаг хүмүүсийн нэгэн адил 60, 65 настай болох ийм шаардлагатай байгаа юм. Тэгэхлээр энэ чинь бүх хүн хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй байна, хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлнэ гэж өнөөдөр энэ шүүхийн тухай асуудлыг ярьж байхад олон нийт ч ийм хүлээлттэй байгаа. Дээр нь өнөөдөр энэ хуулийн төслийг оруулж ирж байгаа ажлын хэсгийнхэн ч ийм бодолтой байх байх гэж бодож байна. Тэгэхлээр би зарчмын зөрүүтэй санал гаргасан байгаа. Энэ саналыг хураалтын үеэр бас энэ зүйлээ бас нэмж тайлбарлая. Ийм одоо санал бодолтой байна, энийг дэмжих ийм боломжтой юу гэдэг талаар бас ажлын хэсгийн гишүүдээс бас асууя.

С.Бямбацогт: За ажлын хэсгийн ахлагч Энхбаяр гишүүн хариулах уу?

Б.Энхбаяр: За чи бас энэ асуултад хариулъя. Энэ төсөлд бол хөндөөгүй ажлын хэсэг бол хөндөөгүй тэгээд зарчмын хувьд бол Адьяшаа гишүүнтэй бас санал нэг байна. Тийм яагаад гэхээр энэ бас бусад прокурор, нөгөө цагдаагийн албан хаагч дээр чинь бид нар чинь дээд насны нь 60 гээд тавьчихсан шүү дээ. Тэгээд бас тэрэнтэйгээ адилхан байх нь зөв байх гэсэн ийм саналтай байна. Адьяшаа гишүүний саналыг дэмжиж байна. Анх удаагаа гэх үү.

С.Бямбацогт: Энх-Амгалан гишүүн асуултаа асууя.

Б.Энх-Амгалан: Би 49.2, 49.2.1, 49.2.2, 49.2.3, 49.3, 49.4, 49.5, 49.7, 49.8 гээд энэ шүүгчийн нийгмийн баталгаатай холбоотой энэ асуудал дээр бол ярих юм алга. Шүүгч хэрэв албан үүргээ гүйцэтгэж яваад нас барсан бол яах вэ, гэмтсэн бол яах вэ, хөдөлмөрийн чадвараа бүтэн алдсан бол яах вэ, хагас алдсан бол яах вэ, эрүүл мэндэд нь хохирол учирсан бол яах вэ, ээлжийн амралттай үед нь яах вэ гэдэг энэ шүүгчийн нийгмийн баталгаатай холбоотой асуудлаар бол энэ хуулийн одоо оруулж ирж байгаа өөрчлөлттэй санал нэг байна. Гэхдээ энэ одоо баталгаанууд дээр бол их олон давуутай заалтууд байлаа шүү. Гэхдээ 49.1 дээр нэг асуудал байгаа юм. Шүүгч эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн даатгалаас хэтэрсэн зардлыг нь бүрэн хэмжээгээр олгоно, цалин хөлсийг нь бүрэн хэмжээгээр олгоно л гэсэн юм байгаа юм. Энэ бол түүнчлэн одоо өвчтэй эсвэл хөгжлийн бэрхшээлтэй болсон ч түүний цалин хөлсийг бүрэн хэмжээгээр олгоно гэж байгаа юм. Энэ одоо хэрэв суурь өвчтэй байж байгаад энэ чинь нөгөө албан үүргээ гүйцэтгэж байгаа биш, одоо тухайн хүн суурь өвчтэй байж байгаад эмнэлэгт хэвтвэл зардлыг нь төрд байх нь дээ янз.

Тэгээд дараа нь тэрнээсээ болоод ямар нэгэн байдлаар одоо хавдартай ч байдаг юм уу, ямар нэгэн асуудлаар ингээд хөгжлийн бэрхшээлтэй болох эсвэл өвчтэй болох юм бол цалин хөлсийг нь бүрэн хэмжээгээр олгох нь дээ. Би ингэж ойлгож байна. Зөв үү? Ингэж цаашаа явж болох юм уу. Ингэх юм бол наадах чинь энд шүүхийн энэ зардлаа ер нь даах уу, яах вэ, зүгээр би хангалттай юм олгочихсон хэлж байна. Тэгэхдээ энэ чинь бол бусад одоо төрийн байгууллагад ажиллаж байгаа хүмүүсээс арай л нэг өөр заалт орчхоод байх юм. Одоо цагдаа хүн хэрэв одоо ингээд хэвтэж эмчлүүлэх юм бол яах юм. Тэгээд прокурор хүн яах юм. Тэр цол мөрдөгчтэй одоо тангараг өргөчихсөн тэр хилчид яах юм. Тэгэхээр яг энэ дээр би нэг тийм цалин хөлсийг нь бүрэн хэмжээгээр олгоно гэсэн энэ заалтыг би сайн ойлгосонгүй. Энийг надад нэг сайн тайлбарлаад өгөөч. 49.6 дээр бол яалт ч үгүй Адьшаа гишүүний саналтай санал бол нэг байна. Одоо гар ч өгдөггүй ингээд л 65 наснаас хойш ингээд байж байх юм бол наадах чинь одоо мөнхөрлөө шүү дээ. Одоо болохгүй, бусадтайгаа яг адилхан байх ёстой. Тэн дээр бол санал нэг байна л гэж хэлэх гээд байгаа юм. Энийг надад нэг хариулаад өгөөч.

С.Бямбацогт: Хэн хариулах юм. Атарцэцэг гишүүн шүүх хэргийн зөвлөлийн гишүүн, хоёрдугаар микрофонд хариулъя.

Л.Атарцэцэг: Гишүүний асуултад хариулъя. Энэ 49 дүгээр зүйлийн нэг. Өмнөх Засгийн газрын төслөөр орж ирсэн бид нар анх төслийг боловсруулахдаа Шүүхийн тухай хуулийн 2002 оны хуулийн 4 одоо нөгөө хууль байсныг нэгтгэсэн. Энэ нөгөө нэг 2002 оны хуульд бол байсан зохицуулалт. Энэ зохицуулалт 12 хоногийн хуулиар бол байхгүй болсон юм. Тэгэхээр бол энэ зохицуулалтыг бол бид нар шүүгчийн нийгмийн баталгааны бол бас их чухал зохицуулалт гэж үзэж байгаа. Ингээд ажлын хэсэг дээр, ер нь энэ өмнө байсан энэ зохицуулалтыг оруулж ирэх нь зүйтэй гэдгээр санал хураагаад, ингээд энэ асуудал бол хөндөгдөж яригдаагүй байгаа тийм.

С.Бямбацогт: Энх-Амгалан гишүүн тодруулъя.

Б.Энх-Амгалан: Амьдрал их баян юм байгаа. Одоо энэ дээр бол одоо ингээд 8, 9 заалт дээр бол маш онцгой, онцгой, ийм эрхүүд байна шүү дээ. 15 жилийн цалинтай тэнцэх шүүгчийн өв залгамжтай олгоно, цалинг нь олгоно. Сүүлийн гурван жилийн жилд цалинтай тэнцэх олгоно барина гээд зөндөө сайхан заалтууд байна. Хэрэв шүүгч гадаадад явж эмчлүүлэхээр бол яах вэ? Энэ эрүүл мэндийн даатгалаас хэтэрсэн зардал болгоныг нь одоо улс төлөх нь дээ. Тэр хүмүүс би хэлж байна шүү дээ. Суурь өвчтэй байж байгаад тэгээд одоо ямар нэгэн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй ч юм уу ингээд хөдөлмөрлөх чадваргүй бол цалинг нь бүтэн олгох нь дээ. Энэ тэгээд цаашаа ингэж явбал бусад нь бусад хүмүүс яах вэ? Төрийн байгууллагад ажиллаж байгаа хүмүүс. Ажил үүргээ гүйцэтгэж явж байгаад ямарваа нэгэн асуудалд орсныг би бол шууд ойлгож байна. Энэ дээр чинь зүгээр ямар ч ажил үүргээ гүйцэтгэж явсан гэдэг юм байхгүй юу. Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн бол тэгнэ, хэтэрсэн зардлыг нь төлнө. Өвчтэй юу, хөгжлийн бэрхшээлтэй болчихсон бол түүний цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгоно гээд биччихсэн учраас л би асуугаад байгаа байхгүй юу. Ингэж болдог юм уу гэж.

С.Бямбацогт: Ажлын хэсэг анхаарах нь байна, тийм үү? Энх-Амгалан гишүүн санал гаргах гэж байна уу? Энх-Амгалан гишүүн санал гаргах гэж байх шиг байна. Дэлгэрсайхан гишүүн асуултаа асууя.

Б.Дэлгэрсайхан: Би энэ Адьшаа гишүүний гаргасан саналаас эсрэг юм ярих гэж байна л даа. 49.6-д энэ шүүгчийг өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар 65 байна. 55 насанд хүрсэн эмэгтэй, 60 насанд хүрсэн эрэгтэй эсхүл бол шүүгч 25 жил ажилласан бол өөрийн хүсэлтээр тэтгэвэртээ гарна гэж. Манай ажлын хэсгийнхэн бол ингээд бусад юман дээр олон улсын жишиг их ярих дуртай, иш татах дуртай улсууд жишээлбэл шүүгчийг бол одоо Америк, Европт дээр бол насаараа сонгож байгаа шүү дээ дээд шүүхийн шүүгч эд нарыг. Тэгэхлээр бид нөгөө хонгил гээд одоо байнга орилж чарлаад байдаг. Насаар нь одоо ялангуяа дээд миний саналаар бол бичгээр өгчихсөн байгаа. Дээд шүүхийн шүүгчийг бас насаар нь сонгох ёстой. Ингэвэл одоо 1 дүгээрт бол тэр хэн нэгний гар хөл гэж яригдаад байхгүй хэн нэгний одоо тавьсан хүн гээд яригдаад байхгүй нэг амар болно.

Хоёрдугаарт бол шүүгч бол удаан ажиллах тусмаа ер нь ямар ч хүн удаан ажиллах тусмаа мэдлэг туршлага одоо улам их хуримтлагдаж энэ одоо хүмүүсийн хувь заяаны дэнсийг дэнслэхэд бол бас энэ чухал шалгуур болж байгаа юм. Энэ ажилласан жил нь. Дээрээс нь манайхан бол одоо бүгд мэдэж байгаа. Дэлхий нийтээрээ бол хүмүүсийн одоо биологийн нас бол уртассан. Манайхан одоо ерөөсөө нэг 50, 60 хүрээд тэтгэвэрт суудаг нэг ийм сонин зүй тогтолтой болчихсон. Ид ажил хийдэг туршлага, хуримтлуулсан насан дээр нь хүнийг одоо тэтгэвэрт хөөгөөд гаргачихдаг. Тэгээд ийм заалт ялангуяа энэ тавин тав, жар хүрээд өөрөө хүсвэл хорин таван жил ажиллаад өөрөө хүсвэл гээд гэдэг юм бол одоо энэ бусад хууль хяналтын байгууллага дээр хараад байхад бол одоо ингээд үндсэндээ бол өөрөө хүсвэл гэдэг биш ямар нэгэн шахалт дарамтаар тэтгэвэрт гаргачхаж байгаа юм. Тийм болгомооргүй байгаа байхгүй юу. Тэгэхлээр эд нарыг бүгдийг нь авч хаяад энэ шүүгч бол 65 нас хүртэл одоо ажиллана. Дээд шүүхийн шүүгч бол насаараа ажиллана гэдэг ийм заалтыг оруулах ийм саналтай байгаа. Би бол бичгээр өгсөн.

Тийм учраас бол бас энэ манай ажлын хэсэг одоо юу гэж үзэж байгаа юм? Ер нь шүүгчийн хувьд бол насаараа бол маш их эрсдэлтэй бөгөөд бидний ярьдгаар бол гал тэвэрч байгаад л ийм л ажил, ажил үүрэг гүйцэтгэж байгаа улсууд шүү дээ. Ял зэмийн тухай болохлоор баахан тал талаас нь одоо ярьж ярьж одоо тавина гэж баахан одоо хатуу гэж ярихад хаашаа юм заалт оруулчихаад тэгээд ийм одоо шалгуур давсан хүмүүсээ яг ид ажил хийх насанд нь одоо тэтгэвэрт гаргах.../минут дуусав/

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулах уу? Санал нэг байна уу, үгүй юу? Хариул, шүүхийн ерөнхий зөвлөл 2 дугаар микрофон. Атарцэцэг гишүүн.

Л.Атарцэцэг: Асуултад тайлбар хэлчихье. Яагаад энэ 65 гээд орчихсон талаар л энэ бас л нөгөө хуулийн төслийг хэлэлцүүлж байх явцад нийт шүүгчдээс авсан саналаар орж ирсэн томъёолол 65 гэдэг томъёолол. Тэгээд энийг одоо 65 байх уу, 60 байхуу гэдэг дээр нэлээн ярилцсан. Өмнөх ажлын хэсэг. Ингээд ажлын хэсэг дээр энэ шүүгч нараас ирүүлсэн энэ саналыг хураагаад ажлын хэсгийн олонхын саналаар 65 гэдэг нь тогтоод ингээд л орж ирчихсэн байгаа зохицуулалт. Ер нь бол зүгээр энэ болоодоо, миний хувьд тайлбар.

С.Бямбацогт: Мөнхсайхан доктор багш олон улсын жишиг дээр ямар байдаг юм, юу гэж бодож байгаа юм.

О.Мөнхсайхан: Энэ чиглэлээр бас судалдаг хүний хувьд тайлбар хэлье. Тэгэхээр Америкийн нэгдсэн улсын Үндсэн хууль бол 1789 онд батлагдсан тэрэн дээр бол одоо шүүгч бүх насаараа ажиллана гээд биччихсэн байдаг. Одоо хүртэл хэвээрээ. Энэ бол одоо сайн тал нь бол шүүгчийн хараат бус байдлыг хангаж өгсөн гэж яригддаг. Сөрөг тал нь юу үүссэн бэ гэхээр ерөөсөө шүүгч өөрөө нас барахгүй л бол ажлаа хийгээд байна гээд одоо 80, 90 хүртлээ ажиллах ийм асуудал бол гарсан. Жишээлбэл 1930, 1940-өөд онд бол нөгөө нийгэм өөрчлөгдөөд ингээд одоо социал асуудлууд гараад хууль гарсан чинь 90 настай одоо зөнөсөн шүүгч нар хуулиудыг Үндсэн хууль зөрчсөн гээд унагаад байна гэсэн маш том шүүмжлэл гарч байсан юм. Тэгээд тэр Рузвелт гээд одоо Ерөнхийлөгч нь бол нийгмээсээ ингээд тасарчхаад байна. Энэ бол болохгүй гээд, тэгээд нөгөө court taken буюу нэмж одоо шүүгч нар томилно гэдэг асуудал яригдаж байсан юм.

Тэгээд энэ сургамж дээр Европ бол одоо үндэслээд ерөөсөө шүүгчийг бүх насаар нь томилж болохгүй юм байна. Тэгэхээр ер нь бол тэтгэврийн насыг одоо зааж өгөх ёстой юм байна гэдэг тэр жишиг рүү ороод Европын одоо миний судалсан нэлээн улсуудад бол тэтгэвэрт гаргаж байгаа юм. Бүх насаар нь томилохгүй байгаа юм. Тэгээд сүүлийн үед бас Америкт яаж байна гэхээр маш хүчтэй явж байгаа нэг юм бол ерөөсөө Дээд шүүхийн шүүгчээ бүх насаар нь ч больё, тэтгэвэр ч больё, 15 жил юм уу ийм тодорхой бүрэн эрхийн хугацаатай байхгүй бол Үндсэн хууль гэж юу вэ, хууль гэж юу вэ гэдгийг эцэслээд шийддэг энэ шүүх чинь ерөөсөө есөн хүн одоо 40, 50 настай хүмүүс томилоод л 40 жил энэ хүмүүсийн үзлээр одоо ардчиллаар гарч ирсэн парламентын хуулийг ч үгүйсгэдэг ийм юм руу яваад байна гэдэг ийм юм бол сүүлийн үед бас гарч байгаа. Тэгэхээр манай жишиг бол энэ Европын арай дэвшилтэт, энэ одоо туршлагатай нийцэж байгаа буюу одоо насны дээд хязгаарыг нь зааж өгч байгаа нь бол бас зөв байгаа юм гэдэг ийм байр суурь байгаа юм.

С.Бямбацогт: Одоо нас зөндөө ярьчихлаа. Одоо ерөнхийдөө ойлгомжтой болчихлоо. Тийм ээ. Санал хураалт явуулна. 49 дүгээр зүйлтэй холбогдуулан 49 дээр чинь 36 дахь санал энийгээ эхлээд ажлын хэсгийг саналаа эхлээд хураалгана тийм ээ. 36.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.2.1 дэх заалтын “өв залгамжлагчид” гэснийг “гэр бүлд” гэж өөрчилж, 49.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 49.7, 49.8 дахь хэсэг болгох:

“49.7.Шүүгчийг өндөр насны тэтгэвэрт гарахад түүний авч байсан сарын дундаж цалингийн хэмжээгээр 36 сарын хугацаагаар тооцож нэг удаагийн тэтгэмж олгох бөгөөд өндөр насны тэтгэврийн хэмжээг түүний авч байсан сарын дундаж цалин хөлсний 80 хувиар тогтооно. Шүүгчийн өндөр насны тэтгэвэртэй холбоотой бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

49.8.Шүүгчийн ээлжийн амралтын үндсэн болон нэмэгдэл амралтын хугацааг энэ хууль болон Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоох бөгөөд шүүгчээр ажилласан таван жил тутамд ажлын гурван өдрийн нэмэгдэл амралт олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14

гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 85.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Одоо гишүүдийн гаргасан саналуудаар санал хураана. Бичгээр гаргасан байна.

Төслийн 49.1 дэх хэсгийн шүүгч эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн даатгалаас хэтэрсэн зардал, түүнчлэн өвчтэй эсвэл хөгжлийн бэрхшээлтэй болсон бол түүний цалин хөлсийг бүрэн хэмжээгээр олно гэсэн 2 дахь өгүүлбэрийг хасах. Энх-Амгалан гишүүн саналаа тайлбарлая.

Б.Энх-Амгалан: Би энэ дээр бас их зөв ойлгоорой. 49.2.1, 49.2.3, 49.3, 49.4, 49.5, 49.7, 49.8 тэгээд энэ одоо шүүгчийн нийгмийн баталгаатай холбоотой албан үүргээ гүйцэтгэж яваад бие махбод нь гэмтэл учирсан, нас барсан, хөдөлмөрийн чадвараа алдсан, эрүүл мэнд нь хохирсон, тэгээд тэтгэвэрт гарах болохоор нь ингэсэн энэ бүх заалтуудыг би бол дэмжиж байгаа. Яах аргагүй тэтгэвэрт гарахдаа 36 сарын сараар нь тооцож нэг удаа шүүгч 80 хувиар одоо цалингийнхаа хэмжээг авна гэдэг бол нэг 5 сая төгрөгийн цалинтай шүүгчид бол бас багагүй мөнгө ирнэ. Би зүгээр нэг л юмыг яагаад би та бүхэнд хэлээд ойлгохгүй, болохгүй байна гэхээр зэрэг энэ өөрөө шүүгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын хураамжийг улсын төсвөөс хариуцна гэдгийг нь бол зөвшөөрч байна. Энэ болж байна. Харин шүүгч эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн энэ зардлын даатгалаас хэтэрсэн хэсгийг нь улс төлнө гэдгийг ойлгохгүй байна. Мөн түүнчлэн өвчтэй эсвэл хөгжлийн бэрхшээлтэй болсон бол түүний цалин хөлсийг бүрэн хэмжээгээр олгоно гэдгийг би ойлгохгүй байгаа юм. Энэ бол нөгөө мэргэжлээс шалтгаалсан өвчин биш шүү дээ. Энэ хүнд байгаа суурь өвчний асуудлыг яах вэ гэдэг асуудал.

Тэгээд энэ чинь ингээд бүрхэг өгүүлбэрээр орчихоор би гадаадад явж эмчлүүлнэ. Ер нь миний элэг жоохон хатуураад байх шиг байна. Ингэнэ тэгнэ гээд ингээд явчихвал улс даах болчих гээд байгаа байхгүй юу. Яг ингэх юм бол бусад хүчний байгууллага бусад одоо энэ төрийн байгууллагууд чинь барьцаж эхэлнэ. Шүүгч гэдэг чинь тусгай хүн, бид нар чинь хүн биш юм уу гээд л эхэлнэ. Тийм учраас энэ заалтыг бол хасчих гэж хэлээд байгаа юм. Энэ дээр тэгээд гишүүд бас нэг бодлоготой ингээд санал хураалтад оролцоорой. Тэгэхгүй бол шүүхийн энэ зардал чинь бол дийлдэхгүй шүү, яг энүүгээр бол. Тэгээд санал хураалт.

С.Бямбацогт: Энх-Амгалан гишүүний саналаар санал хураалт явуулна. Тийм санал гаргачихсан. Төслийн 49.1 дэх хэсгийн шүүгч эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн даатгалаас хэтэрсэн зардал, түүнчлэн өвчтэй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй болсон бол түүний цалин хөлсийг бүрэн хэмжээгээр олгоно гэснийг хасах. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 78.6 хувийн саналаар Энх-Амгалан гишүүний санал дэмжигдлээ. Адьшаа гишүүний гаргасан санал. 49.6.шүүгчийг өндөр насны тэтгэвэрт гарах нас нь 60 байх 55 насанд хүрсэн эсхүл шүүгчээр 25 жил ажилласан шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно. Адьшаа гишүүн саналаа тайлбарлаж үгээ хэлэх үү.

Ш.Адьяа: Эхлээд Энхбаяр чинь.../үг тасрав/

С.Бямбацогт: Тэгэхээр 65 нас, тэгээд яах юм бэ, гурван саналын аль нь төслийн санал. Шүүгчийн шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар

65 нас байна. Харин дээд шүүхийн шүүгч насаараа сонгогдоно. Өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно. Ингээд энэ чинь энэ хоёр чинь хоёрт эсрэг, тэсрэг санал дунд нь төслийн санал байж байгаа шүү дээ. Яах юм бэ тэгээд. Төслийн санал ч яах юм бэ тэгэхээр энийг, манай дэгийн зохицуулалтаа сайн хараарай. Дэлгэрсайхан гишүүн саналаа тайлбарлая.

Б.Дэлгэрсайхан: Би энэ шүүгч юу энэ бас доктор Мөнхсайхан хоёрын саналыг сонслоо л доо. Тэгээд яах вэ ер нь бол энэ төсөл дээр байгаа 65 нас гэдгээр нь үлдээе гэж бодож байна. Харин энэ 55, 60 гэдгийг нь бол авч байсан нь дээр байх. Дээрээс нь энэ 25 жил ажилласан бол өөрөө хүссэн бол гэдэг энэ 25 жил ажилласан 55 хүрсэн эмэгтэй, 60 хүрсэн эрэгтэйгээ оруулчихлаар зэрэг манайхан ингээд дээрээс нь шахаад, одоо тэтгэвэртээ гар гээд ямар нэгэн байдлаар ахуйн буюу ёс суртахууны ингээд дарамт үзүүлээд ингээд тэтгэвэрт гаргачхаад дараагийн хүнээ томилох ийм юу үүсэх вий л гэж бодоод байгаа юм л даа. Тийм учраас бол ядахдаа энэ хуульд орж ирсэн төслөөр нь 65, тэр бүх насаар нь гэдгийг нь татаж аваад 65 гэдгээр нь үлдээе л гэдэг иймээр санал хураалгая. Үгүй ээ, үгүй тэр тийм байхгүй. Ер нь бол олон улсын жишгээ бас бодох хэрэгтэй шүү дээ. Одоо бид бүгдээрээ ингээд зөвхөн одоо энэ гаднынхныг их ярих дуртай. Одоо Америкийн Ерөнхийлөгч гэхэд чинь одоо 70, 80 хүн өрсөлдөж байна шүү дээ. Та нар одоо ич л дээ. Шүүмжлэх нь ямар хамаатай юм, тэгээд л өрсөлдөөд л байгаа биз дээ. Одоо бид нарын ярих дуртай. Тийм учраас энэ жоохон тогтвортой байх, цаашдаа одоо бас энэ мэдлэг туршлага, бас энэ хүмүүсийн хувь заяаны асуудлыг дэнсэлж байгаа улсуудын хувьд бол энэ нь зөв байх л гэдэг ийм л саналтай байгаа юм.

С.Бямбацогт: Адьшаа гишүүний санал дээр санал хураалт явуулна. 49.6.шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах 69 нас байх, 55 насанд хүрсэн, эсвэл шүүгчээр 25 жил ажилласан шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэврээ тогтоолгож болно. Санал гаргасан Адьшаа гишүүн дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 12 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Одоо тэгэхээр таны саналаар санал хураалгах боломжгүй болж байна.

49.6.Алтанхуяг гишүүний санал байна. Шүүгчээр 30 болон түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно. Бүр наашлах нь байна шүү дээ. Одоо тийм хоёр дахь өгүүлбэр нэмэх юм уу. Алтанхуяг гишүүн саналаа тайлбарлах уу. Эмэгтэй 55, эрэгтэй 60 гэж байхгүй бол энэ чинь эрэгтэй нь 55 болох гэж байна шүү. Тийм. Алтанхуяг гишүүн.

Н.Алтанхуяг: Наадах чинь би уг нь нөгөө эхний хэсэгтэй нь хамт бичсэн Адьшаа гэж гишүүнийхтэй давхцаад хасчихсан юм. Одоо дангаараа бие даахаар утгатай болж байна уу үгүй юу би бас мэдэхээ байчихлаа. Өмнөх 60 гэдэгтэй чинь хамт явж байсан юм л даа. Энэ санаа нь бол ийм юм. Дээдэх чинь бол 60 гэж байгаа юм. Энэ дээр болохлоор 55 гэж байгаа юм. Тэгэхээр яагаад 55 болчхов гэхээр 30, шүүгчээр 30 болоод түүнээс дээш хэд жил ажиллачихсан бол тэтгэвэр тогтоолгоод л гэж байгаа юм. Ер нь нэг юман дээр их удах хэрэггүй л гэсэн юм л даа. Энэ тэр эхнийх минийх энэ хамт байсан юм. Тэгээд сая давхцахаар нь би хасаад хаячихсан юм. Тэгээд минийх ингээд дангаараа үлдчихээр утга учир байна уу та нар бас яриарай. Өмнөхтэйгөө нийлж байвал утгатай байсан юм. Харин тийм.

С.Бямбацогт: Үгүй ээ, бараг татчихвал. 30 жил чинь ер нь тэгээд магадлал их бага л даа.

Н.Алтанхуяг: Харин зүгээр, тэг. За нэг санал хураалгаад байх. Би ер нь ерөнхий санаагаа хэлчихлээ эхнийхтэйгээ хамт байсан юм. Одоо салчихсан юм. Тэгээд нэг санал хураалгаад байх.

С.Бямбацогт: 25 жил 30 болохоор нөгөө тэр нөгөө наад шүүгч болохын тулд бас л байна шүү дээ өндөр шалгууртай 5 жил, 10 жил ажилласан байна. Алтанхуяг гишүүний санал. Шүүгчээр 30 болон түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно. Хоёр дахь өгүүлбэр энэ 49.6 дээр хоёр дахь өгүүлбэр нэмэх гэж байгаа шүү. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. 49 дүгээр зүйлээр санал хураалт явуулж дууслаа. Бичгээр гишүүдээс гаргасан саналуудаар. Хуулийн төслийн тавьдугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Энэ дээр, Энх-Амгалан гишүүн асуултаа асууя. Энх-Амгалан гишүүнээр тасаллаа.

Б.Энх-Амгалан: Энэ тавьдугаар зүйлийг гишүүдээ нэг хараад байхаарай. Шүүгчийн мэргэжлийн түвшинг дэмжих гэж байгаа юм. Тэгээд энэ дээр яаж байна гэхээр шүүх бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг мэргэжлээ дээшлүүлж байх үүрэгтэй бөгөөд жил бүр сургалтад хамрагдана. Шүүгч мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах хугацаанд түүнд шүүгчийн цалин хөлсийг хэвээр олгоно. Энэ нөгөө бид нарын түрүүний яриад байсан 43.6-д нөгөө гадаадад хоёр жилээр сурна тэр үед нь ажлын байрыг нь хэвээр хадгална. Шүүгч гэдэг хүн одоо заавал гадагшаа сурч байх ёстой гээд байдаг энэтэй энэ чинь мэргэжлийн түвшинг нь дээшлэхдээ энэ чинь цалин мөнгийг нь хэвээр олгоно гэдэг энэ юм чинь ингээд явчихаар цаашдаа хоёр жил нөгөө гадаадад сурах юм чинь ингээд цалин мөнгө нь ороод ажлын байр нь хадгалагдаад ингээд нэг зөрчилтэй юм болчих гэж байна шүү. Энийг анхаараарай. Түүнээс түрүүний бол асуудал чинь ингээд дэмжигдээд явчихлаа шүү дээ. Өөрийн хүсэлтээр одоо ингээд гадаадад хоёр жил сураад эрдэм шинжилгээний судалгаа ажил хийгээд ингэхэд нь бол ажлын байрыг нь эргээд ирэхэд нь хэвээр хадгална гээд. Тэгээд энэ дээр чинь эргээд 50.2 дээр түүнд шүүгчийн цалин хөлсийг хэвээр олгоно гээд. Ийм нэг юм болчихлоо.

С.Бямбацогт: Нямбаатар гишүүн хариулъя. Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Энэ нөгөө төслийн санал учраас би хариулъя. Энх-Амгалан гишүүний асуултад. Энэ бол одоо ч хийгдэж байгаа сургалт. Энэ бол нөгөө үргэлжилсэн сургалтын тухайд асуудал байгаа. Сая бид нар энэ төсөл дээр хорин хоёрдугаар зүйл дээр улсын дээд шүүхийн дэргэд сургалт судалгааны хүрээлэнг одоо байгуулахаар үлдээсэн байгаа. Тэгэхээр энэ дээр энэ байгууллага шүүгчдийнхээ үргэлжилсэн сургалтыг хариуцна. Шинээр батлагдан гарч байгаа хууль тогтоомжийн хуулийн хэрэглээний асуудлыг шүүгч нарт таниулах энэ сургалтууд явагдана. Өмнөх нөгөө бид нарын ярьсан миний одоо эргэж хараарай гээд байдаг протокол тэмдэглүүлж үлддэг сургалт бол ахисан түвшний сургалт буюу эрдмийн цол зэрэг хамгаалах, докторантурт суралцах энэ чиглэлээр бүр 2 жил өөрийнхөө одоо эрх бүрэн эрхээ хэрэгжүүлэлгүйгээр, ажлын байраа хадгалуулж явах сургалт. Энэ бол

ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ үргэлжилсэн сургалтыг цаг ямагт одоо манай энэ шүүгч нар маань авч байх ёстой. Энэ сургалтын тухай энэ 50 дугаар зүйлээр зохицуулж байгаа юм.

С.Бямбацогт: Нямбаатар сайдын тийм хууль санаачлагчийн тайлбарласан, хариулсан үзэл баримтлалаар бид нар хуулийн төсөл протоколд үлдээгээд цаашдаа журмаа гаргаж хуулиа хэрэгжүүлэхдээ яг энэ агуулгаар хэрэгжиж явна. Тэгэхгүй одоо Энх-Амгалан гишүүний хэлж байгаа тийм үү гадагшаа яваад өгөх, мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх гэж байна гээд ахисан түвшний сургалт гээд энд хамаарахгүй нь байна шүү. Ингэж хууль хэрэгжүүлэхдээ бас протокол тэмдэглэж үлдээж байна. Зөв үү? Тавьдугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж дууслаа. Санал хураалт байхгүй байна. Бичгээр гарсан санал байхгүй байна, протоколд үлдсэн.

Тавин нэгдүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулт асуух гэж нэрсээ өгнө үү. Алга байна. 51 дүгээр зүйл. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 37.Төслийн 51 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 51.2.3 дахь заалт нэмж, мөн зүйлийн 51.9 дэх хэсгийг хасах:

“51.2.3.ажил хэргийн нэр хүнд;” санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 78.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Ажлын бичгээр гарсан санал байхгүй, тийм ээ.

Хуулийн төслийн 52 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Энх-Амгалан гишүүнээр тасаллаа. Амарсайхан гишүүн байсан. Амарсайхан гишүүн эхлээд асууя. Амарсайхан, Энх-Амгалан, Нямбаатар, Адьшаа гээд 4 гишүүнээр тасаллаа. Хэдүүлээ хуралдана. Тэгэхгүй бол болохгүй байх. Цагаа сунгачихъя. 18 цаг болж байна гишүүдээ. Тэгээд энэний дараа бас цэцийн дүгнэлт хэлэлцэнэ. Хуулийн хугацаатай хуулийн одоо хугацаа дуусах өдөр өнөөдөр байж байгаа. Тийм учраас өнөөдөр хуралдаад дуусна. Тэртээ тэргүй л манай Байнгын хороо энэ Шүүхийн хуулийг хэлэлцэж дуусгана. Өнөөдөр дуусах уу, маргааш дуусах уу бид л хэлэлцэж дуусах юм чинь. Одоо тэгээд нөгөө жаргалын удаан зовлонгийн түргэн гэж өнөөдөр дуусгачихъя. Цаг сунгалаа. Хэлэлцэх асуудлаа өнөөдрийг дуустал. Тамгын газраас хоол бэлдүүлээрэй. Тэгээд тийм ажлын хэсэгт. Амарсайхан гишүүн асуулт асууя.

С.Амарсайхан: 52.1 шүүгч хүний үндэс угсаа, хэл, арьс өнгө, үзэл бодол, эрхэлж байгаа ажлаар нь ялгаж болохгүй гэж зөв. Энэ бол одоо хаана ч байдаг шаардлага. Тэгэхдээ одоо манай ажлын хэсгийн гишүүний нөгөө би энэ Мөнхсайхан доктороос асууя гэж байгаа юм. Тэгээд нэг хүний эрхийг дээдэлсэн ардчиллын бэлгэ тэмдэг болсон Америк одоо ингээд эрхэлсэн ажил үүргээр нь ялгаварлаад байдаг асуудал бас байдаггүй байх. Тэгээд түрүүний би энэ өмнө нь хураасан саналтай уялдуулж ярих гээд байгаа юм. Тэгээд шүүгчид ямар нэгэн шагнал урамшил гэхээс илүүтэй шагнал одоо сайшаал авч болохгүй гээд байгаа чинь энэ хүний эрхийг зөрчсөн дахиад энэ шүүгч хүн биш гэж одоо үзэж байгаа агуулга чинь энэ 52.1.3-аар нотлогдож бас энэ чинь нэг ийм хуулийнхаа өмнөх зүйл заалт хураасан саналтай та нарын илэрхийлж байгаа байр суурьтай чинь зөрчилдөөд байгаа юм биш үү. Шүүгч хүнийг ялгаж болохгүй. Тэгэхдээ хүн бусад нь шүүгчийг ялгаж болно гэдэг энэ

хандлага гээд. Иймэрхүү жижиг сажиг алдаанууд гаргамааргүй байгаа юм. Тэгээд энийгээ тэр өмнөх одоо санал хураалгаж хасагдсан зүйл заалттайгаа та хэд ер нь яаж уялдуулах гэж байгаа юм бэ? 52.1.3, 31 уучлаарай 31 байна шүү дээ.

С.Бямбацогт: 52.1.31. Ажлын хэсэг хариулъя, хэн хариулах вэ? За Мөнхсайхан багш 2 дугаар микрофон.

О.Мөнхсайхан: Баярлалаа. Та 52-ын хэд гэсэн бэ уучлаарай Амарсайхан гишүүн. 31. Баярлалаа. Тэгэхээр тийм ер нь бол Монгол Улсын Үндсэн хуулийн арван дөрвийн хоёрт бол хэнийг ч ялгаварлан гадуурхаж болохгүй гэдэг ийм суурь зарчимтай. За ялгаварлан гадуурхаж болохгүй гэдэг маань юу вэ гэхээр зүй ёсны үндэслэл шалтгаангүйгээр хүмүүсийг ялгаж аль нэгийг нь дээрд үзэж, эсвэл доорд үзэж хандаж болохгүй гэдэг ийм агуулга байдаг. Жишээлбэл арьсны өнгөөр нь ч юм уу, хүйсээр нь ч юм уу ялгаатай хандаад нэгийг нь дорд үзэх юм бол энэ ялгаварлан гадуурхал болдог. Харин зүй ёсны үндэслэл шалтгаан байгаад тэрний дагуу ялгаатай хандаж байгаа нь бол ялгаварлан гадуурхал болдоггүй. Одоо жишээлэх юм бол шүүгчээр ажиллана гэдэг бол тэр эрх мэдлийг хэрэгжүүлээд хуулийн засаглалыг тогтоох мэдлэг чадвар, ёс зүйтэй байх шаардлага л тавигдаж байгаа юм. Тэрийг хангасан хүн л зөвхөн шүүгчээр томилогдоно. Хангаагүй хүнийг томилохгүй байгаа явдал бол ялгаварлан гадуурхал биш тийм. Тэгэхээр энэнтэй төстэйгөөр бол юу вэ гэхээр түрүүн шийдсэн шагнал урамшууллын асуудал бол шүүгч нарын маань өөрсдийн саналаар одоо алдарт эхийн одонгоос бусад шагналыг бол олгохыг хориглох зохицуулалт орж ирж байгаа нь бол энэ бол бас ялгаварлан гадуурхал биш болов уу гэж харж байгаа.

Яагаад гэхээр энэ бол өөрөө цаанаа зүй ёсны шалтгаан үндэслэл байна гэж харж байгаа юм. Яагаад вэ гэхээр манай өнөөдрийн бас байж байгаа байдал, соёл бол яаж байна гэхээр тодорхой хэрэг шийдсэнтэй нь уяж тэр шагнал урамшууллыг нь холбодог ийм зүйлүүд бол ойлголт төрдөг. Жишээлэх юм бол зарим нэг одоо олон нийтийн анхаарал татсан хэргийг шийдсэн, дөнгөж 30 гаран насны одоо хүнийг бол, эсвэл энийг шийдэхэд оролцсон хүмүүсийг алтан гадас одонгоор шагнасан гээд л ийм яриа хуулийн салбарт явж байсан байхгүй юу. Тэр нь одоо, жишээ нь алтан гадас одон гээд тэгэхэд чинь 40 гарч байж авдаг. Тэгэхээр тийм залуу хүнд өгөх нь зөв үү, үгүй юу нөлөөнд орсон уу гээд л бөөн хардлага сэрдлэг гээд. Тэгэхээр энэ бол өөрөө нөгөө талаасаа одоо янз бүрийн ийм асуудал гарч байгаа учраас энэ шалтгаан дээр. Өөрөөр хэлбэл шүүгчийн хараат бус төвийг сахисан байх тэр үүргийг үүргээ хэрэгжүүлэх боломжийг нь олгох үүднээс өнөөгийн нөхцөлд бол ийм хязгаарлалт хийсэн. Түрүүчийн санал бол ажлын хэсгийн саналын 52.1.31-тэй бол зөрчилдөхгүй. 52.1.31-д байгаа энэ ялгаварлан гадуурхаж болохгүй, дарамт үзүүлж болохгүй гэж байгаа нь бол шүүгч өөрөө эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ өөрийнхөө өмнө байгаа этгээдүүдийг ялгаварлаж болохгүй гэсэн ийм агуулга байж байгаа.

Энэ бол өөрөө өнгөрсөн 3 сард Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас манай улсын шүүхийн хууль тогтоомжийг судлаад энэ шүүгч нартай ялгаварлан гадуурхахыг хориглох зохицуулалтаа хуульдаа тусгах нь зүйтэй. Энэ бол олон улсын жишиг. Тэгээд шүүхийн өмнө байж байгаа хүмүүс бол арьсны өнгө хөрөнгө, хөрөнгө чинээ, хөдөө амьдардаггүй, хотод амьдардаггүй гэх мэт ялгаагүйгээр одоо шүүгч бол бүх үйлдлээрээ тэгш хандах ёстой. Зүй ёсны

үндэслэлгүйгээр аль нэг талд нь давуу байдал олгож болохгүй, тал засаж болохгүй гэсэн ийм утгаар одоо хориглолт хийе гэдэг тэр жишиг бол явж байгаад энэ ажлын хэсгийн санал дээр тусаж ирсэн. Энэ бол бас 2010, 2014 оны үе үеийн шүүгчийн ёс зүйн дүрэмд бас энэ ялгаварлан гадуурхахыг хориглож ирсэн. Тэгэхээр энэ заалтын санаа нь бол шүүгч өөрөө бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ одоо хүмүүсийг ялгаварлаж болохгүй гэдгийг нь хориглоод энийг зөрчих юм бол сахилгын арга хэмжээ авна гэж байгаа юм. Тэгээд энэ маань Үндсэн хуулийн 19.4.1-д байдаг. Хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш гэдэг тэр зарчмыг одоо тодотгож өгч байгаа маш чухал ийм одоо заалт байгаа гэж ойлгож байгаа.

С.Бямбацогт: Баярлалаа Энх-Амгалан гишүүн асуултаа асууя.

Б.Энх-Амгалан: Энэ 52 дугаар зүйл бол ингээд нийтийн албанд болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухайн шүүгч ч гэдэг тэр албан тушаалд тавигдах хориглолт, хязгаарлалт, ёс зүйтэй холбоотой ийм асуудлууд ингээд бүгд багтсан байгаа юм. Тэгээд би энэ 52.1.20 дээр байна, хэргийн оролцогч болон бусад этгээдтэй албан үүргийн хувьд харилцахдаа зүй бус авирлахыг хориглох. Энэ бол болж байна болж байна. Эсвэл хуралдааны дэг сахиулах хүрээнд бусдын зүй бус авирыг таслан зогсоох талаар шаардлага тавихгүй байх. Үгүй тэр хуралдааны чинь танхимд орж ирээд нэг нөхөр дөвчигнөөд болох бүтэхгүй юм яриад улс төржөөд, эсвэл одоо ингээд гүтгэгдсэн барьсан юм яриад ингээд хашчихаад байвал энийг чинь одоо дэг сахиулна биз дээ. Тэгээд энийг нь ингээд шаардлага тавихгүй хориглочигоор, тэнд чинь одоо яаж одоо шүүх хуралдаан явж яаж шийдвэр гаргах юм? Энийг би сайн ойлгохгүй байна, нэг дэх нь.

Хоёр дахь нь 52.1.36 шүүхэд гэрчээр дуудагдсан, эсвэл өөрийн удирдлага дахь албан ажил, алба ажилтны талаар тодорхойлохоос бусад тохиолдолд гэж байгаа. Хүний зан байдал, ёс зүй, нэр төр, ур чадварын талаар тодорхойлолт гаргана гэж байна. Яах вэ, өөрийнхөө удирдлагад байгаа тэр албан хаагчийн талаар бол тодорхойлолт гардаг байж. Ажил байдлын бусад юмны. Үгүй ээ яагаад яахаараа гэрчээр дуудагдсан хүний зан байдал, ёс зүй, нэр төр, ур чадварын талаар шүүгч тодорхойлолт гаргах ёстой гэж? Тэр чинь гэрч болохоос биш тэр шүүх тодорхойлолт гаргаад сууж байдаг хүн биш шүү дээ. Энэ яагаад ингээд орчихсон юм. Энэ хоёрыг надад нэг сайн тайлбарлаадхаач.

С.Бямбацогт: Мөнхсайхан багш, 2 дугаар микрофон.

О.Мөнхсайхан: Энх-Амгалан гишүүнд баярлалаа. Тэгэхээр та маш чухал асуулт асуулаа. 52.1.20-д бол энэ шүүх хуралдааны дэг сахиулах хүрээнд одоо бусад этгээд зүй бусаар авирлаж байх, юм бол таслан зогсоох шаардлага тавих бол үүрэг шүүгчид одоо би ёс зүйн дүрэм хуулиар ч байгаа, өмнө нь ч байж ирсэн. Тэгээд энд бол ийм шаардлага тавихгүй байх юм бол энэ сахилгын арга хэмжээ болно шүү гэдэг байдлаар тодотгож орж ирж байгаа. Тэгээд энэ бол бас өнгөрсөн хугацаанд Монгол Улсын шүүхийн ёс зүйн хороон дээр яг ийм кэйс гараад шийдэгдэж байсан юм. Яасан бэ гэхээр хэргийн оролцогчид бие биетэйгээ маргасан. Тэгсэн чинь нэг тал нь нөгөө талаа бол бүр одоо энэ танхимд хэлэхийн аргагүй үгээр ингээд доромжлоод янз бүрийн нэр хоч өгөөд байсан байх юм. Тэгсэн чинь шүүгч бол тэрийг нь зогсоож одоо шаардлага тавих нь битгий хэл нөгөө нэг одоо доромжлуулаад байгаа тал нь та энийг

таслан зогсоох дээр анхаараач гэж хэлсэн чинь ингэж хэлүүлснээрээ одоо юугаараа хохирчхоод байгаа юм бэ гээд нөгөө одоо доромжлогдсон хүнийг бүр ингээд нэрмээс болсон. Ийм юу гарсан. Тэгээд энэ бол Шүүхийн ёс зүйн хороон дээр би одоо үгийг нь бол хэлж чадахгүй байна. Энэ нийтэд бол. Аймшигтай үгээр хэлсэн байгаа юм.

Тэгээд Шүүхийн ёс зүйн хороон дээр энэ дээр бол энэ сахилгын зөрчил юм байна, шүүгч бол мэдээж бусдын үйлдлийг бол хянаж чадахгүй. Гэхдээ тэр дэг сахиулж байгаа учраас тэр зохисгүй байдлаар одоо авирлаж байгаа этгээдийг зогсоо гэж шаардлага тавих ёстой юм байна. Энийгээ биелүүлээгүй юм байна, энэ бол сахилгын зөрчил гээд сахилгын шийтгэл ногдуулсан. Тэгээд энэ бол давах болон хяналтын шатаар хянагдаад сахилгын зөрчил гаргасан нь энэ шүүгчийн хувьд үнэн юм байна. Энэ дээр бол маргаан алга. Одоо тэр дэгийг сахиулж зүй бус авирласан үйлдлийг зогсоогоогүй юм байна. Гэхдээ энэ дээр нөгөө нэг жилийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрчихсөн юм байна гээд тэр хэргийг нь хэрэгсэхгүй болгосон хугацаа өнгөрсөн гэдгээр хэрэгсэхгүй болгосон. Гэхдээ зөрчил гэдгийг нь зөвшөөрсөн. Энэ одоо практик бас олон улсын жишиг харгалзан орж ирсэн.

Хоёр дахь зүйл бол энэ гэрчийн мэдүүлэг өгөх удирдлага дахь ажилтныхаа одоо зан байдлын талаар тодорхойлохоос бусдаар бусад этгээдийн ёс зүй, нэр төр, ур чадварыг тодорхойлохыг хориглож өгч байгаа. Энэний цаад санаа бол жишээлбэл шүүгч бас хүн очоод ингээд гудамд явж байсан, тийм үү. Тэгсэн чинь улаан цайм ингээд гэмт хэрэг гарчихлаа, одоо бусдын амь насыг бүрэлгэдэг юм уу, цохиж зоддог юм уу, тэд тэрийг шүүх зүгээр харчихсан хөндлөнгөөс харчихсан. Энэ тохиолдол бол одоо шүүгч бол эрүүгийн процессын хуулиар зохих журмаараа гэрч, гэрчийн этгээд байгаа байхгүй юу. Яагаад гэхээр тэр зүйлийг хөндлөнгөөс харсан. Тэгэхээр яг энэ журмаар бол одоо эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх процесс дээр гэрчийн мэдүүлэг өгч болно. Өөрийнхөө тэр харсан үйл явдлыг, юу харсан гэдгээ одоо үнэн зөвөөр мэдүүлэх үүргээ биелүүлнэ гэсэн үг.

Тэгэхээр энэний энэ үүргээ бол энийг бол яах вэ гэхээр шүүгч одоо хориглож болохгүй. Бас өөрийнх нь удирдлагад байж байгаа хүний зан байдлыг тодорхойлохыг хориглож болохгүй. Энэнээс бусдаар бусад этгээдийн зан байдал, ёс зүй, эдийг тодорхойлохыг бол манай одоогийн болон өмнөх хууль тогтоомж ёс зүйн дүрмээр бас хориглож ирсэн. Олон улсын жишиг Банглорын зарчим ч бас хориглодог. Яагаад вэ гэхээр энэ хоёр тохиолдлоос бусад байдлаар шүүгч одоо энэ бол их сайн хүн байгаа юм, энэ бол энэ албан тушаалд тэнцэнэ, эсвэл энэ хүнийг сонгоорой сайн гишүүн болно ч гэдэг юм уу иймэрхүү байдлаар хэлэх нь бол юу вэ гэхээр шүүгчийн нөгөө төвийг сахисан байдлыг алдагдуулдаг, эсвэл тэгж ойлгогддог, эсвэл шүүгчийн нөгөө нэр хүндээ одоо бусад этгээдийн хувийн ашиг сонирхлыг хангахад ашиглаж байгаа гэсэн ийм байдал үүсгэдэг учраас манай практик одоо жишгээр ч, бусад улсын жишгээр ч энийг бол хориглож өгдөг гэсэн ийм одоо одоо уламжлал дээр үндэслээд манай жишиг дээр үндэслээд энэ хориглолт бол орж ирсэн байгаа юм.

С.Бямбацогт: Энх-Амгалан гишүүн нэмэлт нэг минут. Манай ажлын хэсэг бас товчхон тодорхой хариулна шүү.

Б.Энх-Амгалан: Таны тайлбар энэ хууль дээр биччихсэн байгаа. Энэ хуулийн заалт хоёр бол тэгж уншигдахгүй байна. Та бол яаж байна гэхээр хуралдааны дэг

сахиулах үүргээ биелүүлэхгүй байх юм бол хариуцлага хүлээх талаар ярьж байна шүү дээ. Гэтэл энэ дээр чинь бол таслан зогсоох шаардлага тавихгүй байх ийм юм байж байгаа. Тэгэхээр энийг жоохон найруулга өөрчилбөл яадаг юм, таслан зогсоох үүргээ биелүүлэхгүй байх тэр шүүгч чинь таслан зогсоох үүрэгтэй шүү дээ. Тэр үүргээ биелүүлэхгүй байх юм бол энэ бол шүүгчид хориглох зүйл болно, сахилга зөрчил болно гэж оруулахгүй бол энэ чинь зүгээр нэг шаардлага тавихгүй байх гэдэг бол шал өөр асуудал шүү дээ. Таслан зогсоох үүрэгтэй байхгүй юу. Нэгдэх нь тэр.

Хоёр дахь нь шүүхэд гэрчээр дуудагдсан гэдэг энэ чинь бүх хүнд хамрагдана шүү дээ. Гэрчид, бүх гэрч болгонд. Гэтэл таны саяын тайлбарлаж байгаагаар бол шүүх өөрөө гэрчээр шүүгч өөрөө гэрчээр дуудагдсан бол энэ зан байдлыг нь тодорхойлолт, янз янзын юм удаа гаргаж өгөх ёстой гэсэн ийм юмнуудад тайлбарлаж байна шүү дээ. Тэгэхээр энийгээ бас дахиж найруулахгүй бол.../минут дуусав/

С.Бямбацогт: Тийм үүргээ биелүүлэхгүй байх, тэр шаардлага тавихгүй байх үүргээ биелүүлэхгүй байхыг хориглоно. Шаардлага тавихгүй байхыг хориглоно. Илүү үүргээ биелүүлэхгүй байхыг хориглоно гэвэл найруулгын хувьд илүү ойлгомжтой, тодорхой бас хялбар болж байна шүү дээ. Тийм болохоор энийг бас авчих ёстой юм байна шүү. Чуулган руу орохдоо авах нь биш үү? Хонгорзул тийм. Нямбаатар гишүүн асуултаа асууя.

Х.Нямбаатар: Би Энхбаяраас асууна. Энийг бас яг протоколд хэдүүлээ тэмдэглүүлнэ шүү. Энэ бид нар өнөөдөр шүүхийн хараат бус байдал, шүүгчийн хараат бус байдлыг бий болгох, шүүхийн шинэчлэлийг төгөлдөржүүлэхээр хийж байгаа энэ маш том алхам. Энэ дээр бид нар нөгөө долоо хэмжиж нэг удаа огтлох гэдэг энэ зарчмаар л явах ёстой. Шүүгчид хориглож байгаа үйл ажиллагааг нийтдээ дөч болгож өргөтгөж ажлын хэсэг оруулж ирсэн. Энд нэг, хоёр айхтар заалт байгаа. Дэлгэрсайхан гишүүнээ, энэ нөгөө мэргэжлийн алдаатай холбоотой. Жишээлэхэд энэ 52.1.27 дээр шүүхийн шийдвэрт зайлшгүй шаардлагатай үндэслэлийг огт бичээгүй нь дээд шүүхээр тогтоогдсон гээд энэ тохиолдолд энэ хүнийг сахилгын шийтгэл ногдуулахаар ингээд энд хуульчилж орж ирж байгаа. Энэ чинь санкц нь юу байгаа билээ дээ, тийм. Тэгэхээр энийг бид нар эргэж харахгүй бол энэ шүүгч нар маань айдастай, ажил хийж чадахгүй. Эмч хүртэл мэргэжлийн алдаа гаргадаг. Одоо тэгэхээр бид нар өмнө нь нэг юу батлаад өгчихсөн шүү дээ. Та гадаадад Хятад руу юм уу, Орос руу аль нэг улс руу магистр, докторт сурвал танд 2 жилийн хугацаатай цалинтай чөлөө өгнө гээд хуулийн төсөл баталчихсан. Энэ өөрөө шүүгчийг огцруулах үндэслэл болж байгаа юм. Тэгээд мэргэжлийн алдаа гаргадаггүй байгууллага гэж байхгүй.

Дээд шүүхэд хандаад хууль хэрэглээний алдаа гаргасан гээд л бүх хүн гомдоно, гомдсон болгон нь эргээд нөгөө шүүгчдийг ажлаас халах үндэслэл болно. Тэгэхээр шүүгч бол өөрөө хараат бус ажиллах ёстой. Өөрөө эрх зүйн ухамсар, дотоод итгэлээрээ асуудалд хандах ёстой. Энэ тохиолдолд мэргэжлийн алдаа гарч болно. Мэргэжлийн алдаа гаргасан болгоных нь төлөө хүмүүс сахилгын хороонд хандана. Сахилгын хороо яг энэ 52.1.27 бариад нөгөө шүүгчдийг огцруулна. Тэр огцорсон дээр үү, ажлын байраа хадгалуулаад явах уу гэдэг ийм сонголт дээр ирнэ. Тэгэхээр бид нар цаашид энийг бас эргэж нэг айхтар харах хэрэгтэй шүү, гишүүд ээ. Би энэ та бүхэнд энэ маш том шүүхийн хуулийн шинэчлэлийн асуудал ярьж байгаа. Энэ дээр

Энх-Амгалан гишүүнээ яг анхаараад, Дэлгэрсайхан гишүүнээ асуудалд яг анхааралтай хандмаар байна. Бүх мэргэжил дээр мэргэжлийн алдаа гэж байдаг. Мэргэжлийн алдаа гаргасан болгоных нь төлөө ажлаас нь халаад, чөлөөлөөд, огцруулаад байвал болохгүй. Бусдад давуу байдал олгосон, албан тушаалаа урвуулан ашигласан, хээл хахууль авсан энэ бол бүгд авлигын хэргээрээ шийдэгдэнэ. Энэ бусад төрлийн бүх алдаануудыг би одоо хүлээн зөвшөөрч байна. Гол нь энэ саяын энэ хэлж байгаа бол дээд шүүх дээр очоод л асуудал нь хэргийг буруу шийдсэн гэдэг бүх үндэслэлээр л энэ хүнд шүүхээс одоо шүүгч байх эрхийг нь хасаж, огцруулах л ийм л шийдвэр гаргах ийм ур үр дагавартай урхагтай. Энийг бас гишүүд бүгд тал талаас нь бодоорой. Бид нар бас нөгөө нэг нуухыг нь аваад нүдийг нь сохлох вий гэдэг энэ бас үгийг ч гэсэн бодох ёстой шүү. Энхбаяр гишүүн энэ дээр та нэг хариулт өгөөч?

С.Бямбацогт: 2, 27 хоёр дээр ярьсан тийм ээ. Сүхбаатар гишүүн эхлээд хариулчихъя, дараа нь Энхбаяр гишүүн.

Ж.Сүхбаатар: Үгүй ээ, энэ мэргэжлийн алдаа мэргэжлийн хариуцлагын асуудал яриад байгаа юм. Манайхан мэргэжлийн алдаа байдаг шүү дээ л гээд байгаа юм. Мэргэжлийн хариуцлага гэдэг чинь юу юм бэ гэж. Энэ сахилгын хариуцлага чинь одоо мэргэжлийн хариуцлага биш юм уу гэдгээ бас бодох хэрэгтэй шүү дээ. Энэ сахилга гэж юу юм бэ гэхээр тэр дүрэм журмыг хэлбэрэлтгүй, хууль дүрэм журмыг хэлбэрэлтгүй сахин биелүүлэх явдлыг тэрийг сахилга гээд байгаа байхгүй юу. Тэгээд шүүгч хууль, дүрэм журмаа хэлбэрэлтгүй сахин мөрдөхийг энэ сахилгын хариуцлагын чинь асуудал шахаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр мэргэжлийн хариуцлага, мэргэжлийн алдаа гэж нэг тусдаа юм байгаа. Тийм учраас энэ сахилгын юмнаас ингээд тусад нь авч үзэх ёстой гэж. Тэр мэргэжлийн алдаа чинь мэргэжлийн хариуцлагыг дагуулдаг. Тэр мэргэжлийн хариуцлагын чинь гол хэсэг нь сахилгын хариуцлага байхгүй юу. Энэ мэргэжлийн хариу хариуцлагын чинь яг цаана нь юу байна вэ гэхээр зэрэг ёс зүй гэж байгаа юм. Гэхдээ тэр нь мэргэжлийн ухамсартай, хууль хэрэглээтэй холбоотой тэр ёс зүйн ухамсар, соёл байхгүй юу даа. Тэгэхээр энэ хамгийн шүүхийн шийдвэрт зайлшгүй шаардлагатай үндэслэлийг огт бичээгүй гэдэг чинь энэ хамгийн чухал юм байгаа байхгүй юу. Үндэслэлгүй шийдвэр гаргаж болохгүй шүү дээ. Энэ бол хуульч хүний хувьд хамгийн эхний логик байхгүй юу даа. Энийг өөгшүүлэх энэ хөөрхий энэ нэг мэргэжлийн алдаа ш дээ гэж. Энэ бол мэргэжлийн алдаа биш. Мэргэжлийн хариуцлага хүлээлгэх гол ийм факт болсон үндэслэл байхгүй юу даа.

Тэгээд бид нар нэг мэргэжлийн алдаа тойрч яриад. Мэргэжлийн хариуцлага гэдгийг нь бод. Энэ сахилгын процедур чинь юу болдог юм бэ гэхээр явж явж мэргэжлийн хариуцлага хүлээлгэх гээд. Энэ Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт дээр чинь шүүгчийн хариуцлагын зөвлөл гэж явж байсан шүү дээ. Бид нар нэрийг нь сахилгын хороо болгочихсон. Тэгээд сахилга гэдэг чинь бол одоо парламентын сахилга гэж юу юм гэхээр парламентын гишүүн хүн парламентын хууль, дэг журамд хэлбэрэлтгүй сахин мөрдөхийг л парламентын сахилга гэж байгаа байхгүй юу жишээ нь. Энэний чинь цаана ёс зүй гээд явчхаж байгаа юм. Тэгэхээр энэ ойлголтуудын юмаа бодохгүй бол нэг мэргэжлийн алдаа нэг юм байдаг шүү дээ. Тэгээд энэ мэргэжлийн алдаа болгоныг ор. Энэ дотор шүүхийн шийдвэрт зайлшгүй

шаардлагатай үндэслэлээ бичихгүй байна гэдэг чинь мэргэжлийн хариуцлага хүлээх, сахилгын хариуцлага хүлээх факт байхгүй юу даа энэ чинь. Яг энэ дээр жишээ татаж байгаа бол та тавин хоёрын нэгийн хорин долоо чинь. Сох энийгээ хийхгүй ажиллаж байна шүү дээ. Үндэслэлээ бичихгүй энэ тухай л яваа. Чи 52.1.27 чинь хариуцлага хүлээ гэсэн факт байхгүй юу.

С.Бямбацогт: Энхбаяр гишүүн ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Б.Энхбаяр: Нямбаатар гишүүний асуултад хариулъя. Энэ хуулийн шүүхийн реформын амин сүнс болсон хоёр өгүүлбэрийг авч хаях юм ярьж байна. Санаархал. Энэ ямар заалтад гэсэн чинь хуулийн илт тодорхой маргаангүй заалтыг ноцтой удаа дараа зөрчсөн үйлдэлд үйлдлийг хариуцлагагүй болгох гэж байна. Хоёрдугаарт шүүхийн шийдвэрийнхээ үндэслэлийг огт бичихгүй бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон гэдэг энэ үндэслэлийг авч хаях гэж байна. Тэгвэл энэ шүүхийн реформыг хийж яах гэж байгаа юм. Бид энэ хууль шүүгч хүн чинь хэн нэгэн дарга захирагдахгүй шүү дээ. Хуульд л захирагдана шүү дээ. Тэр дотроо Үндсэн хуульд нийцсэн хуульд захирагдана. Шүүхийн дарга нь бол ерөөсөө л хууль, хууль дарга нь юм бол тэр хүн үндэслэлээ заавал бичих ёстой. Яагаад гэдэг үндэслэл тайлбараа бичих ёстой. Ингэж бичихгүй гаргаж байгааг яагаад өөгшүүлэх гээд байгаа юм. Энэ хоёр заалтыг авчихвал тэгээд шүүхийг дураараа ажил гэж байгаа юм уу, хууль барихгүй ингээд дураараа өөрийнхөө үзэмжээрээ шийдээд, ямар ч хариуцлагагүй байх юм уу. Яах гэж Үндсэн хуульд хуулиар бид сахилгын хороог ноднин жил байгуулсан юм.

Энэ сахилгын хороог байгуулсан Үндсэн хуулийн заалт дээр нэг ийм юм байгаа. 49 дүгээр зүйлийн 6 хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий сахилгын хороо ажиллана гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл, шүүгчид хариуцлага тооцох үндэслэлийг зөвхөн энэ хуульд бичиж бичих гэж байгаа юм. Хэрэв эндээс авбал эндээс авбал шүүгчид өөр ямар ч үндэслэлээр хариуцлага тооцох боломжгүй. Яагаад үндэслэлээ огт бичихгүй байгаад байгаа юм. Би одоо Их Хурлын гишүүдтэй холбоотой нэг үндэслэл ярья. Сая Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр Улсын Их Хурлын гишүүнд халдашгүй эрх гэдэг ойлголт байхгүй гэж шийдвэрээ бичээд Их Хурлын гишүүний халдашгүй эрх үйлчилж байхад цагдан хорих шийдвэр гаргасан шүүгчийн шийдвэр Үндсэн хууль зөрчсөн гэсэн цэцийн шийдвэр гарчихсан байна шүү дээ.

Тэр хүн шүүгч Үндсэн хууль зөрчихсөн байна шүү дээ. Энэ чинь ноцтой зөрчил биш юм уу. Тэгээд энийг яагаад өөгшүүлэх ийм боломжийг ингээд яриад байгаа юм. Энэ чинь юу үндэслэлээ огт бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон гэдэг үндэслэл бичээд байна шүү дээ. Сахилгын хороо бас шууд одоо нөгөө шүүгчийг бас дарамтлах гээд оролцох гээд байгаа юм байхгүй байна. Тэр үндэслэлээ огт бичээгүй гэдэг юмыг чинь дээд шатных нь, шүүгч нь тогтоож байж Сахилгын хороо хариуцлага тооцно гэж бас шүүхийнх нь хамгаалалтад хамгаалалтад шүүгчийг өгөөд байна шүү дээ. Тэгээд байхад чинь яагаад ийм одоо хуулиас давсан дур зороороо байдлыг авирласан, ийм шүүгчийг өөгшүүлэх хууль туй май хамаагүй гэж хэлж байгааг нь давраах, хуулийн дээр гарсан авирласан шүүгчдийг хуулийн хариуцлагагүй болгох, ийм санал санаачилгыг гаргаад байгаа юм бэ одоо болоо юм биш үү. Дээд

шүүхийнхэн одоо боль. Та нар ямар ч хариуцлагагүй байх гэсэн ийм одоо уваагүй лоббигоо одоо боль.

С.Бямбацогт: Нямбаатар гишүүн тодруулга нэмэлт нэг минут.

Х.Нямбаатар: Энхбаяраа нэг юмыг хэлнэ шүү хэдүүлээ. Лобби яриагүй. Энд бид нар хууль гаргах гэж байна. Энэ хууль батлах, популизм хийх хоёрын хооронд маш том ялгаа бий шүү. Энд ерөөсөө би хорин гурвын тухай яриагүй. Хорин долоо дээр ярьсан. Шүүхийн шийдвэр зайлшгүй шаардлагатай үндэслэлийг огт бичээгүй байгаа нь дээд шатны шүүхээр тогтоочихсон. Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шийдвэрийг буруутгаж гаргасан шийдвэр болгон дээр анхан шатны шүүхийн шүүгчийг сахилгын хороонд аваачна л гэсэн үг. Тийм би энд дахиад хэлье. Энэ хууль батлах, популизм хийх хоёр өөр. Тэгэхээр би энийг Бямбацогт дарга, Мөнхтуяа шүүгчээс асуумаар байна. Одоо бас яг энэ чиглэлээр энэ мэргэжлийн хуульч, шүүгч хүмүүсийг асуумаар байна. Улс төрч хуульчид бол хууль хийхэд ална шүү. Аюултай шүү. Популизм нь давж явна шүү.

С.Бямбацогт: Жоохон бас хүлээцтэйнхэн шиг байцгаая гишүүдээ. Хүлээцтэй ханд. Тийм. Тэгээд л ерөөсөө л өөрсдийгөө давахын тулд тэгээд л битгий үг хэл л дээ. Авах гээхийн ухаанаа хандаж болно шүү дээ. Саяын одоо тэр тавин хоёрын нэгийн хорин гурав дээр ярьж байгаад тавин хоёрын нэгийн хорин долоо дээр ярьж байгаа шүү дээ. Тодорхой яг утга найруулгын хувьд бас жаахан өөрчлөөд томьёолоод зөөллөөд хаана хаанаа харилцаад авчхаж болно шүү дээ, бас. Тийм ээ, тэгэхгүй тэгээд заавал одоо юу гэдэг юм, зөвхөн миний зөв гээд бас битгий ингээд байгаач гишүүдээ. Адьшаа асуултаа асууя. Мөнхтуяа шүүгч 1 номерын микрофон.

Д.Мөнхтуяа: Баярлалаа. Би энд нэг юу хэлчихье. Тэгэхээр энэ юу төслийн тавин хоёрын нэгийн хорин гурав, нэгийн хорин долоод орсон заалтыг ер нь бол энд ямар нэг одоо гишүүдийг лоббидоод ингээд одоо увайгүй үйлдэл гаргах гээд байгаа ийм санаа зорилго бол байхгүй. Би бол одоо энэ Ж.Сүхбаатар гишүүн бид хоёр их сургуулийн нэг төгсөлт. Өөр бусдыг нь бол танихгүй, ямар нэг байдлаар одоо лобби хийсэн, уулзсан янз бүрийн юм байхгүй. Энэ заалт яагаад болохгүй вэ гэдгийг зүгээр цэвэр шүүн таслах ажиллагааны фракцыг цэвэр амьдрал дээр яагаад одоо энийг болохгүй байгаа гэж шүүгч нар үзээд байгаа вэ гэдэг талаас нь л хэлье. Эцсийн шийдвэр нь мэдээж Их Хурал дээр гаргана. Энэ зүгээр ийм учраас болохгүй шүү гэдгийг мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй ажлын дэд хэсэгт орчихсоны хувьд зүгээр анхааруулж сануулах гэж л энэ юмыг хэлье гэж бодоод байгаа юм.

Тэгэхээр болгоомжлол байна. Яагаад болгоомжлол байгаа вэ гэхээр тавин хоёрын нэгийн хорин гуравт зааж байгаа хуулийн ил тодорхой маргаангүй заалт гээд байгаа юм. Шүүхэд бол ийм заалт байхгүй шүү дээ. Яг юу, яг ямар заалтыг илт заалт тодорхой заалт маргаангүй заалт гээд байгаа юм. Одоо жишээлбэл, торгох, одоо жишээлбэл торгох ял өгөх ёстой юмыг хорих ял өгчихсөн гээд байгаа юм. Энэ бол маргаангүй заалт биш. Энэ бол тэр гэмт хэргийн зүйлчлэлийг зөв буруу хийсэн л асуудал. Өөрөөр хэлбэл нэгийн хоёроор хорих биш, нэгийн нэгээр зүйлчлээд торгох байсан юм байна. Энэ маргаан өөрөө дээд шүүх дээр ч байдаг. Энэ ерөөсөө илт тодорхой асуудал бол биш. Хүний нас хүртэл одоо арван найман нас гээд заачихсан юм мөртөө шүүх дээр маргаантай байдаг юм. Шүүхээр шийдэгддэг асуудал.

Хоёрдугаарт гэх юм бол энэ одоо шүүхийн шийдвэрт зайлшгүй шаардлагатай үндэслэл гээд байгаа юм. Яг ямар үндэслэлийг хэлж байгааг одоо хэн яаж энэ одоо яг ингээд л асуувал хүн болгон өөр өөрийнхөөрөө тайлбарлах байх. Огт юу ч бичээгүй. Огт бичээгүй гэдэг нь одоо цагаан цаас өгөхийг хэлж байгаа юм уу? Шүүхийн шийдвэр гэж цагаан цаас өгөхгүй, тэнд ямар нэгэн юм бичнэ. Үндэслэл дээрээ дутуу бичнэ, буруу бичнэ, зөв буруу юм л байна уу гэхээс биш огт одоо цагаан цаас өгдөг тийм шүүхийн шийдвэр байхгүй. Тэгэхээр энэ нэгдүгээрт ингээд одоо нэр томъёоны тодорхойгүй байдал, агуулгын тодорхойгүй байдал байгаад байгаа. Энэ хоёр заалт дээр. Ийм учраас энэ ямар үр дагавар гаргах вэ гэхээр сахилгын хороон дээр энэ асуудалд очихоор тэнд Сахилгын хороонд энэ гомдлыг авч байгаа гишүүн үзэмжээрээ шийднэ. Алийг нь сахилгын хэрэг олгох вэ, алийг нь болохгүй вэ гэдэг асуудал бодитой одоо ийм асуудал үүснэ. Энд ямар нэг шүүгчид одоо хариуцлага ногдуулахгүй. Шүүгчийг хамгаалах гээд өөрөө шүүгч би эрх ашгийнхаа үүднээс энд ярьж байгаа юм ерөөсөө байхгүй.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ноцтой нөлөө үзүүлж болзошгүй. Жишээлбэл би гуравхан зүйл дурдчихъя. Нэгдүгээрт нь яадаг вэ гэхээр энэ бол цэвэр одоо хэрэг хянан шийдвэр одоо шүүгч нарын практикт байж байгаа. Өнөөдөр хүмүүс ямар асуудлаар ёс зүйн хороонд гомдол гаргадаг вэ, одоо Мөнхсайхан хэлдэг юм. Өргөдлийн 80 хувь нь буцдаг гээд. Ерөөсөө л энэ байхгүй юу. Буруу шийдлээ, хуулийг буруу тайлбарлалчхлаа, илэрхий юмыг буруу шийдчихлээ л гэдэг үндэслэл шүү дээ. Ийм том уут нээгээд өгчихдөг. Одоо энэ бүх нөгөө шүүхийн шийдвэр таалагдаагүй шүүгчийн гаргаж байгаа өдөр тутам өчнөөн янз бүрийн хүсэлтийг хангана, хангахгүй. Өдөрт хэчнээн захирамж гаргаж байгаа. Тэгээд одоо үндсэндээ нөгөө үндэслэл. Одоо энэ 52.1.23 дээр хуулийн ил тодорхой маргаангүй заалтыг ноцтой зөрчсөн гэдэг бол ерөөсөө шүүхийн тэр захирамж, шүүх хурал хойшлуулъя гээд хүсэлт өгөхөөр нь хангахгүй гээд захирамж гаргачихаар л би өвчтэй байхад илт ингээд л зөрчлөө гээд л Сахилгын хороо руу гүйгээд явчих. Тэгэхээр энэ өөрөө ийм тодорхойгүй учраас энэ дээр ямар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүндрэл учрах вэ гэхээр ер нь одоо Мөнхсайхан ч мэдэж байгаа. Шүүхийн ёс зүйн хороонд өнөөдөр шүүгчийг өгчихсөн бол тэр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас давын өмнө шүүгчийг татгалздаг. Яагаад вэ гэвэл энэ хүний асуудлыг би Сахилгын хороонд ёс зүйн хороонд өгчихсөн учраас одоо үндэслэл шударгаар шийднэ гэдэг итгэл төрөхгүй байна гээд л татгалзах.../минут дуусав/

С.Бямбацогт: Цаг чинь дууссан байна. Нэмж цаг авах уу? Мөнхтуяа шүүгч, Дээд шүүхийн шүүгчид нэг минут.

Д.Мөнхтуяа: Байгаа учраас. Энэ нь өөрөө яах вэ гэхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэг талын хүсэлтээр удаашруулна, хурал хойшлуулна өөрөөр хэлэх юм бол цаг авах ийм боломжийг олгоно. Цаашлаад яах вэ гэхээр магадгүй одоо яг энэ үндэслэлээр энэ 52.1.23-аар юм уу, хорин долоогоор шүүгчдэд сахилгын арга хэмжээ авчихъя. Үгүй тэр гаргасан шийдвэр нь хүчинтэй юу, хүчингүй юу. Бөөн эх адаггүй хэрүүл маргаан үүснэ. Яагаад вэ гэхээр тэр шийдвэрийн нөгөө талд яг зөв шийдсэн гээд нэг хүн бодоод байж байгаа. Тэгэхээр одоо энэ өөрөө шүүхийн шийдвэрийн хүчинтэй, хүчингүй байдал, шүүхийн шийдвэрийн хүчин төгөлдөр байдал өөрөө тэнд маргаан үүсгэнэ. Энэ зүгээр хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагаанд учирч болзошгүй асуудлыг хэлж байгаа. Эцэст нь дээд шатны шүүхээр тогтоогдсон гээд байгаа юм. Өнөөдөр давж заалдах болон хяналтын шатны шүүхийн өдөр тутамд хийдэг хэрэв одоо магадлал, тогтоол уншиж үздэг бол дутуу бичсэн байна, буруу бичсэн байна, энийгээ гүйцээ бүгд л тэгж дүгнэж байгаа. Тэгэхээр дээд шатны шүүхээр энэ чинь тогтоогдсон байна гээд бариад л явах нь байна. Бид нар.../минут дуусав/

С.Бямбацогт: Цаг дууссан, одоо болно. Мөнхсайхан судлаач мэтгэлцэнэ одоо энэ. Сая Мөнхсайхан гэж хэлээд байгаа юм. Мөнхсайхан гээд байсан хэд хэдэн дурдагдчихлаа та бас тайлбараа хэлэх үү?

О.Мөнхсайхан: Энэ эрх эрхэм гишүүд маань эрхэм гишүүд маань хоёр талын үндэслэлийг сонсоод мэргэн шийдвэрээ гаргана гэж итгэж байгаа. Энэ дээр бол нэгдүгээрт бол 52.1.23-т хуулийн илт тодорхой маргаангүй заалтыг ноцтой, эсвэл удаа дараа зөрчсөн бол одоо сахилгын зөрчил болохоор хориглож өгч байгаа юм. Энэ бол юу вэ гэхээр Үндсэн хуульд бол шүүх зөвхөн хуульд захирагдана гэж байгаа юм. Тэр захирагдахын хамгийн маргаангүй, илэрхий утгыг энэ чинь бүр мэргэжлийн алдаа энэ бол ерөөсөө биш. Ямар ч мэргэжлийн мэдлэг чадвар шаардахгүй илэрхий ингээд хуулийг уландаа гишгээд давж шийдээд байгаа юм чинь бол сахилгын зөрчил гэж. Энийг бол би гаднын жишээ бол олон нийт ярьж болно. Гэхдээ Монголынхоо жишээ хэлчихье. Энэ миний хэлэх гэж байгаа жишээ бүгдийг нь захиргааны давах болон хяналтын шатны шүүх, сахилгын зөрчил гээд өнгөрсөн зургаан жил шийдчихсэн.

Нэгдүгээрт 2016 онд юу болсон бэ гэхээр нэг шүүгч сонгуулийн маргаан шийдээд шууд нөгөө цагдаа шийдвэр торгох шийдвэр аваад ирсэн чинь шууд торгоод хаячихсан. Нөгөө нэг буруутгах гэж байгаа хүнээс тайлбар аваагүй. Биечилж оролцох боломж олгоогүй, нотлох баримт гаргаж өгөх боломж олгоогүй, хууль зүйн тусалцаа авах эрх олгоогүй. Тэгээд тэр процессын хуулиар нь энэ эрхтэй гээд байж байгаа байхгүй юу. Тэгээд ёс зүйн хороо бол энэ бол мэргэжлийн алдаа биш, энэ сахилгын юм байна. Хууль дээр илэрхий ийм эрхтэй гээд бүр Үндсэн хууль дээр ч бич процесс үйл дээр биччихээд. Тэгээд сахилгын зөрчил гээд шийдсэн чинь дээд шүүх давах энэ бол дээд шүүх давах бол энэ сахилгын зөрчил юм байна гээд шийдчихсэн. Хоёр дахь нэг кэйс бол юу байна гэхээр хууль дээр бүр илэрхий яг ийм шийдвэр дээр гомдол гаргах эрхтэй гээд ингээд байж байхад эрхгүй гээд гомдлыг нь хаагаад бичээд байгаа байхгүй юу. Энийг мэргэжлийн алтаа гэх юм уу. Энэ бас ахиад дээд шүүх өөрөө зөвшөөрчихсөн юм байж байгаа юм.

Өөр юу байна вэ гэхээр одоо жишээлбэл ингээд гадаад явах эрхийг хязгаарлах хуулийн ямар ч зохицуулалт байхгүй байхад нэг хүнийг одоо бүтэн жил хаачихсан. Тийм тэгэхээр энэ бол юу вэ гэхээр би дуусгая тэгэх тэр уучлаарай гишүүнээ, цагтаа дуусгая. Тэгэхээр тийм, тэгэхээр энэ бол юу вэ гэхээр энэ бол манай практик дээр тогтсон энэ шинэ юм биш. Одоогийн шүүгчийн ёс зүйн дүрмийн гурвын гурвын нэг дээр ийм заалт байдаг юм. Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх бүх үйл ажиллагааг хуульд нийцүүлэн явуулна гээд. Энийг зөрчсөн юмыг манайд ингээд зургаан жил практикаар тогтчихсон. Тэгээд энэ бол өөрөө юу вэ гэхээр түрүүн яах вэ хэлсэн юм маань ингээд мушгигдаад байна л даа. Зөвхөн нэг заалттай зүйл анги дээр ганцхан торгох ялтай ийм хоёр дахь хэсэг гэж байхгүй заалт дээр хорих ялаар шийтгэгдсэн.

Ийм одоо барууны улсад гарсан байхгүй юу. Ийм кейс. Энэ бол мэргэжлийн алдаа биш шүү дээ.

Энийг бид нар маргаангүй байхгүй юу. Энэ дээр ямар ч маргахын утга байхгүй. Тэгээд яах вэ гаднын яг ийм асуудлыг сахилгын зөрчилд тооцож шийтгэдэг улсууд гэвэл Испани, Итали, Бельги, Герман, Америк, Молдова гээд пост коммунист бүх улс байж байгаа юм. Хоёрдугаарт үлдсэн нэг минутдаа хэлэхэд тэр үндэслэл огт бичээгүй гэдэг дээр хуульд захирагдаж байгааг юу илэрхийлдэг вэ гэхээр хуулийн ямар заалт дээр үндэслэж байгаа юм, юу гэж ойлгож байгаа юм гэдгийг бичих чинь наад захын шаардлага байхгүй юу. Энийг чинь оюун дүгнэлт. Хууль дээрээс гардаг шийдэл байгаа юм. Тэгэхээр энийг огт бичээгүй бол шүүхийн шийдвэрээр дээд шатны шүүхийн шийдвэр тогтоогдсоныг л хэлж байгаа байхгүй юу. Тэгээд энэ бол ахиад л одоо маш олон улсуудад энийг ингээд сахилгын зөрчилд одоо тооцдог. Тэгэхээр ер нь бол эцэст нь ингээд хэлэхэд энэ хуулиар бид нар шүүгчдийнхээ хараат бус байдал, хангамжийг бол олон улсын түвшинд хүргэх маш сайн заалтуудыг хийлээ. Одоо хариуцлагын юман дээр энэ бол хараат байдал руу халдаж байна гээд бүх юман дээр ингээд бүр шал дээрээ ортол доошоо татдаг. Ийм юмаа бол би одоо энэ дээр ийм тайлбар хэлж байгаад зүгээр хувь иргэний хувьд бол харамсаж байна. Хараат бус байдал, хариуцлага аль аль нь зоосны хоёр тал зэрэг л явах ёстой. Хараат бус байдал бүх юмаа дээшээ явуулчихдаг. Ийм байгаад олон улсын жишигт байдаг л юм, орж ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ одоо болохгүй гээд яаж байгаа дээр бол судлаачийн хувьд бол санал нийлж чадахгүй байгаа юм.

С.Бямбацогт: Үг авчихсан шүү дээ. Цогтбаатар гишүүнээ. Дэлгэрсайхан гишүүн, Цогтбаатар гишүүнээр асуулт асуух, гишүүдийг тасалъя, Адьшаа гишүүн асуултаа асууя. Энэ бас нэлээн чухал асуудал учраас нэлээн сайн ярилцаад авъя. Сая хоёр талаасаа сайхан мэтгэлцлээ, тэгээд гишүүд бас өөр өөрсдийн итгэл үнэмшилдээ бас өөр өөрсдөө ойлголттой болж байгаа байх. Тэгээд санал хураалт явагдана, анхааралтай байна уу?

Ш.Адьяа: Надад зүгээр би асуулт асуухгүй. Тэгэхдээ энэ үг хэлье. Би анх удаа энэ Нямбаатар сан сайдтай санал нэг байгаа юм. Тийм тэр тавин хоёрын нэгийн хорин гурав, тавин хоёр нэгийн хорин долоо гэдгээр анх удаа би санал нийлж, энийг дэмжиж үг хэлэх гэж байна. Энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр энэ сахилгын хороо гэдэг энэ байгууллагыг байгуулснаар өнөөдөр шүүхийн дотор нэг шүүх байгуулчхаад байгаа шүү дээ. Энэ шүүхийг шинээр байгуулагдсан шүүхийн боловсон хүчний бүх томилгоог Улсын Их Хурал эрх мэдэлдээ авсан. Улсын Их Хурал бүгдийг нь томилно бүх шийдвэрийг нь. Тэгэхлээр энэ одоо зөрөлдөөн гарч байгаа юм уу гэж ойлгож байна. Өнөөдөр Засгийн газар, ажлын хэсэг хоёр өөр өөр саналтай, өөр өөрийн байр сууриас хандаж байна. Тэгэхдээ энийг ер нь улс төржихгүйгээр бодит байдал дээр энийг цэгнэн дүгнэж, Их Хурлын гишүүд шийдвэр гаргах ёстой.

Өнөөдөр шүүхийн сахилгын хороо есөн хүнтэй байгуулагдахаар болсон. Энэ сахилгын хороо чинь тэр бүх Монгол Улсын хэмжээний хэргийн шийдвэрийг уншиж чадах уу? Өнөөдөр шүүх дээр ирж байгаа бүх хүн зуун хувийн гомдол гаргадаг шүү дээ. Тэгээд тэр шүүхийн шийдвэр бүхэнд гомдол гаргана. Тэрнийг дээд шатны шүүх засна. Тэр зассан юм бүхнийг нь аваад тэр хүмүүсийг өнөөдөр сахилгын шийтгэл ногдуулаад огцруулаад байх юм бол энэ таван зуун тавин шүүгч нь нэг жилийн дотор

байхгүй болно. Амьдрал дээр үнэн шүү. Өнөөдөр буруу эмчилсэн эмчид хариуцлагын тухай ярьдаггүй шүү дээ. Өнөөдөр шүүхийн асуудал бол хамгийн чухал асуудал. Өнөөдөр шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн хараат бус байдлыг хамгаалах асуудал бол өнөөдрийн хамгийн чухал асуудлын нэг мөн үү мөн. Гэтэл өнөөдөр шүүгч гэдэг тэр таван зуугаад хүн рүү өнөөдөр нийгмийнхээ бүх муу муухайтай хутгаж өнөөдөр бид дайрч байна.

Энэ чинь бас хүмүүс шүү дээ. Өнөөдөр. Энэ хүмүүсийн чинь асуудлыг бас бид ярих ёстой шүү дээ. Өнөөдөр Энхбаяр гишүүн нэг юм ярихаар л одоо лоббидож байна, шүүгчдийн дээд шүүхийн нөлөөнд автаж байна гэдэг ийм юм яриад байна. Энэ олон талаас нь ярьж хэлж энэ хуулийг гаргах ёстой шүү дээ. Өнөөдөр. Би энэ ажлын хэсэгт байсан, түрүүн ч хэлсэн. Энэ дээд шүүхийн ажлын хэсгийг оролцуулахгүйгээр хөөгөөд явуулсан шүү дээ. Тэгээд дээр нь Монголын шүүгчдийн холбооноос ирсэн санал, дүгнэлтийг олон нийтийн сүлжээн дээр тавиад шүүхэд нөлөөлөх гэж байна, хууль гаргахад нөлөөлөх гэж байна гэдэг байдлаар хүртэл хандаж байсан. Ийм учраас энэ асуудлыг хасах тийм зарчмын одоо зөрөөтэй саналыг оруулсан юм. Нямбаатар сайдтай санал нэг байна энэ дээр бол. Бид нар өнөөдөр нуухыг нь авах гэж байгаад нүдийг нь сохолж энийг.../минут дуусав/

С.Бямбацогт: 1 минут Адьшаа гишүүн. Боллоо гэж байна. Тэгэхээр юу гишүүдээ бас нэг нухацтай хэлэлцье. Тэгээд нуухыг нь авах гээд нөгөө нүдийг нь сохолж болохгүй. Сая Адьшаа хэлж байна. Тийм болохоор аль болох одоо ажил хэрэгчээр, яг асуудлаа яримаар байна. Бодлогын мэтгэлцээн өрнүүлмээр байна. Бие биен рүүгээ дайрсан довтолсон доромжилсон, дээрээс нь шүүгчдэд зарим нь хайртай, зарим нь хайргүй юм шиг, зарим нь шударга шүүгчтэй, зарим нь шударга шүүгчгүй юм шиг иймэрхүү байдлаар нэг талцаж хуваагдсан тиймэрхүү одоо субъектээ юм битгий яриач. Энийг та бүхнээс бас хүсье. Тэгээд энийг аль болох одоо асуудалдаа бодитой хандах ёстой. Шүүгчдийн холбооноос бичиг ирсэн. Албан ёсоор хариуг нь өгсөн. Одоо Дэлгэрсайхан гишүүн асуулт асууя.

Б.Дэлгэрсайхан: Би бас энэ сая энэ Мөнхтуяа шүүгчийн ярьж байгаатай санал нэг байна л даа. Ер нь бол энэ шүүгч нарын үгийг сонсьё гээд байгаа нь ерөөсөө л энэ байхгүй юу. Эрдэмтэн хүн бол эрдэмтэн л байдаг л даа. Судалгаа хийгээд ганц хоёр кэйс гаргаад тэгээд тэрийгээ амьдрал гээд бодчихдог. Гэтэл яг амьдрал дээр эмч хийх, шүүгч хийх хоёр бол яг адилхан зүйл байхгүй юу. Оношийг бол хэн ч одоо бас ингээд шууд тогтоодоггүй. Ерөнхийдөө онош бол таамгаар тавьж ордогтой адилхан. Шүүхийн одоо маргаан бол ингээд олон талтай, тийм одоо энийг илт одоо буруу байна, ноцтой байна гээд одоо үзэх ямар ч арга байхгүй. Ялангуяа одоо шүүгчийн гаргаж байгаа дүгнэлт бол мэдээж одоо ямар улсын шалгалт өгч байгаа шиг ингээд цагаан цаас өгдөг нь ойлгомжтой. Сая шүүгч маш тодорхой хэллээ шүү дээ. Ямар нэгэн заалт бичиж байж, тэгээд энэ заалт, заалтыг баримталж, одоо би ийм одоо шийдвэр гаргаж байна л гэж гаргаж таараа.

Тийм учраас ялангуяа тавин хоёрын нэгийн хорин гурав дээр бол энийг эргэж харахгүй бол ямар энэ маргаангүй заалт тодорхой маргаангүй заалт гэж яг юу хэлэх гээд байгаа юм. Жишээлбэл шүүхийн шийдвэр зайлшгүй гэж одоо яг юуг хэлээд байгаа юм гэдэг ийм ерөнхий үгээр заавал хэлмэгдэл болно. Энэ чинь одоо тэгээд ажил хийх хүн олдохгүй шүү дээ. Тэгээд одоо ингээд энэ Сахилгын хороо гэдгээр

зүгээр л одоо захиалга өгөөд, энэ шүүгчийг одоо явуулчих гээд л ингээд л үүрэг өгөх юм байна шүү дээ. Тэгэх юм бол энэ ер нь энэ гурван шатны шүүгч байгаа шүүх байгаагийн утга учир бол бие биеийнхээ алдаа оноог л засах гэж шүүх байгаа гэж би ойлгож байгаа шүү дээ. Анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүх үзээд энэ хуулийг буруу, одоо юу ял шийтгэл нь буруу байна, зөв байна гэж заагаад дээд шат нь бол энэ хуулийг буруу хэрэглэж гэдэг ч юм уу ингэж зөрчлийг засдаг л байх гэж бодож байгаа юм.

Тийм учраас бол энэ дээр ингээд бие биеэ одоо юу буруутгахын оронд мэргэжлийн зөвлөлөөр эхэлж ороод энэ нь яг мэргэжлийн алдаа байна. Энэ нь бол яг ноцтой хууль зөрчсөн байна гэдгийг гаргасны дараа сахилгын хороогоор ордог ийм л заалт оруулъя л даа. Эхэлж мэргэжлийн хорооны дүгнэлт гарсны дараа одоо энэ тавин хоёрын нэгийн хорин гурав, тавин хоёрын нэгийн хорин долоог мэргэжлийн хорооных нь дүгнэлтээр сахилгын одоо шийтгэл оногдуулах эсэх тухай одоо оруулна гэдэг ийм үг өгүүлбэр нэг заалт болж оруулбал энэний цаана гарах юм байна гэж ойлгож байна. Тэгэхгүй ингээд хоёр талцаад зарим нь одоо ингээд шүүгчийг өмөөрөөд байгаа ч юм шиг маш буруу харагдаад. Зарим нь одоо энэ шүүгчийг одоо ерөөсөө муухай заваан улсууд гэж ингэж харагдаад одоо бид нар их муухай харагдана. Тийм учраас бол энэ амьдрал дээр одоо олон зуун мянган шийдвэр гаргаж байгаа энэ шүүгч нарыг би бүгдээрээ буруу гэж бодохгүй байна. Өдөрт хэдэн зуун мянган шүүхийн шийдвэр, захирамж гарч байгаа. Үнэн шүү дээ.

Тэр саяын Мөнхсайханы хэлдгээр бол илтэд одоо ингээд хилийн хориг тавиад ингээд зөрчил гаргасан бол энийг бол сахилгын зөрчил гэж хэлэх нь ойлгомжтой. Тэгэхдээ энийгээ бас яг үг үсгээр нь мэргэжлийн хүмүүсээр нь эхэлж дүгнэлт гаргуулаад тэр дүгнэлтээ үндэслээд энэ бол сахилгын зөрчил байна, эсвэл энэ мэргэжлийн алдаа байна гэдэг ийм л дүгнэлт гаргуулах хэрэгтэй. Эмч нар дээр ч гэсэн адилхан шүү дээ. Эмч нарын зөвлөгөөн болоод энэ эмч одоо энэн дээр одоо буруу.../минут дуусав/

С.Бямбацогт: Байз ойлголцол төрөх нь үү, манайхан. Тал талаасаа нэг жоохон ойлголцож болох бололцоо бүрдэж байна уу? Ажлын хэсгийн ахлагч, Нямбаатар гишүүнээ. Дэгийн хуулийн гучин есдүгээр зүйл дээр нэг ийм заалт байгаа. Холбогдох Байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг нээлттэй болон хаалттай явуулж, холбогдох санал дүгнэлт гаргана. Шаардлагатай гэж үзвэл Байнгын хороо төслийн тодорхой зүйл, хэсэг заалтын талаар мэтгэлцээн явуулна. Хуралдаан даргаж мэтгэлцээний хугацааг жаран минутаас илүүгүй байхаар тогтоох бөгөөд гишүүд саналаа чөлөөтэй ирэх боломж олгоно. Мэтгэлцээний хугацаа дуусмагц хуралдаан ердийн нэгээр үргэлжилнэ гэж. Энэ нэлээн одоо ярих ёстой асуудал байгаад ойлголцолд хүрэхгүй байгаад байх шиг байна. Гишүүд дахиад нэг сайн ярилцах уу? Нээлттэй байгаа шүү. Чуулганы хуралдаан чинь сая Ийгл телевизээр нээлттэй явж байна гэсэн үү. Орон даяараа одоо ард түмэн үзэж байгаа юм байна гээд аль болох жоохон бүдүүлэг үг хэрэглэхгүй, бие биедээ доромжлохгүй, харилцан уян хатан бас тийм үү, аль болох ойлголцох талдаа хэдүүлээ бас жоохон ярилцъя.

Тэгээд одоо үг хэлэх гишүүд нээлттэй. Сүхбаатар гишүүн, Цогтбаатар гишүүн, Энх-Амгалан гишүүн гучин минут нэг ярилцаарай хэдүүлээ, тэгэх үү? Амарсайхан гишүүн, Энхбаяр гишүүн, ажлын хэсгээс бас нээлттэй шүү. Манай шүүх дээд

шүүхийнхэн тиймээ. Хуралдаанд оролцож байгаа ажлын дэд ажлын хэсэг. Цогтбаатар гишүүн, Нямбаатар гишүүнийг нэмчхээрэй. Аль болох ойлголцъё бүгдээрээ энэ дээр ярилцаад, харилцан буулт хийж ойлголцох талдаа анхааръя. Алтанхуяг гишүүнийг бас нэмчхээрэй.

Д.Цогтбаатар: Ойлголцож болох байх. Би зүгээр энэ дээр маргаан үүсэж байгаа дээр нь их гайхаж байна л даа. Тавин хоёрын нэгийн хорин долоо дээр бол байна шүү дээ хууль үзэж байгаа ямар ч оюутан шүүгчийн шийдвэрийг аваачиж суулгаж уншуулж байгаад наад дотроосоо хоёр юм оллоо гэж эхэлдэг юм. Хуулийн хичээл. Тэр нь нэг нь *obiter dicta* нөгөөх нь *ratio decidendi* гээд. *Ratio decidendi* гэдэг бол шийдвэр гаргах үндэслэлийг нь шүүгчийн шийдвэрээс оюутныг олуулж сургадаг юм. Тийм юмгүй шүүхийн шийдвэр байж болохгүй, байхгүй. Заавал шүүхийн шийдвэр дотор тэр *ratio decidendi* буюу би энэ шийдвэрийг гаргахад юуг үндэслэсэн бэ гэдгийг байлгадаг. Би манай Монголын шүүх тэгтлээ доройтсон гэж би бодохгүй байна. Ийм хараад ийм юмыг оруулахгүй гэж айгаад байна гэдгийг би ойлгохгүй байна. Шийдвэрт зайлшгүй шаардлагатай та ямар нэгэн шийдвэр гаргаж байгаа бол тэнд заавал үндэслэл байх ёстой. Тэр нь зөв байж болно, буруу байж болно. Та тэрийг өөрийн үзэмжээр, дотоод итгэл үнэмшлээрээ гаргаж байгаа болохлоор таны гаргаж байгаа шийдвэр заавал үндэслэлтэй байх ёстой. Тэр үндэслэлээ л за гэж байна. Тэгээд бүр хоёр дахь үг нь бүр ноцтой үг байгаа юм. Огт бичээгүй гэж байгаа шүү дээ.

Огт бичээгүй байж ерөөсөө болохгүй. Заавал бичсэн байх ёстой. Тэр нь зөв, буруу байх бол маргааны асуудал. Тэгэхлээр энэ дээр ийм юмыг ингээд одоо бид нар харин хэлэлцэж байгаад энийг аваад хаячих юм бол наадах чинь дараа нь хууль тайлбарлахад к.п буюу энэ юу хуулийг хэлэлцэж байх үед ямар, ямар рациональ хэлэлцэгдсэн бэ гэдэг орж ирнэ. Тэгээд хэлэлцэж байгаад энийг авсан, энэ хэрэггүй юм байна гэдэг тайлбар орж ирнэ шүү. Одоо бол энэ буцахаасаа буцаж болохгүй шат руугаа ороод явчхаж байгаа юм. Тэгэхлээр энэ дээр ийм ойлгомжтой юмыг зайлшгүй шаардлагатай шийд юу? Үндэслэлийг огт бичээгүй гэдэг юмыг оруулахгүй гэх юм бол огт бичихгүй байж болох нь байна шүү дээ. Үгүй яаж тэгвэл шүүхийн шийдвэрийн юм гарах юм бэ? Зүгээр л энэ чинь тэр *ratio decidendi*-ийн тухай л яриад байна шүү дээ, би тэрийг л гайхаад байна. Тэгэхлээр энэ дээр бол энэ зүгээр асуудал нь зүгээр хоорондоо ойлголцохгүй байгаа байх л гэж бодож байна. Түүнээс бол юу гэж дээ, ойлголцох асуудал гэж бодож байна

С.Бямбацогт: Энэ нэг ийм бас байгаад байгаа шүү дээ. Хорин хоёрдугаар зүйл шүүх, шүүхийн шийдвэр гээд хорин хоёрын гурав шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлал нь шүүхийн шийдвэрийн бүтэц, төрөл, агуулга, хэл найруулга, хууль зүйн техник, шүүхийн шийдвэр ишлэхэд тавих шаардлага, талуудын шаардлага, татгалзал тайлбарт маргаж байгаа үйл баримт болон хууль зүйн үндэслэл бүрт бүрэн дүгнэлт өгөх арга зүйг агуулсан байна гээд бүр заавал ийм байх ёстойг заачихсан байгаа шүү дээ бас. Энийг манай гишүүдээс харгалзаж үзээрэй. Гишүүдээ яриульъя. Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Саяын Бямбацогт даргын хэлдгийг би бас давхар хэлэх гэж байсан юм. Тэгээд энэ дээр нэг их айгаад эмзэглээд байх хэрэггүй л дээ. Саяын хэлдэг хорин хоёрын хоёр дээр чинь шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлал, журмыг улсын дээд шүүх өөрөө тогтоох байхгүй юу. Тэр зайлшгүй шаардлагатай

үндэслэл чинь юу байж болох юм бэ гэдгийг улсын дээд шүүх өөрөө тогтоочих л байхгүй юу даа. Тэрнээс одоо хэн нэгэн хүн тэр Мөнхтуяа шүүгч бол тэгж байна л даа. Зайлшгүй шаардлагатай гэдэг чинь бас одоо өөрөө нэг бүрхэг байна шүү дээ гэж. Тэр бүрхэг юмыг тодорхой болгох ирэх боломж нь бол энэ хорин хоёр дээр бол байж л байгаа байхгүй юу. Байж л байгаа байхгүй юу. Хоёрдугаарт саяын хэлдэг Цогтбаатар гишүүний асуудал байж байгаа юм. Ерөөсөө Монголын энэ одоо явж ирсэн систем, өнгөрсөн системийн хоцрогдол одоо хүртэл одоо бүрэн арилахгүй байгаа юм бол даргын гэдэг юм уу, шүүхийн ч байна уу, цэцийн ч байна уу одоо олон жил энэ үндэслэл дутуу бичдэг, үндэслэлгүй шийдвэр гаргадаг явдлыг л ярьж ирсэн байхгүй юу.

Захиргааны ерөнхий хууль гэхэд одоо захиргааны шийдвэрийг үндэслэе гэж шаарддаг болсон. Сүүлийн жилүүдэд харин энэ чиглэлд бол ахиц гарч байгаа. Ер нь зайлшгүй шаардлагатай үндэслэлээ гаргаж чадаагүй бүх шийдвэр бол хүчингүй байхгүй юу даа. Энэ Монголын чинь хамгийн гол эмгэнэл нь юу юм гэхээр юунд үндэслээд байгаагаа тодорхой бичдэггүй. Тодорхой бичдэггүй учраас тэрний үр дагавар нь өөрөө сайн хянагдаж болдоггүй байхгүй юу. Хууль хүлээн зөвшөөрөгддөггүй. Одоо иргэдэд энэ шүүхийн шийдвэр чинь зайлшгүй шаардлагатай үндэслэлүүдээ зөв бичээд байх юм бол хүмүүс гомдох нь багасна шүү дээ. Тухайн үедээ гомдоно, илэрхий одоо миний эрх ашгийг зөрчлөө. Гэхдээ тэнд байгаа үндэслэлүүдийг нь дараа нь үзэхэд үгүй ээ бас аргагүй ийм үндэслэлтэй шийдвэр гаргаж өгч гэж. Тэгэхээр энэ бол дэндүү одоо ойлгомжтой. Сая Цогтбаатар гишүүний хэлдгээр энийг одоо хасаад хаячих юм бол энэ чинь одоо шүүгчид хориглож байгаа зүйл шүү дээ. Түрүүний тэр бүр тавин хоёрын нэгийн хорин гурав бол бүр инээдтэй, ноцтой удаа дараа зөрчсөн үйлдэл гаргаж байна гэж байгаа юм. Энийг чинь хэн нэгэн хөндлөнгөөс бид нар тогтоох гээд байгаа юм биш шүү дээ. Энэ чинь дандаа фактууд нь цаанаа явах байхгүй юу. Тэр хүмүүсийг чинь шийдвэр гаргаж байгаа, энэ удаа дараа ноцтой гэж байна.

Тэгээд энэ болгоны чинь цаана нь улсын дээд шүүхийн гүйцэтгэх үүрэг өөрөө энэ хуульд, хуулийн төсөлд суучихсан байгаа улсын дээд шүүх. Улсын дээд шүү сургалт судалгаа хийж байна, тэр шийдвэрийн хяналтын журмаар хянаж байна. Нөлөөлөх боломжууд нь байж байна, шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлал, журмыг баталж байна. Тэгэхээр энэ бол ийм боломжууд байгаа учраас энэ хоёр заалтыг сугалж аваад, эсвэл сулруулаад бичнэ гэх юм бол энэ буруу. Харин зүгээр одоо үнэхээр сайхан томьёоллоо ингээд өөрсдөө гаргах юм бол байж болох байх. Түүнээс биш энийг одоо сулруулаад алга болгоод ингээд явах юм бол харин энэ дээр ноцтой асуудал нь харин энд үүсэх байх. Тэгээд яаж байна вэ гэвэл тайлбар нь хэлж байна шүү дээ. Үгүй ээ сахилгын хороо маань ингээд дур зоргоороо биднийгээ янз бүр болгочих гээд байгаа юм. Тодорхой биш томьёолол байна гээд. Энэ л жоохон болгоомжлолтой хэцүү байна гээд байгаа шүү дээ. Түүнээс биш одоо огт буруу гэж бол үзэхгүй байна гэж би ойлгож байгаа.

Тэгээд энэний чинь энэ хоёрын чинь яг заалтыг нь ингээд уях юм бол энэ чинь жинхэнэ одоо мэргэжлийн хариуцлагатай холбоотой асуудал байгаа байхгүй юу. Сахилгын зөрчил болохоор. Бусад нь бол нэлээн ёс зүйн хязгаарлалтууд эд нар байж байгаа. Энэ бол илүү мэргэжлийн талтай юм байгаа байхгүй юу. Гэтэл хамгийн гол хоёр мэргэжлийн талтай байж болох заалтыг нь одоо авч хаях тодорхойгүй байна гэж

ингэж үзэх бол буруу. Тэр тодорхой хуулийн илт тодорхой маргаангүй гэж байна. За маргаангүй гэдгийг нь хасмаар байгаа бол хуулийн илт тодорхой заалт гэж байх л даа. Ил тодорхой заалт гэдгийг бид нар ойлгож л байгаа шүү дээ. Хуулийн илт тодорхой заалтууд маш тод.../минут дуусав/

С.Бямбацогт: Гишүүдээ сонсчихоод, дараа нь Мөнхтуяа шүүгч, Мөнхсайхан багш хоёрыг сонсьё. Та хоёр бас бэлдэж л байгаарай. Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Бид нар яагаад энэ шүүхийн хууль дээр ингэж олон цаг зараад л, хүн болгон яриад л, тайлбар тавиад л, асуугаад л, тодруулаад л байгаа юм бэ гэхээр энэ шүүх өөрөө хүний эрхийг хязгаарладаг байхгүй юу. Хүний эрх, эрх чөлөөг хязгаарладаг. Хүнийг одоо шоронд хийх эсэхийг шийддэг, хувь заяаг нь шийддэг ийм байгууллага учраас бид нар энд оролцоод байгаа юм. Асуугаад тодруулаад байгаа юм. Тэгээд сая бол бас ярьж байна л даа. Тэр хууль бол нэг мөр ойлгогдох ёстой шүү дээ. Хоёрдмол утгагүйгээр шууд ойлгогдох ёстой. Тийм учраас би хоёрдмол утгагүйгээр ойлгогдох үүднээс түрүүн шаардлага тавихгүй байх гэдэг дээр ядаж тэр дэг сахиулах хүрээнд бусдын зүй бус авирласан авирыг таслан зогсоох үүрэг нь тэр танхимын, одоо шүүх хуралдааныг удирдаж байгаа шүүгчид байх ёстой шүү дээ. Тэгвэл үүргийг биелүүлээгүй байх гээд найруулаад байхаач гэхээр болж байгаа байхгүй юу.

Дахиад энэ дээр шүүхэд гэрчээр дуудагдсан гэхээр бүх хүнийг хамруулж байгаа. Энэ бол шүүхэд хэн ч гэрчээр дуудагдаж болно. Тэгэхэд энд өөрөө тавьсан тавин хоёрын нэгийн гучин зургаа чинь шүүгч өөрөө гэрчээр дуудагдах асуудлыг томьёолоод байгаа байхгүй юу. Тэгээд өөрөөр тайлбарлаад байгаа юм. Тэгэхээр шүүгч гэрчээр дуудагдсан гээд л найруулагчид болж байна гэхээр за яах вэ ингэж авч болж байна гэж байгаа юм. Яг тэрэн шигээ одоо энэ яригдаад байгаа асуудал чинь нэг л юм байгаа шүү дээ. Хууль шүүхийн өмнө хүн болгон ижил тэгш эрхтэй байна. Монгол улсын иргэн бүр одоо шударга шүүхээр асуудлаа шийдвэрлүүлэх ёстой. Яагаад адилхан таван мал хулгайлчихаад нэгэн шоронд ороод нэг нь цагаадчихдаг юм. Би яагаад нэг вараны шилний хэрэг явсаар байгаад одоо ингээд дээд шүүх дээр яваад очдог юм бэ. Энийг яагаад хүлээгээд авчихдаг юм бэ? Яагаад надад миний асуудлыг дээд шүүхэд өгөхөөр тайлбар өгөхгүй хаагаад хаячихдаг юм бэ. Юунаас болсон гэдэг тайлбар өгөхгүй хаагаад хаячихаж байгаа юм бэ. Яагаад миний гадагшаа явах тийш одоо ийш тийшээ зорчих эрхийг хязгаарлачихаж байгаа юм бэ? Шалтгаан нь юу юм бэ? Яагаад ийм харилцан адилгүй шийдвэр гаргаж байгаа юм бэ? Яг ижил кэйс дээр.

Ийм юмнаас чинь л иргэд шүүхэд итгэх итгэхгүй бол итгэлгүй болоод байгаа юм л даа. Тийм учраас тэд нар зөрүүлээд, үгүй ээ үгүй, энэ яг ийм учраас чи ингэсэн гэдгийг надад нэг тайлбар өгөөдхөөч л гэж хэлж байгаа юм. Тэгэхээр зөрүүлээд тийм байж болохгүй ээ. Одоо яагаад ингэж шийдсэнээ бол тайлбарлах албагүй гэдэг юм ярьж байгаа бол болохгүй шүү дээ. Тийм учраас энд шүүхийн шийдвэрийг бичих аргачлал нь улсын дээд шүүх өөрөө байна. Журмаа гаргах нь улсын дээд шүүх өөрөө байна. Маргааныг хянан хэлэлцээд шийдвэр гаргах нь, хэлбэрүүд нь улсын дээд шүүхэд өөрт нь байна. Анхан шатны шүүх болоод одоо цагаатгах тогтоол, шүүхийн шийдвэр шүүгчийн шийдвэр энэ тэрийг гаргах бүх энэ ажил улсын дээд шүүхэд өөрт нь байж байгаа. Тийм учраас энийг бид нар яах гэж байна гэхээр зэрэг хамаагүй. Тэр

хуулийн илт тодорхой маргаангүй гэдэг заалтуудыг бид нар тэр найруулгынхаа ямар юмаар авбал энэ зөв болох юм тэрүүгээр нь шийдэж болж байна.

Шүүхийн шаардлагатай зайлшгүй шаардлагатай үндэслэлийг огт бичээгүй гэдэг ийм нөхцөлийг бид нар юу гэж ойлгох юм энэ дээр та нар маань хэлээд найруулаад ирвэл болж байгаа байхгүй юу. Нэг ёсондоо бид нар шүүгч алдаа гаргахгүй байхыг л хүсэж байна шүү дээ. Шийдсэн тэр шийдвэр чинь хүнд маш ойлгомжтой, нэг мөр ойлгогдохыг л хүсээд байгаа байхгүй юу. Тэгэхгүй зүгээр өмнөөс ингээд нэг шийдвэр тавиад май энэ асуудлыг шийдлээ гэдэг, яагаад шийдсэн юм бэ гэхээр чамд тайлбарлах албагүй вэ гэвэл энэ бол байж болохгүй асуудал шүү дээ. Ийм л нөхцөл байдал байгаа учраас та бүхнийг энэ дээрээ нэг жоохон тайлбаруудаа сайхан дээд шүүхийнхээ тайлбарыг сайхан зөв гаргаад энэ дээрээ найруулаад ингээд оруулбал энд ямар нэгэн байдлаар одоо ингээд юм алдагдах юм байхгүй шүү дээ.

С.Бямбацогт: Баярлалаа. Амарсайхан гишүүн саналаа хэлье. Энэ дээр би бас түрүүн хэлж байсан. Тэр мэргэжлийн хороо, сахилгын хороо гэдэг хоёроо ялгаж салгахгүй бол болохгүй гэж яриад байдаг чинь л энэ. Мэргэжлийн алдаа, сахилгын зөрчил гэдэг хоёр юм чинь тэс хоёр өөр юм шүү дээ. Тэгээд алдаа гаргадаггүй хүн ажил хийдэг тийм мэргэжилтэн гэж байдаггүй учраас алдаа болгон дээр нь дөрөөлж, тэрийг ийм хатуу хориглосон заалтаар оруулж байгаа нь өөрөө болохгүй юм байгаад байгаа юм. Тийм учраас тэр сахилгын хороо гэдгээсээ гадна мэргэжлийн хороог бий болгоё гэхээр Үндсэн хуульд заагаагүй гээд байдаг. Үндсэн хуулиар бүх юмыг зохицуулах боломжгүй шүү дээ. Үндсэн хуульд заагаагүй юмыг бид энэ дээр нэмж оруулаад хийх боломжтой. Ингэхгүй бол яг энэ маргаан чинь өнөөдрөөс илүү ирээдүйд хамгийн хүндрэлтэй, хамгийн ноцтой ийм сөрөг үр дагаврыг энэ салбарт авч ирнэ. Шүүгч болгоныг энэ зүйл заалтаар ялладаг буруутгадаг ийм туйлшрал бий болно.

Тийм учраас тэр мэргэжлийн хороог бий болгоё гээд байгаа нь тэр юм. Ганцхан энэ сахилгын хороо байна гэдэг чинь үндсэндээ явж явж нөгөө л яриад байдаг шүүхийн мэргэшсэн, дагнасан байх гэдэг юм аа орхигдуулчихаад бид зөвхөн хүн яриад байгаа. Хариуцлага шийтгэл яриад байгаа. Хүнээ яаж хөгжүүлэх вэ, мэргэшил, ёс зүйн зөрчил хоёрыг нь хооронд нь яаж ялгах вэ гэдэг асуудлаа хаячихаад байгаа чинь л өөрөө энэ маргааныг дагуулаад байгаа шүү дээ. Тэгээд ганцхан энэ сахилгын хороотой байна гэдэг энэ асуудал чинь өөрөө явж, явж ер нь шүүхээс илүү давсан, шүүхээс илүү ачаалалтай, шүүгч болгоныг сахилгын хороо руу чирсэн, сахилгын хороо нэртэй албан бус шүүх гарч ирнэ шүү энэ. Тэгээд энэ шүүх гэдэг салбар чинь өөрөө аяндаа бүр дампуурал руугаа орно.

Тийм учраас энэ бүхэн дээр бид нар нэлээн ийм нухацтай хандаж, энэ шүүхийн мэргэжлийн хүмүүс, бусад гишүүдийн ярьж байгаа энэ санал онолыг нэг маш тодорхой тусгахгүй бол болохгүй ээ нэгдүгээрт. Хоёрдугаарт бол энэ Их Хурал гэдэг чинь өөрөө шүүмж мэтгэлцээний талбар. Энэ нь бие бие рүүгээ дайрсан, хэн том дуутай нь ялна гэсэн үг биш шүү. Асуудал шийднэ гэдэг үг. Зарим нэг хүндэтгэлтэй, хүлээцтэй, чимээгүй сууж байгаа гишүүдээ бас энэ одоо олон нийтээ хүндлээрэй зарим гишүүд. Заавал хэн нэгнийх нь зөв байж байж гарах гэхээсээ илүүтэй зөв буруугаа яаж тодорхойлох вэ гэдгээ хүлээцтэй ярьж, сонсож байж асуудалд хандах ёстой шүү. Мэдээж улс төрийн шийдвэр гарсан юмнууд байж болно. Дээрээс нь

мэргэжлийн одоо харгалзах зүйлүүд бий. Гэхдээ энэ бүхнийг нэлээн одоо нухацтай хэлэлцэж байж хамгийн зөв шийдлийг гаргахын тулд л Их Хурал гэж байгаа. Тийм учраас манай энэ гишүүд энэ дээрээ маш сайн ойлголцохгүй бол энэ бол тийм хуумгай гоомой шийддэг ажил асуудал биш шүү. Энэ шударга ёс, хууль тогтоомжийн хамгийн нарийн шүүлтүүр чинь өөрөө шүүх. Тийм учраас энэ салаа утгатай ямар нэгэн зүйл заалт бол байж болохгүй.

Тийм учраас тэр Үндсэн хуулиа битгий буруу тайлбарлаж, битгий буруу ашиглаад бай гэж энэ зарим дэд ажлын хэсгийн гишүүд би хэлээд байгаа нь тэр юм. Өөрсдийн үзэл бодол, итгэл үнэмшил гэхээсээ илүүтэй үзэмжээрээ Үндсэн хууль тайлбарладаг. Үндсэн хуульд ингэж заасан учраас энэнээс өөр гарц байхгүй гэдэг. Тэгсэн мөртөө ингэж заагаагүй учраас бид нар ингэж хийж болж ч болно, болохгүй ч байж болно гэдэг ийм агуулгаар битгий юм яриач л гээд байгаа юм. Тэгээд энийг бол бид нар анхаарах ёстой заалт шүү энэ. Тийм учраас тэр хамгийн сүүлд нь тэр мэргэжлийн хороогоо байгуулах зүйл заалтыг оруулах саналыг би бас энэ тавин хоёрын нэгийн гурав дээр биш ээ, тавин долоогийн энэ зүйл заалт дээр бас саналаа бичгээр өгчихсөн байж байгаа. Мэргэжлийн хороо байх ёстой. Тавин найм, тавин наймыг хасаад хаячихсан байгаа байхгүй юу.

С.Бямбацогт: Энхбаяр гишүүн саналаа хэлье.

Б.Энхбаяр: Баярлалаа. Тэгэхээр яагаад энэ шүүхийн шийдвэрт зайлшгүй шаардлагатай үндэслэлийг огт бичээгүй, тэгээд тэр нь дээд шатны шүүхээр тогтоогдсон тохиолдолд энэ шүүгч чинь бас хариуцлагатай байхгүй юм уу л гэдэг асуудал яриад байгаа юм. Тэгээд энийг аваад хаячихаар энэ шүүгч чинь бүр хяналтаас хариуцлагаас гараад явчхаж байгаа юм. Тэгээд шүүгч хүн болохоор алдаж болно, хүн л юм чинь уучилж болно гэдэг үндэслэл бол өөрөө шударга ёсны үндэслэл бол биш байх л гэж бодож байна. Шүүгч хүн алдах эрхгүй. Алдах ч ёсгүй. Зүгээр алдааг яриагүй шүү дээ. Бид нар зүгээр нэг оюутны дипломын ажил яриагүй байхгүй юу. Монгол Улсын Үндсэн хуульт байгуулал, Үндсэн хуулийг хэрэглэж байгаа. Тэгээд тэр нь эцсийн шийдвэр болох, хүний хувь заяаг шийдэх, хэдэн тэрбум их наяд төгрөгийн хөрөнгө маргаан шийдэх, ийм шийдвэр дээр сайнаар ч бай, муугаар ч бай тэр үндэслэлээ бичихгүй юм уу тэгээд. Яагаад гэдэг асуултдаа тэр шүүхийн шийдвэр чинь хариулдаг байх ёстой шүү дээ. Бид нар шүүхийн хууль дээрээ одоо маш олон шинэчлэлүүд хийж байна л даа.

Тухайлбал Монгол улсын дээд шүүхийн шийд, шүүх шийдвэрээ олон нийтэд нийтэлдэг байх, тайлбарладаг байх шаардлагуудыг яагаад тавиад байгаа вэ гэхээр нэг хуулийн заалтыг хэрэглээд өөрөөр шийдсэн маш олон тохиолдлуудыг одоо гараад байна. Маш олон тохиолдол. Манайх саарал жагсаалтад ороход би дэд сайдаар ажиллаж байхад манайхыг мөнгө угаах гэмт хэргээр нэг ч хүн шийтгээгүй байна гэж байсан юм. Судлаад үзсэн чинь МИАТ, төмөр замтай холбоотой хоёр хэргийг дээд шүүхээс буцаах замаар хэрэгсэхгүй болгочихсон байсан. Яг адилхан хүний, бүр тэрнээс ч бага хохиролтой хэрэг дээр тав, арван жилийн хорих ял ногдуулчихсан л байсан. Яг нэг заалтыг хүнд өөр өөрөөр хэрэглэдэг. Тэгээд тэр шийдвэрээ та тайлбарладаггүй. Монгол улсын одоо шүүхийн шийдвэрийг ард түмнийхээ өмнө, олон нийтийн өмнө хяналтад оруулах гээд байгаа байхгүй юу. Тайлбарладаг байгаач. Үндэслэлээ бичдэг байгаач. Яагаад гэдэгтэй хариулдаг

байгаа ч, яагаад ийм хуулийн нэг заалтыг илт өөрөөр хэрэглээд нэгийг нь цагаатгаад нэгийг нь яллаад байгаа юм бэ. Үгүй ээ энийгээ зүгээр үндэслэлээ тайлбарлах гэж байгаа шүү дээ. Тэр шийдвэртээ биччихээч гэж гуйж байна шүү дээ.

Тэгээд бичихгүй байгаад байгаа энэний чинь одоо гор өнөөдөр хууль ийм тэгш бус шударга бус байдал гарахад нөлөөлөөд байна шүү дээ. Ийм л шаардлага тавьж байна шүү дээ. Энэ ерөөсөө зүй бус шаардлага тавиагүй. Шүүхээ бас хариуцлагатай болгоё л гэдэг шаардлага тавьж байгаа шүү дээ. Тэгээд энэ хоёр заалтыг авчихвал би бол хэлж мэдэхгүй байна. Улсын Их Хуралд ямар нүүртэйгээр сонгогчдоо очих юм. Юу гэж хэлэх юм. Энэ чинь шүүгчдэд тавьж байгаа шаардлагыг л өндөржүүлэх гэж байгаа шүү дээ. Тийм учраас би, одоо би бол одоо хэлж чадахгүй л байна. Тэгээд энэ саналыг.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Энхбаяр гишүүн санал хэлчихлээ. Нямбаатар гишүүн.

Х.Нямбаатар: Яг зөв. Бидний өнөөдрийн энэ мэтгэлцэж байгаагийн гол зорилго бол энэ шүүхийг хариуцлагатай болгоё, шүүхийг эрүүл саруул болгоё л гэдэг ийм л нэг үзүүрт сэтгэлээр бид нар өнөөдөр сууж байгаа. Жишээлэхэд, тавин хоёрын нэгийн хорин долоо дээр зүйлчлэлийн алдаа гаргасан шийдвэр болгон яг энэ заалтаар алдаатай зүйлчилж шийдвэр гаргасан шүүгч өөрөө огцорно. Өөрөөр хэлбэл аль заалтыг зайлшгүй шаардлагатай үндэслэл, алийг нь зайлшгүй шаардлагагүй үндэслэл гэж үзэх юм. Эсхүл бол энийгээ хэдүүлээ задлаад биччихье. Задлаад биччихвэл энэ дээр ингээд цаашаагаа хэдүүлээ явчхаж болж байна. Бямбацогт даргаа. Энийгээ маш тодорхой болгомоор байна. Жишээлэхэд, тавин хоёрын нэгийн хорин гурав дээр юуг илт алдаатай, юуг тодорхой заалтыг, юуг тодорхой заалт, юуг маргаангүй заалт, юуг ноцтой одоо алдсан заалт гэж үзэх юм. Энийгээ хэдүүлээ бүр задлаад ингээд маш тодорхой биччихвэл. Ингээд цаашаагаа явчихъя.

Би түрүүн хэлээд байгаа шүү дээ. Хэдүүлээ нуухыг нь авах гээд нүдийг нь сохолчих вий шүүхийнхээ. Өнөөдөр энэ Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бас нэг баталгаа бол яах аргагүй шүүх засаглал. Би тэгээд Мөнхсайхан энэ тэрийг түрүүн асуусан шүү дээ. Чи яг хэдэн хэрэг дээр шүүн таслах ажиллагаа хийж явсан юм бэ? Энэ шүүн таслах ажиллагаа гэдэг бол өөрөө маш их баялаг, баян зүйл. Амьдрал өөрөө маш их баян. Түрүүн чиний гаргаж авсан жишээ бол гаднын улс орнуудад байсан жишээ ярьж байгаа юм. Цав цагаан цаас ингээд өгвөл ямар ч үндэслэлгүйгээр шийдвэр гаргаж бай л гэж ойлгоно. Монголын шүүх аль ч тохиолдолд цав цагаан цаасаар хүн яллан шийтгэсэн, хүний өмч хөрөнгийг хураасан ийм шийдвэр гаргасан тохиолдол огт байхгүй. Мэргэжлийн алдаа гаргадаггүй салбар гэж ерөөсөө огт байхгүй. Алддаггүй хүн ч гэж ерөөсөө огт байхгүй. Буруу зүйлчлээд хэрэг шийдсэнийхээ төлөө бүх шүүгч ажлаасаа огцроод байвал энэ ажлыг хэн хийх юм. Би энэ тухай л ярьж байгаа юм.

Тэгэхээр энэ ерөнхий тавьчихсан зүйлээ эсвэл тодорхой болгоё. Зүйлчлэлийн алдаа болгон дээр хүнийг ажлаас халаад байвал энэ болохгүй. Хоёрт нь энэ хуулийн илт тодорхой маргаангүй заалтыг ноцтой одоо зөрчсөн гэж байгаа байхгүй юу. Хуулийн илт заалт гэж юуг хэлдэг юм. Хуулийн тодорхой заалт гэж юу хэлэх юм. Маргаангүй заалт гэж юуг хэлэх юм. Яг энийгээ эсвэл тодорхойлчихмоор байна. Тэгээд хэдүүлээ цаашаа явъя.

С.Бямбацогт: Бас яг энэ дээр хэлэхэд дээд шүүх чинь Үндсэн хуулиас бусад хуулийг тайлбарлах эрх нь хуулиараа байгаа шүү дээ, эрх нь. Тийм ээ энэ дээрээ бид нар дээд шүүх тайлбар гаргахдаа норматив тайлбар гаргахдаа тийм үү энэ бол яг гарцаа байхгүй мэргэжлийн алдаа байна. Энийг мэргэжлийн ханалтаа гэж үзнэ. Үүнийг бол сахилгын зөрчил гэж үзнэ. Тийм учраас энэ бол энэ хуулийн заалтад хамаарна, энэ бол хамаарахгүй гээд тайлбар гаргачих нэг гаргалгаа байж болж байна. Юу эсхүл сая бас яригдаж л байна л даа. Дээд шүүх, тийм үү яг шүүгчийг огцруулах шийдвэрийг бас гаргах тийм гаргалгаа бас байж болж байна. Энэ дээр та бүхэн бас бодооч бас ярилцаач. Одоо Алтанхуяг гишүүн. Тэгээд энэ Дэлгэрсайхан гишүүн, Мөнхцэцэг гишүүн, Мөнх-Оргил гишүүн бас нэг саналаа хэлье гээд байх шиг байна. Нэг гурав гурван минут саналаа хэлчихье. Нэрийг нь оруулчихъя, бэлдэж байгаарай.

Н.Алтанхуяг: Болж байна даа хэдүүлээ сайхан ярьсан нь дээр л дээ. Энэ чинь тийм амар эд биш ээ. Янз янзаар ойлгогдох байх. Тэгэхээр энэ хоёр тодорхой заалт ирээд байгаа юм. Би болохоор ийм санаа хэлмээр байна. Энэ бол одоо Үндсэн хууль дээр шүүгчид одоо хариуцлага тооцдог. Сахилгын хороо гэдэг юм байгуулахаар Үндсэн хуульд заагаад, хуучин бол ер нь ёс зүйн хороо гэлүү нэг тийм юм байсан шүү дээ. Тэр бол одоо та нар шүүгчид уучилна биз. Ерөнхийдөө шүүгч янз бүрийн алдаа гаргахад иргэн хүн гомдол гаргахад дийлэнх нь шүүгчээ хамгаалж үлддэг ийм л тогтолцоо байсан. Тэгэхээр энэнийг сайхан тал талаасаа ярьж байгаад Үндсэн хуульд өөрчлөлт оруулаад одоо шүүгчийн сахилгын хороо бол. Одоо шүүгчийн сахилгын хороо гэхээр шүүгчийг л одоо баллах гээд байна гэж ойлгоод байх юм. Би одоо энэ ажлын хэсэгт орж одоо өчнөөн олон хоног суугаад эд нарын ярианаас энэ шүүгч ч шүүхийнхний ярианаас юу гэж ойлгож байна гэхээр энэ чинь эсрэгээр нь шүүгчээ хамгаалж байгаа юм байхгүй юу.

Чи ийм юм хийж болохгүй юм байна шүү, хөөе эртхэн шиг. Тэгэхдээ энэ зуун юм яриагүй, дөчин ширхэг юм ярьж байгаа шүү дээ. Чи шүүгч хүн ийм дөчин ширхэг юмыг ерөөсөө хийж болохгүй. Би энийг бол их сайн л зүйл явж байгаа гэж бодож байгаа. Тэгээд би яг энэ мэргэжлийн биш хүн мөртөө би энэ салбарын практикийн хүн байхгүй юу. Олон шүүх хуралд орж олон янзын хэргээр бүх шатаар чинь явсан. Би өөрөө сэжигтэн болж байна юу билээ, гэрч зөндөө гоё байж үзсэн. Сэжигтэн байж үзсэн. Яллагдагч хүртэл явж үзэж би энийг бас ингээд бүгдийг нь үзсэн юм. Тэгээд шүүхийн шийдвэрт зайлшгүй шаардлагатай үндэслэлийг огт бичээгүй, одоо ер нь юу гэсэн үг вэ. Үгүй ээ чи намайг яагаад яллаад байгаагаа ядаж нэг өгүүлбэр үндэслэл бичихгүй юм бол тэрнийг чинь ямар шийдвэр гэж үздэг юм. Чи юуг үндэслэж гаргаж байгаа юм. Чи харин нэг амьтны үгэнд ороод гаргачихсан юм биш биз. Би бол тэгж шууд тэгж хэлнэ. Тийм учраас би энийг харин ч энэ Энхбаяр даргад хэлсэн юм. Та одоо яасан бөөрөнхий хүн бэ? Энэ тавин хоёрын нэгийн хорин долоо дээр дээд шатны шүүхээр тогтоогоод байхдаа яадаг юм. Бараг илүү дамжлага шүү дээ.

Үгүй ээ, Алтанхуяг гэдэг хүнийг яагаад яллаж байгаагаа үндэслэлээ яагаад бичдэггүй юм. Ийм учраас хэдүүлээ энэ дээр та нар сайн ярьж байгаад би бол бараг дээд шатны шүүхээр тогтооно гэдэг чинь баахан процесс болоод тэгээд жонхуураад алга болно. Яах вэ, нөгөөх нь Нямбаатар сайдтай би нэг юм дээр санал байна. Хуулийн илт, тодорхой маргаангүй заалтыг ноцтой гээд. Энийг найруулчих л даа та

нар. Ер нь санаа нь бол түрүүн Мөнхсайхан хэллээ шүү дээ. Юу гэж байна вэ гэхээр үгүй ээ, яах юм бэ улаан цайм торгох ялтай байсан юмыг шоронд хийчихдэг. Шоронд хийх, ялтай байсан юмыг торгох энэ хуулийг нь үгэнд бид нар салгачихсан шүү дээ. Би зүгээр ингээд л бүдүүлэг жишээ авч байна. Ингэчихсэн ийм ноцтой улаан цайм хийчихсэн юмыг чинь алдаа гэж үзэхгүй яах юм. Шүүгчид бид нар анхааруулж байна шүү дээ. Чи хөөе тэр Монголд гараагүй нь хамаагүй. Дэлхий дээр ийм жишээ гарсан юм. Ийм юмыг ингээд хийгээд ингээд алдаа болсон юм шүү чи энийг анхаараарай гээд. Би одоо шүүгч бол энэ дөчийг бол цээжээрээ л би маш сайн уншмаар байна. Ийм дөчин зүйлийг би ерөөсөө хэрхэвч хийж болохгүй юм байна. Би энэ энэ дээр нь жаахан сул байгаа. Би энэ талаар мэдлэг боловсролоо дээшлүүлээд асуугаад сураад, ингээд ингээд ингэх юм байна.

Миний энэ алдаанууд гэдэг бол цаанаа хүний амьдрал, айл гэрийн амьдрал, олон хүний амьдралаар тоглож мэдэх юм байна. Би бас хүний нөлөөнд орчхож болох юм байна. Үгүй ээ ядаж энэ дээр бичсэн юмыг чинь харчхаад би бол шүүгч бол ингэнэ. Хөгшөөн хуулийн илт тодорхой маргаангүй заалтыг зөрчиж болдоггүй юм хаана байгаа юм.

С.Бямбацогт: Алтанхуяг гишүүн 1 минут.

Н.Алтанхуяг: Би энэ ажлын хэсэг дээр ажиллаж байхдаа тэгж их ойлгосон. Дандаа шүүгчийг яллах гээд байгаа юм байхгүй шүү дээ. Шүүгчийг бид нар хамгаалах гээд байгаа юм. Ингээд биччихсэн байхад би яг шүүгч хийвэл яг энэний дагуу ажиллана. Хүүш ээ болдоггүй байхгүй юу. Энэ улаан цайм ингээд биччихсэн юмыг би ингэхээр ингэдэг. Үгүй ээ, чи нэг аргалаад нэг ийм шийдвэр гаргачих л даа. Үгүй ээ би энэ үндэслэлийг ямар ч гэсэн нэг өгүүллээр бичихгүй бол тэгээд л дуусаа. Дахиад цаана нь зөндөө ийм гох дэгээ байгаа шүү дээ. Ингээд иргэн хүн өгөнгүүт сахилгын хороо аваачаад тийм шийдвэр гаргахгүй. Одоо эд нарын хүсэлтээр байна шүү дээ. Сахилгын хороон дээр чинь сахилгын хороо эцсийн шийдвэр гаргахаа болиод шүүх дээр очиж шийдэгддэг боллоо шүү дээ. Тэр есөн хүний чинь дөрвийн шүүхээс, тавыг нь гаднаас аваад. Тэгээд тэрэн дээр гарсан шийдвэрийг дахиж шүүх хянадаг боллоо. Ингээд хэдүүлээ аль ч талд нь нэг нэгнийгээ хэлмэгдүүлэхгүй байхаар. Тэгэхдээ бас иргэн хохирохгүй байхаар, бас шүүгч хохирохгүй байхаар ийм л одоо их л уялдаатай их гайгүй л юм хийгээд байгаа юм шиг надад ингэж ойлгогдоод л явж байгаа юм л даа. Тэгээд та нар сайн ярь.

С.Бямбацогт: Дэлгэрсайхан гишүүн саналаа хэлье.

Б.Дэлгэрсайхан: Үгүй ээ яах вэ дээ, зүгээр амьдрал дээр бол мянга түмэн л одоо асуудал байгаа. Тэгээд нэг хэдхэн кэйс одоо олон улсад ийм кэйс байна, манайд ийм кейс байна гээд ингээд яриад бас юмыг хэт туйлшруулж болохгүй л дээ. Тэгэхдээ би бол Энхбаяр гишүүний бол ярьж байгааг ойлгож байна. Мэдээж бид одоо шүүхэд шинэчлэл хийх гээд. Тийм учраас энэ заалтыг одоо оруулах нь чухал энэ тэр гэдгийг бол ойлгож байна. Тэгэхдээ ийм ерөнхийлсөн заалт оруулчхаад, тэгээд түүнийгээ зөв гэж зүтгээд байж болохгүй л дээ. Тийм учраас бол энэ ерөнхийлсөн заалтуудаа нэгэнт одоо бид нар хуульд энэ дөч биш, дөрвөн зуун одоо ийм олон одоо төрлийн юм оруулах оруулж чадахгүйгээс хойш миний ойлгож байгаагаар бол мэргэжлийн хороо байгуулаад, мэргэжлийн хороо нь өөрөө энэ шүүгч нарын гаргаж

байгаа алдаа аль нь мэргэжлийн алдаа юм, аль нь одоо улаан цагаан зөрчил юм гэдэг ийм дүгнэлт гаргуулсны дараа сахилгын хороо энийг нь авч хэлэлцдэг ийм л одоо заалт оруулчихвал бид нарын энэ яриад байгаа нь одоо бас нэг талдаа гарч шийдэгдэх ийм боломжтой юм уу гэж би харж байгаа юм.

Тэрнээс биш одоо шууд ингээд энэ тавин хоёрын, нэгийн хорин гурав, тавин хоёрын нэгийн хорин долоо шиг ингээд заагаад оруулчихлаар зэрэг хэн дуртай нь одоо шүүхийн гаргасан, өөрийнх нь эсрэг гаргасан дүгнэлт болгонд л шийдвэр болгонд л сахилгын хороонд гомдол гаргана. Тэгээд ямар ч хэрэг шийдэгдэхгүй, энэ шүүхийн ажил цаашаа явахгүй, тэгээд нэг хонзогносон нөхөр өөрийнх нь талд шийдвэр гараагүй бол тэгээд л одоо ямар нэгэн үнэ төлбөрөөр ч хамаагүй, нөгөө дахиад л нэг шинэ төрлийн нөгөө яриад байгаа юу чинь бий болно шүү дээ. Нөгөө хонгилыг бас нэг өөр нарийхан хонгил ч байдаг юм уу, өөр төрлийн хонгил болгочих юм биш биз дээ. Тэгэхлээр энэ чинь шүүгч нар өөрсдөө шийдвэр гаргахаас одоо бүгдээрээ эмээдэг ийм болчихно шүү дээ. Тэрнээс ямар ч үндэслэлгүй заалт одоо үндэслэлгүй заалт бичээд гэдэг юм уу, эсвэл огт заалт бичихгүйгээр шийдвэр гаргана гэж би одоо бодохгүй байна. Заавал тэр шүүгч өөрийнхөө гаргасан тэр захирамж юм уу, тэр шийдвэрт ямар нэгэн тайлбар гаргана шүү дээ. Мэргэжлийн хорооны одоо урд очоод.

Тэгээд энэ мэргэжлийн хороо нь энэ нь яг шүүгчийн мэргэжлийн алдаа байна гэх юм уу, эсвэл чи энэ хуулийг ноцтойгоор зөрчсөн байна. Түрүүний Энхбаярын хэлдгээр чи урьд нь одоо энэ хорих ял авсан юм, энэ дээр яагаад торгуулийн ял болдгийн гэдэг ийм ноцтой зөрчсөн зөрчлийг чинь мэргэжлийн хороо дүгнэлт гаргаад, тэгээд сахилгын хороо өөр тэр арга хэмжээ авдаг. Ийм маягаар л.../минут дуусав/

С.Бямбацогт: Мөнхцэцэг гишүүн саналаа хэлье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ удаагийн шүүхийн хуулиар шүүгчийн сахилгын зөрчил болон мэргэжлийн хариуцлагын зөрчлийг ингэж ялгаж тэр дотроо сахилгын зөрчлийг одоо маш тоочин одоо эс үлдэхүй болон шүүгчийн одоо хориглосон үйлдлийг зааж өгч байгаа нь бол ер нь дэвшилтэй зүйл байгаа. Тэгээд ер нь олон улсын практик ч гэсэн яг энэ тавин хоёрын нэгийн хорин гурав, тавин хоёрын нэгийн хорин долоо бол угаасаа байдаг заалт байна. Жишээлбэл энэ Америкийн одоо мужууд, Герман, Молдова зэрэг улсад бол энэ хэрэг хянан шийдвэрлэх тухай, эсвэл бусад хуулийг заавал биелүүлэх шинжтэй, илэрхий тодорхой заалтыг шууд санаатай, эсвэл хэт болгоомжгүйгээр зөрчих бол сахилгын зөрчилд орж байна. Яг манай энэ тавин хоёрын нэгийн хорин долоотой бас адилхан байгаа. Хүндэтгэн үзэх шалтгаангүй байхад шүүхийн шийдвэр шаардагдах үндэслэлийг огт бичээгүй нь шүүхийн эцсийн шийдвэр тогтоогдсон байх юм бол Испани, Америк, Бельги зэрэгт бас ийм сахилгын зөрчил болно.

Тэгээд ер нь энэ сахилгын зөрчлийг энэ удаагийн энэ хуулиар ингээд маш дэлгэрэнгүй, тодорхой зааж өгч байгаа маань шүүгчийг бас хамгаалах, одоо маш том зүйл болно. Субъектив, одоо үндэслэлээр гэдэг юм уу, сахилгын хороо тодорхой, одоо субъектийн мэдрэмжээр тухайн одоо шүүгчийн сахилгын зөрчил ногдуулахаас энэ заалт маань өөрөө бас хамгаалж байгаа. Хоёрдугаарт нь одоо илт мэдэгдэхүйц, одоо санаатайгаар гэдэг юм уу, хуулийг одоо үл хэрэгсэх. Мөн одоо хуулийн заалтыг

одоо ямар нэгэн одоо дарамт гэдэг юм уу, эсвэл нөлөөн дор одоо санаатайгаар мушгин хэрэглэх явдлаас хамгаалж байгаа. Ер нь тэгээд олон улсын одоо шүүхийн байгууллагууд, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны нийгэмлэг, Венецийн комисс энэ тэр бол ерөөсөө энэ шүүхийн сахилгын зөрчлийг одоо иймэрхүү дэлгэрэнгүй байдлаар оруулах нь зөв гэдгийг бол зөвлөж ирсэн. Тэгээд яах вэ зүгээр өнгөрсөн энэ гучин жилийн хугацаанд энэ шүүхийн практик дахь одоо нөгөө шударга бусын хонгил, шүүгчийг одоо хараат ажиллаж байна гэдэг юм уу энэ болгон маань энэ сахилгын зөрчлийг тодорхой, ийм одоо дэлгэрэнгүй байдлаар оруулаагүй.

Дээр нь сахилгын одоо шийтгэл нь оновчгүй байсан гэдэг юм уу, эсвэл тодорхой шийтгэлүүдийг оноодоггүй байсантай холбоотой. Тийм учраас бид нар энэ одоо саяын хоёр заалт дээр, тавин хоёрын нэгийн хорин гурав, тавин хоёрын нэгийн хорин долоо дээр бол эмзэглээд гэдэг юм уу, энэ дээр бол айгаад одоо шүүгчийн хэлмэгдүүлнэ гэдэг ийм одоо юм байж болохгүй. Энэ чинь угаасаа олон улсын практик. Тэгээд бид нар одоо шүүхийн реформыг хийх гэж байгаа бол яг л одоо шинэчлэл чигээр нь байдаг юм уу, энэ дэвшлийг бол зайлшгүй хийх шаардлагатай.

С.Бямбацогт: Баярлалаа. Одоо болно, тийм одоо тэгээд л би ярина, би ярина гээд байгаа. Одоо би Мөнхтуяа шүүгч, Мөнхсайхан судлаач хоёрыг сонсчихъё. За тэгээд нэг номерын микрофон. Гурван минут шүү. 4 минут биш 3 минут.

Д.Мөнхтуяа: Баярлалаа. Тэгэхээр яах вэ, зүгээр энэ шүүгчийг одоо хариуцлагаас мултлах гээд алдаа гаргадаг шүүгч нарыг хариуцлагаас мултраад, ингээд хариуцлага хүлээдэггүй болох тухай асуудал ерөөсөө байхгүй. Угаасаа ер нь бол шүүгч хүн бол ер нь алдаа гэдэг бол өөрөө их сонин ойлголт. Энэ жижиг хэрэг гэж байхгүй, хүний хувь тавилан шийддэг, хариуцлагатай ажилд хариуцлагатай хандах ёстой. Тэрэн дээр бол бүгд санал нэг. Хамгийн гол нь энэ асуудал дээр яагаад болгоомжлол төрөөд байгаа вэ гэхээр одоо жишээлбэл сая гишүүдийн хэлсэн тайлбараас хүртэл харахад яг энэ тавин хоёрын нэгийн хорин гурав хорин долоо дээр бид нар бүгд өөр өөрөөр ойлгож байгаа байхгүй юу. Цогтбаатар гишүүн жишээлбэл ratio decidendi гэж ойлгож байна. Энд Мөнхсайхан жишээлбэл торгох ял уу, хорих ял өгчихсөн, эсвэл одоо хилээр гарахыг нь хориглочихсон энэ тэр гээд ойлгож байна. Энхбаяр гишүүн болохоор Улсын Их Хурлын гишүүнд одоо шүүх ял оноочихсон асуудлыг ойлгож байна. Ийм аюултай учраас энийг тодруулахгүй бол энүүгээр нь явуулж болохгүй гээд байгаа юм.

Тэрийг одоо жишээлбэл илтэд одоо ойлгомжтой заалт гэдгийг сахилгын хороо тогтоох гэж байна. Илтэд одоо шаардлагатай шүүхийн шийдвэрт шаардлагатай үндэслэл гэдгийг сахилгын хороо тогтоох гэж байна. Ер нь бол энэ шүүхийн шийдвэрт юу бичих вэ гэдгийг шүүхийн хуулиар биш тэр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, тэр захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай процессынх нь хуулиар шүүхийн шийдвэрийн үндэслэх, тодорхойлох, хянах хэсэгт юу юу орох вэ гэдгийг бүр нарийн заагаад ирчихсэн. Тийм учраас шүүхийн шийдвэр гэдэг дээр огт үндэслэл бичихгүй цагаанаар нь өгсөн. Одоо нэг ч шүүхийн шийдвэр байхгүй, гарах боломжгүй. Хамгийн гол нь тэрэн дотор нөгөө маргаантай хэрэг дээр арван үндэслэлээр маргадаг. Зургаан үндэслэлээр маргадаг. Хамаатай, хамаагүй бүх юмыг холиод маргадаг. Шүүгч шийдэхдээ гурвын энэ үндэслэлийн чухал юм байна гээд авч үзээд дүгнэлтээ бичдэг, нэгийг нь бичдэггүй, нэгийг нь дутуу бичдэг ийм л асуудал байдаг. Дээд шатны шүүх

нь хянан үзэхээрээ үнэхээр энэ шүүхийн шийдвэр гарахад зайлшгүй шаардлагатай зарим юм дутуу байна гэвэл буцаадаг. Дахиж энэ дутуу ажлаа гүйцээгээд дахиад ороод ир гээд.

Зарим тохиолдолд чи нэг үндэслэлийг нь бичээгүй юм байна, дутуу байна, чиний дүгнэлт. Гэхдээ наадах чинь хэргийн шийдэлд нөлөөлөхгүй юм байна гээд хэвээр нь үлдээгээд явуулдаг юм байгаа. Энэний алийг нь зөв бэ, алийг нь буруу вэ гэдгийг шүүхээс гадна сахилгын хороон дээр ялгаж салгах гээд байгаад л болгоомжлоод байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ олон одоо гомдол дээр сахилгын хороо энэ дээр зөрчил мөн үү, биш үү гэдгийг тогтоохын тулд шүүхийн шийдвэрийг уншиж үзэх нь байна. Шүүгч шийдвэрээ сахилгын хороон дээр очиж тайлбарлах юм байна. Үндэслэлээ. Би ингээд ингээд үндэслэлтэй, одоо илэрхий зөв тайлбарлачихсан юм гэдгээ. Ийм нөхцөлд ямар болгоомжлол байгаа вэ гэхээр сахилгын хороо, зарим гомдолд сахилгын хэрэг үүсгэнэ, заримд нь үүсгэхгүй. Өөрөөр хэлбэл энэ бол энэ зөрчил биш, үзэмж орно, субъектив байдалд орно. Ингэхээр цаашдаа одоо энэ чинь эргээд бид нар ямар асуудалд энэ ноцтой үр дагавар учруулж болзошгүй учраас болгоомжлол байна гэдэг үндэслэл хэлээд байгаа юм. Түүнээс шүүгч нарыг одоо хариуцлагаас мулт.../минут дуусав/

С.Бямбацогт: Мөнхсайхан багш, гурван минут.

О.Мөнхсайхан: Баярлалаа. Тэгэхээр миний энэ хэлж байгаа жишээ гадаад жишээ ерөөсөө биш шүү. Өөрөөр хэлбэл одоогийн шүүгчийн ёс зүйн дүрмийн гурвын нэг, гурвын гуравт хууль дээдлэх зарчмыг зөрчих, эсвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд нийцүүлэн явуулах үүргээ зөрчихийг сахилгын зөрчилд тооцоод шийтгэдэг. Яг зургаан жил ингэж ажилласан. Миний түрүүн хэлсэн тэр торгох ял одоо ганцхан заалтыг одоо хорихоор сольсон гэж гаднын жишээ. Бусад нь бүгд Монгол жишээ. Энэ болохоор гээд ёс зүйн хороо энэ ёс зүйн дүрмийг зөрчөөд зөрчил гаргаж гээд шийтгэснийг зөрчлийг нь дээд шүүх, зарим дээр нь Мөнхтуяа шүүгч бас оролцсон. Яагаад би сайн мэдэж байна гэхээр би ёс зүйн хороонд таван жил ажилласны хувьд Нямбаатар гишүүн асууж байна. Энэ хэрэг уншсан уу гээд. Би бол ийшээ дахиж ажиллахгүй. Би цэвэр судлаачийн хувьд бас энэ талаар таван ном бичсэн судлаачийн хувьд хэлж байгаа юм.

Тэгээд энэ жишээ түрүүн хэлсэн жишээнээс гадна юу байна гэхээр өөрөөр хэлбэл нөгөө гомдол гаргах эрхтэй гээд бичээд байхад эрхгүй гээд байдаг. Шүүх хуралд биечлэн оролцоно гээд эрхтэй байхад ямар ч боломжийг нь олгоогүй. Үгүй ээ, илэрхий энэ маргах ямар ч юмгүй заалтыг зөрччихсөн юмыг явж байгаа байх. Одоо бүр нэг тодорхой жишээ байгаа. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зуун хорин нэгийн нэгийн хоёрт гагцхүү уг шийдвэрийг биелүүлж эхлэхээс өмнө шүүх шийдвэрийнхээ талаар тайлбар гаргаж болно гээд байдаг байхгүй юу. Тэгэхээр чинь нэг шүүгч яасан бэ гэхээр шийдвэр нь биелж эхэлснээс хойш найман сарын дараа шийдвэр дээрээ тайлбар гаргачихсан, Монголд хийсэн. Тэгээд энэ ёс зүйн хороо бол энэ бол сахилгын зөрчил байна, энэ мэргэжлийн алдаа ерөөсөө биш гэж үзээд арга хэмжээ авсан. Дээд шүүхийн нэг зөрчил гээд үзчихсэн. Бас нэг одоо хүн яасан гэхээр гадаадад ээжийгээ асраад оршуулаад ингээд хоёр сар явж байгаад ирсэн чинь тэр хооронд нь шүүхийн шийдвэр гарчихсан. Тэгээд үгүй ээ би хүндэтгэн

үзэх шалтгаантай байсан юм гээд нөгөө хугацаа сэргээлгэх хүсэлт гаргасан чинь шүүгч татгалзаад байгаа байхгүй юу.

Тэгээд ёс зүйн хороо энэ сахилгын зөрчил гээд шийдсэн. Шүүх бас л мөн бичсэн. Энэ цоо шинэ юм биш. Тэгээд энэ гаднын улс гээд би зүгээр нөгөө одоо энэ чинь эх газрын тогтолцоотой улсууд бүр хууль дээрээ яг ингээд биччихсэн байхгүй юу. Испани, Итали, Бельги гээд. Энийг дурдахаа больё. Тэгээд энэ сахилгын хороонд чинь одоо Франц, Америкт энэ тэрд бүр иргэн ороод шийдчихэж байгаа юм энийг чинь. Ерөнхийдөө бүр одоо Францад иргэд олонх нь орж байгаа энийг шийдэж байгаа. Иргэдийн нөгөө нэг наад захын тэр юугаар шалгуур хангаж байна уу гээд. Манайх харин яаж байна гэхээр энэ төслийг харахаар сахилгын хороонд чинь дөрвийн дөрвөн шүүгч анх удаа оруулж ирж байгаа. Шүүгч нар нь сууна шүү дээ энэ чинь. Дээрээс нь таван хууль зүйн өндөр мэргэшилтэй хүн оруулж байгаа юм. Тэгээд энэ чинь дотроо сахилгын хороо хоёр шаттай шийдэхийн. Эцсийн шийдвэрийг нь хоёр шүүгч, нэг шүүгч биш гишүүн гаргаж байгаа юм. Энэ шүүгч нарынхаа болгоомжлоод байгаа зүйлүүдийг энд бол харгалзсан. Мэргэжлийн хороо гэж Үндсэн хуулийн биш байгууллагад өгвөл энэ бол сахилгын зөрчил, юу Үндсэн хуулийн зөрчил болно. Цэц хоёр мянга таван онд яг мэргэжлийн хорооны дүгнэлтээр шүүгчийг чөлөөлдөг хуулийг Үндсэн хууль зөрчсөн гээд гаргаж байсан юм. Тэгээд тусгайлсан чиг үүрэгтэй сахилгын хороо байгаад байхад энийг яана гэдэг бол болохгүй гэж. Тэр хуулийн юу, шүүхийн шийдвэрийн үндэслэл бичихгүй байна гэдэг бол хуульд захирагдаагүй л юм байгаа байхгүй юу. Ядаж нэг ч гэсэн үндэслэлээ бич л гэдэг ийм шаардлага байгаа.

С.Бямбацогт: Мэтгэлцээний цаг дууслаа 30 минут гэсэн. Одоо санал хураалт 15 минутын дараа явуулъя. Одоо 15 минут завсарлаад санал хураалт явуулъя. Камераа хаачих уу, хоорондоо жаахан бая ярилцъя бас тэгээд камергүй, микрофонгүй.

ЗАВСАРЛАГА

С.Бямбацогт: Гишүүд Нямбаатар гишүүн, Алтанхуяг гишүүн, өөр хэн байна вэ? Энүүгээр чинь хэн байгаа билээ? Амарсайхан гишүүн. Дэлгэрсайхан гишүүн байна. Одоо чинь санал хураалт явна тийм ээ. 52-оос нөгөө 2 саналыг нь үлдээгээд хураалгая тэгэх үү. Шууд хэлээд яахаар яадаг юм бэ, уншихдаа хасаад уншиж болохгүй юу. Тийм. Санал хураалт, гишүүд орж ирж байгаа байх. Хуулийн төслийн 52 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууслаа. Бас 23, 27 гэсэн заалт дээр сая тодорхой 30 минутын хугацаанд бас мэтгэлцээн явуулсан. Одоо санал хураалт явуулна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна. Ингэхдээ тэр түрүүн унасан 52.1.14 одонгоор шагнахтай холбоотой унасан саналыг хураалгахгүй. Мөн 52.1.23 сая маргаад мэтгэлцээд бас тодорхой үр дүнд хүрээгүй байгаа. 52.1.7 бас тодорхой шийдэл гараагүй байгаа энэ 3 саналыг хасаад саналаа хурааж байя. Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Лүндээжанцан гишүүнийг бас энэ 52.1.23, 27 дээр бас тодорхой байр сууриа илэрхийлж саналаа хэлээч гэж хүсье. Санал хураалтын дараа та бэлтгэлтэй байгаарай гэдгийг хэлье.

Ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналаар, Энхбаяр гишүүн ажлын хэсгийн ахлагч. Саналаа тайлбарлаж үг хэлье.

Б.Энхбаяр: Баярлалаа. Сая нөгөө 52.1.14 санал хураалгахгүйгээр түрүүн шийдсэн гэдгээр хасъя. Гэхээр энэ өгүүлбэр дотор нэг ийм юм байгаа юм. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийг одонгоор шагнах. Улсын тэтгэврийг өргөтгөн нэмэгдүүлэх тухай хуульд зааснаас бусад цол одон гэж байгаа юм. Тэгэхээр энэ нөгөө юу вэ гэхээр түрүүн бол төрийн дээд одон буюу Монгол Улсын Ерөнхийлөгчийн шагналыг л авч болохгүй гэдгийг бол гишүүд дэмжсэн. 52.1.14-д бид бас юуг багтааж оруулсан бэ гэхээр цол гэдэг нь тэмдэг шагнал гээд яваад байгаа юм бас.

Цол, тэмдэг, шагнал. Өөрөөр хэлбэл энэ нөгөө бусад байгууллагаас бас олгодог төрийн бус байгууллагууд юм уу энд бол бүр салбарын тэргүүнийг хүртэл ойлгосон. Яамны жуухыг хүртэл ойлгосон. Одоо онц тээвэрчин ч гэдэг юм уу мэргэн буудагч ч гэдэг юм уу янз бүрийн шагнал байдаг юм байна л даа. Тэгээд ийм шагналууд бас аваад байж болохгүй шүү гэдэг утгаар энэ 52.1.14-г юу яасан юм. Тэгэхээр та бас нөгөө бүхэлд нь хасаад нөгөө бүхлээрээ алга болчихоод байна. Тэрийг бол одоо авч болохгүй юм байгаа биз дээ арай бас. Энийг тийм агуулга бас яваад байгаа юм.

С.Бямбацогт: Энийг бид нар юу яая. Ажлын хэсэг санал хураалтын дараа бас найруулга агуулгын хувьд бас яг ямар байдлаар авах уу томъёолол бэлдчих одоо. Одоо бэлдчих. Бид нар хураалгахгүй байхад нь дараа нь саналын томъёолол тэгээд хураалгая. Хураалгаж байх хооронд тийм. Ингээд ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд уншиж танилцуулъя. Санал хураалт явагдана.

“52.1.Шүүгчид дараах зүйлийг хориглоно:

52.1.1.албан тушаалын байдал, эрх нөлөөгөө урвуулан ашиглаж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгох;

52.1.2.албан үүрэгтэй нь холбоотой, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн нууцыг задруулах;

52.1.3.албан үүрэгтэй нь холбоотой, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн албаны, байгууллагын, хувь хүний нууцыг задруулах;

52.1.4.шүүхээр хянан хэлэлцэгдэж байгаа хэрэг, маргааны талаар шүүхийн шийдвэр гарахаас өмнө өөрийн байр суурийг олон нийтэд мэдээлэх, илэрхийлэх;

52.1.5.албан ажлын хэрэгцээнд зориулсан материал, техник хэрэгслийг шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс өөр зориулалтаар ашиглах;

52.1.6.бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн аливаа мэдээллийг шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс өөр зорилгоор ашиглах;

52.1.7.шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан бусад шүүгчийн шүүн таслах ажиллагаанд хуульд зааснаас бусад хэлбэрээр оролцох, нөлөөлөх, заавар, удирдамж, чиглэл өгөх, авах, урьдчилан санал хэлэх;

52.1.8.шүүгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хэргийн оролцогч, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч болон бусад иргэн, хуулийн этгээдээс шууд ба шууд бусаар тусламж авах, үйлчлүүлэх, давуу байдал, хөнгөлөлт, мөнгөн болон бусад урамшуулал, хууль тогтоомжоор зөвшөөрөгдөөгүй шагнал авах;

52.1.9.өөрийн, гэр бүлийн гишүүний, төрлийн хүний, эсхүл албан байгууллагын эрх ашиг хөндөгдсөнөөс бусад тохиолдолд гуравдагч этгээдийн хууль ёсны төлөөлөгч байх, хууль зүйн зөвлөгөө өгөх;

52.1.10.тухайн шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчтэй гэр бүл, эсхүл төрөл, садангийн холбоотой талаар Ерөнхий зөвлөлд мэдэгдэхгүйгээр ажиллах;

52.1.11.өөрөө, эсхүл итгэмжлэгдсэн этгээдээр дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, аж ахуйн нэгж, тэдгээрийн холбоо, нэгдлийн удирдах бүрэлдэхүүнд орох, зохион байгуулалтын үйл ажиллагаа явуулах;

52.1.12.Монгол Улсын олон улсын гэрээ, гадаад улсын шүүх, олон улсын болон гадаадын байгууллагатай харилцан тохиролцсоноос бусад гадаад улс болон олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүний санхүүжилтээр багшлах, эрдэм шинжилгээний болон бусад ажил эрхлэх, гадаад улсад зорчих;

52.1.13.гадаад улсын төр, олон нийтийн болон бусад байгууллагын шинжлэх ухааныхаас бусад хүндэт, тусгай цол, шагнал, одон, тэмдэг авах;

52.1.14 болж уншигдах нь тийм ээ. Энэ дугаарлалтыг бас ойлгоорой.

52.1.14.Монгол Улсын олон улсын гэрээгээр гадаад улсын холбогдох шүүх, олон улсын болон гадаадын байгууллагатай харилцан тохиролцсоноос бусад Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин байгаа гадаад улсын болон олон улсын байгууллага, түүний салбар нэгжийн удирдах бүрэлдэхүүнд орох;

52.1.16.багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсрах;

52.1.17.улс төрийн байгууллагын удирдах болон бусад албан тушаал эрхлэх, улс төрийн байгууллага, улс төрийн сонгуульд нэр дэвшигчийн талаар олон нийтэд хандаж үг хэлэх, сонгуулийн сурталчилгаанд оролцох, улс төрийн сонгуульд нэр дэвшигчид санхүүжилт, хандив өгөх;

52.1.18.хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах, харилцах;

52.1.19.хэргийн оролцогч болон бусад этгээдтэй харилцахдаа шүүхийн нэр хүнд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох хувийн дотно харилцаа тогтоох;

52.1.20.хэргийн оролцогч болон бусад этгээдтэй албан үүргийн хувьд харилцахдаа зүй бус авирлах, эсхүл хуралдааны дэг сахиулах хүрээнд бусдын зүй бус авирыг таслан зогсоох талаар шаардлага тавихгүй байх; энэ дээр зогсоох талаар шаардлагагүй тавихгүй байх гэдэг дээр бас найруулгын санал Энх-Амгалан гишүүн гаргасан. Энийг бас анхаараарай.

52.1.21.хуульд заасны дагуу олгосон бие хамгаалах тусгай хэрэгслийг зориулалтын бусаар ашиглах, бусдад ашиглуулах;

52.1.22.энэ хуулийн 19.2.2, 19.2.5-д заасан дараалал, журмыг санаатай зөрчих;

52.1.23.хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах;

52.1.24.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр албан ажлаа удаа дараа таслах;

52.1.25.шүүх хуралдаан, урьдчилсан хэлэлцүүлгийн товыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа зөрчих;

52.1.26.шүүхийн шийдвэр гаргахтай холбоотой хуульд тодорхой заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа 30 хоногоос дээш хугацаагаар, эсхүл нэг удаа 60 хоногоос дээш хугацаагаар зөрчих;

52.1.28.хуульд заасны дагуу татгалзан гарах үүрэгтэйгээ мэдсээр байж татгалзан гараагүй;

52.1.29.ажлын байранд болон албан үүргээ гүйцэтгэхдээ согтууруулах мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, эсхүл ийм байдалтай ажилдаа ирэх;

52.1.30.шүүгчийн сахилгын хэрэг шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах;

52.1.29 дээр мансууруулах эм сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх эсхүл ийм байдалтай ажилдаа ирэх. 30-г уншсан.

52.1.31.хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээл зэргээр нь ялгаварлан гадуурхах, дарамт үзүүлэх;

52.1.32.хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээ ашиглахдаа шүүх, шүүгчийн нэр хүндэд харшилсан, эсхүл шүүхийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх санал, сэтгэгдэл, зураг, дууны, дуудүрсний бичлэг болон бусад хэлбэрийн мэдээ, мэдээлэл тараах, байршуулах;

52.1.33.шийдвэр гаргахаар зөвлөлдөх явцад бусадтай аливаа хэлбэрээр харилцах, зөвлөлдөх тасалгааны нууцыг задруулах;

52.1.34.шүүх хуралдааны явцад гар утас хэрэглэх зэрэг хэрэгт хамааралгүй өөр бусад үйл ажиллагаа явуулах;

52.1.35.шүүхийн ажилтан болон өөрийн удирдлага дахь этгээдэд албан үүрэгт нь хамааралгүй үүрэг даалгавар өгөх;

52.1.36.шүүхэд гэрчээр дуудагдсан, эсхүл өөрийн удирдлага дахь ажилтны талаар тодорхойлохоос бусад тохиолдолд хүний зан байдал, ёс зүй, нэр төр, ур чадварын талаар тодорхойлох; 52.1.36 дээр шүүхэд гэрчээр дуудагдсан хүн эсхүл өөрийн удирдлага дахь ажилтны талаар тодорхойлохоос бусад тохиолдолд хүний зан байдал ёс зүй нэр төр ур чадварын талаар тодорхойлох.

52.1.37.албан үүргээ гүйцэтгэхээс бусад тохиолдолд шүүгчийн үнэмлэх, тэмдэг ашиглан өөртөө давуу байдал бий болгох, хувийн хэрэгцээнд шүүгчийн үнэмлэх, тэмдэг ашиглах, барьцаа болгон үлдээх;

52.1.38.хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн талаар эргэлзээ төрүүлэхүйц ойлголтыг бусдад өгөх, нийтэд мэдээлэх;

52.1.39.энэ хуулийн 46.8-д заасан үүргээ биелүүлээгүй;

52.1.40.энэ хуулийн 68.6-д заасныг биелүүлээгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Яриагүй байгаа тийм. Дараа нь хураах юм. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 92,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Одоо томъёолол бэлдсэн үү? Дараагийн санал хураалт. 3 санал саяын 52 угаар зүйлээс 3 санал үлдсэн байгаа. Санал хураалт. 52.1.14.төрийн дээд одон, медаль, шинжлэх ухааныхаас бусад хүндэт, цол, шагнал, одон, тэмдэг авах; хориглох заалтад орж байгаа. дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Нямбаатар гишүүн санал хураалт хүчингүй болгоё. За. Санал хураалт хүчингүй шүү. 52.1.14.төрийн дээд одон, медаль, шинжлэх ухааныхаас бусад хүндэт, цол, шагнал, одон, тэмдэг авахыг хориглоно. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Ажлын хэсэг, санал гаргасан ажлын хэсэг. Тэрэнтэй холбож найруулсан юм. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Одоо 23 дугаар санал, 23, 24 дүгээр санал хураалт явуулна. Сая мэтгэлцээн хийсэн. Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Лүндээжанцан гуайг микрофонд урьж байна бас. Санал сонсьё. Дараа нь санал хураалт явуулна.

Д.Лүндээжанцан: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ажлын дэд хэсгийнхний оройн амгаланг айлтгая. Миний бие бас ажлын дэд хэсгийнхэнтэй хамт энэ томьёоллууд дээр бас оролцож суусан. Тэгээд яах вэ нэлээн л ажилласан. Судалгаа шинжилгээ бол нэлээн их хийгдсэн. Хэлэлцүүлэг бол их олон удаа Засгийн газрын төсөл өргөн баригдахын өмнө болон дараагаас эхлээд олон удаа хийгдэж ирсэн. Тэгээд ер нь бол мэдээж хэрэг энэ Монгол Улсын хувьд бол шударга ёсыг тогтоох, шүүхийн шинэчлэлийн эрс шинэчлэлийг хийхтэй холбоотой маш их хөдөлмөр зарцуулагдсан гэдгийг бол би харж байсан.

Ингээд энэ 3 асуудлаар манай дэгийн хууль ч гэсэн бас ахиц дэвшил гарсныг харуулж байгаа юм. Өөрөөр хэлбэл мэтгэлцээнийг хаалттай болон нээлттэй хийх энэ нөхцөл байдлыг бий болгож чадсан. Өмнө нь бол ерөөсөө л тэгээд л аль нэг тийш нь шууд хагалаад л шийдээд л явдаг бол энэ хуулийн заал бүр дээр бол их олон талаас нь ярих нөхцөл бүрдэж байна. Манай Хууль зүйн байнгын хорооны гишүүд бол үнэхээр мэтгэлцээнийг бол би өрнүүлж байна. Ийм ч байх ёстой гэж ингэж бодож байгаа. Тэрнээс одоо нэг нэгийгээ бол аль нэг тийш нь туйлшруулж ярьж байна гэж би бол бодохгүй байгаа. Энэ мэтгэлцээн байхаас өөр аргагүй ийм зүйл.

Ажлын дэд хэсгийн хуралдаан дээр энэ 40 асуудал гарч ирэхэд хэчнээн юм болж байж гарч ирсэн бэ. Тэгээд бол би яагаад байна шүү дээ энэ дэд хэсэг гэсэн энэ асуудал орж ирсэн бэ гэж ойлгоход бол би юу гэж ойлгосон бэ гэхээр эхнийх нь бол тэр 52.1.23 дээр хуулийн илт тодорхой маргаангүй заалтыг гэж. Маргаангүй заалт гэж ер нь ямар юмыг хэлдэг юм бэ энэ тэр гээд л ярих байх. Энийг бол найруулгаар бол авчхаж болох юм гэж ингэж бодож байгаа юм. Заалтыг ноцтой энэ ноцтой гэдэг үг дээр нь бол би энэ бол сахилгын энэ бол зүгээр мэргэжлийн алдаа гэж үзэж болохгүй. Сахилгын зөрчил байх ёстой юм байна. Ноцтой зөрчиж байж сахилгын зөрчил болно гэж. Тэгэхээр энийг бол дараа нь тайлбарлаж болох юм гэж ингэж ойлгож байгаа.

2 дахь нь удаа дараа гэж. Ер нь бол ажлаа удаа дараа таслах энэ тэр гээд Хөдөлмөрийн хууль дээр бол удаа дараа таслах энэ тэр гэж бараг ойлголт байхгүй шахуу юм байна лээ. Харин шүүхийн юм дээр байлаа гээд ингээд тал талаасаа ярилцсан юм. Тэгэхээр ийм алдааг удаа дараа зөрчсөн үйлдэл эс үйлдэхгүйг гаргах гээд. Ийм ноцтой удаа дараа гэдэг 2 юм дээр нь бол одоо бид ач холбогдол өгөөд энэ бол мэргэжлийн алдаа гэж хэлэхэд бол хэцүү юм. Сахилгын зөрчил гэж үзэхээс аргагүй юм гэдэг л ойлголтод хүрсэн. Тэрнээс биш бид шүүгчдээ хэлмэгдүүлье гэсэн байдлаар бол тэр ажлын дэд хэсэгт орсон улсууд нэг ч одоо яриагүй байх гэж би бол ойлгож байгаа. 2 дахь нь тэр зайлшгүй шаардлагатай заах ёстой үндэслэлийг огт бичээгүй гээд. Тэр нь дээд шатны шүүхээр тогтоогдсон.

Тэгэхээр огт гэж үг байгаад байгаа юм. Тэрийг бас манай гишүүд бас нэг ойлгуулъя. Огт бичээгүй бол нээрээ бас бичиж таараа шүү дээ ер нь бол. Огт бичээгүй юм байх юм бол энийг бол мэргэжлийн алдаа гэж хэлэх ямар ч арга байхгүй. Ямар ч энгийн ухамсрын түвшинд хэн ч уншлаа гэсэн энэ чинь огт бичээгүй тийм шүүхийн шийдвэр гэж ер нь хаашаа харсан юм байх юм бэ? Тийм учраас энийг бол алдаа биш энэ бол санаатай эсхүл хэт хайхрамжгүй хэт хариуцлагагүй сахилгын зөрчил гэж үзэхээс аргагүй юм гээд ингээд хүлээн зөвшөөрөөд оруулаад ирсэн.

2 дахь гал хамгаалалтуудыг бол хийж өгсөн. Өөрөөр хэлбэл одоо бид бол сүүлийн хэдэн жил бол их том хийдэл гаргалаа. Энийгээ хүлээн зөвшөөрөхөөс өөр арга алга. Норматив тайлбар гаргахаа байсан. Үндсэн хуулиас бусад хуулийг Улсын дээд шүүх албан ёсны тайлбар гаргана гэдэг Үндсэн хуулийн заалт байсаар байтал ерөөсөө тогтоолоор тайлбарлахаа байсан. Ийм учраас энэ заалтыг нээж өгснөөрөө одоо ингээд Улсын дээд шүүхийн тогтоолууд гарч жишээ нь энэ 52.1.23 ноцтой гэж энийг ийм зүйлийг ойлгоно. Удаа дараа зөрчсөн үйлдэл эс үйлдэхүй гэж ийм зүйлийг ойлгоно. Огт бичээгүй гэдгийг ийм зүйлийг ойлгоно гээд энэ одоо хуулийг бол тайлбарлах боломж нээгдэж байгаа юм.

2 дугаарт энэ асуудлуудаар бид бүхэн бол юу л даа. Энэ тийм юм гарахгүй болов уу гэж бид найдаж байгаа юм. Энэ чинь ер нь бид одоо ер нь шүүгч хүн тэгээд тэр болзол шалгуурыг даваад сонгон шалгаруулалт одоо ирсэн шүүгч хүн үндэслэлээ бичихгүй байна гэж одоо байна гэж одоо юу байх вэ. Тэгэхээр хуулийг хийхдээ бид муугаар бодож хийгээд сайнаар үйл явдал нь яваасай гэж бодож хийдэг учраас тийм юм гарахгүй байлаа ч гэсэн энэ дотор байхад бол болох юм гэж ингэж бол бодож байгаа юм.

3 дугаарт сонголттой. Нээлттэй, хаалттай сануулах мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтад суулгах тэгээд одоо шүүгчээс огцруулах хүртэл арга хэмжээ авах нь бол тийм үү сонголттой заалтуудыг бол энэ харин 40 юм дээр яг онож уу үгүй юу гэдгийг бол манай гишүүд тал талаас нь сайн анхаарч үзээсэй билээ гэж ингэж бодож байгаа юм. Сахилгын хороог бол одоо шүүх болно гэж. Ер нь бол Германд бол шүүхийн асуудлыг хариуцсан яг энэ мэргэжлийн алдаа сахилгын зөрчлүүд дээр ажилладаг шүүх байж байгаа тусдаа шүүх. Энэ бол сахилгын хороог бол орон тооны тэгээд дээр нь бол шүүгчдээс бүрдсэн хууль зүйн өндөр мэргэжилтэй тийм хуульчдаас бүрдсэн орон тооны байгууллага ажиллана.

Тийм учраас эд нар бол улс төрийн захиалгаар ажиллах ёс байхгүй. Ийм учраас тэр 75 дугаар зүйл дээр шүүн таслах үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдох асуудлыг эрүүгийн хуулиар зааж зохицуулсан заалтыг бол хийж өгөх саналууд бол манай гишүүд яриад явж байна лээ. Энийгээ бол хийгээд өгөх нь зөв байх. Дээр нь бол одоо бид бүхэн бол энэ мэргэжлийн хорооны асуудал яриад байгаа юм. Тэгэхээр сонгуулийн шүүхийн ерөнхий зөвлөл нь орон тооны, сахилгын хороо нь орон тооны, дандаа хуульчдаас бүрдсэн тийм үү шүүгч болон хуульчдаас бүрдсэн энэ байгууллагууд бол яг энэ дээрээ бол ажиллахад бол заавал мэргэжлийн хороо гээд бас нэг давхардсан байгууллага гараад ирэх нь бол зохимжгүй байна гэсэн ийм үндэслэлүүдээр яригдсан учраас бид бүхэн бол ингээд урагшаагаа явбал яасан юм бэ.

Ер нь бол байна шүү дээ бас ч манай зарим шүүгчид арайч дээ л байгаа шүү дээ. Бид бүхэн олон түмэн бол энэ шүүх нь олигтой ажиллаад.../минут дуусав/

С.Бямбацогт: Цаг сунгая. Бараг хэлчихлээ.

Д.Лүндээжанцан: Хэлчихлээ энийгээ бол дэмжээд явъя. Найруулгын хувьд. Тэгээд 1 дүгээр хэлэлцүүлэг яагаад гэхээр энд шууд хасчих юм бол нөгөө Их Хурлын

нэгдсэн хуралдаан дээр яригдаад нээлттэй үлдэх нь бол одоо бас хүндрэл учрах юм. Ийм учраас 2 дугаар эцсийн хэлэлцүүлэг, 1 дүгээр хэлэлцүүлэг, 2 дугаар хэлэлцүүлгийн хооронд бид зай аваад тэгээд найруулж дахин ажиллах бололцоог хангая. Тэр болтол бодоцгооё. Шүүгчдээ хэлмэгдүүлж шүүгчдээ ажиллах урам зоригийг нь хугалж шүүгчийнхээ ажиллах нөхцөлийг боогдуулах талаар бол энд сууж байгаа нэг ч хүн бодоогүй байх гэж бодож байна. Хамгийн гол нь хүний эрхийг хамгаалдаг шударга ёсны баталгаа болсон шүүх дээр энэ мэргэжлийн алдаа ч гэсэн бага гарч, дээр нь сахилгын зөрчлөөс зөрчлүүдийг нарийн зааж өгснөөрөө харин тэдэнд бол одоо тэднийгээ хамгаалах урьдчилан сэргийлэх нэг гол нөхцөл болно гэж ингэж ойлгож байгаа юм. Ийм учраас энийг бол хүмүүс ойлгож манай шүүгчид ч гэсэн хүлээж авах болов уу гэж би бол ойлгож байгаа.

С.Бямбацогт: Их Хурлын даргын ахлах зөвлөхөд баярлалаа. Одоо ярьсан даа. Сая шийдэл гарчихлаа шүү дээ. Саналаа тайлбарлаж бас ярих эрхтэй. Нямбаатар гишүүн 1 минутад саналаа тайлбарлая.

Х.Нямбаатар: Сая Лүндээжанцан дарга бол шийдэл хэлсэнгүй. Бид нар хэдүүлээ нэг ийм юм дээр зөвшилцөлд хүрээд цаашаагаа явчихмаар байна. Жишээлбэл 52.1.23 дээр хуулийн илтэд тодорхой заалтыг ноцтой зөрчсөн гээд ингээд найруулаад явчихвал цаашаа явъя.

С.Бямбацогт: Яг тэгье. Яг тэгж хэлсэн тийм.

Х.Нямбаатар: 2 дахь нь 52.1.27 дээр шүүхийн шийдвэрт үндэслэл огт бичээгүй гээд. Ингээд явъя. Зайлшгүй шаардлагатай гэж юуг хэлэх юм бэ? 2, 3 зүйл ангитай нөхрийн 2 зүйлээр нь зүйлчлээд 1-нь зүйлчлээгүй гэдэг нь давахын шүүхээр тогтоогдвол энэ чинь аль нэг зайлшгүй шаардлагатай үндэслэлийг нь бичээгүй байна гээд л эргээд. Үгүй ээ үгүй зайлшгүй шаардлагатай гэдгээ хэлэх гээд байна шүү дээ. Хэд хэдэн үндэслэлүүд байя гэж бодъё. Тэр нь та Лүндээжанцан ах дундуур нь орж ирж бүр.../минут дуусав/

С.Бямбацогт: Одоо би саналын томъёоллыг уншаад танилцуулъя. Сая бол ерөнхийдөө Нямбаатар гишүүний гарч байгаа санал Лүндээжанцан зөвлөхийн бас хэлсэн санал үндсэндээ бол агуулгын хувьд нэг байна. Одоо би томъёоллыг та бүхэнд уншаад танилцуулъя. Өөр сайжруулах шаардлагатай бол 2 дахь хэлэлцүүлгийн явцад сайжруулж болно. Ингээд 52.1.23.хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах; санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Маргаангүй л хасаж байгаа юм. Дахиад бас ярилцъя. Ямар ч байсан ингээд явж байя. Чуулганы хуралдаанд орохоос өмнө бас манайхан дахиад нэг сайн ярилцаарай. Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 73,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

52.1.27.шүүхийн шийдвэрт үндэслэл огт бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон; Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 66,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Мэргэлцсэн, тал талаасаа ярилцсаны үр дүн гарч байна. Баярлалаа гишүүддээ. Гацаанаас гарчихлаа шүү. Одоо ямар санал байгаа билээ гишүүдээс байхгүй тийм ээ.

Одоо 53 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. 53 дугаар зүйл дээр ажлын хэсгээс санал гараагүй. Гишүүдээс бас бичгээр санал гараагүй биз дээ гараагүй байна.

Хуулийн төслийн 54 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Алга байна. 54. 54 дээр ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гаргасан байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 54.Төслийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Хуулийн төслийн 55 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гараагүй байна. Цаашаа явъя. Бичгээр бас санал гараагүй гишүүдээс. 56 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. 56 дээр алга байна. 56 дээр асуулт байна. Саналаа хэлэх юм уу? Санал гаргасан юм уу. Санал хураалт явуулъя. Ажлын хэсгээс 56 чинь 40 үү. Ажлын хэсгийн гаргасан саналаар санал хураалт явуулъя.

40.Төслийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 56.1, 56.2 дахь хэсэг болгож, 56.2 дахь хэсгийн “алдаа” гэсний өмнө “мэргэжлийн үйл ажиллагааны” гэж нэмж, 56.3 дахь хэсгийг хасаж, 57.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 58 дугаар зүйлийг хасах:

“56.1.Шүүгч зөвхөн хуульд захирагдах бөгөөд зөрчсөн бол хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

56.2.Шүүгчид зөвхөн энэ хуульд заасан үндэслэл, журмаар сахилгын шийтгэл оногдуулна.” Болж байгаа юу тийм ээ.

57.1.Шүүхийн сахилгын хороо энэ хуулийн 52, 53.1, 54, 55 дугаар зүйлд заасан хориглосон, хязгаарласан, үүрэг болгосон зохицуулалтыг зөрчсөн /цаашид “сахилгын зөрчил” гэх/ шүүгчид сахилгын шийтгэл оногдуулна.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Энийг хураасны дараа ажлын хэсэг. Гишүүд тусдаа бичгээр санал гаргана шүү дээ тийм ээ. 57 чинь хамт явчих шиг боллоо тийм ээ. Санал хураалтад 15 гишүүн оролцож 12 гишүүн буюу 80 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. 57 дээр биш юм байна тийм ээ.

56 дугаар хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд бичгээр санал гаргасан байна. Энэ 2 саналыг хэрэггүй юм шиг байна тийм ээ. Пүрэвдорж гишүүн шүүхийн тухай хуулийн төсөлд 56.4 дэх заалт нэмэх.

Улсын дээд шүүхийн шүүгч, дээд шүүхийн ерөнхий шүүгчийг Үндсэн хуулийн суурь зарчим иргэний үндсэн эрхтэй зөрчилдсөн үйл ажиллагаа явуулсан, хууль мэргэжлийн ёс зүйгээ зөрчиж шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулсан гэх үндэслэлээр Улсын Их Хуралд импичмент хийж албан тушаалаас нь чөлөөлөх шийдвэр гаргасан бол огцорсонд тооцно. Санал гаргасан Их Хурлын гишүүн Пүрэвдорж. Пүрэвдорж гишүүн саналаа тайлбарлаж үг хэлье.

Б.Пүрэвдорж: Бид нар нэг талаараа бас ингээд шүүгч нараа томилж байгаа юм. Тэгээд хариуцлага тооцдог юм нь болохоор дахиад шүүх дээрээ очоод шүүхээсээ шүүгч нараасаа бүрдсэн тэр хэсэг дээрээ очиж байгаа. Тэгээд ер нь бол улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч ер нь ялангуяа ерөнхий шүүгч бол энэ хуулиар бол бараг тийм огцрох боломж байхгүй. Яагаад гэвэл нэлээн одоо олон асуудал дээр энд аль болох л одоо тэр хариуцлагаас зайлсхийсэн ийм заалтууд энэ дээр орсон байж байгаа. Тэгэхээр ер нь бол бид нар нөгөө талдаа энэ нөгөө гараараа бид нар энэ шүүгч нарт хариуцлага тооцдог ийм системийг бүрдүүлэх нь хамгийн чухал байгаа юм.

Тэгээд би түрүүн хэлсэн. Өөрөөр хэлбэл яг нөгөө Үндсэн хуулийн зөрчсөн иргэний эрхийг Үндсэн хуулийг зөрчиж иргэний эрхийг одоо зөрчсөн тийм шүүхийн шийдвэр гаргасан тохиолдолд одоо Үндсэн хуулийн цэц дээд шүүхийн шүүгч болон Ерөнхий шүүгчид хариуцлага тооцох тухай асуудлыг тавьсан. Харамсалтай нь одоо санал хураалгасангүй. Тэгэхээр ер нь бол шүүгч нар бол урд нь юу яадаг юм Ерөнхийлөгч гээд ганцхан даргатай тэндээ одоо бүх тэрнийхээ дагуу явдаг гэдэг л ийм л яриа ард олон дотор байдаг. Тийм учраас ер нь бол сахилгын хороо гэдэг нэг хариуцлага тооцох ганцхан байгууллагатай. Тэгэхээр энийг аль болох одоо юу яадаг юм импичмент тооцож Улсын Их Хурал дээр асуудал шийдвэрлэх энэ заалтыг оруулж ирье гэж байгаа юм.

Ер нь бол Монгол Улсад бол импичмент тооцох энэ асуудал бол маш бага явагддаг. Өөрөөр хэлбэл төрийн өндөр албан тушаалтныг эргүүлэн татах хариуцлага тооцох энэ одоо зүйл бол маш бага хүрээнд энэ дэлхий нийтээр хэрэгждэг энэ зүйлийг бол маш бага хүрээнд хэрэгжүүлдэг. Тийм учраас тодорхой хэмжээгээр энэ иргэний эрхийг зөрчсөн ийм шийдвэр гаргасан дээрээс нь шүүхэд итгэх олон нийтийн алдагдуулсан арга хэмжээ явуулсан ийм дээд шүүхийн шүүгч ерөнхий шүүгчид Их Хурал дээр очоод ч бас импичмент тооцож огцруулах хариуцлага тооцох ийм одоо арга хэмжээг энэ хуульд оруулъя гэсэн ийм саналтай байгаа юм.

Тэгэхээр би бол өөрөөр хэлбэл энэ зөвхөн сахилгын хороо гэхээр нэг өөрөөр хэлбэл шүүгч нар дотроо байгаа учраас энд бүрэн дүүрэн тийм хариуцлага тооцох боломж гарахгүй гэж л үзэж байгаа юм. Дээрээс нь Их Хурал дээр импичмент тооцдог болъё. Дээрээс нь цэц дээр яг тэр Үндсэн хуулийн хүний заяагдмал эрх болон бусад зүйлтэй холбоотой Үндсэн хууль зөрчиж шийдвэр гаргасан тэр шүүгч нартаа хариуцлага тооцдог болъё. Тэгээд ийм олон одоо асуудлыг нь шийддэг ийм субъекттэй болчих юм бол энэ ийм олон юмнуудад таалагдах гэж ийм олон

хүмүүсийн үгээр явах гэж явж байснаас ерөөсөө асуудлыг шударгаар шийдвэрлэе гэдэг л ийм л орчин бий болох болно гэж л тооцож энэ Улсын Их Хурал дээр импичмент тооцох энэ саналыг оруулж ирж байгаа. Ингээд та бүхэн дэмжиж санал өгөөрэй гэж хүсэж байна.

С.Бямбацогт: Санал хураалт явах уу ажлын хэсгээс юу байгаа юу. Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Энэ юу л байгаа юм л даа. Санал хураалгахаар Пүрэвдорж гишүүн маань бас ойлгох нь бид нар чинь бол энэ шүүгч нарт бол ерөнхийдөө импич хийдэг журмаа бол шүүхийн сахилгын хороо гэдэг механизмаар л явуулахаар болгоод байгаа шүү дээ. Зүгээр ер нь зүгээр нэг яригдаж байгаа яриа бол байдаг. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг дээр бол Ерөнхийлөгч, Ерөнхий сайд хоёр дээр бид нар бол огцруулах ялангуяа Ерөнхийлөгч дээр бол импичмент хийдэг процесс бол ерөнхийдөө тусгагдсан байгаа. Цаашдаа энэ ерөнхий прокурор дээд шүүхийн ерөнхий шүүгч, тэгээд бусад өөр ганц нэг улсууд байгаа. Авлигатай тэмцэх газрын дарга ч гэдэг юм уу. Энэ дээр бол тусгай зүгээр тийм процедур тогтоох шаардлага бол байгаа байх гэж бодож байгаа юм.

Яг одоо энэ шүүхийн тухай хууль дээр бид шүүхийн сахилгын хороо гээд энэ шүүхэд сахилгыг бий болгохын тулд хариуцлага тооцдог энэ импич хийдэг сахилгын хорооны процедуртай бүхэл бүтэн ийм хэсэг хийсэн юм чинь яг энэтэйгээ бол одоо зөрчилдөх гээд байгаа байхгүй юу. Шүүгчийг бол шүүхийн сахилгын хороо л хариуцна. Улсын Их Хурал дахиад тусдаа дахиад өөрөө импич хийж хариуцлага татдаг. Зүгээр тийм юм хийнэ гэвэл чуулганы хуралдааны дэгийн тухай хууль дээр байж байгаа сахилгын хороо руу шилжүүлдэг. Улсын Их Хурлын одоо магадгүй хяналт шалгалтын ямар нэгэн хороо хууль гаргаад тэгээд эндээ нэг сонсгол маягийн юм хийчхээд түүгээрээ шууд сахилгын хороо руу шилжүүлдэг эд нар юм дараа гарч магадгүй. Тэрнээс яг одоо ингэж хийхэд бол энэ чинь авцалдахгүй л байх гэж бодож байна.

С.Бямбацогт: Цогтбаатар гишүүнээр тасаллаа.

Д.Цогтбаатар: Зүгээр энд нэг ийм юмыг хэдүүлээ бодож үзвэл яах вэ. Энэ чинь Үндсэн хууль дээр тодорхой заасан байгаа шүү дээ. Тэгэхээр одоо энүүгээр санал хураахад чинь бид нар Үндсэн хууль зөрчсөн санал өгөөд өөрсдөө дараа нь Үндсэн хууль зөрчихөөр Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл мөн биз. Энэ чинь акт шүү дээ. Та санал хураалгахад өөрөө Үндсэн хууль зөрчих юм биш биз. Бас наадах чинь таны хувьд акт болоод явна. Нэмээд та өөрөө дэмжсэн кноп дарвал дахиад дараагийн акт болно. Давтан үйлдсэн. Нээрээ шүү.

С.Бямбацогт: Тайлбар ерөнхийдөө сонссон. Түрүүн бол Пүрэвдорж гишүүний санал бол тодорхой яг Үндсэн хуулийн тодорхой зүйл заалтыг зөрчсөн санал хураалгах гэсэн. Тэр бол мэдэж байна. Энэ дээр бол би яг шууд Үндсэн хууль зөрчсөн гэж харахгүй байна. Тэгэхээр одоо гишүүний саналыг хүндэтгээд санал хураалгая. Шүүхийн тухай хуулийн төслийн 56.4-т заалт нэмэх. Улсын дээд шүүхийн шүүгч дээд шүүгчийн ерөнхий шүүгчийн Үндсэн хуулийн суурь зарчим иргэний үндсэн эрхтэй зөрчилдсөн үйл ажиллагаа явуулсан хууль мэргэжлийн ёс зүйгээ зөрчих зөрчиж шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулсан гэх үндэслэлээр Улсын Их Хуралд импичмент хийж албан тушаалаас нь шийдвэр гаргасан бол огцорсонд тооцно. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Бүр тэгвэл дэмжээд саналаа өгье тэгвэл. Санал хураалтад 15 гишүүн оролцож 3 гишүүний буюу 20 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй. Дараагийнх нь 57 тийм ээ.

Төслийн 57 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Мөнхцэцэг гишүүн. Пүрэвдорж гишүүнээ хуралдаа суугаарай. Та ганцаараа эрт харьж болохгүй шүү. Хурал таслахгүй шүү.

Ц.Мөнхцэцэг: Энэ 57 дугаар зүйл маань сахилгын зөрчлийг зааж өгсөн байгаа. Гэтэл энэ түрүүн бид нарын нөгөө 46.10 дээр санал хураасан. Шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй бол түүнийг сахилгын зөрчилд тооцож хариуцлага хүлээлгэнэ гэсэн заалт маань энэ 57.1 дээр ерөөсөө орж ирээгүй байна. Ер нь бол энэ шүүгчийг хараат бус байлгах улс төр болон бусад дарамтаас ангижруулах гол нэг заалт бол нөлөөллийн мэдүүлэг хөтлөх ёстой. 2012 оны шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар бол нөлөөллийн мэдүүлэг хөтлөхийг заасан боловч тухайн одоо хэрэг дээр гэдэг юм уу нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй бол шүүгчид ямар нэг хариуцлага хүлээлгэхээр зааж өгөөгүй учраас яг энэ шүүгчийн ерөнхий зөвлөлд энэ хэдэн шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг. Ер нь одоо шүүгчид хэрэг шийдвэрлэх процесст ямар дарамт нөлөөлөл ирж байгааг мэдэх боломжгүй байгаад байгаа.

Мэргэжлийн судлаачид бол энэ судалгааны дүнгээр ингээд үзэхээр жишээлбэл оюуны инновац төрийн бус байгууллага өнгөрсөн жилийн судалгаанаас ингээд харахаар нийт 275 шүүгчээс 84 шүүгч нь ямар нэгэн байдлаар сүүлийн 3 жилийн хугацаанд хэрэг маргаан шийдвэрлэхэд нөлөөлөл ирсэн гэж хариулсан байгаа. Гэтэл одоо бид нар энэ саяын 46.10 дээр шүүгч бол заавал нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө гэж оруулж байгаа учраас энэ тохиолдолд хэрэв мэдүүлэг хөтлөөгүй бол сахилгын зөрчилд тооцоод 57.1 дээр нэмж оруулахгүй байсан юм уу. Жишээлбэл энэ одоо сахилгын хорооноос нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй гэдэг шалтгаанаар сахилгын шийтгэл ноогдуулахад энэ нөгөө 57.1 дээр энэ заалт чинь байхгүй байгаа учраас асуудалд орох юм биш үү гэдэг ийм асуулт байна ажлын хэсгээс.

С.Бямбацогт: Ажлын хэсэг Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ 57 дугаар зүйлийн гол агуулга бол энэ хуулийн 52, 53.1, 54, 54, 55-д заасан зөрчлийг гаргавал сахилгын шийтгэл ноогдуулна гэдэг тэр ерөнхий заалт нь. Энэ 52-т нь 53.1-т 52, 53.1-т юу байгаа вэ гэхээр нөгөө түрүүн ярьсан нөгөө 46.10 гэж та хэлээд байгаа 46.10 дээр болохоор 46.8 үүргээ биелүүлээгүй нь шүүгчид сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно гээд 46.8 дээр нөгөө албан тушаалтнуудтай уулзсан тохиолдолд протоколоо өгөхгүй бичээгүй уулзах юм бол гэдэг асуудал нь орж байгаа учраас ингэж уулзаагүй бол сахилгын шийтгэл ноогдуулна гэдэг агуулга бол үлдэж байгаа юм. Тийм хийсэн. 52.1.39-г та хараарай. 52.1.39.

Сая бид дөнгөж сая санал хураасан. Тэрэн дээрээ болохоор 46.8-ыгаа хэлээд өгчхөж байгаа юм. Харин нөлөөллийн мэдүүлэг бөглөөгүйн тухайд манай ажлын хэсгүүдээс хэд байна вэ би энийг манай ажлын хэсгээс нэмж хариулах хүн байна уу? Нөлөөллийн мэдүүлэг гээд сая Мөнхцэцэг гишүүний хэлээд байгаа. 45.2 байна уу. 45.2-г тийм байна. Нөлөөллийн мэдүүлэг гэдэг дээр сая Мөнхцэцэг гишүүний хэлсэнчлэн энэ 45.2-г бол харин эшлээгүй байж байна. Өөрөөр хэлбэл энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцогдохгүй болчих юм биш үү гэсэн Мөнхцэцэг гишүүний санал үндэслэлтэй байгаад байна л даа.

Тийм учраас 45.2-ыгоо 57.1 дээрээ эшлээд энэ хуулийн 45.2 гээд явчихвал тэгээд 52, 53.1 гээд явчихвал Мөнхцэцэг гишүүний сая хөндсөн энэ асуудал бол шийдэгдчих юм байна. Нөлөөллийн мэдүүлэг. 46.1 байна. Гэхдээ энэ дээр Цогт шүүгч шүүгчдэд бас нэг тайлбар хэлэх үү үгүй юу. Энэ нөлөөллийн мэдүүлэг гэдэг дээр бас сахилгын шийтгэл ноогдуулах үндэслэл бас болж байна уу гэдэг дээр энэ Цогт шүүгчийн тайлбарыг нэг сонсох хэрэгтэй байна.

С.Бямбацогт: 45.2, 46.1 чинь өөрөө шүүгчээ хамгаалсан тийм зохицуулалт заалт л байгаад байх шиг байна. Тэгж байхад шүүгчтэй хариуцлага тооцох сахилгын шийтгэл оногдуулахаар оруулах гээд байгаа чинь зөв юм уу. Цогт шүүгч. 1 дүгээр микрофон.

Ц.Цогт: Асуултад хариулъя. Тэгэхээр шүүгчид энэ нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй үйлдэл нь өөрөө шууд сахилгын шийтгэл ноогдуулах ийм үндэслэл болох бол жаахан эргэлзээтэй байгаа. Яагаад гэхээр нөгөө нөлөөлөх тийм оролдлого хийлээ гэхэд тэрийг яг шүүгч маань өөрөө нөлөөлөх оролдлого тэр 1 дүгээрт тэр орлогод автсан уу үгүй юу гэдэг асуудал байгаа. Автаагүй байгаа тохиолдолд зөвхөн юу тэр нөлөөлөх оролдлого ирсэн гэдгийг мэдүүлээгүйн төлөө сахилгын шийтгэл ноогдуулах гэж байгаа бол тэр шийтгэлийн төрөл хэлбэр энэ тэр дээр их сайн анхаарахгүй бол энэ чинь өөрөөс нь үйлдэлтэй биш цаад хүнээс ирж байгаа үйлдэлд намайг буруутгах бас нэг үндэслэл болох гээд байна л даа. Тийм учраас энэ дээр жаахан болгоомжтой хандахгүй бол болохгүй болов уу гэж бодож байна.

С.Бямбацогт: Мөнхцэцэг гишүүн тодруулъя.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ саяын Цогт шүүгчийн хэлж байгаатай бол санал нийлэхгүй байна л даа. Бид нар энэ 46.8 болон 46.10 дээр ийм заалт оруулсан шүү дээ. Нийтийн албанд шүүгч энэ хуулийн 46.1-д заасан нөлөөллийн мэдүүлгээс гадна гээд тэрийгээ 46.10 дээр энэ хуулийн 46.8-д заасан үүргээ биелүүлээгүй нь шүүгчид сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно гэсэн байгаа. Тэгэхээр шүүгчийн нөлөөллийн мэдүүлгээ өгөөгүй маань шийтгэл хүлээх үндэслэл болно гэсэн энэ 46.10 дугаар заалтаа бид нар хаяж болохгүй шүү дээ. Тэгэхээр энэ 45.2-оор орох нь зөв байх.

С.Бямбацогт: 52.1.39 дээр сая Нямбаатар гишүүний хэлж байгаа орсон юм байна 46.8-д заасан үүргээ биелүүлээгүй бол гээд. Хориглох заалт тийм, хураасан байна. Тэгэхээр ойлгомжтой болчихлоо, тийм ээ одоо. Цаашаа явъя.

58 дугаар зүйлтэй холбогдуулан, энэ дээр санал 57-оор хураасан. 58 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Энх-Амгалан гишүүн асуулт асууя. Энх-Амгалан гишүүнээр тасаллаа.

Б.Энх-Амгалан: Энэ 58 дугаар зүйлийг хөндөлгүй орхисон байна. Тэгэхээр бүр хасаад санал хураасан юм уу? Тэгвэл ямар ч асуудал байхгүй юм байна тийм ээ. Ерөөсөө ор тас байхгүй юм байна тийм ээ. За.

С.Бямбацогт: Ажлын хэсэг санал гаргаагүй байна. 59 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

41.Төслийн 59 дүгээр зүйлийн 59.1.3, 59.1.4, 59.6.1 дэх заалтуудыг доор дурдсанаар, мөн зүйлийн 59.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 59.2-59.5 дахь хэсэг болгож, 59.4 дэх хэсгийг хасах:

“59.1.3.цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах;

59.1.4.шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах;”

“59.6.1.энэ хуулийн 59.1.1, 59.1.2-т заасан шийтгэл оногдуулах зөрчлийг 10-аас дээш удаа, эсхүл энэ хуулийн 59.1.3, 59.1.4-т заасан шийтгэл оногдуулах зөрчлийг таваас дээш удаа гаргаж сахилгын шийтгэл хүлээсэн;”

“59.2.Энэ хуулийн 59.1.5-д зааснаас бусад шийтгэл оногдуулах сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш нэг жил, зөрчил гаргаснаас хойш хоёр жил өнгөрсөн бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулж болохгүй.

59.3.Энэ хуулийн 59.1.5-д заасан шийтгэл оногдуулах сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш хоёр жил, зөрчил гаргаснаас хойш таван жил өнгөрсөн бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулж болохгүй.

59.4.Шүүгчид сахилгын хэрэг үүсгэснээр энэ хуулийн 59.2, 59.3-т заасан хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсооно.

59.5.Энэ хуулийн 59.1.4-т заасан шийтгэл оногдуулсан шүүгчид сургалтад суух хугацаанд албан тушаалын цалинг 50 хувиар тооцож олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалт. Тэгье. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 12 гишүүний саналаар буюу 85,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Ундрах гишүүн дээд шүүхийн шүүгч. 59, 60 хоёр дээр тодорхой бас.

Б.Ундрах: Энэ дээр хоёрхон зүйлийг л хэлэх гэсэн юм. Хариуцлагатай холбоотой. Тэгэхээр сахилгын хариуцлага ноогдуулах нэг үндэслэл нь болохоор түдгэлзүүлээд сургалтад суулгах ийм үндэслэл байгаа. Тэрэнтэй холбоотой цалингийн 50 хувь гээд. Тэгээд сахилгын нэг зөрчилд нэг хариуцлага ноогдуулна. Тэгэхэд энд бол сахилгын нэг зөрчилд 3 хариуцлага ноогдуулж байна нэг дор гэж харж байгаа. 1 дүгээрт түдгэлзүүлэх юм байна. 2 дугаарт сургалтад суулгах юм байна. 3 дугаарт цалингийн 50 хувь өгөх юм байна гээд. Тэгж ойлгогдож байгаа.

Тэгэхээр үнэхээр сургалтад суулган зайлшгүй шаардлагатай гэж үзэж байгаа бол түдгэлзүүлэх зайлшгүй ямар шаардлага байгаа юм бэ гэж харж байна. Тэгэхээр нэг зөрчилд 2 хариуцлага ноогдуулахгүй гэдэг талаас нь авч үзэхийг ямар вэ гэдгийг 1 дүгээрт энийг хармаар байна. 2 дугаарт тэр хөөн хэлэлцэх хугацаатай хөөн хэлэлцэх хугацаа хариуцлага ноогдуулах хугацаатай холбоотой. Хариуцлага ноогдуулах хугацаа нь болохоор 1 зөрчилд сонголт байгаа. Нээлттэй сануулах, хаалттай сануулах цалин хасах заримд нь огцруулах гээд хамт орсон. Тэгэхээр хугацаанаасаа хамаараад хэрэв тэр заасан хугацаа нь өнгөрчихвөл огцруулахаас өөр сонголт байхгүй хугацаа л үлдэж байгаа.

Тэгэхээр энийг бид нар харгалзаж яг нөгөө хариуцлагынхаа хэлбэрээс нь хамаараад хугацаа тоолох нь зөв үү гэдэг талаас нь харах нь зөв байх гэж ийм санал хэлмээр байна.

С.Бямбацогт: Саяын бас Ундрах шүүгчийн хэлж байгаа саналыг бас анхаарах ёстой байх. 1 зөрчилд 3 дахин 3 удаа. Ажлын хэсэг Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Би жаахан харамсаж байна. Ийм тайлбар хэлж байгаад. Яагаад түдгэлзүүлж сургалтад суухыг даалгаад байгаа вэ гэхээр энэ чинь нөгөө алдаа гаргаад байгаа, санаатай санамсаргүй алдааг ингээд байнга гаргаад байна шүү дээ. Тэгэхээр байнга гаргаад байгаа учраас энэ хүнийг чинь тухайд үнэхээр одоо

мэргэжил ур чадвар нь болохоо больчхоод байгаа юм уу энэ ер нь цаашдаа яг шүүгчээр нь бас ажиллуулж болохгүй байгаад байгаа байхгүй юу. Тэр бүрэн эрхийг нь хэрэгжүүлэхэд аягүй төвөг учраад байна шүү дээ. Байнга гаргаад байна.

Тэгэнгүүт сургалтад суухыг даалгая гэхээр энэ хариуцлага биш шагнал болж байгаа юм. Цалингаа аваад сургалтад суугаад. Бүр амар энэ чинь нөгөө цалин хассаны дараах шийтгэл шүү дээ. Цалинг 6 сараар 20 хүртэл хувиар бууруулах шийтгэлийн дараагийн шатны чангарч байгаа шийтгэл байхгүй юу. Тэгэхээр энийг чинь зүгээр сургалтад суулгахыг даалгана гэж байхгүй шүү дээ. Тэр ажлыг нь энд хийж болохгүй түдгэлзүүлээд тэгээд 3 сарын хугацаагаар суулгаад тэгээд цалинг нь хасахгүй юм бол энэ чинь бүр жаргасан амьтан болох нь байна шүү дээ. Нөгөө хэд нь бүр нөгөө шийтгэл хүлээсэн шүүгчийн хуваарилагдсан хэргүүдийг өмнөөс нь шийдээд л энэ чинь шийтгэл шүү дээ.

Тэгэхээр тэр цалинг чинь бас нэг 50 хувиар хасах нь зөв биз дээ. Энийг 3 өөр шийтгэлийг нэг дор биччихлээ гэж яаж тайлбарлаж чаддаг юм бол энэ ерөөсөө бүр ойлгомжгүй юм.

С.Бямбацогт: Энэ ч бас анхаарах л ёстой асуудал байна. 59.1.1 дээр хаалттай сануулах, 59.1.2 дээр нээлттэй сануулах тийм үү. Энэ зөрчлийг энэ хоёр зөрчлийг 10 удаа давтсан бол тийм үү 10 удаа давтсан бол энэ чинь үндсэндээ 10 удаа зөрчил гаргаад байхад л энэ зөрчлөө шийтгэл болох нь байна шүү дээ. Дараа нь 59.1.3, 59.1.4 дээр тийм ээ цалингийн хэмжээг 6 хүртэл сараар 20 хувиар бууруулсан бол. Шүүгчийн бүрэн эрхийг 3 сар хугацаагаар түдгэлзүүлж сургалтад суулгахыг даалгасан бол энэ зөрчлийг 5 удаа давтсан бол. Үндсэндээ ингээд эхлээд нээлттэй хаалттай сануулах нь. Тэгээд дараа нь цалингийн 6 сараар 5 удаа хасах нь. Ингээд 15 удаа зөрчил гаргаад байгаа хүнийг чинь бас байж болох л юм байна шүү дээ энэ чинь.

15 удаа зөрчил гарч байгаа, 15 удаа сахилгын шийтгэл оногдуулсан байхад сайжрахгүй хүн дээр бол иймэрхүү шийтгэл бас оногдуулах ёстой л байх. Энэ бол цаашаа явъя. Хуулийн төслийн, энэ дээр гишүүдээс бичгээр санал гараагүй тийм ээ.

Хуулийн төслийн 60 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга бана. Ажлын хэсгийн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 42. Төсөлд доор дурдсан агуулгатай 60 дугаар зүйл нэмэх:

“60 дугаар зүйл.Шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах

60.1.Энэ хуульд заасан сахилгын зөрчил гаргасан шүүгчид дараах сахилгын шийтгэлийг энэ хуулийн 59.5-д заасныг баримтлан оногдуулна:

60.1.1.энэ хуулийн 52.1.5, 52.1.21, 52.1.34, 52.1.35, 52.1.36, 52.1.37, 52.1.38, 52.1.40-д заасан зөрчилд хаалттай сануулах, эсхүл нээлттэй сануулах;

60.1.2.энэ хуулийн 52.1.13, 52.1.14, 52.1.20, 52.1.25, 52.1.29, 52.1.32, 52.1.33, 53.1-д заасан зөрчилд хаалттай сануулах, эсхүл нээлттэй сануулах, эсхүл цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах;

60.1.3.энэ хуулийн 52.1.3, 52.1.4, 52.1.9, 52.1.28-д заасан зөрчилд нээлттэй сануулах, эсхүл цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах;

60.1.4.энэ хуулийн 52.1.18, 52.1.19-д заасан зөрчилд нээлттэй сануулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах;

60.1.5.энэ хуулийн 52.1.22, 52.1.26, 52.1.31-д заасан зөрчилд нээлттэй сануулах, эсхүл цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах;

60.1.6.энэ хуулийн 52.1.15, 52.1.17, 52.1.23, 52.1.30, 55.1-д заасан зөрчилд цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах;

60.1.7.энэ хуулийн 52.1.6, 52.1.10, 52.1.12, 52.1.39, 54.1-д заасан зөрчилд хаалттай сануулах, эсхүл нээлттэй сануулах, эсхүл цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах, эсхүл огцруулах;

60.1.8.энэ хуулийн 52.1.8, 52.1.16, 52.1.24-д заасан зөрчилд цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах, эсхүл огцруулах;

60.1.9.энэ хуулийн 52.1.7, 52.1.11, 52.1.27-д заасан зөрчилд шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах, эсхүл огцруулах;

60.1.10.энэ хуулийн 52.1.1, 52.1.2-д заасан зөрчилд огцруулах.”
Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 92,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Хуулийн төслийн, энэ бичгээр гарсан байхгүй тийм үү 60 дээр. Хуулийн төслийн 61 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух асуулттай гишүүд байна уу? Энх-Амгалан гишүүнээр тасаллаа. Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Энэ 61 дээр иргэдийн төлөөлөгчдөд тавих шаардлага гэж байгаа юм. Энэ шаардлага дээр эрх зүйн чадамжтай 25-60 нас хүртэлх Монгол Улсын иргэн. Тухайн харьяаллын шүүхийн нутаг дэвсгэр дээр байж байгаа оршин суудаг, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй ийм хүн оруулна гэж байна. Тэгээд энэ дээр чинь одоо тэр хүн чинь эрх зүйн яах вэ чадамжтай эрүүл саруул байдаг юм байж. Одоо энэ ямар шүүхэд төлөөлж байгаагаа мэдэхгүй тийм боловсрол муутай хүн орчихвол яах вэ. Энэ дээр боловсролын талаар эрх зүйн боловсролын талаар юу ч заагаагүй байна.

Тэгсэн хэр нь энэ 68.3.1 дээр шүүх хуралдааны үеэр тодруулах асуулт тавих замаар нотлох баримт шинжлэхэд оролцох, 68.3.2 дээр байгаа шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр шүүгдэгч зохих хэргийн оролцогч тэдгээрийн төлөөлөгч өмгөөлөгч прокурор гэрч шинжээчид асуулт тавих, хэргийн баримтад үнэлэлт дүгнэлт өгч шүүгдвэл зохигчийн гэм буруутай эсэх талаар бичгээр дүгнэлт гаргах хэрэгтэй. Тэгээд тэрнийгээ буцаагаад аваачаад энэ юун дээрээ хаагаад хаяж байгаа байхгүй юу. Ур тал дээр нь байж байна. Энэ нөгөө нотлох баримт цуглуулахыг хориглоно гээд. Хэргийнхээ материалтай танилцаагүй нотлох баримтаа цуглуулаагүй энэ хүн чинь ямар юмаараа дүгнэлт гаргаж ямар юмныхаа асуултыг асууж ямар юмныхаа хэрэг шүүхэд оролцох ю бэ.

Тэгээд эрх зүйн боловсролгүй бол тэр хүн чинь юугаа асуух юм бэ? Юу шүүж байгааг нь яаж байгааг нь мэдэхгүй бол. Энийг нэг тайлбарлаж өгөөч. Энэ чинь нэг тий сонин заалт ороод байна л даа.

С.Бямбацогт: Нямбаатар сайд хариулах уу. Энэ хэд вэ, 4 Сайнзориг дарга.

П.Сайнзориг: Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Энэ бол Монгол Улсын Үндсэн хуульд заасан анхан шатны шүүх хэрэг маргааныг хамтын журмаар шийдвэрлэж байгаа тохиолдолд иргэдийн төлөөлөгчдийн хуралд төлөөлөгчөөр оролцуулахаар заасан байж байгаа. Үндсэн хууль ер нь явж ирсэн хуулиудаар яг энэ оролцох иргэн дээр боловсролын байдал бол тавьдаггүй. Энэ өөрөө эргээд олон нийт шүүхийн үйл ажиллагаа дахь олон нийтийн хяналтыг л одоо хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байдаг. Яг одоо юу гэдэг юм эрх зүйн боловсролтой гэдэг юм уу заавал дээд боловсролтой хүн оролцох шаардлагагүй ийм байдалтайгаар явж ирсэн.

Ер нь бусад орны олон улсын жишиг дээр ч ийм байдаг. Энэ бол тухайн шүүхийн үйл ажиллагаан дахь тэр дундаж иргэний оролцоог хангаж бас тодорхой хэмжээний хяналтыг хэрэгжүүлэх энэ бололцоог бүрдүүлж өгч байгаа. 2 дугаарт Монгол Улсын Үндсэн хуулиар ч гэсэн тодорхой одоо юу гэдэг нотлох баримтуудыг мэдээж 3 процесс дээрээ бол харилцан адилгүй. Иргэн дээрээ бол захиргаан дээр ч гэдэг юм уу талууд эсхүл шүүхийн оролцоотойгоор цуглуулж байгаа бол эрүү дээр бол зүгээр эрүүгийн хэрэг дээр бол зөвхөн мөрдөгч прокурор гэдэг юм уу тийм ээ

тодорхой энэ одоо яллах тал болон цагаатгах нотлох баримтуудыг тэгш цуглуулах бололцоотой байж байгаа.

Тэгэхээр энэ тэгээд маань нотлох баримт энэ тэр бол цуглуулаад явахгүй. Байгаа хэргийн материалтай танилцаж шинжээчээс асуулт асууж яг энэ дээр бол тодорхой дүгнэлт өгч энэ дүгнэлт нь бас шүүхийн шийдвэрт тодорхой суулгаж өгөх тусгаж өгөхөөр бас энэ хуулийн зохицуулалт цаашдаа орж байгаа. Мэдээж энэ одоогийн түвшин ч гэсэн яг иргэдийн төлөөлөгчдийн хурал төлөөлөгчөөр оролцох иргэдийн асуудал бол хүнд байгаа юм байна лээ. Бас оролцох иргэн тэр болгон бас олдоггүй. Энэ асуудал нэлээн хүндрэлтэй байдаг. 2 дугаарт мэдээж одоо бас зүгээр та энэ шүүх хуралдаанд ороод суу гэхгүй. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тодорхой хэмжээний сургалт гарын авлага тодорхой удирдаж ч гэдэг юм уу ийм холбогдох мэдээллээр хангаж бас энэ иргэдийг бас шүүх хуралдаанд оролцуулдаг байгаа.

С.Бямбацогт: Энх-Амгалан гишүүн тодруулъя. Гэхдээ нэг ийм юм байна л даа. Нэг талаараа аваачаад шүүх хурал дээр оролцох энэ эрхийг нь ингээд оролцогч түүний өмгөөлөгч төлөөлөгчтэй уулзаж болохгүй хэргийн талаар нотлох баримт цуглуулж болохгүй. Хуралдааны дэг зөрчиж болохгүй гээд нэг баахан ийм хориглох заалт тавьчихаад. Нөгөө тал дээрээ шүүхийн хуралдаанд орохдоо шүүх хуралдааны үед тодруулах асуулт тавих замаар нотлох баримтад шинжлэхэд оролцоно. Шинжээч одоо өмгөөлөгч прокурор энэ тэрт асуулт тавина. Тэгээд буруутай эсэх талаар бичгээр дүгнэлт гаргана гээд ингэхээр чинь тэр хүн одоо яаж энд оролцох юм бэ би ерөөсөө сайн ойлгохгүй юм.

Энэ нэг талаараа бүх эрхийг нь хааж хаячихаад нөгөө талаараа чи ийм юм хий гэхээр чинь тэр хүн чинь яаж хийх юм бэ? Тэгээд дээр нь энд боловсрол харгалзахгүй, эрх зүйн боловсрол энэ тэр хамаагүй гэхээр энд чинь ороод тэр шүүх ажиллагаанд оролцоод асуулт тавиад ингээд явах хүн олдох уу? Учрыг нь олохгүй байгаа хүн зүгээр ингээд харж байгаад нэг зур гэсэн юм дээр зурчихаад гарах юм биш үү. Энэ бол бас жаахан.../минут дуусав/

С.Бямбацогт: Төслийн заалт хөндөгдөөгүй байна. Ажлын хэсэг хариулах уу. Энхбаяр гишүүн ажлын хэсэг.

Б.Энхбаяр: Энх-Амгалан гишүүн нөгөө ажлын хэсгийн хөндөгдөөгүй заалтаас гадна хөндсөн буюу одоо бидэнд дараагийн санал хураах гэж байгаа 43 дахь буюу 68 дугаар зүйлтэй холбоотой холбож асууж байгаа учраас хариулж байгаа юм. Энэ иргэдийн төлөөлөгч гэдэг Үндсэн хуульд бол шүүх таслах үйл ажиллагааг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ гэж байгаа юм. Тэгэхээр шүүхийн шийдвэрийг бол шүүгч л гаргах нь байна. Гэхдээ энэ иргэдийн төлөөлөгч гэдгийг бол амилуулах ёстой. Энэ бол зүгээр нэг хараад сууж байгаад ингээд ангайж байгаад гардаг бол хүн байж болохгүй.

Нэгэнт энэ чинь олон түмний буюу ард түмний нөгөө шүүхэд тавьж байгаа хөндлөнгийн бас нэг хяналт байхгүй юу.

Хөндлөнгийн хяналт тавьж байгаа учраас энэ бас асуулт тавих бас нэг дүгнэлтээ хэлэх тэгээд хамгийн гол нь энэ дээр дараагийн санал дээр хураах нэг зүйл бол нөгөө шүүх чинь шийдвэртээ энэ иргэдийн төлөөлөгчийн бас гаргаж байгаа тэр санал дүгнэлт дээр заавал үнэлэлт дүгнэлт өгнө шүү гэдгийг үүрэгжүүлж өгөх гэж байгаа. Энэ өөрөө бас Монгол Улсын Ерөнхийлөгчөөс бас чуулган дээр хэлсэн энэ ажлын хэсэгт бас тухайлан ирүүлсэн ийм санал байгаа юм. Өөрөөр хэлбэл бас энэ олон нийтийн ард иргэдийн төлөөлөл болж байгаа энэ одоо этгээдийн тэр үүрэг оролцоог бас нэмэгдүүл, энэ хяналтыг бас сайжруул. Энийгээ бас амилуул гэдэг ийм бас саналыг ирүүлсэн юм.

Энэ саналыг бас хүндэтгэж ажлын хэсэг хүлээж аваад бас оруулсан. Тэгээд энэ 68 дугаар зүйл дээр бол яг энэ томъёоллууд нь бол илүү тодорхой дараагийн санал хураах асуудал дээр тусаж байгаа юм.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. 61-тэй холбоотой байсан тийм ээ. Ажлын хэсгээс тодорхой санал гараагүй. Бичгээр санал гараагүй байна. Хуулийн төслийн 62 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Санал хураалт явуулъя. Ажлын хэсэг дээр тухайн зүйл дээр санал гараагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр санал гараагүй байна. Санал хураалт байхгүй. Хуулийн төслийн 64 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Санал хураалт явуулъя. Ажлын хэсэг дээр санал гараагүй байна. Хуулийн төсөлтэй холбоотой бичгээр санал гараагүй.

Хуулийн төслийн 65 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 43.Төслийн 65 дугаар зүйлийн 65.5 дахь хэсгийн “үзэх шалтгаантай” гэснийг “шүүх хуралдаанд оролцох боломжгүй” гэж өөрчилж, 68 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 68.3-68.8 дахь хэсэг нэмэх:

“68.3.Иргэдийн төлөөлөгч хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх анхан шатны шүүхийн хуралдаанд оролцохдоо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

68.3.1.шүүх хуралдааны үед тодруулах асуулт тавих замаар нотлох баримт шинжлэхэд оролцох;

68.3.2.шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр шүүгдэгч, зохигч, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, прокурор, гэрч, шинжээчид асуулт тавих;

68.3.3.хэргийн үйл баримтад үнэлэлт өгч, шүүгдэгч, зохигчийн гэм буруутай эсэх талаар бичгээр дүгнэлт гаргах;

68.3.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

68.4.Иргэдийн төлөөлөгч энэ хуулийн 68.3.3-т заасан дүгнэлтийг бичгээр гаргах боломжгүй бол энэ тухай шүүх хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлж, дүгнэлтийг амаар гаргаж болно.

68.5.Иргэдийн төлөөлөгч энэ хуулийн 68.3.3-т заасан дүгнэлтээ шүүх хуралдаанд уншиж сонсгоно.

68.6.Шүүх бүрэлдэхүүн шийдвэр гаргахдаа иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг харгалзан үзнэ.

68.7.Шүүх бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичиж, уг дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгана.

68.8.Давж заалдах шатны шүүх хуульд заасан тохиолдолд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг харгалзан үзэж, энэ хуулийн 68.7-д заасны дагуу шийдвэртээ тусгана.

68.9.Шүүх бүрэлдэхүүн энэ хуулийн 68.7-д заасныг биелүүлээгүй бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцож 10 гишүүн буюу 71,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ 68 дугаар зүйл дээр бид нар иргэдийн төлөөлөгчийн оролцоог нэг талаасаа амилуулж байгаа тодорхой болгож байгаа юм байна. Тэгээд энэ эцсийн хэлэлцүүлэгт бэлдэхэд энэ санааг хармаар байх юм. 68.6 өөрөө дотроо 2 хэсэгт байхгүй юу. Нэг нь шүүх бүрэлдэхүүн шийдвэр гаргахдаа иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг харгалзан үзнэ гэж байгаа. 2 дахь хэсэг нь дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичиж уг дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэл хэсэгт тодорхой тусгана гээд. Тэгээд 68.8-аараа шүүх бүрэлдэхүүн энэ хуулийн 68.6-д заасныг биелүүлээгүй бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно гээд орчихоор эхний хэсэг нь болохгүй болчихоод байгаа юм.

Шүүх бүрэлдэхүүн шийдвэр гаргахдаа иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг харгалзан үзнэ гэдэг чинь чи дүгнэлтийг харгалзаж үзээгүй байна гэдэг дээр сахилгын шийтгэл гаргах үндэслэл гарч магадгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ 68.8-ыгаа янзлаад 2 өгүүлбэр болгоод иргэдийн төлөөлөгч дүгнэлтээ шийдвэрийг тодорхойлох хэсэгт бичээгүй бол харин сахилгын шийтгэл байж болно. Энэ бол. Тэрнээс биш дүгнэлтийг харгалзаж үзээгүй гэдэг нь бол сахилгын шийтгэл болох үндэслэл болохгүй. Шүүгч өөрөө мэдээд шийдвэрээ л гаргана шүү дээ өөрийнхөө итгэл үнэмшлээр. Тэрийг засчихмаар байна.

С.Бямбацогт: Энэ яг Мөнх-Оргил гишүүний саналаар 2 хэсэг болгоод чуулганы хуралдаанд оруулъя. Одоо хураах юм уу? Шууд засаад томьёолоод яагаарай. Саяын Мөнх-Оргил гишүүний хэлсэн агуулгаар дэмжигдлээ шүү энэ санал. 69 гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна. Хуулийн төслийн 69 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс тухайлсан тухайн зүйл дээр санал гараагүй. Гишүүдээс бичгээр гарах санал байхгүй байна.

Хуулийн төслийн 70 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгийн бэлдсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 44.Төслийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсгийн “шүүгч” гэсний өмнө “шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах,” гэж, 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн “зорилго” гэсний өмнө “, хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах” гэж тус тус нэмж, 72.2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 72.2.3 дахь заалтын “эрх” гэснийг “хараат бус байдлыг хангах” гэж өөрчлөх:

“72.2.1.шүүхийн бие даасан байдлыг хангах,” санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 84,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийнх. Гишүүдээс санал гараагүй тийм ээ. 71 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гараагүй байна. Бичгээр бас гишүүдээс санал гараагүй байна.

72 хуулийн төслийн 72 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсэг дээр тухайн зүйл дээр санал гараагүй байна ажлын хэсгээс. Гишүүдээс бичгээр санал гараагүй байна. 72 дээр. Тийм байна, нэг заалт болгоод хураасан байна.

73 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Нямбаатар гишүүн тасаллаа. Асуулт.

Х.Нямбаатар: Би энд санал гаргасан байгаа. Энд нөгөө шүүгчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх орон сууцны хөтөлбөр гэдэг ийм захиргааны ажилтан бас нэмж орно. Энэ дээр санал хураалгая гээд өгсөн байгаа.

С.Бямбацогт: Эхлээд ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулъя. 45. Төслийн 73 дугаар зүйлийн гарчгийг “Шүүхийн бие даасан байдлыг хангах” гэж, 73.1 дэх хэсгийн “захиргааны удирдлагын” гэснийг “шүүхийн бие даасан байдлыг хангах” гэж, 73.1.1 дэх заалтын “шүүх эрх мэдлийн” гэснийг “шүүхийн бие даасан, шүүхийн хараат бус байдлыг хангах” гэж, 73.1.2 дахь заалтын “Засгийн газар болон Улсын дээд шүүхтэй зөвшилцөн Улсын Их Хуралд” гэснийг “Улсын дээд шүүхтэй зөвшилцөн Засгийн газарт” гэж өөрчилж, 73.1.23 дахь заалтыг 73.2 дахь хэсэг болгон шилжүүлж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 73.1.26, 73.1.27 дахь заалт нэмэх:

“73.1.26.хэргийн хөдөлгөөний удирдлагыг хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацаа, үзүүлэлт, ажиллагаанд байгаа хэргийн насжилт, тодорхой хэргийн хөдөлгөөний талаар хяналт-шинжилгээ хийх болон хуульд заасан бусад аргыг ашиглан хэрэгжүүлэх;

73.1.27.хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт болон шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг тогтоосон журмын дагуу хуваарилсан, томилсон эсэхэд хяналт тавих, улирал бүр нийтэд мэдээлэх, хүсэлт гаргасан этгээдэд уг мэдээллийг гаргаж өгөх; Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 84,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээс санал гарсан байгаа. 73 дугаар зүйл дээр. Нямбаатар гишүүн 73 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 73.1.27 дахь заалт нэмэх. 73.1.27 шүүгч шүүхийн захиргааны ажилтныг орон сууцаар хангах хөтөлбөр баталж хэрэгжүүлэх гэж санал оруулъя гэсэн байна. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулах уу? Саналаа тайлбарлах уу? Тайлбарлахгүй юу. Санал хураалт. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 4 гишүүн буюу 30,8 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийн 74 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. 74 асуулт алга байна. Ажлын хэсгийн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 46.Төслийн 74 дүгээр зүйлийн 74.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 74.1.5 дахь заалтын “болон шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн талаар дүгнэлт гаргах журам, шалгуурыг Мэргэшлийн хороотой хамтран” гэснийг “журам” гэж өөрчлөх:

“74.1.4.шүүгчийг сэлгэн ажиллуулах шийдвэр гаргах;” санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 13 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 92,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Энэ техникийнхэн дэлгэц дээр гаргадаг болгомоор байх юм. Тэнд гарч байгаа юм уу? Яах вэ болно. Гишүүдээс бичгээр гарсан санал байхгүй.

Хуулийн төслийн 75 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явуулъя. 75 дээр. 47.Төслийн 75 дугаар зүйлийн гарчгийн, 75.1 дэх хэсгийн “эрх” гэснийг “хараат бус байдлыг хангах” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 75.2-75.4 дэх хэсэг нэмэх:

“75.2.Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй үйл ажиллагаа явуулсан бол Ерөнхий зөвлөл даруй хуралдаж, Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргуулах саналыг Улсын дээд шүүхэд хүргүүлнэ. Улсын дээд шүүх Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлтээ гаргаж, шийдвэрлүүлнэ.

75.3.Энэ хуулийн 75.2-т зааснаас бусад этгээд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл үйл ажиллагаа явуулсан, шүүгчийн эрх ашгийг зөрчсөн тохиолдолд Ерөнхий зөвлөл даруй хуралдаж, дээрх шийдвэр, үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалахад зайлшгүй шаардлагатай арга хэмжээг хуульд заасны дагуу хүсэлт, гомдол, нэхэмжлэл, мэдэгдэл гаргах зэрэг хэлбэрээр авч хэрэгжүүлнэ.

75.4.Шүүгчийн эрх ашгийг зөрчсөн, хараат бус байдлыг алдагдуулсан талаар шүүгчээс Ерөнхий зөвлөлд хандан гомдол, хүсэлт гаргасан бол уг асуудлаар шүүгчийг төлөөлөн гомдол, нэхэмжлэл гаргах зэргээр холбогдох этгээдэд хандаж хуульд заасан журмын дагуу шийдвэрлүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Шүүгчийн хараат бус байдалтай холбоотой маш чухал заалт орж байна. Гишүүдээс бичгээр гаргах санал байна уу? 75 дээр. Байхгүй юу. Үүнтэй холбоотой бас процессын хууль эрүүгийн хуульд бас тодорхой заалт оруулах шаардлага байгаа юу. Ажлын хэсэг. Энхбаяр гишүүн. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Байнгын хорооны гишүүдээ баярлалаа. Тэгэхээр энэ саяын орж байгаа Байнгын хорооны гишүүдийн дэмжсэн заалт бол ер нь их чухал заалт юм. Яагаад гэхээр 92 оны Үндсэн хуульд шүүхийн ерөнхий зөвлөл нь өөрөө шүүгчийнхээ хараат бус байдал, шүүхийн бие даасан байдлыг хангах үндсэн чиг үүрэгтэй ийм Үндсэн хуулийн байгууллага гэххээд яг энийгээ яаж хамгаалах уу гэдэг талаар ямар ч үүрэгжүүлсэн ийм заалтыг ердийн хуулиар амилуулаагүй байсан. Тэгээд энэтэй холбоотой бас хамгийн гол нь шүүхийн бие даасан байдалд мэдээж жирийн иргэн халдах гэдэг бол нэг асуудал. Яг одоо ийм шийдвэр гаргаж байгаа улс төрийн Үндсэн хуулийн дээд түвшний субъектүүд халдвал яах вэ гэдэг асуудлаа зохицуулаагүй байсан.

Тэгэхээр энэ асуудлаар ийм Үндсэн хууль зөрчсөн буюу хууль дээдлэх ёсыг зөрчсөн үйлдлүүдээ бол цэцээр ингээд шийдэгдэх нь. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн цэцийн хяналтын хүрээ хязгаарт байдаг Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурал Засгийн газрын гишүүн, улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, улсын ерөнхий прокурор гэсэн хүмүүсийн тухайд бол Үндсэн хуулийн цэцээр орж одоо импич болдог, огцордог ийм одоо асуудлыг бол 1 дүгээрт хэлж байна. 2 дугаарт эрүүгийн хууль зөрчсөн буюу шууд шүүн таслах ажиллагаанд оролцоод энэ хэргийг ингэж шийд, тэгж шийд, энийг одоо ялла. Энд ийм ял өг гээд ингээд бүр нэг гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагаа явуулбал энийг шүүн эрүүгийн хуулийн шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг гэдэг дээр бас биежүүлэх ийм бол шаардлага үүсэх байх.

Тийм учраас хуралдаан даргалагчаас одоо энэ санал дэмжигдэж байгаа учраас энийг бас эрүүгийн хууль дээр цаашид тодотгон яг шүүн таслах ажиллагааны гэмт хэрэг дээр бас илүү тодотгох ийм шаардлага үүсэх байх гэж ингэж бодож байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Саяын бид нарын баталсан энэ чухал заалт байна шүү дээ нөгөө 32 дугаар санал хураалтаар батлагдсан 46.8 дээр шүүгч энэ хуулийн 46.1-т заасан нөлөөллийн мэдүүлгээс гадна энэ хуулийн 45.2-т заасан этгээдтэй уулзсан харилцсан бөгөөд энэ нөгөө төрийн улс төрийн нөлөө бүхий албан тушаалтнууд дэд сайд гээд одоо олон албан тушаалтнууд байгаа шүү дээ. Тэд нар уулзаад өөрөө эсхүл бусдаар дамжуулан тухайн шүүгчид аливаа хэлбэрээр нөлөөлсөн нөлөөлөхөөр оролдсон үүрэг чиглэл өгсөн бол энэ талаарх бүхий л мэдээллийг агуулсан тэмдэглэл үйлдэж ерөнхий зөвлөлд битүүмжлэн хүргэнэ гэж байгаа юм. Энэтэй хамт 1 дүгээрт уншигдах ёстой юм байгаа юм.

Энэ одоо энэ бол шүүгч нарт бид нар нэг талаас үүрэг болгоод байгаа байхгүй юу. Ингээд төрийн өндөр албан тушаалтнууд чамайг утасдаад загнаад энэ хэргийг ингэ тэг гээд нөлөөлбөл чи тэр тухайгаа тэр нөлөөллийн мэдүүлгээс гадна яг энэ хүмүүстэй холбогдуулаад тусад нь юугаа гаргаад энэ мэдүүлгээ гаргаад шүүхийн ерөнхий зөвлөлд өг гэж. Гэхдээ энэ дараагийнх нь 46.9 дээр тэрийг нь шүүхийн ерөнхий зөвлөл битүүмжлээд хадгалахаар юм шиг ойлгогдоод байгаа юм. Бас биш шүү. Хадгална гэхдээ энэтэйгээ холбогдуулаад саяын бид нарын баталсан нөгөө заалт байна шүү дээ тэрэнтэй дагуулаад арга хэмжээ авах шаардлагатай байна уу үгүй юу гэдгээ шийдээд арга хэмжээ авах шаардлагатай юм байна гэвэл дээд шүүхдээ хандаад цэцэд өргөдөл гаргах тэр процесс нь хамт явж байгаа юм шүү.

Тэгэхгүй бол зүгээр энэ намайг ингээд дарамтлаад байна хэрэг шийд гээд ингээд загнаад байна. Энийг би бичээд өгчихлөө гэхээр нь ерөнхий зөвлөл нь аваад тэрийг нь таг дарчихдаг биш шүү. Тэрийг протоколд тэмдэглүүлээд дараа нь энийг хэрэгжилтийг нь бид нар шаардах хэрэгтэй юм байгаа юм. Энэ бол үндсэндээ шүүгч нарыг бид нар үүрэгжүүлээд байгаа юм шиг мөртөө үндсэндээ шүүгч нараа хамгаалж байгаа заалт. Өөрөөр хэлбэл өнөөдөр шүүгч нар бол юу гэж хэлэх вэ гэвэл уучлаарай та шүүхийн хуулийн 48.6.8 ийм заалт орсон шүү мэдэж байгаа биз. 2-лаа хэрэг ярих юм бол би таны энэ ярьсан хэргийг чинь энэ тухай би протокол үйлдээд ерөнхий зөвлөлд хүргүүлнэ шүү дээ та мэдэж байгаа биз дээ гэж хэлдэг ийм дэгтэй болно гэсэн үг.

Энэ бол Монголд байдаггүй гэхдээ бусад бүх улс орнуудад байдаг Ерөнхийлөгчөө прокурор болон шүүгч нарт. Тэгээд энийг нь бол ерөнхий зөвлөл бүр сургалт явуулаад нарийн журам гаргаад дэгтэй болгож өгмөөр байгаа юм. Тэгээд энэ шүүгч нарыг хамгаалж байгаа их чухал заалт. Энийг бол саяын баталсан нөгөө ерөнхий зөвлөл тэр мэдүүлгийг аваад цаашаа ямар ажил хийх вэ гэдгийг нь баталгаажуулж өгч байгаа юм. Өөрөөр хэлбэл шүүгчийн бие даасан шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус байдлыг баталгаажуулж байгаа нөгөө хамгийн том процесс нь энд явж байгаа юм. Бид нар бол Үндсэн хуулиараа одоо ингээд хараат байна, бие даасан байна гээд л бичээд байдаг. Тэр нь яг яаж байх юм бэ гэдэг нь

одоо болтол байгаагүй юмыг бид нар бол хуулиар нарийвчилж процессжилж өгч байгаа шүү.

Энэ бол төрийн өндөр албан тушаалтнууд энэ нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн нөгөө улс төрийн нөлөө бүхий албан тушаалтнууд гээд одоо тоолох юм бол энэ чинь 400 хэдэн хүн байгаа шүү дээ. Энэ хүмүүст бас өндөр хариуцлага ноогдуулж байгаа шүү гэдгийг ойлгож хэлмээр байгаа юм шүү. Байнгын хорооны дарга энийг нэгдсэн хуралдаан дээр бас тайлбарлаж хэлээрэй. Тийм ээ. Нэг талаас үүрэг, нөгөө талаас бол том хамгаалалт орж ирж байна гэж ойлгох хэрэгтэй.

С.Бямбацогт: Тийм Үндсэн хуулийн 49.1 шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана. 49.2-т Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн төр нам олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан иргэн хэн боловч шүүгчээс шүүх таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй гэсэн ийм заалттай энэ заалт маань одоо амьдрал дээр хэрэгждэггүй байсан. Үүнтэй холбоотойгоор бас ажлын хэсгээс энэ дээр 75.2, 75.3, 75.4 гэсэн заалт оруулж ирж байгаа юм байна.

Сая бол Байнгын хороон дээр дэмжигдлээ. Энэ чуулганы хуралдаан дээр дэмжигдэх юм бол үүнтэй холбоотойгоор бид нар эрүүгийн болон бусад хуулиудад энэ шүүгчийг хараат бус байх шүүгчид хэн нэгэн хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдох энэ үйлдлийг бол бас эрүүгийн хуулийн санкцтай болгох асуудлыг бас ярих гэдэг агуулгаар манай ажлын хэсэг санал гаргаж байна гэж ойлголоо. Энийг чуулган дээр дэмжигдсэний дараа бол Байнгын хороо бас анхаарч үзье. Ажлын хэсэг бас энийг анхааралдаа аваарай гэдгийг бас протоколд тэмдэглүүлье.

Үүнтэй холбоотой 75-тай холбоотой гишүүдээс санал гараагүй тийм үү. Ажлын хэсгийн санал дэмжигдсэн. Хуулийн төслийн 76 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс санал гараагүй байна. Гишүүдээс бичгээр санал гараагүй. Хуулийн төслийн 77 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс энэ зүйл дээр санал, 77 дээр санал алга байна. Гишүүдээс бичгээр санал гараагүй байна.

Хуулийн төслийн 78 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Энх-Амгалан гишүүн, Дэлгэрсайхан гишүүн. Мөнхбаатар гишүүн асуултаа асууя.

Л.Мөнхбаатар: Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн 5-г нь шүүгч нар дотроос, 5-г нь нээлттэйгээр нэр дэвшүүлж томилохоор ийм өөрчлөлт орсон. Энэ зарчмын зөрүүтэй энэ санал дээр бол шүүхийн ерөнхий зөвлөлийн 5 гишүүнийг шүүхийн шатлал тус бүрээс хангахаар ингэж тооцоод

хяналтын шатнаас нэг, давж заалдахаас хоёр, анхан шатнаас хоёр гэсэн ийм төлөөллийг нэр дэвшүүлж сонгохоор оруулж ирсэн байгаад байгаа юм. Гэхдээ энэ бол зөв. Гэхдээ яг үүнийг хэрэгжүүлэх явцад бас уг зарчим алдагдаж магадгүй гэсэн ийм болгоомжлол бол байна. Болгоомжлол байна.

Одоо нийтдээ энэ танилцуулгад дурдсанаар бол 518 шүүгч байгаад ажиллаж байгаа. Эдгээр шүүгчдийн одоо нууц санал хураалтаар нийт шүүгчдийн хуралдаанаас эдгээрийг нууцаар санал хурааж сонгохоор байгаа юм. Ингэхээр энэ бол сонгууль болно. өрсөлдөнө. Тийм ээ, одоо давж заалдахаас гурван хүн ч гэдэг юм уу, таван хүн гэдэг юм уу, дээд шүүхээс хяналтын шатнаас одоо дөрвөн хүн ч гэдэг юм уу, ингээд өрсөлдөх нь байна. Тэгэнгүүт, энэ би энэ шатлал хоорондын энэ хараат бус байдал алдагдах вий гэсэн болгоомжлол байна. Яагаад гэвэл анхан шатны шүүгч нар бол дийлэнх олонх нь дал, наян хувь нь анхан шатны шүүгч нар. Эдгээрийнхээ хэргийг хянадаг, давж заалдахын шүүгч нь одоо анхан шатныхаа шүүгчээс гуйх нь байна шүү дээ. Намайг одоо дэмжээд өгөөч гээд лоббидоно, гуйдаг ийм байдал руу орох нь. Ингэхээр энэ өөрөө шатлал хоорондын ийм, одоо, хараат бус байдалд бол нөлөөлөх вий гэж бодоод байгаа юм. Ийм учраас энэ асуудал дээр бол уг нь тухайн одоо шатныхаа шүүгч нар нь одоо хяналтын шатны шүүгчид нь дотроосоо энэ хоёрыгоо сонгодог, хяналтын шатны шүүгч нь нэг одоо төлөөллөө сонгодог. Анхан шат нь хоёроо сонгодог энэ системээрээ явах нь зүйтэй байх.

Ер нь бол яагаад шатлалтай байгаа юм. Анхан шат, давж заалдах хяналт гэсэн гурван шатлал байгаад байна шүү дээ. Тэгээд энэ гурван шатлалаа ингээд нийтэд нэгдэн нэг тийм том тоонд оруулаад бүгдийг нь бичмээргүй байгаад байгаа юм. Ийм учраас энэ дээрээ бүгдээрээ одоо нэг шийдэл гаргаад явах нь зүйтэй гэсэн бодол байна. Хоёрдугаарт бас нэг анхаарах зүйл бол одоо энэ иргэний хэргийн шүүгч бол хамгийн олон нь байж байгаа шүү дээ. Бас одоо тавь жаран хувь нь иргэний хэргийнх байгаа байх. Гуч, дөч орчим нь гуч гучин хэдэн хувь нь бол нэг эрүүгийнх байх. Захиргааных бол бүр цөөхөн байгаа шүү дээ. Одоо арван тав, зургаан хувь хүрдэг юм уу, үгүй юу. Ингэхээр ер нь иргэний шүүгч нь хамгийн олон санал авч сонгогдох магадлалтай байдаг ч гэдэг юм уу. Ийм олон зүйлүүдийг одоо асуудал үүсгэхээс яаж сэргийлэх вэ? Ялангуяа саяынх бол яах вэ нэг талын нь хоёр дахь үндэслэл нь бол.

Эхнийх нь буюу одоо шатлал хоорондын энэ хараат бус байдал алдагдах байдлаасаа бол сэргийлж, энэ тухай тухайн шатнаас нь шүүгч нарын төлөөллийг нь шүүгчийн төлөөллийг нь одоо шүүхийн ерөнхий зөвлөл сонгох нь зүйтэй гэсэн ийм саналтай байгаа юм. Энэ асуудлыг бол одоо ажлын хэсэг бас хүлээж аваад цаашдаа ингээд зохицуулаад явах нь илүү зохимжтой байх. Тусгайлсан гурван шатлал байгаад байна шүү дээ. Шүүхийн хувьд.

С.Бямбацогт: Санал хэлчихсэн үү? Ажлын хэсэг хариулах уу? За Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Мөнхбаатар гишүүний асуултад хариулъя. Тийм болгоомжлол Мөнхбаатар гишүүний бас яг хэлж байгаа тийм болгоомжлол бас гарч болзошгүй. Ер нь магадлалтай байхгүй юу. Энэ чинь нөгөө таван зуун хэдийн яг санал хураавал дийлэнх нь ер нь тавуулаа анхан шатнаас гарах юм. Яг нэг тоогоороо үзвэл энэ чинь дээд шүүх чинь хорин хэдхэн хүнтэй шүү дээ. Тэгэхээр чинь дээд шүүхээс жишээлбэл нэг ч хүн сонгогдохгүй байх магадлалтай. Нөгөө хүний олноороо гэдэг шиг. Тэгээд нууц санал хурааж байгаа. Тийм учраас нөгөө бүр зориуд тодотгож яг анхан шатнаас бүр хоёр шүү. Давж заалдах шатнаас бүр яг хоёр шүү. Дээд шүүх буюу хяналтын шатнаас бол яг нэг шүү гэдгийг нь одоо зориуд ингэж хуульд бас бичиж өгч байгаа юм. Энэ саналыг бас Ерөнхийлөгч бас санаачилсан хуулийн төсөл дээр бас гаргаж байсан. Өөрөөр хэлбэл яг ийм таны хэлж байгаа яг ийм болгоомжлол бас гарах эрсдэлтэй байна шүү гэдэг агуулгаар энийг бас тодорхой ингэж яг хаанаас хэдэн квоттой байх вэ гэдгийг нь зааж өгөх ёстой шүү гэдэг ийм саналыг гаргасан байгаа юм.

Тийм учраас нэгэнт хууль биччихэж байгаа учраас энэ хуулийг давж бол нэр дэвшүүлж санал хураалтын дүн бол гарахгүй болов уу гэсэн ийм зүгээр бодол бол байгаа. Зүгээр яг энэ хуульд одоо бичиж байгаа бид нар энэ далан наймдугаар зүйл бичиж байгаа энэ журмаас давсан, магадгүй маш тооцоолоогүй бас амьдрал бол баялаг учраас харилцаа гаргахыг бас үгүйсгэхгүй. Хэрэв яг тийм асуудал үүсэх юм бол, өөрөөр хэлбэл энэ хуульд бичигдээгүй, журамд бичигдээгүй ийм асуудал үүсэх юм бол нийт шүүгчдийн хуралдаан өөрөө энэ хуулийн заасан журамд нийцүүлж, дэг гаргаад дэг батлаад тухай тухайн үед нь Жишээлбэл одоо хоёр хүний санал нь тэнцчихвэл яах вэ гэдэг ч асуудал үүсдэг ч юм уу. Ийм тохиолдолд тухайн үед нь дэгээ гаргаад шийдээрэй гэдэг ийм нээлттэй, бас ийм боломжийг бас хуулийн ажлын хэсгээс бас оруулж ирсэн байгаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Мөнхбаатар гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаатар: Яах вэ эх баригч миний хэлээд байгаа санаа бол ойлгож байна. Яг ингээд саяын агуулгаар бичигдсэн зөв. Энийг нь бол бид нар дэмжиж байна шүү дээ. Гэхдээ тухайн шүүгчийн анхан шатны шүүгч тодорхой хэрэг маргааныг одоо шийдвэрлэдэг. Тухайн анхан шатны шүүгчийн хэрэг маргааныг зөв буруу шүүснийг нь шүүдэг давж заалдах болон хяналтын шатны шүүгч нар нь анхан шатныхаа шүүгч нараас санал гуйгаад одоо явах нь байна шүү дээ. Лоббид нь мэдээж сонгууль юм чинь бүх нийтийн санал хураалт болох гээд байна шүү дээ. Сонгууль. Ингэх нь хэр зохимжтой вэ? Энэ нь өөрөө шатлал хоорондын хараат бус байдалд жаахан нөлөөлөх гээд байгаа юм биш үү. Тийм учраас тус тусад л хийчихье л дээ. Одоо давахынх нь анхан шатных нь ингээд тус улсынхаа төлөөллийг гаргаад ирье. Ингээд шүүхийн ерөнхий зөвлөлөө бүрдүүлье л гэж байгаа. Энэ л би логик санаагаа нэхээд байгаа шүү.

С.Бямбацогт: Сүхбаатар гишүүн ажлын хэсгийн гишүүн хариулъя.

Ж.Сүхбаатар: Энэ яах вэ хоёр хандлага л байгаа л даа. Энийг бол яг тэр хяналтын шат нь өөрөө тэндээ хорин хэдүүлээ хуралдаад нэгийгээ, давж заалдах нь одоо хэдүүлээ байдаг юм ингээд тус тусдаа ингээд явж болно. Гэхдээ энэний нэг агуулга нь энэ нийт шүүгчдийн хуралдаан буюу нийт шүүгчдийн төлөөлөл болж шүүхийн ерөнхий зөвлөлд орох гээд байгаа юм. Легитим чанар нь хүлээн зөвшөөрөгдөх. Төлөөллийн шинж чанар байхгүй юу. Тэгэхээр нэгэнт төлөөлөл юм бол давж заалдах ч бай, хяналтын ч бай, анхан шат ч бай нийт шүүгчдийнхээ тэндээсээ эрхээ олж авах ёстой байхгүй юу. Сонгууль ч гэсэн энэ төлөөлөгчид төлөөлж байгаа утгаар. Тэгэхээр энэ утгаараа бол энэ нь бол ингээд зөв. Зүгээр тэр санал хураалтыг зохион байгуулахад бол гайгүй шүү дээ. Анхан шат, хяналтын шатны нэр дэвшигчийг тус тусад нь гаргачхаад л, тэгээд тэнд нь гурван удаа хэсэгт хуваагаад л саналаа хурааж байна.

Тэр хэний Мөнхбаатар гишүүний хэлээд байгаа чинь бол арай хумиад анхан шатны нөлөөнд орохгүй юм биш үү? Ер нь энэ шүүхийн шүүгчид бол нийт шүүгчдийн хуралдаан гэдэг бол нэг институт байхгүй юу. Нэг институт нэгдмэл хүсэл зориг тэр одоо тэр байж байгаа хамт олон. Тэр анхан давж заалдах гэж хуваагдахгүй байхгүй юу дотроо. Шүүгчид бол нэг бүрэлдэхүүн, нэг том хэсэг. Тэгээд энэ дээр ганц энэ бол олон юм руу орж байгаа биш. Нийт шүүгчдийн хуралдааны гол юм нь өөрийгөө одоо бие даасан байдлыг хамгаалдаг, зохицуулдаг, захиргааных нь үйлчилгээг авдаг шүүхийн ерөнхий зөвлөлөө нийт шүүгчид нь хүсэл зоригоо илэрхийлээд ингээд тэр нэг таван хүнийгээ гаргачихъя гэдэг л асуудал байгаа шүү дээ. Энэ утгаараа хийж байгаа.

Түүнээс биш анхан шат нь ингээд ялгараад нөлөөлөх юм биш үү эд нар гэж. Мэдээж олонх анхан шатанд байж байгаа. Ер нь энэ анхан шатнаас чинь л ургаж гарах ёстой шүү дээ бүгд. Анхан шатан дээр байж байна. Давж заалдах ч байна уу, хяналтын шат ч байна уу. Олонх шүүгчдийнхээ хүсэл зориг эрмэлзэл дээр л байх ёстой шүү дээ. Гол юм нь төлөөлөх гэж байгаа юм чинь тэд нарыгаа. Олонх нь л олонхын хүсэл зориг нь тэндээ төлөөлөл нь л тусгагдах ёстой. Тэгэхдээ мэдээж тэр хяналтын шат, давж заалдах, анхан шатанд нь ажиллаж байгаа тэр хүрээллээсээ төлөөлөн ингээд орно. Энэ утгаараа бол би бол энийг бол буруу биш л гэж үзэж байгаа юм. Зүгээр тэр заавал нэг салгаад л анхан шатны хүрээнийх нь хэсэг. Энэ чинь хөдөлгөөнтэй шүү дээ. Анхан шатны нөхдүүд чинь цаашдаа давж заалдах руу орно. Давж заалдахад байгаа нь хяналтын шат руу орж гараад л, ингээд наашаа цаашаа хөдөлгөөнд орж явах ёстой. Ийм л шатны шүүх юм чинь.

С.Бямбацогт: Ерөнхийдөө бол ойлгомжтой болчихлоо шүү дээ. Тийм ээ, нийт шүүхийн нөгөө чуулганаас сонгогдоно. Нийт шүүгчдийнхээ эрх ашгийг хамгаалах

ёстой. Хэрэв тус тусдаа анхнаас тусдаа, давахаас тусдаа хяналтынхаас тусдаа гэх юм бол зөвхөн одоо тэр сонгогдсон төлөөллийнхөө эрх ашгийг хамгаалах ийм болчих юм байна. Тэгэхгүй нийтлэг гэдэг үүднээсээ ажлын хэсэг оруулж ирсэн юм байна гэж ойлгож байна. Одоо Дэлгэрсайхан гишүүн.

Б.Дэлгэрсайхан: Үгүй ээ, би яг л Мөнхбаатар гишүүнтэй гишүүний саналыг давтах гээд байна л даа. Энэ дээд шүүхээс нэг, давж заалдах шатны шүүхээс хоёр гээд ингэчихлээ зэрэг бас энэ нийт анхан шатны шүүхэд ажиллаж байгаа гурван зуун ерэн шүүгч байгаа юм. Энэний бараг тавин хувь нь нэгээс таван жил л ажиллаж байгаа гэж. Гэтэл давж заалдах шатны шүүхээс сонгогдож байгаа хоёр, дээд шүүхээс сонгож байгаа нэг гишүүддээ энэ дээр танихгүй, одоо ба зарим нь ч бараг хөдөөгийн шүүгч нар барааг нь ч хараагүй байгаа. Тийм учраас бол энэ Мөнхбаатар гишүүний хэлж байгаа шиг одоо дээд шүүхийн хорин гурав дотроосоо нэгийг, давж заалдах шатных нь зуун арван гишүүн дотроосоо хоёрыг ч гэдэг юм уу ингэх нь бол арай бас төлөөлөл одоо шат шатныхаа төлөөлөлд илүү одоо ойрхон нийцнэ гэж л үзэж байгаа юм л даа.

Тийм учраас энэ талаар бол бас бичгээр санал гаргасан байгаа. Ингэвэл бас төлөөллийнхөө, төлөөллөөрөө дамжуулж эрхээ бодитой хэрэгжүүлэх ийм боломж бололцоо бүрдэх юм. Тэгэхгүй бол нөгөө бие биеэ хянадаг шүүх шатны байгууллагуудын шүүгч нар ингээд юу бусад төрийн бус байгууллагууд шиг ингээд бас ингээд л шүүгч нарыг гуйгаад л бас нэг ийм лобби маягийн юм хийгээд явах нь бас амьдрал дээр бас жоохон тийм харагдах байх. Энэ чинь бас шүүх шүү дээ гэдэг утгаар энүүгээр одоо бичгээр санал гаргасан. Тэгээд энэ саналын томъёоллоор нь нэг санал хураалгаж өгнө үү л гэж байгаа юм. Баярлалаа.

С.Бямбацогт: Дэлгэрсайхан санал гаргасан байгаа хураалгана. Энх-Амгалан гишүүн асуултаа асууя.

Б.Энх-Амгалан: Би дээрх хоёр гишүүнтэй бол бараг адилдуу саналтай байгаа юм. Тэгэхдээ нэг юмыг бас анзаармаар байна л даа. Ерөнхий зөвлөлийн орон тооны таван гишүүнийг бол одоо ингээд мэргэжлийн шүүгчдээс бүрдүүлэх гэж байна. Тэгээд ингээд мэргэжлийн шүүгчдээс бүрдүүлэхээр энэ ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд бол олонх буюу анхан шатнаас ороод ирдэг энэ анхан шатны шүүгч нар хоёр байх нь хэр одоо зохимжтой вэ? Хяналтын шатнаасаа хоёр, анхан шатнаасаа нэг, одоо тэр давах шатсанаас шатнаасаа хоёр байвал ямар байдаг юм. Яагаад гэвэл тэр дээд шүүхийн шүүгч болох гээд тэр чинь нэлээн их цаг хугацаа, хөдөлмөр, ажлын туршлага гээд л тэр чинь доктор болсон байх ёстой гээд өчнөөн олон шат давж байгаа шүү дээ. Тэр нь ямар ч байсан нэгээс таван жил ажиллаж байгаа анхан шатны шүүхээсээ бол хуруу илүү л байж байгаа байхгүй юу. Тэгэхээр тийм одоо ажлын туршлагатай, чадвартай дадлагатай хүмүүсээсээ ерөнхий зөвлөлдөө мэргэжлийн таван гишүүн л юм бол зөвлөлдөө оруулах үүднээс хяналтын шатны шүүхээсээ хоёр,

анхан шатнаасаа нэг, давж заалдахаасаа хоёр ийм байдлаар оруулж томьёолбол яадаг юм бэ гэсэн л ийм санал байгаа юм.

Яагаад гэхээр одоо сая Дэлгэрсайхан гишүүн хэлж байна. Зуун тавь гаруй анхан шатанд ажиллаж байгаа шүүгчид чинь ихэнх нь л нэгээс таван жил ажилласан, ажлын туршлага багатай хүмүүс байж байдаг. Гэтэл шүүхийн ерөнхий зөвлөл өөрөө бас их томоохон эрхтэй ийм байгууллага байж байдаг. Тийм учраас мэргэшсэн буюу ажлын дадлага туршлага гэдэг талаасаа одоо дээд шүүхээсээ оруулбал яадаг юм бэ л гэсэн энэ саналыг оруулж байгаа юм.

С.Бямбацогт: Мөнхсайхан багш хариулъя хоёрдугаар микрофон.

О.Мөнхсайхан: Баярлалаа. Тэгэхээр саяын гишүүдийн бас санаа зовж байгаа зүйл дээр ойлгож, бас энэ дээр тайлбар хэлье гэж бодож байна. Тийм тэгэхээр нэгдүгээрт бол энэ нийт шүүгчийн хуралдаан буюу чуулган гээд одоо бүтцээр ерөнхий зөвлөл, сахилгын хорооны шүүгч гишүүдийг сонгохоор бид нар бол хорьдугаар зүйл дээрээ шийдчихсэн. Тэгээд энэ маань бол өөрөө Үндсэн хуулийн дөчин есийн тавд бол ерөнхий зөвлөлийн шүүгч гишүүдийг шүүгчид дотроосоо сонгоно гэдэг тэр одоо нэмэлт, өөрчлөлтийн заалтын үзэл санааг бол нарийвчилсан байдлаар орж байгаа.

Өөрөөр хэлбэл анхан, давах, хяналтын шатны шүүгч нар бол тэр албан тушаал дээрээ тухайн чиг үүргээ хэрэгжүүлж байгаа юм. Энэ ерөнхий зөвлөлийн гол одоо ажил бол шүүгчийн хараат бус шүүх, шүүхийн бие даасан байдлыг хамгаалах. Тэгээд энэ функцийг хэрэгжүүлэхэд бол ямар шатанд ажиллаж байгаагаас үл хамаараад шүүгч болгон адил тэгш юм. Шүүгчийнхээ хувьд энд оролцож одоо төлөөллөө гаргаж ирнэ гэдэг утгаар. Тэгээд энэ чинь квотыг маш тодорхой зааж өгч байгаа учраас баланс бол алдагдахгүй. Харин тэр анхан шатны шүүгч энэ шүүгч таван гишүүний хоёрхон нь байгаа юм. Гурав нь бол нэг нь дээд шүүхээс нэг нь давахаас үгүй ээ хоёр нь давахаас гээд олонх нь бол тэр давах хяналтаас гарч ирж байгаа. Ингэхдээ бол тэр нийт шүүгчдээ ерөнхийдөө энэ чухал Үндсэн хуулийн чиг үүргийг хэрэгжүүлэх, нэр хүнддээ итгэл даах уу, үгүй юу гэдэг нь хамгийн гол шалгуур учраас орж ирж байгаа юм гэсэн.

Тэгээд гишүүдийн гаргаж байгаа тэр шат шатнаасаа гаргана гэдэг бол тэр арван хоёр оны шүүхийн захиргааны хууль дээр байдаг одоо ийм зохицуулалт. Тэр хуучин зохицуулалт бол бас ажиллаад төдийлөн бас одоо сайн үр дүн бол гараагүй болсон энэтэй холбоотой. Хоёрдугаарт тэр квот заах дээр бол Үндсэн хуулийн одоо дөчин есийн тавд бол шүүгчид дотроосоо шүүгч таван гишүүнийг сонгоно гэж байгаа юм. За энэ нь бол ямар үзэл баримтлалтай вэ гэдгийг одоо хоёр мянга хорин оны нэг сарын одоо Улсын Их Хурлын хоёрдугаар тогтоол дээр бол энэ хувь тэнцүүлэн гаргаж ирнэ гэдэг зарчмыг зааж өгсөн байгаа юм. Тэрний цаад санаа бо ерөөсөө одоо анхан, давах, хяналт дээр хэдий тооны шүүгч нар байна, тэд нартай пропорцоор

гаргаж ирнэ гэж. Өөрөөр хэлбэл анхан шат, давах шат, давах шатанд бол дийлэнх шүүгч нар байгаа учраас арай олонх нь тэндээс байна. Тэгж байж нөгөө шүүгчдийнхээ төлөөллийг хангана гэдэг тэр зарчмаар бол дээд шүүхээс нэг, давахаас хоёр, анхнаас хоёр гэсэн байдлаар квот бол одоо гарч орж ирж байгаа.

Тэгээд энэ дээр бол одоо шүүх одоо гишүүдийн санаа зовж байгаа энэ асуудлыг тусгаад энэ сонгогдох таван шүүгч тавуулаа шүүгчээр арваас доошгүй жил ажилласан байна гэдгийг бол ажлын хэсгийн Их Хурлын гишүүд бол санал гаргаад энэ дээр тодруулж оруулж ирж байгаа юм. Одоо дөнгөж томилогдсон, туршлага багатай тийм биш. Анхан, давах, хяналтын алинаас нь ч гарч ирж байгаа шүүгч нар бол шүүгчээр доод тал нь арван жил ажилласан байна. Тэгээд энэ одоо олон шүүгчийнхээ итгэлийг даасан ийм ёс зүйтэй, нэр хүндтэй энэ эрхэм ажлыг одоо хариуцна гэдэг энэ шалгуур нь л хамгийн гол байж байгаа. Тэгээд энэ далан ес дээр бол нарийн процессоор ингээд явахаар бол ерөнхийдөө энэ шигшигдээд гарчих. Тэр одоо агуулга та бүхэнд харагдах байх. Энэ дээр бол зүгээр нөгөө хаана хаанаас гарах вэ гэдэг нь далан найм дээр байгаа. Далан естэй нарийн процесс энэ анх удаа ер нь орж ирж байгаа юм.

Тэгээд Монголд бол энэ хорин найман жил шүүгч нар өөрсдөө шууд ингэж сонгож ерөнхий зөвлөлийн гишүүдийг гаргаж байсан удаа бол байхгүй байсан юм. Нэг бол дарга нар, ерөнхий шүүгч нар дээд шүүхийнхэн орно. Эсвэл нэг одоо улс төрийн албан тушаалтан томилдог. Бид нар анх удаа яг энэ шүүгч нарын шууд сонгож гаргаж ирдэг энэ бүрэлдэхүүн бол шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах, тэр зүй бус нөлөөллийг сааруулах олон улсын жишиг, энэ Үндсэн хуулийн одоо нэмэлт, өөрчлөлтийн гол амин сүнс бол энэ заалтын цаана нь бол явж байгаа юм.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. 78 дугаар зүйлтэй холбоотой ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна. 78.2 дээр хоёр гишүүн санал гаргасан уу? Гишүүд Дэлгэрсайхан гишүүн санал гаргасан учраас 78.2-ш орхиод, бусад заалтуудаар нь саналаа хураачихъя. 78.2 дээр Дэлгэрсайхан гишүүний саналтай зэрэгцүүлж санал хураалт явуулна. 78.

48.Төслийн 78 дугаар зүйлийн 78.1-78.9 дэх хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 78.1-78.10 дахь хэсэг болгох:

78.1.Ерөнхий зөвлөл орон тооны 10 гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллана.

78.2.-г орхиж байгаа.

78.3.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох шүүгч гишүүн нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан, сахилгын шийтгэлгүй, бусад гишүүд нь хууль зүйн өндөр

мэргэшилтэй, эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй, сүүлийн таван жил шүүгч, улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байна.

78.4.Ерөнхий зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа сонгоно. Ерөнхий зөвлөлийн даргын сул орон тоо гарснаас хойш 14 хоногийн дотор даргыг сонгоно.

78.5.Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрх сонгогдож, томилогдсоноор эхэлж, дараагийн гишүүн сонгогдож, томилогдсоноор дуусгавар болно.

78.6.Ерөнхий зөвлөлийн нөхөн сонгогдсон, томилогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

78.7.Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа хуулиар тогтоосон хугацаанаас өмнө дуусгавар болсон бол өөр хүнийг энэ хуульд заасан журмын дагуу нөхөн сонгох, эсхүл нөхөн томилно.

78.8.Ерөнхий зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр нь бүрдсэнээр бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэлдэхүүнтэйд тооцно.

78.9.Ерөнхий зөвлөлийн гишүүн нь төрийн өндөр албан тушаалтны зэрэг, зиндаа, түүнтэй адилтгах албан тушаалтны зэрэглэлд тохирсон цалин хөлс, зайлшгүй шаардлагатай бусад хангамж эдэлж, хуульд заасан баталгаагаар хангагдана.

78.10.Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тус зөвлөлийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцож, 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. 78.2 ажлын хэсгээс гарсан саналыг та бүхэнд уншиж танилцуулъя. Дараа нь Дэлгэрсайхан гишүүний гарсан саналыг уншиж танилцуулна.

78.2.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах болон анхан шатны шүүхээс тус бүр хоёр шүүгчийг Нийт шүүгчийн чуулганаас хуралдаан гэж бид нар ярьсан тийм ээ, нууц санал хураалтаар сонгож, Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно. Ажлын хэсгийн санал.

Дэлгэрсайхан гишүүний санал. Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах болон анхан шатны шүүхээс тус бүр хоёр шүүгчийг тухайн шатны шүүхийн шүүгчдээс сонгоно гэж өөрчлөх. Санал гаргасан Их Хурлын гишүүн Дэлгэрсайхан. Ийм хоёр санал байна. Саналаа тайлбарлаж үг хэлэх үү, ойлгомжтой юу. Ойлгомжтой байна. Ажлын хэсгийн саналаар санал хураалгана. Ажлын хэсгийн санал дэмжигдэхгүй бол Дэлгэрсайхан гишүүний санал дэмжигдсэн тооцно. Энхбаяр гишүүн ажлын хэсгийн ахлагч.

Б.Энхбаяр: Баярлалаа. Ажлын хэсгийн оруулж байгаа саналыг дэмжээд өгөөч гэж хүсэх гэж байгаа юм. Яагаад гэхээр яах вэ хяналтын шатны, ажлын хэсэг дээр бол яах вэ дээд шүүхийнхэн бол дээд шүүхээс гурав байя гэдэг санал ярьж байсан юм. Гаргаж байсан юм. Тэгээд энэ хоёр байх уу, нэг байх уу, гурав байх уу гэдэг бол зутарч байна л даа. Яагаад гэхээр өмнө нь жишээлбэл хоёр мянга хоёр, гурван онд одоо Мөнх-Оргил сайд бол их сайн мэдэж байгаа байх. Дээд шүүхийн нэг шүүгчдийн тоо ихэсгэж багасгах асуудал Их Хурал дээр шийдэгдээд. Тэгээд дээд шүүх чинь үндсэндээ нэг яг тэтгэвэрт гарах гэж байсан тавин найм, тавин естэй хүмүүсээ бүгдийг нь ерөнхий зөвлөл рүү явуулчихсан байхгүй юу. Тийм учраас энэ ерөнхий зөвлөл гэдэг бол нөгөө тэтгэвэрт гарах гэж байгаа тэр дээд шүүхийнхний очдог бас газар биш байхгүй юу. Энэ чинь өөрөө нийт шүүхийн хараат бус байдлыг одоо хангах, тэгээд энэ нийт шүүгчдийн хуралдаанд мөрийн хөтөлбөр дэвшүүлж байж сонгогдоно бүр. Энэ хараат бус байдлыг одоо яаж арилгах вэ, үүний төлөө юу хийх вэ гэдэг ийм мөрийн хөтөлбөр гаргаж байж бид нар чинь одоо нэг тийм цензур тавьдаг болох гээд байгаа шүү дээ. Энэ хуулиар ер нь.

Тийм учраас яах вэ би бол энэ хяналтын шатны шүүхээс буюу дээд шатны шүүхээс ер нь нэг байхад болох байх л гэж хэлэх гээд байгаа. Тийм учраас ажлын хэсгийн саналыг дэмжиж өгөөч гэж хэлэх гэж байгаа юм.

С.Бямбацогт: Тийм Дэлгэрсайхан гишүүн бас хяналтын шатны шүүхээс нэг л гэж байгаа. Ганцхан нөгөө тус тусад нь шат шатны шүүхээс сонгон шалгаруулъя гэсэн санал тавьж байгаа. Сая Энхбаяр гишүүн бол ажлын хэсэг бол нийт шүүхийн эрх ашгийг хамгаалах, нийт шүүхийн хараат бус байдлыг хангах мөрийн хөтөлбөр дэвшүүлж ажиллах учраас нийт шүүхээс байх нь зөв байх гэсэн санал хэлж байна. Дэмжье, ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар ажлын хэсгийн санал дэмжигдлээ. Ийм учраас Дэлгэрсайхан гишүүний саналаар санал хураах шаардлагагүй болж байна. Саяынх чинь 78 байсан. Одоо 79 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулт байна шүү гишүүд байна уу? Энх-Амгалан гишүүн, Дэлгэрсайхан гишүүн, Адьшаа гишүүн. Адьшаа гишүүн. Энх-Амгалан гишүүн асуулт асууя. Адьшаа гишүүнийг оруулчихаарай.

Б.Энх-Амгалан: Энэ шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд бол одоо ингээд шүүгчээр арван жил ажилласан, сахилгын зөрчилгүй, мэргэшсэн шүүгч нар орох нь. Тэгээд энэ бол төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа эдлэх юм байна. Тэр зэрэглэлд тохирсон цалин хөлс авах юм байна. Зайлшгүй шаардлагатай бусад хангамж эдэлж хуульд заасан баталгаагаар хангагдах юм байна. Нийт шүүгчдийнхээ төлөөлөл байх юм байна ингээд таван хүн байх нь. Энийг бол шүүгч нар өөрсдөө мэдээд мэргэжлийн шүүгчдээ тавьчих. Хажуугаар нь бас одоо хууль зүйн өндөр мэргэшилтэй эрх зүйч мэргэжлээр арваас доошгүй жил ажилласан ийм одоо хуульч нар бас орох нь. Эд нарын төлөөлөл ингээд ороод ирэхээр зэрэг Монгол улсын Ерөнхийлөгчөөс, Засгийн газраас, Хүний эрхийн үндэсний комиссоос, Монголын хуульчдын холбооноос, Монголын өмгөөлөгчдийн холбооноос, Хууль зүйн сургалт судалгааны байгууллагаас(Хууль зүйн их дээд сургуулиас санал болгосон гээд нэг арван нэгэн хүний бүрэлдэхүүнтэй Их Хурлын гишүүн ахалсан ийм ажлын хэсэг бий болж эд нар нь ингээд тавих юм байна.

Тэгэхээр бид нар сая нэг ингээд энэ дөрвөн жилээр сонгож байгаа хүмүүсийн нэг зүй бус үйлдлийг нь сааруулах гэж байгаа энэ хуулийн амин сүнс нь эндээ байгаа юм энэ тэр гээд яриад байна шүү дээ. Гэтэл нийт шүүх нэг нийт одоо энэ ерөнхий зөвлөлийн чинь тавин хувь нь бол ингээд мэргэжлийн шүүгчид болчхож байна. Тэгээд ингээд харахаар зэрэг одоо Ерөнхийлөгч, Засгийн газар, тэр Хүний эрхийн комисс нь одоо өөрөө мэдэг. Энэ Монголын хуульчдын холбоонд чинь шүүгч, тэр цагдаа нар, прокурорууд гээд ингээд нэг баахан хүмүүс байж байдаг. Шүүгчид гуравны нэг нь байж байдаг гэж би сонссон юм. Тэгээд дээр нь одоо прокурор, цагдаа, энэ компанийн хуульч нар бол шүүхээр асуудлаа шийдүүлэх гэж орж байгаа хүмүүс байхгүй юу. Асуудлаа шийдүүлэх гэж орж байгаа юм. Тэгэхээр энэ хүмүүсийн төлөөлөл байх ямар хэрэгтэй юм. Тэр Өмгөөлөгчдийн холбоо нь байдаг л юм байгаа биз. Хүний эрхийн комисс нь байдаг л юм байгаа биз. Тэр хууль зүйн сургалт судалгааны байгууллага, хууль зүйн их дээд сургуулиудын санал болгосон төлөөлөл байдаг л юм байгаа биз. Шүүхээр асуудлаа шийдүүлдэг байгууллагын төлөөлөл, тэгээд бас шүүгч дотор нь байдаг тэр холбооны төлөөлөл байхаар нь наадах чинь зургаа дахь шүүгч бий боллоо шүү дээ.

Тэгээд наад чинь тавин нэгэн хувь болоод даваад явчихлаа шүү дээ. Ийм юм оруулж яах гэсэн юм ажлын хэсгийн даргаа. Энийг надад нэг тайлбарлаад өгөөч. Энийг одоо ямар бодлогоор оруулчихсан юм. Наад ерөнхий зөвлөл дээр чинь шүүгч нар олон олонх болчхоод тэгээд цаашдынхаа ажлуудаа наадахыг чинь татаж аваад л, тэгээд л яваад өгнө шүү дээ. Тэрэнд орсон дөрөв чинь юу хийх юм бэ. Ядаж нэг тавь тавин хувь байж байж нэг юм тэнцвэржинэ биз дээ. Ийм нөхцөл байдлаар хийе дээ. Та энийг хар даа. Хуульчдын холбоонд тийм байдаг гэж би сонссон. Одоо би зөв сонсож уу, буруу сонсож уу. Ийм нөхцөл байдлыг бол та нэг энэ дээрээ нэг анхаараад байхаач. Тэгэхгүй бол наадах чинь зургаан шүүгч орлоо шүү дээ. Тийм за энийг нэг надад хэлээд өгөөч.

С.Бямбацогт: Ажлын хэсэг Сүхбаатар гишүүн хариулъя.

Ж.Сүхбаатар: Яг энэ бол зүгээр нөгөө сонгон шалгаруулалт зохион байгуулах ажлын хэсэг юм байгаа юм. Яг шүүхийн ерөнхий зөвлөлийн тавь тавин нэг бол биш нэгдүгээрт. Хоёрдугаарт яг таны хэлдэг зүгээр хуульчдын холбоог бол манай ажлын хэсэг дээр одоо ажлын хэсгийн гишүүдээс санал гаргаад ингээд оруулсан юм. Ер нь бол яах вэ яриа бол явсан. Тэгээд одоо шүүгчид эд нар чинь ордог шүү дээ гэсэн. Тэгээд цаашдаа бол энэ шүүгч эд нар бол энд орохгүй юм байна гээд ингээд. Тэгээд ямар ч байсан Монголын хуульчдын холбоо бас нэг ийм төлөөлөл, тэгээд одоо энэ Нямбаатар сайд тэргүүтэй улсууд маань одоо оруулсан юм байгаа юм. Тийм.

С.Бямбацогт: Энх-Амгалан гишүүн тодруулъя.

Б.Энх-Амгалан: Би энэ Хуульчдын холбоо гэдэг төрийн бус байгууллагыг ад үзээд байгаа юм биш л дээ. Энэ дотор чинь нөгөө шийдвэр гаргадаг шүүгч нар чинь шууд сууж байгаа учраас л би гуравны нэг нь шүүгч байгаа шүү дээ. Тэгээд эд нар чинь дахиад лоббидоод ордог. Энэ чинь нөгөө сонгон шалгаруулдаг асуудал байхгүй юу. Бид нар өмнө нь энэ Хүний эрхийн үндэсний комисс дээр яаж алдлаа. Яг энийгээ ингээд юу яахгүй явж байгаад тулгаад ороод ирдэг. Тийм учраас энэ Хуульчдын холбоо гэдэг байгууллагаа болиод тэр бусад хуулийнх нь байгууллага, тэр Хүний

эрхийн үндэсний комисс, Өмгөөлөгчдийн холбоо гээд бүгд байж л байдаг юм байгаа биз. Ингэвэл яадаг юм бэ гэж байгаа юм. Энэ дээр би нэг зарчмын зөрүүтэй санал гаргая. Тэгээд та нар санал хураалгаж өгөөрэй. Энэ дээр нэмэлт тайлбар байвал одоо ажлын хэсгийн дарга байдаг юм уу, хэлж өгөөч.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Хуульчдын холбооноос шүүгч нар бол түдгэлзэж байгаа. Ер нь түдгэлзэх юм уу, цаашдаа бүр Хуульчдын холбооны гишүүн байх шаардлагатай шаардлагагүй юу энийг бас манай ажлын хэсэг бас анхаарах ёстой байх. Энхбаяр гишүүн, ажлын хэсэг Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Энх-Амгалан гишүүнээ энэ Хуульчдын холбоог оруулъя гэдэг саналыг Нямбаатар гишүүн сайд бид хоёр оруулсан юм. Тэгээд ийм учиртай юм Энх-Амгалан гишүүнээ. Хуульч, шүүгч биш гишүүд байгаа шүү дээ. Тэд нар нь хууль зүйн мэргэшилтэй, эрх зүйч мэргэжлээр ажилласан, тэгээд хамгийн гол нь сүүлийн таван жил шүүгч, улс төрийн албан тушаал хашаагүй хүмүүс байх ёстой байхгүй юу. Тэгэхлээр тэнд бол дахиж нөгөө шүүгч биш таван гишүүн дээр нэмэгдээд дахиад шүүгч орно гэсэн асуудал байхгүй. Нөгөө Хуульчдын холбооноос. Тэрийг нь 78.3-аараа бид нар хаачихсан юм. Наад Хуульчдын холбоог оруулах юм чинь бол нөгөө зохион байгуулах, сонгон шалгаруулах, материал цуглуулах ажлын хэсэгт л Хуульчдын холбооноос оруулж байгаа байхгүй юу. Хуульчдын холбоо нь цаашдаа ер нь шүүгч нар байх уу, үгүй юу гэдэг асуудал бол тэр тусдаа асуудал. Би бол одоо энэ бол зохимжгүй юм гэдгийг олон удаа олон жил ярьж явж байгаа юм. Тэгээд тэр чигээрээ цаашаа яваад явчих юм бол ойлгомжтой. Ер нь бол Хуульчдын холбоо цаашдаа бэхжээд энэ чинь хуульчид гэхлээр чинь зөвхөн шүүгч, өмгөөлөгч хоёр биш шүү дээ. Энд чинь нөгөө хуулийн зөвлөгөө өгдөг, өмгөөлөгчийн эрхгүй өчнөөн хуульчид одоо тэр компани дээр ажилладаг ч юм уу, хувиараа бизнес эрхэлдэг ч юм уу, мэргэжилтэй өчнөөн хүмүүс байж байна шүү дээ. Хуульч гээд одоо эрхээ авчихсан. Тэр хүмүүсийн асуудлыг зохицуулдаг нөгөө сургалтыг нь хийдэг тэр байгууллага байгаа юм. Тэгээд энэ санал дэмжигдээд явахад Хуульчдын холбооноос шүүгчид шүүхийн ерөнхий зөвлөл дээр нөгөө 5 шүүгч дээрээ нэмэгдэж 6 юм уу 7 болно гэсэн асуудал байхгүй шүү. Энэ нөгөө шүүгч биш хүн гэдэг нь бол тодорхой 78.3 дээрээ байж байгаа шүү.

С.Бямбацогт: Ер хариулт хангалттай болчихлоо. Адьшаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адьяа: Энэ шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг сонгох, тэр дээд шүүхийн шүүхээс шүүгч гишүүдийн томилогдох асуудал бол тодорхой байна. Энэ шүүгч биш гишүүдийг томилох энэ хувилбарыг дэмжихгүй байгаа юм. Энэ шүүхийн ерөнхий зөвлөл гэдэг энэ байгууллага бол Монгол улсын Үндсэн хуулийн бүтцийн байгууллага. Энэ бүтцийн байгууллагыг хууль тогтоох байгууллага томилдог энэ хувилбар бол үнэхээр Үндсэн хуулийг бас зөрчсөн агуулгатай гэж үзэж байгаа юм.

5 гишүүний сонгон шалгаруулалт бол ерөөсөө энэ улс төрийн томилгоо мэтээр харагдах ийм өнцөг ажиглагдаж байгаа юм. Хүний эрхийн үндэсний комиссын гишүүдийг сонгон шалгаруулсан тухай бас та нөхөд яриад байгаа шүү дээ. Энэ Хүний

эрхийн комисс гэдэг бол Улсын Их Хурлын бүтцийн байгууллага. Гэтэл бол Үндсэн хуулийн бүтцийн байгууллагыг Улсын Их Хурал сонгон шалгаруулдаг, томилдог энэ асуудал бол өнөөдөр хууль зүйд нийцэхгүй. Ийм учраас энэ сонгон хуульч биш шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг хуульчдын холбоо юм уу төрийн албаны зөвлөл энийг зохион байгуулах нь хамгийн зохимжтой хувилбар байна гэсэн ийм саналыг гаргаж байгаа юм. Хуульчдын холбоо бол өнөөдөр төрийн бус байгууллагын хуульчдын хамгийн том төлөөлөл. Хуульчийн эрх зүйн байдлаар эрх үүрэг нь баталгаажсан ийм байгууллага байгаа.

Төрийн албаны зөвлөл бол өнөөдөр Монгол Улсын хэмжээнд төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулдаг Улсын Их Хурлын бүтцийн байгууллага. Улсын Их Хурал үнэхээр энэ шүүх эрх мэдлийг томилдог энэ зарчмыг хэрэгжүүлэх гэж байгаа бол Төрийн албаны зөвлөлөөрөө дамжуулж энэ асуудлуудыг шийдвэл шударга ёс, хууль дээдлэх зарчимд үнэхээр бас нийцнэ гэсэн ийм саналыг гаргаж байгаа юм. Тэгээд би бас нэг зарчмын зөрүүтэй саналаа гаргасан байгаа. Тэрнийг би энэ санал хураалтын дараа энийгээ тайлбарлая.

С.Бямбацогт: 79. Хуулийн төслийн 79 дүгээр зүйлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулъя. 49.Төслийн 79 дүгээр зүйлийн 79.1-79.10 дахь хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 79.1-79.19 дэх хэсэг болгох:

79.1.Улсын Их Хурал Ерөнхий зөвлөлийн шүүгч биш гишүүнийг дараах журмаар нээлттэйгээр нэр дэвшүүлж, томилно:

79.1.1.Ерөнхий зөвлөлийн дарга тус зөвлөлийн шүүгч биш гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 120-оос доошгүй хоногийн өмнө, эсхүл гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсноос хойш ажлын гурван өдрийн дотор Байнгын хороонд болон олон нийтэд энэ тухай мэдэгдэх;

79.1.2.Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө, эсхүл гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсноос хойш 14 хоногийн дотор, хэрэв чуулганы чөлөө цагт эдгээр нөхцөл бий болсон бол ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор Байнгын хорооноос Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай зарыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх;

79.1.3.иргэн сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлснээс хойш 21 хоногийн дотор нэр дэвших тухай хүсэлтээ дараах баримт бичгийн хамт Байнгын хороонд хүргүүлэх:

79.1.3.а.Ерөнхий зөвлөлийн гишүүний хувьд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэлээ бичсэн тайлбар;

79.1.3.б.төрийн албан хаагчийн анкет;

79.1.3.в.мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга;

79.1.3.г.нийгмийн даатгалын дэвтэр, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;

79.1.3.д.энэ хуулийн 78.3-т заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бичиг.

79.1.4.Байнгын хороо нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудаст хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг байршуулах;

79.1.5.Байнгын хороо энэ хуулийн 79.1.4-т заасан мэдээллийг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхсон этгээдээс нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг хүлээн авах бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг бүртгэхгүй;

79.1.6.Байнгын хороо энэ хуулийн 79.1.2-т заасан зарыг нийтэд мэдээлснээс хойш 21 хоногийн дотор сонгон шалгаруулалтыг хараат бусаар зохион байгуулах чиг үүрэгтэй ажлын хэсэг байгуулах.

79.2.Ажлын хэсэг нь Улсын Их Хурал дахь олонх, цөөнх, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн сургалт, судалгааны байгууллага, хууль зүйн их, дээд сургуулийн санал болгосон төлөөллөөс бүрдсэн 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар томилсон Улсын Их Хурлын гишүүн ахална.

79.3.Ажлын хэсэг энэ хуулийн 79.1.2-т заасны дагуу зарыг нийтэд мэдээлснээс хойш 60 хоногийн дотор сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, Ерөнхий зөвлөлийн гишүүнд тавих шаардлагыг хамгийн сайн хангасан нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгоно.

79.4.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг дараах журмаар зохион байгуулна:

79.4.1.энэ хуульд заасан шаардлагыг хангасан нэр дэвшигчийг бүртгэн нийтэд мэдээлэх;

79.4.2.нэр дэвшигчийг тохиолдлын журмаар ажлын хэсгийн гишүүдэд тэнцвэртэй хуваарилж, илтгэгч гишүүнийг томилох;

79.4.3.илтгэгч гишүүн нь нэр дэвшигчийн баримт бичиг, олон нийтээс ирүүлсэн саналыг судлах, нэр дэвшигчтэй болон бусад этгээдтэй ярилцлага хийх зэргээр мэдээллийг бүрдүүлж, тухайн нэр дэвшигч Ерөнхий зөвлөлийн гишүүнд тавих шаардлагыг хангаж байгаа эсэх талаар дэлгэрэнгүй тайлан бичих;

79.4.4.ажлын хэсгийн гишүүд илтгэгч гишүүний тайлан болон холбогдох бусад баримт, мэдээлэлд үндэслэн нууцаар санал хураах;

79.4.5.энэ хуулийн 79.4.4-т заасан санал хураалтын дүнгээр ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг саналын дарааллаар эрэмбэлэн сул орон тоогоор болон дараагийн олонхын санал авсан хоёр хүртэлх хүний хамт нэр дэвшүүлж, Байнгын хороонд тайлангийн хамт ажлын гурван өдрийн дотор хүргүүлэх.

79.5.Байнгын хороо энэ хуулийн 79.4.5-д заасны дагуу ирүүлсэн тайланг хүлээн авснаас хойш дараах ажиллагааг хийнэ:

79.5.1.хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг агуулсан тайланг ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах;

79.5.2.энэ хуулийн 79.5.1-д заасны дагуу тайланг байршуулснаас хойш ажлын таван өдрийн дотор томилгооны сонсголын товыг зарлах;

79.5.3.тайланг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхогч этгээд нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг хүлээн авах бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг бүртгэхгүй;

79.5.4.энэ хуулийн 79.5.3-т заасан хугацаа өнгөрснөөс хойш 14 хоногийн дотор хуульд заасны дагуу томилгооны сонсголыг зохион байгуулах.

79.6.Энэ хуулийн 79.5.4-т заасны дагуу томилгооны сонсголыг хийснээс хойш ажлын таван өдрийн дотор нэр дэвшигчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилох эсэх талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

79.7.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нэр дэвшигчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилно.

79.8.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар нэр дэвшигчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилохоос татгалзсан бол ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчдээс дараагийн хамгийн олон санал авсан хүнийг энэ хуулийн 79.4.5-д заасны дагуу Улсын Их Хуралд нэр дэвшүүлнэ.

79.9.Энэ хуулийн 79.8-д заасан нөхцөлд ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигч байхгүй бол ажлын таван өдрийн дотор Байнгын хороо сонгон шалгаруулалт явуулах тухай зарыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, 90 хоногийн дотор энэ зүйлд заасан журмын дагуу сонгон шалгаруулалтыг дахин явуулна.

79.10.Улсын Их Хурлаас татгалзсан нэр дэвшигчийг дахин нэр дэвшүүлэхгүй.

79.11.Ерөнхий зөвлөлийн шүүгч биш гишүүнийг сонгон шалгаруулахтай холбоотой журмыг энэ хуульд нийцүүлэн Байнгын хороо баталж, Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулна.

79.12.Нийт шүүгчийн чуулган Ерөнхий зөвлөлийн шүүгч гишүүнийг дараах журмаар нэр дэвшүүлж, сонгоно:

79.12.1.Ерөнхий зөвлөлийн дарга тус зөвлөлийн шүүгч гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө, эсхүл гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсноос хойш ажлын таван өдрийн дотор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх;

79.12.2.Ерөнхий зөвлөлийн шүүгч гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө, эсхүл гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсноос хойш 14 хоногийн дотор Нийт шүүгчийн чуулганы товыг энэ хуулийн 20.4-т заасны дагуу зарлаж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх бөгөөд нийтэд мэдээлснээс хойш 45 хоногийн дараа Нийт шүүгчийн хуралдааныг зохион байгуулах;

79.12.3.Нийт шүүгчийн хуралдааны товыг нийтэд мэдээлснээс хойш 21 хоногийн дотор шүүгч Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвших тухай хүсэлтээ дараах баримт бичгийн хамт энэ хуулийн 20.9-д заасан ажлын хэсэгт хүргүүлэх:

79.12.3.а.Ерөнхий зөвлөлийн гишүүний хувьд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэлээ бичсэн тайлбар;

79.12.3.б.мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга.

79.12.4.ажлын хэсэг хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор Ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршуулах;

79.12.5.мэдээллийг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхогч этгээд нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг ажлын хэсэг хүлээн авах бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг бүртгэхгүй.

79.13.Нийт шүүгчийн чуулганд нэр дэвшигч нь хийх ажил, нэр дэвшсэн үндэслэлээ танилцуулж, оролцогчийн асуултад хариулна.

79.14.Нэр дэвшигчийн танилцуулга хийх дарааллыг тохиолдлын журмаар тогтоож, танилцуулга хийх, энэ хуулийн 79.12.5-д заасны дагуу ирүүлсэн асуултад хариулах ижил хугацааг нэр дэвшигч бүрд олгоно.

79.15.Нийт шүүгчийн хуралдаанд оролцогчид нийтээрээ, чөлөөтэй, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах бөгөөд санал хураалтыг цахим хэлбэрээр явуулж болно.

79.16.Нийт шүүгчийн хуралдаанд оролцогчдын олонхын санал авсан нэр дэвшигчдийг саналын дарааллаар эрэмбэлж, сул орон тоо гарсан тоогоор Ерөнхий зөвлөлийн гишүүнээр сонгогдсонд тооцно. Санал хураалтаар нэр дэвшигчдийн хэн нь ч оролцогчдын олонхын санал аваагүй бол дахин санал хураалт явуулж, хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцно.

79.17.Ажлын хэсэг энэ хуулийн 79.16-д заасан санал хураалт дууссанаас хойш ажлын гурван өдрийн дотор Нийт шүүгчийн чуулганы тогтоол, тэмдэглэлийг үйлдэж, Ерөнхий зөвлөлд хүргүүлнэ.

79.18.Энэ хуулийн 79.12.3-т заасан хугацаанд хүсэлт гаргаагүй шүүгчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээр сонгохыг хориглоно.

79.19.Ерөнхий зөвлөлийн гишүүнд шүүгчийг нэр дэвшүүлэх, сонгох ажиллагаанд шүүгчийн хараат бус, нээлттэй, ил тод байдлыг хангах, үүссэн асуудлыг шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай бусад асуудлыг энэ хуулийн 20.3-т заасан дэгээр зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 83,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Адъяаа гишүүний санал байгаа. 79.11 хэсгийг нэмж оруулах нэмэлт. Ажлын хэсэг нь Улсын Их Хурал олонх, цөөнх, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын өмгөөлөгчдийн холбоо, хуульчдын сургалт судалгааны байгууллага, их, дээд сургуулийн санал болгосон төлөөллөөс бүрдсэн 11 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ажлын хэсгийг Төрийн албаны зөвлөлийн дарга ахална. Санал гаргасан Адъяаа гишүүн. Саналаа тайлбарлаж үг хэлэх үү та. Адъяаа гишүүн.

Ш.Адъяаа: Би энэ Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооноос Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч биш 5 гишүүнийг томилох асуудлаар энэ зарчмын зөрүүтэй саналыг оруулж байгаа юм. Энэ ажлын хэсэг нь Улсын Их Хурал дахь олонх цөөнх Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Хүний эрхийн үндэсний комисс, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Монголын хуульчдын холбоо гээд энэ 11 хүний бүрэлдэхүүнтэй энэ ажлын хэсгийг байгуулаад комиссын даргаар нь Улсын Их Хурлын гишүүн биш Төрийн албаны зөвлөлийн даргыг ахлуулж ажиллуулах ийм саналыг оруулж байгаа юм.

Улсын Их Хурал бол өнөөдөр Шүүхийн ерөнхий зөвлөл буюу шүүхийн боловсон хүчин, шүүхийн хөрөнгө санхүүг барьдаг энэ байгууллагын боловсон хүчнийг томилж байгаа нь өнөөдөр шүүх эрх мэдлийг хууль тогтоох эрх мэдлийн шууд хараанд оруулсан ийм байдал бий болж байгаа. Тэгэхээр энэ байдлаас гарахын тулд өнөөдөр Монгол Улсын хэмжээнд төрийн албаны ажилтнуудыг сонгон шалгаруулж зохион байгуулдаг төрийн албаны зөвлөлийг энэ шүүх эрх мэдлийн шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг томилох энэ ажиллагааг зохион байгуулбал арай хууль ёсонд нийцсэн Үндсэн хуулийн зөрчлөөс сэргийлсэн ийм томилгоо болно гэдэг тийм бодлын үүднээс ийм саналыг оруулж байгаа юм.

Өнөөдөр хууль тогтоох байгууллага шүүх эрх мэдлийн байгууллагыг өөрийнхөө харьяанд оруулж боловсон хүчин удирдлага энэ асуудлыг нь зөвхөн Их Хурал томилдог бүр тухайлбал энэ сонгон шалгаруулалтыг Улсын Их Хурлын гишүүн ахалж хийх нь өнөөдөр хууль дээдлэх зарчим үнэхээр алдагдана. Ийм учраас үнэхээр Их Хурал өөрийнхөө мэдэлд энийг авчрах гэж байгаа юм бол төрийн албаны зөвлөлөөр энэ сонгон шалгаруулалтыг зохион байгуулдаг ийм асуудлыг шийдэх нь бас ач

холбогдолтой гэж бодож байгаа учраас ийм саналыг оруулсан юм. Эрхэм гишүүд та бүхэн энэ миний саналыг дэмжиж өгөөрэй гэж хүсэж байна.

С.Бямбацогт: Адьшаа гишүүний саналыг саналаа тайлбарлаж үг хэллээ сая. Гишүүд ойлгосон байх тийм ээ, Адьшаа гишүүний саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 4 гишүүн буюу 33,3 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй. Одоо чинь 80 билүү?

Хуулийн төслийн 80 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс бэлдсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 50.Төслийн 80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсгийн “архив, бүх шатны шүүхийн тамгын газарт түүний салбар” гэснийг хасаж, 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсгийн “хэлэлцэн” гэсний дараа “ил санал хураалт явуулж” гэж нэмж, 81.4 дэх хэсгийн “тав” гэснийг “гурав” гэж өөрчилж, 81.6 дахь хэсгийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 81.8 дахь хэсэг нэмэх:

“81.8.Ерөнхий зөвлөл хуульчдаас шүүгчийг шилж олох, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбогдуулан гаргасан шийдвэрээ тухай бүр, ажлын тайланг жил бүр өөрийн цахим хуудаст байршуулна.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүдээ анхааралтай. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 83,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй тийм үү.

Хуулийн төслийн 81 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хураасан. Гишүүдээс санал бичгээр санал гараагүй. Хуулийн төслийн 82 дугаар зүйлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. 82 дээр алга байна. Ажлын хэсгийн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 51.Төслийн 82 дугаар зүйлийн 82.1.1 дэх заалтын “удирдах” гэснийг “уялдуулан зохицуулах” гэж, 82.1.11 дэх заалтын “Шүүгчдийн зөвлөлд” гэснийг “Нийт шүүгчийн хуралдаанд” гэж тус тус өөрчилж, 82.4 дэх хэсгийн “түр” гэснийг, “орон тооны” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 11 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Бичгээр гишүүдээс санал гараагүй байна.

83 хуулийн төслийн 83 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгийн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 52 шүү дээ. 52.Төслийн 83 дугаар зүйлийн 83.1.1 дэх заалтын “орон тооны гишүүний хувьд” гэснийг хасаж, 83.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 83.1.6, 83.1.7 дахь заалт нэмэх:

“83.1.6.Ерөнхий зөвлөлийн хуралдаан болохоос ажлын гурваас доошгүй өдрийн өмнө холбогдох баримт бичгийг урьдчилан хүлээн авч танилцах;

83.1.7.хүндэтгэн үзэх шалтгаантай бол Ерөнхий зөвлөлийн хуралдаанд цахим хэлбэрээр оролцох, эсхүл саналаа бичгээр өгөх;” санал гаргасан ажлын хэсэг

дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 83,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

84 дүгээр зүйл, гишүүдээс бичгээр санал байхгүй тийм ээ 83 дээр. Хуулийн төслийн 84 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгийн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 53.Төслийн 84 дүгээр зүйлийн 84.2.1 дэх заалтын “энэ хуулийн 20.2.3-т заасны дагуу сонгогдсоноос бусад гишүүн” гэснийг, 84.2.6 дахь заалтын “хороо болон Шүүхийн мэргэшлийн” гэснийг тус тус хасаж, 84.2.1 дэх заалтын “гурван” гэснийг “нэг” гэж, 84.2.2 дахь заалтын “үүсэхээс урьдчилан сэргийлэх” гэснийг “үүсгэх” гэж тус тус өөрчилж, 84.2.7 дахь заалтын “авах” гэсний дараа “, өөртөө аливаа давуу байдал бий болгохыг шаардах” гэж нэмж, 84.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 84.2.5-84.2.7 дахь заалт болгох:

“84.2.5.шүүн таслах ажиллагаа, шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх, хөндлөнгөөс оролцох;

84.2.6.нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтын болон үнэлгээ, шалгалтын баримт бичгийг урьдчилан ил болгох, тодорхой нэр дэвшигчийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр байр сууриа илэрхийлэх;

84.2.7.нэр дэвшигчийн үнэлгээг үндэслэлгүйгээр өөрчлөх;” Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 11 буюу 91,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй.

Төслийн хуулийн төслийн 85 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгийн гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 54.Төслийн 85 дугаар зүйлийн гарчгийн “, эгүүлэн татах” гэснийг, 85.7 дахь хэсгийн “эгүүлэн татах,” гэснийг тус тус хасаж, мөн зүйлд дараах агуулгатай 85.2.3 дахь заалт нэмж, 85.3, 85.4, 85.5 дахь хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 85.3-85.8 дахь хэсэг болгох:

“85.2.3.энэ хуулийн 89.3-т заасны дагуу хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтад нэр дэвшигчийг урьдчилан мэдэх боломжгүй байх, хөндлөнгийн байдлаар үнэлэх нөхцөлийг зөрчсөн, эсхүл шалгалтын даалгаврын агуулга, нууцлалыг задруулсан;”

“85.3.Энэ хуулийн 85.2-т заасан зөрчил гарсан тухай өргөдөл, мэдээллийг Сахилгын хороонд гаргана.

85.4.Сахилгын хороо Ерөнхий зөвлөлийн гишүүний талаарх өргөдөл, мэдээллийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор сахилгын хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэнэ. Сахилгын хэрэг үүсгэсэн бол тухайн өргөдөл, мэдээллийн үндэслэлийг шалгах хараат бус шинжээч /цаашид “шинжээч” гэх/-ийг Сахилгын хороо томилно.

85.5.Шинжээч томилогдсоноосоо хойш 30 хоногийн дотор өргөдөл, мэдээлэлд дурдсан зөрчлийн талаарх баримт, мэдээллийг цуглуулж, хууль зүйн дүгнэлт гаргах

бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

85.6.Шинжээч энэ хуулийн 85.2-т заасан сахилгын зөрчил гарсан байх үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан бол Сахилгын хороо уг дүгнэлтийг эрх бүхий этгээдэд даруй хүргүүлж, Ерөнхий зөвлөлийн гишүүнийг огцруулах эсэх асуудлыг дараах журмаар шийдвэрлэнэ:

85.6.1.Ерөнхий зөвлөлийн шүүгч гишүүнийг огцруулах асуудлыг энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан журмын дагуу хуралдааныг зохион байгуулж, Нийт шүүгчийн чуулганд оролцогчдын олонхын саналаар, нууцаар санал хурааж, шийдвэрлэх;

85.6.2.Ерөнхий зөвлөлийн шүүгч биш гишүүнийг огцруулах асуудлыг Байнгын хороогоор хэлэлцэж, санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх;

85.6.3.гэмт хэргийн шинжтэй бусад үйлдэл, эс үйлдэхүйг шалгуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх.

85.7.Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүний энэ хуулийн 84.1, 84.2-т заасныг зөрчсөн үйлдэлд огцруулах шийтгэл оногдуулахааргүй бол зөрчлийн шинж, хэр хэмжээнд тохируулан хаалттай, эсхүл нээлттэй сануулах шийтгэлийг Ерөнхий зөвлөл оногдуулах бөгөөд уг асуудлыг шийдвэрлэхэд тухайн гишүүнийг оролцуулахгүй.

85.8.Сахилгын хороо энэ хуулийн 84.1, 84.2-т заасныг зөрчсөн талаарх өргөдөл, мэдээллийг хүлээн авах, сахилгын хэрэг үүсгэх, шалгах, хянан шийдвэрлэх журмыг хараат бус, бодитой байх зарчимд нийцүүлэн батална.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 91,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 88 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? 86 билүү? Тийм. хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гарсан санал байхгүй. Хуулийн төслийн 86 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй. Гишүүдээс бичгээр ирсэн санал байхгүй.

Хуулийн төслийн 87 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Мөнхцэцэг гишүүн. 87 дугаар зүйл.

Ц.Мөнхцэцэг: 87 дугаар зүйл дээр шүүхийн мэргэжлийн хороо гэж шинэ институт зааж өгсөн байгаа. Тэр 87.8, 87.9 дэх заалтуудыг ингээд харахаар шүүхийн мэргэжлийн хороо бол 2 чиг үүрэгтэй байхаар байна. 1 дүгээрт нь одоо шүүгчид нэр дэвшигчээс шалгалт аваад, шалгалтад тэнцэхгүй бол хасна. Тэнцсэнийг нь шүүгчийн ерөнхий зөвлөлд хүргүүлнэ. 2-т нь бол шүүхийн мэргэжлийн хороо шүүгч мэргэжлээрээ тэнцэхгүй гэсэн дүгнэлт гарвал түүнд үндэслээд шүүгчийг чөлөөлөхөөр

заасан байгаа. Гэтэл энэ 72.2.2 дээр шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүрэгт шүүхийг хүний нөөцөөр хангана гэсэн заалт байгаа. Тэгэхээр одоо энэ шүүхийн мэргэжлийн хороо гэдэг энэ хоёр үүргийг, тийм байлгүй дээ.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн бэлдсэн материал дээр дарааллын өөрчлөлт гарсан. Тиймээс гишүүд бас андуурсан байна. 87 бол бүхлээрээ хассан байна. Тэгвэл 87 асуулт асуучихлаа сая. Хасаж байгаа юм байна. Ойлгомжтой боллоо. Бичгээр гарсан санал байхгүй. Ажлын хэсэг санал гаргаагүй.

Хуулийн төслийн 88 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгийн бэлдсэн саналаар санал хураалт явуулъя. 88 ээр чинь хэд вэ? 55. Төслийн 88 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 36 дугаар зүйл болгон Наймдугаар бүлэгт шилжүүлэх:

“36 дугаар зүйл. Шүүгчид нэр дэвшигчийг бүртгэх

36.1. Энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан болзол, шаардлагыг хангасан гэж үзсэн иргэн энэ хуулийн 35.2-т заасны дагуу зарыг нийтэд мэдээлснээс хойш 30 хоногийн дотор шүүгчид нэрээ дэвшүүлэх эрхтэй.

36.2. Энэ хуулийн 36.1-д заасны дагуу өргөдөл гаргагч нь энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан болзол, шаардлагыг хангасан тухай баримтыг өргөдөл, анкет, мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга, оршин суугаа газрын хаяг, гэр бүлийн болон эд хөрөнгийн эрхийн лавлагаа, Монгол Улсын иргэний үнэмлэх, мэргэжлийн боловсролын диплом, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын дэвтэр, хөдөлмөр эрхлэлтийн талаарх болон бусад баримт бичгийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт Ерөнхий зөвлөлд цахимаар болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

36.3. Ерөнхий зөвлөл өргөдөл гаргагчийн бүрдүүлсэн баримт бичгийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор бүрэн гүйцэд, үнэн зөв эсэхийг нягтлан шалгаж, шүүгчид нэр дэвшигчээр бүртгэсэн, эсхүл бүртгэхээс татгалзсан тухай тогтоол гаргана.

36.4. Энэ хуулийн 36.3-т заасан тогтоол гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор нэр дэвшигчийн баримт бичгийг Ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршуулах бөгөөд хувь хүний нууцад хамаарах мэдээллийг нийтлэхгүй.

36.5. Энэ хуулийн 36.4-т заасан мэдээллийг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхсон этгээд нэр дэвшигчээс асуух асуулт, саналаа Ерөнхий зөвлөлд ирүүлэх бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг хүлээн авахгүй.

36.6. Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн мэдээллийг тухайн шүүхийн болон нутгийн захиргааны байгууллагын цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

36.7. Анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тавих болзол, шаардлагад нийцүүлэн бүрдүүлэх баримт бичиг болон

бүртгэлтэй холбогдсон харилцааг энэ хуулийн 74.1.5-д заасан журмаар зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 83,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

56.Дээрх 8 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 87 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Сая Мөнхцэцэг гишүүн асуусан хасагдаж байна. Гишүүдээ анхааралтай. Ажлын хэсгийн ахлагч горимын саналаа гарга. Гаргасан юм байна Сүхбаатар гишүүн, Сандаг-Очир гишүүн ажлын хэсгийн гишүүн. Сандаг-Очир гишүүн. Горимын санал.

Ц.Сандаг-Очир: Миний санал орсонгүй. Тийм учраас дахиж санал хурааж өгөөч.

С.Бямбацогт: Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн горимын саналыг Сандаг-Очир гишүүн гаргаж байна. Горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Сандаг-Очир гишүүний горимын санал дэмжигдсэнтэй холбогдуулан 56 дугаар саналаар дахин санал хураалт явуулъя. Дээрх 8 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 8 дугаар зүйлийг хасах. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 12 гишүүн оролцож 11 гишүүн буюу 91,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Бичгээр гарсан санал байхгүй байна гишүүдээс.

Хуулийн төслийн 89 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ 37 дугаар зүйл дээр шүүгчид нэр дэвшигчийн шалгалт гээд бид нар тодруулж оруулж байгаа юм. Тэгээд энэ саналыг би бүхэлд нь дэмжиж байгаа юм. Зүгээр нэг ийм редакцын шинжтэй юм байгаа юм. Энэ шалгалтыг нөгөө 2 хэсгээс хувааж авах гэж байгаа шүү дээ. Нэг нь бол хууль эрх зүйн мэдлэг чадварын шалгалт гээд нөгөөх нь мэргэшил ёс зүйн зан төлөвийн шалгалт гээд.

Тэгэхээр би зүгээр редакц дээр байна шүү дээ ингэж санал оруулмаар байгаа юм. Энэ хууль зүйн мэдлэг чадварын шалгалт гэж аваад нөгөөх нь ёс зүй зан төлөвийн шалгалт гэж оруулмаар байгаа юм. Тэгээд мэргэжил хууль зүйн мэдлэг чадварын шалгалт нь 50 оноотой, ёс зүй зан төлөвийн шалгалт нь 30 оноотой байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ 2-лаа 50, 50 байх ёстой юм. Би яагаад ингэж хэлээд байгаа юм бэ гэхээр байна шүү дээ энэ хууль зүйн мэдлэг чадвараасаа илүү энэ нөгөө ёс зүй зан төлөвийн байдал буюу одоо нөгөө нэг яг энэ хүн шүүгч хийх тэр темперамент гэж нэг яриад байгаа шүү дээ хувь хүний ааш араншин, хүний өөрийн нэг төрх байдал байна шүү дээ. Энд гол анхаарал хандуулах ёстой асуудал байгаад байгаа байхгүй юу. Тэр мэдлэг боловсрол мэдээж ойлгомжтой тэр бол чухал.

Гэхдээ мэдлэг боловсролоосоо бараг илүү анхаарах ёстой юм бол энэ нөгөө шүүгч хийх тэр хувь хүний төлөвшил зан араншин буюу тэр нэг judgement темперамент гээд темперамент гэж л яриад байгаа юм л даа. Мэргэжлийн ёс зүй биш. Нөгөө нэг өмгөөлөгч хийх хүний ааш араншин нэг байдаг. Шүүгч хийх хүний бол арай өөр аршинтай байх ёстой байхгүй юу. Тэгэхээр тэр хүний өөрийнх нь одоо нөгөө нэг хувь хүний шинж чанарыг нь харж энэ хүн бол яг үнэхээр яг үнэхээр шүүгч хийх чадвартай хүн байна уу шүү. Зан төлөв нь мөн байна шүү темперамент нь таарч байна шүү гэдгийг харж байх нь бол энэ Ерөнхий зөвлөлийн нөгөө мэргэшсэн нарийн ажлынх нь гол учир байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр нь мэргэшил ёс зүй зан төлөв гээд орчихоор тэгээд тэрэн дээр нь 30-хан оноо өгчихөөр тэр ажил хойшоо тавигдчих гээд байгаа юм. Тэгэхээр миний редакцын санал бол ерөөсөө энэ шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийг олж шалгаруулахдаа тэр зан төлөв ааш араншин тэр нөгөө нэг миний би өөрийгөө зөв ойлгуулж чадаж байна уу үгүй юу. Хүний нэг ерөнхий нэг араншин гэж байна шүү дээ тийм ээ. Мэргэжлийн ухамсар биш юм байна. Зарим хүн чинь ингээд хэчнээн мэргэжлийн ухамсартай мөртөө шүүгч хийх хувь хүний зан чанар төлөвшөөгүй ч юм уу хувь хүний цаанаасаа ингээд юу нь байхгүй байж болж байгаа байхгүй юу. Өөрийнх нь одоо ааш араншин гэх юм уу нэг нуруу гэх юм уу. Энэ бол бусад орнуудад бол ерөөсөө энэ шүүгчийн сонгон шалгаруулах асуудал дээр гол асуудал ерөөсөө энд л анхаараад байгаа байхгүй юу. Энэ хүн бол тэр шударга ёс зүйтэй тэр бол ойлгомжтой. Гэхдээ яг хувь хүнийхээ өөрийн ааш араншин байж байгаа байдал төлөвлөөрөө энэ бол яг шүүгч хийчих хэмжээний тэр хэмжээний тулгатай гэх юм уу нуруутай гэх юм уу ийм хүн байна гэдэг тэр хувь хүний занг нь л харах нь чухал болчихоод байгаа юм. Тэр талаас нь нэг жаахан янзлаад 50, 50 гэдэг оноог оруулаад мэргэшил гэдэг юм нь яг энэ юугаараа бол бид нар чинь 70, 80 хувийг нь харах гээд байна шүү дээ. мэргэшлээсээ гадна тэр хувь хүний зан чанар чухал шүү гэдэг нь редакцияраа засаж оруулж өгмөөр байна.

С.Бямбацогт: Тэгэхээр редакцын найруулгын санал биш байна л даа. Энэ зарчмын санал болчихоод байна. 70, 30-аар үнэлнэ гэсэн байж байгаа. Тэгэхээр та бол өөрчилье гэх юм бол зарчмын зөрүүтэй санал гаргах нь. Та тэгвэл бичгээр санал гаргах ёстой болох нь. Энэ дээр болохгүй юу. Мөнхсайхан багш ажлын хэсэг. Товчхон хариулъя.

О.Мөнхсайхан: Мөнх-Оргил гишүүн маш чухал энэ ажлын хэсгийн саналын үзэл баримтлалыг тайлбарлачихлаа. Ер нь бол яах вэ судалгаагаар бол юу гарсан бэ гэхээр шүүгчийн шалгалт гэж тусгайлан шалгалт авдаг улс их ховор юм байна лээ. Хуульчийнхаа шалгалт аваад л тэгээд тэрэн дээр тэнцсэн хүмүүсээ харин шүүгчээр ажиллах чадвар мэргэшил ёс зүйтэй юу гэдгийг нь шалгаад л тэрүүгээр томилох нь бол дийлэнх байгаа юм. Судалгаагаар бол ганцхан Англи бол нэг юм манай энэ дээр

байгаа шиг бичгийн шалгалт аваад шүүрдээд тэгээд бичгийн шалгалт дээр гарч ирсэн хүмүүсээ зан төлөвийг нь судалж байгаад томилдог ийм нэг юу байгаа юм.

Манайх бол бас шилжилтийн үе учраас одоогийн 6000 хуульчийн чинь зарим нь хуульчийн шалгалт өгөөгүй. Зарим нь янз бүрийн хүмүүс байгаа учраас энэ мэдлэг чадварын шалгалт бичгийн шалгалт бол нэргүй ийм шалгалтууд бол заавал байж шигших шаардлагатай байгаа юм. Тэнцсэн хүмүүсээсээ бол зан төлөв ёс зүйг нь шалгаад гаргах энэ юу бол маш чухал. Тэгээд гишүүний хэлж байгаа агуулга бол ерөнхийдөө багтсан. Хэдийгээр энд 100 оноог 70 оноо нь мэдлэг чадварын шалгалт, 30 оноо нь ёс зүй зан төлөвийн гэсэн боловч аль аль дээр нь 70-аас доош хувиар авсан бол шууд унах юм. Өөрөөр хэлбэл тэр бичгийн шалгалтын 70 онооны 50-иас доош буюу 70 хувиас доош авбал унана гэсэг үг.

Энэ дээр тэнцсэн хүмүүс мэргэшил ур чадварынхаа шалгалтад ороод энэ 30 онооны 20-иос доош авчих юм бол бас унана. Тэгэхээр гишүүний санаа зовж байгаа тэр асуудал үнэхээр ёс зүй зан төлөвийн хувьд хангахгүй гэж үзвэл шүүгч болох юу нь бол энүүгээр хаагдана. Тэгээд энэ харьцааг өөрчлөхөөр бол нэг болгоомжлол юу вэ гэхээр нөгөө энэ ёс зүй зан төлөвийг шалгах нь өөрөө маш чухал боловч энэ өөрөө энэ ажлыг хийж байгаа тэр ерөнхий зөвлөлийн гишүүд дээр итгэл дээр явдаг. Одоо ярилцлага хийнэ, судалгаа хийнэ. Бичгийн материалыг нь үзнэ. Тийм учраас энэ бол тухайн тэр ерөнхий зөвлөлийн 10 гишүүний үнэлгээ энэ дээр орж байгаа юм. Тэгэхээр энэ 70, 30 гэсэн харьцааг өөрчлөөд 50, 50 болговол манайх шиг шилжилтийн үед бол эрсдэл нь юу вэ гэхээр нөгөө хувь хүний яг үнэлгээ ордог юу нь ихсээд ирэхээр магадгүй субъектив зүйл бол хэт нөлөөтэй болчих ийм эрсдэл байж байгаа. Энэ дээр бас 7 жилийн өмнө Монголд ирж байсан. Аризонагийн их сургуулийн профессор яг манайд бас хэлж байсан. Энэ мэдлэг чадвар бол арай объектив авч байгаа учраас энүүгээрээ гол баримжаагаа аваад шигш. Эндээсээ харин гарсан хүн дээрээ бас ёс зүй зан төлөв тэнцэхгүй хасдаг юмаа хий гэдэг ийм зөвлөгөө гарч байсан.

Тэгэхээр энэ аль аль балансыг нь хангаад энэ 70, 30 гэдэг онооны харьцаа бол гарч ирсэн. Тэгэхээр аль аль шалгуурыг нь 70 хувьтай ханга байж л энэ хүн шүүгч болно гэдэг тэр зарчим байгаа учраас гишүүний санаа зовж байгаа агуулга байгаа юм болов уу гэж бодож байна.

С.Бямбацогт: Эхлээд шалгалтдаа хууль зүйн мэдлэг чадварын шалгалтдаа тэнцээд дараа нь мэргэшил ёс зүйн зан төлөвийн шалгалтаа өгөх юм байна шүү дээ. Асуулт асууж дууслаа. Ажлын хэсгийн бэлтгэсэн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт биш хүчингүй шүү. Саналын томьёоллоо уншиж дуусаагүй амжаагүй уншаагүй байна. Саналын томьёоллоо уншъя та бүхэнд. 57.Төслийн 89 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 37 дугаар зүйл болгон Наймдугаар бүлэгт шилжүүлэх:

“37 дугаар зүйл.Шүүгчид нэр дэвшигчийн шалгалт

37.1.Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийг энэ хуулийн 36.3-т заасны дагуу бүртгэснээс хойш 60 хоногийн дотор шүүгчид нэр дэвшигчийн шалгалт авна. Шүүгчид нэр дэвшигчийн шалгалт нь хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт болон мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтаас бүрдэнэ.

37.2.Хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтыг эрх зүйн тохиолдол шийдвэрлэх, сорилын асуултад хариулах, эрх зүйн баримт бичиг боловсруулах, хууль тайлбарлан хэрэглэх, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх зэрэг аргаас сонгон хэрэглэж, 70 хүртэлх оноогоор үнэлнэ. Анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн шалгалт ялгаатай байна.

37.3.Хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт нь нэр дэвшигчийг урьдчилан мэдэх боломжгүй, хөндлөнгийн байдлаар үнэлэх нөхцөлийг хангасан байх бөгөөд шалгалтын даалгаврын агуулга, нууцлалыг Ерөнхий зөвлөл хариуцна.

37.4.Энэ хуулийн 37.2-т заасан шалгалтад 50, түүнээс дээш оноо авсан нэр дэвшигчийг хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтад тэнцсэнд тооцож, тогтоол гарган мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтад оруулна.

37.5.Энэ хуулийн 37.4-т заасан тогтоол гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор хувь хүний нууцад хамаарахаас бусад нэр дэвшигчийн мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга болон холбогдох баримт бичгийг Ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршуулна. Ийнхүү байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхогч этгээд нэр дэвшигчийн талаарх саналаа Ерөнхий зөвлөлд хүргүүлж болох бөгөөд нэр, хаяггүй саналыг хүлээн авахгүй.

37.6.Энэ хуулийн 37.4-т заасан нэр дэвшигчийг тохиолдлын журмаар Ерөнхий зөвлөлийн гишүүн /цаашид “илтгэгч гишүүн” гэх/-д тэнцвэртэй хуваарилна. Илтгэгч гишүүн өөрт хуваарилагдсан нэр дэвшигчийн баримт бичиг, шүүн таслах болон бусад ажлын туршлага, шүүгчээр ажиллаж байсан нэр дэвшигчийн хувьд хянан шийдвэрлэсэн хэргийн шийдвэрийн чанар, олон нийтээс хүлээн авсан санал, нэр дэвшигчийн талаар бусад этгээдтэй болон нэр дэвшигчтэй хийсэн ярилцлагын дүн зэргийг судалсны үндсэн дээр тухайн нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг үнэлсэн үндэслэл бүхий тайлан бичиж, Ерөнхий зөвлөлийн бусад гишүүдэд хүргүүлж, хуралдаанд танилцуулна.

37.7.Ерөнхий зөвлөл нэр дэвшигчтэй ярилцлага хийсний дараа дараах зүйлийг үндэслэн нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг 30 хүртэл оноогоор үнэлэх бөгөөд 20, түүнээс дээш оноо авсан нэр дэвшигчийг уг шалгалтад тэнцсэнд тооцно:

37.7.1.нэр дэвшигчтэй хийсэн ярилцлага;

37.7.2.нэр дэвшигчийн баримт бичиг;

37.7.3.нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх хөндлөнгийн дүгнэлт;

37.7.4.олон нийтээс хүлээн авсан санал;

37.7.5.илтгэгч гишүүний тайлан;

37.7.6.бусад.

37.8.Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадвар болон мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалт тус бүрд өгсөн оноо, тэдгээрийн нийлбэр онооны дарааллаар эрэмбэлэн өөрийн цахим хуудаст байршуулж, нийтэд мэдээлнэ.

37.9.Энэ хуулийн 37.8-д заасан үнэлгээ хоёр жилийн хугацаанд хүчинтэй байна.

37.10.Шүүгчийн сонгон шалгаруулалт олон нийтэд ил тод байх бөгөөд шалгалттай холбогдуулан гаргасан Ерөнхий зөвлөлийн шийдвэр үндэслэл бүхий, оролцогч болон сонирхогч этгээдэд ойлгомжтой, нээлттэй байна.

37.11.Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчээс шалгалт авахдаа зохих журмын дагуу хөндлөнгийн хараат бус шинжээчийг оролцуулж болно.

37.12.Шалгалт авах арга, хэлбэр, үнэлэх аргачлал, нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх хөндлөнгийн дүгнэлт гаргах, олон нийтээс санал хүлээн авах болон холбогдох бусад харилцааг энэ хуулийн 74.1.5-д заасан журмаар зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Та бичгээр санал гаргачих. Төсөлтэй холбогдуулж шүү дээ тийм ээ. Санал хураалтад 12 гишүүн оролцож 8 гишүүн буюу 66,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Та чинь ажлын хэсгийн гишүүн шүү дээ таны оруулж ирсэн санал шүү дээ саяын санал чинь. Ажлын хэсгийн гишүүд цөөнх байхгүй. Бичгээр санал байхгүй байна. Төсөлтэй холбогдуулж бичнэ шүү дээ бас. Ажлын хэсгийн санал дээр биш та төсөлтэй холбогдуулж бичнэ. Мэдэхгүй тэр болох юм уу ярилцаарай ажлын хэсэг бас дахиад Мөнх-Оргил гишүүн Энхбаяр гишүүн ажлын хэсэг юм чинь дотроо ярилцаарай. Авах саналууд байвал бас уян хатан байгаарай.

Хуулийн төслийн 90 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан санал байна уу? 90 дээр, 90 дээр алга байна.

Хуулийн төслийн 91 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгийн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 58.Төслийн 91 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 91.1.9 дэх заалт нэмэх:

“91.1.9.иргэн, хуулийн этгээдээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасны дагуу шийдвэрлэж, хариу өгөх;” санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалт гишүүдээ. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 9 гишүүн буюу 75

хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гарсан санал байхгүй.

Хуулийн төслийн 92-той холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр санал гараагүй байна.

Хуулийн төслийн 93 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр санал гараагүй байна.

94 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 59.Төслийн 94 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 94.2 дахь хэсэг нэмэх:

“94.2.Улсын дээд шүүхийн шүүгч энэ хуулийн 94.1-д зааснаас гадна хэрэг, маргаан хянан шийдвэрлэхтэй холбоотой судалгаа хийх чиг үүрэг бүхий гурав хүртэлх судлаач туслахтай байх бөгөөд судлаач туслах нь хууль зүйн магистраас дээш зэрэгтэй, харьцуулсан эрх зүйн судалгаа хийх чадвартай байна.” олон туслахтай болох нь. Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 9 гишүүн буюу 75 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. 90 төслийн бичгээр гарсан гишүүдээс санал байхгүй байна.

Хуулийн төслийн 95 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр санал гараагүй байна.

Хуулийн төслийн 96 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр санал байхгүй байна.

Хуулийн төслийн 97 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гарсан саналаар санал хураалт явуулъя. Алга байна.

Хуулийн төслийн 98 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр санал байхгүй байна.

Хуулийн төслийн 99 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна.

Хуулийн төслийн 100 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар

санал хураалт явуулъя. 100. 60.Төслийн 100 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“100 дугаар зүйл.Шүүхийн сахилгын хороо

100.1.Энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий бие даасан байгууллага болох Шүүхийн сахилгын хороо /цаашид “Сахилгын хороо” гэх/ ажиллах бөгөөд улсын хэмжээнд нэг байна.

100.2.Сахилгын хороо орон тооны есөн гишүүнээс бүрдэнэ.

100.3.Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгч гишүүн нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан, сахилгын шийтгэлгүй, бусад гишүүн нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй, сүүлийн таван жил шүүгч, улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байна.

100.4.Сахилгын хорооны бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах шатны шүүхээс хоёр, анхан шатны шүүхээс нэг шүүгчийг Нийт шүүгчийн хуралдаанаас чуулганаас тийм ээ нууц санал хураалтаар сонгож, Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилох бөгөөд эдгээр гишүүн шүүгчээр ажиллаж байгаагүй иргэн байна.

100.5.Нийт шүүгчийн чуулган энэ хуулийн 79.12, 79.13, 79.14, 79.15, 79.16, 79.17, 79.18-д заасан журмаар Сахилгын хорооны шүүгч гишүүнийг нийтээрээ, чөлөөтэй, шууд, тэгш сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, олонхын саналаар сонгоно. Улсын Их Хурал энэ хуулийн 79.1, 79.2, 79.3, 79.4, 79.5, 79.6, 79.7, 79.8, 79.9, 79.10-т заасан журмыг баримтлан Сахилгын хорооны шүүгч биш гишүүнийг сонгон шалгаруулж, томилно.

100.6.Сахилгын хорооны шүүгч гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох ажиллагаанд хараат бус, нээлттэй, ил тод байдлыг хангах болон үүссэн асуудлыг шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай дэгийг Нийт шүүгчийн хуралдаан батална.

100.7.Сахилгын хорооны шүүгч биш гишүүнийг сонгон шалгаруулж, томилох ажиллагаанд хараат бус, нээлттэй, ил тод байдлыг хангах болон үүссэн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай журмыг Байнгын хороо энэ хуульд нийцүүлэн батална.

100.8.Сахилгын хорооны бүрэлдэхүүнд Ерөнхий зөвлөлийн гишүүн, шүүхийн захиргааны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, прокурор, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн болон сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан хүн орохыг хориглоно.

100.9.Сахилгын хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа зургаан жил байх бөгөөд зөвхөн нэг удаа сонгогдож, томилогдоно. Сахилгын хорооны гишүүний бүрэн

эрх сонгогдож, томилогдсоноор эхэлж, дараагийн гишүүн сонгогдож, томилогдсоноор дуусгавар болно.

100.10.Сахилгын хорооны шүүгч биш гишүүний албан тушаалын зэрэг зиндаа, цалин хөлс, нэмэгдлийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.

100.11.Сахилгын хорооны даргыг гишүүд дотроосоо нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа сонгоно. Сахилгын хорооны даргын сул орон тоо гарснаас хойш 14 хоногийн дотор даргыг сонгоно.

100.12.Сахилгын хороо бүрэн эрхийнхээ хүрээнд өргөдөл, мэдээлэл, гомдол, эсэргүүцэл, сахилгын хэргийг дангаар болон хамтын зарчмаар хянан хэлэлцэж, илээр санал хурааж, шийдвэрээ олонхын саналаар гаргана.

100.13.Сахилгын хорооны дарга, гишүүн нь хүний нэр төр, алдар хүнд, эрх, эрх чөлөөг хүндэтгэх, шударга байх, төвийг сахих, хууль дээдлэх, ялгаварлан гадуурхахгүй байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, гишүүний нэр хүндээ эрхэмлэх зарчмыг баримтална.

100.14.Сахилгын хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байна.

100.15.Сахилгын хорооны гишүүдийн гуравны хоёр нь бүрдсэнээр түүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэлдэхүүнтэйд тооцно.

100.16.Сахилгын хорооны дарга, гишүүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд аливаа этгээд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, заавар өгөх, үйл ажиллагаанд нь саад учруулахыг хориглоно.

100.17.Сахилгын хороо ажлын албатай байх бөгөөд бүтэц, орон тоо, үйл ажиллагааг зохицуулах дүрэмтэй байна.

100.18.Сахилгын хороо бие даасан төсөвтэй байх бөгөөд чиг үүргээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нөхцөлийг төр хангана.

100.19.Сахилгын хороо хэвлэмэл хуудас, тамга, тэмдэгтэй байна.

100.20.Сахилгын хорооны шийдвэр хууль ёсны, үндэслэл бүхий байх бөгөөд захирамж, тогтоол, магадлал хэлбэртэй байна.” санал гаргасан ажлын хэсэг. Нямбаатар гишүүн өөр үг байна уу? Алга байна. Үг байгаа юу тийм ээ, санал байгаа юм байна.

Х.Нямбаатар: Байнгын хорооны даргаа би одоо 2 удаа үг дараад та өгсөнгүй.

С.Бямбацогт: Уучлаарай харсангүй.

Х.Нямбаатар: Энэ 100.5 дээр нэг зүйлийг хэдүүлээ бас протоколд тэмдэглүүлээд үлдье гэж бодож байгаа юм. Энэ юу вэ гэхээр 100.5 дээр энэ сахилгын

хорооны гишүүдийг сонгох журмыг энэ хуулийнхаа 79.2-оор эш татаж байгаа юм. Тэгэхээр би юу гэж тэмдэглүүлж үлдэх гэж байгаа вэ гэвэл төрийн алба бас цаг заваа хэмнэж нэг комисс байгуулагдаад нэг комисс нь шүүхийн ерөнхий зөвлөлөө ч байгуулчихдаг. Сонгон шалгаруулчихдаг. Шүүгчийн сахилгын хороогоо ч гэсэн байгуулчхаж л хэрэгтэй байна. Энийг бүр протоколд ингэж тэмдэглээд дараа нь нөгөө Их Хурлын тогтоолоор ажлын хэсэг байгуулагдаж байгаа тохиолдолд энэ дээрээ энэ протоколоо үндэслээд явчихмаар байгаа юм.

Дараагийн дугаарт бол энэ хоёр маань хугацааны хувьд зөрнө. Нэг нь 4 жил, нэг нь 6 жилээр байгаа. Мэдээж хэрэг хугацаа зөрж байгаа тохиолдолд дараагийн комиссууд нь тухайн үедээ шинээр байгуулагддаг юм уу энэ зарчмаараа явчих байх гэж бодож байгаа. Тэгэхээр энийг би протоколд тэмдэглүүлъя. Тэгээд дараа нь Их Хурлын тогтоол гарахад тухайн үед хууль хэлэлцэх явцад протоколд миний тэмдэглүүлснээр явъя гэсэн энэ зүйлийг хэлж үлдэх гэсэн юм.

С.Бямбацогт: Нямбаатар гишүүний хэлж байгаа саналыг бас харгалзаж цаашид бас анхааръя. Хугацаа зөрөх болон өөр асуудал үүсэхгүй болов уу. Энэ бас анхаарах санал байх шиг байна. Ажлын хэсгийн саналаар дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцож 10 гишүүн буюу 83,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Адьшаа гишүүн санал гаргасан байгаа. Улсын Их Хурал сахилгын хорооны шүүгч биш гишүүнийг сонгон шалгаруулалтыг Улсын Их Хурлын даргын захирамжаар томилсон төрийн албаны зөвлөлийн дарга ахална гэж нэмэх. Санал гаргасан Адьшаа гишүүн. Саналаа тайлбарлаж үг хэлэх үү.

Ш.Адьшаа: Би түрүүн шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг Улсын Их Хурлаас томилдог зарчим дээр энэ байр сууриа илэрхийлсэн юм. Тэгэхээр шүүхийн сахилгын хорооны шүүгч биш гишүүдийг томилдог энэ зарчим дээр миний илэрхийлсэн байр суурь хэвээрээ байгаа. Цаг хэмнэх үүднээс энэ саналаа би тайлбарлахгүй шууд санал хураалт явуулъя гэсэн ийм бодолтой байна.

С.Бямбацогт: Адьшаа гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 12 гишүүн оролцож 9 гишүүн буюу 25 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй. 3 гишүүн дэмжсэн буюу. 3 гишүүн буюу 25 хувийн саналаар дэмжээд дэмжигдсэнгүй. 100-тай холбогдуулаад санал хураагдлаа.

101. Хуулийн төслийн 101 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

61.Төслийн 101 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“101 дүгээр зүйл.Сахилгын хорооны зөвлөгөөн

101.1.Сахилгын хорооны нийт гишүүнээс бүрдсэн Сахилгын хорооны зөвлөгөөн ажиллана.

101.2.Сахилгын хорооны зөвлөгөөн дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

101.2.1.Сахилгын хорооны хөдөлмөрийн дотоод журмыг хуульд нийцүүлэн батлах;

101.2.2.гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн, Сахилгын хорооны хуралдаан болон хянан үзэх хуралдаан /цаашид “хуралдаан” гэх/ даргалагчийн дарааллыг тогтоох;

101.2.3.Сахилгын хорооны гишүүнийг мэргэшүүлэх сургалтыг төлөвлөх, зохион байгуулах;

101.2.4.Сахилгын хорооны даргыг гишүүд дотроосоо сонгох;

101.2.5.сахилгын хэрэг, өргөдөл, мэдээлэл, гомдол хүлээн авах, хуваарилах болон сахилгын хэрэг хянан шийдвэрлэх гишүүн, бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журмыг энэ хуулийн 19.3, 19.4-д заасан нөхцөл, шаардлагад нийцүүлэн батлах;

101.2.6.сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай журмыг энэ хуульд нийцүүлэн батлах;

101.2.7.Сахилгын хорооны зөвлөгөөний дэгийг тогтоох;

101.2.8.Сахилгын хорооны гишүүн гурван сараас дээш хугацаагаар эмчилгээ хийлгэх бол чөлөө олгох;

101.2.9.Сахилгын хорооны ажлын албаны даргыг томилох, чөлөөлөх;

101.2.10.энэ хуулийн 40.4, 51.8-д заасан саналыг хянан үзэж, шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэх, энэ хуулийн 40.5-д заасны дагуу шүүгчийн бүрэн эрхийг сэргээх;

101.2.11.Сахилгын хорооны ажлын албаны ажилтны ёс зүйн дүрмийг батлах;

101.2.12.энэ хуулийн 85.8, 120.2-т заасан журам, энэ хуулийн 100.17-д заасан дүрмийг батлах;

101.2.13.Сахилгын хорооны ажлын албаны хагас, бүтэн жилийн ажлын тайланг сонсох;

101.2.14.энэ хуулийн 85.4-т заасны дагуу Ерөнхий зөвлөлийн гишүүнд сахилгын хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх, сахилгын хэрэг үүсгэсэн тохиолдолд хараат бус шинжээч томилох;

101.2.15.энэ хуулийн 102.2.6-д заасан мэдээлэлтэй танилцах;

101.2.16.энэ хуульд заасан бусад мэдээлэл. Заасан заасан гээд 2 орсон байна шүү. Анхаараарай тэр 101 дээр 2.15 дээр.

101.3.Сахилгын хорооны зөвлөгөөн нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байх бөгөөд ээлжит зөвлөгөөнийг улиралд нэгээс доошгүй удаа, ээлжит бус зөвлөгөөнийг Сахилгын хорооны дарга, эсхүл гишүүдийн гуравны нэгийн саналаар хуралдуулна.

101.4.Сахилгын хорооны гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор зөвлөгөөнийг хүчинтэйд тооцох бөгөөд энэ хуулийн 101.2-т заасан асуудлыг зөвлөгөөнд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана.” Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гарсан санал байхгүй тийм ээ.

Хуулийн төслийн 102 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

62.Төслийн 102 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“102 дугаар зүйл.Сахилгын хорооны гишүүн, даргын бүрэн эрх

102.1.Сахилгын хорооны гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд бүрэн эрхийнхээ хүрээнд захирамж гаргана:

102.1.1.хуралдааныг даргалах;

102.1.2.хуралдааныг товлон зарлах, хуралдуулах, сахилгын хэргийн оролцогчийг тогтоох;

102.1.3.хуралдааны бэлтгэлийг хангах ажлыг ажлын албатай хамтран зохион байгуулах;

102.1.4.бүрэлдэхүүнтэйгээр сахилгын хэрэг, гомдол, эсэргүүцэл хянан шийдвэрлэхэд оролцох;

102.1.5.бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байгаа сахилгын хэрэг, гомдол, эсэргүүцлийн талаар саналаа бие даан гаргах, тусгай саналтай бол бичгээр гаргаж, сахилгын хэрэгт хавсаргах;

102.1.6.сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасан дэг, журам, хугацааны дагуу явуулах нөхцөлийг бүрдүүлэх, хуралдааны дэг зөрчсөн сахилгын хэргийн оролцогч болон бусад этгээдэд хуульд заасан арга хэмжээ авах, шийтгэл оногдуулах;

102.1.7.Сахилгын хорооны даргад нэрээ дэвшүүлэх, хуульд зааснаар Сахилгын хорооны даргыг орлох;

102.1.8.багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх;

102.1.9.энэ хуульд заасан бусад бүрэн эрх.

102.2.Сахилгын хорооны дарга энэ хуулийн 102.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал, захирамж гаргана:

102.2.1.Сахилгын хороог дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

102.2.2.Сахилгын хорооны зөвлөгөөнийг товлон зарлах, бэлтгэлийг хангах, хуралдуулах, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

102.2.3.энэ хуульд өөрөөр заагаагүй бол хуралдааны даргалагч болон бүрэлдэхүүнийг томилсон шийдвэрийг албажуулах;

102.2.4.сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамааралгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдолд ажлын албаар дамжуулан хариу өгөх ажлыг зохион байгуулах;

102.2.5.Сахилгын хорооны гишүүнд энэ хуулийн 101.2.8-д зааснаас богино хугацааны чөлөө олгох эсэхийг Сахилгын хорооны зөвлөгөөнөөр хэлэлцүүлэн шийдвэрлэх, хөдөлмөрийн дотоод журамд заасан чөлөөг дангаар олгох;

102.2.6.өргөдөл, мэдээлэл, гомдол, эсэргүүцэл, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанар, үр дүн, сахилгын хэргийн хөдөлгөөний ерөнхий удирдлага, хяналтын талаар Сахилгын хорооны зөвлөгөөнд мэдээлэл хийх;

102.2.7.төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд төсвийн төсөл боловсруулж, хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

102.2.8.Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг нэгтгэж Сахилгын хорооны зөвлөгөөнд танилцуулах;

102.2.9.сахилгын хэргийн оролцогчоос гаргасан гишүүнийг татгалзан гаргах тухай хүсэлтийг энэ хуульд заасны дагуу шийдвэрлэх;

102.2.10.энэ хуульд заасан бусад бүрэн эрх.

102.3.Сахилгын хорооны даргыг түр эзгүйд, эсхүл сул орон тоо гарсан тохиолдолд дараагийн даргыг сонгох хүртэл Сахилгын хорооны хамгийн ахмад

настай гишүүн орлоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Сахилгын хороонд ажлынхаа тайланг хүргүүлнэ. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 91,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийнх нь 103 юу? Бичгээр санал байхгүй байна. Хуулийн төслийн 103 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна? Алга байна. Ажлын хэсгийн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

72.Төслийн 103 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 103, 104 дүгээр зүйл болгох:

“103 дугаар зүйл.Сахилгын хорооны дарга, гишүүний үүрэг, хориглох зүйл

103.1.Энэ хуулийн 100.13-т зааснаас гадна Сахилгын хорооны дарга, гишүүн дараах үүрэгтэй:

103.1.1.Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан чиг үүргээ хараат бусаар гүйцэтгэж, бусад гишүүний хараат бус байдалд хүндэтгэлтэй хандах;

103.1.2.албаны чиг үүргээ хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлэх;

103.1.3.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан албан тушаалтанд тавих хориглолт, хязгаарлалтыг дагаж мөрдөх;

103.1.4.энэ хуульд заасан бусад үүрэг.

103.2.Сахилгын хорооны дарга, гишүүнд дараах зүйлийг хориглоно:

103.2.1.илтгэгч гишүүнээр сонгогдсоноос бусад тохиолдолд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай харилцах, санаачилга гаргах, зөвшөөрөх;

103.2.2.бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулах, албан үүрэгтэйгээ холбоогүй зорилгоор ашиглах;

103.2.3.өөрийн, гэр бүлийн гишүүний эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөнөөс бусад тохиолдолд шүүхэд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, бусдыг төлөөлөх;

103.2.4.сахилгын хэргийн оролцогч болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдээс бэлэг, шан харамж, зээл, эд хөрөнгө, хандив, үйлчилгээ, бусад үнэ бүхий зүйл авах;

103.2.5.хараат бус, төвийг сахих байдалд харшлах улс төрийн үйл ажиллагаанд оролцох;

103.2.6.өөрийн, эсхүл бусдын ашиг сонирхлыг хангах зорилгоор албан тушаалын нэр хүндийг урвуулан ашиглах, зохисгүй байдал гаргах;

103.2.7.энэ хуулийн 52, 53.1, 54, 55, 84.2.1-д заасан хориглосон, хязгаарласан, үүрэгжүүлсэн зохицуулалтыг зөрчих;

103.2.8.энэ хуульд заасан бусад.

103.3.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Сахилгын хорооны дарга, гишүүн дараах тохиолдолд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах үүрэгтэй:

103.3.1.өргөдөл, мэдээллийг өөрөө, эсхүл түүний хамаарал бүхий этгээд гаргасан;

103.3.2.сахилгын хэргийн оролцогчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садан, эсхүл түүнтэй хувийн харилцаатай;

103.3.3.ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон;

103.3.4.тухайн хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал.

103.4.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх явцад Сахилгын хорооны гишүүний өөрийн, эсхүл сахилгын хэргийн оролцогчийн хүсэлтээр Сахилгын хорооны нэгээс илүү тооны гишүүнийг татгалзан гаргахыг хориглоно. Хуралдааны бүрэлдэхүүн хүрэлцэхээр байгаа бол энэ хуулийн 103.3-т заасан үндэслэлээр нэгээс илүү тооны Сахилгын хорооны гишүүнийг татгалзан гарах асуудлыг шийдвэрлэж болно.

103.5.Сахилгын хорооны дарга, гишүүнийг дараах үндэслэлээр огцруулна:

103.5.1.албан тушаалын байдал, эрх нөлөөгөө урвуулан ашиглаж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгосон;

103.5.2.албан үүрэгтэй нь холбоотой, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн нууцыг задруулсан;

103.5.3.гэм буруутайд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

103.5.4.энэ хуулийн 103.1, 103.2, 103.3-т заасныг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн.

103.6.Сахилгын хэрэгт шалгагдаж байгаа Сахилгын хорооны дарга, гишүүн энэ хуулийн 106.1.1-106.1.4-т заасан эрхийг эдэлнэ.

103.7.Сахилгын хорооны гишүүнийг бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан, эсхүл санал өгсөн шийдвэрийн агуулгад үндэслэн огцруулах, бусад сахилгын шийтгэл оногдуулахыг хориглоно. Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томьёоллоо санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 9 гишүүн дэмжсэн байна. 103 104 хоёрыг хамтад унших ёстой дутуу уншсан байна. Одоо уншаад тэгээд юу яая. Дахиад санал хураая.

104 дүгээр зүйл.Сахилгын хорооны гишүүнийг огцруулах, сахилгын бусад шийтгэл оногдуулах

104.1.Энэ хуулийн 103.5-д заасан зөрчил гарсан тухай өргөдөл, мэдээллийг Ерөнхий зөвлөлд гаргана.

104.2.Ерөнхий зөвлөл Сахилгын хорооны гишүүний талаарх өргөдөл, мэдээллийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор сахилгын хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх бөгөөд сахилгын хэрэг үүсгэсэн бол тухайн өргөдөл, мэдээллийн үндэслэлийг шалгах шинжээч томилно.

104.3.Шинжээч томилогдсоноосоо хойш 30 хоногийн дотор өргөдөл, мэдээлэлд дурдсан зөрчлийн талаарх баримт, мэдээллийг цуглуулж, хууль зүйн дүгнэлт гаргах бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

104.4.Шинжээч энэ хуулийн 103.5-д заасан сахилгын зөрчил гарсан байх үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан бол Ерөнхий зөвлөл уг дүгнэлтийг эрх бүхий этгээдэд даруй хүргүүлж, Сахилгын хорооны гишүүнийг огцруулах эсэх асуудлыг дараах журмаар шийдвэрлэнэ:

104.4.1.Сахилгын хорооны шүүгч гишүүнийг огцруулах асуудлыг энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан журмын дагуу хуралдааныг зохион байгуулж, Нийт шүүгчийн чуулганд оролцогчдын олонхын саналаар нууц санал хураалтаар шийдвэрлэх;

104.4.2.Сахилгын хорооны шүүгч биш гишүүнийг огцруулах асуудлыг Байнгын хороогоор хэлэлцэж, санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх.

104.5.Сахилгын хорооны дарга, гишүүн энэ хуулийн 103.1, 103.2, 103.3-т заасныг зөрчсөн үйлдэлд огцруулах шийтгэл оногдуулахааргүй бол зөрчлийн шинж, хэр хэмжээнд тохируулан зөрчилд хаалттай, эсхүл нээлттэй сануулах шийтгэлийг Сахилгын хороо оногдуулах бөгөөд уг асуудлыг шийдвэрлэхэд шалгагдаж байгаа гишүүнийг оролцуулахгүй. Зөрчлийн талаарх өргөдөл, мэдээллийг хүлээн авах, сахилгын хэрэг үүсгэх, шалгах, хянан шийдвэрлэх журмыг хараат бус, бодитой байх зарчимд нийцүүлэн Ерөнхий зөвлөл батална.” Санал гаргасан ажлын хэсье. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Огцрохгүй юм байна л даа сахилгын хорооны гишүүн чинь. Нийт шүүгчдийн чуулганаар огцрох нь байна шүү дээ. 4 жилд нэг удаа хуралдана шүү дээ тэгээд. Ээлжит бус тэгээд жилд нэг удаа хуралдаад байх уу тийм ээ. 2 хүн гарвал хагас жил. 11 гишүүн санал хураалтад оролцсоноос 8 гишүүний саналаар 72,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Энийг бас анхаарах ёстой байх шүү дээ. 9 гишүүнтэй тэгээд 9 гишүүн чинь 3 нь нэг зэрэг болчихвол яах вэ. Улирал болгонд асуудал гарвал яах вэ? Улирал болгон нийт чуулган хуралдах уу тийм ээ. Гайгүй байхаа тийм ээ. Гишүүдээс бичгээр гаргасан санал алга. Хуулийн төслийн 104 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгийн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

64.Төслийн 104 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“104 дүгээр зүйл.Сахилгын хорооны ажлын алба

104.1.Сахилгын хорооны ажлын албаны дарга хууль зүйн дээд боловсролтой, Төрийн албаны тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.

104.2.Ажлын алба Сахилгын хорооны дарга, гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

104.3.Ажлын албаны дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 104.3.1.ажлын албыг өдөр тутмын удирдлагаар хангах;
- 104.3.2.ажлын албаны ажилтанг томилж, чөлөөлөх;
- 104.3.3.төсвийг захиран зарцуулах;
- 104.3.4.ажлын тайланг Сахилгын хороонд тайлагнах;
- 104.3.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

104.4.Ажлын алба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

104.4.1.Сахилгын хороонд харьяалагдах өргөдөл, мэдээлэл, гомдлыг хүлээн авч бүртгэх;

104.4.2.өргөдөл, мэдээлэл гаргагчид сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцын талаар мэдээлэл өгөх;

104.4.3.Сахилгын хорооны болон ажлын албаны дарга, гишүүний өгсөн үүрэг, даалгаврыг зохих журмын дагуу шуурхай гүйцэтгэх;

104.4.4.захирамж, нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал, магадлал, тогтоол бэлтгэхэд Сахилгын хорооны гишүүнд туслах;

104.4.5.Сахилгын хорооны гишүүнийг шаардлагатай хууль тогтоомж, мэдээллээр хангах;

104.4.6.Сахилгын хорооны дарга, гишүүнд техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх;

104.4.7.хуралдааны бэлтгэлийг зохион байгуулах, шийдвэрийг албажуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах;

104.4.8.энэ хуульд заасны дагуу захирамж, тогтоол, магадлал, албан бичиг, бусад баримт бичгийг холбогдох этгээдэд хүргэх;

104.4.9.Сахилгын хорооноос гаргасан шийдвэрийн талаар бүртгэл хөтөлж, тайлан гаргах;

104.4.10.сахилгын хэрэг, Сахилгын хорооны шийдвэр, албан бичиг, бусад баримт бичгийг хадгалах, хамгаалах, зохих журмын дагуу архивлах;

104.4.11.хуульд заасан бусад чиг үүрэг.

104.5.Ажлын албаны дарга, ажилтан ажлын албаны ажилтны ёс зүйн дүрмийг мөрдөхөөс гадна энэ хуулийн 103.1, 103.2, 103.3-т заасан зохицуулалт нэгэн адил хамаарна.

104.6.Энэ хуулийн 104.5-д заасан үүргээ ажлын албаны ажилтан зөрчсөн тухай өргөдөл, мэдээллийг ажлын албаны даргад, ажлын албаны дарга зөрчсөн тухай өргөдөл, мэдээллийг Сахилгын хорооны зөвлөгөөнд гаргана.

104.7.Энэ хуулийн 104.6-д заасныг зөрчсөн ажлын албаны дарга, ажилтанд Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулна.” Санал гаргасан ажлын хэсгийн дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 8 гишүүн буюу 72,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Ажлын хэсгийн саналаар санал хураасан. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй.

105 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

65.Төслийн 105 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“105 дугаар зүйл.Шүүгчид холбогдох сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ерөнхий нөхцөл

105.1.Сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь энэ хуулийн 57.1-д заасан сахилгын зөрчлийн тухай өргөдөл, мэдээлэл /цаашид “өргөдөл, мэдээлэл” гэх/-ийг хүлээн авах, сахилгын хэрэг үүсгэх, шалгах, Сахилгын хорооны хуралдаанаар хянан шийдвэрлэх, гомдол, эсэргүүцэл гаргах, гомдол, эсэргүүцлийг хянан шийдвэрлэх ажиллагаанаас бүрдэнэ.

105.2.Сахилгын хороо шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэхдээ хууль дээдлэх, шударга, ил тод, хараат бус байх, өргөдөл, мэдээллийг заавал хянан шийдвэрлэх зарчмыг мөрдлөг болгоно.

105.3.Энэ хуулийн 108.2-т заасны дагуу сахилгын хэрэг үүсгэсэн бол өргөдөл, мэдээллээсээ татгалзсан эсэхээс үл хамааран сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна.

105.4.Сахилгын хорооны хуралдаан зарлахаас өмнө өргөдөл, мэдээлэлд дурдагдаагүй шүүгчийн сахилгын зөрчлийн шинжтэй үйл баримт сахилгын хэрэг хянан шийдвэрлэх явцад илэрсэн бол түүнд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулна.

105.5.Сахилгын зөрчилд холбогдох шүүгч /цаашид “холбогдох шүүгч” гэх/, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийг сахилгын хэргийн оролцогч гэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гаргасан санал 105 дугаар зүйлтэй холбоотой байхгүй байна.

106 дугаар зүйлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгийн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

66.Төслийн 106 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“106 дугаар зүйл.Сахилгын хэргийн оролцогчийн эрх, үүрэг

106.1.Сахилгын хэргийн оролцогч сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах эрхтэй:

106.1.1.өргөдөл, мэдээлэл, сахилгын хэргийн баримттай танилцах, тэмдэглэл хийх, хуулбарлан авах, амаар болон бичгээр тайлбар гаргах, нотлох баримт гаргаж өгөх;

106.1.2.хуралдаанд биечлэн болон цахимаар оролцох, тайлбар гаргах, хуралдааныг хойшлуулах талаар хүсэлтийг нэг удаа бичгээр болон цахимаар гаргах;

106.1.3.Сахилгын хорооны гишүүн, хуралдааны бүрэлдэхүүнийг энэ хуульд заасан үндэслэлээр татгалзан гаргах хүсэлт гаргах;

106.1.4.Сахилгын хорооны гишүүний гаргасан захирамж, Сахилгын хорооны магадлалыг эс зөвшөөрвөл энэ хуульд заасны дагуу гомдол гаргах.

106.2.Сахилгын хэргийн оролцогч болон бусад этгээд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах үүрэгтэй:

106.2.1.сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, хуралдааны дэгийг сахих;

106.2.2.Сахилгын хорооны дуудсанаар хүрэлцэн ирэх;

106.2.3.үнэн зөв тайлбар өгөх;

106.2.4.Сахилгын хорооны шаардсан нотлох баримтыг гаргаж өгөх.

106.3.Сахилгын хэргийн оролцогч болон бусад этгээд хуралдааны явцад дууны, дуу-дүрсний бичлэг хийх, утсаар ярихыг хориглоно. Энэ хориглолт энэ хуульд заасны дагуу хуралдааны тэмдэглэл хөтлөх зорилгоор дууны, дуу-дүрсний бичлэг хийхэд хамаарахгүй.

106.4.Согтуурсан, мансуурсан этгээдийг хуралдаанд оруулахыг хориглоно.

106.5.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, хуралдааны дэг зөрчсөн этгээдэд хуралдаан даргалагч урьдчилан сануулна. Дахин зөрчил гаргасан этгээдийг хуралдаан даргалагч хуралдааны танхимаас гаргаж, энэ тухай хуралдааны тэмдэглэлд бичиж, хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Процесс нь жаахан ерөнхий болоод байна уу үгүй юу. Хойшлох тусмаа гайгүй юу. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 8 гишүүн буюу 72,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 107 дугаар зүйлтэй холбогдуулан, гишүүдээс бичгээр санал байхгүй. Хуулийн төслийн 107 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгийн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

67.Төслийн 107 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“107 дугаар зүйл.Өргөдөл, мэдээлэл гаргах, хүлээн авах, хуваарилах

107.1.Сахилгын зөрчил гарсан гэж үзсэн хүн, албан тушаалтан, хуулийн этгээд холбогдох шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр Сахилгын хороонд өргөдөл, мэдээлэл гаргана.

107.2.Өргөдөл, мэдээллийг итгэмжлэгдсэн төлөөлөгч гаргасан бол төлөөлөх эрх олгосон баримт бичиг болон итгэмжлэлийг хавсаргана.

107.3.Сахилгын хороо өргөдөл, мэдээллийг хүлээн авч, хавсаргасан баримт, хуудасны тоог бүртгэх дэвтэрт бичиж, гарын үсэг зуруулан, баримт үйлдэх ба хуудасны тоо, огноо, цаг, минутыг тэмдэглэн баталгаажуулна.

107.4.Өргөдөл, мэдээллийг хүлээн авсан даруй энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар Сахилгын хорооны гишүүн /цаашид “илтгэгч гишүүн” гэх/-нд хуваарилна.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 9 гишүүн буюу 75 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гарсан санал 107 дугаар зүйлтэй холбоотой байхгүй байна.

Хуулийн төслийн 108 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Мөнх-Оргил гишүүн, өөр гишүүн байна уу? Алга байна.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ зарчмын зөрүүтэй саналын жаран найм дахь санал хураалт буюу томьёолол төслийн зуун наймдугаар зүйл шинээр өргөтгөж оруулж ирж байгаа юм. Тэр заалтаас болоод би яг одоогийн байдлаар ажлын хэсгийнхээ ихэнх саналыг дэмжиж байгаа боловч энэ заалтаас болоод ажлын хэсгийн дүгнэлт дээр гарын үсэг зурж чадахгүй байгаа юм. Энэ гишүүдээ ийм юм болчхоод байгаа юм. Хэрт. би зөв ойлгож байгаа бол шүү. Би зөв ойлгож байгаа бол өргөн барихдаа ийм байсан юм. Зуун наймын нэг нь, уучлаарай маскаа авчихъя. Илтгэгч гишүүн гомдол мэдээллийг хүлээн авсан өдрөөс хойш гуч хоногийн дотор шалгаж сахилгын хэрэг үүсгэх эсвэл үүсгэхээс татгалзах тухай захирамж гаргана гээд нөгөөдөх чинь шийдвэр гаргачхаж байсан байхгүй юу асуудлаа судлаад хэрэггүй юм байна гээд. Одоо манай ажлын хэсгээс томьёолсноор бол нөгөө бид нарын түрүүн тавин хоёрдугаар зүйл дээр томьёолсон нөгөө хориглосон дөчин зүйл байна шүү дээ. Энэ дөчин зүйлд хамаарсан байх юм бол тэр нь үнэн байна уу, худлаа байна уу, заавал сахилгын хэрэг үүсгэх хэрэгтэй болчхоод байгаа юм. Одоо нөгөө дөч дээр чинь бид нар одоо маш олон хориглолтуудын шүү дээ. Албан тушаалаа урвуулан ашиглахгүй, албаны машин унахгүй согтуугаараа ажилд ирэхгүй нууц задруулахгүй гээд л ерөөсөө бөөн нөгөө хориг оргилсон зүйлүүд оруулчихсан.

Тэгэхлээр яг энэ заалтаар явах юм бол би одоо юунаас болгоомжлоод байна вэ гэвэл шүүгч болгон дээр нэгээс хоёр бүр хамгийн багадаа шүү гомдол гарна. Энэ хүн одоо албан тушаал урвуулаад ашигласан, нууц задруулсан, албаны машинаа унасан одоо юу байдаг юм. Тэгэхлээр өргөн барьснаараа бол илтгэгч гишүүн нь гомдлыг нь аваад нэгдүгээрт процессын шаардлага хангасан байна. Хоёрдугаарт хурдхан одоо гуч хоногийн дотор үзчихэж байсан байхгүй юу. Худлаа юм байна. Эсвэл энэ ортой юм байна энэ дээр ер нь хэрэг үүсгэх хэрэгтэй юм байна гээд явж байсан юм.

Одоо болохлоор за гомдол чинь энэ хуулийн тавин хоёрдугаар зүйл буюу одоо энэ тавин долоогийн нэг тавин долоодугаар зүйлд заасан тэр асуудлаар байна уу, үгүй юу гэдгийг шалгаад л тэр асуудлаар байна нууц задруулсан байна гэдэг гомдол байна. Тийм учраас үнэн худлаа нь хамаагүй заавал хэрэг үүсгэх гээд байгаа байхгүй юу. Тэгэхлээр бид нар чинь явсаар байгаад байна шүү дээ, нөгөө яг эцсийн дүндээ бид нар энэ сахилгын хороо гэдэг чинь нөгөө манаачийг хэн манах вэ л гэдэг асуудлыг л зохицуулаад байна шүү дээ. Тэгсээр байгаад нөгөө манаачаа манах гэж байгаад нөгөө нуухыг нь авах гэж байгаад нүдийг нь сохлох гээд байна шүү дээ. Энэ таван зуун арван найман шүүгч дээр чинь байна шүү дээ бүгд дээр нь хэрэг үүснэ, нэг биш хэрэг үүснэ. Яг энэ процессоор явах юм бол. Асуудлаа шийдүүлсэн шийдүүлээгүй сэтгэл хангалуун, хангалуун бус, за ер нь хүн болгон л гомдол гаргана даа.

Тэгээд энэ процессоороо энэ шүүгч нар чинь ерөөсөө нөгөө сахилгын хороон дээрээ очоод л юмаа тайлбарлаад л зогсож байдаг хүмүүс болно. Тэгэхлээр би бол энд анх өргөн барьсан зуун наймын нэгийн илтгэж гишүүн гомдлыг нь хүлээж аваад гуч хоногийн дотор шалгаад сахилгын хэрэг үүсгэх үүсгэхээс татгалзах захирамжаа гаргаад тэрэнд нь харин гомдол гаргадаг процесс нь тусдаа байж болж байгаа байхгүй юу. Тэгэхгүй нөгөө шүүгч чинь нөгөө сахилгын хорооны гишүүн чинь гомдлыг нь аваад энэ үгүй юм байна, энэ бол ерөөсөө би үзлээ, харлаа материалуудыг нь үзлээ, гомдлыг нь харлаа, шүүгчээс тайлбар авлаа, энэ дээр сахилгын шийдэл сахилгын хэрэг үүсгээд байх хэрэг алга гэдэг энэ эрхийг өгөхгүй бол энэ сахилгын хороо чинь хэдэн мянган хэрэгт дарагдана. Хэдэн шүүгч нар чинь ерөөсөө сахилгын хорооны үүдийг сахиад л тэрэндээ тайлбар өгсөн хүмүүс бол дуусна шүү. Энэ шүүгч чинь ажлаа хийж чадахгүй шүү.

Тэгээд бид нар шүүхээ нөгөө манаачаа мануулах гэсэн биш манаачаа дээр нь дарж суучхаад ажлыг нь хийлгэдэггүй нөгөө хэдэн сахилгын хорооны гишүүд чинь энэ олон гомдлуудыг үзэж үзэж процесс явж явж тэр чинь дахиад гомдол гаргана гэж байгаа шүү дээ. Ингэж байгаад яг энэ процессоороо явах юм бол арван дөрвөн хоног гээд 14, 14, 45 хоногийн дараа гомдол бид нар үзлээ.../минут дуусав/

Б.Дэлгэрсайхан: Үгүй ээ, тэгээд та чинь өөрөө ажлын хэсэгт байгаа хүн чинь тэгээд ажлын хэсэг нэг ойлголтод хүрч чадаагүй юм уу? Тэгээд одоо Мөнх-Оргил гишүүний асуултад хэн хариулах юм. Мөнхсайхан ажлын хэсгээс.

О.Мөнхсайхан: Мөнх-Оргил гишүүн маш чухал асуудал хөндлөө тийм. Тэгээд одоо бол яадаг вэ гэхээр шүүгч шүүгчийн талаар одоо шүүгчийн сахилгын зөрчлийн талаар ирсэн гомдол болгон болгоныг үүсгэх эсэхээсээ өмнө бол шалгаад байгаа юм. Одоогийн практик. Тэгэнгүүт чинь яадаг вэ гэхээр ерөөсөө одоо тэрэн дээр заавал шүүгчээс тайлбар авна, шалгана их процесс явдаг. Гэтэл тэр яг манай монголд ирж байгаа энэ сахилгын зөрчлийн талаарх нийт гомдлын далаас наян хувь нь яг энэ харьяаллын биш, нөгөө шүүгчдийн хэлдэг шиг ерөөсөө л дээд шүүхэд давахаар шийдэгдэх юмнуудаа л өгчхөж байгаа байхгүй юу. Хэргийн агуулга. Тэгэхээр чи энэ нь бол яаж байна гэхээр нэгдүгээрт сахилгын хорооны ачааллыг үүсгээд, хэрэггүй, харьяаллын биш юм шалгаад.

Хоёрдугаарт тэр болгон дээр шүүгчээс заавал тайлбар авна гэхээр ерөөсөө шүүгч дээр тэн дээр тайлбар өгсөөр байгаад ачаалалдаа дарагддаг. Нөгөө талаар энэ нь хэрэг хянан шийдвэрлэхэд нь нөлөөлөөд байгаа юм. Тийм тэгээд энэ болохоор өөрөө яагаад орж ирсэн бэ гэхээр саяын асуудлыг нэгдүгээрт хийхийг зорьсон. Өөрөөр хэлбэл энэ зуун наймын нэгд заасан гурван зүйл, тавин долоод заасан тэр нөгөө сахилгын илэрхий зөрчлүүд ерөөсөө биш юм өгчихье, энэ шийдвэр буруу гарчхаж ч гэдэг юм уу, ийм бол одоо энийг шалгах шаардлагагүйгээр үүсэхээс татгалзчихна. Эсвэл хэрэг үүсгэхээс татгалзчихсан хэргийг нь хэрэгсэхгүй сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгочихсон, шийдвэр хүчин төгөлдөр байгаа бол наадхаар чинь шалгахгүй шүүгчээс тайлбар авахгүй гээд буцаачихна. Эсвэл энд хэн нь мэдээлэл өгч байгаа нь тодорхойгүй ийм байх юм бол бас буцаачихна гэдэг энийг ярьж байгаа юм. Энэ бол өөрөө бас манай практикт бас яг шүүхийн процесс бүр ихэнх нь ингэж явж байгаа. Одоо жишээ нь захиргааны хэргийг үүсгэхээд л шүүгч ажиллагаа хийдэг, шалгана, тайлбар авна. Хэрэг үүсгэхгүйгээр ажиллагаа хийдэггүй. Манай энэ суурь зарчимд нийцэж байгаа.

Гуравдугаарт олон улсын практик бас бид нар энэ дээр судалж байсан юм. Одоо америкийн мужуудын яг ийм сахилгын хороод европт ч гэсэн харьяаллын хэсгийг нь шууд screening хийнэ гээд одоо шалгах шаардлагагүй, ерөөсөө байж байгаа мэдээлэл нь харьяаллын биш^ Үөгөө тавин хоёрт байж байгаа жагсаалт байхгүй юм, эсвэл хэн нь мэдэгдэхгүй энэ нь бол шууд үүсгэхээс татгалзчихаж байгаа байхгүй юу. Тийм тэгэхээр энэ яг олон улсын жишигт байдаг энэ юу нь бас орж ирж байгаа. Энүүгээрээ бол шүүгчийнхээ нөгөө бас хараат бус байдлыг нь хамгаалж байгаа юм. Тэгэхгүй бол ирсэн гомдол мэдээлэл болгон дээр шүүгчээс тайлбар өг гээд байхаар жинхэнэ ачаалал үүсэхээр нөгөө яг нийт ирж байгаа өргөдөл гомдлын дал, наян хувь дээр ийм ажиллагаа хийх шаардлагагүй байгаа юм. Ганцхан юм гишүүнээ. Тэгээд энийг гурван гишүүн шал өөр гурван гишүүн хяначхаж байгаа юм угаасаа тэр үүсгэчихсэн хэрэг буруу байвал хэрэгсэхгүй болгочихно. Тэгэхээр энд бол шүүгчид бол ямар нэгэн байдлаар одоо зүй бус нөлөөлөл үүсэх ийм асуудал бол энэ дээр ерөөсөө гарахгүй.

Жирийн иргэдийн маргааныг хэрэг үүсгэж байж л шийддэг. Тэгэхээр тэр л зарчмаараа бид нар бас шүүгчийн асуудал дээр ч гэсэн тэгж явах нь зүйтэй болов уу. Олон улсын жишиг манай одоо суурь зарчимд бол энэ нь нийцэж байгаа юм.

С.Бямбацогт: Мөнх-Оргил гишүүн тодруулъя.

Ц.Мөнх-Оргил: Гишүүдээ энэ асуудалд онцгой хэдий орой болсон ч гэсэн энэ асуудалд онцгой анхаарал хандуулж өгөөч гэж би та хэдээс хичээнгүйлэн хүсэж байна. Тэгээд байна шүү дээ, энэ одоо манай Их Хурал байна шүү дээ нэг далан долоон гишүүнтэй болчихлоо. Манай Мөнхсайхан багш одоо ажлын хэсгийг төлөөлөөд л тайлбар хэлээд л сууж байдаг. Дээд шүүгч нарын шүүгч нарын урдур ороод л Их Хурлын гишүүдийн урдур ороод л олон улсын жишиг практик яриад л. Ингээд энэ одоо жоохон хэмжээ хязгаараа бид нар энийг нь тааруулж өгмөөр байна. Судлаач хүний саналыг бид нар сонсолгүй яах вэ. Тэгэхдээ ийм юм ярьж энд шүүхийг үймүүлж болохгүй. Эцсийн дүндээ энэ шүүхийг үймүүлээд хэн хариуцлага хүлээх юм. Олон улсын жишиг ярьсан Мөнхсайхан хүлээх юм уу? Бид нар энэ хууль баталчхаад бид нар хүлээх юм уу? Одоо байна шүү дээ миний гол хэлээд байгаа санаа ийм

байгаа байхгүй юу Бямбацогт даргаа. Тэр бид нарын зааж өгсөн дөчин асуудалтай холбоотой л гомдол гаргах юм бол шууд хэрэг үүсэж байгаа байхгүй юу. Тэр нь үнэн байна уу, худлаа.../минут дуусав/

С.Бямбацогт: Мөнх-Оргил гишүүний микрофоныг сунгая.

Ц.Мөнх-Оргил: Холбоотой л гомдол ирэх юм бол шууд. Дөчин асуудалтай холбоогүй миний хэргийг буруу шийдчихлээ ч гэдэг юм уу, давж заалдах шатныхаа шүүхтэй асуудалтай холбоотой юм явуулчих юм бол тэр буцаж байгаа юм. Гэхдээ тийм тэнэг гомдол гаргах хүн байхгүй байхгүй юу. Одоо энэ хууль чинь гараад ирэнгүүт ямар ч өмгөөлөгч байна шүү дээ энэ хуулийг чинь уншаад энэ шүүгчийг тэгвэл сахилгын хороонд өгнө. Юу гэж өгөх вэ албан тушаалаа урвуулан ашигласан, албаны машин унасан, улсын нууц задалсан, хувийн нууц задалсан гээд өгчихнө. Тэр өгчих юм бол энэ процессоороо Мөнхсайхан шууд хэрэг үүсэж байна за юу. Шууд хэрэг үүсгэж байна. Яагаад гэвэл энэ дөчин асуудал дотор чинь орчхож байгаа байхгүй юу гомдол чинь. Тэрэнтэй холбоотой гомдол ирчхэж байгаа юм. Тэр чинь худлаа юу, үнэн үү гэдэг бол ерөөсөө огт хамаагүй асуудал болчихоод процесс эхэлчхэж байгаа юм. Энэ чинь байна шүү дээ шүүгчийн сахилгын шийтгэл, шүүгчид сахилгын шийтгэл ноогдуулах процесс, иргэний захиргааны шүүхэд гаргасан гомдол, шийтгэл хоёр чинь шал өөр хоёр юм. Чи энийг ялгаж үз за юу. Сахилгын шийтгэл, сахилгын шийтгэл ярьж байна шүү дээ.

С.Бямбацогт: Энэ Засгийн өргөн барьсан төсөл дээр бол зуун наймын нэг дээр илтгэгч гишүүн гомдол мэдээллийг хүлээн авсан өдрөөс хойш гуч хоногийн дотор шалгаж сахилгын хэрэг үүсгэх эсхүл үүсэхээс татгалзах бол захирамж гарга гэсэн байгаа юм. Нэг гишүүн. Ажлын хэсгийнх дээр бол тавин долоодугаар зүйлд заасан зөрчилд хамаарахгүй бол татгалзана. Хамаарах юм бол хэрэг үүсгэнэ. Гэхдээ бас илтгэгч гишүүн гэсэн байна шүү дээ. Бас нэг л гишүүн. Цогт гишүүнийг сонсъё Улсын дээд шүүгч Цогт. Нэгдүгээр микрофон.

Ц.Цогт: Гишүүдийн анхааралд нэг зүйлийг хандуулъя гэж бодож байна. Тэгэхээр энэ шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр гомдол бол гардаг. Энэ тохиолдолд бол тухайн сахилгын хэрэг үүсгэсэн тохиолдолд үүсгэсэн шийдвэрт нь ядаж харьяаллын биш асуудлаар та нар сахилгын хэрэг үүсгэчихлээ гээд тэр холбогдсон шүүгч нь гомдлоо гаргаад яг тэр хэрэг үүсэх үүсэхгүй юу тэр шийдвэр дээр шийдвэрийг нь өөрийг нь тухайн үед нь хянуулдаг байх ийм зохицуулалт хийж өгвөл аль аль талдаа хэрэгтэй байна. Яагаад гэхээр одоо энэ төслөөрөө одоо энэ зарчмын зөрүүтэй саналаар явахаар нөгөө одоо сахилгын хороо ирсэн өргөдлийг аваад хэрэг үүсгэхээд, тэрэнд нь өгөөд шүүгч тухайн үед нь гомдлоо гаргаад энэ харьяаллын асуудал биш байна гээд шийдүүлэх боломж нь тухайн үедээ байхгүй, явсаар явсаар байгаад хэзээ хойно ямар нэгэн байдлаар шийдэх болчихоод байгаа юм л даа. Тэгэхээр энэ хооронд чинь нөгөө шүүгчийн чинь ажил хэргийн нэр хүнд холбоотой холбоогүй юман дээр хэрэг үүсгэгдээд сэтгэл санаа ингээд олон юм байдаг байхгүй юу. Үгүй ээ, үгүй. Үгүй ээ, үгүй та бүхэн та бүхэн саналаа хэлээд шийдэх байх. Гэхдээ та энэ зүйлийг бас та хэд маань анхаарч өгөхгүй бол.../үг тасрав/

С.Бямбацогт: Цогт шүүгч.

Ц.Цогт: Тэгэхээр зарчим бол юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр хэрэв иргэний гаргасан өргөдлийн дагуу сахилгын хороо хэрэг үүсгээд шалгах эрхтэй. Яг тэр шалгаж байгаа үед нь наад чинь танай харьяаллын асуудал биш байна гээд шүүгч хэрэв гомдлоо гаргавал тэрийг нь тэр үед нь шийдээд явчихдаг байвал процесс хэмнэнэ. Шүүгч талдаа ч, иргэн талдаа ч хий дэмий гомдол цааш нь ингээд явсаар байгаад эцэст нь хэрэгсэхгүй болгоод харьяаллын асуудал биш гэж шийдэх ийм нөхцөлөөс, үгүй ээ, үгүй та таны хэлээд байгаа чинь харьяаллын асуудал байхгүй юу даа. Өөрөөр хэлбэл та бүх асуудлыг хэрэг аваад үүсгэж байна гээд байна шүү дээ. Тэр чинь л өөрөөр хэлбэл шүүгч энэ энэ дээр чинь энэ сахилгын асуудал биш юм, мөн гэдэг тайлбараа хэлээд нөгөө хүн нь энэ сахилгын асуудал мөн юм гэдэг тайлбараа хэлээд л, тэрийг нь тэр гурван хүн нь хагалаад л тухайн үед нь шийдчихдэг л байвал болчих юм биш үү л гэж байгаа юм.

С.Бямбацогт: Ажлын хэсэг гишүүн Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Би яах вэ зүгээр сонсоод дахиад эргээд л бодож л байна л даа. Мөнх-Оргил гишүүний хэлээд байгаа бол зүгээр ийм л юм байгаа. Автоматаар сахилгын хэрэг шууд үүсчээд байна л гээд байна. Зуун наймын хоёроор чинь. Ганц тэрэн дээр л яриад байна л даа. Тэгэхээр энэ Засгийн газрын өргөн барьсан дээр бол нөгөө урьдчилсан хэрэг үүсгэхийн өмнөх гомдол мэдээллийг шалгах ийм ажиллагааны шат хийчхээд байгаа юм. Тэгэхээр бид нарын ажлын хэсгийн орсон энэ шатыг алга болгоод шууд хэрэг үүсгэхээд байгаа юм. Тэгэхээр гомдол бол урьдчилан ингэж хэрэг үүсгэхийн өмнө урьдчилсан ийм шалгалт хийгдэх юм хийгдэх юм биш үү. Шууд хэрэг үүсчихээр чинь зэрэг нөгөө шүүх чинь дуудагдаад бариад ингээд юм нь албан ёсны процесс нь эхлээд ингээд явчхаж байна гэдэг. Сая Цогт шүүгчийн зүгээр хэлж байгаа юмыг би сайн ойлгоогүй ч гэсэн нөгөө яг одоо ажил хэргийн нэр хүнд гэдэг шиг бас хэрэг үүсчихсэн гээгүй. Наана нь гомдол мэдээллийг урьдчилан шалгаж байгаа энэ ажиллагааны шатанд бол бас яах вэ шүүгч хүн чинь бас тэгээд л нэг юм хумаа яриад ингээд явж болох л байх л даа, тийм.

Тэгэхдээ энэ зүгээр яах вэ энд нэг ийм асуудал концепцын асуудал гарч байна шүү дээ. Автоматаар шууд хэрэг үүсгэж бол болохгүй л дээ. Ер нь бол яах вэ, энэ дээр зүгээр би энэ томьёолол дээр бид нарт нэг жоохон асуудал бол аль алинд нь бас байгаа байх. Татгалзана гэдэг нь нэг захирамж байгаа. Ийм гурван юман дээр бол татгалзана гэххэж байгаа юм. Тэгээд зуун наймын хоёр дээр бол энэ гурваас бусад тохиолдолд хэрэг үүсгэх захирамж гарна гэж байгаа. Гэхдээ энд нэг жоохон хийдэл байгаад байгаа байхгүй юу. Хийдэл. Энэ дотор бол би зүгээр зааснаас бусад тохиолдолд өргөдөл гомдол, мэдээллийг хүлээн авсан өдрөөс хойш долоо хоногийн дотор яг үүсгэх тухай захирамж гаргаж биш, долоо хоногийн дотор гомдол мэдээллийг шалгаж сахилгын хэрэг үүсгэх тухай одоо захирамж гаргая ч гэдэг юм уу, ийм шалгалтын нэг юм алдчихаад байна л даа энэ дээр нэг. Тийм юм байх шиг байна.

Шууд автоматаар бол үүсэж болохгүй л дээ энэ чинь. Шууд одоо ингээд л энэ гуравт хамаарахгүй бол хэрэг үүслээ гээд ингээд явчих гэхээр тэнд нэг шалгалт яваад тэгээд юу яах ёстой л доо. Үгүй ээ үгүй сахилгын хэрэг юм чинь тэгээд хэрэг үүсгэхийн тулд шалгалт л явж таарна л даа.

С.Бямбацогт: Цогтбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Үгүй ээ, үгүй яах вэ, хэн Энхбаярын хэлээд байгаа бол хэрэг үүсгэхгүйгээр шалгалт эхлэхгүй гэдэг ийм юм яриад байгаа юм. Үгүй ээ, үгүй. Харин тэгэхээр Энхбаярын энэ хэлээд байгаа дээр ийм юм байгаа байхгүй юу. Энхбаяр зөв хэлээд байгаа боловч энд нөгөө шууд цэцийн гишүүн чинь ингээд шалгадаг боловч тэр хэргээ үүсгэхээд гэж гэдэг дээр байж байхад энд нэг дутаад байгаа юм нь энэ чинь гээд шууд үүсчээд байгаа байхгүй юу. Манай энэ зуун найман хоёр дээр яах вэ шууд үүсчээд байгаа юм. Цэцийнх чинь бол шууд үүсэхгүй шүү дээ. Цэц бол харин тэр нь харагдаж өгөхгүй байна гээд байгаа байхгүй юу. Тэр нь бол нөгөө хэрэг үүссэний дараа болчихоод байна.

С.Бямбацогт: Цогтбаатар гишүүн санал хэлхэж ёстой, дараа нь Энхбаяр гишүүн. Нямбаатар гишүүн дараа нь.

Д.Цогтбаатар: Би нэг ийм юм бодох юм зүгээр аль аль нь л бодож үзэх санал яриад байна. Тэгээд энд Цогт шүүгч сая дундын хувилбарыг чинь гаргаад байгаа юм биш үү? Тэгэхлээр Цогт шүүгчийн хэлснийг та нар дахиад нэг сонсодох доо. Энэ хүн чинь бол байж болох хувилбар аль аль нь. Энэ дээр нэг юм яригдаж байна. Ингээд шүүгч шалгуулахаар нэр хүндэд нь одоо сэв сууна ч гэх шиг. Шалгуулах ёстой бол хэн ч шалгуулна. Шүүгч байгаад ч шалгуулахгүй гэдэг ойлголт байхгүй. Энэ дээр нэр хүндийн асуудал ярьж бусдыг айлгаад хэрэггүй. Иргэн болгон хэн ч шалгуулах боломжтой. Тэглээ гээд шүүхээр эцэслэн ер нь л тогтоогдоогүй бол тэр хүнийг бид нар буруугүй гэдэг тэр одоо гол үзэл чинь байж л байгаа шүү дээ. Тийм учраас тэрэн дээр зүгээр одоо яадаг юм, хэвлэл мэдээллээр янз бүрийн юм ярина уу энэ бол тусдаа асуудал. Эрх зүйн хувьд бол тэр хүн тогтоогдоогүй байхдаа буруугүй л байж байгаа. Тэгэхлээр тэр зарчим бол үйлчилж байгаа.

Энд гол яриад байгаа юм нь би Мөнх9Оргил сайдын нэг юмтай санал нэгдэж байна. Энэ чинь аваачаад шүүгчийг тэр нэр хүндийнх нь асуудал биш. Ажлыг нь хийлгэхгүй болчихвол нийгэмдээ хохиролтой болчихож байгаа байхгүй юу. Аваачаад ачаалаад байнгын тийм юмаар нээрээ л олон гомдол гарах байх. Тэгэхлээр ажлыг нь хийлгэх боломжийг энэ хуульдаа заавал бодож суулгаж өгөх ёстой. Тэгэхлээр тэрийг нэг хамгаалах гээд байгаадаа биш, нэг их сайн царайлах гээд байгаадаа биш, шалгадаг ч байх ёстой. Гэхдээ тэр ажлыг нь хийх боломжийг нь бас олгодог байх ёстой. Тэгээд тэр дундын хувилбар бол би энэ Цогт шүүгчийн юунаас гараад байна л гэж бодож байна.

С.Бямбацогт: Цогт шүүгч саналаа бэлдэж байя. Энхбаяр ажлын хэсгийн ахлагч дараа нь Нямбаатар сайд, тэгээд Цогт шүүгч.

Б.Энхбаяр: Энэ асуудлыг бол ажлын хэсэг дээр их олон өдөр ярьсан шүү нэг. Олон өдөр ярихдаа энэ бас юутай холбоотой байгаад байгаа вэ гэдгийгээ та бүхэн бас сайн бодоорой. Энэ сахилгын хорооны гишүүдийн тоотой холбоотой байгаад байгаа юм. Хэрэв арван хоёр байсан бол Мөнх-Оргил гишүүний хэлж байгаа агуулгаар шийдэж болно. Яагаад энэ тооноосоо хамаараад байна вэ гэхээр хуульд заасан хориглосон тавин хоёрдугаар зүйлд заасан тэр гучин ес дөчин арга хориглосон арга хэмжээг одоо бас хориглосон яг тэр арга хэмжээгээр бол гомдол гаргалаа. Яг энэ тохиолдолд бол шууд хэрэг үүсгээд шалгана. Тэгэхдээ нэг илтгэгч

шүүгч, сахилгын хорооны гишүүн. Энийг нь арван дөрвөн хоногийн дотор энэ үндэслэлгүй гаргачихлаа хэрэг үүсгэчихлээ гээд гомдлоо гаргах эрхтэй байгаа. Энэ тохиолдолд хоёр сахилгын хорооны гишүүн тэрийг нь шийднэ. Тэр нь эцсийн шийдвэр байна.

Ингээд нэг шүүгчийн гаргасан гомдол дээр гурван шүүгч урьдчилсан маргаанд оролцож байгаа байхгүй юу. Гурван шүүгч. Одоо нөгөө үндсэн зөрчсөн үү үгүй юу гэдэг яг нөгөө асуудлыг шийднэ. Одоо яг одоо бол урьдчилсан маргаан биш нөгөө жинхэнэ маргаанаа шийднэ. Тэр маргаан дотроо бас давж заалдах боломжтой байх ёстой. Өөрөөр хэлбэл урьдчилсан маргаанд оролцоогүй гурав биш, нөгөө гурав чинь биш дахиад давж заалдахад нөгөө гурав биш тав хянах ёстой байхгүй юу. Цэцийн процесс чинь тийм байгаа шүү дээ. Нэг шүүгч хэргээ үүсгээд, бага суудал нь гурав, дунд суудал нь тав, их суудал нь долоогоос ес. Бид нар ерөөсөө энэ тооноосоо хамаараад энэ процесс орж ирж байгаа юм. Хэрэв энэ санал хөндөгдвөл энэ өөрөө сахилгын хорооны гишүүдийн тоо руу орно. Дахиад энэ сахилгын хорооны энэ нэг шүүгчийн гомдол дээр гарсан шүүгчийг хэдэн сахилгын хорооны гишүүн шийдэх юм. Эсвэл бүр ганц тэр хүнийх нь шийдвэр дээр нь гомдол гаргахгүй байх юм уу, шууд эцсийн шийдвэр болж явах юм уу.

Хэрэв ингэвэл энэ өнөөдрийн процесс, өөрөөр хэлбэл нэг сахилгын ёс зүйн хорооны гишүүн нэг шүүгч дээр шууд хэргээ үүсгээд, хэргээ үгүйсгэхгүйгээр ажиллагаа явуулаад байгаа шүү дээ. Тэгэхээр тэр процесс руугаа буцаад орчихно гэсэн үг байхгүй юу. Бид нар уг нь энэ процессыг яагаад бичээд байна вэ гэхээр шүүгчээ хамгаалах гэж бичээд байгаа байхгүй юу. Сахилгын хорооны нэг, одоо нөхрийн дарамтаас болж. Сахилгын хорооны нэг гишүүн гэдэг тийм эрх мэдэлтэй байж болохгүй. Энэ эцсийн хянагдах боломж бол хамгийн багадаа гурван хүн энэ хэрэг маргааныг хянан шийдвэрлэх үүсгэх асуудал дээр оролцох ёстой гэж үзэж байгаа байхгүй юу. Тэр оролцоог нь зуун наймын долоогоор биччихээд байгаа байхгүй юу. Энэ шийдвэр дараагийн шатанд үндсэн маргаан шийдэгдээд давж заалдахаар чинь энд оролцоогүй сахилгын хорооны гишүүд шийдэхгүй бол эд нар чинь урьдчилаад анхнаас нь маргааныг нь үүсгэхээс эхлээд нөгөө урьдчилсан гэж гэж хэлэх үү, итгэл үнэмшил бий болчихсон. Урьдчилаад шийдвэр гаргачихсан учраас дараа нь энүүгээр хэргээ шийдүүлж байгаа тэр шүүгч чинь гомдол гаргана шүү дээ.

Энэ чинь урьдчилсан намайг хэрэг үүсгэж байсан хүнээр би дахиж давж заалдах асуудлаа шийдүүлэхгүй гэж хэлнэ шүү дээ. Тэгэхээр сахилгын хорооны шийдвэр чинь эцсийн байна гээд Үндсэн хуульд биччихээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ бүх асуудлаас болоод энэ тооноос улбаалаад ийм процесс бичигдчихээд байгаа байхгүй юу. Хэрэв ингэхгүй гэхээр энэ процесс бүхэлдээ задрах гээд байгаа байхгүй юу. Энийг бид нар их олон хоног ярьсан юм. Тоон дээр нь. Тэгээд уг нь бол одоо арван хоёр болгочихъё гээд. Тэгээд Засгийн газар өөрөө төсөл нь өөрөө ес орж ирсэн байх.

С.Бямбацогт: Нямбаатар гишүүн.

Х.Нямбаатар: Энхбаяр гишүүний хэлж байгаа шиг тийм процесс хаана ч байхгүй. Бүх төрлийн хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа заавал өргөдөл гомдол шалгах үе шаттай явагддаг. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргасан хүний мэдээллийг хүлээж

аваад цэцийн хуваарилагдсан гишүүн Үндсэн хуулийн маргаан үүсэх үү, үгүй юу гэдгийг шийддэг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа явагдахад нэхэмжлэгч нэхэмжлэлээ гаргаад нэхэмжлэлээр иргэний хэрэг үүсэх үү, үгүй юу гэдэг шийдвэр гаргадаг. Эрүүгийн хэрэг дээр сая Энхбаяр гишүүн шал буруу мэдээлэл өгч байна. Эрүүгийн хэргийн талаар гомдол гаргалаа. Өргөдөл гаргалаа. Харьяалагдаж мөрдөгч дээр хуваарилагдаад мөрдөгч арван ес хоног байх би хоногийн андуурч магадгүй. Энэ хугацаанд өргөдлийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээх үү, үгүй юу гэдэг шийдвэрээ тэр хугацаанд тухайн материал дээр нь өөрөө өргөдөл дээр нь ажиллагаа явуулж байж шийдвэрээ гаргадаг. Захиргааны хэрэг дээр мөн адилхан.

Тэгэхээр энд бол заавал өргөдөл шалгах үе шат гэж байх ёстой. Энхбаяр гишүүн бол ярьсныхаа эсрэг юмыг ярьж байна. Ингээд харин ч үүсгэснээрээ шүүгчийг хамгаалж байгаа юм гээд. Үгүй. Бүх юун дээр шүүгч дээр зөрчлийн хэрэг нээлээ. Хэрэг нээсэн тохиолдол болгонд шүүгч заавал тайлбар өгөх ёстой. Тэр хэргийг чинь хаахын тулд заавал нөгөө сахилгын зөрчилд одоо шалгагдаж байгаа хүнээс чинь сахилгын хэрэг нээгдсэн тохиолдолд заавал тайлбар өгнө. Тэгэхээр хэдэн мянган зөрчилд хэдэн мянган тайлбарыг нөгөө хэдэн шүүгч нар маань л өгөх ийм процесс явна. Илэрхий үндэслэлгүй өргөдөл гомдлыг нөгөө сахилгын хорооны гишүүн маань хүлээж аваад өргөдлийг үзээд шаардлагагүй гээд тайлбар өгч болно. Баян-Өлгий аймгийн сум дундын шүүхийн шүүгч энэ талаар юугаа одоо тайлбараа ирүүлээ гээд шуудангаар тайлбараа явуулна. Бүх шүүгч нарт зөрчлийн хэрэг үүссэн тохиолдол болгонд тайлбар өгнө.

Тийм учраас энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд заавал өргөдөл шалгах үе шат гэж байдаг. Энийг алгасаж шууд бүх зөрчил дээр өргөдөл гомдол дээр зөрчлийн хэрэг нээнэ гэдэг бол нөгөө шүүгч нарыг улам л хүндрүүлнэ гэсэн үг. Харин шүүгч нараа хайрлаж байгаа биш ажлыг нь хийлгэхгүй, хэдэн арван одоо зөрчлийн хэрэг дээр тайлбар өгөх ийм ажилтай дийлэнх цагаа өнгөрөөнө шүү. Энийг та бүхэн маань бас хараарай. Тийм учраас бүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өргөдөл шалгах үе шат гэж байдаг. Энийг өргөдөлд шалган шийдвэрлэх тэр эрх бүхий субъект нь хянаж үзээд өргөдөл нь одоо цаашид хэрэг үүсгэх шаардлагатай юу, үгүй юу гэдгээ одоо өөрсдөө шийдээд явдаг л ийм л зарчимтай. Тэгээд энэ дээр хэт ингээд бусад гишүүдийгээ жоохон хүндэтгэлтэй хандах хэрэгтэй. Бид нар одоо өнөөдөр чинь чамд загнуулж суулаа шүү дээ. Бүгд. Хуульд байхгүй үндэслэл ярь нь. Эрүүгийн хэрэг дээр ерөөсөө хэзээ ч хэрэг бүртгэлтийн хэрэг шууд нээхгүй шүү дээ.

С.Бямбацогт: Цогт шүүгч дараа нь хоёр гишүүн бэлдэж байгаарай.

Ц.Цогт: Нэг тайлбар хэлж болох уу гээд энэ дээр. Тэгэхээр яах вэ сая бас ажлын хэсгийн ахлагчийн хэлсэн тэр нөгөө урьдчилаад дөрвөн шүүгч хэрэг үүсгэхтэй холбоотой асуудал дээр оролцож байгаа учраас хойно нөгөө дахиж хянах дээр өмнө нь шийдсэн сахилгын хорооны гишүүн оролцох боломжтой байж сая энэ сахилгын хороо дотроо ажилладаг механизм ажиллана гэдэг ийм үндэслэл хэлсэн. Энэ бол бас үндэстэй. Тэгэхдээ энийг бол ийм байдлаар шийдвэл яасан юм бэ гэж бодож байна. Яагаад гэхээр та бүхэн маань энэ дээр нэг баланс адилхан пропорцтой байх байдлыг харгалзаж үзээч. Энэ одоо энэ зарчмын зөрүүтэй саналын төслөөр бол иргэн сахилгын хороонд гомдол гаргангуут сахилгын хороо хэрэв татгалзчихвал тэр иргэн арван дөрвөн хоногийн дотор гомдол гаргаад сахигын хорооны өөр гурван гишүүн

хэлэлцээд одоо тэр сахилгын хорооны татгалзсан гишүүний шийдвэрийг буруу байна гэж үзвэл дахиад энэ хүний гомдлыг шийдвэрлэхэд сахилгын хорооны дөрвөн гишүүн оролцож байгаа байхгүй юу ялгаагүй.

Тэгэхээр шүүгчийнх дээр болохоор, алив байж л даа. Би саналаа хэлье л дээ. Тэгэхээр энэ нэг юм хөдлөхөөр их олон зүйл хөдлөх болчихоод байгаа гэдэг агуулгаар л бас хэлж байна л даа. Тэрнээс, тэгэхээр хараа, ингэж байж болдоггүй юм уу гэж. Энэ гомдол гаргах гаргах эрхийг нь шүүгчид ч тэр, өргөдөл нэхэмжлэл гаргасан иргэн ч тэр энэ гурван гишүүнээрээ шийдэх бололцоог нь олгоод ингээд энэ маргаанаа таслаад явчихвал болохгүй юу. Тэгвэл хойно бүрэлдэхүүн дээрээ гомдол гаргахад оролцсон таслахад оролцсон гишүүн нь хяналт давахаар орж ирэхэд нь тэрийг нь дахиад шийдэхэд нь оролцоод явдаг л байж болно шүү дээ, Энхбаяр гишүүнээ? Үгүй ээ үгүй. Хэрэг үүсэхээ гурваар шийдэж байна шүү дээ. Нэг хүн шийдэж байна шүү дээ. Татгалзлаа, гурваараа шийдлээ. Дөрөв орлоо шүү дээ алин дээр нь ч гэсэн. Тэгвэл дараа нь дотроо хянахад нь тэр өмнө нь оролцсон гишүүд нь оролцоод явж болно шүү дээ.

С.Бямбацогт: Дэлгэрсайхан гишүүн саналаа хэлье.

Б.Дэлгэрсайхан: Үгүй ээ, энэ Нямбаатар сайдын ярьж байгаа үнэн байхгүй юу. Ямар ч хууль хяналтын байгууллага эхлээд өргөдөл аваад өргөдөл нь эрүү үүсгэх, хэрэг үүсгэх үндэслэл байна уу, үгүй юу гэдгийг шалгаж байж дараа нь хэрэг үүсгэдэг шүү дээ энэ чинь. Энэ чинь олон жил явж ирсэн практик шүү дээ. Тэгэхлээр зэрэг хүний тоо нэмэгдэхлээр болдог, хүний тоо өнөөдөр энүүгээрээ байхлаар болдоггүй гэдэг тийм утгагүй тайлбар байж болохгүй шүү дээ. Тэгээд Цогт шүүх ч гэсэн бас өөрөө нэг юмаа хоёр тал руу нь холбироод байх юм. Нэг л талдаа байя л даа. Эхлээд өргөдлийг хүн ямар ч одоо хууль хяналтын байгууллага аваад энэ өргөдөл гаргагч үнэн зөв ярьсан юм уу, үгүй юу гэдгийг нь шалгахгүй бол хор уршиг нь юу байна вэ гэхээр нэг шүүгчийг янаглах ажил болж байгаа байхгүй юу. Одоо бид нарын хэллэгээр гудамжны хэллэгээр бол. Тэгээд нөгөө ямар ч одоо хэргээ шалгуулж байгаа нөхөр өмгөөлөгчөөрөө дамжуулаад энэ шүүгч нэг л биш байна, энийг хэргээс холдуулчихъя гээд өргөдөл өгөөд ингээд наад сахилгын хороо чинь бол өргөдөл дарагдсан, хэрэгт дарагдсан нэг ийм л байгууллага болж хувирна шүү дээ.

Тэгсэн дор бол өргөдлийг тухай бүрд нь одоо хоног хугацааг нь заагаад төчнөөн хоногийн дотор бүр болж өгдөг бол долоо хоногийн дотор ч байдаг юм уу, өргөдлийг нь шалгаад хэрэг үүсгэх үндэстэй үндэсгүйг нь хэлээд л. Тэгээд цаашаа явъя л даа. Тэгэхгүй ингээд энэ ингээд олон бүлэг хөдөлнө гээд хэрэг үүсгэх ийм юм аваачиж болохгүй шүү дээ. Хэрэв шаардлагатай гэвэл энийгээ бүлгээ ахиад одоо ярьснаа ахиад задалж байгаад ахиад эхэлье л дээ тэгвэд. Тийм биз дээ.

С.Бямбацогт: Алтанхуяг гишүүн саналаа хэлье.

Н.Алтанхуяг: Ингэвэл яасан Энхбаяр даргаа. Ажлын хэсэг юм чинь. Энэ Мөнх-Оргил гишүүний хэлээд байгаа, энэ Нямбаатар сайдын одоо энэ Засгийн газрын өргөн барьсан дээр чинь ингээд нэг хоног авч гуч хоногийн дотор шалгаж сахилгын хэрэг үүсгэх эсвэл үүсгэхээс татгалзах тухай захирамж гаргана гээд. Нэг ийм, ийм хугацааг ямар нэгэн хэмжээгээр өгмөөр юм шиг байна л даа. Манай төсөл дээр

болохоор бид нар долоо хоногийн дотор сахилгын хэрэг үүсгэх тухай захирамж гаргана гэхээр л энэ дээр зөрчил үүсчээд байна л даа. Тэгэхээр хэдүүлээ ярьж байгаад гуч хоног нь байна уу, арван дөрвөн хоног нь байна уу, сахилгын хэрэг үүсгэх эсэх тухай асуудлыг төчнөөн хоногийн дотор одоо шийднэ гэдгээрээ, та нөгөө хүнээ түрээ орхичих. Есөн хүн дотроо баригдаад байхаар ингээд нөгөө баригдаад болж өгөхгүй байна. Тэгээд нэг хүнээрээ ингээд явуулаад. Тэгэхээр хэрэг шууд үүсээгүй байхгүй юу. Сахилгын хэрэг үүсээгүй. Тэгэхдээ манай энэ сахилгын хорооны нэг нөхөр энийг авчихсан. Хоногоо бол хэдүүлээ ярья. Энэ долоо хоног гэдэг бол ойрхон байж магадгүй. Арван дөрөв хоног ч юм уу, хэд хоног ч юм нэг хоног болоод.

Энийгээ шийдчихээд ийм хугацаа өгчихвөл яг Мөнх-Оргил гишүүний хэлээд байгааг бид нар хангачхаж байгаа юм. Тэр бас зөв ч байх. Шууд ингээд Алтанхуяг гэдэг нөхөр сахилгын хэрэг үүсчихлээ гэхээр тэнд ажил хийж яваа хүн дээр бас жаахан сонин байдал үүсэж магадгүй. Тан дээр ийм өргөдөл ирсэн. Энэ асуудлаар бид нар ингээд ингэж байна. Сахилгын хэрэг үүсгэх эсэх асуудлыг судалж байна гэвэл бас ч наанатай цаанатай. Тэрэн дээр нь Цогт гишүүн та нэг томьёолол яриад байна шүү дээ. Тэр шүүгчийн зүгээс нэг өгөх, өгөх гэдэг юм уу хандах нэг хандлага байна шүү дээ. Ийм хоёр юмыг комби хийчихвэл би энийг бол шийдчихэж болно гэж бодож байна. Есөн хүнээ тэгээд дахиад үлдсэн дээр нь хуваарилаад л явчихъя л даа. Болохгүй юм байхгүй шүү дээ. Одоо энэ байтугай л юм шийдлээ шүү дээ. Одоо тэгээд л бид нар чинь есийг чинь арван хоёр бас болгосон шүү дээ. Мөнх-Оргил гишүүн. Би бол тэр арван хоёр талд чинь байсан. Хүн чинь хүрэлцэхгүй аягүй хэцүү байна. Тэгээд арван хоёр биш ес гэдэг рүү аваачаад хийчихсэн л байгаа. Ийм зөрчил байгаа юм.

Тэгэхдээ энэ нэг том зөрчил биш нөхөд. Ингээд нэг уян хатан наана цаанаасаа яаж байгаад. Түрүүн манай Бямбацогт дарга эвтэйхэн зохицуулаад л байсан шүү дээ. Ингээд холболтыг нь хийгээд шийдчих л дээ. Энэ байтугай л юм шийднэ шүү дээ.

С.Бямбацогт: Энхбаяр гишүүн жоохон бас саяын гишүүдийн хэлж байгаа Алтанхуяг гишүүний хэлж байгаа, тэр Цогт шүүгчийн хэлж байгаа тэр тал руу бас саналаа жоохон өөрчлөх бололцоо байна уу? Ажлын хэсгийн ахлагч. Хэрэв тэгээд явах юм бол цаашаа үргэлжилье. Тэгэхгүй гэвэл хойшлуулъя одоо. Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Тэгэхээр манай гишүүдийн бас болгоомжлоод байгаа асуудал нь юу вэ гэхээр энэ ерөөсөө ингээд л шууд хэрэг үүсгээд л, тэгээд л нэр хүнд ч байхгүй болоод л нэг хэрэг үүсгэчихсэн хүн юм шиг болчхоод байгаа гэдэг нэг ийм л ер нь гол асуудал нь тэр байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энийг нь уг нь хааж та бүхэн зуун наймны нэгийг хар даа. Энэ чинь одоо байгаа практикийг халах гээд байгаа байхгүй юу. Дуртай юман дээрээ шүүгч дээр хэрэг үүсгээд, тэгээд шалгаж байна барьж байна гээд дуудаад л, тайлбар аваад л ингээд л байдгийг нь харин хязгаарлаад. Ерөөсөө энэ тавин хоёрдугаар зүйлд заасан тэр гучин ес юу дөчин асуудал дээр л ярина шүү. Тэрнээс одоо бусад буюу миний хэргийг хөнгөн шийдсэн хүнд шийдсэн гээд агуулга руу нь ороод ингээд байдаг тэр асуудлаар ерөөсөө гомдол саналыг нь авахгүй шүү гэдгийг нь шууд хэлчхэж байгаа чинь шүүгчдээ хамгаалалт, ингэж хамгаалахаас илүү яах юм бэ. Одоо надад хэлээд байна шүү дээ. Энэ шүүгчийн ёс зүйн хорооны таван жил ажиллалчихсан гишүүн чинь хэлээд байна шүү дээ.

Энэ ёс зүйн хороонд ирдэг гомдлын чинь далан хувь нь миний хэргийг хүнд хөнгөн шийдсэн гэдэг гомдол буюу агуулга руу орчихсон гомдол яриад байгаа байхгүй юу, ирдэг гэж. Тийм учраас тэр ирдэг буюу шүүгчийг нөгөө нөлөөндөө оруулах гээд байгаа, дарамтлах гээд байгаа тэр далан хувь гомдлыг чинь шууд хэрэг үүсгэхгүй гэж хэлж байгаа энэ зуун наймын нэг чинь өөрөө шүүгчдээ хамгаалаад байгаа байхгүй юу. Хэрэв үгүй гэж байгаа бол тэгээд энийг авбал харин эсрэгээрээ тэр тавин хоёрдугаар зүйлд заасан дөчин асуудлаас бүр хамаагүй болоод бүх асуудлаар сахилгын хороонд, нөгөө сахилгын хорооны гишүүд чинь хэрэг үүсгэх үү, үгүй юу гээд янагладаг юм чинь харин энэ ажлын хэсгийн саналаар чинь хаах гэж байгаа саналыг дэмжээгүйгээс болоод үүсэх гээд байна шүү дээ. Тийм байгаа биз дээ. Би буруу ойлгоод байгаа юм уу? Мөнхсайхан багшаа. Цогт шүүгчээ. Тэгээд байгаа биз дээ. Та нар ингээд нэг бодлын өөрсдийгөө хамгаалах гэж байна гэж нюанс гаргаж ингээд байгаа мөртөө яг тэр санал нь дэмжигдэхээр эсрэгээрээ энэ чинь энийг чинь бид нар их олон хоног ярьсан шүү дээ. Тэгээд л ингээд л гишүүдийн тархи толгой үймүүлээд л. Тэгээд гишүүд маань сайн бодол л доо. Яг энэний цаана яг ямар нюанс гарах гээд байгаа юм. Энэ ажлын хэсгийн санал унаад төслөөрөө үлдэхээр чинь төслийн чинь заалт тийм байгаад байгаа байхгүй юу. Тэр зөвхөн тавин хоёроос гадна ирсэн санал дээр хэрэг үүсгэхгүй гэсэн заалт байхгүй байгаа байхгүй юу. Бүгдийг нь шалгана гээд байгаа байхгүй юу. Эсрэгээрээ ийм болох гээд байна шүү дээ. Яг ярьсныхаа эсрэг, бодож байгаагийнхаа эсрэг ийм санал өгөх гээд байгаа байхгүй юу.

С.Бямбацогт: Үгүй ээ, харин тийм. Энхбаяр гишүүн тэр ойлгож болохгүй байгаа юм уу. За тэр тавин долоодугаар, тавин долоодугаар зүйлд заасан тийм үү? Тэр зөрчлүүд дээр хэрэг үүсгэх, үүсгэхгүй байх асуудлыг л шалгая гэдгээр явчихъя гээд гишүүд эхийг хэлээд байна шүү дээ. Заавал хэрэг үүсгэж шалгана биш тийм үү? Хэрэг үүсгэх, эсхүл үүсгэхээс татгалзах тухай. Одоо энэ Засгийн газрын төсөл дээр байгаа шүү дээ. Илтгэгч гишүүн гомдол мэдээллийг хүлээн авсан өдрөөс хойш гэдэг дээрээ бид нар 57 дугаар зүйлд заасан зөрчилд хамаарах гомдол мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоног гэдэг юм уу. Тэр дотор шалгаж сахилгын хэрэг үүсгэх эсхүл үүсгэхээс татгалзах бол захирамж гаргана. Ингээд л томьёолъё л доо. Ингээд л болж байна шүү дээ. Энийг ингээд л томьёолъё л доо. Харин тийм. Болж л байна шүү дээ. Тийм хэрэг үүсгэх эсэх тухай болгоод л 108.2 дээрээ. Ингээд өөрчилъё л дөө. Тэгээд хураалгая. Саяын зарчмаар уншаад хураалгалаа шүү. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. 108 дугаар зүйлтэй холбогдуулаад.

68.Төслийн 108 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“108 дугаар зүйл.Сахилгын хэрэг үүсгэх, үүсгэхээс татгалзах, гомдол хянан шийдвэрлэх

108.1.Илтгэгч гишүүн дараах тохиолдолд сахилгын хэрэг үүсгэхээс татгалзах тухай захирамж гаргана:

108.1.1.энэ хуулийн 57 дугаар зүйлд заасан зөрчилд хамаарахгүй бол;

108.1.2.өргөдөл, мэдээлэлд заасан үйл баримт, шүүгчийн үйл ажиллагааны талаар, эсхүл уг өргөдөл, мэдээллийн дагуу сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосон Сахилгын хорооны гишүүний

захирамж, Сахилгын хорооны магадлал, тогтоол, хянан үзэх хуралдааны тогтоол хүчин төгөлдөр байгаа;

108.1.3.өргөдөл, мэдээлэл гаргасан этгээд тодорхойгүй.

108.2.Илтгэгч гишүүн энэ хуулийн 108.1-д зааснаас бусад тохиолдолд өргөдөл, мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоног уу, 30 хоногийн дотор сахилгын хэрэг үүсгэх эсэх тухай тийм үү, эсхүл үүсгэхээс татгалзах тухай захирамж гаргана. Шалгаж захирамж гаргана. Ингээд энэнээс цаашаа процесс чинь бол ингээд явж болж байна шүү дээ.

108.3.Сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан захирамжийг гаргаснаас хойш даруй өргөдөл, мэдээлэл гаргагчийн оршин суугаа газар болон ажлын газрын аль нэг хаягаар баталгаат шуудангаар, эсхүл ажлын албаны ажилтнаар хүргүүлнэ. Уг захирамжийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор өргөдөл, мэдээлэл гаргагч Сахилгын хороонд гомдол гаргаж болно. Энэ хугацааны дотор гомдол гаргаагүй бол захирамж хүчин төгөлдөр болно.

108.4.Илтгэгч гишүүний энэ хуулийн 108.2, 109.11-д зааснаас бусад захирамжид гаргасан гомдлыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар томилогдсон хоёр гишүүний бүрэлдэхүүн /цаашид “гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн” гэх/-тэйгээр хэлэлцэж шийдвэрлэнэ. Уг бүрэлдэхүүнд илтгэгч гишүүн орохыг хориглоно.

108.5.Илтгэгч гишүүн нь шүүгч гишүүн бол гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүний хоёр гишүүн нь шүүгч биш байна. Илтгэгч гишүүн нь шүүгч биш бол бүрэлдэхүүний нэг нь шүүгч, нөгөө нь шүүгч биш гишүүн байна.

108.6.Сахилгын хорооны гишүүнд гаргасан татгалзал, эсхүл бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 108.5-д заасан шаардлага хангагдахгүй болсон бол энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар Сахилгын хорооны гишүүнийг гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүнд оруулж болох бөгөөд илтгэгч гишүүнийг оруулахыг хориглоно.

108.7.Гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүн дараах тогтоолын аль нэгийг гаргана:

108.7.1.захирамжийг хэвээр үлдээх, эсхүл захирамжийн үндэслэлийг өөрчлөн захирамжийг хэвээр үлдээх;

108.7.2.сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан захирамжийг хүчингүй болгож, сахилгын хэрэг үүсгэх.

108.8.Энэ хуулийн 108.7-д заасан тогтоолыг гомдол шийдвэрлэх бүрэлдэхүүний хоёр гишүүн санал нэгтгэйгээр гаргана. Санал нэгдээгүй бол захирамжийг хэвээр үлдээнэ.

108.9.Энэ хуулийн 108.8-д заасан тогтоол нь эцсийн шийдвэр байна.” санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Мөнх-Оргил гишүүнээ санал хураалт. Зассанаараа. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Энэ санал дэмжигдсэнтэй

холбогдуулан 108.2-г сая найруулсан тийм үү. Хэрэг үүсгэх болон хэрэг үүсгэхээс татгалзах гэж орсон шүү. Үүнтэй холбоотой тэр эсэх тухай. Үүнтэй холбоотой бусад заалтуудыг уялдуулж бас найруулаарай гэдгийг ажлын хэсэгт бас чиглэл болгож байна. Дараагийн санал. Одоо дөхөж байна шүү дээ. Одоо 6-хан санал байна. 108 болсон тийм ээ.

Хуулийн төслийн 109-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. 109 дээр асуулт алга байна. Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

69.Төслийн 109 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“109 дүгээр зүйл.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

109.1.Сахилгын хэргийг үүсгэснээс хойш 60 хоногийн дотор, сахилгын хэргийг дахин шалгуулахаар буцааснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Энэ хугацааг шаардлагатай тохиолдолд 30 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.

109.2.Илтгэгч гишүүн сахилгын хэргийг үүсгэсний дараа доор дурдсан шалгах ажиллагаа явуулна:

109.2.1.сахилгын хэрэг үүсгэсэн захирамж, тогтоол гарсан өдрөөс хойш 14 хоногийн дотор уг захирамж, тогтоолыг өргөдөл, мэдээллийн хуулбарын хамт холбогдох шүүгчид гардуулж, эсхүл энэ хуулийн 115.6, 115.7-д заасан журмаар хүргүүлж, энэ тухай баримтжуулах;

109.2.2.сахилгын хэргийн оролцогчид эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухайгаа баримтжуулах;

109.2.3.сахилгын хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, гэрчийг дуудаж мэдүүлэг авах, шинжээч, орчуулагч, хэлмэрч томилох болон шаардлагатай бусад ажиллагаа явуулах;

109.2.4.сахилгын хэргийн оролцогчийг дуудан ирүүлэх;

109.2.5.сахилгын хэрэг хянан шийдвэрлэх бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах;

109.2.6.шаардлагатай тохиолдолд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх хугацааг энэ хуульд заасны дагуу сунгах;

109.2.7.шаардлагатай тохиолдолд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасны дагуу түдгэлзүүлэх, сэргээх;

109.2.8.энэ хуульд заасан бусад ажиллагаа.

109.3.Холбогдох шүүгч энэ хуулийн 108.2-т заасан сахилгын хэрэг үүсгэсэн тухай захирамж, тогтоолыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор өргөдөл, мэдээллийн талаар бичгээр хариу тайлбар, нотлох баримт, нотлох баримт гаргах хүсэлт гаргаж болно.

109.4.Нэг шүүгчид холбогдуулан гаргасан хэд хэдэн өргөдөл, мэдээлэл, эсхүл хэд хэдэн шүүгчид холбогдуулан гаргасан нэг агуулга бүхий өргөдөл, мэдээлэлтэй хэд хэдэн сахилгын хэргийг нэгтгэн шалгаж, хянан шийдвэрлэж болно. Нэгтгэн гаргасан, эсхүл хэд хэдэн өргөдөл, мэдээлэл гаргасан болон хэд хэдэн шүүгчид

холбогдуулан гаргасан өргөдөл, мэдээллийн шаардлагатай нэг болон хэд хэдэн хэргийг тусгаарлаж болно.

109.5.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шаардсан нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээд илтгэгч гишүүнд гаргаж өгөх үүрэгтэй.

109.6.Илтгэгч гишүүн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1-д заасан үндэслэлээр сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг захирамж гарган түдгэлзүүлнэ. Түдгэлзүүлсэн нөхцөл байдал арилсан тохиолдолд илтгэгч гишүүн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээнэ.

109.7.Энэ хуулийн 109.6-д зааснаас бусад үндэслэлээр сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхийг хориглоно.

109.8.Сахилгын хэрэг шалгах ажиллагаа сахилгын хэргийн оролцогчоос бусад этгээдэд хаалттай байна.

109.9.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад энэ хуулийн 108.1, 108.2, 109.11-д зааснаас бусад асуудлаар гаргасан захирамжийг Сахилгын хорооны гишүүн ажлын гурван өдрийн дотор бичгээр гаргаж, сахилгын хэргийн оролцогчид даруй хүргүүлэх бөгөөд сахилгын хэргийн оролцогч уг захирамжийг хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор Сахилгын хороонд гомдол гаргах эрхтэй. Энэхүү захирамж илт үндэслэлгүй бол түүнийг гаргасан Сахилгын хорооны гишүүн хүчингүй болгох, эсхүл өөрчилж болно.

109.10.Сахилгын хэргийн оролцогч, эсхүл өргөдөл, мэдээлэл гаргагч энэ хуульд заасны дагуу илтгэгч гишүүний захирамжид гомдол гаргах хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтээ холбогдох нотлох баримтын хамт илтгэгч гишүүнд гаргах бөгөөд хүсэлтийг хангах эсэхийг илтгэгч гишүүн тухайн хүсэлтэд хавсаргасан баримтыг үндэслэн шийдвэрлэж, захирамж гаргана.

109.11.Сахилгын хэрэг үүсгэх тухай захирамж, тогтоол гаргаснаас хойш илтгэгч гишүүн 30 хоногийн дотор дараах дүгнэлт, саналын аль нэгийг Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамж гаргана:

109.11.1.сахилгын зөрчил гаргасныг нотлох дүгнэлт;

109.11.2.сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал.

109.12.Илтгэгч гишүүн энэ хуулийн 109.11-д заасан хугацааг зайлшгүй шаардлагатай тохиолдолд 30 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Гишүүд санал хураалт. Суугаарай. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Манай ажлын хэсгийн ахлагч, сайд хоёр хаачсан бэ, хууль санаачлагч хоёр. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Дараагийн санал.

110, гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй. Хуулийн төслийн 110 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулт байна уу? Гишүүд алга байна. Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

70.Төслийн Арван зургадугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 110, 111, 112, 113 дугаар зүйл нэмэх:

“110 дугаар зүйл.Нотлох баримт бүрдүүлэх ажиллагаа

110.1.Илтгэгч гишүүн сахилгын хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах үүрэгтэй.

110.2.Сахилгын хороо сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргуулан авах эрхтэй бөгөөд холбогдох этгээд гаргаж өгөх үүрэгтэй.

110.3.Холбогдох шүүгч хариу тайлбарын үндэслэлийн талаар нотлох баримтаа гаргаж өгөх ба гаргаж өгөх боломжгүй, түүнчлэн мэдэгдээгүй нотлох баримтын эх сурвалжийг заах үүрэгтэй.

110.4.Сахилгын хэргийн оролцогч өргөдөл, мэдээлэлтэй холбоотой нотлох баримттай хуралдаан товлороос өмнө танилцах эрхтэй.

110.5.Сахилгын хэргийн оролцогч, өргөдөл, мэдээлэл гаргагч, илтгэгч гишүүн хуурамч, хуульд заасан арга хэрэгслээр олж аваагүй нотлох баримт гаргахыг хориглоно. Энэ хэсэгт заасныг зөрчсөн гэм буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

110.6.Сахилгын хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргийн нотлох баримтаас хасах бөгөөд уг баримтыг шаардан гаргуулж болохгүй.

110.7.Хилийн чанадад нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай бол сахилгын хэргийн оролцогчийн хүсэлтээр, эсхүл Сахилгын хорооны санаачилгаар эрх бүхий байгууллагаар дамжуулан тухайн улсын зохих байгууллагад хандаж болно.

110.8.Нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор, тухайн сахилгын хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв талаас нь үнэлнэ.

110.9.Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, эсхүл Сахилгын хорооны шийдвэрээр нэгэнт тогтоогдсон болон нийтэд илэрхий үйл баримт сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй.

110.10.Нотлох баримт гаргах, цуглуулах талаар хууль бус аргаар олж авсан нотлох баримт нотлох чадвараа алдах бөгөөд Сахилгын хорооны шийдвэрийн үндэслэл болохгүй.

110.11.Сахилгын хэргийн оролцогчийн гаргасан тайлбар бодит үнэнд нийцсэн, сахилгын хэрэгт авагдсан нотлох баримтад үндэслэсэн байна.

110.12.Энэ хуулийн 110.11-д заасан этгээд өөрийн тайлбарт холбогдох өөрт байгаа болон гаргах боломжтой нотлох баримтыг өгнө.

110.13.Гэрчээр дуудагдсан этгээд Сахилгын хороонд заавал хүрэлцэн ирэх ба үнэн зөв мэдүүлэг өгөх үүрэгтэй.

110.14.Гэрч мэдүүлэг өгөхөөс татгалзах, зайлсхийх, эсхүл зориуд худал мэдүүлэг өгсөн бол хуульд заасан хариуцлага оногдуулна.

110.15.Гэрч өөрийн болон гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй.

110.16.Дараах хүнийг гэрчээр дуудах болон мэдүүлэг авч болохгүй:

110.16.1.үүргээ гүйцэтгэх замаар хэргийн нөхцөл байдлыг мэдэх болсон хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч;

110.16.2.иргэний эрх зүйн чадамжгүй этгээд.

111 дүгээр зүйл.Бичмэл нотлох баримт

111.1.Сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий бичгийн хэлбэртэй баримтыг бичмэл нотлох баримт гэнэ.

111.2.Бичмэл нотлох баримтыг Сахилгын хороонд эх хувиар нь, хэрэв тухайн баримтын эх хувийг өгөх боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг өгнө. Сахилгын хороо шаардлагатай гэж үзвэл тухайн баримтын эх хувийг шаардан авах эрхтэй.

111.3.Төрийн байгууллага, хуулийн этгээд нь бичмэл нотлох баримтыг өөрийн байгууллагын архивын “хуулбар үнэн” гэсэн тэмдэг дарж баталгаажуулна.”

112 дугаар зүйл.Шинжээчийн дүгнэлт

112.1.Тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулахын тулд илтгэгч гишүүн өөрийн санаачилгаар, эсхүл сахилгын хэргийн оролцогчийн хүсэлтээр шинжээч томилж болно.

112.2.Шинжээч шинжилгээ хийж дүгнэлт гаргахдаа Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан журмыг баримтална.

113 дугаар зүйл.Тэмдэглэл

113.1.Сахилгын хорооны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх тохиолдолд хуралдааны тэмдэглэл үйлдэнэ.

113.2.Хуралдааны тэмдэглэлийг ажлын алба хөтөлж, хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж байгаа гишүүн албажуулна.

113.3.Тэмдэглэлд ямар ажиллагааг хэн, хэзээ, хаана явуулсан, эхэлсэн, дууссан цаг, ажиллагаанд оролцсон болон байлцсан хүн нэг бүрийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, ажиллагааны дараалал, явц, илэрсэн нөхцөл байдлыг бичнэ.

113.4.Тэмдэглэлийг уг ажиллагаа явуулахад оролцсон болон байлцсан хүнд танилцуулах бөгөөд тэмдэглэлд засвар оруулахаар санал гаргах эрхтэйг тайлбарлаж өгнө” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 84,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. 110 дугаар зүйлтэй холбогдуулан бичгээр гишүүдээс санал байхгүй.

Хуулийн төслийн 111 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. 111 чинь явсан биз дээ. 110-тай холбоотой. Төслийн 110 дугаар зүйлтэй холбоотой ажлын хэсгээс гарсан санал байна.

71.Төслийн 110 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 114 дүгээр зүйл болгох: санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Унших юм байна шүү. Уучлаарай санал хураалтыг хүчингүй болголоо. Санал хураалт хүчингүй. Уншина.

“115 дугаар зүйл.Сахилгын хорооны хуралдаан

115.1.Сахилгын хорооны хуралдааны бүрэлдэхүүнд энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар томилогдсон гурван гишүүн орно.

115.2.Сахилгын хорооны хуралдааны бүрэлдэхүүний хоёр нь шүүгч биш гишүүн, нэг нь шүүгч гишүүн байх бөгөөд илтгэгч гишүүн орохыг хориглоно.

115.3.Сахилгын хорооны хуралдааныг энэ хуулийн 101.2.2-т заасан дарааллын дагуу бүрэлдэхүүний аль нэг гишүүн даргална.

115.4.Сахилгын хорооны хуралдааныг доор дурдсан дарааллаар явуулна:

115.4.1.даргалагч хуралдааныг нээж, хянан шийдвэрлэх гэж байгаа сахилгын хэргийн талаар танилцуулах;

115.4.2.хуралдааны ирцийг нарийн бичгийн дарга бүртгэж, ирээгүй оролцогчид хуралдааны товыг урьдчилан мэдэгдсэн эсэх, ямар шалтгаанаар ирээгүй болохыг хуралдаан даргалагчид танилцуулах;

115.4.3.сахилгын хэргийн оролцогчтой танилцаж, төлөөлөх бүрэн эрхийг шалгаж, эрх, үүргийг тайлбарлах;

115.4.4.даргалагч бүрэлдэхүүнийг танилцуулан, татгалзан гаргах эрхийг сахилгын хэргийн оролцогчид тайлбарлан өгөх;

115.4.5.сахилгын хэргийн оролцогчийн зүгээс шинээр нотлох баримт гаргаж өгөх эсэхийг асуух;

115.4.6.сахилгын хэргийн оролцогчийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэх;
115.4.7.илтгэгч гишүүн гомдол, хүсэлт, сахилгын зөрчил гарсныг нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг танилцуулах;
115.4.8.сахилгын хэргийн оролцогчийн тайлбарыг сонсох;
115.4.9.гэрчийн мэдүүлэг сонсох, нотлох баримтыг шинжлэн судлах;
115.4.10.хуралдаанд оролцогч болон илтгэгч гишүүнээс асуулт асууж, хариулт авах;
115.4.11.сахилгын хэргийн оролцогч болон илтгэгч гишүүнээс нэмэлт тайлбарыг сонссоны дараа хуралдаан завсарлаж, бүрэлдэхүүн шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орох.

115.5.Зөвлөлдөх үед гишүүд хэлэлцэж байгаа асуудлаар ил санал хурааж, олонхын саналаар шийдвэрлэнэ. Сахилгын хорооны гишүүн санал өгөхөөс татгалзах, түдгэлзэх эрхгүй бөгөөд нэрийн эхний үсгийн цагаан толгойн дарааллаар саналаа хэлнэ. Зөвлөлдөх тасалгаанд гаргасан гишүүний санал нууц байна.

115.6.Сахилгын хорооны хуралдааныг нээлттэй явуулна. Хэргийн нотлох баримт, үйл явдал нь төрийн болон албаны, байгууллагын, хувь хүний нууцад хамаарах бол сахилгын хэргийн оролцогчийн хүсэлтээр, эсхүл гишүүний санаачилгаар хуралдааныг бүрэн, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулж болно.

115.7.Сахилгын хорооны хуралдааны тэмдэглэлийг ажлын албаны ажилтан хөтөлж, хуралдаан даргалагч болон ажилтан ажлын долоон өдрийн дотор тэмдэглэлд гарын үсэг зурж, тэмдэг дарна.

115.8.Сахилгын хорооны гишүүнд гаргасан татгалзал, эсхүл бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 115.2-т заасан шаардлага хангагдахгүй болсон бол энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар Сахилгын хорооны хуралдааны бүрэлдэхүүнд нэгээс илүүгүй гишүүнийг оруулж болох бөгөөд илтгэгч гишүүнийг оруулахыг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 84,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гарсан санал байхгүй.

Хуулийн төслийн 114 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт алга байна. Ажлын хэсгээс бэлдсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

72.Төслийн 111 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 115 дугаар зүйл болгох:

“115 дугаар зүйл.Сахилгын хорооны хуралдааны шийдвэр

115.1.Сахилгын хорооны хуралдаанаар сахилгын хэргийг хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

116.1.1.нотлох дүгнэлтийг хүчингүй болгож, сахилгын хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох;

116.1.2.сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг хүлээн авч, сахилгын хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох;

116.1.3.нотлох дүгнэлтийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүлээн авч, шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах;

116.1.4.шүүгчийн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх;

116.1.5.сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал, эсхүл нотлох дүгнэлтийг хүчингүй болгож, дахин шалгуулахаар илтгэгч гишүүнд буцаах.

116.2.Сахилгын хорооны хуралдаан энэ хуулийн 116.1.1, 116.1.2, 116.1.3-т заасны дагуу сахилгын хэргийг шийдвэрлэж, магадлал гаргана.

116.3.Сахилгын хорооны хуралдаан энэ хуулийн 116.1.4, 116.1.5-д заасан болон хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой бусад асуудлаар тогтоол гаргах бөгөөд тогтоол нь эцсийн шийдвэр байна.

116.4.Тогтоол, магадлал уншиж сонсгосноор хүчинтэй болох бөгөөд даргалагч, гишүүд гарын үсэг зурж, тамга дарж албажуулна. Бүрэлдэхүүнд орсон гишүүд тогтоол, магадлалд гарын үсэг зурахаас татгалзах эрхгүй.

116.5.Сахилгын хорооны хуралдаанаас гаргах тогтоол, магадлал нь дараах агуулга бүхий удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсэгтэй байна:

116.5.1.удиртгал хэсэгт тогтоол, магадлалыг хэзээ, хаана гаргасан, бүрэлдэхүүнд орсон гишүүдийг нэрлэн заах;

116.5.2.тодорхойлох хэсэгт нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох санал, түүний үндэслэл болон сахилгын хэргийн оролцогчийн тайлбарын агуулгыг тусгах;

116.5.3.үндэслэх хэсэгт нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналын талаар хууль зүйн үндэслэл, нотлогдсон байдлын талаар заах;

116.5.4.тогтоох хэсэгт сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд үндэслэсэн хуулийн холбогдох заалт, шийтгэлийн төрөл, нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг хэрхэн шийдвэрлэсэн болон гомдол гаргах талаар тодорхой тусгах;

116.5.5.тогтоох хэсэг нь захиран тушаах хэлбэртэй байх.

116.6.Сахилгын хорооны тогтоол, магадлалыг гаргаснаас хойш 14 хоногийн дотор сахилгын хэргийн оролцогч болон өргөдөл, мэдээлэл гаргагчийн оршин суугаа газар болон ажлын газрын аль нэг хаягаар баталгаат шуудангаар, эсхүл ажлын албаны ажилтнаар хүргүүлнэ.

116.7.Энэ хуулийн 116.6-д заасны дагуу хүргүүлснээр магадлалыг гардан авсанд тооцох бөгөөд энэ нь гомдол гаргах хугацааг тоолох үндэслэл болно.

116.8.Энэ хуулийн 116.7-д заасны дагуу Сахилгын хорооны магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор сахилгын хэргийн оролцогч гомдол, илтгэгч гишүүн эсэргүүцэл Сахилгын хороонд гаргаж болно.

116.9.Сахилгын хэргийн оролцогч, эсхүл илтгэгч гишүүн энэ хуулийн 116.8-д заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтээ холбогдох нотлох баримтын хамт магадлал гаргасан бүрэлдэхүүнд гаргах бөгөөд хүсэлтийг хангах эсэхийг уг бүрэлдэхүүн тухайн хүсэлтэд хавсаргасан баримтыг үндэслэн шийдвэрлэж, тогтоол гаргах бөгөөд тогтоол нь эцсийн шийдвэр байна.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 84,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

Хуулийн төслийн 116 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

73.Төслийн 112 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 116, 117 дугаар зүйл болгох:

“116 дугаар зүйл.Сахилгын хорооны хуралдаанд бэлтгэх ажиллагаа

116.1.Илтгэгч гишүүн нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх захирамж гаргаснаас хойш 14 хоногийн дотор энэ хуулийн 114.1-д заасан хуралдааныг товлон зарлаж, хуралдуулна.

116.2.Хуралдаан болохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө нотлох дүгнэлт, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох саналыг сахилгын хэргийн оролцогчийн оршин суугаа газар болон ажлын газрын аль нэг хаягаар баталгаат шуудангаар, эсхүл ажлын албаны ажилтнаар хүргүүлнэ.

116.3.Ажлын алба Сахилгын хорооны хуралдааны товыг бүрэлдэхүүний гишүүдэд мэдэгдэж, хуралдаан болохоос ажлын гурваас доошгүй хоногийн өмнө энэ хуулийн 109.11-д заасан захирамжийг холбогдох баримтын хамт хүргүүлнэ.

116.4.Сахилгын хэргийн оролцогчид Сахилгын хорооны хуралдаан болохоос долоогоос доошгүй хоногийн өмнө товыг мэдэгдэж, энэ тухай баримт үйлдэж, сахилгын хэрэгт хавсаргана. Сахилгын хэргийн оролцогч Сахилгын хорооны хуралдааны товыг лавлах үүрэгтэй.

116.5.Сахилгын хорооны хуралдаанд сахилгын хэргийн оролцогч оролцож болно. Сахилгын хэргийн оролцогч хуралдаан болохоос өмнө хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хүрэлцэн ирэх боломжгүй тухай хүсэлтээ бичгээр болон цахимаар ирүүлсэн бол хуралдааныг хойшлуулж болох бөгөөд хэргийг хянан шийдвэрлэх хугацаа сахилгын хэрэг үүсгэснээс хойш 90 хоногоос хэтрэхгүй.

116.6.Сахилгын хорооны хуралдаан болохоос долоогоос доошгүй хоногийн өмнө товыг өргөдөл, мэдээлэл гаргагчид мэдэгдэж энэ тухай баримт үйлдэж, сахилгын хэрэгт хавсаргана. Өргөдөл, мэдээлэл гаргагч нь гэрчээр дуудагдсанаас бусад тохиолдолд хуралдаанд ажиглагчаар оролцож болно.

116.7.Бүрэлдэхүүнд орсон гишүүнийг энэ хуулийн 103.3-т заасан үндэслэлээр татгалзан гаргах тухай сахилгын хэргийн оролцогчоос хүсэлт гаргавал тухайн гишүүнийг байлцуулахгүйгээр бүрэлдэхүүн уг асуудлыг шийдвэрлэнэ. Бүрэлдэхүүний санал тэнцсэн тохиолдолд тухайн гишүүнийг татгалзан гаргаж, хуралдааныг хойшлуулах тухай тогтоол гаргана.”

117 дугаар зүйл.Сахилгын хорооны хянан үзэх хуралдаан

117.1.Энэ хуулийн 116.8-д заасан гомдол, эсэргүүцлийг бичгээр гаргаж, дараах зүйлийг тусгана:

117.1.1.сахилгын хэргийн оролцогчийн, эсхүл илтгэгч гишүүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал;

117.1.2.магадлалын огноо, дугаар;

117.1.3.магадлалыг эс зөвшөөрсөн үндэслэл;

117.1.4.гомдол, эсэргүүцлийн шаардлага.

117.2.Сахилгын хорооны магадлалд гаргасан гомдол, эсэргүүцлийг энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар томилогдсон гурван гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх бөгөөд уг бүрэлдэхүүн нь дараах шаардлагыг хангасан байна:

117.2.1.бүрэлдэхүүний хоёр нь шүүгч гишүүн, нэг нь шүүгч биш гишүүн байх;

117.2.2.Сахилгын хорооны тухайн магадлал гаргасан бүрэлдэхүүнийг оролцуулахгүй;

117.2.3.илтгэгч гишүүнийг оролцуулахгүй.

117.3.Сахилгын хорооны гишүүнд гаргасан татгалзал, эсхүл бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 117.2.1, 117.2.2-т заасан шаардлага хангагдахгүй болсон бол Сахилгын хорооны бусад гишүүнээс энэ хуулийн 101.2.5-д заасан журмаар хянан үзэх хуралдааны бүрэлдэхүүнд оруулж болох бөгөөд илтгэгч гишүүнийг оруулахыг хориглоно.

117.4.Сахилгын хорооны магадлалд гаргасан гомдол, эсэргүүцлийн үндэслэлд Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцээгүй шинэ нотлох баримтыг заах эрхгүй.

117.5.Энэ хуулийн 101.2.2-т заасан дарааллын дагуу томилогдсон хуралдаан даргалагч Сахилгын хорооны магадлалд гомдол, эсэргүүцэл гарсан талаар илтгэгч гишүүн, сахилгын хэргийн оролцогчид мэдэгдэж, танилцах боломжоор хангана.

117.6.Сахилгын хэргийн оролцогч гомдлоосоо татгалзсан бол гомдол гаргаагүйд тооцно.

117.7.Илтгэгч гишүүн эсэргүүцлээсээ татгалзах эрхгүй.

117.8.Сахилгын хорооны магадлалд гаргасан гомдол, эсэргүүцлийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор Сахилгын хорооны хянан үзэх хуралдаанаар

шийдвэрлэж, дараах агуулга бүхий хяналтын тогтоолыг бүрэлдэхүүний гишүүдийн олонхын саналаар гаргана:

117.8.1.гомдол, эсэргүүцлийг хангахгүй орхиж, магадлалыг хэвээр үлдээх;

117.8.2.гомдол, эсэргүүцлийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хангаж, магадлалд өөрчлөлт оруулах;

117.8.3.гомдол, эсэргүүцлийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хангаж, магадлалыг хүчингүй болгож, дахин шалгуулахаар илтгэгч гишүүнд, эсхүл дахин хэлэлцүүлэхээр Сахилгын хорооны хуралдаанд буцаах;

117.8.4.гомдол, эсэргүүцлийн зарим хэсгийг хангаж, магадлалын зарим хэсгийг хэвээр үлдээх, өөрчлөх, хүчингүй болгож, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл дахин шалгуулахаар илтгэгч гишүүнд, эсхүл дахин хэлэлцүүлэхээр Сахилгын хорооны хуралдаанд буцаах.

117.9.Хянан үзэх хуралдааны товыг мэдэгдэж, хуралдаанд оролцох эрхийг хангана. Хуралдааны товыг мэдэгдсэн боловч хуралдаанд ирээгүй нь гомдлыг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.

117.10.Хуралдаан даргалагч гомдол, эсэргүүцэл, магадлалын агуулгыг танилцуулсны дараа сахилгын хэргийн оролцогчийн болон илтгэгч гишүүний тайлбарыг сонсоно.

117.11.Бүрэлдэхүүн сахилгын хэргийн оролцогчийн болон илтгэгч гишүүний тайлбарыг сонссоны дараа асуулт тавих, нэмэлт тайлбарыг сонсож, хуралдаан завсарлан зөвлөлдөх тасалгаанд орж, хяналтын тогтоол гаргана.

117.12.Хяналтын тогтоол нь уншиж сонсгосноор хүчин төгөлдөр болох бөгөөд энэ хуулийн 118.1-д заасны дагуу гомдол гаргаснаас бусад тохиолдолд эцсийн шийдвэр байна.

117.13.Хяналтын тогтоолд магадлал, гомдол, эсэргүүцлийн агуулга, тогтоолын үндэслэл, гаргасан шийдвэрийг бичнэ.

117.14.Хяналтын тогтоолыг уншиж сонсгосноос хойш 14 хоногийн дотор тогтоолын агуулгыг бүрэн эхээр нь бичгээр үйлдэж, бүрэлдэхүүн гарын үсэг зурна. Тогтоолыг сахилгын хэргийн оролцогч болон өргөдөл, мэдээлэл гаргагчид энэ хуулийн 116.6, 116.7-д зааснаар хүргүүлнэ.

117.15.Энэ хуулийн 114 дүгээр зүйл, 115.3, 115.4, 115.5, 115.6, 115.7, 116.4, 116.5-д заасан журам хянан үзэх хуралдаанд нэгэн адил хамаарна.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 84,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Одоо хэд билээ зүйлээрээ. 118, 199 чинь хаана байна вэ, болсон юм биш үү, дууссан юм биш үү.

74.Төсөлд доор дурдсан агуулгатай 118, 119 дүгээр зүйл нэмэх:

“118 дугаар зүйл.Хяналтын тогтоолд гомдол гаргах

118.1.Хяналтын тогтоолыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор энэ хуулийн 119.1-д заасан үндэслэлээр хүчингүй болгуулах тухай гомдлыг сахилгын хэргийн оролцогч, илтгэгч гишүүн эсэргүүцлийг Улсын дээд шүүхэд гаргаж болно.

118.2.Сахилгын хэргийн оролцогч, эсхүл илтгэгч гишүүн энэ хуулийн 118.1-д заасан гомдол, эсэргүүцлийг бичгээр гаргаж, дараах зүйлийг тусгана:

118.2.1.холбогдох шүүгч болон илтгэгч гишүүний нэр, албан тушаал, оршин суугаа газрын хаяг, утас, цахим шуудангийн хаяг;

118.2.2.Сахилгын хорооны хяналтын тогтоолын огноо, дугаар;

118.2.3.Сахилгын хорооны хяналтын тогтоолыг хүчингүй болгуулах үндэслэл.

118.3.Энэ хуулийн 118.1-д заасан гомдол, эсэргүүцэлд дараах баримт бичгийг хавсаргана:

118.3.1.хяналтын тогтоолын эх хувь, эсхүл түүний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

118.3.2.хяналтын тогтоолыг хүчингүй болгуулах үндэслэлийг нотлох баримт;

118.3.3.итгэмжлэл.

118.4.Хяналтын тогтоолд гаргасан гомдол, эсэргүүцлийг хянан үзэх хуралдааны даргалагч гишүүн хүлээн авч, сахилгын хэргийн оролцогч, эсхүл илтгэгч шүүгчид танилцуулан тайлбар гаргуулан сахилгын хэрэгт хавсаргана.

118.5.Энэ хуулийн 118.1-д заасан гомдол, эсэргүүцлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

118.6.Хянан үзэх хуралдааны даргалагч гишүүн нь энэ хуулийн 118.1, 118.2, 118.3-д заасан шаардлагад нийцээгүй гомдол, эсэргүүцлийг буцаах тухай захирамж гаргаж, энэ талаар хариу мэдэгдэнэ.”

“119 дүгээр зүйл.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан

119.1.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан хяналтын тогтоолыг зөвхөн дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

119.1.1.Сахилгын хорооны хянан үзэх хуралдааны товыг энэ хуулийн 116.3, 116.4, 116.6-д заасны дагуу мэдэгдээгүйн улмаас хуралдаанд зохих ёсоор оролцож чадаагүй гэдгийг сахилгын хэргийн оролцогч, эсхүл илтгэгч гишүүн нотолсон;

119.1.2.Энэ хуулийн 106.1-д заасан эрхийг эдлүүлээгүй гэдгийг сахилгын хэргийн оролцогч, эсхүл илтгэгч гишүүн нотолсон.

119.2.Хяналтын тогтоолд сахилгын хэргийн оролцогчоос гомдол, илтгэгч гишүүнээс эсэргүүцэл гаргасан тохиолдолд тухайн тогтоолын биелэлт түдгэлзэнэ.

119.3.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан энэ хуулийн 118.1-д заасан гомдол, эсэргүүцлийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

119.4.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан энэ хуулийн 118.1-д заасан гомдол, эсэргүүцлийг таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэнэ.

119.5.Энэ хуулийн 119.4-т заасан бүрэлдэхүүнийг энэ хуулийн 19.2.5-д заасан журмын дагуу томилох бөгөөд тухайн шүүхийн Зөвлөгөөнөөс тогтоосон дарааллаар томилсон шүүгч даргална.

119.6.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдааны товыг хэргийн оролцогч, илтгэгч гишүүнд долоогоос доошгүй хоногийн өмнө мэдэгдэж баримтыг сахилгын хэрэгт хавсаргана. Уг мэдэгдлийг хүлээн авсан этгээд ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

119.7.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан энэ хуулийн 119.1-д заасан үндэслэл байгаа эсэхийг гомдол, эсэргүүцлийн шаардлага болон татгалзлын үндэслэл, шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтыг шинжлэх замаар тогтооно.

119.8.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдаан хяналтын тогтоолыг хүчингүй болгуулах тухай гомдол, эсэргүүцлийг хянан хэлэлцэж, дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

119.8.1.хяналтын тогтоолыг хэвээр үлдээх;

119.8.2.хяналтын тогтоолыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгох;

119.8.3.сахилгын хэргийг дахин хэлэлцүүлэхээр Сахилгын хорооны хуралдаан, эсхүл хянан үзэх хуралдаанд буцаах.

119.9.Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдааны шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.

119.10.Энэ хуулийн 119.9-д заасан тогтоолд доор дурдсан зүйлийг тусгана:

119.10.1.маргаж байгаа хяналтын тогтоолын тухай мэдээлэл, түүнийг гаргасан газар;

119.10.2.хяналтын тогтоолыг хүчингүй болгуулах тухай гомдол, эсэргүүцлийн агуулга;

119.10.3.шүүхээс гаргаж байгаа шийдвэрийн үндэслэл;

119.10.4.хяналтын тогтоолыг хэвээр үлдээсэн, эсхүл бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгосон, эсхүл энэ хуулийн 119.8.3-т заасны дагуу буцаасан тухай заалт.

119.11.Энэ хуулийн 119.9-т заасны дагуу гарсан Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдааны тогтоол гармагц хуулийн хүчин төгөлдөр болох бөгөөд эцсийн шийдвэр байна.” санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

75 дахь дугаар саналтай холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу?

75.Төслийн 113 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 120 дугаар зүйл болгох: Алга байна.

“120 дугаар зүйл.Шүүгчийн сахилгын хэргийн бүртгэл, тайлан болон шийдвэрийн ил тод байдал

120.1.Ажлын алба шүүгчийн сахилгын хэргийн бүртгэл хөтөлж, Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг гаргана.

120.2.Энэ хуулийн 120.1-д заасан бүртгэл, тайланд хамаарах мэдээлэл хөтлөх журамтай байх бөгөөд тайланг цахим хуудаст байршуулна.

120.3.Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд хүргүүлнэ.

120.4.Сахилгын хорооны магадлал, хяналтын тогтоол, Улсын дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдааны тогтоолыг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 21 хоногийн дотор цахим хуудаст байршуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүн буюу 69,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна.

76 дахь санал буюу 76.Төслийн 114 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах: Асуулт байна гишүүдээс, алга байна.

“114.1.Энэ хуулийг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 84,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Найруулгын санал. 1.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “хуулиар” гэсний өмнө “тухайлсан” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “шүүгчдийн зөвлөгөөнийг” гэсний дараа “/цаашид “Зөвлөгөөн” гэх/ гэж, 26 дугаар зүйлийн “Нийт шүүгчдийн” гэсний өмнө “Улсын дээд шүүхийн” гэж тус тус, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн “түдгэлзүүлэх” гэсний өмнө “шүүгчийн бүрэн эрхийг” гэж, 74 дүгээр зүйлийн 74.1.9 дэх заалтын “дарга” гэсний дараа “/цаашид “Гүйцэтгэх нарийн бичгийн дарга” гэх/” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Нийт шүүгчдийн чуулганы гэдэг чинь орж байгаа тийм ээ. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 12 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “түүний” гэснийг “шүүгчийг” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “байгуулагдсан” гэснийг “байгуулсан” гэж, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “холбогдох” гэснийг “тухайлсан” гэж, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “мэдээлж байна” гэснийг “мэдээлнэ” гэж, 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийн “шийдвэрлэгдсэн” гэснийг “шийдвэрлэсэн” гэж, 15.5 дахь хэсгийн “харгалзах” гэснийг “харгалзан үзэх” гэж, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “шаардан гаргуулах” гэснийг “гаргуулан авах” гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “бичих” гэснийг “боловсруулах” гэж, “тогтооно” гэснийг “батална” гэж, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр” гэснийг “сайн дураараа” гэж, Долдугаар бүлгийн гарчиг, 34 дүгээр зүйлийн гарчгийн, 37.2 дахь хэсгийн “тавигдах” гэснийг “тавих” гэж, 39 дүгээр зүйлийн “хоногийн” гэснийг “өдрийн” гэж, 43 дугаар зүйлийн 43.7 дахь хэсгийн “хууль зүйн” гэснийг “хуулийн” гэж, 49 дүгээр зүйлийн 49.2.1 дэх заалтын “бие махбодь гэмтсэн буюу эрүүл мэндэд нь хохирол учирснаас нас барсан” гэснийг “эрүүл мэндэд нь хохирол учирснаас амь насаа алдсан” гэж, 49.5 дахь хэсгийн “нас барвал” гэснийг “амь насаа алдвал” гэж, 49.6 дахь хэсгийн “байна” гэснийг “байх ба” гэж, “тэтгэврээр” гэснийг “тэтгэвэр” гэж, 51 дүгээр 51.3 дахь хэсгийн “буруутайд тооцогдсон” гэснийг “буруутай” гэж, “ямар нэгэн” гэснийг “аливаа” гэж, 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсгийн “хойших” гэснийг “хойш” гэж, 73 дугаар зүйлийн 73.1.17 дахь заалтын “иргэдийн” гэснийг “хүн, хуулийн этгээдээс” гэж, 76 дугаар зүйлийн 76.1.6 дахь заалтын “орчин үеийн” гэснийг “дэвшилтэт” гэж, 77 дугаар зүйлийн 77.2.2 дахь заалтын “байрлуулах” гэснийг “байршуулах” гэж, 77.2.3 дахь заалтын “хуудсыг” гэснийг “хуудасны мэдээллийг” гэж, 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсгийн “байх бөгөөд” гэснийг “байна.” гэж, 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсгийн “хуралдаанаас тогтоол гаргана” гэснийг “хуралдааны шийдвэр тогтоол хэлбэртэй байна” гэж, 85 дугаар зүйлийн 85.6 дахь хэсгийн “104.1.1-104.1.5-д” гэснийг “106.1.1-106.1.4-т” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 84,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “бүх” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “холбогдох” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн “заавал” гэснийг, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “/цаашид “Нийт шүүгчдийн хуралдаан” гэх/” гэснийг, 26.3 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн” гэснийг, 26.4 дэх хэсгийн “хэлэлцсэн” гэснийг, 49 дүгээр зүйлийн 49.2.2 дахь заалтын “бие махбодь гэмтсэн буюу” гэснийг, 49.2.3 дахь заалтын “бие махбодь,” гэснийг, 49.4 дэх хэсгийн “гэмтсэн болон” гэснийг, 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсгийн “/цаашид “Ерөнхий зөвлөл” гэх/,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төслийн талаарх саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томьёог жигдлэх, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Ажлын хэсгийн ахлагч Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүддээ баярлалаа. Сая энэ төслийн дөрөвдүгээр санал, нөгөө энэ саналыг нь өнөөдөр бид нарын санал хурааж

дэмжигдсэнтэй холбоотойгоор нэр томъёог жигдлэх зүйл, заалтын дугаарыг нийтэд нийцүүлж өөрчлөх гэж байгаа юм байна. Тэгээд өнөөдөр ажлын хэсгийн оруулж ирсэн санал дэмжигдчихсэн. Тэгээд бас гишүүнээс гарсан нэг санал дэмжигдсэн байгаад байгаа юм. Тэгээд хоорондоо зөрчилдөөд байна. Яг хоорондоо эсрэг зөрчилдөөд байгаа юм. Тэгэхээр ийм хоорондоо зөрчилдсөн саналыг Байнгын хороо хоёуланг нь дэмжээд ингэж чуулганаар бас оруулж таарахгүй байх л даа. Тэгэхээр энэ ямар заалт ажлын хэсгээс концепцын хувьд орж ирсэн бэ гэхээр энэ төслийн арван наймын дөрөв нэгийн дөрөв дээр ажлын хэсгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамааралгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдолд Тамгын газраас хариу өгч байгаа ажиллагаанд хяналт тавих гээд энэ бүх шатны ерөнхий шүүгчдийн бүрэн эрх дээр ийм асуудлыг тавь тавьчихсан юм.

Өөрөөр хэлбэл ерөнхий шүүгч бол өөрөө ер нь энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоогүй асуудлаар энэ иргэдийн өргөдөл гомдолд бол хариу өгөхгүй шүү. Энэ бол тамгын газрын одоо үндсэн чиг үүрэг шүү гэдэг концепц явсан. Ерөнхий шүүгч бол харин энэ тамгын газрынхаа энэ иргэдийн өргөдөл гомдолд хариу өгч байгаа байдалд бол хяналт тавих ёстой. Тэгсэн энэ хорин долоодугаар зүйл буюу улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн бүрэн эрх дээр хорин долоогийн нэгийн долоо гээд манай Пүрэвдорж гишүүн санал гаргаад ийм санал дэмжигдчихээд байгаа юм. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх талаарх өргөдөл гомдолд албан бичгээр хариу өгнө гээд. Тэгээд бүх шатны ерөнхий шүүгч энэ хэрэг маргааны асуудлаас бусад тэр асуудал дээр ерөнхий шүүгч бол ерөөсөө оролцохгүй шүү. Энэ бол тамгын газрын ажил шүү гээд ингээд ийм концепц явчихсан чинь. Ерөнхий шүүгч дээр нөгөө арван наймын нэгийн дөрөвтэйгөө зөрчилдсөн санал хураагдаад дэмжигдчихээд байна л даа. Тэгээд энийг нэг мухарлаж зөрүүг арилгаж чуулганы нэгдсэн хуралдаанд оруулахгүй бол бас нэг ийм юу үүсчхээд байна. Зөрчил үүсчхээд байна. Хоорондоо нөгөө зөрчилтэй заалтыг бид хураачхаад ингээд чуулганд оруулах гээд байна л даа.

Тийм учраас энэ яах вэ миний санал бол энэ ажлын хэсгийн саналыг хууль хэрэглээний зөрүүг арилгах үүрэгтэй учраас энэ хажуу нь ажлын хэсгийн хажуугаас орж ирсэн буюу хорин долоогийн нэгийн долоо түрүүн хураагдаад дэмжигдсэн байгаа энэ саналыг одоо дэмжигдсэн арван наймын нэгийн дөрөвт нийцүүлж хорин долоогийн нэгийн долоо буюу иргэний хэрэг хянан шийдвэрлэх талаарх өргөдөл гомдолд албан бичгээр хариу өгнө гэж дээд шүүхийн ерөнхий шүүгч дээр бичсэн энэ саналыг хүчингүй болгож өгөөч гэсэн ийм санал гаргаж байгаа юм. Тэгэхгүй тийм. Тэгэхгүй бол энэ хоорондоо зөрчилдөөд байгаа байхгүй юу. Ажлын хэсгийн саналтай дэмжигдсэн саналтай хоорондоо ийм хоёр зөрчилтэй санал чуулган руу орох гээд байна л даа.

С.Бямбацогт: Тэгээд одоо яг гишүүний дэмжигдсэн саналыг бид нар санал гаргаад хүчингүй болгох санал хураах нь бол дэгийн хуулиар хориотой. Тэгэхээр эцсийн чуулганы хуралдаан дээр анхны хэлэлцүүлэг хийгдэнэ. Тэр үед хуралдаан даргалагчаас чиглэл аваад хоёр дахь хэлэлцүүлэг дээр гуравны хоёроор л одоо унагах эсвэл чуулган дээр унагаах бас нэг бололцоо байгаа шүү дээ. Тэгээд чуулган дээр цэгцлэх. Тэгэхгүй бол яг одоо гишүүдийн дэмжсэн саналыг бид нар санал хураагаад унагаах дэгээр дэгд нэг тийм заалт байхгүй биз дээ. Тийм тийм. Яг бас яг тодорхой яг нэг асуудлаар ч бас биш шүү дээ. Тийм болохоор ажлын хэсэг анхаараад чуулганы хуралдаан дээр бас сануулаад анхаараад явчихъя тэгэх үү?

Мөнх-Орил гишүүнээс бас бичгээр санал гаргасан байна. Төслийн дөрвийн нэгийн нэгийг хасах гэсэн. Мөнх-Оргил гишүүн саналаа тайлбарлаж санал хэлье.

Ц.Мөнх-Оргил: Гишүүдээ уучлаарай, нэг ганц санал оруулж байгаа юм. Энэ би ажлын хэсэгт оруулах гэж байгаад амжаагүй хоцорчихсон. Сая хуралдаа бас хоцроод нөгөө телевизэд ярилцлага өгч байгаад хоцорч орж ирээд хураалгаж чадсангүй. Энэ өргөн барьсан хуулийн төсөл дээр ийм заалт байгаа байхгүй юу. Шүүх дараах эрхэм зорилготой гээд дөрвийн нэгийн нэг дээр Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Үндсэн хуульт байгууллагыг бататган бэхжүүлж, хамгаалах гэсэн заалт байгаа юм. Тэгээд би бол ингэж бодоод байгаа юм. Энэ бол шүүхийн эрхэм зорилго биш. Шүүхийн эрхэм зорилго бол хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчсөн эрхийг сэргээх, шударга шүүхээр шүүлгэх эрхийг л хамгаалах, баталгаажуулах асуудал.

Үндсэн хууль нь ч гэсэн тэгээд заачихсан байгаа. Ерөөсөө шүүхийн зорилго нь бол энэ юм. Тэгэхлээр энэ тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Үндсэн хуульт байгууллагыг бататган бэхжүүлж хамгаалах асуудлыг хасчихмаар байна. Энэ яах вэ, зүгээр байхад буруу биш юм шиг заалт уншигдаж магадгүй. Гэхдээ шүүхэд яг ийм үүрэг, эрхэм зорилго ноогдуулна гэдэг чинь шүүх өөрийнхөө үйл ажиллагаа, гаргаж байгаа шийдвэртээ нөгөө хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, шударга шүүхээр шүүлгэх эрхийг баталгаажуулах асуудал биш. Энэ нөгөө тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, аюулгүй байдал одоо юу гэдэг юм энэ асуудал руу хазайгаад явах бас бид нар суурийг нь гаргаж өгөөд байгаа байхгүй юу, үндэслэл. Тэгэхээр харахад нэг их хоргүй юм шиг мөртөө би бол илүү заалт байна аа л гэж бодоод байгаа юм. Тэгээд энэ дээр гишүүд саналаа хэлээд санал хураагаад өгөөч гэсэн хүсэлттэй байна.

С.Бямбацогт: Энэ дээр хууль санаачлагч Нямбаатар сайд юу яах уу? Тайлбар хэлэх үү? Алга уу? Сүхбаатар гишүүн, дараа нь Цогтбаатар гишүүн, Адьшаа гишүүн.

Ж.Сүхбаатар: Энэ Мөнх-Оргил гишүүний хэлж байгаа санал бас үндэстэй л дээ. Ер нь бол яах вэ төрийн эрх мэдлийн салаа мөчир нь бол шүүх эрх мэдэл л дээ. Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэл гээд үндсэндээ бол төрийн эрх мэдэл гэдэг бол Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндсэн хуулийг бататган бэхжүүлж хамгаалах энэ зорилго руу бол ард түмний хүсэл зоригийг илэрхийлээд энэ зорилго руу бол төрийн эрх мэдэл бол үйлчилнэ. Тэр тусмаа шүүх эрх мэдлийн өөрийнх нь одоо яг шүүх эрх мэдлийнх нь гол чиг үүргийн нэг нь бол бас Үндсэн хуульт байгууллагыг бататган бэхжүүлж хамгаалах явдал бол мөн. Зүгээр яг шүүхийн эрхэм зорилго гээд явчихаар шүүх гэдэг чинь өөрөө юу билээ гэдгээ бодох шүү дээ. Шүүх болгоно гэдэг чинь бид нар энд шүүх гэдэг бол ийм гээд ингээд биччихсэн байгаа шүүгч нар гээд ингээд ажиллаж байгаа.

Тэгэхээр яг энэ тэр улсуудад бол юу юугүй тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалах тэр одоо эрхэм зорилго гээд явчихаар яг саяын хэлдэг дээ. Ерөөсөө Монгол улсын Үндсэн хуульд зааснаар Монгол улсын төр иргэнийхээ өмнө зөрчигдсөн эрхийг сэргээх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах энэ одоо үүргийг, тэгээд шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангах гээд энэ зүйлүүд нь байгаа байхгүй юу. Тэгэхээр яах вэ энийг бол би хасахдаа тэр гэмгүй ч юм уу, ач холбогдолгүй ч гэдэг юм

уу ингээд тэр утгаар нь биш. Энэ бол шүүх эрх мэдлийн өөрийнх нь цаад зорилго, чиг үүрэг бол мөн үү мөн. Гэхдээ яг шүүхийн эрхэм зорилгын асуудлыг тодорхойлж байгаа учраас хамгийн гол туг нь бол хүний эрх л дээ. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, иргэний болон улс төрийн эрхийн факт гэж бодоход шүүхийн гол юм бол тэр л юм чинь. Тэгэхээр энэ асуудал үүднээсээ дээр нь энэ цаад зүгээр эрх зүйн системээ хамгаалах, Үндсэн хуульд байгууллагаа бататган бэхжүүлэх эд нар гэдэг нь бол тэр эрх зүйн системийнх нь, шүүх эрх мэдлийнх нь, бүх л талынх нь бол тэр ийм зорилго, чиг үүрэг бол байгаа байх. Тэгээд би бол энийг бол яах вэ хасчихад бол буруугүй л гэж бодож байгаа. Зүгээр нэр томьёо, зарим юмыг нь бол яах вэ.../минут дуусав/

С.Бямбацогт: Энэ дээр юу яаж тэгэх үү Сайнзориг дарга хууль бичсэн Цолмон манай хоёр хариулах уу? Энэ хууль бичсэн улсууд яг тухайн үедээ яагаад оруулсан юм. Дөрөвдүгээр микрофон Нямдорж сайд манай Сайнзориг дарга хоёр бичсэн хууль шүү дээ яг.

П.Сайнзориг: Асуултад хариулъя. Сайнзориг. Ерөнхийдөө яах вэ мэдээж энэ эрхэм зорилгын хувь дээр яг Ж.Сүхбаатар гишүүнтэй бол санал нэг байгаа. Хэрэг маргааныг хянан шийдвэрлэх гэдэг юм уу, энэ мөн чанараараа яг л Үндсэн хуульд заасан тэр үзэл санаа, сайн дэвшилтэт энэ бүх зарчмыг л нутагшуулж энэ одоо зарчим, үзэл санаа өөрөө энэ шүүхийн үйл ажиллагаагаар дамжиж бэхжих л асуудлыг л одоо шийдэж байгаа гэсэн үг.

Хоёрдугаарт яах вэ зүгээр энийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бас нэг одоо юу гэдэг юм гол шийдэж байгаа асуудал юу вэ гэхээр төрийн байгууламжийг хамгаалах гэдэг юм уу, төрийн эсрэг энэ гэмт хэргийг шийдэх энэ замаараа бас шууд утгаараа ч бас яригдах асуудлууд байгаа. Тэгэхдээ мэдээж энэ дээр нөгөө зохицуулалтын одоо юу гэдэг юм ач холбогдол гэдэг юм уу энэ нь одоо нэг их тодрохгүй байгаа учраас төслөөс одоо үлдсэн эсвэл хасагдсан эсэхээс хамаараад нэг их тийм бусад заалт руугаа хөвөрч гэдэг юм уу, нэг их тийм нөлөөлөх зүйл бол байхгүй байж байгаа. Тэгээд яах вэ зүгээр саяын саналаар бол Мөнх-Оргил гишүүний яг тэр сүүлийн редакцын саналаар нь тэгээд хураалгаад явъя л гэсэн саналтай байна.

С.Бямбацогт: Яагаад тэгээд оруулчихсан юм, гоё харагдуулах гээд оруулсан юм уу? Одоо хуульдаа байгаа юм уу? Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Үгүй ээ, би жаахан гайхаж байна л даа. Энэ Үндсэн хуульт Монгол улсад оршиж байгаа Монгол улсын иргэн гээд явж байгаа хүн Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын төлөө л ялангуяа төрд ажил хийгээд явж байгаа бол бүгд явж байгаа. Эмч нь байна уу, тэр төрд ажиллаж байгаа цахилгаан станц дээр ажиллаж байгаа хүн. Би бүгдийг нь ингэж ярьж болно. Гадаад яам бол бүр бүр тэр чигээрээ. Тэгэхлээр энэ чинь яг функционал утгаараа энэ шүүхийн юу хийхийг энэ чинь одоо уянгын халил шүлэг зохиол юм уу хаашаа юм. Шүүхдээ ингэж хандаж болохгүй шүү дээ. Шүүх ойлгомжтой шүү дээ. Үндсэн хуулийг хамгаалж байна гэдэг бол Монгол улсын суурь үнэт зүйлийг хамгаалж байна гэдгээр нь үнэн. Тэгэхдээ ингэж яривал бүх юм ийм болчих байхгүй юу. Тэгэхлээр бид нар Үндсэн хуультай тэр Үндсэн хуульдаа бид нар хүртэл өөрсдөө тангараг өргөснөөрөө энэ ажлыг өдөр

болгон хийгээд явж байгаа шүү дээ. Тэгэхлээр энд бол заавал одоо байлаа гээд буруудахгүй. Гэхдээ энэ чинь яг байгаа онохгүй л нэг тийм томъёо явж байна л даа.

С.Бямбацогт: Энэ ер нь одоо хуульдаа байгаа юм бол саналаа татчих, тэгэх үү? Тэгэхгүй бол наадах чинь нөгөө төрийн нийтийн өмч гэдэгтэй адилхан нэг хоёрын хооронд баахан улс төр болох юм байна. Шал дэмий ёстой тийм. Саналаа татсан учраас санал хураахгүй. Одоогийн хуульд байгаа юм байна шүү дээ, тийм тэгээд байсныг нь уламжлаад Засгийн газар өргөн барьчихсан, одоо тэгэнгүүт нь бид нар хасчих юм бол яршиг. Өөр саналууд байхгүй. Энэ бас нэг ийм санал байгаа шүү, түрүүн бас ярьсан. Арван дөрөв дэх саналын томъёоллын хорин хоёрын найм дахь хэсгийг Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаарх улсын дээд шүүхийн албан ёсны тайлбарыг төрийн мэдээлэл эмхэтгэлд нийтэлнэ гэж өөрчлөх. Энэ уул нь хураагдаад дэмжигдчихсэн. Тийм ээ. Шүүхийн дээд шүүхийн албан ёсны тайлбар. Харин шийдвэр гэхээр чинь хэрэг маргаан хэргийн оролцогчдоо тэгээд л юутай бүгдийг нь бичих гээд байна. Энэ саналыг больё.

Далан тавын хоёр, далан тавын гурав, далан тавын дөрөв гээд нөгөө шүүгчийн хараат бус байхтай холбоотой Үндсэн хуулийн дөчин есийн нэг хоёртой холбоотойгоор саналууд ажлын хэсгээс дэмжигдсэн. Мөн хуулийн төслийн дөчин зургаа дээр орсон. Үүнтэй холбоотойгоор нөгөө процессын болон эрүүгийн хуулиуд бас тодорхой өөрчлөлт оруулах, энийг юун дээр зөвхөн шүүхтэй холбоотой биш, прокурортой холбоотой асуудлаар бас хөндөгдөх нь байна шүү. Энийг ажлын хэсэг цаашдаа анхаараарай. Хуралдаан даргалагчаас бас чуулганы хуралдаанаар дэмжигдвэл бас чиглэл аваарай гэдгийг. Энхбаяр гишүүнээ чиглэл аваарай гэдгийг бас протоколд тэмдэглэж үлдээе. Явчихсан орчоод шүү. Тийм.

Саналууд ажлын хэсэг дээр чуулган дээр дэмжигдвэл наад асуудлаа протоколд оруулж хуралдаан даргалагчаас чиглэл аваарай гэж хэлсэн. Тийм ээ. Одоо дагалдах хуулиуд дээр хэдхэн санал байгаа.

Нэг.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Давж заалдах шатны шүүхийн шийдвэрт дараах үндэслэлээр оролцогч хяналтын журмаар гомдол, прокурор, дээд шатны прокурор эсэргүүцэл гаргаж болно:

1.1.анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;

1.2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн;

1.3.шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.”

2/40.2 дугаар зүйлийн 4, 5, 6 дугаар хэсэг:

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан шүүхийг шүүгч хэргийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор дараах тогтоолын аль нэгийг гаргана.

4.1.гомдол, эсэргүүцлийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх;

4.2.гомдол гаргахдаа энэ хуульд заасан журмыг баримтлаагүй гэсэн үндэслэлээр гомдлыг хяналтын шатны шүүхийн хуралдаанаар хэлэлцүүлэхгүй.

5.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан тогтоолыг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэлэлцэж шийдвэрийг олонхын саналаар гаргана. Тогтоол шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Тогтоол эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй.

6.Гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэхэд хэргийн оролцогч, өмгөөлөгч оролцохгүй.

3/40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Хяналтын шатны шүүх нь анхан шатны болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн эсэх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн эсэх, шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн эсэхийг хянаана.”

4/40.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүхийн таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэх бөгөөд шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг тогтоосон журмын дагуу томилно.”

5/40.8 дугаар зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг:

“2.Хяналтын шатны шүүх хуралдаан даргалагч гомдол, эсэргүүцлийг хангасан эсэхийг сонсгоно. Шийдвэрийг шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргах бөгөөд хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

3.Хяналтын шатны шүүхийн тогтоолд шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Хяналтын шатны шүүхийн тогтоолд анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсгийн агуулга, гомдол, эсэргүүцэл болон гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тус тус тусгана.

4.Хяналтын шатны шүүхийн тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд уг тогтоолд гомдол гаргахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Мөнхтуяа шүүгч. Санал хураалтыг хүчингүй болгоё. 1 дүгээр микрофон.

Д.Мөнхтуяа: Би нэг юу хэлье. Энэ нөгөө дагаж мөрдөж гарч байгаа эрүүгийн, иргэний, захиргааны процессын хуулиудыг энд шүүх өөрсдөө ерөнхийдөө үндсэндээ төслөө гаргаж өгсөн юм. Тэгээд ажлын хэсэг бол албан ёсоор энийг нэг хуралдаж тэд ажлын хэсэг дээр яриагүй л дээ. Тэгээд бид нар гурван танхим шүүх дээрээ ярьж байгаад хамгийн дээд шүүх дээр энэ хорин тавын зургаагийн тавын, өөрөөр хэлбэл дээд шүүхийн хяналтын хүрээнд хамаарах хэргээ одоо ирж байгаа гомдлоосоо яаж ялгаж авах вэ гэдэг процессоо ярьж байгаад танхимын хурлаараа найман шүүгчээрээ хэлэлцэх нь зөв юм байна гээд. Ингээд гурван ижил процесс оруулж ирснийг ажлын хэсгийн ахлагч гурвуулаа шийдэх нь зөв гээд өөрчилсөн юм байна лээ. Тэгээд яах вэ энэ зүгээр та нар өөрсдөө олонхоороо шийднэ биз. Би яагаад энэ ийм процесс оруулж ирсэн бэ гэдгээ хэлэх гэсэн юм.

Уг нь бол одоогийн байгаа процесс бол нэг шүүгчид хуваарилагдаж ирээд тэгээд тэр шүүгч өөрөө захирамж гаргадаг юм. Хяналтын шатны шүүхээр хэлэлцүүлэх үү үгүй юу гэдгийг захиргаа, эрүү хоёр дээр тийм байгаа юм. Тэр захирамжийг зөвшөөрөхгүй бол гомдол гаргаад гурван шүүгч хянадаг. Нөгөө захирамжаа. Тэгээд гурван шүүгч хянаад захирамж үндэстэй гээд хэвээр үлдээнэ, эсвэл захирамжийг хүчингүй болгоно. Ингээд үндсэндээ дөрвөн шүүгч ордог юм. Одоо энэ хэрэг хянан шийдвэрлэх юу хэргийг хуралдаанаар оруулах уу, үгүй юу гэдгийг. Тэгэхээр одоо энэ дээр ямар асуудал гарах гэж байгаа вэ гэхээр гурван шүүгч ороод шийдэхээр үндсэндээ хоёр шүүгчийн саналаар энэ гомдол дээд шүүхийн хяналтын шатны хуралдаанаар орох уу, үгүй юу гэдэг нь шийдэгдэх гэж байна. Хоёр шүүгчийн саналаар.

Тэгэхээр одоо бид нар ямар асуудал гарч байгаа вэ гэхээр маргаанаа шийдэх гээд тавуулаа яваад орохоор тавуулаа яваад орохоор яг нөгөө шийдэх гэж байгаа маргаан дээр үгүй ээ энэ чинь манай харьяаллын юм мөн юм уу, биш юм уу гээд ийм асуудал гардаг, гарна. Энэ ер нь бол. Яагаад вэ гэхээр одоо энэ хяналтын хүрээ маш хумигдаж байгаа. Янз бүрийн маргаантай улс төрийн янз бүрийн хэрэг асуудал ордог. Тэгэхээр энийг одоо нэг гурвуулаа хуралдаад хоёрын саналаар оръё, оръё гээд шийдчихдэг, эсвэл авахгүй байхгүй гээд шийдчихдэг. Гэтэл тэр нь эсвэл авах хэрэг маргаан гомдол байсан, эсвэл авахгүй гомдол байсан ч гэдэг юм уу. Ийм юм гарахаар таван шүүгч одоо ямар орчхоод энэ манай авахгүй байсан гомдол байна гээд буцааж байлтай байна биш. Тэгэхээр ерөөсөө энэ нөгөө танхимын шүүгчдийн зөвлөгөөн угаасаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа сунгадаг процессын янз бүрийн эрхтэй л дээ. Нийтээрээ зөвлөгөөнөөрөө хуралдаад тогтоол гаргаад бүх шүүгч нар гарын үсэг зурдаг.

Тэгэхээр одоо үндсэндээ жишээлбэл захиргааны танхимд гэхэд сард одоо гучин гомдол ирвэл нэг хуралдаад л ялгана гэсэн үг байхгүй юу. Энийг хэлэлцүүлэх юм байна, энэ хамаарахгүй юм байна, энэ хамаарах юм байна. Тэрэнд бол тэр гомдол гаргасан этгээд орохгүй. Одоо яг нөгөө зөвлөгөөн хэлэлцдэг журмаараа

хэлэлцээд шийдчихнэ. Тэгээд энэ тохиолдолд нөгөө таваараа ороод тэгнэ. Тэгэхэд бол хэргийн агуулга руу ордоггүй. Одоо яг адилхан. Бид нар одоо гурваар ярихад хэргийн агуулга руу орохгүй. Энэ манай харьяаллын хяналтын гомдол мөн үү, биш үү гэдгийг л харж байгаа юм. Хэлбэрийн хэлбэрийг нь харж байгаа юм. Тэгэхээр таваараа ороод шийддэг. Энэ дээр бол аягүй тийм цэвэр процесс гарах гээд байгаа юм уг нь бол. Одоо ингээд гурваараа орж шидэхээр нэг жоохон тийм. Тэгээд манайхаас бол яг энэнтэй нь гурван процессоо яг ийм процессоор хуулийг нь уул нь төслийг нь хийгээд өгсөн юм. Тэгээд яах вэ ийм нэг санал байгаа юм. Тэгээд та хэд өөрсдөө бас бодолцож үзнэ биз. Ер нь бол маргаан гарах бололтой юм. Одоо гурваар шийдвэл. Гурав гэдэг чинь үндсэндээ хоёр шүүгчийн саналаар л шийдэж байгаа байхгүй юу.

С.Бямбацогт: Нямбаатар гишүүн.

Х.Нямбаатар: Одоо улсын дээд шүүх нийт хэргийн гурван хувийг хяналтын шатны журмаар шийдвэрлэж байгаа гэдэг ийм статистик ярьж байгаа гурван хувь. Энэ шүүхийн тухай хууль одоо ингээд хүчин төгөлдөр үйлчлээд эхэлмэгц одоо бид нарын урьдчилсан харж байгаагаар нийт хэргийн нэг хувийг шийдэхээр байгаа. Өөрөөр хэлбэл шүүхийн оролцогчид шүүхийн шийдвэр өөрийнх нь өөрт нь таалагдаагүй хүмүүс юу гэж үзэх вэ гэвэл ерөөсөө дээд шүүхээр хэргээ хянуулъя гэдэг ийм хүсэлт маш их байна. Тэгэхээр сая бид нар өнөөдөр хэлэлцээд гуравхан үндэслэлээр улсын дээд шүүх, ирүү, иргэн захиргааны хэргийг хяналтын шатны журмаар шийдвэрлэе гээд ингээд тогтчихлоо.

Тэгэхээр гурван танхимын гурван шүүгч энэ улсын дээд шүүхийн харьяалал мөн биш гэдгийг шийдсэнээс илүүтэй хэргийн агуулга ярилгүйгээр танхимын найман гишүүний зөвлөгөөнөөрөө асуудлаа шийдээд явбал илүү одоо тэр ач холбогдолтой л гэж харж байгаа юм. Бид цаана нь нөгөө одоо бас тэр иргэдийн шүүхэд хандах, мэдүүлэх эрх зөрчигдсөн эрхээ сэргээлгэх энэ эрхэнд одоо сая энэ шүүхийн хуулиар нэлээн хаалт хязгаарлаж, тогтоож байгаа. Тэр утгаараа энийг танхимын зөвлөгөөн нь шийдэх нь илүү одоо ач холбогдолтой юм. Ийм учраас энэ саналыг дэмжиж өгөөч гэж гишүүдэд хандаж хэлж байгаа юм. Би одоо гарын үсэг зураад өгчихье. Бямбацогт даргаа.

С.Бямбацогт: Өргөн барьсан төсөлдөө ямар заалттай байсан юм бэ, ажлын хэсэг. Ажлын хэсгийн ахлагч хариулъя. Тайлбар яагаад гурав болгосон юм. Найм байж болоогүй юм. Өргөн барьсан төсөлтэй ямар байсан юм.

Б.Энхбаяр: Баярлалаа. Энэ дээд шүүхийн санал бол яах вэ энэ юу шүү дээ. Тухайн дээд шүүхийнхээ хуралдаанаар хэрэг маргааныг хянан шийдвэрлэх гэж байгаа квотын тоо биш. Дээд шүүхээрээ дээд шүүхээр ер нь хэлэлцэх хэрэг мөн байна уу, биш байна уу гэдгийг арай илүү одоо нухацтай имэрч үзэх боломжийг олгох гэж ингэж хуваарилах гэж гурав гэж одоо тавья гэсэн юм. Өөрөөр хэлбэл бөөндөө цуглаж байгаад наймуулаа цуглаж байгаад тэр гучин хэргээ барьж байгаад өдөр ингээд мөн биш байна, мөн биш байна гээд ингэхээр энийг яг хэн нэг хүн энэ ямар нэгэн байдлаар энийг чинь нэг бүгд эсвэл бүх хэргээ имэрч үзээд шийдээд тэгж болж байгаа бол одоо болж байна. Зүгээр нэг энэ чинь одоо дээд шүүх ч гэсэн нэг илтгэгч шүүгч буюу энэ чинь заавал нэг илүү судлаад нөгөө хэдийнхээ асуулт хариултад

хариулаад. Энэ бол нэг гарцаагүй яагаад ийм мөн юм байна гэдэг эсвэл биш юм байна гэж байгаа юман дээр илүү их нухацтай үзэх тийм боломжийг олгохын тулд гурав л гэж тавьсан юм.

Тэгвэл найм бол тэгвэл яг хэн нь юм уу эсвэл хэд нь илүү жоохон нухацтай үзэх тийм одоо бололцоо байхгүй юу. Зүгээр задгай тавьж байгаад л судлаагүй, хэн нь судлах юм, эсвэл тамгын газар нь судлах юм уу? Нэг тийм энийг чинь нэг судалж нэг тэр танхимын нэг шүүгч нарт чинь нэг ийм танилцуулах нэг юм байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ нэг шүүгч бол байхаар энэ бас арай биш байна. Нэг гурван шүүгч ядаж итгэл үнэмшил төрөөд ингээд нэг тэр танхимаараа хэрэг үүсгэх үү гэдгийгээ ярьдаг байвал гэдэг л процесс шүү дээ. Энэ чинь нөгөө хэргээ ярих гээд байгаа биш байхгүй юу. Зүгээр тэр танхимынхаа хуралдаанд ер нь оруулах хэмжээний асуудал мөн биш байна уу гэдгийг л одоо ярих гээд байгаа л ийм одоо. Дээд шүүх дотроо мөртөө ийм нэг доторх, ийм урьдчилсан л квот байхгүй юу.

С.Бямбацогт: Өргөн барьсан төсөлтэй юу гэж байсан юм бэ?

Б.Энхбаяр: Энэ юу ч байхгүй. Энэ чинь ерөөсөө хөндөгдөөгүй ийм цоо шинэ процесс орж, цоо шинэ орж ирж байгаа процесс орж ирж байгаа учраас ингээд байгаа юм л даа. Хэрэв наймуулаа шууд шийднэ гэхээр ингээд байгаа юм. Наймуулаа шууд шийдэнгүүтээ энэ манай дээд шүүхийн шийд хэрэг байна гэхивэл энэ ерөнхийдөө бол одоо урьдчилсан шийдвэр бол гарч байна л гэсэн үг. Урьдчилаад энэ бол дээд шүүхийн шийдвэр гарчхаж байгаа байхгүй юу. Урьдчилаад хэрэг мөн эсвэл хэрэг биш. Эсвэл хууль зөрчсөн, эсвэл зөрчөөгүй гээд наймуулаа сууж байгаад шууд урьдчилаад шийдчихэж байгаа байхгүй юу. Энэ чинь нөгөө хэргээ үүсгэх үү, үгүй юу гэж байгаа тоо байхгүй юу даа.

Тийм учраас би бол энэ дээр бол ямар нэгэн асуудал үүсэхгүй байх. Наймуулаа л сууж байгаад шийдчихээр, дараа нь энийг чинь үндсэн хэрэг маргаанаа шийдвэрлэнэ гэхээр бүгдээрээ шийдчихсэн байгаад байгаа байхгүй юу. Хаашдаа шийдчихсэн. Үгүй ээ, харин хэрэг ярихгүй гэж байгаа боловч ингээд наймуулаа сууж байгаад хэргийг чинь ярьчихсан байгаа байхгүй юу. Ийм л асуудал байгаад байгаа юм. Тийм учраас энэ чинь ингээд одоо бид нар бүх эрүү, иргэн гээд, эрүү дээр одоо жишээлбэл урьдчилсан хэлэлцүүлэг энэ тэр гэж яагаад нэг шүүгч нь хэлээд шийдээд, энэ бол ерөнхийдөө боогдоод дуусчихжээ, энэ бол манай хэрэг мөн юм байна гээд үндсэн шүүх хуралдаан чинь гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй. Тэрийг давж заалдвал дахиад одоо гурав тав гэж яагаад ийм. Гэхдээ өмнө нь ороогүй шүүгч шийднэ гэдэг энэ процессуудыг чинь яагаад хийгээд байна вэ гэхээр учиртай шүү дээ. Одоо энэ процесс чинь дээд шүүх дээр байхгүй болох гээд байгаа байхгүй юу. Тийм учраас гурав гэж.../минут дуусав/

Г.Занданшатар: Амарсайхан гишүүн, Адьшаа гишүүн, дээд шүүх бас дахиад нэг тайлбар үндэслэл бэлдэж байгаарай. Амарсайхан гишүүний микрофон өгье. Хоёр, хоёр минутад бүгдээрээ ярья.

С.Амарсайхан: Би саяын энэ асуудлыг бас тодруулъя гэж байсан, сая яригдчихлаа. Ер нь зүй нь бол энэ дээд шүүх дээр энэ хэрэг үүсгэж шалгах уу, үгүй юу гэдэг асуудал хэргийн агуулгыг хэлэлцэхгүйгээр танхимаараа эсвэл одоо энэ манай

шүүхийн төлөөллийнхөн Мөнхтуяа шүүгчийн ярьж байгаа шиг нэг найм биш юм гэхэд тав байх. Ингэхдээ энэ мэдээж одоо аль нэгэн шүүгчид хуваарилагдаж, тэр шүүгч нь зөвлөлдөө танилцуулга танхимдаа тэгж байж цааш нь хэрэг үүсэх үү, үгүй юу гэдгээ шийдэх ёстой гэж үзэж байгаа юм. Тэгэхийн тулд заавал хэн нэгэн шүүгчид хуваарилагдаж байж тухайн шүүгч нийт танхимын бүрэлдэхүүндээ танилцуулдаг байж эсвэл одоо бүтэн биш гэвэл тэр тав байдаг юм уу, арай гурав биш байхаар. Энхбаяр гишүүний хэлээд байгаа тайлбар бас жоохон юу ойлгомжгүй байгаад байна л даа. Гурван шүүгч шийдвэрлэх ийм гарц байгаа юм шиг, эсвэл одоо үгүй юм шиг гээд. Тэгэхээр энийгээ бол бас бид нар энэ танхимынх нь гишүүдийн хүрээнд шийдвэрлэх энэ боломжийг нь үлдээх ёстой гэж байгаа.

Хоёрдугаарт тэр дээд шүүхээр хэлэлцэх гэж байгаад дахин одоо хянагдах гэж байгаа асуудалд хэргийн оролцогч, өмгөөлөгч оролцохгүй гэж прокурор эсэргүүцэл бичсэн тохиолдолд. Тэгээд хэргийн оролцогч, өмгөөлөгч оролцохгүйгээр тухайн хэргийг хянан шийдвэрлэх гэдэг асуудал өөрөө байж болохгүй ийм асуудал байгаа байхгүй юу. Түрүүн зургаа дээр байсан байх. Нэгэнт одоо давах шатны шүүх шийдчихсэн байхад прокурор эсэргүүцэл бичиж байгаа бол тэнд оролцогч мөн өмгөөлөгч оролцож байж тухайн хэргийн үнэн мөн эцсийн байдлаар хянагдаж шийдвэрлэгдэх ёстой шүү дээ. Тэгээд энэ хоёр асуудал дээр хоёр дахь асуудал дээр бас манай дээд шүүхийнхэн ямар байр суурьтай байгаа юм. Ажлын хэсэг ямар байр суурьтай байгаа юм. Энийг бас тодорхой болгомоор байгаа.

С.Бямбацогт: Адьшаа гишүүн саналаа хэлье. Хоёр хоёр минутад багтаагаад хийе.

Ш.Адьяа: Тэр хэргийн оролцогч оролцохгүйгээр прокурорын эсэргүүцлээр гээд ингээд тэр дээд шүүх, за гурав ч байна уу, найм ч байна уу ингээд яахаар тэр нөгөө мэтгэлцэх зарчим гэдэг юм чинь хаачих юм. Ер нь тэр мэтгэлцэх зарчим гэдэг юм чинь алдагдчихаад байна шүү дээ. Сая Амарсайхан гишүүн ярилаа. Энэ асуудлыг нь бас шийдэж байж энийг нь ярихгүй бол тэр аливаа бүх хэрэг маргааныг мэтгэлцэх зарчмаар шийднэ л гэсэн энэ үндсэн шүүхийн чинь үндсэн зарчим байна шүү дээ. Энэ зарчим чинь яах юм. Тэр хууль дээдлэх гэдэг юм чинь бүр байхгүй болно шүү дээ. Тэгээд дээр нь тэр найман шүүгч гэдгийг би дэмжиж байна. Тэр дээд шүүхийн. Энэ асуудлуудаа нэг тийш болоод энэ шинээр орж ирж байгаа саналын бол тэр саналынхаа томьёоллыг хэн нь оруулах юм тэгээд хураагаад одоо явж болдог л байх л даа.

С.Бямбацогт: Дээд шүүх, Мөнхтуяа шүүгч үү? Нэгдүгээр микрофон.

Д.Мөнхтуяа: Энэ нэг бас жоохон буруу ойлгуулчих шиг боллоо. Ер нь бол нөгөө юу хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэх үү, үгүй юу гэдгийг ерөөсөө зөвхөн гомдлыг нь л үздэг юм. Хэргийг бол үзэхгүй. Яагаад гэхээр хэргийн агуулга руу орохгүй. Энэ бичигдсэн гомдол хорин зургаагийн тавд заасан гурван үндэслэлийн аль нэг нь хамаарч байна уу үгүй юу гэдгийг хяналтын шатны шүүхэд гаргасан гомдол одоо хоёр хуудас юм уу, гурван хуудас энийг л үзнэ гэсэн үг. Хэрэг шийдэж байгаа бүрэлдэхүүн бол тавуулаа ороод хэргээ үзэж шийднэ. Тэгэхээр энэ хоёр бол хоёр өөр юм ярих яригдах юм. Энэ бичсэн гомдлыг нь хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэхэд бол хэргийн оролцогч прокурор аль нь ч орохгүй. Яагаад вэ

гэхээр энэ бол одоо шүүх өөрөө хэлэлцэх үү, үгүй юу гэдгээ шийдэж байгаа юм. Энд мэтгэлцээд байх юм байхгүй. Одоо энэ дээд шүүх онолын шүүх. Энэ асуудал нь үнэхээр одоо хуулийн энэ гурван асуудал мөн үү, биш үү гэхэд тэнд заавал тэр хүмүүсийг авчирч янз бүрийн одоо мэтгэлцүүлэх шаардлагагүй учраас тэрэнд бол орохгүй. Тавуулаа хэргээ шийдэх гээд ороход бол өмгөөлөгч нь орно, прокурор нь орно, төлөөлөгч нь орно. Одоо яг нөгөө хяналтын шатны шүүхэд оролцогчийнхоо эрхийг эдлээд оролцоно. Тэгэхээр, үгүй ээ, үгүй тэр зүгээр юу байх. Одоо энэ нөгөө нэг гурваараа хэлэлцэнэ. Эхлээд энэ оруулах уу үгүй юу гэдгээ гурваараа хэлэлцэнэ гэхээр нэг хурал шиг юм болох гээд байгаа байхгүй юу. Гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хурал болоод. Тэгээд тэр хуралдаа оролцуулахгүй гээд орчхож байгаа юм.

Бид нарын санал бол наймуулаа учраас танхимын хуралд угаасаа тэр хэргийн оролцогч, гомдол гаргасан этгээд, прокурор хэнийг ч оруулахгүй. Өөрсдөө шийднэ л гэсэн үг. Харин тэгэхээр манайхаас наймуулаа ордог процессын хуулийн төсөл хийгээд өгсөн юм. Тэгээд одоо энэ бол өөрчлөгдчихөөд байгаа гурваараа хуралдаж шийддэг бол гээд тийм өөр процесс орж ирчхээд байгаа юм. Тэгэхээр яах вэ зүгээр гурван зөв юм гэвэл энэ хэвээрээ л явах байх. За наймуулаа гэх юм бол манай боловсруулж өгсөн. Гол үр дагавар нь бол ерөөсөө тийм, Цогт шүүгч бас хэлэх байх. Гол яагаад энийг найм гурав биш ээ, найм гээд байгаа вэ гэхээр одоо энэ нөгөө хяналтын хүрээ их хумигдаад ирэхээр одоо жишээлбэл бүх ирж байгаа гомдлыг шүүгч нар энэ адилхан шүү дээ. Хуваарилагддагаараа бол нөгөө санамсаргүй тохиолдлоор гомдлууд нь хуваарилагдана. Тэр хуваарилж авсан шүүгч нь өөрөө танхимынхаа хурал руу оруулна. Ийм гомдол ирлээ гээд, тэгж шийдэх юм.

Одоо бол хуваарилж авсан шүүгч өөрөө хэн нэг шууд өөрөө захирамж гаргачихдаг байхгүй юу. Хэлэлцүүлнэ, хэлэлцүүлэхгүй гээд. Тэр захирамжийг зөвшөөрөхгүй бол гурав нэг гомдол гаргана. Тэрийг нь гурвуулаа хэлэлцээд авна, авахгүй гээд л эцэслэхсэн юм. Хэрэв авбал буцаад над дээр хүрээд ирнэ. Одоо нөгөө хэрэг маань авах юм байна чи гээд. Тэгээд би өөрөө орно. Хяналтын таван бүрэлдэхүүнд бол энэ захирамж хянасан шүүгч нар хамаагүй ордог. Яагаад вэ гэхээр энэ хэрэг хянаагүй байхгүй юу. Тийм учраас энэ бүрэлдэхүүний давхцал гарахгүй. Өөрөөр хэлэх юм бол одоо өмнө нь орчихсон хүн, дараа нь шүүгч орно энэ тэр гэдэг ийм асуудал бол гардаггүй, одоо ч гарахгүй. Одоо бол яг энэ процессоор л явж байгаа л даа. Одоо хамгийн гол нь энэ нөгөө их нарийсаад ирэхээр бид нарын зүгээр одоо таамаглал байгаа юм шүү дээ. Бодитой мэдэхгүй, юу болох юм бүү мэд. Ямар ч байсан одоо ирж байгаа гомдлууд бол ирдгээрээ ирэх байх. Тэгээд ирэхээр зэрэг энэ гуравт алинд нь нийцэж байгаа вэ, аль нь мөн бэ, биш вэ гэдгийг л нэг селекшн хийх асуудал гарцаагүй гараад байгаа байхгүй юу.

Тэгэхээр одоо хоёроороо шийдчихдэг, дараа нь тавын бүрэлдэхүүн хэргээ тэврээд орохоор наадах чинь энэ гурвын алинд нь ч хамаарахгүй байна шүү дээ гээд л тэгвэл аягүй хэцүү болох гээд байгаа байхгүй юу. Энэ ямар хуралдаж байснаа л хүлээн авахаас татгалзаж байлтай биш. Хүчээр шийднэ гэхээр нөгөө гурав дотор чинь орохгүй учраас хууль зөрчих гээд байна шүү дээ, бид нар.

С.Бямбацогт: Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа гишүүддээ би ийм саналтай байна. Энэ дээд шүүхийн саналыг хүлээгээд авчих нь зөв юм шиг санагдаад байна. Яагаад гэвэл байна шүү дээ энэ дээд шүүх хэргийг нь дотрыг нь ухаагүй. Тэгэхдээ энэ асуудлыг авч хэлэлцэх үү, үгүй юу гэдэг шийдвэр нь аягүй чухал шийдвэр болчихоод байгаа байхгүй юу. Яг нөгөө онолын шүүх болох гээд байна шүү дээ, одоо бидний яриад байгаа шиг. Тийм ээ. Тэгэхлээр жишээ нь бол одоо зүгээр ингээд зүйрлээд ярихад Америкийн дээд шүүхийн хамгийн гол дүрэм бол нөгөө дөрвийн дүрэм гэж байдаг байхгүй юу. rule of four гэж. Тэр нь есөн шүүгчийн дөрөв нь энэ асуудлыг хэлэлцье гээд шийдчих юм бол нэг шүүгчид хуваарилаад, тэгээд есүүлээ хэргээ уншаад шийддэг. Энэ бол нөгөө хэргээ уншаагүй яг дээд шүүхэд энэ асуудлыг хэлэлцэх зарчмын асуудал мөн байна уу, үгүй юу гэдэг л гол нь тохирч байгаа байхгүй юу. Тэр нөгөө хамгийн гол юм нь бол одоо энэ дээд шүүхэд очоод асуудлаа шийдүүлэх нь наад талын тэр шат нь.

Дээд шүүхээр энэ асуудлаа хэлэлцүүлэх ёстой гэдгээ нотлох нь хамгийн чухал асуудал. Энэ босгыг давна гэдэг бол өөрөө хамгийн том босго. Жишээ нь одоо юу гэдэг юм Америкийн дээд шүүхэд жилдээ арван мянга, арван нэгэн мянган хэрэг ирэхэд наа юм уу ерэн хэрэг л үзэж байгаа байхгүй юу. Тэр нөгөө read of s... гээд нөгөө зөвшөөрөл өгөх нь хамгийн чухал. Тэр зөвшөөрлийг одоо яг энэний хэлээд Мөнхтуяа шүүгчийн хэлээд байгаа шиг хоёрхон шүүх шийдчих юм бол тэр асуудал дуусчхаж байгаа байхгүй юу. Дахиж тэр ерөөсөө хэлэлцэгдэхгүй. Тийм ээ. Хоёрхон шүүгчээр хэлэлцэгдэхгүй болчихож байгаа юм. Гэтэл хоёр шүүгч нь хэлэлцье гэххээд байтал нөгөө таван шүүгч нь үгүй ээ энэ чинь биш байна шүү дээ гэж сая Мөнхтуяа шүүгчийн хэлээд байгаа бас асуудал үүсчих байхгүй юу.

Тэгэхлээр наймуулаа, тэгэхдээ наймаасаа одоо дөрөв нь байхад хангалттай гэж бодож байна. Тийм ээ дөрөв нь. Энэ бол заавал олонхоороо биш. Хэрэг биш шүү дээ энэ чинь. Авах уу, үгүй юу гэдгээ хэлж байгаа учраас тавин хувь нь хэрэгтэй юм байна гэж үзэхэд л энэ тэр босгыг давдаг л байх хэрэгтэй байх. Тэрнээс доошоо болгоод хэрэггүй байх. Заавал тав болгоод хэрэггүй. Тав болгочих юм бол Энхбаяр гишүүний яриад байгаа нөгөө хэрэг шийддэг тал руугаа бас дөхчхөж магадгүй. Тийм зөвлөгөөн бол яах вэ. Тэр зөвлөгөөнөөрөө шидэж болно, одоо Мөнхтуяа шүүгчийн будилуулаад байгаа нь ингээд байгаа байхгүй юу. Энэ нөгөө нэг процессоо хурдлуулах гээд байгаа юм шиг яриад байгаа байхгүй юу. Тэгтэл процессоо хурдлуулах гээд байгаа асуудал биш. Наадах чинь өөрөө дээд шүүхэд хэлэлцэгдэх ёстой асуудал уу, үгүй юу гэдгийг шийднэ гэдэг чинь процессоосоо илүү агуулгын чанартай болох байхгүй юу. Тэгэхдээ хэрэг заавал уншина гэсэн үг биш. Хэргийг дотрыг нь задлахгүйгээр. Найм. Гэхдээ шийдвэрээ дөрвөн нь ok энийг хэлэлцье гэх юм бол тэрийг нь хэлэлцүүлэг шатанд нь явуулаад, дараа нь таван шүүгч нь эцсийн шийдвэрээ гаргадаг юманд байх нь зөв юм байна.

С.Бямбацогт: Мөнх-Оргил гишүүний саяынхаар хэрэв ярилцаад шийдчихье гэх юм бол ингээд шийдчихье. Тэгвэл ажлын хэсэг саяын саналаар гурав биш дөрөв гэж томъёолоод. Юу яах уу эсхүл энэ дагах хуулиудаа маргааш үдээс өмнө нь хуралдвал яасан юм бэ? Уг нь жоохон л байна л даа. Тэгвэл томъёоллоо хийе тэгэх үү. Та нарт материал тараагдчихсан биз дээ. Тараагдсан байгаа бол томъёоллоо бэлдээд өгөөч. Сайнзориг дарга томъёолсон байгаа юм уу? Та нарын томъёолсон чинь өөрчлөгдөөд яригдаад байна шүү дээ. Энэ чинь найман шүүгч байх юм бол дөрөв гээд ярьчихсан байна шүү. Та нар ч бол танхимаараа бүтнээрээ гэсэн байна шүү дээ. Би чинь сая

хаана хүртэл уншсан билээ. Мэдэж байгаа. Тэгвэл саяынхаар томьёоллыг тийм үү саяын зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг би уншиж танилцуулсан. Түүнийгээ өөрчлөөд тэр 4 дэх хэсэгт заасан тогтоолыг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэлэлцэж гэснийг хэлэлцэх шийдвэрийг олонхын саналаар гаргана гэснийг танхимын бүрэлдэхүүнээрээ хэлэлцээд 4 шүүгчийн 4-өөс доошгүй шүүгчийн саналаар гаргана гэдэг байдлаар өөрчиллөө шүү. Ингээд дэмжье гэсэн томьёоллоор санал хураая. Санал хураалаа шүү гишүүдээ. Саяын зарчмыг ойлгосон тийм ээ. Санал хураалтад 13 гишүүн оролцож 11 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Арваадхан санал байгаа. 2.Төслийн 2 дугаар зүйлийн “22.1.3” гэснийг “22.3” гэж өөрчилж, “3.4 дүгээр” гэсний өмнө “2.2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “Тэргүүний шийдвэрээр” гэснийг “шийдвэрээр” гэж, “Ерөнхий шүүгчийн” гэснийг “шүүгчдийн зөвлөгөөний” гэж,” гэж нэмж, “40.10 дугаар зүйлийн 3, 4 дахь хэсгийн “хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн” гэснийг “нийт шүүгчдийн” гэж, 40.10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “бичгээр” гэснийг “ажлын албаны даргаар дамжуулан бичгээр” гэснийг “40.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн нь” гэснийг “Танхимын зөвлөгөөнөөс” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Ажлын хэсгийн ахлагчаа санал чинь явж байна шүү. Санал хураалтад 12 гишүүн оролцож 11 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.2 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 40.10, 40.11, 40.12 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Дараагийн санал.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Санал хураалт явуулъя. Ажлын хэсэг дээр тухайлсан санал гаргаагүй байна. Байхгүй байна тийм үү. Байгаа юм уу санал. Энэ дээр байхгүй гэж бичсэн байна. Тэр чинь нөгөө хэрэг шийдэх биш тийм үү хэргийг зүгээр гомдол хүлээж авах, авахгүй юу гэдэг асуудал ярьсан шүү дээ. Тэрэн дээр бол шаардлагагүй хуучин ч тийм байдаг гээд сая Мөнхтуяа шүүгч ярилаа шүү дээ. Одоо тэр асуудлыг дууссан дахиад дараа нь тэгэх үү.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 20.9-д заасан ажлын хэсэг Нийт шүүгчийн чуулганыг уг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 120 хоногийн дотор зохион байгуулж Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны шүүгч гишүүнийг сонгоно.” Санал хураалт. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцож 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “хороо, Шүүхийн мэргэшлийн” гэснийг хасах. Нямбаатар гишүүн.

Х.Нямбаатар: Энэ 2013 онд шүүхийн тухай хууль багц хууль үйлчилж эхлээд тухайн үед шүүгчээр ажиллаж байсан бүх шүүгч нарыг нэг өдөр чөлөөлөөд буцааж томилохдоо нэр бүхий 13 шүүгчийг томилоогүй ийм нэг том асуудал гарсан. Энэнээс болж маш тэр олон одоо өнөөдрийг хүртэл нийтдээ 8 жил хохироод явж байгаа юм. Тэгэхээр дагаж мөрдөх журмын тухай хуульд энэ хүмүүсийг эргүүлж одоо томилохыг энэ дагаж мөрдөх журмын хуульдаа оруулж өгмөөр байна. Төр алдаа гаргасан. Гаргасан алдаагаа бас засдаг байх ёстой. Энэ хүмүүс маш олон удаа шүүх цэц гээд олон газраар явсан. Энэ бол цаанаа улс төрийн шалтгаантай байсан.

Энэ бол манай бас шүүхийн нөгөө хараат бус бие даасан байдлыг алдагдуулсан ийм асуудал байсан. Тийм учраас би ийм заалт тусад нь ингэж оруулъя гэж санал оруулж байна. Энэ 13 шүүгчийн асуудал бол өнөө хэр нь хэл ам нь тасраагүй явж байгаа шүү дээ.

С.Бямбацогт: Манай ажлын хэсэг хоорондоо сайн ярилцаарай. Тийм. Тэр шүүх байгуулахтай холбоотой шүүх асуудал яригдаж байсан. Тэрнээс болж тиймэрхүү асуудал үүссэн гэдэг. Яг одоо энэ дагаж мөрдөх журмын тухай хуульд орж болох уу, болохгүй юу. Энгийг та бүхэн бас ярилцаарай. Саналаа хураая. 2.Төслийн 2 дугаар зүйлийн “хороо, Шүүхийн мэргэшлийн” гэснийг хасах. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Ажлын хэсгийн гаргасан саналыг дэмжье. Санал хураалтад 12 гишүүн оролцож 11 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8 дугаар зүйл.Улсын Их Хурал Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 120 хоногийн дотор Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч биш гишүүнийг сонгон шалгаруулж, томилно.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 12 гишүүн оролцож 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг батлахаас өмнө Улсын Их Хуралд танилцуулахаар ирүүлсэн Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчид Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 37.2 дахь хэсгийн зохицуулалт хамаарахгүй.” Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцож 9 гишүүн буюу 75 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11 дүгээр зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 47.2 дахь хэсгийн дагуу шүүгчид олгох “онцгой нөхцөлийн, төрийн албанд ажилласан хугацааны, докторын зэргийн” нэмэгдлийг 2022 оны 01 дүгээр сарын 01-

ний өдрөөс эхлэн олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Бусад нэмэгдэл нь хэзээнээс олгогдох юм бэ тэгээд. Санал хураалтад 12 гишүүн оролцож 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Төсөлд доор дурдсан агуулгатай 12 дугаар зүйл нэмэх:

“12 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 49.7 дахь хэсгийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Шүүгч нарын цалин гэхээр бүгд дарж байна шүү. Санал хураалтад 12 гишүүн оролцож 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.Төсөлд доор дурдсан агуулгатай 13, 14 дүгээр зүйл нэмэх:

“13 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн дагуу байгуулагдах Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны 2021 оны үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг Засгийн газар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

14 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 75.2 дахь хэсгийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан. Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Гишүүдээ энэ 13 дугаар зүйлийн Засгийн газар хөрөнгө гаргаж шийдвэрлэнэ гээд орж байна шүү дээ. Энийг хуульдаа биш тусдаа тогтоол болгоод оруулбал яасан юм бэ. Засгийн газарт үүрэг болгосугай гээд. Хөрөнгө мөнгөтэй асуудал юм ярьж байна шүү дээ. Тэгэхээр Засгийн газар өөрөө зохицуулаад гаргаад мөнгийг нь өгч бай. Засгийн газарт үүрэг болгосугай гээд тусдаа тогтоол болгоод оруулаад. Энэ хуулийн ийм заалт орохооргүй л юм шиг санагдаад байх юм. харин тийм. Тэгээд тэрийгээ Засгийн газартаа л тогтоолоороо үүрэг болгоод өгчих нь зөв байх. Хуульдаа юу билээ Засгийн газар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ гэдэг заалт орчихоор чинь нэг л тийм хуулийн заалт хэм хэмжээний заалт л биш л болоод байна л даа. Нэг удаагийн л шинжтэй юм уу.

С.Бямбацогт: Бид нар чинь нөгөө дагаж мөрдөх журмын тухай хууль чинь арай жаахан өөр томьёололтой бас өөр хэллэгтэй бас яадаг шүү дээ. Үндсэн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль дээр их сонин, сонин томьёолол орсон шүү дээ. Тэгэхээр тэр томьёоллоор, яах вэ манай ажлын хэсэг дахиад анхаарчих. Ямар ч байсан зарчмын хувьд, зарчмыг нь дэмжээд найруулгын хувьд анхаараарай. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Наана чинь болох юм уу та нар сайн ярилц л даа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. Нямбаатар гишүүнээ яах юм бэ наадах чинь болох юм уу энэ болохгүй байх.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явуулъя. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гараагүй. Хуулийн төсөлтэй холбоотой гишүүдээс бичгээр гарсан санал алга. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явуулъя. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гараагүй байна. Хуулийн төсөлтэй холбоотой гишүүдээс бичгээр гарсан санал алга байна. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан хамт өргөн мэдүүлсэн Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гараагүй. Гишүүдийн бичгээр гарсан санал алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гараагүй байна. Хуулийн төсөлтэй холбоотой гишүүдээс бичгээр гарсан санал алга байна. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн захиргааны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Санал хураалт, Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гараагүй санал хураалт алга байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд бичгээр гаргасан санал байхгүй байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Санал хураалт явуулъя. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд бичгээр гаргасан саналаар санал гаргаагүй байна. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн захиргааны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Гишүүд алга байна. Ажлын хэсэг санал гаргаагүй байна. Гишүүд бичгээр санал

гаргаагүй байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Санал хураалт ажлын хэсэг санал тухайн зүйл дээр санал гаргаагүй. Гишүүдийн бичгээр гаргасан санал байхгүй байна. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн энийг ярьсан. Одоо цаашаагаа Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байгаа. Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна. Ингээд уншъя тийм ээ эндээс эхэлнэ тийм ээ. Ажлын хэсгийн саналын томъёоллыг та бүхэнд уншиж танилцуулъя.

“1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/122 дугаар зүйлийн 122.3 дахь хэсэг:

“122.3.Хяналтын журмаар гомдол гаргасан бол хэргийг хэлэлцүүлэхээс татгалзах тогтоол гарах, эсхүл хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд энэ хуулийн 69 дүгээр зүйлд зааснаар урьд нь авсан шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ хүчинтэй хэвээр байна.”

2/173 дугаар зүйлийн 173.5, 173.6, 173.7, 173.8 дахь хэсэг:

“173.5.Хяналтын шатны шүүх гомдлыг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор дараах тогтоолын аль нэгийн гаргана.

173.5.1.гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх;

173.5.2.гомдол гаргахдаа энэ хуульд заасан журмыг баримтлаагүй гэсэн үндэслэлээр гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх татгалзаж улсын тэмдэгтийн хураамжийг буцаах.

173.6.Энэ хуулийн 173.5-д заасан тогтоолыг танхимын нийт шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэлэлцэж шийдвэрийг олонхын саналаар гаргана. 4-өөс доошгүй гишүүний саналаар гаргана. 4-өөс доошгүй шүүгчийн саналаар гаргана. Тогтоолд шүүх бүрэлдэхүүн гарын зурснаар хүчин төгөлдөр болно. Тогтоол эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй.

173.7.Гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэхэд хэргийн зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч оролцохгүй.”

3/176 дугаар зүйлийн 176.4, 176.5 дахь хэсэг:

176.4.Хяналтын шатны тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй.

176.5.Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш долоо хоногийн дотор зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, эсхүл өмгөөлөгчид хүргүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Иргэний процесс. Санал, 12 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Санал хураалт явуулъя.

2.Төслийн 2 дугаар зүйлийн гарчгийн “Бичмэл” гэсний дараа “, цахим” гэж, мөн зүйлийн 110.1 дэх хэсгийн “бичмэл” гэсний дараа “, цахим” гэж, мөн зүйлийн 110.3 дахь хэсгийн эхний өгүүлбэрийн “Хэрэгт байгаа бичмэл” гэсний дараа “, цахим” гэж, хоёр, гурав дугаар өгүүлбэрийн “Бичмэл” гэсний дараа “, цахим” гэж, мөн зүйлийн 110.4 дэх хэсгийн “Бичмэл” гэсний дараа “, цахим” гэснийг “110 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 1010.3 дахь хэсэг, 110.4 дэх хэсгийн “Бичмэл” гэсний дараа, мөн зүйлийн 1010.1, 1010.3 дахь хэсгийн “бичмэл” гэсний дараа “, цахим” гэж, 120 дугаар зүйлийн 120.1.2 дахь заалтын “гаргаагүй” гэсний дараа “, эсхүл гомдол гаргасан боловч гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзах тогтоол гаргасан гэж” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 83,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс гаргасан саналаар зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

3.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг:

“31.1.Прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25, 26 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно.”

1/51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэг:

“51.1.Анхан шат, хяналтын шатны шүүх хуралдаанд тэмдэглэл үйлдэнэ. Хэргийн оролцогч оролцож байгаа бол давж заалдах шатны шүүх хуралдаанд тэмдэглэл үйлдэнэ.”

2/172 дугаар зүйлийн 172.2 дахь хэсэг:

“172.2.Хяналтын журмаар дараах үндэслэлээр гомдол гаргана:

172.2.1.анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;

172.2.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн;

172.2.3.шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.”

3/173 дугаар зүйлийн 173.4 дэх хэсэг:

“173.4.Хяналтын журмаар гомдол гаргахад энэ хуулийн 167.5, 173.3-т заасныг хангаагүй бол анхан шатны шүүх гомдлыг хүлээн авахгүй бөгөөд энэ тухай шүүгч захирамж гаргана.”

4/174 дүгээр зүйлийн 174.1 дэх хэсэг:

“174.1.Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тогтоол гарснаас хойш 30 хоногийн дотор хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.”

5/176 дугаар зүйлийн 176.1, 176.3 дахь хэсэг:

“176.1.Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүхийн таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэж, энэ хуулийн 114.1-д заасан журмын дагуу шийдвэрээ гаргаж гомдлыг хангасан эсэхийг сонсоно. Шийдвэрийг шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргах бөгөөд хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

176.3.Тогтоолд шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Тогтоолд анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсгийн агуулга, хяналтын гомдлын болон гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тус тус тусгана.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 9 гишүүн буюу 75 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна. 3 дугаар зүйлтэй холбоотой.

4 дүгээр зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

4.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх “хуваарилна” гэснийг “хуваарилах бөгөөд уг журам нь урьдчилан мэдэх боломжгүй, тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан байна” гэж, 59 дүгээр

зүйлийн 59.3 дахь хэсгийн “шийдвэр, магадлалыг” гэснийг “шийдвэрийг” гэж, 172 дугаар зүйлийн 172.3 дахь хэсгийн “тооцож, улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгох тухай шүүгч захирамж гаргана.” гэснийг “тооцно. Энэ тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгохгүй.” гэж, 176 дугаар зүйлийн 176.4 дэх хэсгийн дугаарыг “176.6” гэж тус тус өөрчлөх.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Бичгээр гарсан гишүүдээс санал алга байна.

5 дугаар зүйлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Гишүүдээс гаргасан зарчмын ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

5.Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.6 дахь заалтын “давж заалдах, хяналтын журмаар” гэснийг, 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсгийн “буюу хяналтын” гэснийг, 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсгийн, 122 дугаар зүйлийн 122.2 дахь хэсгийн “болон хяналтын” гэснийг тус тус хассугай.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 9 гишүүн буюу 75 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. 5 дугаар зүйлтэй холбоотой гишүүдээс бичгээр гаргасан санал алга. 5 дугаар зүйлийн.

6.Төслийн 5 дугаар зүйлийн “79.2 дахь хэсгийг” гэснийг “79.2 дахь хэсэг, 176², 177¹, 178¹ дүгээр зүйлийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Иргэний, одоо дуусах гэж байна. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 8 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ. Хуулийн төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу, алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “зүйл,” гэснийг хасаж, 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2, 3, 4 дэх заалт болгох:

2/123 дугаар зүйлийн 123.2 дахь хэсэг:

“123.2.Дараах үндэслэлээр Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргана:

123.2.1.анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;

123.2.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн;

123.2.3.шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.”

3/124 дүгээр зүйлийн 124.3, 124.4, 124.5 дахь хэсэг:

“124.3.Хяналтын шатны шүүх гомдлыг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор дараах тогтоолын аль нэгийг гаргана:

124.3.1. гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх;

124.3.2.гомдол гаргахдаа энэ хуульд заасан журмыг баримтлаагүй гэсэн үндэслэлээр гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, улсын тэмдэгтийн хураамжийг буцаах.

124.4.Энэ хуулийн 124.3-т заасан тогтоолыг танхимын нийт шүүгчдийн бүрэлдэхүүнтэй хэлэлцэж шийдвэрийг олонхын саналаар гаргана. Дөрвөөс доошгүй шүүгчийн саналаар гаргана. Тогтоолд шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Тогтоол эцсийн шийдвэр байх бөгөөд гомдол гаргахгүй.”

124.5.Гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэхэд хэргийн оролцогч тэдгээрийн төлөөлөгч хүмүүс оролцохгүй.”

4/125 дугаар зүйлийн 125.1 дэх хэсэг:

“125.1.Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тогтоол гарснаас хойш 30 хоногийн дотор хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.”

5/127 дугаар зүйлийн 127.1 дэх хэсэг:

“127.1.Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүхийн таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэж, энэ хуулийн 105.1-д заасан журмын дагуу шийдвэрээ гаргаж гомдлыг хангасан эсэхийг сонсгоно. Шийдвэрийг шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргах бөгөөд хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.” Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 12 гишүүн оролцож 10 гишүүн буюу 83,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой бичгээр гишүүдээс гарсан санал алга байна. Төслийн 2 дугаар зүйлтэй.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар доор дурдсан агуулгатай 127.4, 127.5, 127.6 дахь хэсэг нэмсүгэй:

“127.4.Тогтоолд шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Тогтоолд анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсгийн агуулга, хяналтын гомдлын болон гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тус тус тусгана.

127.5.Хяналтын шатны тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй.

127.6.Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш долоо хоногийн дотор хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид хүргүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцож 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн “75 дугаар” гэсний өмнө “16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “Ерөнхий шүүгч” гэснийг “Шүүгчдийн зөвлөгөөн” гэж,” “даргалагч” гэсний өмнө “шүүх хуралдаан” гэж,” тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 91,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1.2 дахь заалтын “гаргаагүй” гэсний дараа “, эсхүл гомдол гаргасан боловч гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзах тогтоол гарсан” гэж нэмсүгэй. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 9 гишүүн буюу 75 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу, алга байна. Ажлын хэсгээс гарсан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

5.Төслийн 3 дугаар зүйлийн “гэснийг” гэсний дараа “, 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалтын “давж заалдах, хяналтын журмаар” гэснийг” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцож 11 гишүүн буюу 91,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулъя. 6.Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсэг, 128, 129 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болгосугай.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцож 11 гишүүн буюу 91,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гаргасан санал байхгүй байна. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье. Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу, алга байна. Санал хураалт явуулъя. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал байхгүй байна. Байна гээд юу бичсэн юм. Санал алга байна. Гишүүдээс бичгээр гарсан санал алга байна. Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбоотой гишүүдээс бичгээр гарсан санал алга. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Төслийн 1 дүгээрт зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгийн санал байна. Гэхдээ байхгүй гээд бичсэн байна. Энийг анхаараарай та нар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “орон тооны” гэснийг хасаж, 2 дугаар зүйлийн “байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаал” гэснийг “байгууллага” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 11 буюу 91,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Гишүүдээс бичгээр гарсан санал алга байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулаад асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал байхгүй байна. Энэ дээр байна гээд бичсэн байна энийг анхаараарай. Бичгээр гарсан санал алга байна. 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд алга байна. Ажлын хэсгээс санал гараагүй байна. Гишүүдээс бичгээр санал байхгүй байна. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс санал гарсан байна. 1.Төслийн гарчгийн “өөрчлөлт” гэсний өмнө “нэмэлт,” гэж нэмэх. Ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 11 гишүүн буюу 91,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гарсан санал алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсэг

дээр тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр ирсэн санал алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гарсан санал алга байна. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. Дуусчихлаа шүү дээ. Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Эвлэрүүлэн зуучлал дээр энэ Сайнзоригоос асуух юм уу. Энэ Эвлэрүүлэн зуучлалын хууль дээр ийм шаардлага оруулаад ирэх юм. Шүүх дэх эвлэрүүлэн. Зуучлах үйл ажиллагааны оролцох эвлэрүүлэн зуучлагч нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйн мэргэжилтэй байна гээд. Хуульчлаад ороод ирэх юм. Тэгэхээр энэ ямар эвлэрүүлэн зуучилж байгаа шиг шүүхийн жил хийж байгаа биш тийм ээ. Анх чинь бид нар энэ эвлэрүүлэн зуучлалын тухай хууль оруулаад шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг зохицуулна гэж байхдаа яах вэ дээ заавал бас нэг эрх зүйч байх шаардлагагүй юм даа. Тухайн маргаанаа мэддэг ойлгодог итгэлийг нь хүлээсэн туршлагатай хүмүүс байж байгаад хооронд нь уулзуулаад тайлбарлаад эвлэрүүлээд гаргадаг л ийм хүмүүс байх ёстой юм гэж яриад л явсан шүү дээ.

Одоо тэгээд энэ чинь ингээд заавал эрх зүйч мэргэжилтэй байна гэхээр яах вэ мэдээж нэг процесс дагах ёстой. Гарч байгаа шийдвэрээ бичих ёстой. Гэхдээ тэрийг чинь заавал эрх зүйч мэргэжилтэй хүн хийгээд байх албагүй шүү дээ. Тэр ямар ч мэргэжилтэй хүн байсан гэсэн эвлэрүүлэн зуучлал чинь ийм хуультай шүү. Та энэ номын дагуу явуулна шүү гээд тайлбарлахад болж байгаа байхгүй юу. Жишээ нь би зүгээр энд юун дээр л бодоод байна л даа. Хөдөлмөрийн маргаан дээр ч байдаг юм уу эсхүл гэр бүлийн маргаан дээр. Эрх зүйчээсээ илүү тэр асуудлыг ёстой нөгөө зовлон үзсэн чавганц гэдэг шиг тэр асуудлуудаа мэддэг үйлдвэрчний эвлэлийнхээ асуудлуудыг мэддэг хүмүүс байхад эд нарын чинь эвлэрүүлэн зуучлаад явж болно шүү дээ.

Энийг заавал ингэж хатууруулж эрх зүйч мэргэжилтэй байна гэж оруулах хэрэг байгаа юм уу. Дараа нь энэ чинь дараагийн шатандаа энэ чинь бол хуульч байна гээд л орох нь байна шүү дээ. Яг энэ логикоор яваад байх юм. Энэ дээр нэг тайлбар өгөөч. Хаанаасаа ийм санал гараад ирсэн бэ? 2 номерын микрофон Ундрах шүүгч. Атарцэцэг ерөнхий зөвлөл.

Л.Атарцэцэг: Ийм шаардлага тавьсан гэдэг энэ асуудал шаардлагыг оруулаад ирсэн бэ гэдэг энэ асуудал тавьж байна. Мөн энэ хуулийн төслийг хэлэлцүүлж байх явцад бид нар бүхий л хуульчидтай уулзаж санал юуг нь авч байсан. Одоо манай эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны үйл ажиллагааг шүүхэд удирдаж байгаа Тунгалаг шүүгч олон жил манай Улсын дээд шүүхийн иргэний хэргийн танхимд шүүгчээр ажиллаж байсан. 12 оноос хойш эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааг өөрөө яг гардаж өдийг хүртэл ажиллаж байгаа.

Энэ эвлэрүүлэн зуучлагчдаас гарсан энэ санал ерөөсөө. Тэгэхээр ер нь бол шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа шүүхэд энэ ажиллагаа хийгдэж байгаа учраас эрх зүйч мэргэжилтэй хүн байхгүй бол бас болохгүй юм байна. Ийм учраас энэ хуульд эрх зүйч мэргэжилтэй гэдэг энэ шаардлагыг тавих өөрчлөлтийг оруулж өгөөч

гэсэн энэ хүсэлтийг нь бид нар ажлын хэсэг дээр хэлэлцүүлээд ингээд оруулсан юм байгаа юм. Ер нь бол зүгээр яг ингээд эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа шүүхийн өмнөх процесст бол их олон л хүндрэлүүд гардаг юм байна л даа. Энэ яг ийм шаардлага тавихгүйгээс болоод тэр процессын ажиллагаа гэдэг маань жижиг асуудал биш. Шүүхийн үйл ажиллагаатай энэ үйл ажиллагаагаа хутгадаг, хольж ойлгодог. Шүүхийн бүр одоо хэрэг маргааныг шийдвэрлэж байгаа мэтээр бүр дүгнэлт гаргадаг.

Өөрөө тэр нөгөө мэдэхгүй мөртөө ийм асуудал юм гаргадаг. Энэ олон л зовлон тоочиж байна лээ. Тэгээд энэ үндэслэлийг нь бид нар хүлээж аваад саналыг нь ажлын хэсэгт уламжлаад ингээд оруулсан.

С.Бямбацогт: Асуулт асууж хариулт авлаа. Нийгмийн даатгалын сан гэж байгаа юм биш үү. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал байгаа юу? Байхгүй байна. Гишүүдээс бичгээр ирсэн санал алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбоотой асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгээс санал ирсэн юм уу тийм ээ. Ажлын хэсгээс санал байхгүй. Гишүүнээс бичгээр санал гарсан байна. Алтанхуяг гишүүнээс.

3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт дараах өгүүлбэр нэмэх.

Шүүгчээр 30 болон түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн шүүгч. Дагаж дэмжигдэх ёстой юу тийм ээ. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Санал хураалт явуулъя. Ажлын хэсэг дээр санал гараагүй байна. Хуулийн төсөлтэй холбоотой гишүүдээс бичгээр санал гараагүй байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсэг дээр ажлын хэсгээс санал гараагүй байна. Гишүүдээс бичгээр санал гараагүй байна. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ шүүгчид Хуульчдын холбооны гишүүн байх уу үгүй юу гээд л бид нар тал талаасаа яриад л маргалдаад л байдаг юм л даа. Тэгээд энэ удаадаа бол ерөөсөө байхгүй гэдгээр нь хатуу таслаад орж ирж байгаа юм байна тийм үү. Би бол ийм саналтай байх юм. Гишүүд энийг нэг бодолцоод байхаач. Хуульчдын холбооны гишүүн байх уу үгүй юу гэдгээ заавал бай гэдэг шаардлага тавихгүй. Хуульчлахгүй. Одоо бол хуульчилсан байгаа шүү дээ. Заавал бол гээд. Хуульчлахгүй заавал байх албагүй. Гэхдээ өөрөө хүсвэл шүүгч нь хуульчдын холбооны гишүүн байгаад тэрнийхээ үйл ажиллагаанд орж болмоор байгаа байхгүй юу. Эрх нь нээгдмээр байгаа юм. Тэгэхгүй шүүгч болчихоод л яагаад ч ерөөсөө хуульчдын холбооны үйл ажиллагаанд оролцож болохгүй шүү гэж хуульчлахаар чинь энэ дээр чинь тэгж байна шүү дээ. Хуульч нь шүүгчээр томилогдсоноор хуульчдын холбооны гишүүнчлэл түдгэлзэнэ гэж байна. 44.7 дээр чинь харин шүүгчээр томилогдоод л гишүүнчлэл нь түдгэлзэж байгаа байхгүй юу. Орохгүй болж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энийг нь нээгээд өгье. Би шүүгч хэдийгээр шүүгч ч гэсэн хуульчдын холбооны үйл ажиллагаанд оролцмоор байна. Тэр сургалтад нь оролцмоор байна, ингэмээр байна гэвэл тэр нь нээлттэй л байж байг л даа. Харин тийм л баймаар байгаа байхгүй юу. Заавал ингээд нэг хатуурхаад л заавал бай гэж нэг үзээд л. Эсхүл ерөөсөө болохгүй гэж нэг үзээд л. Өөрийнхөө сонголтын асуудал баймаар байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг зарчмаар нь санал хураагаад яамаар байх юм. Тэгэхээр чинь энэ 4 заалтад 5 заалт дээр чинь тавуулан дээр нь дөрвүүлэн дээр нь өөрчлөлт орох гээд байна шүү дээ. Би бичих гээд байна тийм үү. Дараагийн энэ 2, 3 дугаар зүйлүүд дээр байгаа шүүгч, прокурор энэ тэр гэдэг нь бол саяын санаатай уялдаж орж байгаа биз дээ бас. Түдгэлзэнэ гэдэгтэй л уялдсан саналууд явж байгаа биз дээ. Тэгвэл би юу яая. Түдгэлзэж болно гэдэг саналыг нь оруулъя. Санал болгохдоо шүүгч биш байна бид нар хуульчилсан биз дээ. Тийм санал хураалгаад өгөөч даргаа.

С.Бямбацогт: Шүүгчдийн холбооноос бас бичиг ирсэн. Бид нар ерөөсөө шүүгчдийн холбоонд юунд хуульчдын холбоонд байх ёсгүй энийг хуульдаа оруулж өгөөч гэж. Шүүгч нараас. Тайлбар хэрэггүй. Хуульчдын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна сая асуусан. Санал хураалт явуулна. Ажлын хэсэг дээр санал гараагүй байна. Гишүүдээс бичгээр ирсэн санал алга байна. Юу яаж байна шүү Их Хурлын дарга сая ярьж байна. Парламентын 44 дүгээр сувгаар гарч байна. Та нар одоо болтол хуралдаж байгаа юм байна. Тэгээд парламентын түүхэнд 13 цаг хуралдсан рекорд байдаг юм байна Байнгын хороо тасралтгүй 13 цаг хуралдсан. Манай Байнгын хороо тэгсэн чинь одоогийн байдлаар бараг 16 цаг болсон явж байна. Өглөө 9 цагаас эхэлсэн. Рекорд тогтоож байгаа юм шиг байна. Их Хурлын дарга ажил хэрэгч хуралдаж байгаа Хууль зүйн байнгын хорооны гишүүддээ их баярлаж байна гэж мэнд хүргээрэй гэж шөнө унтаагүй биднийг хараад сууж байна гэж хэлж байна. Даргаа өөрөө сонсож байгаа байх гэж бодож байна. Эндээс гараад Их Хурлын даргын очъё гэсэн санал гарч байна шүү Их Хурлын даргаа.

Төслийн 1 дүгээр зүйлийн 44.7-г хуульчдын холбооны гишүүнчлэлээс түдгэлзэнэ гэснийг түдгэлзэж болно гэж өөрчлөх саналыг Мөнх-Оргил гишүүн гаргалаа. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан санал байна уу байхгүй байна. Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулт байна уу гишүүдээс, алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Бичгээр гарсан санал байхгүй байна. Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу, алга байна. Ажлын хэсгээс санал гаргаагүй байна. Гишүүдээс бичгээр гарсан санал алга байна. Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу, алга байна. Ажлын хэсгээс тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Бичгээр гарсан санал алга байна. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу, алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

1.Төслийн “15.31 дүгээр” гэснийг “15.32 дугаар” гэж, 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “хүлээхээргүй” гэснийг “хүлээлгэхээргүй” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай. Санал хураалтад 12 гишүүн оролцож 9 гишүүн буюу 75 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд бичгээр гарсан санал байхгүй байна. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу, алга байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 1.Төслийн “15.31 дүгээр” гэснийг “15.32 дугаар” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт Энхбаяр гишүүнээ. Төслийн 2 дугаар зүйл дээр, санал хураалтад 12 гишүүн оролцож 75 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна. Гишүүдээс бичгээр санал гараагүй байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсэг

дээр тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Гишүүдийн бичгээр гарсан саналаар санал хураалт гишүүдээс бичгээр гарсан санал алга байна. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу, алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбоотой гишүүдээс бичгээр гарсан санал алга. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсэг тухайн зүйл дээр санал гаргаагүй байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гарсан саналаар санал хураалт явуулъя. Алга байна. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу, алга байна. Ажлын хэсгийн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 1.Төслийн 1 дэх заалтын “орон тооны” гэснийг хасаж, “ТӨ-VA-ийн тусгай албан тушаалд “Монгол банкны тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч,”” гэснийг “ТӨ-VIA-ийн тусгай албан тушаалд “Монгол банкны тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч,”” гэж өөрчлөх. Энэ юутай ямар хамаатай юм бэ? Техникийн алдаа гарсан юм байна. Тэрийг засаж өгөх юм байна. “ТӨ-VIA-ийн тусгай албан тушаалд “Монгол банкны тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч,”” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүдээс тогтоолын төсөлтэй холбоотой бичгээр гаргасан санал алга. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. Дуусаж байгаа билүү? Одоо дахиад унших юм уу тэгээд хаанаас юм бэ? Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар саналын томъёолол нэг.

1.Төслийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, хавсралтыг хасах:

“1.“Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 18 дугаар тогтоолын нэг дэх заалт, мөн тогтоолын хавсралтын гарчгийн “Үндэсний статистикийн хороо,” гэсний дараа “Шүүхийн сахилгын хороо,” гэж, мөн хавсралтын “Үндэсний статистикийн хороо” гэсэн хэсгийн дараа “Шүүхийн сахилгын хороо” гэсэн 13 дахь хэсэг, түүнд “Тэргүүн түшмэл” гэсэн ангиллын “АА-1” гэсэн зэрэглэлд “Ажлын албаны дарга” гэж, “Эрхэлсэн түшмэл” гэсэн ангиллын “АА-4” гэсэн зэрэглэлд “Хэлтсийн дарга” гэж, “АА-5” гэсэн зэрэглэлд “Ахлах референт” гэж, “Ахлах түшмэл” гэсэн ангиллын “АА-6” гэсэн зэрэглэлд “Референт” гэж, “АА-7” гэсэн зэрэглэлд “Ахлах шинжээч” гэж, “АА-8” гэсэн зэрэглэлд “Шинжээч” гэж, “Дэс түшмэл” гэсэн ангиллын “АА-9” гэсэн зэрэглэлд “Ахлах мэргэжилтэн” гэж, “АА-10” гэсэн зэрэглэлд “Мэргэжилтэн” гэж, “АА-11” гэсэн зэрэглэлд “Ахлах зохион байгуулагч” гэж тус тус хамааруулан нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 10 гишүүн буюу 83,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа. Байнгын хорооны гишүүддээ баярлалаа. Ямар санал. Энэ мөн үү. Хураалгах юм уу? Хурааж болох юм уу. Хурааж болох юм уу?

2013 онд Шүүх байгуулах хууль батлагдсантай холбогдуулан шүүгчээс чөлөөлөгдөөд чөлөөлөөд дахиж томилоогүй шүүгч нарыг шүүхийн ерөнхий зөвлөл дахин өргөн барьж шийдвэрлүүлнэ. Саналаа тайлбарлах уу? Нямбаатар гишүүн саналаа тайлбарлая. Санал гаргасан Нямбаатар гишүүн саналаа тайлбарлая. Санал гаргасан Нямбаатар гишүүн.

Х.Нямбаатар: Би энийг дахиад тайлбарлая. Лүндээжанцан даргаа би тайлбарлачихъя. Энэ хоёр мянга арван гурван онд шүүхийн тухай багц хууль батлагдаад, улмаар тухайн үед албан үүргээ гүйцэтгэж байсан бүх шүүгчдийг Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргаж, Элбэгдорж ерөнхийлөгч зарлиг гаргаж бүгдийг нь чөлөөлсөн. Буцаагаад томилохдоо яг бидний яриад байгаа энэ нэр бүхий арван гурван шүүгчийг томилолгүй орхисон. Энэ хүмүүс өнөөдрийг хүртэл ингээд найман жил ямар нэгэн тайлбар шалтгаан хэлээгүй. Найман жил эргээд одоо ажил төрөлгүй, эргээд шүүгчээр томилогдолгүй яг ийм байдалтай байгаа. Энэ хүмүүсийн асуудлаар Шүүхийн ерөнхий зөвлөл тухайн үед Монгол Улсын Ерөнхийлөгчид нэрийг нь шүүгчээр томилуулахаар өргөн барьсан. Харамсалтай нь Ерөнхийлөгч ямар нэгэн хариу өгөөгүй. Улмаар энэ арван гурван хүн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандсан. Цэц манай харьяаллын асуудал биш гээд захиргааны хэргийн шүүхэд

хандахыг зөвлөсөн. Захиргааны хэргийн шүүхэд хандмагц манайд яг энэ одоо та бүгдийн гаргаж байгаа асуудлыг шийдвэрлэх ийм процесс дэг байхгүй гэдэг хариуг өгсөн байгаа.

Тэгээд өнөөдөр энэ хүмүүс одоо төрийн бүх байгууллагад хандаад ямар нэгэн хариу авалгүй өнөөдрийг хүрч байгаа. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах тэр журмын хуулиараа бүх шатандаа хандчихсан. Шүүхийн процессоор явъя гээд шүүхэд нэхэмжлэлээ гаргасан хариу өгөөгүй. Үндсэн хуулийн цэцэд хандсан хариу өгөөгүй. Ямар нэгэн шалтгаан байхгүй энэ хүмүүс шүүгчийнх нь одоо бүрэн эрх ингээд дуусгавар болчихоод өнөөдрийг хүртэл ингээд найман жил явж байгаа. Тэгээд яг энэ үндэслэлээр би яагаад энэ дагаж мөрдөх журмын хуульд оруулж байна вэ гэж энэ саналаа оруулж байна вэ гэхээр нэг ийм үндэслэл байгаа. Одоо бид нарын өнөөдөр энэ анхны хэлэлцүүлгийг хийсэн шүүхийн тухай хууль нь өөрөө шүүгчийн эрх зүйн байдлын харилцааг давхар зохицуулж орсон.

Хоёрдугаарт шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн ерөнхий зөвлөл, хуульчдаас шүүгчдийг шилж сонгон шалгаруулах энэ эрх зүйн харилцаа энэ хуулийн төсөлд бүрэн агуулагдаж байгаа. Гуравдугаарт шүүхийн ерөнхий зөвлөл Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх харилцаа бас энд давхар зохицуулагдаж байгаа. Тэгэхээр би энэ гаргаж байгаа үндэслэлээ юу гэж тайлбарлах гээд байна вэ гэвэл шүүхийн ерөнхий шүүхийн тухай хуульд заасан хуульчдаас шүүгчдийг шилж сонгон шалгаруулах журмыг одоо хялбаршуулж шууд Монгол Улсын Ерөнхийлөгчид дээрх нэр бүхий арван гурван хүнийг шүүгчээр томилуулахаар өргөн мэдүүлэх энэ харилцааг л энэ дагаж мөрдөх журмын хуулиараа зохицуулъя гэж байгаа юм. Та бүхэн өөрсдөө бас энэ хүмүүсийн хооронд өөрсдийгөө тавиад үз. Улс төрийн үзэл бодол одоо юу гэдэг юм, өөр бусад байдлаар ялгаварлан гадуурхагдаж, найман жил ажил төрөлгүй явна гэдэг бол энэ хүмүүст ямар их хохиролтой байх вэ. Энэ хүмүүс маань өөрсдөө шүүх засаглалын нэг бүрэлдэхүүнд үйл ажиллагаа явуулж байсан. Ямар нэгэн сахилгын зөрчил дутагдлаар энэ хүмүүс чөлөөлөгдөөгүй. Зөвхөн тухайн үед шүүхийн хууль батлагдсан, дагаж мөрдөх журмын хууль батлагдсан. Үүнийгээ дагуулаад Ерөнхийлөгч тухайн үеийн Ерөнхийлөгч Элбэгдорж бүрэн эрхээ хэрэгжүүлж байсан бүх шүүгч нарыг нэг өдөр зарлиг гаргаж чөлөөлсөн. Чөлөөлөөд буцааж томилохдоо энэ арван гурван хүнийг л томилоогүй орхичихсон. Эргээд энэ хүмүүс эрхээ хамгаалуулахаар манайд байдаг бүх л хууль шүүхийн байгууллага, хууль хяналт.../минут дуусав/

С.Бямбацогт: Энэ яг энэ арван гурван шүүгчтэй холбоотой асуудлыг ойлгож байгаа. Яг үүнтэй адилхан бас хэлмэгдсэн, хохирсон олон шүүгч нар бас олон төрийн албан хаагчдын асуудал бас байдаг байх. Яг гэхдээ бидний хэлэлцэж байгаа асуудал дээр одоо хэлэлцэж байгаа хуультай холбогдоод хамааруулаад бид нар шийдэх бололцоотой юу боломжгүй юу? Тэгээд энийг ямар ч гэсэн бас ажлын хэсгээс асууя. Бид энийг хэлэлцээд санал хураалгаад явах бололцоотой юу? Ер нь бол иймэрхүү байдлаар одоо тийм үү шүүгч нартай холбоотой тийм үү. Зарим нь одоо дахиж томилогдоогүй, эсвэл өргөн баригдаад бас зарлиг нь гараагүй олон л тохиолдлууд байдаг. Энэ болгоны бүгдэд хамааруулаад явчих бололцоо байх уу? Ажлын хэсгийн ахлагч хариулах уу.

Б.Энхбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ арван гурван шүүгчийг чөлөөлсөн асуудал нь өөрөө Үндсэн хуулиас гадуур хийгдлээ. Тэр дотроо Элбэгдорж Ерөнхийлөгч арван гурван шүүгчийг томилоогүй эс үйлдлээрээ Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргасан иргэн нь би байгаа юм. Тэгээд цэц энэ маргаан үүсгэхээс татгалзсан хариу надад өгч байсан юм, тэр үед. Тэгээд энэ асуудал бол Үндсэн хуулийнхаа хүрээнд шийдэгдсэн нь зөв байх гэж би зүгээр бодож байгаа. Энэ шүүгчдийн одоо шүүгчдэд хайргүй ч юм уу, нэг нь хайртай нэг нь хайргүйн тухай асуудал биш. Энэ асуудлыг нэгэнт одоо Үндсэн хуулийн бус байсан гэдгийг бол одоо бид бол хүлээн зөвшөөрөх ёстой. Зарчмын хувьд. Тэгэхдээ энэ хүмүүсийг томилох асуудал ч гэсэн бас эргээд дахиад Үндсэн хуулийнхаа хүрээнд байх ёстой. Би бол гарц шийдлүүд Үндсэн хуулийн хүрээнд бол байгаа гэж бодож байгаа. Шүүгчдийг томилох асуудал бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуульд заасан бүрэн эрх байгаад байгаа юм.

Улсын Их Хурал шүүгчдийг томилох, тэр дотроо хууль гаргаж томилох нь эргээд өөрөө энэ хууль нь өөрөө Үндсэн хууль зөрчсөн дахиад асуудалд орох би бол ийм эрсдэл байна уу гэж харж байгаа юм. Энэ арван гурван шүүгчийг Үндсэн хуулийн цэц, улсын дээд шүүх, шүүхийн ерөнхий зөвлөл, захиргааны шүүх гэсэн дөрвөн байгууллага бие бие рүүгээ манай харьяаллын биш гэдгээр чулуу шидээд дунд нь хаясан юм. Улсын Их Хурал Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах эрх байгаа. Үндсэн хуульд зааснаар шүү. Өөрөөр хэлбэл тухайн үеийн тэр Монгол Улсын Ерөнхийлөгч эс үйлдлээрээ Үндсэн хууль зөрчсөн үү, үгүй юу гэдгийг тогтоож өг гэдэг хүсэлтийг Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцэд гаргавал шууд маргаан үүсгэж Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэдэг ийм хуультай. Энэ Үндсэн хуульд заасан процессынх нь дагуу асуудлыг би шийдвэрлэвэл яасан юм бэ гэж жишээлбэл бодож байна. Нямбаатар сайдын одоо яг энэ гаргаж байгаа санал дээр. Бид ч яах вэ, одоо сайхан сэтгэл гаргаад кноп дарчихдаг эргээд Цэц дээрээ оччих вий гэсэн л одоо тийм болгоомжлол байна.

Тийм учраас ер нь энэ эс үйлдэхүй гэдгийг цэцээр ер нь мухардуулж, тогтоолгоод, цэц мухарлаад тогтоовол Ерөнхийлөгч ч гэсэн тэр цэцийн шийдвэрийг сахин биелүүлэх ийм үүрэг, хууль ёсны үүрэг хүлээх юм. Монгол Улсын Ерөнхийлөгчид Улсын Их Хурал ч үүрэг хүл өгөх яг ийм заалт бол байхгүй байгаа. Ерөнхийлөгчийн хууль бус шийдвэрийг хүчингүй болгох л эрх байгаа шүү дээ. Ерэн хоёр оны Үндсэн хуульд байгаа нэг ийм заалт байгаа. Энийг хорин найман жилийн турш огт хэрэглээгүй ийм одоо жишиг байгаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуульд нийцээгүй шийдвэрийг Улсын Их Хуралд хүчингүй болгох эрхтэй шүү дээ Үндсэн хуульд зааснаар. Энэ эрхээ Улсын Их Хурал мартчихсан хэрэглээгүй. Дэгийн хуульд яаж хянах нь ч байдаггүй, энийгээ ч хэрэгжүүлэх боломж байгаа. Тийм учраас ийм Үндсэн хуулийнхаа хүрээнд байгаа нөөц боломжоо шахвал яасан юм бэ гэсэн ийм саналтай байна.

С.Бямбацогт: За одоо яах юм бэ. Тийм. Одоо сая тодорхой үндэслэл санал бас ярилаа шүү дээ. Бидний хамаарал, бидний хэлэлцэж байгаа хуультай хамааралгүй асуудлаар бид нар ингээд хамааруулж яриад тэгээд олон нийтийн өмнө бас тийм үү, зөв бурууг шүүмжлэл дагуулж байхын оронд сая Энхбаяр ажлын хэсгийн ахлагч тодорхой тайлбар хэллээ шүү дээ. Өөр боломжууд байна. Тэр арван гурван шүүгчийн хохирсон тийм үү, зөрчигдсөн эрх ашгийг хангах боломж байна. Тэрэн дээр

одоо ажлын хэсгийн юу Нямбаатар гишүүнээ хоёулаа хамтраад санал гаргаад явъя. Таны саналыг хураалгая тэгээд. Дэмжье томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад арван хоёр гишүүн оролцсоноос нэг гишүүн буюу 8,3 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй. Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Энхбаяр танилцуулна. Ямар ч байсан нэг том хуулийн ард хэдүүлээ хэлэлцээд гарчихлаа. Дараагийн асуудалдаа оръё. Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Манай улсын дээд шүүхийн шүүгч Цогт, шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Атарцэцэг, судлаач, багш Мөнхсайхан, Хууль зүй, дотоод дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн дарга Баасандорж, Хууль зүй, дотоод хэргийн яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах биш ээ, Хууль зүйн бодлогын газрын дарга Сайнзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах мэргэжилтэн Цолмон, Монгол Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Лүндээжанцан нарын одоо ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа. Дэд ажлын хэсгийн гишүүддээ. Дараагийн асуудалдаа оръё. Хэдүүлээ. Нэг асуудал байгаа.